

Сургаал ба Гэрээ болон Сүмийн түүх

Сайн мэдээний сургаалын багшийн гарын авлага



Сургаал ба Гэрээ болон Сүмийн түүх

Сайн мэдээний сургаалын багшийн гарын авлага

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс хэвлэв
Солт Лейк хот, Юта муж

Санал зөвлөмж

Энэхүү гарын авлагын талаарх та бүхний санал зөвлөмжийг хүндэтгэн хүлээж авах болно. Санал зөвлөмжөө дараах хаягаар ирүүлнэ үү:

Curriculum Planning
50 East North Ариун сүм Street, Floor 24
Солт Лейк City, UT 84150-3200
USA
E-mail: cur-development@ldschurch.org

Нэр, хаяг, тойрог, гадсаа бичнэ үү.
Тухайн гарын авлагын нэрийг заахаа бүү мартаарай. Энэ гарын авлагын чанар чансаа, цашид сайжруулах зүйлсийн талаар санал, зөвлөмжөө ирүүлнэ үү.

Хавтас: *Анхны Үзэгдэл*, Дел Парсон

Хуудас 174: *Миссурийн Жаксон дүүргээс хөөгдсөн Гэгээнтнүүд*, К.К.А.Крисченсен
© Бригам Янгийн Их Сургуулийн Дүрслэх Урлагийн музей.
Бүх эрх хамгаалагдсан

Хуудас 210: *Иосеф ах*, Давид Линдсли

Хуудас 218: *Бригам Янг, Америкийн Мосе*, Кеннет А.Корбетт
© Кеннет А.Корбетт

© 1999 by Intellectual Reserve, Inc.

Бүх эрх хамгаалагдсан

2003 онд шинэчилсэн

АНУ-д хэвлэв

Англи эхийн зөвшөөрөл: 11/03

Орчуулгын зөвшөөрөл: 11/03

Doctrine and Covenants and Church History:

Gospel Doctrine Teacher's Manual -ын орчуулга

Mongolian

Printed in the United States of America

Агуулга

Хичээлийн дугаар ба нэр	Хуудас
Багшид зориулсан тусламжууд	v
1 Сургаал ба Гэрээ болон Сүмийн түүхийн оршил	1
2 “Болгоогтун, Бибээр Есүс Христ, дэлхийн Аврагч болой”	7
3 “Би үзэгдэл харсан”	13
4 “Шинэ гэрээ, бүр Мормоны Номыг санагтун”	19
5 “Энэ бол илчлэлтийн Сүнс болой”	27
6 “Ариун Сүнсээр оюунд чинь мөн зүрх сэтгэлд чинь би чамд ярих болно”	33
7 “Сайн мэдээний анхдагч зарчмууд ба ёслолууд”	40
8 Санваарын сэргээлт	47
9 “Цорын ганц үнэн бөгөөд амьд Сүм”	54
10 “Энэ бол бүгдэд хандах миний дуу хоолой болой”	60
11 “Талбай цагаан, хадахад бэлэн байна”	66
12 “Миний хүмүүсийн цугларалт”	72
13 “Энэ үеийнхэн миний үгийг чамаар дамжуулан хүлээн авах болно”	79
14 Өргөлийн хууль	85
15 “Та нар хамгийн шилдэг бэлгүүдийг хичээнгүйлэн эрэлхийл”	92
16 “Чи . . . миний ариун өдөр ариун ёслолуудаа өргөх ёстой”	99
17 Аравны нэгийн ба мацгийн хууль	106
18 “Бурханы өргөөг . . . байгуул”	113
19 Авралын төлөвлөгөө	120
20 Алдар суугийн хаант улсууд	126
21 “Их Эзэний Аугаа Өдөр ирэхийг хүсэн хүлээх нь”	132
22 Мэргэн Ухааны Үг: “Амлалт бүхий зарчим”	138
23 “Чи . . . миний ариун өдөр ариун ёслолуудаа өргөх ёстой ”	145
24 “Бүү мэхлэгд, харин гуйвшгүй байдалд үргэлжлүүл”	153
25 Санваар: “Бурханлиг чанарын хүч”	160
26 “Бүх дэлхий рүү явагтун та нар, мөн сайн мэдээг номлогтун”	166
27 “Тэд бүр Абрахамын адилаар гэгсгээн цээрлүүлэгдэж, мөн соригдох шаардлагатай байна”	172
28 “Ай Бурхан минь, Та хаана байна вэ?”	180

29	Иллинойн Наувуд Бурханы хаант улсыг байгуулсан нь	187
30	“Хоригдлууд чөлөөтэйгөөр явах болно”	195
31	“Энэ амьдралд болон бүх үүрд мөнхөд. . . лацдан холбогдох нь”	201
32	“Гэрчлэлийг лацдахын тулд”	209
33	Ерөнхийлөгч Бригам Янг Гэгээнтнүүдийг удирдсан нь	216
34	Алхам тутам дахь итгэл	223
35	“Авралын үүрэг”	230
36	“Зэлүүд газар, цөл баярлан, замар цэцэг мэт дэлгэрнэ”	237
37	“Бурхан минь, Бошиглогч илгээсэн Танд баярлалаа”	243
38	“Миний өөрийн арга замаар”	251
39	“Хүүхдүүдийн зүрх сэтгэл эцгүүд рүүгээ эргэх болно”	258
40	Ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажилд баяр баяслыг олох нь	265
41	“Гишүүн бүр номлогч”	271
42	Хожмын үеийн Бошиглогчдод илчлэлт ирсээр байгаа нь	278
43	“Миний өвч хуяг дуулгыг өөрсөд дээрээ авагтун”	285
44	Сайн иргэд байх нь	292
45	“Гэр бүл Бурханаас томилогддог”	298
46	“Сион зүрх сэтгэлдээ тэд цэвэр ариун болой”	305
	Сүмийн түүхийн он дараалал	312
	Газрын зураг 1: Нью-Йорк, Пеннсилвани ба Нэгдсэн Улсын Огайогийн бүс нутаг	314
	Газрын зураг 2: Миссури, Иллиной, Нэгдсэн Улсын Айовагийн бүс нутаг	315
	Газрын зураг 3: Сүм Өрнөд рүү шилжсэн нь	316

Багшид зориулсан тусламжууд

Энэ жилийн судлах цуврал хичээл бол Сургаал ба Гэрээ болон Сүмийн түүх. Сургаал ба Гэрээ бол Бошиглогч Иосеф Смит болон Сүмийн Ерөнхийлөгчийн Зөвлөл дэх түүний зарим залгамжлагчдаар дамжуулан өгөгдсөн бошиглол, үзэгдэл, зарлиг болон сургаалуудын түүвэр юм. Судрын энэ ном “эдгээр хожмын өдрүүдэд Сүмийн суурь, мөн дэлхийд ашиг тус болж, бидний Аврагчийн хаант улсын нууцын түлхүүрүүд хүмүүнд дахин итгэмжлэн өгөгдсөн” (С ба Г 70-ын тойм)-г харуулаа хэмээн Бошиглогч онцлон тэмдэглэжээ. Энэ номон дахь илчлэлтүүд Сүмийн түүхийн үндсэн хэсгийг бүрдүүлдэг. Мөн “хэрэгтэй цагт залбирлын хариу болж ирсэн бөгөөд бодит хүмүүс оролцсон үнэн бодит амьдралын нөхцөл байдлаас үүдэлтэй юм” (Сургаал ба Гэрээний тайлбар оршил).

Сургаал ба Гэрээ болон Сүмийн түүхээс сайн мэдээг заахдаа өнгөрсөн үеэс талархал, одоо үеэс хүч чадал, ирээдүйгээс найдварыг олоход нь та ангийн гишүүдэд тусалж чадна. Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлсэн нь:

“Энэхүү агуу зарчмын өнгөрсөн үе хичнээн алдар суутай билээ. Өнгөрсөн үе баатарлаг үйлс, эрэлхэг зориг, итгэл бишрэлээр дүүрэн юм. Их Эзэний үйлчлэгчдийн захиасыг сонсож дагах аль ч газрын хүмүүсийн амьдралыг адислахын төлөө бид урагшлан ахиж байгаа өнөө үе хичнээн гайхалтай билээ. Бүхнийг Чадагч алдар суут ажлаа үргэлжлүүлэн, Түүний сайн мэдээг хүлээн авч, үүгээр амьдрах бүх хүмүүст сайн сайхнаар нөлөөлж, дэлхийн Гэтэлгэгчийг хайрлах хайраар зүрх сэтгэл нь дүүрсэн хүмүүсийн амь бие хайргүй ажлаар дамжуулан, Түүний хөвгүүд, охидын бүх үеийнхний мөнхийн адислалд хүрэх ирээдүй хичнээн гайхалтай билээ” (In Conference Report, 1995 оны аравдугаар сар, 95; *Ensign*, 1995 оны 11-р сар, 72).

Энэ цуврал хичээлийн зорилго

Дэс дарааллаар эсвэл хэсэг хэсгээр заахын оронд энэ цуврал хичээлүүд нь Сургаал ба Гэрээ болон Сүмийн түүхэнд заагддаг гол сэдвүүд дээр анхаарал төвлөрүүлдэг. Цуврал хичээлүүд дараах зүйлсээр та нарт туслах зорилготой юм:

1. Есүст ирж, мөнх амьдралыг өвлөхөд нь хувь хүмүүс, гэр бүлүүдэд шаардлагатай сэргээгдсэн сайн мэдээний сургаал, ёслол, гэрээнүүдийг заах.
2. Есүс Христийн сэргээгдсэн Сүмийн өнөө үеийн түүхийг заах.
3. Сүнснийг хичээлд урих.
4. Судруудыг ойлгох, судруудад дуртай болоход нь ангийн гишүүдэд туслах.
5. Сайн мэдээний үнэнүүдийг амьдралдаа хэрэглэхэд нь ангийн гишүүдэд туслах.
6. Бие биедээ зааж, бие биенээ гэгээрүүлэхэд нь ангийн гишүүдийг урамшуулан дэмжих.
7. Сүмийн түүхэн дэх өөрсдийнх нь үеийн ач холбогдлыг ойлгоход нь ангийн гишүүдэд туслах. Энэ үе бол тэд агуу өвийг уламжлан авсан, Их Эзэний ажлыг урагш ахиулах үүргээ баяр баясалтайгаар биелүүлж чадах үе юм.

Таны ашиглах ёстой материал

Энэ цуврал хичээлүүдийг бэлтгэж, заахдаа дараах материалыг ашиглах ёстой:

1. Судрууд (хуудас ix дээрх “Судруудаас заах нь”-ыг үз).
2. Багшийн гарын авлага (доорх “Энэ гарын авлагыг хэрхэн ашиглах вэ” хэсгийг үз).
3. *Сургаал ба Гэрээ болон Сүмийн Түүхийн Ангийн Гишүүний Судлах Удирдамж* (35686) нь хичээл бүрд зориулсан унших даалгавар, ярилцлагын зарим асуултыг агуулдаг. Хичээл бүрд бэлтгэхдээ, *Судлах Удирдамж* дахь материалыг хэрхэн ашиглахыг анхааралтай авч үз. Хэрэв ангийн гишүүд унших даалгаврыг судалсан мөн хариулахад тэдний бэлтгэх асуултуудыг та асуусан бол тэд илүү сайн оролцох боломжтой байна. *Судлах Удирдамжийг* хувиараа судлах, гэр бүлээрээ ярилцахад ашиглахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Ангийн гишүүн бүр *Судлах Удирдамжтай* байх ёстой. *Судлах Удирдамжийн* хувиудыг та Ням гарагийн хичээлийн Ерөнхийлөгчийн Зөвлөл, тойргийн бичиг хэргийн ажилтан, материал хариуцдаг тойргийн бичиг хэргийн ажилтны туслахаас хүлээн авч болно.

4. *Бидний Өв: Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Товч Түүх* (35448). Бошиглогч Иосеф Смитийн үеэс өнөө үеийг хүртэлх Сүмийн түүхийн сүнсээр нөлөөлөгдсөн шастир энэ номд агуулагддаг. Эл номон дахь олон шастирыг хичээл дээр ярилцах болно.

Ангийн гишүүн бүрд *Бидний Өв* ном нэг байх ёстой (мөн бүрд нэг ном). Олон гишүүнд энэ ном байх болно. Та энэ номыг Ням гарагийн хичээлийн Ерөнхийлөгчийн Зөвлөл, тойргийн бичиг хэргийн ажилтан эсвэл материал хариуцдаг тойргийн бичиг хэргийн ажилтны туслахаас хүлээн авч болно. Хэрэгтэй бол нэмэлт хувиудыг захиалахад бичиг хэргийн ажилтан тусалж чадна.

5. *Сургаал ба Гэрээ болон Сүмийн Түүхийн видео хуурцгууд*, (53912) *Teachings from the Doctrine and Covenants and Church History видео танилцуулгууд* (53933). Эдгээр видео хуурцгууд хичээлд нэмэлт болох танилцуулгыг агуулдаг. Эдгээрийг ашиглах зөвлөмжүүд эл гарын авлага дахь олон хичээлийн “Нэмэлт заах санаанууд” хэсэгт буй. Дээрх видео танилцуулгууд сайн мэдээний зарчмууд болон Сүмийн түүхийн талаарх ангийн гишүүдийн ойлголтыг өргөжүүлж чадна. Гэвч видео танилцуулгыг хэт олон удаа ашиглахгүй байх эсвэл судар дээр тулгуурласан ярилцлагыг орлуулахгүй байхад анхаар.

Сайн мэдээний үндсэн зарчмуудыг заахад тусламж авахын тулд оршил дахь заавар болон дараах эх сурвалжуудад ханд:

“Сайн мэдээний заалт ба удирдлага,” *Сүмийн Заавруудын Гарын Авлага*, 2-р ном 16-р хэсэг: *Санваартны болон туслах бүлгүүдийн удирдагчид* (35209 эсвэл 35903)

Teaching, No Greater Call, 1999 оны хэвлэл (36123)

Заах Удирдамж (34595)

Энэ гарын авлагыг

хэрхэн ашиглах вэ Энэ гарын авлага бол Судрууд болон Сүмийн түүхээс сайн мэдээний сургаалуудыг заахад тань туслах хэрэгсэл юм. Эл гарын авлагыг Сайн мэдээний

Сургаалуудын ангийн залуучууд болон насанд хүрэгчдэд зориулсан бөгөөд дөрвөн жил тутамд хэрэглэх ёстой. Хичээл заахад нэмэлт эшлэлүүд болон зөвлөмжүүдийг ашиглах шаардлагагүй. Ахлагч М.Рассел Баллард хэлсэн нь:

“Нэмэлт материалуудыг ашиглахаасаа өмнө судар болон гарын авлагуудаа анхааралтай судалж байхыг багш нарт хичээнгүйлэн зөвлөж байна. Судар, гарын авлагуудыг бүрэн нэгтгэж үзэлгүйгээр батлагдсан сургалтын материалуудаас гаждаг багш нар олон байдаг бололтой. Хэрэв тухайн хичээлийг заахад судар, гарын авлагуудаас гадна зарим сайн нэмэлт материалыг ашиглах хэрэгтэй гэж багш нарт санагдвал, юуны өмнө Сүмийн сэтгүүлүүдийг л ашиглахыг хичээх ёстой” гэж хэлжээ (In Conference Report, 1983 оны 4-р сар, 93; *Ensign*, 1983 оны 5-р сар, 68).

Хичээл бүрийг долоо хоногийн өмнө нэгтгэн дүгнэж үз. Унших даалгавар болон хичээлийн материалыг эрт судалснаар хичээл заахад чинь туслах санаанууд долоо хоногийн туршид танд төрөх болно. Долоо хоногийн туршид тухайн хичээлийг тунгаан бодох үедээ, өөрийг тань удирдах Сүнсний төлөө залбирч бай. Их Эзэн өөрийг тань адислахуйц итгэлтэй бай.

Энэ гарын авлага дахь хичээл бүр нь нэг удаагийн хичээлээр зааж болохоос илүү их мэдээллийг агуулсан байгаа. Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох судрын шастир, асуултууд, хичээлийн бусад материалыг сонгож авахдаа Их Эзэний Сүнсийг эрэлхийл. Ангийн гишүүдийн нас, сонирхол, боловсролын төвшинг байнга харгалзаж бай.

Энэ гарын авлага 46 хичээлтэй. Таны заах ням гараг 46-гаас илүү байж болох учир, зарим үед та нэг хичээлийг хоёр хичээл болгон салган зааж болно. Энэ нь хичээл 4, 7, 27 зэрэг урт хичээлүүдийн хувьд бүр ч хэрэгтэй байж болно.

Хичээл нь дараах хэсгүүдтэй байна:

1. *Зорилго*. Тухайн хичээлд бэлтгэж, заахдаа анхаарвал зохих гол санааг зорилго тодорхойлдог. Зорилго нь хичээлийн үр дүнд ангийн гишүүд юуг ойлгосон байх ёстойг илэрхийлдэг.
2. *Бэлтгэл*. Энэ хэсэг нь тухайн хичээлийг төлөвлөхөд ашиглах судрын шастир, бусад материалын жагсаалт юм. Энэ хэсэгт материалыг ангид авчрах болон бэлтгэл хангах бусад зөвлөмж орж болно. Эдгээр материалуудын ихэнх нь цуглааны байрны номын санд байдаг. (Зөвлөмж болгосон материалын нэрний дараах таван оронтой тоо бол зүйлийн дугаар юм. Хэрэв зураг нь Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулгад орсон бол дугаарыг [34730] бас заасан байдаг.)
3. *Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа*. Энэ хэсэг нь суралцах, оролцох, Сүнсний нөлөөг мэдрэхэд нь ангийн гишүүдэд туслах суралцах энгийн үйл ажиллагаанаас бүтсэн байдаг. Та гарын авлагын анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг эсвэл өөрийнхөө үйл ажиллагааг ашиглана уу ялгаагүй, ангийн гишүүдийн анхаарлыг хичээлийн эхлэлд төвлөрүүлэх нь чухал. Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа богинохон байх ёстой.
4. *Ярилцах ба хэрэгжүүлэх нь*. Энэ бол хичээлийн үндсэн гол хэсэг. Түүхэн шастируудыг үр ашигтайгаар зааж, ярилцахын тулд судрыг залбирч судал. “Судруудаас заа” (хуудас ix), “Анги дахь ярилцлагыг урамшуулан дэмж” (хуудас ix-x) хэсгүүд дэх зөвлөмжүүдийг заах арга барилаа өөрчлөх, ангийн гишүүдийн сонирхлыг татахын тулд ашигла. Тэдний нас, туршлагад тохирох асуултууд болон аргуудыг сонгож ав.

5. *Дүгнэлт*. Энэ хэсэг нь тухайн хичээлийг нэгтгэн дүгнэж, ярилцсан зарчмуудаараа амьдрахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмжихэд тань тусална. Энэ нь бас гэрчлэлээ хэлж байхыг тань сануулдаг. Хичээл бүрийг нэгтгэн дүгнэхэд хангалттай цаг гаргахад анхаар.

6. *Нэмэлт заах санаанууд*. Энэ хэсэг гарын авлагын ихэнх хичээлүүдэд байгаа. Эл хэсэг судрын шастир, үйл ажиллагаанууд, эсвэл хичээлийг тоймлон төлөвлөхөд нэмэлт болдог бусад зөвлөмжүүдээс үнэнүүдийг нэмж оруулдаг.

Эл гарын авлага Сүмийн түүхийн он дараалал (хуудас 312-313), Сүмийн түүхийн чухал газруудын гурван газрын зургийг агуулдаг (хуудас 315-316). Олон хичээл эдгээр эх сурвалжуудтай холбогддог, эдгээр нь бас *Ангийн Гишүүний Судлах Удирдамжид* (хуудас 27-31) орсон байгаа.

Сүнсээр заах нь

Сайн мэдээг заахаар бэлтгэхдээ Ариун Сүнсний нөлөө, удирдамжийг эрэлхийлэх нь чухал юм. “Сүнс итгэлийн залбирлаар та нарт өгөгдөх болно; мөн хэрэв та нар Сүнсийг эс хүлээн авбаас та нар заах нь үгүй” (С ба Г 42:14) гэж Их Эзэн хэлжээ. Хичээл дээр нь Ариун Сүнс багш байх ёстойг санагтун.

Залбирч, мацаг барин, судрыг өдөр бүр судалж, зарлигуудыг сахиснаар та Сүнсийг эрэлхийлж чадна. Хичээлд бэлтгэхдээ, судруудыг болон ангийн гишүүдийн хэрэгцээг сайн ойлгохын тулд Сүнсийг хүсэн залбирч бай. Судруудын тухай ярилцах, өнөө үед судрыг хэрэглэх үр ашигтай арга хэлбэрийг төлөвлөхөд Сүнс танд тусалж чадна.

Хичээлдээ Сүнсийг урих зарим зөвлөмжийг доор өгөв:

1. Хичээлийн өмнө болон дараа залбирч байхыг ангийн гишүүдээс хүс. Хичээлийн үед Сүнс өөрийг чинь удирдаж, ангийн гишүүдийн зүрх сэтгэлийг нээж, гэрчлэх болон бурханлигаар нөлөөлөхийн тулд зүрх сэтгэлдээ залбир.
2. Судруудыг (энэ хуудсан дээрх “Үнэн сургаалыг заах нь”, хуудас ix дээрх “Судруудаас заа”) ашигла. Сонгож авсан хэсгүүдийг ангийн гишүүдээр чангаар уншуул.
3. Зөвхөн хичээлийн төгсгөлд төдийгүй, Сүнс өөрийг чинь өдөөсөн үед хэдийд ч хамаагүй гэрчлэлээ хэлж бай. Есүс Христийн тухай гэрчил. Гэрчлэлээ хэлэхэд нь ангийн гишүүдийг байнга урьж бай.
4. Сүнсийг мэдрэхэд ангийн гишүүдийг сүнслэг байдалд бэлтгэхийн тулд дуулал, Хүүхдийн Хэсгийн дуунуудыг ашигла.
5. Ангийн гишүүд, бусад хүмүүс, Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийг хайрлах хайраа илэрхийл.
6. Тохиромжтой үед тухайн хичээлтэй холбоотой ойлголт, мэдрэмж, туршлагыг хуваалц. Мөн үүндээ ангийн гишүүдийг урь. Өмнөх хичээлүүд дээр ярилцсан зарчмуудыг ангийн гишүүд хэрхэн хэрэглэж байгаа тухайгаа бас ярьж болно.

Үнэн

сургаалыг заа

Арванхоёрын Чуулгын Ахлагч Бойд К.Пакер, “Зөв ойлгогдсон сургаал харьцаа хандлага, зан төлөвийг өөрчилдөг” хэмээн сургажээ (In Conference Report, 1986 оны 10-р сар, 20; *Ensign*, 1986 оны 11-р сар, 17).

Хичээлд бэлтгэж заахдаа судрууд болон хожмын үеийн бошиглогчдын сургаалуудад байдаг сайн мэдээний аврагч сургаалууд дээр анхаарал төвлөрүүл. Ийнхүү анхаарал төвлөрүүлэх нь судруудыг хичээнгүйлэн залбирч судлахыг танаас шаардана. “Миний үгийг тунхаглахыг бүү эрэлхийл, харин эхлээд миний үгийг олж авахыг эрэлхийл, тэгвэл хэл чинь чөлөөтэй байх болно; тэгээд, хэрэв чи хүсэх аваас, миний Сүнс мөн миний үг, тийм ээ, хүмүүнийг итгүүлэх Бурханы хүч чамд байх болно” (С ба Г 11:21) хэмээн Их Эзэн зарлиг болгосон билээ.

Судруудаас заа

Сайн мэдээний сургаалуудыг заахад судруудыг ашиглах нь агуу хүч юм. Судрын сонгосон хэсгүүдийг хамтдаа уншихын тулд судраа долоо хоног бүр ангидаа авчирч байхад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Судрын шастируудыг үр ашигтайгаар, бас өөр өөр байдлаар заахын тулд дараах зөвлөмжүүдийг ашигла:

1. Судрууд Есүс Христийн тухай юу зааж байгааг ойлгоход нь ангийн гишүүдэд тусал. Аврагчид итгэх итгэлийг нь нэмэгдүүлж, Түүний хайрыг мэдрэхэд нь судрын тодорхой хэсгүүд хэрхэн тусалдагт анхаарлаа хандуулахыг тэднээс хүс.
2. Сонгож авсан хэсгүүдэд нэрээ орлуулан тавих замаар судруудад өөрсдийгөө байгаа мэтээр дүрслэхийг ангийн гишүүдээс хүс.
3. Судрын хэсгүүд бидний амьдралд хэрхэн холбогддогийг харуулахын тулд Сүмийн түүхэн дэх сүнслэг нөлөө бүхий түүхүүдийг хуваалц.
4. Судрын хэсэгт олон давтагддаг буюу тэдний хувьд онцгой утга учиртай үгс, өгүүлбэрүүд, санаануудыг ангийн гишүүдээр эрж олуул.
5. Судруудын Удирдамж, Библи болон гурамсан судрын индекс зэрэг Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн судруудын хэвлэлийн төгсгөл дэх судлах тусламжуудыг ашиглахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.
6. Судрын шастиртай холбоотой өгүүлбэр, түлхүүр үгс эсвэл асуултуудыг самбар дээр бич. Тэгээд уг шастирыг уншиж нэгтгэн дүгнэ. Ангийн гишүүд өгүүлбэр, түлхүүр үгс, асуултууд дээр ирэх үед зогсож, эдгээрийн тухай ярилц.
7. Ангийг хоёр буюу түүнээс олон жижиг бүлгүүдэд хуваа. Судрын шастирыг нэгтгэн дүгнэсний дараа уг шастирт заагддаг зарчим болон сургаалуудыг бүлэг бүрээр тэмдэглүүл. Дараа нь эдгээр сургаалууд өдөр тутмын амьдралд нь хэрхэн хэрэглэгддэгийг бүлгүүдээр ээлжлэн яриул.
8. Ангийн гишүүдийн хувьд онцгой учир холбогдолтой шүлгүүдийг тэмдэглүүлэхийн тулд харандаа авчирч байхыг сануул.

Анги дахь ярилцлагыг урамшуулан дэмж

Ер нь та лекц унших ёсгүй. Үүний оронд судруудын тухай ярилцахад зорилго чиглэлтэйгээр оролцоход нь ангийн гишүүдэд тусал. Анги дахь ярилцлагын талаарх Их Эзэний зөвлөгөө С ба Г 88:122-т байдаг: “Өөрсдийнхөө дунд багшийг томил, мөн бүгдээрээ нэг зэрэг яригчид бүү байг; бүгдээрээ ярихад бүгдээрээ бүхнээс сэнхэрсэн байж болохын тулд, мөн хүн болгон тэгш боломжтой байж болохын тулд нэг нь хэсэг хугацаанд ярьж, тэгээд бүгдээрээ түүний хэлэхийг сонсог.”

Анги дахь ярилцлагыг урамшуулан дэмжихийн тулд дараах удирдамжуудыг ашигла:

1. Тунгаан бодохыг өдөөсөн асуултууд асуу. *Яагаад, яаж, хэн, юу, хэзээ, хаана* гэсэн үгсээр эхэлсэн асуултууд ярилцлагыг урамшуулан дэмжихэд ихэвчлэн хамгийн үр ашигтай байдаг. Энэ гарын авлага дахь асуултуудыг судлахдаа Сүнсний удирдамжийг эрэлхийлж, алийг нь асуухаа шийд.
2. Ярилцаж байгаа судрын зарчмуудтай холбоотой туршлагыг товчхон хуваалцахад гишүүдийг урьж бай. Мөн судраас юу сурч мэдсэн тухай бодол санаагаа хуваалцахад нь тэднийг урамшуулан дэмжиж бай. Сүнслэг туршлага болон бодол санаагаа “болгоомжтойгоор мөн Сүнсний өдөөлтөөр” (С ба Г 63:64) хуваалцах ёстойг ойлгоход нь тэдэнд тусал. Зарим туршлага, бодол санааг хуваалцахад тохиромжгүй байдаг.
3. Ангийн гишүүн бүрийн хэрэгцээнд мэдрэмтгий бай. Хичээлд оролцоход нь ангийн бүх гишүүдийг урамшуулан дэмжих ёстой ч, зарим хүмүүс хариулахдаа эргэлзэн тээнэгэлзэж болно. Чангаар унших буюу хичээлд оролцох талаар юу гэж боддогийг нь мэдэхийн тулд та тийм хүмүүстэй ганцаарчлан ярилцаж болно. Ангийн гишүүдийн нэрийг дуудах нь тэднийг ичээж мэдэхээр байвал ингэхээс болгоомжил.
4. Зарим асуултын хариуг олоход нь ангийн гишүүдэд туслахын тулд судрын эшлэлүүдийг өг.
5. Хэрэв ангийн хэдхэн гишүүн ихэнхдээ ярилцлагад оролцож байвал ярилцлагад оролцдоггүй хүмүүсийг оролцуулах талаар хүчин чармайлт тавь. “Одоо өөр нэг хүний үгийг сонсоцгооё,” эсвэл “Энд яригдсан зүйл дээр нэмж хэлэх өөр хүн байна уу?” гэж хэлэх замаар та ярианы чиглэлийг аятайхан өөрчилж болох юм.

Бэлтгэсэн хичээлийнхээ бүх материалыг хамран заахаас илүүгээр судруудыг ойлгож, амьдралдаа хэрэглэхэд нь ангийн гишүүдэд туслах нь бүр ч илүү чухал юм. Хэрэв ангийн гишүүд сайн ярилцлагаас юм сурсан бол энэ нь хичээлийн бүх материалыг хамран заах гэж оролдсоноос илүү ашиг тустай байх нь олонтаа тохиолддог. Гэвч ярилцлага ашиг тусгүй эсвэл гэгээрүүлэгч биш байвал та үүнийг өөрчлөх ёстой.

Шинэ гишүүдэд туслах нь

Сүмд харьцангуй шинээр ирсэн гишүүдэд заах боломж танд тохиолдож болно. Итгэлээрээ бат бөх болоход нь эдгээр гишүүдэд таны заалт тусалж чадна. “Сүмийн гишүүн бүр, ялангуяа баптисмын дараах эхний хэдэн сард хайрлуулж, тэжээн тэтгэгдэж байх хэрэгтэй. Шинэ гишүүд чин сэтгэлийн нөхөрлөл, үйлчлэх боломж, түүнчлэн Бурханы үгийг судалснаас ирдэг Сүнсний тэжээлтэй болсноор удаан үргэлжлэгч хөрвүүлгийн үйл явцыг биеэр туулан, ‘ариун хүмүүсийн адил нутгийн иргэд, Бурханы гэр бүлийнх’ (Ефес 2:19) болдог билээ” гэж Тэргүүн Зөвлөл хэлжээ: (Тэргүүн Зөвлөлийн захидал, 1997 оны 5-р сарын 15).

Сайн мэдээг залуучуудад заах нь

Хэрэв та залуучуудад заадаг бол идэвхтэй оролцооноос гадна ярилцаж байгаа сургаалуудыг үзүүлэн хэрэглэж заах нь илүү нөлөөтэйг сана. Үйл ажиллагаа, видео танилцуулга, энэ гарын авлагад зөвлөмж болгосон зургуудыг ашиглах нь хичээлд сонирхолтой байхад нь залуучуудад тусалж чадна.

Сургаал ба Гэрээ болон Сүмийн Түүхийн оршил

Хичээл
1

Зорилго Сургаал ба Гэрээ болон Сүмийн түүхийг энэ жил судлахыг ангийн гишүүдэд танилцуулж, цаг хугацааны бүрэн байдлын эрин үе дэх байр сууриа ойлгоход нь тэдэнд туслах.

- Бэлтгэл**
1. Дараах судрууд болон бусад материалыг залбирч судал:
 - а. Сургаал ба Гэрээ; Сургаал ба Гэрээ 1-ийн оршил тайлбар.
 - б. *Бидний Өвийн* оршил.
 2. *Сургаал ба Гэрээ болон Сүмийн Түүхийн ангийн гишүүний Судлах Удирдамж* (35686)-ийн нэг хувийг ангийн гишүүн бүр олж авах. Эдгээр номуудыг та Ням гарагийн хичээлийн Ерөнхийлөгчийн Зөвлөл, тойргийн бичиг хэргийн ажилтан, материал хариуцдаг тойргийн бичиг хэргийн ажилтны туслахаас авах хэрэгтэй. *Судлах Удирдамж* дахь энэ хичээлийн материалыг нэгтгэн дүгнэж, хичээлийн үед хэрэглэх арга хэлбэрийг төлөвлө.
 3. Ангийн гишүүн бүр хувиараа судлахад зориулж *Бидний Өв: Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Товч түүх* (35448)-ийн нэг номтой (айл бүрд нэг ном) байхаар бодож, энэ номыг хангалттай тоогоор олж ав. Олон гишүүн энэ номыг олж авсан байгаа. Та энэ номын хувиудыг Ням гарагийн хичээлийн Ерөнхийлөгчийн Зөвлөл, тойргийн бичиг хэргийн ажилтан, материал хариуцдаг тойргийн бичиг хэргийн ажилтны туслахаас авч болно. Хэрэгтэй бол нэмэлт хувиудыг захиалахад бичиг хэргийн ажилтан тусалж чадна.
 4. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах бол Солт Лейкийн Ариун сүмийн зургийг (62433; Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 502) ангид авчир.
-

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

Солт Лейкийн Ариун сүмийн зургийг үзүүл. Тэнгэр элч Моронай дээр нь зогсож байгаа Ариун сүмийн орой дээрх бөмбөгөрийг зааж, уг бөмбөгөрийн дээд талын хагас нь Солт Лейкийн Ариун сүмийн оройн чулуу юм гэдгийг тайлбарла. 1892 оны дөрөвдүгээр сарын 6-нд Сүм Табернеклд ерөнхий чуулган хийжээ. Үдийн өмнөхөн Ерөнхийлөгч Вилфорд Вудрафф цуглааныг тараав. Ариун сүмийн Талбай дээр дөчин мянган хүн цуглаж, мянга мянган хүн талбайг эргэн тойрон хүрээлсэн байжээ. Ерөнхийлөгч Вудрафф цахилгаан товчин дээр дарахад оройн чулуу байрандаа доошлон бууж ирэв.

Тэртээ доор Табернеклын Найрал Дуу хөгжмийн бүлгийн аяар “Бурханы Сүнс” дууллыг дуулж эхлэхэд Гэгээнтнүүд даган дууллаа. Дараа нь тэд Солт Лейкийн Ариун сүм бараг дуусах шахсанд баярласнаа харуулан Хозанна хэмээн хашгирч, цагаан алчуураар даллаж байлаа.

Сүмийн 13 дахь Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон Сургаал ба Гэрээ манай шашны оройн чулуу байж чадахыг дүрслэн тайлбарлахдаа:

“Сургаал ба Гэрээ хүмүүсийг Есүсийн хаант улс, бүр ‘бүх дэлхийн гадаргуу дээрх цорын ганц үнэн бөгөөд амьд сүм,’ Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд авчирдаг [С ба Г 1:30]. . . .

“Мормоны Ном манай шашны ‘суурийн чулуу’, харин Сургаал ба Гэрээ бол хожмын үеийн үргэлжлэгч илчлэлт бүхий оройн чулуу нь юм. Их Эзэн батлах тамгаа суурийн чулуу, оройн чулуу хоёр дээр аль алин дээр нь дарсан юм” гэжээ (In Conference Report, 1987 оны 4-р сар, 105; *Ensign*, 1987 оны 5-р сар, 83).

Суурийн чулуу, оройн чулуу нь манай шашны булангийн чулуу (Ефес 2:20) болох Аврагчийн тухай бидэнд заадгийг гэрчил. Эдгээр судрууд Аврагч болон Түүний сайн мэдээ үнэн болохыг мөн гэрчилдэг.

Ярилцах ба
хэрэгжүүлэх нь

Энэ хичээл нь нэг хичээл дээр заах боломжтойгоос илүү их материалыг агуулдаг. Ангийн гишүүдийн хэрэгцээг хамгийн сайнаар хангах хичээлийн материалыг залбирч, сонго.

Энэ цуврал хичээл нь Сургаал ба Гэрээ болон Сүмийн түүхийг судлахад сэдвийн хэлбэрийг ашигладгийг тайлбарла. Сайн мэдээний тусгай сэдвүүдийн талаар Сургаал ба Гэрээ болон Сүмийн түүхийн заадаг зүйлүүдийг мэдэж, амьдралдаа хэрэглэхэд нь ангийн гишүүдэд туслах зорилгыг эдгээр хичээлүүд агуулдаг. Энэ жил суралцсаны үр дүнд ангийн гишүүд сайн мэдээний адислалуудыг эрэлхийлэх илүү их хүсэлтэй болсон байх ёстой.

Энэ жилийн хичээлүүд нь сэдэвчилсэн байгаа учраас Сургаал ба Гэрээний зарим хэсгүүд унших даалгавруудад ороогүйг хэл. Гэсэн ч ангийн гишүүд тухайн жилийн туршид Сургаал ба Гэрээг бүхэлд нь уншихаар төлөвлөх ёстой.

Ангийн гишүүний Судлах Удирдамж товхимлуудыг тарааж өг. Энэ судлах удирдамж нь хичээл бүрийн унших даалгавар, ярилцлагын асуултуудыг агуулдгийг тайлбарла. Эдгээр даалгавруудыг унших шийдвэр төгс байж, долоо хоног бүрийн хичээлд бэлтгэж байхад ангийн гишүүдийг урь. Долоо хоног тутмын даалгаврыг унших хэвшлийг хэрхэн бий болгох тухай санаа бодлоо хуваалцахыг тэднээс хүс.

Бидний Өв номыг үзүүлж, айл болгонд нэг ном байхаар бодож, номоор ханга. Энэ ном Бошиглогч Иосеф Смитийн үеэс өнөө үеийг хүртэлх Сүмийн түүхийн сүнслэг нөлөө бүхий шастирыг агуулдгийг тайлбарла. Ангийн гишүүд энэ номыг жилийн туршид унших ёстой. Түүхийн ихээхэн хэсгийг хичээл дээр ярилцах болно.

Энэ цуврал хичээлийг амжилттай болгох хариуцлагыг ангийн гишүүд хуваалцдагийг хэл. Хичээлд оролцохоор бэлтгэхэд нь, сайн мэдээний зарчмуудыг амьдралдаа хэрхэн хэрэглэх туршлагаа хуваалцахад нь тэднийг урамшуулан дэмж.

1. Сургаал ба Гэрээн дэх илчлэлтүүд манай өнөө үеийн хэрэгцээий тухай өгүүлдэг.

- Сургаал ба Гэрээний эхэнд байдаг Тайлбар Удиртгалын гурав дахь догол мөрийг (энэ догол мөр “Сургаал ба Гэрээ ном бол” гэсэн гэсэн нийлэмж үгээр эхэлдэг) унш. Сургаал ба Гэрээ судрын бусад номуудаас ямар ялгаатай вэ? Сургаал ба Гэрээн дэх ямар хэсгүүд та нарын хувьд онцгой хэрэгтэй мөн учир холбогдолтой вэ?
- Тайлбар Удиртгалын зургаа дахь догол мөрийг (энэ догол мөр “Эдгээр ариун илчлэлтүүд” гэсэн нийлэмж үгээр эхэлсэн байгаа) унш. Сургаал ба Гэрээн дэх илчлэлтүүд хэрхэн хүлээн авагдсан тухай энэ догол мөр юу зааж байна вэ? Ихэнх илчлэлтүүд залбирлын хариу болж ирснийг ойлгох нь яагаад ашигтай вэ?
- Тайлбар Удиртгалын найм дахь догол мөрийг (энэ догол мөр “Сайн мэдээний номлолууд” гэсэн нийлэмж үгээр эхэлсэн байгаа) унш. Сургаал ба Гэрээнд сайн мэдээний ямар сургаалууд тайлбарлагддаг вэ? (Эдгээр сургаалуудаас хоёр эсвэл гурвыг сонгож, Сургаал ба Гэрээнд илчлэгдсэн үнэнүүдгүйгээр бидний амьдрал хэрхэн өөр байх байсныг ярилц)

2. Их Эзэн Сургаал ба Гэрээний удиртгалыг зохиосон юм

Дараах мэдээллийг нэгтгэн дүгнэх замаар Сургаал ба Гэрээний хэсэг 1-ийг танилцуул:

1831 оны арваннэгдүгээр сарын 1-нд, Бошиглогч Иосеф Смит Огайогийн Хайрамд болсон ахлагч нарын тусгай чуулганыг тэргүүлж байв. Чуулганд оролцогчид Бошиглогчийн хүлээж авсан илчлэлтүүдийн заримыг нь эмхтгэн, Зарлигуудын Ном гэсэн нэг ном болгон хэвлүүлэхээр шийджээ. Энэ чуулганы анхны хуралдааны дараа “миний зарлигуудын номны оршил” (С ба Г 1:6) хэмээн Өөрийнхөө нэрлэсэн нэг илчлэлтийг Их Эзэн Иосеф Смитэд өгч, хэвлүүлэхийг сайшааж байгаагаа мэдэгдсэн ажээ. Энэ илчлэлт бол эдүгээ Сургаал ба Гэрээний хэсэг 1 юм.

“Сургаал ба Гэрээ бол оршлыг нь Их Эзэн Өөрөө бичсэн, дэлхий дээрх цорын ганц ном мөн. Уг оршилд Түүний дуу хоолой бүх хүмүүнд хандсаныг (ш.2-ыг үз), Их Эзэний ирэлт ойртож байгааг (ш.12-ыг үз), Сургаал ба Гэрээн дэх үнэнүүд гүйцэлдэх болно (ш.37-38-ыг үз) гэдгийг Тэрээр тунхагласан юм” хэмээн Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон хэлжээ (In Conference Report, 1986 оны 10-р сар, 101; *Ensign*, 1986 оны 11-р сар, 79).

- С ба Г 1-д, Их Эзэн “сэрэмжлүүлгийн дуу хоолойг” өргөж, Сургаал ба Гэрээний (С ба Г 1:4) эхнээс дуустал үргэлжлүүлсэн юм. Энэ хэсэгт Их Эзэн ямар сэрэмжлүүлгүүд өгсөн байна вэ? (С ба Г 1:7-10, 12-16, 31-33-ыг үз. Та эдгээрийг самбар дээр жагсаан бичиж болно) Эдгээр сэрэмжлүүлэг бидэнд ямар хамааралтай вэ?
- Сургаал ба Гэрээний захиасууд хэнд зориулагдсан бэ? (С ба Г 1:1-4, 11, 34-35-ыг үз.) Эдгээр захиасууд бүх хүмүүст яаж очих ёстой вэ? (С ба Г 1:4-ийг үз.)
- С ба Г 1-д Их Эзэн хожмын үеийн ажлынхаа агуу ирээдүйг угтан хэлсэн байдаг (С ба Г 1:23, 30). Их Эзэн энэ хэсгийг илчлэх үед Сүм зохион байгуулагдаад дөнгөж жил хагас болж байсныг мөн ердөө хэдхэн зуун гишүүнтэй байсныг тайлбарла. Сүмийн өсөлт хөгжилтийн тухай бошиглолууд манай өнөө үед хэрхэн биелэгдэж байна вэ?

- С ба Г 1, Их Эзэн Сургаал ба Гэрээн дэх илчлэлтүүдийн зарим зорилгыг тайлбарлажээ. С ба Г 1:17-28-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Эдгээр шүлгүүдэд цэдэглэгдсэнээр илчлэлтийн зорилго юу вэ? (Хариулт нь доор дурдсан өгүүлбэрүүд байж болно)
 - а. “Хүн болгон Их Эзэн Бурханы, бүр дэлхийн Аврагчийн нэрээр ярьж болохын тулд буюу” (С ба Г 1:20).
 - б. “Тэрхүү итгэл бас өсч болохын тулд буюу” (С ба Г 1:21).
 - в. “Тэрхүү миний үүрдийн гэрээ үндэслэгдэн бий болж болохын тулд буюу” (С ба Г 1:22).
 - г. “Миний сайн мэдээний бүрэн байдал тунхаглагдаж болохын тулд буюу” (С ба Г 1:23).
 - д. “Ойлголтод хүрэхэд” (С ба Г 1:24) нь Их Эзэний үйлчлэгчдэд туслахын тулд юм.
 - е. “Мөн тэд алдаа гаргахын хэрээр энэ нь мэдэгдэж болохын тулд бөлгөө” (С ба Г 1:25).
 - ё. “Мөн тэд мэргэн ухааныг эрэлхийлэхийн хэрээр тэд зааварлагдаж болохын тулд бөлгөө” (С ба Г 1:26).
 - ж. “Мөн тэд нүгэл үйлдэхийн хэрээр тэд гэсгээн цээрлүүлэгдэж, наманчилж болохын тулд буюу” (С ба Г 1:27).
 - з. “Мөн тэд даруу байхын хэрээр тэд хүчирхэгжиж, мөн дээрээс адислагдан, мөн цагаас цагт мэдлэг хүлээн авч болохын тулд бөлгөө” (С ба Г 1:28).
- Сургаал ба Гэрээнд зориулсан Их Эзэний удиртгал Түүний үгсийг судлах тухай зарлигаар төгсдөг. С ба Г 1:37-38, 18:34-36-г ангийн гишүүдтэй хамт унш. Эдгээр шүлгүүд дэх Түүний үгс, Түүний дуу хоолойн талаар Их Эзэн бидэнд юу зааж байна вэ? Судруудыг судлах нь судрыг зүгээр уншихаас ямар ялгаатай вэ? Сургаал ба Гэрээн дэх Их Эзэний үгсийг судалснаар та нар ямар ашиг тусыг олсон бэ?

3. Энэ цуврал хичээлээр цаг хугацааны бүрэн байдлын эрин үеийн гол үйл явдлуудын тухай ярилцах болно

Судруудын Удирдамжийн хуудас 241-г ангийн гишүүдээр гаргуул. *Эрин үеүд* гэдэг үгийн тайлбарын эхний өгүүлбэрийг унш. Тэгээд энэ жилийн хичээлүүдээр манай эрин үе-цаг хугацааны бүрэн байдлын эрин үеийн гол үйл явдлуудаас олныг нь үзнэ гэдгийг тайлбарла (С ба Г 112:30-32). Бошиглогч Иосеф Смитийн дараах мэдэгдлийг хуваалц:

“Бошиглогчид, санваартнууд болон хаад . . . бидний амьдарч байгаа энэ үеийг баяр баясалтайгаар хүсэн хүлээсээр байлаа. Тэд тэнгэрлэгээр, баяр хөөртэй хүсэн хүлээлтээр сүнслэгээр нөлөөлөгдөж, манай өнөө үеийн тухай дуулж, бичин, бошиглож байв. Гэвч тэд манай өнөө үеийг үзэлгүйгээр нас барсан юм Бид бол хожмын үеийн алдар сууг тохиолгон авчрахаар Бурханаар сонгогдон, ивээгдсэн хүмүүс билээ. Хожмын үеийн алдар суу ‘цаг хугацааны бүрэн байдлын эрин үеийг’ харах, урагш ахиулахад оролцох, туслах нь бидний үүрэг юм” (*Teachings of the Prophet Joseph Smith*, эмхтгэсэн Жозеф Фиелдинг Смит [1976], 231).

- Манай эрин үе өмнөх бүх эрин үеүдээс яагаад ялгаатай байдаг вэ? (энэ эрин үе Урвалтаар төгсгөл болохгүй, Сүм газар дэлхийг дүүргэх хүртлээ,

мөн Их Эзэний Хоёр дахь Ирэлтийн зам бэлтгэгдэх хүртэл үргэлжлэн өсч хөгжинө гэдэг нь хариулт байж болно) Энэ эрин үед амьдарч буй учраас бидэнд ямар адислал, үүрэг хариуцлага байдаг вэ?

Энэ эрин үе түүхийн зургаан үед хуваагдаж болохыг тайлбарла. Эдгээр үеүдийг та дараах байдлаар самбар дээр бичиж болох юм:

Нью-Йоркийн үе	1820-1830 он
Огайо-Миссурийн үе	1831-1838 он
Наувугийн үе	1839-1846 он
Өрнөд рүү шилжсэн нь	1846-1898 он
Сүмийн өргөжилт	1899-1950 он
Дэлхий дахины Сүм	1951 оноос-одоог хүртэл

Түүхийн эдгээр зургаан үеийн чухал үйл явдлуудаас ихэнхийг нь энэ гарын авлагын хуудас 312-313 дээрх “Сүмийн Түүхийн Он Дараалал” түүнчлэн *Ангийн гишүүний Судлах Удирдамжийн* хуудас 27-28 дээр нэгтгэн дүгнэснийг хэл. Эдгээр үйл явдлуудыг ангийн гишүүдээр товч дүгнүүл.

- Сүмийн түүхэн дэх ямар үйл явдлууд та нарын хувьд онцгой учир холбогдолтой вэ?

4. Хожмын үеийн энэ агуу ажлыг урагш ахиулахад бид бүгд тусалж чадна

Анги дахь хүмүүсийг тойруулан харахыг ангийн гишүүдээс хүс. Энэ цаг үед бид дэлхий дээр байгаа нь тохиолдлын хэрэг биш гэдгийг тайлбарла. Эцсийн энэ эрин үед Түүний хаант улсыг байгуулахад туслахын тулд Бурхан биднийг илгээсэн. “Бидний байгаа цаг хугацааны энэ богинохон үеийг итгэлтнүүд хэзээ ч ийм ихээр хүсэн хүлээж байгаагүй юм” гэж Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон хэлжээ (In Conference Report, 1989 оны 10-р сар, 48; *Ensign*, 1989 оны 11-р сар, 36-гаас Марвин Ж.Аштон иш татжээ).

“Бидэнд тулгарч байгаа хамгийн ноцтой сорилт бас хамгийн гайхалтай сорилт бол өсөлт хөгжилтөөс үүдэлтэй сорилт юм” гэж Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлжээ (“Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли,” *Ensign*, 1995 оны 4-р сар, 6-гаас иш татав.

- Сүмийн асар хурдацтай өсөлтөөс үүдэлтэй зарим сорилтууд юу вэ? Эдгээр сорилтыг шийдвэрлэх Сүмийн хүч чармайлтын зарим жишээг хэлнэ үү? (Ариун сүм барих хэт хурдан өсөлт, санваартны удирдлагыг төлөвшүүлэх ажил, судруудыг олон хэлэнд хурдацтай орчуулж байгаа нь хариулт байж болно)

Бид Сүмийн өсөлтийг харж, сэтгэл догдлом байдлыг нь мэдэрч чадна гэдгийг онцлон тэмдэглэ. Гэвч өсөлтөд оролцохоос илүү дуу хоолойгоороо урамшуулан дэмждэг хүмүүс Их Эзэнд хэрэгтэй байдаг. Гэр бүлийн хувьд ч, хувь хүмүүсийн хувьд ч бид өөрсдөөсөө шаардагдах бүхнийг хийж байгаа бил үү? хэмээн өөрсдөөсөө асуух ёстой. Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли: “Энэ үе бол үй олон боломжийн үе мөн. Бид боломжуудаас чанга барьж, урагш ахих ёстой. Их Эзэний ажлыг гайхамшигт ирээдүй рүү нь урагш ахиулахад бидний хүн нэг бүр бага ч гэсэн хувь нэмрээ оруулах хичнээн гайхалтай үе билээ” хэмээн хэлжээ (In Conference Report, 1997 оны аравдугаар сар, 90-91; *Ensign*, 1997 оны арваннэгдүгээр сар, 67).

- Их Эзэний хожмын үеийн агуу ажлыг урагш ахиулахад туслахын тулд бид бүгд хувиараа болон гэр бүлээрээ юу хийж чадах вэ?

Дүгнэлт

Цаг хугацааны бүрэн байдлын үед амьдрах онцгой боломж бидэнд тохиосныг онцгойлон анхаар. Бид эрт дээр үед бошиглогдсоны дагуу Сүм урагшлан ахиж байгааг харж чадна (Даниел 2:44-45; мөн С ба Г 65:2-ыг үз). Бид сэргээгдсэн сайн мэдээний адислалуудыг хүртэж байна. Бид Сургаал ба Гэрээг унших үеэрээ Их Эзэний дуу хоолойг сонсдог. Бид амьд Бошиглогчоор удирдуулдаг. Энэ жил судлах цуврал хичээл нь энэ эрин үед амьдрахын боломжууд болон адислалуудын тухай илүү ихийг ойлгоход бидэнд туслах болно.

“Болгоогтун, Бибээр Есүс Христ, дэлхийн Аврагч болой”

Хичээл
2

Зорилго

Сургаал ба Гэрээгээр дамжин ирдэг Аврагчийн тухай хүчирхэг гэрчлэлийг мэдрэхэд нь мөн Аврагчийн Цагаатгалын тухай гэрчлэлээ бэхжүүлэхэд нь ангийн гишүүдэд туслах.

Бэлтгэл

1. Энэ хичээл дэх судруудыг залбирч судал. Хуудас 10 дээрх судрын хэсгүүдийг судлахдаа ангийн гишүүдэд аль нь хамгийн ашиг тустай байхыг анхаар. Сонгож авсан судрын хэсгүүдийг өөрөө сайн эзэмшиж, хичээлд ашиглахаар бэлтгэ.
2. *Ангийн гишүүний Судлах Удирдамж* (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.
3. Хэрэв дараах зургууд байвал хичээлийн үед ашиглахаар бэлтгэ: Их Эзэн Есүс Христ (62572; Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 240); Гетсеманид залбирч буй Есүс (62175; Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 227); Цовдлолт (62505; Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 230). Хичээлийн бүх хугацааны туршид та Их Эзэн Есүс Христ зургийг үзүүлж болно.
4. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах бол модны нэг мөчрийг ангид авчир.

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

Модны мөчрийг үзүүл. Энэ мөчир цаашид амьдрахад хэрэгтэй тэжээлийг авч чадахгүй болсныг хэл.

- Энэ мөчир өөртөө хэрэгтэй тэжээлийг яагаад авах боломжгүй болсон бэ? (Мөчир үндсээсээ таслагдсан байна)

Арванхоёрын Чуулгын Ахлагч Боид К.Пакерын дараах мэдэгдлийг хуваалц:

“[Есүс Христийн Цагаатгал] бол Есүсийн сургаалын үндэс нь юм. Сайн мэдээ болон үүнээс салбарласан мөчрүүдийн тухай та нар ихийг мэдэж болно. Гэвч та нар зөвхөн мөчрүүдийн тухай мэдээд, үндсэнд нь хүрэхгүй бол, хэрэв мөчир, үндэс нь үнэнээс таслагдсан бол энд амьдрал байхгүй болж, матери биш болж, гэтэлгэл байхгүй болдог” (In Conference Report, 1977 оны 4-р сар, 80; эсвэл *Ensign*, 1977 оны 5-р сар, 56).

Үхсэн мөчрийг хүчтэй, эрүүл модтой харьцуул. Есүс Христийн Цагаатгал бидэнд амьдралыг авчирч, сайн мэдээний бусад бүх сургаалын утга учрыг таниулдгийг онцгойлон анхаар. Энэ цуврал хичээлийн үлдсэн хэсэг дэх бусад зарчмыг судлах явцад бид Цагаатгалыг санаж байх ёстой.

1. Сургаал ба Гэрээ Есүс Христийн тухай гэрчилдэг

Бүх судрын нэг зорилго нь Есүс Христийг гэрчлэн Түүнд ирж, авралыг хүртэхийг хүмүүст итгүүлэх явдал байдгийг онцлон тэмдэглэ. Библи, Агуу Үнэт Сувд дахь Мосе болон Абрахамын номнууд мөн Мормоны Ном бол Есүс Христийн тухай эртний гэрээнүүд бас гэрчлэлүүд юм. Сургаал ба Гэрээ бол энэ эрин үед өгөгдсөн Есүс Христийн гэрээ мөн. Судрын энэ ном Есүс бол Христ гэдгийг, Тэр амьдыг, өнөөдөр Тэрээр бошиглогчдод хандан ярихаа үргэлжлүүлж, Өөрийн хүмүүсийг удирддагийг гэрчилдэг.

Сургаал ба Гэрээний Удиртгал тайлбарыг гаргахыг ангийн гишүүдээс хүс. Найм дахь догол мөрний сүүлчийн өгүүлбэрийг тэднээр уншуул (энэ өгүүлбэр “Эцэст нь . . . , өгөгдсөн гэрчлэл” гэсэн нийлэмж үгээр эхэлсэн байгаа).

Аврагч болон Түүний ажлын тухай Сургаал ба Гэрээ хүчирхэг гэрчлэлүүдийг агуулдгийг онцлон тэмдэглэ. Гэрчлэлүүдийн ихэнхийг Аврагч Өөрөө хэлсэн байдаг. Дараах хэсгүүдийг жишээ болгон ангийн гишүүдээр уншуул: С ба Г 50:41-44, 76:22-24.

Энэ хичээл нь Аврагчийн талаарх Сургаал ба Гэрээн дэх сургаалуудыг агуулдгийг тайлбарла.

2. “Бүх хүмүүн наманчилж мөн түүнд ирж болохын тулд Есүс Христ бүх хүмүүний зовлонг биеэрээ амссан бөлгөө”

Гетсеманид болон загалмай дээр байгаа Есүсийн зургуудыг үзүүл. Есүс Христийн Цагаатгалын тухай бидний ойлголтыг өсгөн нэмэгдүүлж чадах олон илчлэлтийг Сургаал ба Гэрээ агуулдгийг тайлбарла. Эдгээр илчлэлтүүд нь Аврагчийн зовлон шаналлыг, түүнчлэн биднийг хайрладаг Түүний болон Тэнгэрлэг Эцэгийн хайрын чухлыг мэдрэх гүн гүнзгий мэдрэмжийг бидэнд төрүүлдэг билээ.

Аврагч цагаатгагч золиослолоо дүрсэлсэн нь

- С ба Г 19:16-19-ийг ангийн гишүүдийн хамт унш. Энэ бол цагаатгах золиослолынхоо үе дэх зовлон шаналлаа Аврагч дүрсэлсэн судрын цорын ганц хэсэг юм гэдгийг тайлбарла. Бидний төлөөх Аврагчийн зовлон шаналлын тухай энэ хэсэг юу заадаг вэ? Яагаад Есүс бидний төлөө ийм их зовлон шаналлыг биеэр амсахыг хүссэн юм бол? (С ба Г 18:10-11; 19:19, 24; 34:3-ыг үз.)

Цагаатгалаар дамжин бид бүгд амилуулагдана

- Дараах судрын хэсгүүдийг ангийн гишүүдтэй хамт унш: С ба Г 88:14-18; 93:33; Алма 11:42-44. Эдгээр хэсгүүдээс Амилуулалтын тухай бид юу мэдэж болох вэ? (Доор жагсаасан зүйлүүд хариулт болж чадна)
 - а. Амилуулалт бол бодгалиудын гэтэлгэл юм. Сүнс бие хоёр дахин нэгдэж, төгс хэлбэрээр салшгүйгээр холбогддог (С ба Г 88:14-16; 93:33; Алма 11:42-43).
 - б. Амилуулалт биднийг селестиел алдар сууд бэлтгэдэг (С ба Г 88:18).

- в. Баяр баяслын бүрэн байдлыг хүлээн авахад Амилуулалт бидэнд шаардлагатай (С ба Г 93:33).
- г. Бүх хүмүүс амилуулагдана (Алма 11:44).

Цагаатгалаар дамжуулан бид нүглээсээ уучлагдаж, селестиел алдар сууг өвлөж чадна

- Дараах судрын хэсгүүдийг ангийн гишүүдтэй хамт унш: С ба Г 18:11-12; 19:16-17, 20; 58:42; 76:62-70. Аврагчийн Цагаатгалаар дамжуулан бидний хүлээн авч чадах адислалын тухай эдгээр хэсгүүд юу зааж байна вэ? (Доор жагсаасан зүйлүүд хариулт болж чадна)
 - а. Бид нүглээ наманчилж, Түүнд ирж чадна (С ба Г 18:11-12).
 - б. Хэрэв бид наманчлах юм бол, бидний нүглийн төлөөх зовлон шаналлыг Есүс өөр дээрээ авсан билээ (С ба Г 19:16-17, 20).
 - в. Хэрэв бид наманчлах юм бол Их Эзэн биднийг уучилж, бидний нүглийг дахин санахгүй байх болно (С ба Г 58:42).
 - г. Бид эхний Амилуулалтад урагш гарч ирэн Есүсээр дамжин төгс болгогдож, селестиел алдар сууг өвлөж чадна (С ба Г 76:62-70).

Аврагч Цагаатгалаар дамжуулан бидний бүх уй гашуу, өвчин эмгэг, гай зовлонг бидний төлөө төгс байдлаар хуваалцсан билээ

Аврагч амьдралынхаа үед түүнчлэн Цагаатгалын оргил үед бидний бүхий л зовлон зүдгүүрийг ойлгох төгс ойлголтыг Өөрт нь өгсөн хэлбэрээр зовж шаналсныг тайлбарла.

С ба Г 122-ыг ангийн гишүүдээр гаргуул. Энэ хэсэг бол Бошиглогч Иосеф Смитийг Миссурин Либерти шоронд хоригдож байх үед өгөгдсөн илчлэлт юм. Эхний долоон шүлэгт Бошиглогч Иосефт тохиолдсон хүнд сорилтуудын тухай Их Эзэн өгүүлжээ. Дараа нь шүлэг 8-д Их Эзэн Өөрийнхөө тухай өгүүлдэг.

- С ба Г 122:8-ыг ангийн гишүүдийн хамт унш. Ямар байдлаар Аврагч бүх зүйлээс “доогуур бууж ирсэн” бэ? (Алма 7:11-12; С ба Г 62:1; 133:53-ыг үз. Тэтгэ гэдэг нь туслах гэсэн утгатай болохыг тайлбарла. Аврагч бидний бүх уй гашуу, өвчин эмгэг, зовлон зүдгүүрийг биеэрээ амссан учраас бидэнд ямар байдгийг Тэрээр ойлгодог. Бидэнд яаж туслахыг Тэр мэддэг билээ) Биднийг хүнд сорилтуудтай тулгарсан үед энэ мэдлэг бидэнд хэрхэн тусалж чадах вэ?

Арванхоёрын Чуулгын Ахлагч Жефффри Р.Холланд: “Хүнд цаг үе бидэнд ирэхэд . . . Тэрээр нигүүлслээр дүүрч, Өөрийн хүмүүст төгс бус байдалд нь хэрхэн тусалж болохыг мэдэхийн тулд Есүс бүх зүйлийн дээр залрахаас өмнө бүх зүйлээс доогуурт бууж ирэх шаардлагатай байсныг, Тэрээр өвдөлт, зовлон шаналал болон бүх төрлийн уруу таталтыг хүлцэн тэвчсэнийг бид санаж чадна” хэмээн хэлжээ (С ба Г 88:6; Алма 7:11-12-ыг үз) (In Conference Report, 1995 оны аравдугаар сар, 91; *Ensign*, 1995 оны арваннэгдүгээр сар, 69).

- Цагаатгалын хүчийг та нар амьдралдаа хэзээ мэдэрсэн бэ? Энэ хүчийг илүү бүрэн дүүрэн мэдрэхийн тулд бид юу хийж чадах вэ?
- Бид Цагаатгалын төлөөх талархлаа Аврагчид хэрхэн харуулж чадах вэ? Цагаатгалын талаарх бидний ойлголт өдөр тутмын амьдралд маань хэрхэн нөлөөлөх ёстой вэ?

3. Аврагчийн үүрэг, зан чанарыг ойлгоход Сургаал ба Гэрээ бидэнд тусалдаг

Бурханд итгэх итгэлээ хэрэглэх чадвартай байхын тулд, бид “түүний зан чанар, төгөлдөржилт, харьцаа хандлагын тухай зөв ойлголттой” (Иосеф Смит, эмхт., *Lectures on Faith* [1985], 38) байх ёстойг тайлбарла. Ийм ойлголттой болоход Сургаал ба Гэрээ бидэнд тусалдаг.

- Та нар өнөөдөр уншсан судрын хэсгүүддээ Аврагчийн ямар зан төлөвийг олж харав? (Ангийн гишүүдийн хариултыг самбар дээр бич. Энэрэл, дуулгавартай байдал, даруу зан, хүлцэнгүй номхон байдал нь хариулт байж болно)

Ангийн гишүүдтэй хамт уншихын тулд дараах судрын хэсгүүдээс заримыг нь сонгож ав. Хэсэг бүр нь Аврагчийн үүрэг, зан төлөвийн тухай юу зааж байгааг ярилц. Мэдээллийг самбар дээр нэгтгэн дүгнэ.

- а. С ба Г 6:20-21. (Хэрэв бид дуулгавартай, хичээнгүй байх юм бол Аврагч хайрынхаа мутраар биднийг тэврэх болно. Тэр бол харанхуйд гялалзагч гэрэл юм)
 - б. С ба Г 6:32-37. (Тэрээр бидэнд хамгаалалт, тайтгарлыг өгдөг бөгөөд бид Түүнийг санаж, зарлигуудыг нь сахисан тохиолдолд биднийг адислахад бэлэн байдаг)
 - в. С ба Г 19:1-3. (Эцэгийн хүслийг биелүүлснээрээ Тэр бүх зүйлийг ялан дийлж, бүх хүчийг өөртөө үлдээсэн юм. Тэрээр Сатан болон түүний ажлыг устгана. Тэрээр бүх хүмүүсийг ажил үйлсийнх нь дагуу шүүнэ)
 - г. С ба Г 29:1-2. (Түүний нигүүлслийн мутар бидний нүглийг цагаатгасан юм. Хэрэв бид Түүний дуу хоолойг сонсон дагаж, өөрсдийгөө даруусгах юм бол Тэрээр биднийг тахиа дэгдээхийнүүдээ цуглуулдаг шиг цуглуулна)
 - д. С ба Г 38:1-3. (Тэр бол дэлхийг Бүтээгч мөн, бас Тэрээр бүх зүйлийг мэддэг)
 - е. С ба Г 43:34. (Тэр бол дэлхийн Аврагч мөн)
 - ё. С ба Г 45:3-5. (Тэр бол Эцэгийн өмнө бидний Өмгөөлөгч мөн)
 - ж. С ба Г 50:44. (Тэр бол Сайн Хоньчин, Израилын Хад, дээр нь бид барьж болох баг бөх суурь мөн)
 - з. С ба Г 76:5. (Түүнээс эмээдэг хүмүүст Тэрээр нигүүлсэнгүй, талархалтай ханддаг бөгөөд эцсийг хүртэл зөв шударга байдал болон үнэнээр, Өөрт нь үйлчилдэг хүмүүсийг хүндэтгэхдээ баяртай байдаг.)
 - и. С ба Г 93:5-19. (Тэр бол Эцэгийн Төрсөн Цорын Ганц Хүү. Тэрээр алдар суугийн бүрэн байдал, Эцэгийн хүчийг хүлээн авах хүртлээ “ач ивээлээс ач ивээлд үргэлжлүүлсээр байсан билээ”)
 - й. С ба Г 133:42-52. (Тэрээр Хоёр дахь Ирэлтээрээ сүр жавхлантайгаар ирэх үед гэтэлгэсэн хүмүүс нь Түүний хайрын нигүүлсэл, нинжин сэтгэлийг санах болно)
 - к. С ба Г 136:22. (Түүний мутар Өөрийнхөө хүмүүсийг аврахын тулд урагш сунгагдана)
- Аврагчийн эдгээр үүрэг, зан төлөвийг мэдэх нь та нарын хувьд яагаад чухал вэ? Сургаал ба Гэрээн дэх илчлэлтүүд Аврагчийн тухай та нарын гэрчлэлийг хэрхэн баяжуулсан бэ?

Дүгнэлт

- С ба Г 19:23-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Өнөөдөр бидний ярилцсан үнэнүүд амар амгаланг хүлээн авахад та нарт хэрхэн тусалж чадах вэ?

Сүнсээр өдөөгдсөний дагуу Есүс Христийн тухай гэрчил. Түүний Цагаатгалын улмаас бид бүгдээрээ амилуулагдана гэдгийг онцлон тэмдэглэ. Цагаатгалаараа дамжуулан Тэрээр наманчилж, Түүнд очих, улмаар “энэ дэлхийд амар амгаланг, ирэх дэлхийд мөнх амьдралыг” (С ба Г 59:23) хүлээж авах урилгыг бидэнд өгдөг. Есүс Христэд итгэх итгэлийг хөгжүүлж, наманчлан зарлигуудыг дуулгавартай дагаж, эцсийг хүртэл тэвчсэнээр Цагаатгалын бүх адислалыг хүртэхэд ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Сургаал ба Гэрээг энэ жил судлахдаа Есүс Христийн тухай юу заадгийг эрж хайхаа үргэлжлүүлэхийг тэдэнд зөвлө. Есүс Христ бол энэ номон дахь гол баатар юм. Эдгээр илчлэлтүүдэд өгөгдсөн хүчирхэг гэрчлэл болон үнэнүүд нь Түүний тухай хувь хүний гэрчлэлийг баяжуулж чадна.

Нэмэлт заах санаанууд

1. “Би гайхширна ”

“Би гайхширна” (Сүмийн дуулал болон хүүхдийн дуу, х.22) дууллын үгсийг урьдчилан судал. Сургаал ба Гэрээн дэх хэсгүүдийг нотолж чадах бадгуудыг дууллаас ол. Дараах жишээнүүд танд тусалж болох юм.

Дууллын бадгууд	Адил утгатай хэсгүүд
“Би Есүсийн хайранд өлгийдөгдөн гайхширч байна”	С ба Г 34:3
“Тэм нүгэлт, даруу бус нэгэн намайг аврахаар”	С ба Г 19:16-19
“Тэнгэрлэг гэрээсээ ирсэнд би гайхширна”	С ба Г 88:6; 122:8
“Тэр төлөөсийг төлөхөөр цусаа урсган зовсон”	С ба Г 6:36-37
“Тэрхүү энэрлийг үтэр түргэн мартана гэж үү, би?”	С ба Г 20:77

Хичээл дээр уг дууллыг чанга уншихдаа дууллын холбогдох мөрүүдийн дараа зогсолт хийж, судрын адил утгатай хэсгүүдийг ангийн гишүүдээр уншуул.

2. “Эцэгийн өмнө [бидний] өмгөөлөгч” (С ба Г 45:3)

Өмгөөлөгч гэдэг үгийг самбар дээр бич. Тэрээр бидний Өмгөөлөгч гэдгээ Их Эзэн Сургаал ба Гэрээнд нэлээд хэдэн удаа хэлснийг тайлбарла (С ба Г 29:5; 45:3; 62:1; 110:4).

- Өмгөөлөгч гэж хэн бэ? (Өөр хүний өмнөөс хүсэлт тавьдаг хүн)
- С ба Г 45:3-5-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Юуны учир бидэнд “Эцэгийн өмнө өмгөөлөгч” хэрэгтэй вэ? Шүлэг 4, 5-д бид үүрдийн амьдралыг хүлээн авах ёстой гэдгийг харуулах ямар нотолгоог Аврагч Эцэгт танилцуулах вэ? (Хамгийн түрүүнд Тэрээр Цагаатгалынхаа тухай – Өөрийн зовлон шаналал, үхэл, цусны тухай өгүүлнэ. Дараа нь Тэр Өөрт нь итгэх бидний итгэлийн тухай ярина)

3. Нэрсээр нь дамжуулан Есүс Христийн тухай гэрчлэх нь

Сургаал ба Гэрээ Есүс Христийн 60 гаруй нэрийг агуулдаг бөгөөд эдгээр нэр тус бүр нь Түүний тухайд онцгой хүндэтгэл агуулдгийг тайлбарла.

Жишээ нь, Их Эзэн Өөрийгөө “Гэтэлгэгч,” “Аврагч,” “Дэлхийн гэрэл ба амь” гэсэн байдаг.

Есүс Христийн бусад нэрүүдийг гурамсан судрын индексээс олуулахын тулд хуудас (72-78)-ыг ангийн гишүүдээр гүйлгэн уншуул. Тэдний олсон нэрүүдийг самбар дээр жагсаа.

- Есүсийн нэрс Түүний зан төлөв, үүрэг зорилгын тухай юу зааж байна вэ?

4. Христийн Гэрэл

Бидний ухамсрыг зарим үед Христийн Гэрэл гэдэг боловч Христийн Гэрэл нь үүнээс хавьгүй илүү зүйл юм. Христийн Гэрлийн тухай илүү сайн ойлголттой болоход нь туслахын тулд Судруудын Удирдамжийн 54-р хуудас дээрх “Христийн Гэрэл”-ийн хоёр, гурав дахь догол мөрийг ангийн гишүүдээр уншуул. Дараа нь тэднээр С ба Г 88:6-13; 93:2; Моронай 7:13, 16-19-ийг уншуул.

- Судруудын Удирдамж болон судрын эдгээр хэсгүүдээс Христийн Гэрэлийн талаар бид юу мэдэж болох вэ? (Доор жагсаасан зүйлс нь хариулт болж чадна.)
 - а. Христийн Гэрэл “сансрын хязгааргүй уудмыг [дүүргэж]”, “бүх зүйлд амьдралыг өгдөг” (С ба Г 88:12-13).
 - б. Христийн Гэрэл бол дэлхийд төрсөн хүн бүрийн хувьд дээш өргөгч нөлөө юм (С ба Г 93:2).
 - в. Энэ нь муугаас сайныг ялгаж мэдэхэд бидэнд тусалж, сайныг үйлдэж, Христэд итгэхэд биднийг урьдаг (Моронай 7:13, 16-19).
- Христийн Гэрэл бидний амьдралд илүү их нөлөө үзүүлэх боломжийг бид түүнд хэрхэн олгож чадах вэ?

Зорилго

Анхны Үзэгдлийн тухай, Бурханы сайн мэдээний бүрэн байдлыг дэлхийд сэргээсэн Бошиглогч Иосеф Смитийн дуудлагын тухай ангийн гишүүдийн гэрчлэлийг бэхжүүлэх.

Бэлтгэл

1. Дараах судрууд болон бусад материалыг залбирч судал:
 - а. Иосеф Смит–Түүх 1:1-26.
 - б. *Бидний Өв*, хуудас 1-5.
 2. *Ангийн гишүүний Судлах Удирдамж* (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед ашиглах арга хэлбэрийг төлөвлө.
 3. Залуу Иосеф Смитийн хөлний мэс заслын тухай (*Бидний Өв*, хуудас 2) шастирыг нэгтгэн дүгнэж бэлтгэхийг ангийн нэг гишүүнээс хүс.
 4. Дараах зургууд байвал заримыг нь сонгож, хичээлд ашигла: Бошиглогч Иосеф Смит (62002; Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 401); Иосеф ах (62161); Иосеф Смит Библиэс мэргэн ухааныг эрсэн нь (Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 402); Анхны Үзэгдэл (62470; Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 403).
 5. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах бол нэг цаг, дэлхийн газрын зураг эсвэл глобус, эрэгтэй хүний ямар нэг хувцас авчир. Эдгээр юмст зориулж дараах шошгуудыг бэлтгэ: *Зөв цаг, Зөв газар, Зөв хүн*.
-

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа

Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

Цаг, газрын зураг эсвэл глобусыг, дараа нь эдгээр юмсын шошгыг ангийн гишүүдэд үзүүл (“Бэлтгэл,” дугаар 5-ыг үз). Урвалтын олон зуун жилийн дараа Их Эзэн Өөрийн сайн мэдээний сэргээлтийн зөв цаг, зөв газрыг хэрхэн бэлтгэснийг энэ хичээлээр ярилцана гэдгийг тайлбарла.

Эрэгтэй хүний хувцсыг шошготой нь хамт ангийн гишүүдэд үзүүл. Иосеф Смит бол сайн мэдээг сэргээх Бошиглогч байж болох зөв хүн хэмээн Бурхан хэрхэн сонгож, бэлтгэснийг энэ хичээлээр ярилцах болно гэдгийг тайлбарла.

Ярилцах ба хэрэгжүүлэх нь

Энэ хичээл нь нэг хичээл дээр заах боломжтойгоос илүү их материалыг агуулдаг. Ангийн гишүүдийн хэрэгцээг хамгийн сайнаар хангах хичээлийн материалыг залбирч, сонго.

1. Урвалтын дараа Бурхан Сэргээлтийн замыг бэлтгэсэн юм

Есүс Христийг цовдлогдсоны дараа Түүний Төлөөлөгчид Сүмийг тэргүүлж байсныг тайлбарла. Гэвч удалгүй мөрдлөг хавчлага, хагаралт, урвалт газар авсан юм. Төлөөлөгчдийн бошиглож байсанчлан хэдхэн арван жилийн дотор Сүмээс урвах урвалт тохиосон билээ (Үйлс 20:28-30; 2 Тесалоник 2:1-3; 2 Тимот 4:3-4). Энэ урвалтыг Их Урвалт гэдэг.

- Их урвалтын зарим үр дагавар юу байсан бэ? (С ба Г 1:15-16; Иосеф Смит-Түүх 1:8-9, 19, 21; Мормон 1:13-14-ийг үз. Доор жагсаасан зүйлс нь хариулт байж болно.)
 - а. Дэлхий дээр санваарын эрх мэдэл байсангүй.
 - б. Дэлхий дээр Төлөөлөгчид эсвэл Бошиглогчид байсангүй.
 - в. Бурханы мөн чанарын тухай зайлшгүй шаардлагатай мэдлэг алга болсон байв.
 - г. Сайн мэдээний сургаалууд гажиж ялзарсан байлаа.
 - д. Баптисм гэх мэт ариун ёслолууд өөрчлөгдсөн байв.
 - е. Анхны Сүм зөрчилтэй бүлгүүдэд хуваагдсан байлаа.

Урвалтын харанхуй олон зууны туршид үргэлжилсэн юм. Гэвч Бурхан үүнийг угтан харсан бөгөөд хожмын өдрүүд дэх сайн мэдээний сэргээлтийг төлөвлөж байжээ. Сайн мэдээг сэргээх энэхүү бэлтгэл Анхны Үзэгдлээс олон зууны тэртээ эхэлснийг Арванхоёрын Чуулгын Ахлагч Брус Р.МкКонки заасан байдаг:

“14 дүгээр зуунаас эхлэн Их Эзэн сүүлчийн удаа сайн мэдээг хялбархан сэргээж болох нийгэм, боловсрол, шашин, эдийн засаг, засаг төрийн нөхцөлүүдийг бэлтгэж эхэлжээ” (*Mormon Doctrine*, 2 дахь хэвлэл [1966], 717).

- Иосеф Смитийг төрөхөөс өмнө сайн мэдээний сэргээлтийн замыг бэлтгэхэд ямар үйл явдлууд тусалсан бэ? (Та хариултыг самбар дээр жагсаан бичиж болно. Доор жагсаасан зүйлүүд хариулт байж болно)
 - а. Сэргэн Мандалт бол мэдлэгийн, ялангуяа уран зохиол, урлаг, шинжлэх ухааны дахин сэргэлт байлаа. Хэвлэх машин зэргийг зохион бүтээв.
Сэргэн Мандалт бол тохиолдлын хэрэг биш харин “Олон зууны дараа гүйцэлдэхээр товлогдсон Есүс Христийн сайн мэдээний сэргээлтийн бэлтгэлд зориулж, хүмүүний харанхуйлагдсан оюун ухааныг гэрэлтүүлэхийн төлөө Бурханы оюунд урьдчилан шийдэгдсэн хөгжилт байлаа” гэж Арванхоёрын Чуулгын Ахлагч Жеймс И.Талмейж хэлжээ (*Jesus the Christ*, 3 дахь хэвлэл, [1916], 749).
 - б. Жон Виклиффе (Английн шашны шинэчлэгч, шашны номнолч, 1330–1384), Мартин Лютер (Германы Шинэчлэлийн удирдагч, 1483–1546), Жон Калвин (Францын шашны шинэчлэгч, шашны номнолч, 1509–1564) зэрэг шинэчлэгчид тухайн үед оршиж байсан Сүмүүдийн практик болон сургаалуудад шүүмжлэлтэй хандаж, эдгээр Сүмүүд Христийн сургаалаас гажсаныг хүлээн зөвшөөрчээ.
Мартин Лютер болон бусад шинэчлэгчид “алга болсон үнэнүүд болон санваарын эрх мэдлийг Бурхан сэргээж болох шашны уур амьсгалыг бий болгоход сүнсээр нөлөөлөгдсөн юм” гэж Арванхоёрын Чуулгын Ахлагч М.Рассел Баллард хэлжээ (In Conference Report, 1994 оны аравдугаар сар, 85; *Ensign*, 1994 оны арваннэгдүгээр сар, 66).

- в. Америк тив нээгдэв. Шашны хүмүүс Нэгдсэн Улсад суурьшиж, эцэстээ тусгаар тогтносон үндэстэн болов (1 Нифай 13:12-19).
- г. Нэгдсэн Улсын Үндсэн Хууль батлагдаж, энэ үндэстэнд шашны эрх чөлөөг баталгаатай болголоо (С ба Г 101:77-80).

“Сайн мэдээ сэргээгдэж чадах улс орон болон засаглалын зарчмуудыг хөгжүүлэхийн тулд Бурхан Америкийн эхэн үеийн эзэмшигчид, суурьшигчид болон Нэгдсэн Улсын Үндсэн Хуулийг зохиогчдод сүнслэгээр нөлөөлсөн юм” гэж Ахлагч Баллард хэлжээ (In Conference Report, 1994 оны аравдугаар сар, 85; *Ensign*, 1994 оны арваннэгдүгээр сар, 66).

2. Бурхан Иосеф Смитийг Сэргээлтийн Бошиглогч байхаар бэлтгэжээ

Бурхан сайн мэдээний сэргээлтийн боломжит нөхцөлүүдээр хангаснаас гадна, Сэргээлтийн Бошиглогч байх хүнийг товлосныг тайлбарла. Энэ хүн бол 1805 оны арванхоёрдугаар сарын 23-нд Вермонтын Шаронд төрсөн Иосеф Смит байлаа. Иосеф Смитийн зургийг үзүүл. Сэргээлтийн Бошиглогч байхаар Иосеф Смит хэрхэн бэлтгэгдсэнийг ярилцахдаа дараах материалыг ашигла.

Иосефын гэрийнхэн бэлтгэгдэхэд нь түүнд тусалсан юм

Иосеф Смит сүнслэг байдлын баялаг уламжлалтай гэр бүлээс гаралтай байв. Түүний эцэг эх, өвөг дээдэс нь шашин шүтлэгтэй, эх оронч, боловсролыг эрхэмлэдэг, ёс суртахууны гүн итгэл үнэмшилтэй байлаа. Эцгийнх нь талын өвөг эцэг Асаел Смит, Иосефыг төрөхөөс хэдэн жилийн өмнө “Миний үр удмынхны нэг нь шашны итгэл бишрэлийн ертөнцийг хувьсган өөрчлөх ажлыг зарлан тунхаглах болно гэсэн бодол санаанд минь орж ирээд байх юм” гэж хэлж байжээ (Жозеф Фиелдинг Смит, *Essentials in Church History*, 27 дахь хэвлэл, [1974], 25).

Иосеф Смитын эцэг эх Иосеф Смит, Люси Мак Смит хоёр түүний амьдралд үлэмж нөлөөлсөн ажээ. Тэр хоёр хоёул Бурханд чин сэтгэлээсээ бүхнээ зориулдаг байв. Тэд итгэл бишрэл, шударга ёсны зарчмуудыг хүүхдүүддээ заадаг, тэдэнд бүхнээ зориулдаг байлаа.

Иосефын эцэг эх хоёул шүтлэг бишрэлийн гайхалтай туршлагатай хүмүүс байжээ. Хүү нь Есүс Христийн үнэн сайн мэдээний адислалуудыг хүртэх болно гэсэн баттай итгэлийг төрүүлсэн хэд хэдэн зүүдийг эцэг Иосеф зүүдэлсэн ажээ (Люси Мак Смит, *History of Joseph Smith*, хянан тохиолдуулсан Престон Нибли [1958], 47-50, 64-66-г үз). Люси залуу эх байхдаа нэг удаа хүндээр өвчилсөн үедээ, хэрэв Бурхан гэр бүлдээ анхаарал халамж тавихын төлөө амьд явах боломжийг түүнд олгох юм бол тэрээр Бурханд бүрэн үйлчлэх болно гэсэн гэрээг Түүнтэй хийсэн ажээ. Ингээд удаагүй байтал өөрийг нь тайтгаруулсан дуу хоолойг тэрээр сонсож, улмаар гайхалтайгаар эдгэрсэн ажээ. (*History of Joseph Smith*, 33-35-ыг үз.)

Ахмад Иосеф Люси хоёр үнэн шашныг идэвхтэйгээр эрж хайж байлаа. Тухайн үед оршиж байсан Сүмүүдийн аль нь ч Есүс Христийн үндэслэн байгуулсан Сүмтэй нийцэхгүй гэж тэр хоёр боддог байв. Энэ шалтгааны улмаас эцэг Иосеф аль ч Сүмд нэгдээгүй байв. Баптисм хүртэх нь өөрийнх нь үүрэг гэж Люси боддог байсан учраас Пресбитериен сүмд нэгджээ. Сайн мэдээ сэргээгдэхэд тэр хоёр үнэнийг хүлээн зөвшөөрч, баяртайгаар хүлээн авсан юм.

- Сэргээлтийн Бошиглогч байх үүрэг зорилгодоо бэлтгэгдэхэд нь Иосеф Смитэд гэр бүлийнх нь уламжлал яагаад чухал байсан бэ?

Бэрхшээл түүнд бэлтгэгдэхэд нь туслав

Иосеф Смитийг өсч байх үед өөрт нь болон гэр бүлд нь олон бэрхшээл тулгарч байв. Тэр долоон настай байхдаа хөлд нь халдвар орж хүндээр өвчилсөн аж. Энэ шастирыг *Бидний Өв*, хуудас 1-2-оос товч дүгнэхийг даалгавар авсан ангийн нэг гишүүнээс хүс.

- Энэ туршлагаас хөвгүүн Иосефын зан чанарын талаар бид юу мэдэж болох вэ? Иосефын бага насны хүнд сорилт, зовлон зүдгүүр Сэргээлтийн Бошиглогч болохоор бэлтгэгдэхэд нь түүнд ямар байдлаар тусалсан бэ? Оногдсон үүрэг хариуцлагадаа өөрсдийгөө бэлтгэхэд хүнд сорилт, зовлон зүдгүүр хэрхэн тусалсан бэ?

Бэлтгэхэд нь баруун Нью-Йорк дахь шашны уур амьсгал түүнд тусалжээ.

Иосефыг 10 орчим настай байхад Вермонтод гурван жил ургац алдсан нь Смитийн гэр бүлийг санхүүгийн ноцтой хүндрэлд оруулжээ. Энэ гэр бүл сайтар бодож хэлэлцсэний дараа фермерийн аж ахуй эрхлэх аятайхан нөхцөл бүхий Нью-Йоркийн Палмирагийн бүсэд шилжин ирэв. Тэр үед баруун Нью-Йоркт шашны ер бусын их үймээн, төөрөгдөл бий болж, олон Сүм хөрвөгчдийн төлөө тэмцэлдэж байлаа.

- Ямар Сүмд нэгдэх талаар Иосеф яагаад эргэлзэж байсан бэ? (Иосеф Смит–Түүх 1:5-10-ыг үз.) Иосефын байдал өнөөдөр үнэнийг мэдэхийг эрж хайж байгаа хүмүүсийн байдалтай хэр зэрэг адилхан байсан бэ?
- Судар судалсан нь эргэлзээгээ шийдвэрлэхэд Иосефт хэрхэн тусалсан бэ? (Иосеф Смит–Түүх 1:11-12-ыг үз. Библийг уншиж байгаа Иосеф Смитийн зургийг үзүүл.) Иосефийн үлгэр жишээнээс бид юу сурч болох вэ? (Иосеф зөвхөн судрууд уншиж байсан төдийгүй бас судруудыг судалж, тунгаан бодож, амьдралдаа хэрэгжүүлдэг байсныг та онцлон тэмдэглэхийг хүсч болно) Хэрэгцээтэй эсвэл эргэлзээтэй үед судрууд танд хэрхэн тусалсан бэ?

3. Анхны Үзэгдэл сайн мэдээний сэргээлтийг нээсэн нь

1820 оны хаврын нэг өглөө Иосеф Смит удирдамж хүсч залбирахаар гэрийнхээ ойролцоох ой руу очсоныг тайлбарла.

- Иосефын энэ өглөөний залбирал түүний хэлж байсан бусад залбирлаас юугаараа ялгаатай байсан бэ? (Иосеф Смит–Түүх 1:14-ийг үз.) Бид зүрх сэтгэлийнхээ хүслийг Бурханд өргөн толилуулах үед ганцаарчлан хэлсэн залбирал яагаад ашиг тустай байдаг вэ?
- Иосеф Смитийг залбирч эхлэхэд юу болсон бэ? (Иосеф Смит–Түүх 1:15-ыг үз.) Харанхуйн энэ хүчнээс тэр яаж чөлөөлөгдсөн бэ? (Иосеф Смит–Түүх 1:16-17-г үз. Анхны Үзэгдлийн зургийг үзүүл) Сатаны нөлөөг даван туулсан энэ туршлагаас бид юу сурч болох вэ? Харанхуйн болон хүнд сорилтын цагт байнга залбирч байх нь яагаад чухал вэ? (Ийм бэрхшээлийн үед залбирал тус болсон тохиолдлоо хуваалцахыг ангийн гишүүдээс хүс)
- Яагаад Иосеф Смитэд аль ч Сүмд нэгдэх ёсгүй гэж хэлсэн бэ? (Иосеф Смит–Түүх 1:18-19-ийг үз)

4. Анхны Үзэгдэлд олон үнэн илчлэгджээ

Эцэг Хүү хоёр Иосеф Смит дээр хүрч ирсэн нь сургаалын арвин баялаг ач холбогдолтойг онцлон тэмдэглэ. “Иосеф Смит Эцэг Хүү хоёртой хамт

байж, Мөнхийн Эцэг Бурхан, амилсан Их Эзэний мөн чанарын тухай бүх эрин зууны туршид эрдэм боловсролт хүмүүсийн шүүн хэлэлцсэнээс илүү их зүйл мэдсэнийг би хэдхэн минутын дотор хэлж чадна” гэж Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлжээ (*Church News*, 1998 оны аравдугаар сарын 24, 6).

- Анхны Үзэгдлээс бидний мэдэж болох зарим үнэн юу вэ? (Хариултыг самбар дээр нэгтгэн дүгнэ. Доор дурдсан зүйлс хариулт болж чадна.)
 - а. Бурхан Эцэг, Есүс Христ хоёр амьд.
 - б. Эцэг Хүү хоёр бол бодит, яс махан биетэй, төгс алдаршсан тус тусдаа хүмүүн биес мөн.
 - в. Бид Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн юм.
 - г. Сатан болон түүний хүч бодитой юм. Гэвч Бурханы хүч хязгааргүй агуу билээ.
 - д. Бурхан залбирлыг сонсож, хариулдаг бас бидний төлөө анхаарал халамж тавьдаг.
 - е. Дэлхий дээрх Сүмүүдийн алинд нь ч Христийн сайн мэдээний бүрэн байдал байсангүй.
 - ё. Илчлэлт зогсоогүй байна.

Анхны Үзэгдэл “Бурханы, мөн түүний бурханлиг хувь хүний талаарх бүх асуултад хариулсан юм. . . . Хүүхдүүдтэйгээ харилцдаг түүний харилцаа тодорхой юм. Хүмүүнд соёрхсон эрх мэдлээр дамжуулан Тэрээр хүн төрөлхтнийг сонирхдог нь илт юм. Энэ ажлын ирээдүй баттай юм. Эдгээр болоод бусад алдар суут үнэнүүд Анхны Үзэгдлээр тодотгогдсон юм” гэж Сүмийн ес дэх Ерөнхийлөгч Давид О.МкКей хэлжээ (*Gospel Ideals* [1954], 85).

- “Бурхан Эцэг, түүний Хүү Есүс Христ хоёр бошиглогч хөвгүүн дээр хүрч ирсэн нь Эзэний өмилалтаас хойш энэ дэлхий дээр тохиосон хамгийн агуу үйл явдал мөн” гэж Ахлагч Эзра Тафт Бенсон Арванхоёрын Чуулгад үйлчилж байхдаа хэлжээ (In Conference Report, 1971 оны 4-р сар, 20; *Ensign*, 1971 оны зургадугаар сар, 34). Анхны Үзэгдлийн тухай гэрчлэлтэй байх нь бид бүгдэд яагаад чухал вэ? Анхны Үзэгдэл амьдралыг тань хэрхэн адисалсан бэ?

Дүгнэлт

“Би үнэхээр гэрэл харсан” гэсэн үгсээр эхэлсэн, Иосеф Смит–Түүх 1:25-26-г унш. Дараа нь Бурхан сайн мэдээний сэргээлтийн зөв цаг, зөв газар, зөв хүнийг хэрхэн бэлтгэснийг нэгтгэн дүгнэ. Анхны Үзэгдэл, түүний ач холбогдлын тухай гэрчлэлээ хэл. Та бас Ерөнхийлөгч Гордон Б.Хинклийн дараах гэрчлэлийг хуваалцахыг хүсч болох юм:

“Эцэг Хүү хоёр, Иосеф Смит хөвгүүн дээр хүрч ирсэн 1820 оны хаврын нэг өглөө хамгийн гайхалтай илэрхийлэлт болсон билээ. . . . [Тэрхүү үзэгдлийн] тухай гэрчлэл газар газрын сая сая хүний зүрх сэтгэлд нөлөөлсөн юм. Тэрхүү гайхамшигт үйл явдлын талаарх Бошиглогчийн дүрслэл үнэн гэдгийг, Бурхан Мөнхийн Эцэг, амилсан Их Эзэн Есүс Христ хоёр тэр үйл явдлын үеэр өнөөдөр бид энд ярилцаж байгаа шиг тийм бодитой, хувь хүний шинжтэйгээр, дотночлон түүнтэй ярилцсан тухай Сүнсээр надад өгөгдсөн хувийнхаа гэрчлэлийг би нэмж хэлье” (*Be Thou an Example* [1981], 10).

Зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болгон та дараах санаануудаас нэгийг эсвэл хоёрыг нь ашиглаж болно.

1. Видео танилцуулга

Хэрэв *Teachings from the Doctrine and Covenants and Church History* (53933) видео хуурцаг байвал “Үнэний эрэлд,” 16 минутын хэсгийг үзүүлэхэд анхаар. Энэ хэсэг Сүмийн дөрөв дэх Ерөнхийлөгч болсон Вилфорд Вудраффын хөрвүүлгийн түүхийг өгүүлдэг. Энэ нь Урвалтын тухай, үүнээс үүдэлтэй Сэргээлтийн хэрэгцээг тайлбарладаг.

Ангийн гишүүд энэ видеог үзэхийн өмнө, Вилфорд Вудрафф үнэн сайн мэдээг (Бошиглогчид болон Төлөөлөгчид, санваарын эрх мэдэл, зөв, авралын ёслолууд) эрж байхдаа жагсаасан дөрвөн зүйлийг харахыг ангийн гишүүдээс хүс.

Doctrine and Covenants and Church History Video танилцуулга (53912) байдаг бол 10 минутын “Анхны Үзэгдэл” хэсгийг үзүүлэхэд анхаар.

2. Залуу хүний хувьд Иосеф Смитийн үзүүлсэн үлгэр жишээ

Анхны Үзэгдлийг хүлээн авахдаа Иосеф Смит ердөө 14-хөн настай байсныг залуучуудын багш нар онцлон тэмдэглэхийг хүсч болно.

- Залуу Иосеф Смитийн зан төлөв өнөө үеийн залуу хүмүүст хэрхэн үлгэр дуурайл болж чадах вэ? Хүмүүс та нарын эсрэг эргэх буюу та нарыг шоолох үед, хүнд шийдвэр гаргах шаардлагатай болсон үед үнэнийг мэдэхийн төлөө тэмцэхэд чинь Иосефын үлгэр жишээ та нарт хэрхэн тусалж чадах вэ?

“Шинэ гэрээ, бүр Мормоны Номыг санагтун”

Хичээл

4

Зорилго	Мормоны Номыг гарч ирэхэд Их Эзэний мутар оролцсоныг ойлгоход нь ангийн гишүүдэд туслах, Мормоны Номыг судалж, сургаалуудыг нь дагаж, бусадтай хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмжих.
Бэлтгэл	<ol style="list-style-type: none">1. Дараах судрууд болон бусад материалыг залбирч судал:<ol style="list-style-type: none">а. Иосеф Смит–Түүх 1:27-65; Сургаал ба Гэрээ 3; 5; 10; 17; 20:5-15; 84:54-62.б. <i>Бидний Өв</i>, хуудас 7-12.2. <i>Ангийн гишүүний Судлах Удирдамж</i> (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.3. Гар бичмэлийн 116 хуудсыг алга болгосон Мартин Харрисын тухай шастырыг нэгтгэн хураангуйлж бэлтгэхийг ангийн нэг гишүүнээс хүс. С ба Г 3, 10-ын хэсгийн тойм болон <i>Бидний Өв</i>, хуудас 8-9 дэх “Орчуулгын ажил”-ын эхний гурван догол мөрийг уг гишүүнээр эш татуул.4. Хэрэв дараах зургууд байдаг бол хичээлд ашиглахаар бэлтгэ: Моронай Иосеф Смит дээр өрөөнд нь хүрч ирсэн нь (62492; Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 404), Иосеф Смит алтан ялтсуудыг хүлээн авч байгаа нь (62012; Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 406).

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

Дараах нийлэмж үгүүдийг самбар дээр бич. Эдгээр нийлэмж үгс юуны тухай өгүүлж байгааг ангийн гишүүдээс асуу.

モルモン書

КНИГА МОРМОНА

물 문 경

“Мормоны Ном” гэсэн нийлэмж үгийг та япон, орос, солонгос хэл дээр бичсэнээ тайлбарла. Энэ эрин үе дэх даруухан эхлэлээсээ хойш Мормоны Ном бүх дэлхийн сая сая хүмүүсийн амьдралыг адисалсаар ирсэн билээ. Энэ хичээлээр Мормоны Номын гайхамшиг болон “газар дэлхийг бас [өөрсдийнхөө] амьдралыг Мормоны Номоор дүүргэх” бидний үүрэг хариуцлагын тухай ярилцах болно. (Эзра Тафт Бенсон, In Conference Report, 1989 оны 4-р сар, 3; *Ensign*, 1989 оны 5-р сар, 4)

Ярилцах ба
хэрэгжүүлэх нь

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбирч, сонго. Энэ хичээлийг хоёр хичээл болгон хувааж зааж болно.

1. Мормоны Номыг хүлээн авч, орчуулах Иосеф Смитийн бэлтгэл

- Анхны Үзэгдлээс хойш гурван жилийн дараа Иосеф Смит “ноцтой мөрдлөг хавчлагад” (Иосеф Смит–Түүх 1:27) өртсөн ч гэрчлэлдээ үнэнч хэвээр үлдсэн юм. Мөрдлөг хавчлагатай тулгарсан үед ч гэсэн хүн гэрчлэлдээ хэрхэн үнэнч үлдэж чадах вэ?
- Иосефыг 17 настай байхад Моронай түүн дээр хүрч иржээ. (Хэрэв шаардлагатай бол Моронай Мормоны Номыг бичилцсэн сүүлчийн бошиглогч байсныг мөн МЭ 421 оны орчимд алтан ялтсуудыг булсныг тайлбарла) Моронай түүн дээр хүрч ирсэн шөнө Иосеф юуны төлөө залбирсан бэ? (Иосеф Смит–Түүх 1:28-29-ийг үз.) Бид “[өөрсдийнхөө] сул дорой, төгс биш байдлын улмаас зэмлэгдсэнээ” мэдэрсэн үед Иосефын үлгэр жишээнээс юу сурч болох вэ? (Тохиромжтой гэж үзвэл тэд Бурханы урмыг хугалсан үед залбирал хэрхэн тусалсныг ярихад ангийн гишүүдийг урь)

Иосеф Смит–Түүх 1:30-59-ийг нэгтгэн дүгнэ. Сонгож авсан шүлгүүдийг ангийн гишүүдээр чангаар уншуул. Иосеф Смит дээр хүрч ирсэн Моронайн зураг, ялтсуудыг хүлээн авч байгаа Иосефын зургийг тохиромжтой үед үзүүл. Та энэ гарын авлагын хуудас 314 дээрх Газрын зураг 1, *Ангийн гишүүний Судлах Удирдамжийн* хуудас 29 дээрх газрын зургийг үзүүлж болно.

- Алтан ялтсуудыг Иосеф Смитэд анх үзүүлэхэд тэрээр ялтсуудыг хүлээн авч, орчуулахад бэлтгэгдээгүй байв. Ялтсуудыг хүлээн авч орчуулахад Их Эзэн Иосефыг хэрхэн бэлтгэсэн бэ? (Иосеф Смит–Түүх 1:33-35, 42, 44-46, 53-54-ийг үз) Үүрэг хариуцлагаа биелүүлэхэд чинь та нарыг Их Эзэн хэрхэн бэлтгэсэн бэ? (эсвэл одоо Тэрээр та нарыг хэрхэн бэлтгэж байна вэ?) Ирээдүйн үүрэг зорилгуудаа биелүүлэхэд та нар өөрсдийгөө хэрхэн бэлтгэж болох вэ?
- Моронайн ирэлтийн талаар Иосеф түүнд ярихад аав нь хэрхэн хариулсан бэ? (Иосеф Смит–Түүх 1:50-ийг үз.) Энэ нь Иосефийн ариун журам, итгэл хүлээсэн байдлын талаар юу өгүүлж байна вэ? Их Эзэнийг дагах хүч чармайлтуудад нь бид гэр бүлийн гишүүдээ дэмжих нь яагаад чухал вэ? Их Эзэнийг дагахад нь бид гэр бүлийн гишүүд, бусад хүмүүсийг хэрхэн илүү сайн дэмжиж чадах вэ?

2. Мормоны Ном хадгалагдаж ирсний гайхамшиг

Мормоны Ном гарч ирэхийг зогсоох гэж Сатан оролдсоныг тайлбарла. Алтан ялтсуудыг хулгайлахад тэрээр хүмүүсийг уруу татаж, улмаар Иосеф Смит болон гэрийнхнийг нь мөрдөн хавчихаа хүмүүс үргэлжлүүлж байлаа (Иосеф Смит–Түүх 1:60-61). Гэвч Мормоны Номыг гарч ирэхэд саад учруулах гэсэн Сатаны бүх оролдлогыг Их Эзэн сүйрүүлсэн билээ.

Иосеф Смитийн бичээч нарын нэг Мартин Харрис орчуулагдсан гар бичмэлийн 116 хуудсыг алдахад Мормоны Ном гайхалтайгаар хадгалагдаж ирсний нэг жишээ яруу тод харагдсан юм. Даалгавар авсан ангийн гишүүнээс энэ шастирыг нэгтгэн дүгнэхийг хүс ("Бэлтгэл"-ийн 3 дахь зүйлийг үз). 116 хуудас алдагдсаны дараа Их Эзэний илчилсэн С ба Г 3, 10-ыг зааж, ярилц.

- Гар бичмэлийн 116 хуудас алдагдсаны дараа Бурханаас илүүгээр хүнээс айсных нь төлөө Их Эзэн Иосефыг зэмлэсэн юм (С ба Г 3:7). Иосеф орчуулах бэлгээ түр хугацаагаар алджээ (С ба Г 3:14; 10:1-2). Ямар байдлаар Иосеф Бурханаас илүүгээр хүнээс айсан бэ? Бид Бурханаас илүүгээр хүнээс айдгийг бидний үйлдлүүд заримдаа хэрхэн харуулж болох вэ? (С ба Г 30:1-2-ыг үз. Нэг жишээ гэвэл ямар нэг буруу зүйл хийхийг бидэнд шахаж шаардсан үед бид бууж өгдөг явдал мөн) Хүнээс айх айдсыг даван туулахын тулд бид юу хийж болох вэ? (Энэ асуултад хариулах зарим хариултыг С ба Г 3:8; 10:5-аас үз)
- Гар бичмэлийн 116 хуудас алдагдсаны дараа Иосеф Смитийг хайрлах Их Эзэний хайр хэрхэн харагдсан бэ? (С ба Г 3:8-10; 10:1-3-ыг үз.) Хэрэв та итгэлтэй байх юм бол, "гай зовлон тохиолдох бүрийд Бурхан чамтай хамт байх болно" (С ба Г 3:8) гэдгийг ямар туршлага чамд харуулсан бэ? "Бурхан нигүүлсэнгүйг" (С ба Г 3:10) ямар туршлага та нарт харуулсан бэ?
- Гар бичмэлийн 116 хуудсыг хулгайлсан хүмүүс ямар төлөвлөгөөтэй байсан бэ? (С ба Г 10:10-19, 29-33-ыг үз. Алдагдсан материалыг Иосеф дахин орчуулсан бол тэд гар бичмэл дэх үгсийг өөрчлөх байсан. Тэд өөрчлөгдсөн эх материалыг дахин хийсэн орчуулгатай харьцуулан энэ хоёр хувилбар хоорондоо зөрж байгааг харуулахыг хичээх байсан)
- Гар бичмэлийн хуудсуудыг хулгайлсан хүмүүсийн төлөвлөгөөг бут цохихын тулд Их Эзэн юуг хэдэн зууны тэртээ хийсэн бэ? (С ба Г 10:38-39; мөн 1 Нифай 9:2-5; Мормоны Үгс 1:3-7-г үз. Энэ хуудсууд алдагдахыг Тэрээр угтан харсан байлаа. 2400 орчим жилийн тэртээ Тэрээр, нифайчуудын төрийн түүхийг өгүүлсэн цэдгийн хоёр дахь хувийг бэлтгэхэд сүнслэгээр нөлөөлсөн ажээ. Уг хоёр дахь хувь нь нэг дэх хувийн хамарсан тэр цаг үе буюу нифайчуудын тохинууллын тухай шастирыг агуулдаг бөгөөд сургаалын үнэ цэнийн хувьд эхнийхээсээ илүү байжээ)
- Гар бичмэлийг хулгайлсан хүмүүсийн төлөвлөгөөг нураахын тулд Их Эзэн юу хийхийг Бошиглогчид зааварласан бэ? (С ба Г 10:40-45-ыг үз. 116 хуудас гар бичмэлийг Иосеф Нифайн төрийн түүхээс орчуулсан байлаа. Энэ материалыг дахин орчуулахгүй байх, харин Нифайн цэдгийн хоёр дахь хувийг орчуулахыг Их Эзэн түүнд зарлиг болгожээ)
- Алдагдсан гар бичмэлийн хуудсуудын тухай шастир Их Эзэний хүчний талаар юу заадаг вэ? (Ангийн гишүүд энэ асуултыг ярилцах үед С ба Г 3:1-3; 10:14, 43; мөн 1 Нифай 9:6-г тэднээр уншуул) Юмыг дахин хийх буюу урам хугарсан үе тохиолдоход энэ мэдлэг бидэнд хэрхэн тусалж чадах вэ?
- С ба Г 3:16, 19-20, 10:46-52, 60-66-г ангийн гишүүдээр уншуул. Мормоны Номын зорилгын талаар эдгээр шүлгүүдээс бид юу мэдэж болох вэ? Энэ зорилго өнөөдөр хэрхэн биелэгдэж байна вэ?

3. Мормоны Номын гэрчүүд

- Иосеф Мормоны Номыг орчуулж байхдаа, ялтсуудыг гурван цөөхөн хүмүүст үзүүлэхийг Их Эзэн зөвшөөрснийг мэджээ (эдгээр гэрчүүдийн

талаарх эшлэлүүдийг 2 Нифай 27:12-14, Ифер 5:13-аас үз). Гурван Гэрч хэн хэн байсан бэ? (Мормоны Ном дахь “Гурван Гэрчийн Гэрчлэл”-ийг үз) Яахыг тэдэнд зарлиг болгосон бэ? (С ба Г 5:11-15, 24-25; 17:3, 5) Яагаад тэдний гэрчлэл чухал байсан бэ? (Ифер 5:4; С ба Г 5:16-18; 17:4-ийг үз)



Гурван Гэрч. Оливер Каудери, Давид Витмер, Мартин Харрис.

Гурван Гэрчээс гадна алтан ялтсуудыг тэдэнд үзүүлсэн өөр найман гэрч байсныг тайлбарла (Мормоны Ном, “Найман Гэрчийн Мэдүүлэг”). Гурван Гэрч гурвуулаа, мөн Найман Гэрчээс гурав нь хожим нь Сүмийг орхисон ажээ. Зөвхөн ганц хоёрхон нь эргэж ирсэн ч тэднээс нэг нь ч үзсэн зүйлийнхээ гэрчлэлийг үгүйсгээгүй юм.

Давид Витмер амьдралынхаа сүүлчийн жил худал гүтгэлэгт хариу болгон дараах гэрчлэлийг нийтлүүлсэн байна:

“Гурван Гэрчийн нэг Давид Витмер миний бие *Мормоны Номын* бурханлиг мөн чанарыг үгүйсгэснийг, мөн нөгөөх хоёр гэрч Оливер Каудери, Мартин Харрис хоёр уг номын талаарх гэрчлэлээ үгүйсгэсэн хэмээн *Америкийн Нэвтэрхий Толь Бичиг, Британийн Нэвтэрхий Толь Бичгүүдэд* тэмдэглэжээ. Уг гэрчлэлийг эсвэл гэрчлэлийн аль нэг хэсгийг би хэзээ ч ямар ч үед үгүйсгээгүйгээ бүх хүн төрөлхтөнд дахин давтан хэлж байна. Оливер Каудери ч, Мартин Харрис ч гэсэн ямар ч үед, хэзээ ч гэрчлэлээ үгүйсгээгүйг би бас дэлхийд гэрчилж байна. *Мормоны Номын* бурханлиг гарал үүслийг тэр хоёр хоёул баталсаар нас нөгчсөн юм” (*Address to All Believers in Christ* [1887], 8; *A Comprehensive History of the Church*, 1:145-аас Б.Х.Робертс эш татжээ).

Аврагч бас Мормоны Номын гэрч болохыг анхааруул. С ба Г 17:6, 19:26-г ангийн гишүүдтэй хамт унш.

- Бид ямар арга замуудаар Мормоны Номын гэрчүүд байж чадах вэ? (Моронай 10:3-5-ыг үз. Мормоны Номын тухай гэрчлэлээ хуваалцахад нь ангийн гишүүдийг урьж болно)

Гурван Гэрч, бас Найман Гэрч харсан, сонссон зүйлсийнхээ тухай гэрчилснийг онцлон тэмдэглэ. Өнөөдөр Сүмийн сая сая гишүүд Ариун Сүнсний гэрчлэлийг мэдэрдэг учраас Мормоны Номны тухай гэрчилдэг. Ахлагч Гордон Б.Хинкли Арванхоёрын Чуулгад үйлчилж байхдаа хэлсэн нь:

“Сүмийн хүч чадал нь . . . дэлхий даяарх ариун ёслолын хэдэн мянган байранд нь ч, их сургуулиудад нь ч байдаг юм биш. . . . Энэ Сүмийн хүч чадал хүмүүсийнх нь зүрх сэтгэлд, энэ ажил үнэн болох тухай хувь хүмүүсийн

гэрчлэл, итгэл үнэмшилд байдаг юм” (In Conference Report, ын 1973 оны 4-р сар, 73-74; *Ensign*, 1973 оны долдугаар сар, 49).

4. “Мормоны Ном хэмээх шинэ гэрээг санах нь” бидний үүрэг

- “Бүхэл сүм буруушаалт дор байсныг” (С ба Г 84:55-ыг үз) Их Эзэн энд хэлсэн нэг илчлэлтийг Бошиглогч Иосеф 1832 оны есдүгээр сард хүлээн авсан байна. Сүм яагаад буруушаалт дор байсан бэ? (С ба Г 84:54-56-г үз) Буруушаалтаас гарч урагш ахихын тулд Сүмийн гишүүд юу хийх хэрэгтэй байсан бэ? (С ба Г 84:57-58, 60-62-ыг үз)

Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсоны дараах мэдэгдлийг унш:

“Эхэн үеийн Гэгээнтнүүд Мормоны Номд хөнгөмсгөөр хандсаны улмаас зэмлэл хүлээсэн байхад мөн ингэсний төлөө бид үүнээс ч багагүй буруушаалт дор байгаа бус уу?” (In Conference Report, 1986 оны аравдугаар сар, 4; *Ensign*, 1986 оны арваннэгдүгээр сар, 4-5).

“Христийн нэгэн шинэ гэрчлэл, Мормоны Номд биднийг хэрхэн анхаарал тавьж байгаа байдалд Их Эзэн баярладаггүй. Бид гэр орондоо, гэр бүлдээ энэ номтой байх хэрэгтэй. Энэ ном өнөө үеийн бидэнд зориулж бичигдсэн юм” (*Church News*, 1986 оны арваннэгдүгээр сарын 9, 10).

- Бид хувийнхаа амьдралд, гэр бүлдээ, түүнчлэн Сүмийн үүрэгт ажлууддаа Мормоны Номд илүү их анхаарал тавихын тулд юу хийж болох вэ? Мормоны Номд зохих ёсоор анхаарал тавихад бидэнд ямар адислалууд ирдэг вэ? Мормоны Номыг судалснаараа та нар хэрхэн адислагдсан бэ? (Ангийн гишүүдийн санал бодлыг сонсохыг хүсэхийн хамт, дараах эшлэл болон Мормоны Номын оршлын зургаа дахь догол мөрийг тэднээр уншуул. Мөн гурав дахь нэмэлт заах санааг үз)

Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон хэлсэн нь:

“Та нар энэ номыг нягт нямбайгаар судлахад амьдралд чинь ирэх нэгэн хүч номон дотор байдаг. Уруу таталтыг эсэргүүцэх илүү их хүчийг та нар олно. Залилан мэхлэлтээс зайлсхийх хүчийг та нар олно. Нарийн бөгөөд шулуун зам дээр үлдэх хүчийг та нар олно. Судрууд ‘амьдралын үгс’ (С ба Г 84:85) хэмээн нэрлэгддэг бөгөөд Мормоны Номоос илүү үнэн юм гэж хаа ч үгүй билээ. Эдгээр үгсээр та нар өлсөж, цангасан үед та нар амьдралыг илүү агуу, илүү элбэг дэлбэгээр олж авна. . . . [Та нар бас] гэр орондоо илүү их хайр, эв нийц, эцэг эх, үр хүүхдийн хоорондын илүү их хүндлэл, сүнслэг болон зөв шударга байдалтай болно”

“Эдгээр амлалт бол зүгээр аяндаа биелэгдэх амлалтууд биш, харин Бошиглогч Иосеф Смитийн онож хэлснээр, Бурханд илүү ойртоход Мормоны Ном бидэнд тусална” гэсэн утгатайг Ерөнхийлөгч Бенсон нотолжээ (In Conference Report, 1986 оны аравдугаар сар, 6; *Ensign*, 1986 оны арваннэгдүгээр сар, 7).

- Дэлхий даяар Мормоны Номын тухай гэрчлэлээ илэрхийлэхийг Аврагч бидэнд зарлиг болгосон билээ (С ба Г 84:62; мөн дараах эшлэлийг үз). Энэ хүч чармайлтад тус нэмэр үзүүлэхийн тулд бид бүгд юу хийж болох вэ?

“Газар дэлхийг үй олон Мормоны Номоор дүүргэснээс хойш урт хугацаа өнгөрөөд байна. . . . Электрон мэдээллийн хэрэгслийн эрин зуун, хэвлэмэл үгсийг үй олноор нь хүргэх болсон энэ эрин зуунд, хэрэв бид эдүгээ

Мормоны Номыг аварга алхаагаар дэлгэрүүлэхгүй юм бол Бурхан бидэнтэй хариуцлага тооцно. Бидэнд Мормоны Ном байна, бидэнд гишүүд байна, бидэнд номлогчид байна, бидэнд нөөц боломжууд байна бас дэлхийд хэрэгцээ байна. *Одоо л цаг нь болоод байна!*” хэмээн Ерөнхийлөгч Бенсон хэлжээ (In Conference Report, 1988 оны аравдугаар сар, 4; *Ensign*, 1988 оны арваннэгдүгээр сар, 4-5).

Даруухан нөхцөл байдалд залуу Бошиглогчийн орчуулсан Мормоны Ном эдүгээ дэлхийг дүүргэж байна. Мормоны Ном болон уг номоос хэсэглэн авсан түүврүүд 90 гаруй хэлээр нийтлэгдэж, 100 сая гаруй хувиар хэвлэгдээд байна.

Дүгнэлт

Мормоны Номын төлөө талархаж, Их Эзэний мутраар уг ном гарч ирснийг хүлээн зөвшөөрч, үүнд хариу талархал илэрхийл. Амьдралдаа Мормоны Номонд илүү их анхаарал тавихад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Амьдралд чинь Мормоны Номын үзүүлсэн нөлөөний тухай гэрчлэлээ хэл.

Нэмэлт заах санаанууд

Зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болгон та дараах санаануудаас нэгийг эсвэл илүү олныг ашиглаж болно.

1. Моронай Иосеф Смитэд эш татсан Библийн бошиглолууд

Иосеф Смит–Түүх 1:36-49-д цэдэглэгдсэнээр Моронай Библийн дараах бошиглолуудыг Иосеф Смитэд дөрвөн удаа эш татжээ. Бошиглол бүрийг ангийн гишүүдтэй уншиж, утга болон хэрэгжилтийг нь ярилц.

- а. Малахи 3 (Моронай энэ бүлгийн зөвхөн нэг хэсгийг эш татсаныг анхаар)
- б. Малахи 4 (Иосеф Смит–Түүх 1:37-39-ийг үз)
- в. Исаиа 11 (мөн С ба Г 113:1-6-ааг үз)
- г. Үйлс 3:22-23
- д. Иоел 2:28-32

2. Сургаал ба Гэрээ: Мормоны Номын гадна талын гэрч

“Мормоны Номын гэрчүүдээс гадна Сургаал ба Гэрээ нь Мормоны Ном үнэн болох талаар Их Эзэнээс бидний хүлээн авсан хамгийн агуу гэрч бас нотолгоо мөн” гэж Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон заажээ (In Conference Report, 1987 оны 4-р сар, 105; *Ensign*, 1987 оны 5-р сар, 83).

Мормоны Номын тухай гэрчилдэг Сургаал ба Гэрээний 13 хэсэг: С ба Г 1, 3, 5, 8, 10-11, 17-18, 20, 27, 42, 84, 135-ыг Ерөнхийлөгч Бенсон дурдсан байдаг. Та энэ хичээлийг заахаар бэлтгэхдээ эдгээр хэсгүүдийг судлахыг хүсч болно.

3. Мормоны Номоор дамжуулан Бурханд илүү ойртох нь

“Мормоны Ном бол энэ дэлхий дээрх аль ч номноос хамгийн зөв нь бөгөөд манай шашны суурийн чулуу, аливаа бусад номнуудаас илүүгээр үүний зарчмуудаар амьдарснаар хүн Бурханд илүү ойртох болно хэмээн би ах нарт ярьсан” гэж Бошиглогч Иосеф Смит хэлжээ (*History of the Church*, 4:461).

Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон энэхүү эшлэлийг татаад, дараа нь “Бурханд илүү ойр байхыг эрмэлздэг, бидний өдөр тутмын амьдралд Түүнтэй илүү адилхан байхын тулд, Түүний оршихуй бидэнтэй байнга хамт байгааг мэдрэхийн тулд бидний зүрх сэтгэлийн гүнд ямар нэг зүйл байдаггүй гэж үү? гэж асуугаад, хэрэв тийм бол Мормоны Ном ийм байхад бусад аливаа номоос илүү ихээр бидэнд тусалж чадна” гэжээ (In Conference Report, 1986 оны аравдугаар сар, 6; *Ensign*, 1986 оны арваннэгдүгээр сар, 7)

4. “Бурханы бэлэг болон хүчээр орчуулагдсан нь” (С ба Г 135:3)

Иосеф Смит Мормоны Номын орчуулгыг ажлын 65 орчим өдөрт багтаан дуусгажээ (“I Have a Question,” *Ensign*, 1988 оны 1-р сар, 46-47).

Арванхоёрын Чуулгын Ахлагч Нийл А.Максвелл энэ үйл явцын хурдын талаар тайлбарласан нь:

“Эшлэлийн номууд, хэлний толь бичгүүд, хэрэв хэрэгтэй бол туслахад бэлэн байсан орчуулагч хамтран ажиллагсдаар хүрээлүүлсэн, Японы ХҮГ нэгэн чадварлаг орчуулагч нягт нямбай, үр бүтээлтэй эцсийн орчуулга болгож, өдөрт нэг хуудас гаргаж чадахаа харуулсан аж. Тэр эртний япон хэлнээс орчин үеийн япон хэлэнд дахин хөрвүүлж байжээ! Библийн Хаан Жеймсийн Хувилбарыг бүтээхэд Английн 50 гаруй эрдэмтэн, өмнөх орчуулуудыг ашиглан долоон жил хөдөлмөрлөж, өдөрт дунджаар үнэ цэнэтэй нэг л хуудас гаргаж байв. Бошиглогч Иосеф Смит заримдаа өдөрт 10 хуудас орчуулж байжээ! (the bulletin *Insights: An Ancient Window* [Provo, Utah: Foundation for Ancient Research and Mormon (F.A.R.M.S.), 1986 оны 2-р сар], 1-ийг үз).

“Мормоны Номын орчуулгын явцын хоёр дахь гайхамшиг нь бидэнд мэдэгдсэнээс үзвэл Иосеф нэгэнт хийснээ ховорхон эргэн харж, ховорхон хянах буюу засвар хийж байсан явдал юм. Орчуулга тогтвортойгоор, хөврөх лугаа адил урагшилж байв. . .

“Сүнсээр нөлөөлөгдсөн энэхүү үйл явцын талаар Эмма Смит хэлсэн нь: ‘Хоолны дараа эсвэл түр завсарласны дараа [Иосеф] гар бичмэлийг харалгүйгээр эсвэл үүний аль нэг хэсгийг уншуулалгүйгээр, орхисон газраасаа шууд цаашаа явдаг байсан,’ (“Last Testimony of Sister Emma,” *Saints’ Herald*, 1879 оны аравдугаар сарын 1, 290). Хэлж бичүүлж байгаа хүн түр завсарласны дараа ихэвчлэн ‘Бид хаана зогслоо?’ гэж асуугаад цааш үргэлжлүүлдэг. Харин бошиглогч тэгдэггүй байлаа!

“Хэрэв бичвэр дээр нэг хүн ажиллаж байгаа бол шалгах, хянан тохиолдуулах, тохирлыг байнга өөрөө хийх хэрэгтэй болдог. Хэрэв Бошиглогч хэлж бичүүлэн, далайцтайгаар хянан тохиолдуулж байсан бол ингэх нь илүү их байх ёстой байсан. Гэвч бурханлигаар нөлөөлөгдсөн бичвэрийг хянан тохиолдуулах хэрэгцээ байсангүй. Орчуулгын явцын нарийн ширийн зүйлс ямар ч байдаг байлаа гэсэн, бид үнэхээр гайхмаар үйл явцын тухай өгүүлж байна!” гэжээ (“By the Gift and Power God,” *Ensign*, 1997 оны 1-р сар, 39-40).

Өнөөдөр Мормоны Ном олон хэлэнд орчуулагдаж байгаа үед гайхамшиг үргэлжлэн тохиосоор байна. Гана дахь Сүмийн гишүүн Присила Сампсон-Дависын хуваалцсан дараах түүхийг ярь:

“Би баптисмаасаа хойш хоёр жил орчмын дараа нэг үзэгдэл харав. . . . Би ариун ёслолын цуглаан дээр байх юм. Тэгтэл цагаан хувцастай нэг хүн хүрч

ирээд, индрийн өмнө зогсоод намайг дуудлаа. Би урагш гарч түүний дэргэд зогсол, хүмүүсийн нүүр рүү харж, үйлчлэл тэдэнд бүгдэд нь таалагдаж байгаа эсэхийг харахыг надаас хүсэв. Би хараад тэдний нүүр царайнаас ямар ч ялгаа олж харж чадсангүй гэв. Дараа нь нөгөөх цагаан хувцастай хүн анхааралтай харахыг надаас хүслээ. Цугларагсдын зарим нь толгойгоо бөхийлгөөгүйг би харлаа. Тэр хүмүүс яагаад дуулахгүй байгааг нөгөөх хүн надаас асуув. Тэд англиар уншиж чаддаггүй, тиймээс тэд дуулж чадахгүй бас толгойгоо бөхийлгөөгүй байгааг би түүнд хэллээ. Ах эгч нар минь Тэнгэрлэг Эцэгийг магтан дуулахад бидэнтэй нэгдэж чадахгүй байвал чи тэдэнд туслахгүй юу гэж нөгөөх хүн надаас асуув. Би фанте хэлээр [энэ хүмүүсийн ярьдаг хэл] ярьж чаддаг ч, сайн бичиж чаддаггүй. Гэвч би үгүй гэж хэлсэнгүй. Хичээе, чадах бүхнээ хийе гэв. Тэгтэл нөгөөх үзэгдэл сарнин алга болов. Би тэр даруйд босч, цаас харандаа аваад 'Израилын Гэтэлгэгч' дууг фанте хэлэнд орчуулж эхлэв”

Сампсон-Давис эгч дуулууд, номлогчийн зарим томхимол, *Сайн мэдээний зарчмууд зэрэг* гарын авлагыг орчуулжээ. Дараа нь тэрээр ажил үүргийн даалгавраар Мормоны Ном, Сургаал ба Гэрээ, Агуу Үнэт Сувдыг орчуулахад тусалсан ажээ. “Хүмүүс эцсийн өдрүүдэд сайн мэдээг төрөлх хэл дээрээ сонсох болно гэж судруудад өгүүлсэн байдаг. Энэ бол Их Эзэн надаар хийлгэхийг хүссэн тэр зүйл мөн үүнийг би хийх нь түүний ач ивээлийнх” гэж тэрээр хэллээ (“An Instrument in His Hands,” in “All Are Alike unto God,” хянан тохиолдуулсан, И.Дейл ЛеБарон [1990], 40-42).

5. “Өөртөө байгаа хүч чадлаас илүү хурдан гүйх буюу илүүгээр бүү хөдөлмөрлө” (С ба Г 10:4)

- Мормоны Номыг орчуулах далайцтай ажил Иосефт тулгарсан үед Их Эзэн түүнд ямар зөвлөгөө өгсөн бэ? (С ба Г 10:4-5-ыг үз.) Хэцүү зорилт буюу хүнд үүрэг хариуцлагатай тулгарсан үед энэ зөвлөгөө бидэнд хэрхэн тусалж чадах вэ?

6. Видео танилцуулга

Хэрэв *Teachings from the Doctrine and Covenants and Church History* (53933) видео хуурцаг байдаг бол “Бурханы ажил ба төслүүд” хэсгийг үзүүлэхийг бод. 13 минутын энэ хэсэг бол гар бичмэлийн алдагдсан 116 хуудасны тухай юм. “Бурханы ажил болон төслүүд, мөн зорилгууд хясагдаж болохгүй, бас тэдгээр нь юу ч биш болж болохгүйг” (С ба Г 3:1) онцлон тэмдэглэхийн тулд уг видеог ашигла. Энэ зарчмыг ярилцахын тулд хичээлийн хоёр дахь хэсэг дэх асуултуудыг ашигла.

Сургаал ба Гэрээ болон Сүмийн Түүхийн Видео танилцуулгууд (53912) байдаг бол “Парли П.Пратт Мормоны Номыг олсон нь” 11 минутын хэсгийг үзүүлэхийг бод. Видеог үзүүлсний дараа дараах асуултуудыг асуу:

- Та нар Мормоны Номыг уншаад, үүнийг Парли П.Пратт анх уншихдаа олсон шиг тийм их баяр баяслыг олдог уу? Мормоны Номыг амьдралынхаа илүү чухал хэсэг болгохын тулд та нар юу хийж болох вэ? (Эдгээр асуултуудыг дотроо чимээгүй тунгаан бодохыг та ангийн гишүүдэд зөвлөж болно)
- Ерөнхийлөгч Бенсоны амлалтууд биелэгдсэнийг та нар хэрхэн үзсэн бэ?

“Энэ бол илчлэлтийн Сүнс болой”

Хичээл
5

Зорилго Хувиараа илчлэлт хүлээн авахад хэрхэн бэлтгэхийг ойлгоход нь ангийн гишүүдэд туслах, ингэхэд нь тэднийг урамшуулан дэмжих.

Бэлтгэл

1. Сургаал ба Гэрээ 6, 8, 9, Иосеф Смит–Түүх 1:8-17, энэ хичээлийн бусад судрыг залбирч, судал.
2. *Ангийн гишүүний Судлах Удирдамж* (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Хичээлийн үед уг материалыг дурдах арга хэлбэрийг төлөвлө.
3. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах бол Мосе болон Шатаж байгаа бут (62239; Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 107); Их Эзэнээр дуудагдсан Самуэл хөвгүүн (62498; Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 111); Небухаднезарын зүүдийг тайлж байгаа Даниел (62531; Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 115); Их Эзэний хурууг харж байгаа Жаредын ах (62478; Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 318); Анхны Үзэгдэл (62470; Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 403) зэрэг илчлэлт хүлээн авч байгаа Бошиглогчдын хэдэн зургийг үзүүлэхэд бэлтгэ. Та бас ангийн хэдэн гишүүний гэрэл зургийг олж авч болно.

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

- Бошиглогчдын зургийг үзүүл (“Бэлтгэл,” зүйл 3-ыг үз). Эдгээр зургууд бүгдээрээ ямар нэгэн адил зүйлийг дүрсэлдгийг тайлбарла. Энэ юу вэ? (Зураг бүр нь Бошиглогч илчлэлт хүлээн авдгийг харуулдаг)

Бошиглогч Иосеф Смитийн дараах мэдэгдлийг хуваалц: “Бурхан бүх зүйлийг Иосефт хараахан илчлээгүй байна, гэхдээ ойлголтынх нь төвшин өсөхийн хэрээр Тэрээр Арванхоёрт, түүнчлэн бүр хамгийн өчүүхэн Гэгээнтэн ч бүх зүйлийг түүний нэгэн адил түргэн ойлгож чадахаар илчлэх болно” (*Teachings of the Prophet Joseph Smith*, эмхтгэсэн, Жозеф Фиелдинг Смит [1976], 149).

Их Эзэнээс илчлэлт хүлээн авахын тулд бид бошиглогч байх хэрэггүйг онцлон тэмдэглэ. Сүмийг удирдах илчлэлтийг бид хүлээн авдаггүй ч, сайн мэдээний үнэнүүдийг мэдэх, хувийнхаа амьдралд, тэрчлэн гэр орон, Сүмд хүлээж буй үүргээ удирдуулахад тусалж чадах илчлэлтийг хүлээн авч чадна. Хэрэв та ангийн гишүүдийн гэрэл зургуудыг олж авсан бол Бошиглогчдын зургийн дэргэд байрлуулж үзүүл.

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбирч, сонго. Судрууд өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудад холбоотой туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Хичээл 5, 6 нь хоёул хувийн илчлэлтийн тухай юм гэдгийг тайлбарла. Сургаал ба Гэрээ энэ чухал сэдвээр биднийг үлэмж ихээр гэгээрүүлдэг билээ. Бидэнд хувийн илчлэлт яагаад хэрэгтэй байдаг, хувийн илчлэлт хүлээн авахад бид хэрхэн бэлтгэх талаар энэ хичээл заах болно. Хичээл 6 нь Ариун Сүнснээс ирсэн хувийн илчлэлтийг хэрхэн танихад бидний анхаарлыг хандуулна. Иосеф Смит бичээч Оливер Каудертай хамт Мормоны Номыг орчуулж байх үед хүлээн авсан С ба Г 6, 8, 9 бол энэ хоёр хичээлийн унших даалгавар юм. Хэдийгээр С ба Г 9-ийн бичвэр нь Мормоны Номыг орчуулах гэсэн Оливер Каудерийн оролдлогын талаар өгүүлдэг ч, зарчмууд нь бас нөгөө илчлэлтэд холбогддог.

1. Бидний хувийн илчлэлтийн хэрэгцээ

Тэнгэр нээлтэй байгаа бөгөөд үргэлжилж байгаа илчлэлтээр дамжуулан Их Эзэн хүүхдүүдтэйгээ байнга харилцаж байгаа нь бидэнд байгаа хамгийн агуу адислапуудын нэг мөн гэдгийг тайлбарла. “Бурханлиг илчлэлт бол Есүс Христийн сайн мэдээний хамгийн агуу үзэл баримтлал болон зарчмуудын нэг юм. Учир нь ийм үзэл баримтлал, зарчимгүйгээр хүн Бурханы зүйлүүдийг мэдэж чадахгүй билээ. . . . Бурханаас түүний Гэгээнтнүүдэд илчлэлт үргэлжлэн ирж байгаа нь . . . зөв замаарх өдөр тутмын удирдамжийг боломжтой болгож, итгэлтэй хүмүүсийг селестиел хаант улс дахь бүрэн төгс, мөнхийн аврал руу удирддаг. . . . Илчлэлтгүй бол бүгд таамгийн ажил, харанхуй болон төөрөгдөл байх байсан” (Судруудын Удирдамж, “Илчлэлт,” 100).

- Арванхоёрын Чуулгын Ахлагч Боид К.Пакер: “Хувийн сүнслэг нөлөөгүйгээр өнөөдрийн дэлхийд бидний хэн нь ч тэсэн үлдэж чадахгүй, хувийн сүнслэг нөлөөгүйгээр дэлхий байх ёстойгоосоо бүр долоон дор болно” гэж хэлжээ (In Conference Report, 1991 оны аравдугаар сар, 29; *Ensign*, 1991 оны арваннэгдүгээр сар, 23). Хувийн илчлэлт манай энэ үед яагаад ийм их чухал гэж та нар боддог вэ? (Доор жагсаасан зүйлүүд хариулт болж чадна.)
 - а. Хувийн илчлэлт бол бид Есүс Христ, Түүний сайн мэдээ, Иосеф Смитийн бурханлиг дуудлагын тухай гэрчлэлүүдээ хүлээн авдаг арга зам юм.
 - б. Хувийн илчлэлт бол бурханлиг үнэнүүдийг мэддэг бидний арга зам юм.
 - в. Хувийн илчлэлт бол амьдралын асуултуудад хариулах, сорилтуудыг даван туулах, шийдвэр гаргахад бид хязгаарлагдмал ойлголтоосоо илүү дээгүүр удирдамжийг хүлээн авах арга зам мөн.
- Хувийн илчлэлт бидэнд тусалж чадах ямар ямар шийдвэр буюу нөхцөл байдал байдаг вэ? (Хувийн илчлэлт гэр бүлийн үүрэг хариуцлагад нь, Сүмийн үүрэг хариуцлагад нь, мөн амьдралынх нь бусад талд хэрхэн тусалсныг нь яриулахаар ангийн гишүүдийг урь)

2. Илчлэлт хүлээж авахын тулд бид юу хийх ёстойг ойлгох нь

Бид хувийн илчлэлт хүлээн авахад хэрхэн бэлтгэхийг ойлгох нь чухал гэдгийг тайлбарла. Дараах налуу бичлэгээр бичсэн судрын эшлэлүүдийг ангийн гишүүдээр уншуул. Хувийн илчлэлт хүлээн авахад бид хэрхэн бэлтгэж

болох талаар эдгээр судрууд юу зааж байгааг дараа нь тэднээр олуул (зөвлөмж болгосон хариунууд хаалтанд байгаа). Хариултыг самбар дээр нэгтгэн дүгнэ. Дараа нь хариунуудын талаар ярилц.

А. *Сургаал ба Гэрээ 9:8; Иосеф Смит–Түүх 1:8-10. (Уг асуудлыг дотроо бод)*

- Оюун ухаандаа асуултыг тунгаан бодохын тулд бид юу хийж болох вэ?
Иосеф Смит өөртөө тулгарсан асуултыг оюун ухаандаа хэрхэн тунгаан бодож байсныг харуулах нотолгоонуудыг олохын тулд Иосеф Смит–Түүх 1:8-ыг та ангийн гишүүдээр судлуулахыг хүсч болох юм. Цөөхөн түлхүүр нотолгоонуудыг дор жагсаав:
а. “Миний оюун буурь суурьтай бясалгалд учраад байв”
б. “Миний бодол санаа мэдрэмжүүд маань гүн гүнзгий болон хурц байв”
в. “Би тэдний зарим цуглаануудад их төлөв тохиолдлоор оролцдог байв”
Аль Сүм зөв болох тухай асуудлыг шийдэхийн тулд Иосеф Смит гүнзгийгээр эргэцүүлэн бодож байсныг тэмдэглэ. Тэрээр хариултыг олохын төлөө хоёр жилээс илүү хугацаагаар цуглаануудад оролцох, судруудыг судлах зэргээр их цаг хугацаа, хүч чармайлт гаргасан юм. Илчлэлт эрэлхийлэх үед асуудлуудыг оюун ухаандаа хэрхэн тунгаан бодохын үлгэр жишээ болгож Иосеф Смитийг бодохыг ангийн гишүүдэд зөвлө.
- Илчлэлт хүлээж авахаас өмнө оюун ухаандаа асуудлуудыг тунгаан бодож байхыг яагаад Их Эзэн биднээс хүсэн хүлээдэг вэ? Илчлэлт эрэлхийлэхдээ идэвхгүй биш, идэвхтэй байхыг Их Эзэн биднээс хүсдэг нь хариулт байж болно. Сонгох эрхээ ашиглахыг Тэрээр биднээс хүсэн хүлээдэг билээ. Асуудлыг оюун ухаандаа тунгаан бодоход бидэнд туслахын тулд Түүний хангасан бэлгүүд, нөөц боломжуудыг ашигласнаар бид өсөн хөгждөг) Асуудлыг оюун ухаандаа тунгаан бодсон нь сүнслэг байдлын хувьд өсч хөгжихөд та нарт хэрхэн тусалсан бэ?

Б. *Сургаал ба Гэрээ 138:1-11; Иосеф Смит–Түүх 1:11-12. (Судрууд болон хожмын үеийн бошиглогчдын сургаалуудыг тунгаан бодож, бясалга)* Судруудыг тунгаан бодох нь эдгээр хэсгүүдэд цэдэглэгдсэн хоёр илчлэлтийн аль алинд нь гол хүчин зүйл болсныг тайлбарла.

- Бид илчлэлт эрэлхийлэхдээ судруудыг судалж, тунгаан бодох нь яагаад чухал вэ? Их Эзэнээс илчлэлт эрэлхийлсэн үедээ судар судалсан нь та нарт хэрхэн тус болсон бэ?

Арванхоёрын Чуулгын Ахлагч Даллин Х.Өүкс тайлбарласан нь:

“Судар унших нь . . . Их Эзэн тэр үед уншигчтай харилцахыг хүссэн ямар ч [сэдвээр] тухайн үед тохирсон илчлэлт рүү хөтөлж болно. Бидний хүн нэг бүрийг хувийн илчлэлт хүлээн авахад судрууд Урим ба Туммим болж чадна гэж хэлэх юм бол хэтрүүлэл болохгүй.

“Судар унших нь илчлэлт хүлээж авахад бидэнд тусалж чадна гэдэгт бид итгэдэг учраас, судруудыг дахин дахин уншихыг урамшуулан дэмждэг. Бид энэ аргаар Тэнгэрлэг Эцэг маань биднийг мэдээсэй, мөн өнөөдөр амьдралдаа хэрэгжүүлээсэй хэмээн хүсдэг тэр зүйлд хүрдэг. Энэ бол Хожмын үеийн Гэгээнтнүүд судрыг *өдөр бүр* судлахад итгэдгийн нэг шалтгаан мөн” (“Scripture Reading and Revelation,” *Ensign*, 1995 оны 1-р сар, 8).

В. Сургаал ба Гэрээ 6:5, 14; 8:1; 42:61; 88:63-64. (Итгэлээр, үнэнч шударга зүрх сэтгэлээр, хүлээж авна гэсэн итгэлтэйгээр Их Эзэнээс асуу)

“‘Асуу, тэгвэл та нар хүлээн авах болно’ гэснээс илүү олон удаа, илүү олон хэлбэрээр сударт гардаг захиас гэж үгүй” хэмээн Ахлагч Боид К.Пакер хэлжээ (In Conference Report, 1991 оны аравдугаар сар, 26; *Ensign*, 1991 оны арваннэгдүгээр сар, 21). Итгэлээр залбирах нь хувиараа илчлэлт хүлээн авах үйл явцын амин чухал хэсэг юм. Сургаал ба Гэрээн дэх ихэнх илчлэлт бол Бошиглогч Иосеф Смит Их Эзэнээс асуусан асуултуудын хариу юм гэдгийг цохон тэмдэглэ.

- “Итгэлээр асуух” гэж юу гэсэн үг вэ? (С ба Г 8:1; мөн 1 Нифай 15:11; Моронай 10:4-ийг үз).

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбаллын асуусан дараах асуултууд итгэлээр залбирах гэж юу гэсэн үг болохыг ойлгоход бидэнд тусалж чадна: “Та улиг болтол давтагддаг цөөн хэдэн үг, чихэнд чийр болсон хэдэн өгүүлбэр хэлдэг үү? Эсвэл та Их Эзэнтэй ойр дотноор ярьдаг уу? Та тогтмол, олон удаа, байнга залбирах ёстой атлаа хааяа ганц нэг удаа залбирдаг уу? . . . Та залбирахдаа зүгээр л ярьдаг уу, эсвэл бас сонсдог уу? . . . Та талархал илэрхийлдэг үү, эсвэл зүгээр л ивээл энэрэл хүсдэг үү?” (“Залбирал,” *New Era*, 1978 оны 3-р сар, 17).

- “Үнэнч зүрх сэтгэлээр” асуух гэж юу гэсэн үг вэ? (С ба Г 8:1; дараачийн хуудсан дээр жагсаасан зүйлс хариулт байж болно).

- а. Бид Их Эзэний хүсэл тааллыг ойлгохын төлөө мөн Түүний хүсэлд нийцсэн зүйлүүдийг л хүсэхийг шударгаар эрэлхийлэх ёстой.
- б. Гуйж байгаа зүйлийн маань учир үндэслэл цэвэр ариун байх ёстойг бид анхаарах ёстой.
- в. Бид наманчилдаг байх ёстой.

- Иосеф Смит–Түүх 1:13-16-г ангийн гишүүдтэй унш. Бид залбирлын тухай энэ хэсгээс юу сурч болох вэ? (Чанга дуугаар, өвдөг сөгдөн залбирах, зүгээр л үгсийг хэлэхийн оронд зүрх сэтгэлийнхээ хүслийг уудлан гаргах, Бурханыг дуудахад бүх хүчээ шавхахын чухал нь хариулт байж болно)
- Бид итгэлээр, үнэнч шударга зүрх сэтгэлээр асуусан тохиолдолд Их Эзэн юуг амладаг вэ? (С ба Г 6:14; 42:61-ийг үз.) Их Эзэний амлалтууд амьдралд чинь хэрхэн биелэгдсэн бэ?

Г. Сургаал ба Гэрээ 63:23; 76:5-10; 93:1, 28; 101:7-8. (Дуулгавартай байж Бурханд үйлчил)

- Бид Бурханаас илчлэлт эрэлхийлэхэд дуулгавартай байдал яагаад чухал вэ? “Илчлэлтэд хүрэх арга зам бол зөв шударга байдал мөн” гэж Ахлагч Даллин Х.Өүкс заажээ (*The Lord’s Way* [1991], 34). Тэрээр “Хэрэв бид зөрчил гаргасан бол эсвэл ууртай байх юм бол эсвэл бид Бурханы сонгосон эрх мэдэлтнүүдийг эсэргүүцэх юм бол–Ариун Сүнсний нөхөрлөл бидэнд байж чадахгүй” гэж сургасан байдаг (“Teaching and Learning by the Spirit,” *Ensign*, 1997 оны 3-р сар, 9).

Д. Сургаал ба Гэрээ 5:24; 19:23; 112:10; 136:32-33. (Номхон дөлгөөн, даруу бай)

- Бурханаас бид илчлэлт эрэлхийлэхэд даруу байдал яагаад чухал вэ?

Нэг өглөө Иосеф Смит Мормоны Номын орчуулгыг түр завсарлахад бэлэн болоод байтал, “гэрт ямар нэг таагүй юм болж, тэрээр энэ тухайд сэтгэл түвдэнгүй болсныг Давид Витмер дурсчээ. Эхнэр Эмма нь ямар нэг юм хийсэн байж. Оливер бид хоёр дээд давхарт гарахад Иосеф удалгүй дээшээ гарч ирээд орчуулгаа үргэлжлүүлэх гэсэн ч, тэр юу ч хийж чадсангүй. Тэр ганц ч үг орчуулж чадахгүй байв. Иосеф доошоо бууж, жимсний цэцэрлэгт очоод Их Эзэнд даруухан залбирал өргөв. Цаг орчим байхгүй байснаа гэртээ эргэж ирж, Эммагаас уучлал гуйгаад, дараа нь бидний байсан дээд давхарт гарч ирэхэд орчуулга хэвийн байдлаар цааш үргэлжилж билээ. Тэр даруу, итгэлтэй л байхгүй бол юу ч хийж чаддаггүй байв” (эш татсан Б.Х.Робертс, *A Comprehensive History of the Church*, 1:131).

Е. Сургаал ба Гэрээ 25:10; 30:2. (Дэлхийн зүйлүүдэд биш харин Бурханы зүйлст анхаарал төвлөрүүл)

- Бид илчлэлт эрэлхийлэхдээ “дэлхийн зүйлүүдэд” биш, харин “[Бурханы] зүйлүүдэд” (С ба Г 30:2) анхаарал төвлөрүүлэх нь яагаад чухал вэ? Бид илчлэлт эрэлхийлэхдээ дэлхийн асуудлууд болон дэлхийн чимээ шуугианаас өөрсдийгөө яаж чөлөөлж болох вэ?

Ахлагч Боид К.Пакер сургасан нь:

“Амар амгалан байдалд сүнсний нөлөө амархан ирдэг. *Нам гүм, намуухан, амар амгалан, Тайтгаруулагч* зэрэг үгс судруудад элбэг тааралддаг. . .

“Дэлхий улам чимээ шуугиантай болж байна. Хувцаслалт, үс засалт, биеэ авч явах байдал улам бүр чөлөөтэй, хайш яйш, эрээ цээргүй болж байна. Чих дөжрүүлэм чанга хөгжим, ичгүүр сонжуургүй дууны үгс, солонгорсон өнгө цацруулагч, гялалзсан гэрлийн хамт дуу өсгөгчөөр дамжуулан мансууруулах бодисын хэрэглээг сурталчилна. Эдгээр гаж буруу зүйлс манай залуучуудын дунд өргөн дэлгэрч, үлэмж ихээр нөлөөлж байна. . .

“Чимээ шуугиан ихсэж үймээн бужигнаан, зөрчил сөргөлдөөн улам нэмэгдэж байгаа, хязгаарлалтууд улам багасч, нэр төрөө эрхэмлэх явдал улам бүр хумигдаж, ёс жудаг улам бүр багасч байгаа энэхүү хандлага тохиолдлын давхцал биш, бас гэм зэмгүй, хор хөнөөлгүй ч юм биш.

“Цэргийн хүчээр дайран эзлэх ажиллагаанд командлагчийн гаргадаг анхны тушаал бол дайран эзлэх гэж байгаа талынхаа холбоог таслах явдал байдаг.

“Хүндэтгэлгүй хандах нь оюун ухаан, Сүнсний илчлэлт аль алиных нь эмзэг нарийн сувгуудад саад учруулах замаар дайсны зорилгод нийцдэг” (In Conference Report, 1991 оны аравдугаар сар, 27-28; *Ensign*, 1991 оны арваннэгдүгээр сар, 21-22).

Ахлагч Нийл А.Максвелл Далын Ерөнхийлөгчийн Зөвлөлд үйлчилж байхдаа хэлсэн нь:

“Бурханлиг удирдамж шийдвэрлэгч хэмжээгээр чухал юм . . . Бид ийм онцгой тусламж ирж болох нөхцөлд өөрсдийгөө тавихын тулд үлэмж хүч чармайлт гаргах хэрэгтэй байна. Бид тухайн өдрийн ажил үүрэгтэйгээ зууралдахаас өмнөх өглөөний цаг сүнсний нөлөөлөлд хэрхэн илүү үр өгөөжтэй байдаг тухай Ерөнхийлөгч Давид О.МкКей өгүүлсэн байдаг. Бусад хүмүүс ийнхүү ганцаархнаа байж, судруудыг унших нь Сүнсний хувьд үр бүтээлтэй уур амьсгалыг бүрдүүлж чадна, оюун санааг хөгжүүлж болно гэж боддог ажээ. Эцсийн эцэст, Христийн үгсийг унших нь

аль хэдийнээс бидний өмнө тулгараад байгаа, олон дахин хүсүүлэлтгүйгээр бидний хийвэл зохих ашигтай сайн зүйл мөн” (*Wherefore, Ye Must Press Forward* [1977], 121).

Дүгнэлт

Бидний амьдрал дахь хувийн илчлэлтийн ач холбогдлыг онцлон тэмдэглэ. Сүмийн гишүүн бүр Ариун Сүнсээр дамжуулан илчлэлт хүлээн авч болдгийг гэрчил. Энэхүү бурханлиг удирдамжийг хүлээн авахад өөрсдийгөө бэлтгэхэд нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

“Ариун Сүнсээр оюунд чинь мөн зүрх сэтгэлд чинь би ярих болно”

Хичээл
6

Зорилго Ариун Сүнсээр дамжин ирдэг хувийн илчлэлтийг таньж сурахад нь ангийн гишүүдэд туслах. Энэхүү адислалыг амьдралдаа эрэлхийлэхэд нь тэднийг урамшуулан дэмжих.

Бэлтгэл

1. Сургаал ба Гэрээ 6, 8, 9, 11, түүнчлэн энэ хичээлийн бусад судрыг залбирч, судал.
2. Ангийн гишүүний Судлах Удирдамж (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.
3. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах бол нэг радиог ангид авчир.

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

- Ангийнханд радиог үзүүл. Гэвч радиог залгах хэрэггүй. Радиогоор нэвтрүүлж байгаа зүйлийг бид яагаад сонсож чадахгүй байна вэ?
- Радиог залга, гэхдээ аль нэг суваг дээр бүү тавь. Бид аль нэг радио станцыг тодоор сонсохын өмнө юу хийх ёстой вэ? Ариун Сүнсийг сонсохыг радио станц тохируулахтай хэрхэн харьцуулж болох вэ? (Ариун Сүнсний удирдамжийг эрэлхийлэхэд хүч чармайлт гаргах нь радиог залгаж, хүлээн авах станцыг тохируулахтай харьцуулж болно. Ариун Сүнсний шивнээг хүлээн авахын тулд шаардлагатай зүйлсийг хийх нь радиог аль нэг суваг дээр тохируулах эсвэл шаардлагатай бол радиог засварлахтай харьцуулж болно)

Энэ хичээл Ариун Сүнснээс ирдэг хувийн илчлэлтийг таньж сурахад нь ангийн гишүүдэд туслах зорилготойг тайлбарла.

Ярилцах ба хэрэгжүүлэх нь

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбирч, сонго. Сонгож авсан судрууд өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэгийг ярилц. Судрын зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Энэ бол хувийн илчлэлтийн тухай хоёр хичээлийн хоёр дахь нь гэдгийг ангийн гишүүдэд тайлбарла. Хичээл 5 хувийн илчлэлт хүлээн авахад хэрхэн бэлтгэх тухай ярилцдаг бол энэ хичээл хувийн илчлэлтийг хэрхэн таних тухай өгүүлдэг.

1. Ариун Сүнс бидэнтэй хэрхэн харилцдагийг ойлгох нь

Илчлэлт олон арга замаар ирж болдгийг тайлбарла. Зарим тохиолдолд Их Эзэн буюу Түүний элч нар хүрч ирэх эсвэл Их Эзэний болон Түүний элч нараас дуу хоолой, үзэгдэл, зүүд ирдэг. Гэвч, илчлэлт нь ихэвчлэн Ариун Сүнс бидний оюун ухаан, зүрх сэтгэлийн мэдрэмжтэй харилцах үед бодол санаа болон ирдэг. Ариун Сүнс бол Бурхан тэргүүтний нэг гишүүн. Тэрээр бидэнд заадаг, биднийг тайтгаруулж, сэрэмжлүүлэн, бэхжүүлж, удирддаг.

Сүнс бидэнтэй олон янзын арга замаар харилцдагийг тайлбарла. Налуу бичлэгээр бичсэн дараах судрын эшлэлүүдийг ангийн гишүүдээр уншуул. Тэгээд Ариун Сүнс бидэнтэй хэрхэн харилцдаг тухай эдгээр судрууд юу зааж байгааг тогтоолго (зөвлөмж болгосон хариултууд хаалтанд байгаа). Хариултыг самбар дээр нэгтгэн бич. Дараа нь хариултыг ярилц.

А. *Сургаал ба Гэрээ 8:2-3; 85:6. (Тэрээр бидний оюун ухаан, зүрх сэтгэлтэй харилцахдаа намуун, зөөлхөн дуу хоолойг ашигладаг)* Мөн Хаадын Дээд 19:12; 1 Нифай 17:45; Хиламан 5:30-ыг үз.

Арванхоёрын Чуулгын Ахлагч Даллин Х.Өүкс заасан нь: “Үзэгдэл ирдэг. Хөшигний цаанаас дуу хоолой сонсогддог. Би үүнийг мэднэ. Гэвч эдгээр туршлага ер бусын юм. . . Сүмийн удирдагчид болон гишүүдэд ирдэг илчлэлтийн олонх нь намуухан, зөөлхөн дуу хоолойгоор эсвэл бид сонсож чадах тусгай үгсийг өгүүлдэг үзэгдэл буюу дуу хоолойгоор гэхээс илүүгээр мэдрэмжээр ирдэг. Ийм маягийн илчлэлтийн бодитойг би гэрчилж байна. Үүнийг би Их Эзэний ажилд намайг удирддаг танил, тэр ч байтугай өдөр тутмын туршлагаараа мэдсэн юм” (“Teaching and Learning by the Spirit,” *Ensign*, 1997 оны 3-р сар, 14).

Арванхоёрын Чуулгын Ахлагч Бойд К.Пакер заасан нь: “Сүнсний эдгээр эрхэм нандин, цэвэр ариун харилцаа бидний нүдэнд үзэгддэггүй бас чихэнд сонсогддоггүй. Хэдийгээр энэ нь дуу хоолой хэмээн дүрслэгддэг ч, энэ бол хүн сонсдог биш, харин мэдэрдэг дуу хоолой юм” (*That All May Be Edified* [1982], 335).

- Ариун Сүнс хэрхэн харилцдаг тухай энэ зарчмыг ойлгох нь яагаад чухал вэ? Бурханлиг харилцааг ер бусын буюу ихэд сонирхолтой арга замаар ирэхийг хүлээхийн аюул юу вэ?

Ахлагч Даллин Х.Өүкс анхааруулсан нь:

“Зарим [хүмүүс] сударт цэдэглэгдсэн агуу илэрхийллүүдийг ер бусын байдлаар харсны улмаас өөрсдөд нь ирсэн намуухан, зөөлхөн дуу хоолойг таньдаггүй . . . Их Эзэн чанга дуугаар ховорхон ярьдгийг бид мэдэх хэрэгтэй. Түүний захиас бараг үргэлж шивнээгээр ирдэг. . .

“Илчлэлтийн эдгээр зарчмыг ойлгодоггүйгээс зарим хүмүүс гайхалтай үйл явдал тохиохыг үзэх хүртлээ гэрчлэлээ танин мэдэхийг хойшлуулдаг. Ихэнх хүмүүсийн хувьд гэрчлэлтэй болох нь нэг удаагийн үйл явдал биш, харин удаан үргэлжилдэг үйл явц гэдгийг ойлгодоггүй” (*Ensign*, 1997 оны 3-р сар, 11-12, 14).

Б. *Сургаал ба Гэрээ 6:15; 11:13-14. (Тэр бидний оюун ухааныг гэгээрүүлдэг)*

- Сүнс бидний оюун ухааныг ямар арга замаар гэгээрүүлдэг вэ?

Сүнс бидний оюун ухааныг шинэ санаа буюу ойлголтууд, сүнсний агшин зуурын нөлөө, хүчтэй мэдрэмж буюу сэтгэгдлээр гэгээрүүлдэг нь хариулт

байж болно (Жишээ нь, С ба Г 128:1-ийг үз). Илчлэлт “цэвэр оюун билиг” болж бидний оюун ухаанд орж ирдэг “санаануудын гэнэтийн илрэлт” байдлаар ирж болно гэж Бошиглогч Иосеф Смит сургажээ (*Teachings of the Prophet Joseph Smith*, эмхтгэсэн Жозеф Фиелдинг Смит [1976], 151).

Ариун Сүнс оюун ухааныг нь шинэ санаа эсвэл ойлголт, сүнсний агшин зуурын нөлөө, хүчтэй мэдрэмж буюу сэтгэгдлээр гэгээрүүлсэн туршлагынхаа тухай ярихад ангийн гишүүдийг урь.

В. Сургаал ба Гэрээ 6:22-23. (Тэрээр амар амгаланг бидний оюун ухаанд авчирдаг.)

Оливер Каудери Бошиглогчтой уулзахаасаа өмнө хэсэг хугацаанд Иосеф Смитийн эцэг эхийн гэрт байсныг тайлбарла. Энэ үед Оливер залбирч, Иосефын дуудлага болон уг ажил нь бурханлиг юм гэдэг талаар амар амгалангийн баттай итгэлийг хүлээн авсан ажээ. Тэгээд Оливер, Пеннсилванийн Хармони руу явж, Мормоны Номын орчуулгад Иосефын бичээчээр ажлаа эхэлжээ. Түүнээс хойш удалгүй, Оливер өмнө нь хүлээн авсан итгэлийнхээ “нэмэлт гэрчийг” хүссэн аж (С ба Г 6:22).

- Бошиглогчийн бурханлиг үүрэг зорилгын талаар “нэмэлт гэрч” хүсэхэд нь Их Эзэн Оливер Каудерид юу илчилсэн бэ? (С ба Г 6:22-23-ыг үз.) Сүнс оюун ухаанд нь амар амгаланг өгүүлсэн туршлагынхаа тухай ярихад ангийн гишүүдийг урь. Сүнс бидний оюун ухаанд хандан ярьж байна гэдэгт бид хэрхэн илүү итгэлтэй байж чадах вэ?

Г. Сургаал ба Гэрээ 9:7-8. (Тэрээр цээжин дотор шатах лугаа адил болгож болно) Мөн Лук 24:32-ыг үз.

С ба Г 9-ийн бичвэр нь Мормоны Номыг орчуулах гэсэн Оливер Каудерийн оролдлогын талаар өгүүлсэн ч, зарчмууд нь хувийн илчлэлтэд холбогддогийг анхааруул. Цээжин дотор шатах гэдэг нь Ариун Сүнс бидэнтэй харилцаж болдог зөвхөн ганцхан арга зам мөн гэдгийг онцлон тэмдэглэ. Сүнс харилцагч энэ арга замыг ойлгоход нь ангийн гишүүдэд туслахын тулд та дараах эшлэлүүдийг ашиглаж болох юм.

“Цээжин доторх энэ шаталт бол цэвэр бие бялдын мэдрэмж биш. Энэ бол биеийн тань дотор бүлээхэн гэрэл гялалзахтай адил юм” гэж Ерөнхийлөгч Бонд К.Пакер тайлбарлажээ (In Conference Report, 1994 оны аравдугаар сар, 77; *Ensign*, 1994 оны арваннэгдүгээр сар, 60).

“Цээжин дотор нь ‘шатаж байгааг’ хэзээ ч мэдрээгүй учраас Ариун Сүнснээс гэрчлэл огт хүлээж авч байгаагүй гэж ярьсан хүмүүстэй би уулзаж байсан. ‘Цээжин дотор шатах’ гэж юу гэсэн үг вэ? Энэ бол шаталтаар үүсдэг калорын халуунтай адилхан мэдрэмж гэсэн үг үү? Хэрэв ийм утгаар бол цээжин дотроо шатаж буйг би хэзээ ч мэдэрч байгаагүй. Энэ судар дахь ‘шатаж буй’ гэдэг үг нь тайтгарал, амар тайван байдлын мэдрэмжийг заадаг нь лавтай юм” хэмээн Ахлагч Даллин Х.Өүкс хэлжээ (*Ensign*, 1997 оны 3-р сар, 13).

Д. Сургаал ба Гэрээ 98:12. (Тэрээр юмсыг бүгдийг нэг дор биш, “шат шатаар, дүрэм дүрмээр” илчилдэг)

Бид илчлэлт хүлээн авах бэлтгэлээсээ хамааралтайгаар ихэвчлэн илчлэлт хүлээн авдгийг тайлбарла. Бид хичнээн их бэлтгэх тусам, төдий чинээ их зүйл бидэнд илчлэгддэг.

“Шийдвэр гаргахад туслах сүнсний нөлөөг бид эрэлхийлэхэд Их Эзэн намуун зөөлөн өдөөлтийг өгдөг. Энэ нь бодох, итгэлийг хэрэглэх, ажиллах,

заримдаа тэмцэх, идэвхтэй үйл ажиллагааг биднээс шаарддаг. Шийдвэр гаргахад чухал асуудал буюу иж бүрдэл асуудалд хариулт бүхлээрээ нэг зэрэг ирэх нь ховор байдаг. Энэ нь нэг удаа нэг хэсэг нь гэхчлэн харагдах төгсгөлгүйгээр ирэх нь бүр олонтаа тохиолддог” гэж Арванхоёрын Чуулгын Ахлагч Ричард Г.Скотт сургажээ (In Conference Report, 1989 оны аравдугаар сар, 40; *Ensign*, 1989 оны арваннэгдүгээр сар, 32).

Бурханлиг удирдамжийг хэрхэн шат шатаар, алхам алхмаар хүлээн авсан туршлагаа хуваалцахад ангийн гишүүдийг урь.

2. Хувийн илчлэлтийн тухай анхааруулга

Налуу бичлэгээр бичсэн дараах судрын эшлэлүүдийг ангийн гишүүдээр уншуул. Дараа нь хувийн илчлэлтийн талаар эдгээр судрын анхааруулсан зүйлсийг тогтоолго (зөвлөмж болгосон хариултууд хаалтан дотор байгаа). Хариултыг самбар дээр нэгтгэн дүгнэ.

А. Сургаал ба Гэрээ 109:44. (Их Эзэний хүсэл хэрэгжихийн төлөө–мөн өөрсдийнхөө хүслийг Түүнд захируулах хүсэлтэй байхын төлөө бид залбирах ёстой)
Мөн Матай 6:10-ыг үз.

- Бид хувийн илчлэлт эрэлхийлэхдээ өөрсдийнхөө хүслийг яагаад Бурханы хүсэлд захируулах нь чухал байдаг вэ?
- Бурхан “үгүй” гэж хариулсныг бид хэрхэн мэдэж болох вэ? (Бидэнд сөрөг бодол санаа, эргэлзээ, тайван бус буюу хөнгөн биш мэдрэмж, “дүйнгэ бодол санаа” [С ба Г 9:9] төрөх нь хариулт байж болно. Ийм мэдрэмж хүлээн авсан туршлагаа хуваалцахад ангийн гишүүдийг урь.)
- Бидний ихэд хүссэн ямар нэг зүйлийн тухай чин сэтгэлийн залбирал бидний хүссэн байдлаар хариулагдаагүй үед бид хэрхэн хариу үйлдэл үзүүлэх ёстой вэ? Ийм туршлага бидэнд хэрхэн тусалж чадах вэ?

Б. Сургаал ба Гэрээ 88:68. (Илчлэлт Их Эзэний өөрийнх нь цагт, өөрийнх нь арга замаар ирэх болно гэдгийг бид санах ёстой)

Илчлэлтийг бид нэг дор эсвэл өөрсдийн хүсэн хүлээсэн байдлаар үргэлж хүлээн авдаггүйг тайлбарла. Хэрэв бид илчлэлт хэзээ ирэхийг мөн илчлэлтийг хэрхэн хүсч байгаагаа албадахыг хичээх юм бол хууртаж болно. Ахлагч Даллин Х.Өүкс сургасан нь:

“Их Эзэн Сүнсээр дамжуулан өөрийнхөө цагт, өөрийнхөө арга замаар бидэнд хандан ярина. Энэ зарчмыг олон хүн ойлгодоггүй. Тэд бэлэн байгаа үед бас тэдний нөхцөл байдал аятайхан байгаа тохиолдолд, Их Эзэнд хандан гуйхад тэрээр тэр даруй, тэр ч байтугай бүр яг тэдний төсөөлөн бодсоны дагуу хариулна гэдэгт итгэдэг. Илчлэлт ийм байдлаар ирдэггүй . . .

“Энд [С ба Г 88:68] өгүүлэгдсэн зарчим Тэнгэрлэг Эцэгээс маань ирдэг харилцаа болгонд холбогдоно: ‘Энэ нь түүний өөрийнх нь цагт, түүний өөрийнх нь арга замаар бас түүний өөрийнх нь хүслийн дагуу байх болно.’ Бид Сүнсний зүйлсийг албадаж чадахгүй ” (*Ensign*, 1997 оны 3-р сар, 10-11).

В. Сургаал ба Гэрээ 28:2, 6-7; 43:2-4. (Бид өөрсдийн ажил үйлс, үүрэг хариуцлагын дагуу илчлэлт хүлээж авдаг)

“Сүмийн аль ч гишүүний хувьд эсвэл хэний ч хувьд, өөрсдөөсөө дээгүүр эрх мэдэл бүхий хүмүүст зориулсан заавар хүлээж авна гэдэг Бурханы үйл

хэрэгт харш юм” гэж Бошиглогч Иосеф Смит заажээ (*Teachings of the Prophet Joseph Smith*, 21).

Даллин Х.Өүкс Төлөөлөгчөөр дуудагдахаасаа өмнөхөн: “Тэнгэрлэг Эцэгийн маань өргөө бол дэг журмын өргөө юм . . . Зөвхөн Сүмийн Ерөнхийлөгч л Сүмийг бүхэлд нь удирдах илчлэлтийг хүлээн авдаг. . . . Тойрогт зориулсан илчлэлт хүлээн авдаг хүн бол бишоп юм. . . . Хувь хүмүүс өөрийнхөө амьдралыг удирдах илчлэлт хүлээн авч чадна. Харин хариуцлагынх нь хүрэнээс гаднах хэн нэгэнд зориулсан илчлэлт хүлээн авдаг мэтээр мэдэгддэг хүн–Сүмийг бүхэлд нь удирдах эсвэл Сүмийн дүрэм журмын дагуу тухайн хүнийг тэргүүлэх эрх мэдэлгүй атлаа уг хүнийг удирдах илчлэлт хүлээн авдаг мэтээр мэдэгддэг Сүмийн гишүүн байх юм бол–ийм илчлэлт Их Эзэнээс ирдэггүйг та анхаар” хэмээн тайлбарлажээ (“*Revelation*,” *New Era*, 1982 оны 9-р сар, 45-46).

- Энэ зарчим Сүмийг удирдахад яагаад чухал вэ? Бусад хүмүүстэй харилцах бидний харилцаанд үүнийг ойлгох нь яагаад чухал вэ? (Хэрэв энэ нь танай ангийн хувьд тохиромжтой бол энэ ярилцлагыг хэрхэн явуулах тухай нэг зөвлөмж болгон хоёр дахь нэмэлт заах санааг хэрэглэхийг та хүсч болно)

Г. Сургаал ба Гэрээ 11:12-14; 50:23-24. (*Илчлэлт Бурханаас ирсэн үү гэдгийг бид ялган таньдаг байх ёстой*)

Илчлэлт үнэхээр Бурханаас ирсэн үү гэдгийг ялган таних нь бидний хувьд чухал гэдгийг тайлбарла. Зарим үед илчлэлт хэмээн бидний бодсон зүйл бидний хүслийн тусгал байж болно. Бас зарим үед хуурамч илчлэлт Сатанаас ирж болно.

- Илчлэлт Бурханаас ирсэн үү гэдгийг бид хэрхэн ялган таньж болох вэ? (С ба Г 11:12-14; 50:23-24-ийг үз). Бурханаас ирдэг илчлэлт судартай, амьд бошиглогчдын зөвлөгөөтэй нийцэж байх ёстой. Ийм илчлэлт гэгээрүүлэгч шинжтэй байх болно. Ийм илчлэлт зөв шударга ёсны зарчмуудад харшлах зүйлүүдийг хийхэд биднийг хөтөлдөггүй гэдэг нь хариулт байж болно)

“Сүнсний нөлөө нь . . . Сүмийн хүлээн авсан илчлэлттэй үл нийцэх ямар нэг зүйлийг дамжуулж байвал эсвэл Сүмийн зохих эрх мэдэлтнүүдийн шийдвэрт харшилж байвал, хичнээн үнэмшилтэй мэт санагдсан ч, Бурханаас ирээгүйг Хожмын үеийн Гэгээнтнүүд мэдэж болно. . . . Сүмийн тэргүүнээр дамжин Бурханаас ирдэг зүйлүүдэд харшлах юу ч гэсэн эрх мэдэлтэйгээр буюу найдвартайгаар хүлээн авагдаагүй байдаг” гэж Тэргүүн Зөвлөл өгүүлжээ (Жеймс Р.Кларк эмхтгэсэн, *Messages of the First Presidency of The Church of Jesus Christ of Latter-day Saints*, 6 боть, [1965-1975], 4:285).

3. Илчлэлт хүлээн аваагүй эсвэл үүнийг таниагүй үед

- Хувийн илчлэлт бидний хүссэн үед ирээгүй бол бид яах ёстой вэ? (Доор жагсаасан зүйлс хариулт байж болно)
 - а. Тэвчээртэй байж, Их Эзэнийг цаашид итгэлтэйгээр хүлээ (С ба Г 98:2). Тэрээр Өөрийнхөө цагт хариулна. Тэвчээрийг хөгжүүлэх нь сүнслэг байдлын хувьд өсч, бурханлиг төлөв байдлыг хөгжүүлэхэд бидэнд тусалдаг. Бурханлиг удирдамжийг эрэлхийлэх үед бүр Бошиглогчид ч гэсэн тэвчээртэй байдгийг та анхааруулж, Сургаал ба Гэрээн дэх Албан Тунхаг 2-т (хуудас 409-411) эш татагдсан захидлын хоёр дахь догол мөрийг уншихыг хүсч болно.

- б. Бид Сүнсний шивнэлтийг танин мэдэж, хүлээн авахын тулд сүнслэг байдлын хувьд биеэ бэлтгэх хүч чармайлтаа нэмэгдүүлэх хэрэгтэй.
- в. Судлах, залбирах хүч чармайлтаа нэмэгдүүл, бид ийм хүч чармайлтыг их удаан биш, харин итгэлтэйгээр, үнэнч шударгаар хийх ёстойг ухаарч ойлго.
- г. Зарлигуудыг дуулгавартай дагахад илүү их итгэлтэй бай (Исаиа 59:2).
- д. Асуудлыг түр зуур хойш тавь. Сүнсний агшин зуурын нөлөө биднийг нэн багаар хүсэн хүлээж байсан үед, бидний оюун ухаан уг асуудалд эзэмдэгдээгүй байгаа үед олонтаа ирдэг.
- е. Бид судалгаа, учир шалтгаан дээр тулгуурлаж, хамгийн шилдэг санаа бодлоо ашиглан өөрсдийнхөө төлөө шийдэх ёстой асуудлаар зөвлөгөө эрэлхийлж болно гэдгийг ухаарч ойлго. Энэ тохиолдолд асуудлыг өөрсдөө шийдэхийг Их Эзэн бидэнд үлдээж болно (жишээ нь, С ба Г 58:25-28; 60:5; 61:22; 62:5-ыг үз). Зөв шударга байдалд өөрсдөө шийдвэр гаргах боломжийг Их Эзэн бидэнд олгодог.
- ё. Бид хариугаа хүлээн авчихсан байж болно. Эсвэл хариу нь бидний найдаж байсан буюу хүсэн хүлээж байсан зүйл биш учраас хариу хүлээж аваагүй байж мэднэ гэдэгт үнэлэлт дүгнэлт өг. Хэрэв бид хүсч байгаа зүйлээ шахаж шаардах юм бол өөрсөдтэйгөө харилцах Сүнсний харилцааг хааж мэднэ.

Ахлагч Боид К.Пакер зөвлөсөн нь:

“Зарим үед та нар асуудалтай зууралдаад хариу авахгүй байж болно. Юу нь буруу байж болох вэ? Та ямар нэг буруу юм хийгээгүй байж болно. Та зөв зүйлүүдийг хангалттай удаан хугацаагаар хийгээгүй байж болно. Сүнсний зүйлсийг албадаж болохгүйг сана. Заримдаа бид хариу хүлээж авахгүй юм байна гэж бодсон учраас л яахаа мэдэхгүй болдог. . .

“Хүнд асуултыг оюун ухаандаа сөргүүлж тавиад, амьдрал ахуйгаа бодож яв. Асуултын талаар тунгаан бодож, чимээгүй, шаргуу залбир.

“Хариулт нь цахилгаан цахих шиг хурдан ирэхгүй байж болно. Хариу энд нэг, тэнд нэг, ‘шат шатаар, дүрэм дүрмээр’ (С ба Г 98:12) сүнсний багахан нөлөө болон ирж болно.

“Зарим хариулт судруудыг уншсанаас, зарим нь үг хэлэгчдийг сонссоноос ирж болно. Мөн зарим үед хариу чухал бол зарим нь ихэд шулуун, хүчтэй сүнсний нөлөөгөөр ирнэ. Өдөөлт нь тод томруун, эндүүрэх аргагүй байна” (In Conference Report, 1979 оны аравдугаар сар, 29-30; *Ensign*, 1979 оны арваннэгдүгээр сар, 21).

Дүгнэлт

Сүнсний хэлэнд нэвтэрхий болох онцгой боломж, үүрэг хариуцлага бид бүгдэд байдгийг онцлон тэмдэглэ. Ариун Сүнсний шивнээг таньж, хүлээн авахад шаардлагатай хүч чармайлт гаргахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Бид өөрсдийгөө бэлтгэж, анхааралтай сонсох юм бол Ариун Сүнсээр дамжуулан “илчлэлт дээр илчлэлт” (С ба Г 42:61) хүлээн авах болно.

Нэмэлт заах санаанууд

1. Хувийн илчлэлтийн тухай хүүхдэд заах нь

Хэрэв та насанд хүрэгчдэд заадаг бол хувийн илчлэлтийн зарчмыг хүүхдэд хэрхэн заах тухай ярилцахыг хүсч болох юм.

2. Гэрлэлтийн талаарх илчлэлтийн тухай анхааруулга

Далын Ахлагч Жон Х.Гробергийн дараах анхааруулга ямар хүнтэй гэрлэх талаар бурханлиг удирдамж эрэлхийлэх чухал зарчмыг тайлбарладаг:

“Та нар мөнхийн гэрлэлтийн талаар Бурханаас нэг талын илчлэлт хүлээн авч чадахгүйг би та нарт. . . анхааруулж байна. Хэрэв хоёр тал хоёул адилхан мэдрэмжтэй байх юм бол илчлэлт Их Эзэнээс ирсэнд бат итгэлтэй байж чадна. Бусдын чөлөөт хүслийг хувийнхаа илчлэлтэд албадан оруулах гэж оролддог хүмүүс өөртөө болоод найз нартаа их хор уршиг тарьдаг” (“What Are You Doing Here?” *New Era*, 1987 оны 1-р сар, 37-38).

3. Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит гэрчлэлээ хүлээн авсан үйл явц

Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит өөрийхөө гэрчлэлийг хэрхэн хүлээн авсан тухай шастирыг хуваалц:

“Би хөвгүүн байхдаа анх удаа үйлчлэлд оролцож эхлэхдээ олон удаа гадагш гарч, гэрчлэл хүлээн авахын тулд надад зарим нэгэн гайхалтай зүйлийг үзүүлэхийг Их Эзэнээс гуйдаг байлаа. Гэвч Их Эзэн гайхамшгийг надаас холдуулж, харин үнэнийг тэрээр надад толгойноос минь хөлийн өсгийг хүртэл мэдүүлэх хүртэл, миний эргэлзээ, айдас надаас бүрмөсөн алга болох хүртэл, үнэнийг шат шатаар, дүрэм дүрмээр энд багахныг бас тэнд багахныг үзүүлсэн билээ. Ингэхийн тулд тэнгэрээс тэнгэр элчийг илгээх шаардлага Түүнд байсангүй. Бас тэргүүн тэнгэр элчийн бүрээгээр мэт ярих шаардлага түүнд байсангүй. Амьд Бурханы Сүнсний намуун, зөөлхөн дуу хоолойны шивнэлтээр тэрээр гэрчлэлийг минь надад өгсөн билээ. Мөн тэрбээр энэхүү зарчим болон хүчээр үнэний тухай мэдлэгийг хүмүүний бүх үрсэд өгөх болно” (*Gospel Doctrine*, 5 дахь хэвлэл, [1939], 7).

“Сайн мэдээний анхдагч зарчмууд ба ёслолууд”

Зорилго

Сайн мэдээний анхдагч зарчмууд болон ёслолууд: Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл, наманчлал, баптисм, гишүүний баталгаанаас ирдэг адислалуудыг ойлгож, эдгээр адислалуудыг эрэлхийлэхэд нь ангийн гишүүдэд туслах.

Бэлтгэл

1. Энэ хичээлийн судруудыг залбирч, судал.
2. *Ангийн гишүүний Судлах Удирдамж* (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.
3. Хэрэв танд дараах зургууд байдаг бол хичээл эхлэхийн өмнө тасалгааны өмнө талд байрлуулсан бай: Их Эзэн Есүс Христ (62572; Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 240), Баптисм (Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 601), Ариун Сүнсний бэлэг (Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 602).
4. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах бол нүд бооход ашиглах даавуу авчир.

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа

Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

Сайн дураараа урагш гарч ирэхийг ангийн нэг гишүүнээс хүс. Нүдийг нь боогоод: *Есүс бол дэлхийн гэрэл* гэсэн өгүүлбэрийг самбарт бичихийг хүс. Боолтыг нь авч, уг өгүүлбэрийг самбар дээр дахин бичихийг түүнээс хүс. Тэгээд түүнийг суулга.

- Нүгэл үйлдэх нь нүдээ боогоод бичихтэй хэр зэрэг адилхан байна вэ? Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлж, нүглээ наманчлах нь нүдний боолтоо авахтай хэр зэрэг адилхан байна вэ? Бид наманчилсан үедээ юуг илүү тод харж чаддаг вэ?

Энэ хичээлээр сайн мэдээний анхдагч зарчмууд болон ёслолуудыг ярилцана гэдгийг тайлбарла. Итгэл, наманчлал, баптисм, Ариун Сүнсний бэлгээр дамжуулан бид мөнхийн замнал, мөнх бус амьдралынхаа зорилгыг илүү сайн харах боломжтой байдаг билээ.

Ярилцах ба хэрэгжүүлэх нь

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбирч, сонго. Энэ хичээлийг та хоёр хуваан зааж болно.

Их Эзэн сайн мэдээг Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан “шат шатаар, дүрэм дүрмээр” (С ба Г 128:21) сэргээснийг тайлбарла. Юуны түрүүнд сэргээх ёстой зарчмууд нь сайн мэдээний анхдагч зарчмууд болон ёслолууд

байлаа. Итгэлийн дөрөв дэх тунхгийг эш татахыг ангийн нэг гишүүнээс хүс. Анхдагч зарчмууд болон ёслолуудыг самбар дээр жагсаа.

1. Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл бол сайн мэдээний анхдагч зарчим мөн

Сайн мэдээний сэргээлт Иосеф Смитийн итгэлийн нэгэн үйлдлээр эхэлснийг хэл (Иосеф Смит–Түүх 1:11-14). Тэрээр уучлал гуйж залбирахдаа, “бурханлиг тунхаглал хүлээж авна гэдэгт бүрэн дүүрэн итгэлтэй байснаа” (Иосеф Смит–Түүх 1:29) цэдэглэсэн Иосефын итгэлийн бас нэгэн үйлдлийн хариуд Моронай хүрч ирсэн билээ.

- Есүс Христэд итгэх итгэлтэй байна гэж юу гэсэн үг вэ? Бид итгэлээ Есүс Христэд төвлөрүүлэх нь яагаад чухал вэ?
- Есүс Христэд итгэх итгэлээ бид хэрхэн бэхжүүлж чадах вэ? (С ба Г 19:23; 88:118; Алма 32:27-г үз. Итгэлээ бид ганц нэгхэн туршлагаар биш, харин алгуураар бэхжүүлдгийг онцлон тэмдэглэ. Итгэлээ хүчтэй байлгахын тулд бид үүнийг байнга тэжээн тэтгэж байх ёстойг хэл) Тохиромжтой үед Христэд итгэх итгэлээ бэхжүүлэхэд нь тэдэнд тусалсан туршлагаа хуваалцахад ангийн гишүүдийг урь.
- Христэд итгэх итгэлээ хэрэглэхийг биднээс шаарддаг өдөр тутмын амьдрал дахь зарим нөхцөл байдал юу вэ? Сэтгэл санаагаар унах, сул дорой байдал, эсвэл бусад бэрхшээлийг даван туулахад итгэл та нарт хэрхэн тусалсан бэ? Христэд итгэх итгэл бусадтай харилцах бидний харилцааг хэрхэн бэхжүүлж чадах вэ? (Эхнэр буюу нөхөртэйгөө, хүүхэдтэйгээ, эцэг эхтэйгээ, тойргийн гишүүн, хөрштэйгөө харилцах харилцааны тухай ярилц)
- Бид Христэд итгэх итгэлээ хэрхэн харуулж болох вэ? (С ба Г 20:69; Иаков 2:14-17.) Христэд итгэх итгэл сайныг үйлдэх бидний хүсэлд хэрхэн нөлөөлдөг вэ?
- С ба Г 8:10-ыг ангийн гишүүдтэй хамт унш. *Итгэлгүй бол* бид юуг амжилттай хийж чадах вэ? *Итгэлтэй* бол бид юуг амжилттай хийж чадах вэ? (Энэ асуултын зарим хариуг С ба Г 35:9; 42:48-51; 63:9-11; Моронай 7:33-аас үз.) Итгэлийн хүч харагдахыг та нар хэрхэн үзсэн бэ?
- Сургаал ба Гэрээнд байнга давтагддаг нэг захиас бол итгэлтэйгээр залбирахын ач холбогдол юм. Жишээ нь, С ба Г 10:46-52-т Мормоны Ном хадгалагдаж ирэхийн төлөө эртний бошиглогчид “залбиралдаа итгэлтэй” байсан учраас энэ ном хадгалагдаж ирсэн юм хэмээн Их Эзэн хэлжээ. Бидний залбиралд итгэл ямар үүрэгтэй вэ?

2. Бид чин сэтгэлийн наманчлалаар дамжуулан Цагаатгалын адислалуудыг хүртэж чадна

Наманчлал бол Сургаал ба Гэрээн дэх үндсэн гол сэдэв гэдгийг тайлбарла. Их Эзэн наманчлалын сургаалыг заадаг бас наманчлалын хэрэгцээг дахин давтан онцлон тэмдэглэдэг билээ. Наманчилдаг хүмүүст Тэрээр агуу адислалуудыг–наманчилдаггүй хүмүүст шийтгэлийг амладаг.

- Наманчлал гэж юу вэ? (С ба Г 58:42-43-ыг үз). Наманчлал бол бид нүглээсээ цэвэршиж, Аврагчийн Цагаатгалын хүчээр дамжуулан нүглийнхээ төлөө уучлал хүлээж авах үйл явц юм. Бид наманчлахын тулд нүглээ хүлээж, орхин нүгэл хилэнцээс эргэх ёстой. Бас бид зүрх сэтгэл, хүсэл бодлоо

Бурханд хандуулж, Түүний зарлигуудыг дуулгавартай дагахыг чин сэтгэлээсээ хичээх ёстой. Наманчлалын явцыг ярилцахын тулд хоёр дахь нэмэлт заах санааг үз.)

- Жинхэнэ наманчлал, зөвхөн муу зуршлыг орхих эсвэл зан төлөвөө өөрчлөхийн хооронд ямар ялгаа байдаг вэ?

Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон: “Наманчлал бол зүгээр л зан төлөвөө шинэчлэхээс илүү том зүйл юм. . . . Жинхэнэ наманчлал бол Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл дээр тулгуурласан, үүнээс үүдэлтэй байдаг. Өөр арга зам гэж үгүй. Жинхэнэ наманчлал нь зүгээр л зан төлөвийн өөрчлөлт биш, харин зүрх сэтгэлийн өөрчлөлт юм (Алма 5:13-ыг үз)” хэмээн тайлбарласан байдаг (*The Teachings of Ezra Taft Benson* [1988], 71).

Арванхоёрын Чуулгын Ахлагч Нийл А.Максвелл, “наманчлал нь хилэнцээс эргэх, Бурханд хандахын аль алиныг нь шаарддаг” гэж сургасан байна (In Conference Report, 1991 оны аравдугаар сар, 40; *Ensign*, 1991 оны арваннэгдүгээр сар, 30).

- С ба Г 18:11-13, 19:16-19-ийг ангийн гишүүдтэй хамт унш. Биднийг хайрладаг Аврагчийн хайрын тухай эдгээр хэсгүүд юу заадаг вэ? Нүглээсээ уучлагдахад Аврагчийн Цагаатгал яагаад бидэнд хэрэгтэй вэ? (Мөн 2 Нифай 2:6-9-ийг үз) Нүглээсээ уучлагдахын тулд бид яагаад наманчлах шаардлагатай вэ?

Нүгэл үйлдэхэд бид цэвэр ариун биш болж, шударга ёсны хуулиар шийтгэгдэхэд хүрдгийг тайлбарла. Бид төгс биш учраас өөрсдөө дахин цэвэр ариун болох буюу шударга ёсны шаардлагыг хангаж чаддаггүй. Аврагч бидний нүглийг цагаатгаснаар, шударга ёсны хуулиар шаардлагатай байсан шийтгэлийг Өөр дээрээ авч, цэвэр ариун болоход бидэнд хэрэгтэй нигүүлсэл, уучлалыг санал болгох боломжтой болсон юм. Бид гагцхүү наманчилсан тохиолдолд л Цагаатгалын эдгээр адислалууд бидэнд хүртээмжтэй болдог билээ (Алма 7:14).

- Жинхэнээр наманчлахад Есүс Христэд итгэх итгэл яагаад бидэнд шаардлагатай байдаг вэ?
- *Наманчлахгүй байхын үр дагавруудыг* самбар дээр бич. Бид нүглээ наманчлахгүй байхын үр дагаврууд юу вэ? (Дараах судруудыг ангийн гишүүнээр уншуулж, үр дагавруудыг тогтоолго: С ба Г 1:33, 19:17-18, мөн 29:17. Эдгээр үр дагавруудыг самбар дээр жагсаа. Бурханаас болон бусад хүмүүсээс холдох, гэм буруу, өөрийнхөө үнэ цэнийг доогуурт бодох, бусад нүглүүдийг хаацайлах, бусдыг уучилдаггүй байх нь бусад үр дагаврууд юм.)
- *Жинхэнэ наманчлалаас ирэх адислалууд* гэж самбар дээр бич. Бид нүглээ жинхэнээр наманчилсан үед Их Эзэн юу амладаг вэ? (Дараах судруудыг ангийн гишүүдээр уншуулж, амлалтуудыг нэрлүүл: С ба Г 1:32, 58:42, мөн 109:53. Эдгээр амлалтуудыг самбар дээр бич) Наманчлал амьдралыг нь хэрхэн адисалсныг ярихад ангийн гишүүдийг урь. (*Анхааруулга:* Өнгөрсөн үеийн нүглээ хүлээсэн талаар тодорхой зүйлүүдийг ярихгүй байхыг та ангийн гишүүдэд сануулж болно)
- Наманчлах юм бол биднийг уучилна гэж Их Эзэн амласан ч, өөрсдийгөө болон бусдыг уучлах нь зарим үед бидэнд яагаад хэцүү байдаг вэ?

- Бид хэрхэн илүү их наманчилдаг болж чадах вэ? Зарим үед бид яагаад наманчлалаа хойшлуулдаг вэ? Бардамнал, сэтгэл санаа мохох, гоморхол эсвэл наманчлахад саад тотгор болж мэдэх өөр ямар нэг зүйлийг бид хэрхэн даван туулж чадах вэ?

“Наманчлал бол хатуу хахир биш, харин аврагч сургаал юм. Наманчлал нь томоохон нүгэл үйлдэгч, улам сайжрахын төлөө хичээж буй сайн хувь хүнд хамаатай юм” гэж Ахлагч Нийл А.Максвелл сургажээ (In Conference Report, 1991 оны аравдугаар сар, 40; *Ensign*, 1991 оны арваннэгдүгээр сар, 30). Наманчлал хэдийгээр хүнд хэцүү үйл явц ч гэсэн, бид зүрх сэтгэлээ нүглээс Бурхан руу эргүүлсэн үед бас агуу баяр баясгаланг авчирч чадна гэдгийг онцлон тэмдэглэ.

3. Баптисм бол зайлшгүй шаардлагатай ёслол

Итгэл болон наманчлал нь сайн мэдээний анхдагч ёслол баптисм руу хөтөлдгийг тайлбарла. Сургаал ба Гэрээнд Их Эзэн баптисмын зорилго, шаардлага болон заавруудыг илчилсэн юм. Иохан Баптист Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан энэ ёслолыг гүйцэтгэхэд шаардлагатай санваарын эрх мэдлийг сэргээжээ (хичээл 8-ыг үз).

- Баптисмын зорилго юу вэ? (С ба Г 18:22; 49:13-14-ийг үз). Бид нүглийн ангижралыг хүлээн авч, Сүмийн гишүүн болоод өргөмжлөл өөд хөтөлдөг замд орсноор, түүнчлэн Ариун Сүнсний бэлэг хүлээн авахад бэлтгэсэнээр Аврагчид хандах хоёргүй сэтгэлээ харуулах нь баптисмын зорилго юм. 2 Нифай 9:23; 31:10-13, 17; Мозая 18:17-г үз.) Баптисмын тухай бодол санаагаа хуваалцахад ангийн гишүүдийг урь.
- С ба Г 20:37-г ангийн гишүүдтэй хамт унш. Баптисм хүртэхийн тулд хүн ямар шаардлагыг хангах ёстой вэ? Бид баптисм хүртэхдээ Бурхантай ямар гэрээнүүд хийдэг вэ? (Мозая 18:8-10-ыг үз.) Бид баптисм хүртэхдээ Их Эзэнд өгсөн амлалтуудаа сахих шийдвэр төгс байдлаа хэрхэн дээшлүүлж чадах вэ?
- Баптисм юуг бэлгэддэг вэ? (С ба Г 76:51; Иохан 3:3-5; Ром 6:3-4-ийг үз). Усанд умбуулах баптисм нь Есүс Христийн үхэл, оршуулга, Амилалтыг бэлгэддэг. Баптисм нь бид өтөлсөн үедээ нас барж оршуулагдахыг мөн Христэд дахин төрөхийг бэлгэддэг. Түүнээс гадна, энэ нь бид нүглээсээ цэвэршихийг бэлгэддэг)
- Зохих эрх мэдэлтэй хүнээс баптисм хүртэх нь яагаад зайлшгүй шаардлагатай вэ? (С ба Г 22-ыг үз.) Баптисм яагаад усанд умбуулалтаар гүйцэтгэгдэх шаардлагатай вэ? (С ба Г 20:72-74-ийг үз.) Найман нас хүрэхээс нь өмнө хүүхдэд баптисм хүртээх нь яагаад тохиромжгүй вэ? (С ба Г 20:71; 29:46-47; 68:25; Мороднай 8:9-12-ыг үз.)

4. Бид гишүүний баталгааны ёслолоор дамжуулан Ариун Сүнсний бэлэг хүлээн авдаг

Ариун Сүнс бол Бурхан тэргүүтний нэг гишүүн бөгөөд “Сүнсэн хүн” (С ба Г 130:22) гэдгийг тайлбарла. Усан баптисмын дараа Сүмийн гишүүд гишүүний баталгааны ёслолоор дамжуулан Ариун Сүнсний бэлэг хүлээн авдаг (С ба Г 33:15; 35:5-6-г үз). Энэ ёслолыг бас “галын баптисм ба Ариун Сүнс” (С ба Г 20:41) гэж нэрлэдэг. “Усан баптисм бол хагас баптисм бөгөөд Ариун Сүнсний

баптисмгүйгээр үр дүнгүй юм” гэж Бошиглогч Иосеф Смит хэлсэн байдаг (*Teachings of the Prophet Joseph Smith*, эмхтгэсэн, Жозеф Фиелдинг Смит [1976], 314).

- Ариун Сүнсний илэрхийлэлт, Ариун Сүнсний бэлэг хоёр ямар ялгаатай вэ?

Арванхоёрын Чуулгын Ахлагч Даллин Х.Өүкс: “Ариун Сүнсний илэрхийлэлт нь чин сэтгэлээсээ эрж хайгчдыг наманчлал ба баптисмд итгүүлэн үнэмшүүлэх сайн мэдээний үнэнүүд рүү удирдахын тулд өгөгддөг. Ариун Сүнсний бэлэг бол бүр илүү өргөн хүрээтэй юм. . . . [Энэ нь] ‘түүний Сүнсийг [бид] үргэлж өөрсөдтэйгөө байлгаж’ (С ба Г 20:77) болох байнгын нөхөрлөлийн эрхийг өөртөө багтаадаг” хэмээн тайлбарлажээ (In Conference Report, 1996 оны аравдугаар сар, 80; *Ensign*, 1996 оны арваннэгдүгээр сар, 60).

Арванхоёрын Чуулгын Ахлагч Брус Р.МкКонки харанхуй, шуургатай шөнө цахилгаан цахихтай адил гялбааг хүн баптисмын өмнө хүлээн авахтай Ариун Сүнсний илэрхийлэлтийг зүйрлэжээ. “Тэрээр Ариун Сүнсний бэлгийг баптисмын дараа хүн “амьдралын замнал болон үүний эргэн тойрон дахь бүх зүйлүүд дээр туяа нь туссан үд дундын нарны удаан үргэлжлэгч гялбааг хүлээн авахтай зүйрлүүлсэн ажээ” (*A New Witness for the Articles of Faith* [1985], 262).

- Ариун Сүнсний бэлэг хүлээн авснаар Ариун Сүнс аяндаа бидэнтэй үргэлж хамт байна гэж бүү бод. Ариун Сүнс бидэнтэй үргэлж хамт байхын тулд бид юу хийх ёстой вэ?

“Бурханы зарлигуудыг дуулгавартай дагаж, сахих хүсэлгүй буюу эдгээр зарлигуудыг зориудаар зөрчдөг хүнд Ариун Сүнс оршихгүй” гэж Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит хэлсэн юм (*Church News*, 1961 оны арваннэгдүгээр сарын 4, 14).

- Ариун Сүнсний зарим үүрэг юу вэ? (Дараах судрын хэсгүүдээс заримыг нь ангийн гишүүдтэй хамт уншихаар сонгож ав. Ариун Сүнсний үүргийн тухай хэсэг бүр юу зааж байгааг ярилц. Мэдээллийг самбар дээр нэгтгэн дүгнэ)

а. С ба Г 18:18; 39:6; 42:14; 75:10; 79:2. (Тэр бол багш; мөн Иохан 14:26; 16:13; 1 Нифай 10:19; Мороднай 10:5-ыг үз)

б. С ба Г 39:6. (Тэр бол Тайтгаруулагч; мөн Иохан 14:16-г үз)

в. С ба Г 42:17; 100:8. (Тэр бол гэрчлэгч; мөн Иохан 15:26; Алма 5:46-г үз)

г. С ба Г 11:12. (Тэрээр биднийг сайныг үйлдэх, даруухан амьдрах, зөв шударгаар шүүхэд удирддаг)

д. С ба Г 11:13; 76:10. (Тэр бидний оюун ухааныг гэгээрүүлж, бодгалийг маань баяр баясгалангаар дүүргэдэг)

е. С ба Г 84:33. (Түүгээр дамжин бид ариусдаг; мөн 3 Нифай 27:20-ийг үз)

ё. С ба Г 31:11; 75:27; 84:85. (Хаашаа явах, юу хийх, юу хэлэх зэрэгт Тэрээр бидэнд сүнслэгээр нөлөөлдөг)

Ариун Сүнс тэднийг эдгээр болон бусад арга замаар хэрхэн адисалсныг нь ярихад ангийн гишүүдийг урь. Бид амьдралдаа эдгээр адислалуудыг яаж илүү бүрэн дүүрэн хүртэж болох тухай ярилц. Бурхан тэргүүтний гишүүдийн нэгэнтэй нь нөхөрлөлтэй байх нь бидний хувьд ямар чухал онцгой

боломж байдгийг анхаар. Ариун Сүнс тэй нөхөрлөхийн ач холбогдлын тухай гэрчлэлээ хуваалц.

5. Бид мөнх амьдралыг хүлээн авахын тулд эцсийг хүртэл итгэлтэй байж тэвчих ёстой

Бид баптисм хүртсэнээр өргөмжлөл өөд хөтөлдөг зам дээр гардаг. Гэвч биднийг өргөмжлөгдөхөд энэ туршлага дангаараа хангалтгүй. Сургаал ба Гэрээнд Их Эзэн байнга зөвлөснөөр бид баптисмаар байгуулсан гэрээнүүд дээ насан туршдаа итгэлтэйгээр сахих ёстой.

- 2 Нифай 31:19-20, С ба Г 14:7-г ангийн гишүүдтэй хамт унш. Эцсийг хүртэл тэвчих гэж юу гэсэн үг вэ? Хэрэв бид эцсийг хүртэл тэвчих юм бол Их Эзэн ямар адислалуудыг бидэнд амласан бэ?
- Итгэл бишрэл болон гэрээнүүддээ үнэнч байхын үнэ цэнийг ямар тохиолдлоор та нар сурсан бэ?
- С ба Г 24:8-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Амьдралын хүнд сорилтуудын үед итгэлтэй хэвээр байх нь эцсийг хүртэл тэвчих явдал мөн гэдгийг тайлбарла. Бид хүнд хэцүү үед хэрхэн итгэлтэй хэвээр үлдэж чадах вэ? (Хүнд хэцүү туршлагыг тэсэн тэвчихэд тэдэнд юу тусалсныг ярихад ангийн гишүүдийг урь)

Дүгнэлт

Сайн мэдээний анхдагч зарчмууд болон ёслолуудын ач холбогдлын тухай гэрчлэлээ хэл. Есүс Христ, Түүний Цагаатгал, үлгэр жишээний төлөө талархлаа илэрхийл. Өдөр бүр итгэлээ бэхжүүлж, нүглээ наманчлан, баптисмын гэрээгээ сахиж, Ариун Сүнс байнгын хамтрагч нь байхуйцаар амьдрахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Хэрэв бид эцсийг хүртэл тэвчих юм бол өргөмжлөгдөх болно гэдгийг гэрчил.

Нэмэлт заах санаанууд

1. “Итгэлийн бамбай” (С ба Г 27:17)

С ба Г 27:15, 17-г ангийн гишүүдтэй хамт унш. Энэ судрын тухай Ерөнхийлөгч Бойд К.Пакер ийн хэлжээ:

“Итгэлийн бамбайг үйлдвэрт хийдэггүй харин гэр бүлийн гишүүдийн эерэг нааштай харилцан ажиллагааны үр дүн болгон гэр оронд хөгжүүлдэг.

“Бидний заадаг бүхний эцсийн зорилго нь Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлд эцэг эхчүүд, үр хүүхдийг нэгтгэх, тэднийг гэр оронд нь аз жаргалтай байлгаж, мөнхийн гэрлэлтэд пацдан холбуулж, үр удам, өвөг дээдэстэйгээ холбогдох, тэрчлэн Тэнгэрлэг Эцэгийнхээ оршихуйд өргөмжлөгдөхөд бат итгэлтэй байлгах явдал мөн. . .

“ . . . Тиймээс хийх ёстой хамгаас эрхэм чухал ажил гэр оронд хийгдэх ёстойг ойлгоход нь манай удирдагчид гишүүдэд хүчтэйгээр нөлөөлдөг. Гэвч сайн зорилттой боловч, гэр орноос гадуурх хэт олон үйл ажиллагааны улмаас гэр оронд итгэлийн бамбайг бий болгож, төлөвшүүлэхэд хэтэрхий бага цаг үлдэж байгааг зарим хүмүүс олж харахгүй хэвээр байна” (In Conference Report, 1995 оны 4-р сар, 8; *Ensign*, 1995 оны 5-р сар, 8-9).

- Гэр бүлд итгэлийн бамбайг бий болгож, бэхжүүлэхэд эцэг эх, хүүхдүүд хэрхэн хамтран ажиллаж болох вэ?

2. Наманчлалын үйл явц

- Наманчлахын тулд бид юу хийх ёстой вэ? Наманчлалын үйл явцын тухай С ба Г 58:43, 61:2 юу заадаг вэ? Нүглээ хүлээх нь яагаад наманчлалын чухал хэсэг байдаг вэ? Бид наманчлалын хэсэг болгон нүглээ орхих нь яагаад чухал вэ?

Наманчлалын зайлшгүй бүрдүүлбэрүүдийг Арванхоёрын Чуулгын Ахлагч Ричард Ж.Скотт дараах байдлаар томъёолсон байна:

“Нүглийн төлөө харамсах. Энэ нь өөрчлөгдөх чин сэтгэлийг, уучлалын шаардлага бүрийг хангах хүсэл эрмэлзлийг бий болгодог. . .

“Нүглийг орхих. Энэ бол зөрчлийг давтахгүй байхаар хатуу чанд, эгнэгт шийднэ гэсэн үг юм. . .

“Нүглээ хүлээх. Та нүглээ Их Эзэнд үргэлж хүлээх хэрэгтэй. Хэрэв нүгэл нь ёс суртахуунгүй явдал зэрэг ноцтой зөрчил байгаа бол ийм нүглийг бишопт буюу гадасны ерөнхийлөгчид хүлээх хэрэгтэй. . .

“Нүглээс үүдсэн хохирлыг барагдуулах. Та хулгайлсан, эвдэлсэн эсвэл бузарласан бүх зүйлийг аль болохоор нөхөн төлөх ёстой. . .

“Бүх зарлигуудад дуулгавартай байх. Бүрэн дуулгавартай байдал нь таны амьдралд сайн мэдээний бүрэн төгс хүчийг авчирдаг. . . Энэ нь цуглаануудад оролцох, аравны нэгийг төлөх, үйлчлэл үзүүлэх, бусдыг уучлах зэрэг эхлээд харахад наманчлалын хэсэг гэж таны бодмооргүй зүйлүүд байдаг. . .

“Аврагчийг хүлээн зөвшөөрөх. Гэтэлгэгч байгаа учраас уучлал ирдэг гэдэг итгэл үнэмшил наманчлалд шаардлагатай бүх алхмуудаас та нарт хамгийн чухал гэдгийг би гэрчилж байна” (In Conference Report, 1995 оны 4-р сар, 102; *Ensign*, 1995 оны 5-р сар, 76-77).

Хэрэв та залуучуудад заадаг бол *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* (36550) товхимол дахь наманчлалын тухай зөвлөгөөг тэднээр уншуулж, ярилцаж болох юм.

3. Бүлгийн танилцуулга

Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга (34730)-ыг ангид авчир. Ангийг хоёр бүлэгт хувааж, зургуудыг тэнцүү хувааж өг. Тэгээд зургуудыг ашиглан сайн мэдээний анхдагч зарчмууд ба ёслолуудын тухай заах нэг захиас бэлтгэхэд хэдэн минут гаргахыг тэднээс хүс. 5-10 хүртэлх үзүүлэнг ашиглахад тэднийг урамшуулан дэмж. Бүлэг бүрд танилцуулгаа ярих цаг гаргаж өг.

Зорилго Санваарын сэргээлтийн төлөөх ангийн гишүүдийн талархлыг нэмэгдүүлэх, алба, дуудлагаа хичээл зүтгэл гарган биелүүлэхэд ах нарыг урамшуулан дэмжих, санваарын адислалуудыг бүрэн дүүрэн эдлэхэд нь бүх гишүүдэд туслах.

Бэлтгэл

1. Дараах судрууд болон бусад материалыг залбирч судал:
 - а. Сургаал ба Гэрээ 13; 20:38-67; 27:12-13; 84:6-30; 107:1-20; 110:11-16; Иосеф Смит-Түүх 1:66-73.
 - б. Иосеф Смит-Түүх 1:71-ийн зүүвэр тайлбар дахь Аароны санваарын сэргээлтийн тухай Оливер Каудерийн шастир.
 - в. *Бидний Өв*, хуудас 13-16.
2. *Ангийн гишүүний Судлах Удирдамж* (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.
3. Мелкизедек санваарын сэргээлтийн зураг байдаг бол (62371; Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 408) хичээл дээр ашиглахаар бэлтгэ.
4. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах бол олон төрлийн түлхүүрийн цуглуулгыг хичээл дээр авчир.

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

Нэлээд хэдэн түлхүүрийг өргөж харуул.

- Энэ түлхүүрүүдийн зорилго юу вэ?

Санваар гэдэг үгийг самбар дээр бич. Бид Сүмд санваарын түлхүүрүүдийг олонтаа хэрэглэдгийг тайлбарла.

- Санваарын түлхүүрүүдийн зорилго юу вэ?

Санваарын түлхүүрүүд нь гадас, тойрог, чуулгын хэмжээнд Сүмийг тэргүүлэх болон чиглүүлэх эрх мэдлийг санваар эзэмшигчдэд олгодгийг тайлбарла. Санваарын тэргүүлэх удирдагчид онцгойлон адислагдахдаа эдгээр түлхүүрүүдийг хүлээн авдаг. Санваарын бүх алба болон Сүмийн байгууллага эдгээр тэргүүлэх эрх мэдэлтнүүдийн удирдлагаар үйл ажиллагаа явуулдаг. Энэ хичээл нь санваарын сэргээлт болон түүний түлхүүрүүдийн тухай юм.

Ярилцах ба хэрэг-
жүүлэх нь

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбиран сонгож ав. Судрын зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Санваарын тодорхойлолт ба зорилго

Санваар Сургаал ба Гэрээн дэх гол сэдвүүдийн нэг юм гэдгийг тайлбарла. Санваарын түлхүүр, алба, санваартны байгууллага, санваарын ёслолууд ба үүргүүд, түүнчлэн санваарын адислалуудын тухай бидний ойлголт дээр ихийг нэмсэн олон илчлэлтийг Их Эзэн Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгсөн билээ. Эдгээр илчлэлтүүд дэлхий дээрх Бурханы ажлыг урагш ахиулахад санваарыг ашиглах удирдамжаар хангадаг.

- Санваар гэж юу вэ? (Санваар бол Бурханы мөнхийн хүч болон эрх мэдэл юм. Энэ бол Тэрээр тэнгэр, газрыг бүтээсэн, тэнгэр газрыг удирддаг хүч мөн. Энэ бол Тэрээр Өөрийн хүүхдүүдийг гэтэлгэж, өргөмжлөх хүч юм. Сүмийн зохистой эрэгтэй гишүүд сайн мэдээг номлож, авралын ёслолуудыг гүйцэтгэн газар дээрх Түүний хаант улсыг удирдахын тулд Тэрээр санваарынхаа хүч, эрх мэдлийн нэг хэсгийг тэдэнд өгсөн юм)
- Дэлхий дээр санваар байх нь яагаад чухал вэ? (Бурханы хүүхдүүдийг адислах болон өргөмжлөлд бэлтгэхэд нь туслахад Түүний нэрээр үйлдэх эрх мэдлийг санваар эрэгтэйчүүдэд олгодог нь хариулт байж болно)
- Бурханы хүүхдүүдийг адислахын тулд санваар эзэмшигчид Түүний нэрээр үйлддэг зарим арга хэлбэр юу вэ? (С ба Г 20:38-55; 107:8-12, 23, 35-аас сонгож авсан шүлгүүдийг үз.) Санваар эзэмшигчдийн үйлчлэлээр дамжуулан та нар хэрхэн адислагдсан бэ?
- Танд санваар ямар нөлөө үзүүлдэг вэ? Санваарын хүч амьдралд чинь илэрхийлэгдэхийг та хэрхэн харсан бэ?
- Санваар гэр бүлийг чинь хэрхэн адисалж, бэхжүүлсэн бэ? Та амьдралдаа болон гэр бүлдээ санваарын нөлөө, хүчийг хэрхэн илүү үр ашигтай болгож чадах вэ?

2. Аароны санваарын сэргээлт

Иосеф Смит–Түүх 1:68-72; С ба Г 13; 84:26-27; 107:20-ийг зааж, ярилц. Аароны санваар бол “илүү дээд буюу Мелкизедек санваарын хавсралт” (С ба Г 107:14) гэдгийг тайлбарла.

- Хожмын өдрүүдэд Аароны Санваар дэлхий дээр хэрхэн сэргээгдсэн бэ? (Иосеф Смит–Түүх 1:68-72, *Бидний Өв*, хуудас 13-15; мөн С ба Г 13-ыг үз. Аароны санваарын сэргээлт бол энэ эрин үед бурханлиг эрх мэдлийг анх удаа соёрхсон хэрэг мөн гэдгийг хэл)
- (Санваар эзэмшигчдийн хувьд) Аароны санваар хүлээн авах үед танд ямар санагдсан бэ?

Аароны санваар хүлээн авсан тухай Оливер Каудерийн санаа бодлыг нэгтгэн дүгнэхийг та хүсч болох юм (Иосеф Смит–Түүх 1:71-ийн зүүвэр тайлбарыг үз). Диконы албад томилогдсон нь өөрт нь хэрхэн нөлөөлсөн тухай Арванхоёрын Чуулгад үйлчилж байсан Ахлагч Жеймс И.Талмейжийн дараах бодол санааг та хуваалцаж болно:

“Намайг томилсон тэр даруйд би хэзээ ч бүрэн дүрсэлж эс чадах нэгэн мэдрэмж надад төрж билээ. Над шиг бяцхан хөвгүүн санваарт дуудагдах нь Бурханаас хүндэтгэл хүлээсэн ховорхон боломж юм шиг санагдаж билээ. . . Би Их Эзэнд харьяалагддаг мөн надаас шаардагдах юунд ч туслах болно гэсэн бодол надад хүчтэйгээр мэдрэгдсэн.

“Томилолтын маань нөлөө. . . хөвгүүн миний амьдралын бүхий л талд. . . орж ирэх нь тэр. . . Сургуулийн гаднах талбай дээр тоглож байхад, магадгүй, тоглож байхдаа булхайцахыг оролдох үед, хамт тоглогчидтойгоо маргах үед—‘Би бол дикон шүү дээ, Дикон ийм байдлаар авирлах нь зөв биш’ гэж чанга хэлмээр санагддаг, тэгж бодох ёстойг ч би санадаг байлаа. Шалгалтын үед бусад хөвгүүдийн ажлыг хуулчих нь надад хялбар юм шиг санагдах үед . . . , ‘Би бол дикон учраас ингэх нь миний хувьд тэдэнд байдаг ёс бусаас бүр ч илүү ёс бус явдал болно шүү дээ’ гэж дотроо хэлдэг байлаа” (*Incidents from the Lives of Our Church Leaders* [Диконуудын зааврын гарын авлага, 1914], 135-136).

- Хөвгүүд, залуу эрэгтэйчүүд Аароны санваар хүлээн авахад яаж бэлтгэж болох вэ? Эцэг эх, өвөө эмээ нар, бусад хүмүүс уг санваарыг хүлээн авахад хөвгүүд, залуу эрэгтэйчүүдэд хэрхэн тусалж болох вэ? Санваарын төлөөх гүнзгий хүндэтгэлийг бусад хүмүүс, хөвгүүд, залуу эрэгтэйчүүдийн дотоод сэтгэлд хэрхэн төлөвшүүлж болох вэ?
- Аароны санваараар ямар эрх мэдэл, адислалууд сэргээгдсэн бэ? (С ба Г 13; 84:26-27; 107:20-ийг үз. Энэ ярилцлагыг явуулахын тулд дараах мэдээллийг ашигла. Толгой гарчгуудыг самбар дээр бич)

Тэнгэр элчийн тохинууллын түлхүүрүүд (С ба Г 13; 84:26; 107:20)

- Тэнгэр элчийн тохинууллын түлхүүрүүдийг“? (С ба Г 13) эзэмших гэж юу гэсэн үг вэ?

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли: “Хэрэв та нар санваарын хувьд зохистойгоор амьдрах юм бол үүнийг хүлээн авч, өөрсдийг чинь удирдах, хамгаалах, адислах Тэнгэрлэг хүмүүн биесийн тэрхүү хүчийг эдлэх эрх та нарт байх болно гэсэн үг юм гэж би тайлбарлана” гэжээ (In Conference Report, 1982 оны аравдугаар сар, 64; *Ensign*, 1982 оны арваннэгдүгээр сар, 45).

Тэнгэр элчийн тохинуулал буюу үйлчлэл нь тэд биеэр хүрч ирж болно, “бас үзэгдэхгүй ч байж болно. Тэнгэр элчийн захиас нь зөвхөн дуу хоолойгоор, эсвэл оюун ухаантай харилцах бодол санаагаар буюу мэдрэмжээр ирж болно. . . Тэнгэр элчийн ихэнх харилцаа нь харагдахаасаа илүүгээр мэдрэгдэх буюу сонсогддогийг” тайлбарла (Даллин Х.Өүкс, In Conference Report, 1998 оны аравдугаар сар, 51; *Ensign*, 1998 оны арваннэгдүгээр сар, 39).

- Аароны санваарын сэргээлтээр дамжин, тэнгэр элчийн тохинуулал нь зөвхөн санваар эзэмшигчдэд төдийгүй, Сүмийн бүх гишүүдэд хүртээмжтэй юм. Бид тэнгэр элчийн тохинууллыг хэрхэн хүлээн авч болох вэ? (Моронай 7:35-37 болон дараах эшлэлийг үз)

Арванхоёрын Чуулгын Ахлагч Даллин Х.Өүкс ариун ёслолыг хүртэх, тэнгэр элчийн тохинууллын хоорондох харилцааны тухай хэлсэн нь:

“Аароны Санваарын баптисм болон ариун ёслолоор дамжуулан бид нүглээсээ цэвэршдэг. Хэрэв бид гэрээнүүдээ сахих юм бол Түүний Сүнс

үргэлж бидэнтэй хамт байх болно хэмээн амладаг билээ. Энэхүү амлалт нь зөвхөн Ариун Сүнсэнд төдийгүй, тэнгэр элчийн тохинуулалд холбогдоно. Учир нь ‘тэнгэр элчүүд Ариун Сүнсний хүчээр ярьдаг; иймийн тул тэд Есүсийн тухай үгсийг ярьдаг’ (2 Нифай 32:3). Иймээс Аароны санваар эзэмшигчид ариун ёслолоос зохистойгоор хүртэж, Их Эзэний Сүнсний болон тэнгэр элчийн тохинууллыг эдэлдэг Сүмийн бүх гишүүдэд хаалгыг нээж өгдөг” (In Conference Report, 1998 оны аравдугаар сар, 51; *Ensign*, 1998 оны арваннэгдүгээр сар, 39).

Тэнгэр элчийн тохинууллын тухай судрын хоёр буюу гурван хэсгийг нэгтгэн дүгнэхийг та хүсч болох юм. Эдгээр хэсгүүдэд 3 Нифай 7:18; 17:23-24; Мороднай 7:25, 29-31; С ба Г 84:88 орно.

Наманчлал ба баптисмын түлхүүрүүд (С ба Г 13; 84:26-27; 107:20)

Наманчлал баптисм хоёрыг “бэлтгэл сайн мэдээ” (С ба Г 84:26-27) гэдгийг тайлбарла. Учир нь гэвэл Ариун Сүнсний бэлэг, Ариун сүмийн ёслолууд зэрэг Мелкизедек санваараар дамжин гүйцэтгэгддэг дээд адислалуудыг хүлээн авахад наманчлал баптисм хоёр бидэнд тусалдаг.

- Иохан Баптист наманчлалыг зааж, Аврагчид хүрэх замд бэлтгэхийн төлөө хүмүүст баптисм хүртээж байсныг хэл (Матай 3:1-6, 11). Аароны санваар эзэмшигчид өнөө үед наманчлалыг хэрхэн номлож болох вэ? (Гэрийн багшлалт, номлогчийн ажил, гэрчлэлээ хэлэх, нөхөрлөл нь ариулт байж болно) Аароны санваар эзэмшигчид баптисмын ёслолд хэрхэн оролцож болох вэ? (Бишопын удирдлагаар зохистой санваартнууд баптисмыг гүйцэтгэж, баптисмын үеэр гэрчээр үйлчилж болно)

Хүнд баптисм хүртээсэн ах нарыг баптисмын ёслолыг гүйцэтгэсэн тухай бодол санаагаа хуваалцахад урь.

- Баптисмаас гадна Аароны санваар эзэмшигчид ариун ёслолд үйлчилж болно. Ариун ёслол нь наманчлал ба баптисмтай хэрхэн холбоотой вэ?

Анх удаа ариун ёслол бэлтгэж, адислан, түгээхэд ямар санагдсаныг нь хуваалцахад ах нарыг урамшуул. Эсвэл хөвгүүд ариун ёслол бэлтгэх, адислах, түгээхэд ямар санагддаг тухай бодол санаагаа хуваалцахыг эцэг эхчүүдээс хүс.

Арванхоёрын Чуулгын Ахлагч Жефффри Р.Холланд: “Аврагчийн золиослолын эдгээр бэлгэдлүүдийг зохистойгоор бас хүндэтгэлтэйгээр бэлтгэж, адислан түгээдэг байхыг Аароны санваартан залуу эрэгтэйчүүд та нараас бид хүсдэг. Ийм гайхалтай залуу насанд өгөгдсөн хичнээн эрхэм онцгой боломж, ариун итгэл билээ! Тэнгэр та нарт өгсөн үүнээс илүү өндөр магтаалыг би санахгүй байна. Бид та нарт хайртай. Цэвэр ариунаар амьдарч, Их Эзэний Үдшийн зоогийн ариун ёслолд оролцохдоо өөрсдийгөө хамгийн эрхэм сайхан байлга” хэмээн хэлжээ (In Conference Report, 1995 оны аравдугаар сар, 89; *Ensign*, 1995 оны арваннэгдүгээр сар, 68).

3. Мелкизедек санваарын сэргээлт

С ба Г 27:12-13; 84:19-22; 107:1-12, 18-19-ийг зааж, ярилц. Мелкизедек санваар бол дээд санваар гэдгийг тайлбарла. Үүнтэй холбоотой бүх зүйл бол Бурханы хүүхдүүдийн өргөмжлөлд шаардлагатай эрх мэдэл, мэдлэг, гэрээнүүд юм.



Сасквиеханна гол. Аароны болон Мелкизедек санваар 1829 онд энэ голын эрэг дээр сэргээгджээ (С ба Г 13; 128:20).

- Хожмын үед Мелкизедек санваар дэлхий дээр хэрхэн сэргээгдсэн бэ? (Мелкизедек Санваарын Сэргээлтийн зургийг үзүүл. Иохан Баптист Аароны санваарыг сэргээснээс хойш хэдэн долоо хоногийн дараа Петр, Иаков, Иохан нар Иосеф Смит, Оливер Каудери хоёр дээр хүрч ирэн тэдэнд Мелкизедек санваар хүртээснийг тайлбарла. Энэ Сургаал ба Гэрээнд ороогүй юм. Гэвч энэ тухай эшлэлүүдийг С ба Г 13; С ба Г 27:12-13-ын хэсгийн тойм; С ба Г 128:20; *Бидний Өв*, хуудас 16-гаас олж үзэж болно.)
- Мелкизедек санваараар ямар эрх мэдэл болон адислалууд сэргээгдсэн бэ? (С ба Г 84:19-22; 107:8-12, 18-19; 110:11-16-г үз. Энэ ярилцлагыг явуулахын тулд дараах мэдээллийг ашигла. Толгой гарчгуудыг самбар дээр бич.)

Есүс Христийн сайн мэдээг гүйцэтгэх эрх мэдэл (С ба Г 84:19)

- Есүс Христийн сайн мэдээг гүйцэтгэх эрх мэдэл Мелкизедек санваарт байдаг гэсэн нь юу гэсэн үг вэ? (С ба Г 84:19-ийг үз. Сүмийг удирдах, сайн мэдээг номлох, авралын ёслолуудыг гүйцэтгэх эрх мэдлийг Мелкизедек санваар өөртөө багтаадаг нь хариулт болж чадна)

“Сүмийн сүнсний бүх адислалын түлхүүрүүд” (С ба Г 107:18)

- Мелкизедек санваараар дамжин бидэнд ирдэг сүнсний ямар адислалууд байдаг вэ? (С ба Г 84:19-22; 107:18-19-ийг үз. Доор жагсаасан зүйлүүд хариулт болж чадна. Адислал бүрийн утгыг, түүнчлэн ангийн гишүүдийн амьдралд адислал хэрхэн хэрэгждэгийг ярилц)
 - а. Хаант улсын нууцуудын тухай мөн Бурханы тухай мэдлэг (С ба Г 84:19; 107:19; энэ мэдлэг Ариун Сүнсний бэлгээр дамжин ирдэг).
 - б. Сайн мэдээний ёслолуудаар дамжин илэрхийлэгддэг бурханлиг чанарын хүч (С ба Г 84:20-21). Санваарын ёслолууд “бурханлиг чанарыг” бидний амьдралд хэрхэн илэрхийлдэг вэ? Сайн мэдээний ёслолуудаар дамжин илэрдэг “бурханлиг чанарын хүчийг” мэдэрсэн туршлагаа хуваалцахад ангийн гишүүдийг урь.

в. Бурхан Эцэг, Түүний Хүү Есүс Христийг харж тэдэнтэй харилцан тэдний оршихуйд байх боломж (С ба Г 84:22; 107:19).

- Мелкизедек санваар эзэмшигчид гэр орондоо сүнсний удирдагч байх арга зам юу вэ?

Ерөнхийлөгчийн Зөвлөлийн эрх (С ба Г 107:8-9)

Ерөнхийлөгчийн Зөвлөлийн эрх бол Сүмийг тэргүүлэх эрх юм гэдгийг тайлбарла. Сүмийн Ерөнхийлөгч бол Сүмийг бүхэлд нь удирдах санваарын түлхүүрүүдийг эзэмшдэг (эсвэл ашиглах эрх мэдлийг өөр хүнд олгодог) дэлхий дээрх цорын ганц хүн мөн. Тэрээр дуудлагадаа тэргүүлэхэд нь шаардлагатай түлхүүрүүдийг эзэмших эрх мэдлийг санваартны дараах удирдагчдад олгодог. Үүнд: Ариун сүмийн ерөнхийлөгч, номлолын ерөнхийлөгч, гадасны ерөнхийлөгчид, бишопууд, дүүргийн болон салбарын ерөнхийлөгчид, түүнчлэн чуулгын ерөнхийлөгчид.

Израилын цугларалтын түлхүүрүүд, Абрахамын эрин үеийн сайн мэдээ ба лацдалтын хүч (С ба Г 110:11-16)

Эдгээр түлхүүрүүдийг Мосе, Елиас, Елиа нар 1836 онд Көртландын Ариун сүмд сэргээснийг тайлбарла. Түлхүүрүүдийн тухай хичээл 18-аар ярилцах болно.

4. Санваарын адислалууд бүх хүмүүст

Зөвхөн Сүмийн зохистой эрэгтэйчүүд санваарыг эзэмшдэг ч гэсэн санваарын адислалуудыг хүн бүр хүртэж болно гэдгийг тайлбарла.

- Санваараар эмэгтэйчүүд яаж адислагддаг вэ? Санваараар хүүхэд хэрхэн адислагддаг вэ? (Эмэгтэйчүүд, хүүхдүүд амьдралынхаа туршид хүлээн авч болох санваарын зарим адислалуудыг нэгтгэн дүгнэ. Эмэгтэйчүүд, хүүхдүүд санваар эзэмшдэггүй ч гэсэн тэд санваараар байнга адислагддаг гэдгийг онцлон тэмдэглэ. Эдгээр асуултуудад хариулахад тусалцаа авахын тулд *Хожмын Үеийн Гэгээнтэн Эмэгтэй*, хэсэг А, бүлэг 12, 13-ыг үз [31113].)
- Гэрт нь итгэлтэй санваар эзэмшигчид байхгүй хүмүүс санваарын адислалуудыг хэрхэн хүлээн авч болох вэ? (Гэрийн багш нар, санваартны удирдагчид, мөн ойрын садан төрлийн гишүүдээр дамжуулан санваарын адислалыг авч болох нь хариулт байж болно) Гэрт нь амьдардаггүй санваар эзэмшигчдээс санваарын адислалууд хүлээж авсан туршлагынхаа тухай ярихад нь ангийн гишүүдийг урь.
- Санваарын адислалуудын төлөөх талархлаа бид хэрхэн харуулж болох вэ?

Дүгнэлт

Санваар болон санваарын түлхүүрүүд сэргээгдсэнийг гэрчил. Санваар эзэмшигчид дэлхий дээр Бурханы ажлыг чиглүүлэх, Түүний хүүхдүүдийг адислах, өргөмжлөлд бэлтгэхэд нь туслахад Түүний өмнөөс үйлдэх эрх мэдлийг атгадаг. Санваарын адислал бүх хүмүүст боломжтойг онцлон тэмдэглэ. Эдгээр адислалыг эрэлхийлэхэд нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Нэмэлт заах санаанууд

Та зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болгож дараах санаануудаас нэгийг буюу хоёуланг нь ашиглаж болно.

1. Санваарын алба, чуулгууд ба үүрэг

Санваарын алба, түүний үүрэг болон санваар эзэмшигчдийн зохион байгуулагддаг чуулгуудын тухай чухал зааврыг Их Эзэн Иосеф Смитэд илчилжээ. Та эдгээр заавруудаас заримыг нь доорх схемд харуулсны дагуу нэгтгэн дүгнэхийг хүсч болно:

Аароны санваар

Алба	Үүргүүд	Чуулга
Дикон	С ба Г 20:57-59; 84:111	С ба Г 107:85
Багш	С ба Г 20:53-59; 84:111	С ба Г 107:86
Прист	С ба Г 20:46-52	С ба Г 107:87-88
Бишоп	С ба Г 107:13-17, 68, 71-72, 87-88	

Мелкизедек санваар

Алба	Үүргүүд	Чуулга
Ахлагч	С ба Г 20:38-45; 42:43-44; 43:15-16; 107:11-12	С ба Г 107:89; 124:137
Дээд прист	С ба Г 107:10, 12, 17	С ба Г 124:133, 136
Патриарх	С ба Г 124:91-93, 124	
Дал	С ба Г 107:25, 34, 38, 97	С ба Г 107:25-26; 93-96; 124:138-139
Төлөөлөгч	С ба Г 27:12-13; 107:23, 33, 35, 39, 58; 112:30-32; 124:128	С ба Г 107:23-24

Солт Лейкийн Ариун сүмийн зургийг үзүүл (62433; Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 502). Ариун сүмийн зүүн үзүүр дэх шовх орой нь баруун талын үзүүрийнхээс илүү өндөр байдгийг тайлбарла. Бас зүүн талын шовх орой дээр таван цонх, баруун талынх дээр дөрвөн цонх байгааг ажигла. Энэ зураг төсөл нь санваарыг, Мелкизедек санваар болон үүний таван албыг зүүн шовх орой нь Аароны санваар болон үүний дөрвөн албыг баруун шовх орой нь тус тус төлөөлдгийг тайлбарла.

2. “Санваарын сэргээлт” видео танилцуулга

Хэрэв *Doctrine and Covenants and Church History Video танилцуулгууд* (53912) байдаг бол хичээлийн хоёр дахь хэсгийн түүхэн үндэс суурийн тухай мэдлэг өгөхийн тулд “Санваарын сэргээлт” найман минутын хэсгийг үзүүлэхийг бод.

Зорилго

Бошиглогч Иосеф Смитээр дамжин Есүс Христийн Сүм сэргээгдсэн тухай ангийн гишүүдэд заах, Сүмийн гишүүчлэлийн адислалууддаа талархахад нь тэдэнд туслах, Их Эзэний Сүмийн гишүүнчлэлийнхээ төлөө Түүнд талархлаа харуулахад нь тэднийг урамшуулан дэмжих.

Бэлтгэл

1. Дараах судрууд болон бусад материалыг залбирч судал:
 - а. Сургаал ба Гэрээ 20:1-36, 68-69, 75-79; 21; 27; 115:1-4.
 - б. *Бидний Өв*, хуудас 16-19.
2. *Ангийн гишүүний Судлах Удирдамж* (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.
3. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх хоёр дахь үйл ажиллагааг ашиглах бол ангийн гишүүн бүрд хэсэг цаас, үзэг эсвэл харандаа авчир.

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа

Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл. Ангидаа хамгийн сайн тохирох үйл ажиллагааг сонго.

1. Хэрэв танай анги цөөхөн хүнтэй бол Сүмийн гишүүн байгаагийнхаа төлөө баяр талархалтай байдаг нэг шалтгааныг товчхон хуваалцахыг ангийн гишүүн бүрээс хүс. Хэрэв анги чинь том бол та үүнийг ангийн цөөн гишүүнд даалгаж болно.
2. Дараах асуултуудыг самбар дээр бич. Ангийн гишүүн бүрд хэсэг цаас, үзэг эсвэл харандаа өг. Эдгээр асуултуудаас аль болох олных нь хариултыг бичиж тэмдэглэхийг тэднээс хүс:

Энэ эрин үед Сүм хэдэн оны хэдэн сарын хэдний өдөр зохион байгуулагдсан бэ?

Сүм хэзээ зохион байгуулагдах ёстойг Иосеф Смит яаж мэдсэн бэ?

Сүм хаана зохион байгуулагдсан бэ?

Сүм анх зохион байгуулагдахад хэдэн гишүүнтэй байсан бэ?

Энэ хичээлээр Есүс Христийн Сүм хожмын үед зохион байгуулагдсан тухай ярилцах болно гэдгийг тайлбарла. Хичээлийн явцад асуултуудын хариултыг сонсож, шаардлага гарвал хариуг тэмдэглэх буюу зөв болгоход ангийн гишүүдийг урь.

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбиран сонгож ав. Сонгосон судрууд өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэгийг ярилц. Судрын зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Хожмын өдрүүдэд Сүм зохион байгуулагдсан нь

1830 он дэлхийн түүхэнд чухал үе байсныг тайлбарла. Эрт дээр үеийн бошиг-лолууд биелэгдэх цаг ирсэн байлаа (Исаиа 11:11-12; 29:13-14; Иеремиа 31:31-33; Даниел 2:44-45). Мормоны Ном хэвлэгдсэний дараа, түүнчлэн санваар сэргээгдсэний дараах сайн мэдээний сэргээлтийн дараачийн чухал алхам нь Сүмийг албан ёсоор зохион байгуулах явдал байв. Сүмийг зохион байгуулах тухай Иосеф Смитэд өгсөн Их Эзэний зааврыг Сургаал ба Гэрээ 20 агуулдаг.

- Энэ эрин үед Сүм хэдэн оны хэдэн сарын хэдний өдөр зохион байгуулагдсан бэ? (С ба Г 20:1; 21:3-ыг үз.) Яагаад энэ өдрийг сонгосон бэ? (С ба Г 20-ийн хэсгийн тоймыг үз)
- Анхны Үзэгдэл, Сүм зохион байгуулагдах хоёрын хооронд арван жил өнгөрчээ. Энэ үед Сүмийг зохион байгуулж, удирдахад Иосеф Смитийг бэлтгэх ямар үйл явдлууд болсон бэ? (Хариултыг та самбар дээр жагсааж болно. Шаардлагатай бол энэ асуултанд хариулахад туслахын тулд дараах эшлэлийг үз)

Арванхоёрын Чуулгад үйлчилж байхдаа Ахлагч Гордон Б.Хинкли хэлсэн нь:

“Зохион байгуулалтын энэ өдөр нь чухамдаа эхлэлтийн өдөр, Иосефын хувьд гайхалтай сургуулилтын арван жилийг дуусгасан үе байлаа. Энэ үе 1820 оны хавар Эцэг Хүү хоёр арван дөрвөн настай хөвгүүн дээр хүрч ирсэн, ойн цоорхой дахь ноутай ч зүйрлүүлшгүй үзэгдлээр эхэлсэн билээ. Энэхүү үзэгдэл цаашид олон удаагийн сэрэмжлүүлэг, заавар аль алинаар нь өгөгдсөн Моронайн сургалтуудаар үргэлжилсэн юм. Тэгээд дараа нь эртний цэдгийн орчуулга мөн уг туршлагаас үүдэлтэй сүнсний нөлөө, мэдлэг, илчлэлт ирсэн билээ. Бурханлиг эрх мэдэл олголт ирж, эртний санваарын зөв шударга эзэмшигчид–Иохан Баптист Аароны санваарыг, Петр, Иаков, Иохан нар Мелкизедек санваарыг хүмүүнд дахин олгов. Бурханы дуу хоолой дахин сонсогдож, хүмүүн болон Бүтээгчийн хооронд харилцааны суваг нээгдэн, олон илчлэлт ирсэн билээ. Энэ бүхэн тэрхүү түүхт дөрөвдүгээр сарын 6-ны өдрийн угтал болон тохиосон юм” (“150-Year Drama: A Personal View of Our History,” *Ensign*, 1980 оны 4-р сар, 11-12).

- Мормоны Ном ирсэн нь Сайн мэдээний сэргээлтийн замыг бэлтгэхэд хэрхэн тусалсан бэ? (С ба Г 20:6-12-ыг үз.) Санваарын сэргээлт замыг бэлтгэхэд хэрхэн тусалсан бэ? (Сүмийг удирдах, авралын ёслолуудыг гүйцэтгэхэд санваарын эрх мэдэл шаардлагатай байв)

1830 оны дөрөвдүгээр сарын 6-нд Иосеф Смит, өөр 50 гаруй хүмүүс Нью-Йоркийн Фейетте дахь эцэг Петр Витмерийн дүнзэн байшинд Сүмийг зохион байгуулахаар цуглажээ. Аль нэг Сүм зохион байгуулагдахад наад тал нь зургаан гишүүнтэй байхыг Нью-Йоркийн хууль шаарддаг байв. Тиймээс баптисм хүртэж, алтан ялтсуудыг харсан зургаан хүн бүгдээрээ Сүмийн анхны албан ёсны гишүүд болжээ. Эдгээр хүмүүс бол Иосеф Смит, Оливер Каудери, Хайрум Смит, хүү Петр Витмер, Самуел Х.Смит, Давид Витмер нар байв (нэмэлт түүхэн үндсийг *History of the Church*, 1:76; *Бидний Өв*, хуудас 16-17-гоос үз).

- Сүм зохион байгуулагдахдаа ямар нэртэй байсан бэ? (С ба Г 20:1-ийг үз.) Сүм эхэн үедээ өөр нэртэй байсныг, харин 1838 оны дөрөвдүгээр сард Их Эзэн Өөрийнх нь Сүм нэрлэгдэх ёстой нэрийг илчилснийг тайлбарла. Их Эзэн Сүмдээ ямар нэр өгсөн бэ? (С ба Г 115:4-ийг үз.) Их Эзэний Сүм Түүний нэрээр нэрлэгдэх нь яагаад чухал вэ? (3 Нифай 27:8-ыг үз.)

Мормон гэдэг бол Мормоны Номын улмаас Сүмд өгсөн хоч нэр юм гэдгийг та тайлбарлаж болно. Бид Сүмийнхээ бүрэн нэрээр нь дуудахыг эрхэмлэдгээрээ Аврагч Есүс Христэд итгэх итгэлээ онцгойлон харуулдаг.

Хэрэв та анхаарал төвлөрүүлэх хоёр дахь үйл ажиллагааг ашиглах бол, асуултын бүх хариуг товчхон нэгтгэн дүгнэ (бүх хариулт өмнөх ярилцлагад өгөгдсөн байгаа).



Эцэг Петр Витмерийн дүнзэн байшин. 1830 оны дөрөвдүгээр сарын 6-нд Нью-Йоркийн Фейеттед Сүм зохион байгуулагдсан газарт энэ хуулбарыг барьжээ.

2. Бошиглогчийг дагахыг Их Эзэн Сүмийн гишүүдэд зарлиг болгосон нь

Сүм зохион байгуулагдсан цуглааны үеэр Иосеф Смит Оливер Каудери хоёр Сүмийн тэргүүлэх албатнуудаар дэмжигдэн батлагдав (*History of the Church*, 1:77). Иосеф Смитийг Бошиглогч гэж үзэн дагахыг зааварласан илчлэлтийг Их Эзэн гишүүдэд өгчээ. Энэ илчлэлт С ба Г 21-д цэдэглэгдсэн байдаг.

- С ба Г 1:38, 21:4-5-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Бошиглогчийн үгсэд бид хэрхэн хандах талаар эдгээр шүлгүүд юу зааж байна вэ? (С ба Г 21 дэх мэдэгдлүүд Иосеф Смитийн тухай өгүүлдэг бол, уг мэдэгдлүүд түүний өмнөх Бошиглогчдод бас холбогддогийг цохон тэмдэглэ.) Амьд Бошиглогчийн үгсийг бид хаанаас олж болох вэ? (Хариулт нь албан захидлууд, ерөнхий чуулган, Сүмийн сэтгүүлүүд) Хожмын үеийн Бошиглогчдын ямар зөвлөгөө буюу сургаал таны хувьд онцгой учир холбогдолтой вэ?
- Бид бошиглогчийн үгсэд “бүхий л тэвчээр хийгээд итгэлээр” анхаарал тавих ёстой гэж Их Эзэн С ба Г 21:5-д хэлжээ. Бошиглогчийн зөвлөгөөг дагахад зарим үед тэвчээр, итгэл яагаад шаардагдаж болох вэ?

Бошиглогчийн зөвлөгөөг дагахад тэвчээр, итгэл шаардагдсан туршлагаа хуваалцахад ангийн гишүүдийг урь.

- С ба Г 21:6-г ангийн гишүүдтэй хамт унш. Бошиглогчийг дагадаг хүмүүст Их Эзэн ямар адислалуудыг амласан бэ? (Та эдгээр адислалуудыг самбар дээр жагсаан бичихийг хүсч болно) Эдгээр адислалууд Сүмийн гишүүдийн амьдралд хэрхэн хэрэгжиж байна вэ? Бошиглогчийг дагасны улмаас та нар ямар арга замаар адислагдсан бэ?
- Их Эзэн Өөрийнх нь үйлчлэлд хөдөлмөрлөдөг хүмүүст “хүчирхэг адислалыг” С ба Г 21:9-д амлажээ. Их Эзэнд үйлчилснээрээ та нар хэрхэн адислагдсан бэ? (Их Эзэнд үйлчилсний нэг адислал бол Бошиглогчдын үгсийн тухай бидний гэрчлэлүүд бэхэждэг явдал мөн гэдгийг та онцлон тэмдэглэхийг хүсч болно)

3. Ариун ёслолоос хүртэхийн тулд хамтдаа байнга цуглахад Их Эзэн Сүмийн гишүүдийг урамшуулан дэмждэг

- Сүм зохион байгуулагдсан цуглаан дээр гишүүд ариун ёслолоос хүртсэнийг тайлбарла (*History of the Church*, 1:78). Сэргээгдсэн Сүмийн анхны цуглаан дээр ариун ёслолыг гүйцэтгэсэн нь яагаад чухал гэж та нар боддог вэ?
- Ариун ёслол хэрхэн гүйцэтгэгдэх ёстой тухай мэдээллийг Их Эзэн С ба Г 20-д илчилжээ (шүлэг 75-79). С ба Г 20:75-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Ариун ёслолоос байнга хүртэх нь яагаад чухал вэ?
- Ариун ёслолын залбирлуудыг уншихыг ангийн гишүүдээс хүс (С ба Г 20:77, 79). Бид ариун ёслолоос хүртэхдээ ямар амлалтуудыг хийдэг вэ? (мөн Лук 22:19-20; 3 Нифай 18:7, 10-11-ийг үз.) Хоёр залбирал аль аль нь Есүсийг дурсан санахад онцгой анхаарал тавьдгийг тэмдэглэхийг та хүсч болох юм. Түүнийг үргэлж дурсан санах гэдэг нь юу гэсэн үг вэ? Түүнийг дурсан санахад ариун ёслол бидэнд хэрхэн тусалдаг вэ?
- Ариун ёслолоос зохистойгоор хүртдэг хүмүүст ариун ёслолын залбирал ямар амлалт өгдөг вэ? (С ба Г 20:77, 79-ийг үз.) Тохиромжтой бол ариун ёслолоос хүртсэнээр амьдрал нь хэрхэн адислагдсаныг ярихад ангийн гишүүдийг урь.
- Их Эзэн ариун ёслолын талаар нэмэлт заавруудыг Иосеф Смитэд С ба Г 27-д өгсөн ажээ. Энэ илчлэлтийг хүлээж авах үедээ Иосеф юу хийж байсан бэ? (С ба Г 27-гийн хэсгийн тоймыг үз.) Энэ илчлэлтээр дамжуулан ариун ёслолын тухай Иосеф юу мэдсэн бэ? (С ба Г 27:2-ыг үз.) Бид “[Христийн] алдар сууд бүхнээ зориулсан” ариун ёслолоос хэрхэн хүртэж чадах вэ?

4. Их Эзэн Сүмийн гишүүдийн үүргийг тайлбарласан нь

- С ба Г 20:68-69-ийг ангийн гишүүдтэй хамт унш. Эдгээр шүлгүүдэд “гишүүд баптисмаар хүлээн авагдсаны дараах тэдний үүргийг” Их Эзэн тайлбарлажээ. Их Эзэн Сүмийн гишүүд биднээс юу хүсэн хүлээдэг тухай шүлэг 69 юу илчилдэг вэ? Бид Түүний Сүм дэх гишүүнчлэлийнхээ төлөө Их Эзэнд талархлаа хэрхэн харуулж чадах вэ?

дахь тэрхүү багахан цуглаан ихэнх хүмүүст мэдэгдээгүй ч гэсэн, тэр өдрийн үйл явдлууд дэлхийг өөрчилсөн юм. Ийм даруухнаар эхэлсэн Сүмийн дэлхий дахиныг хамарсан өсөлтийн гайхамшгийн талаар эргэцүүлэн болоход ангийн гишүүдийг урь. Та дараах туршлагыг ярьж болох юм:

Сүмийн өсөлтийн тухай Бошиглогч Иосеф Смитийн бошиглосон нэг цуглааны тухай Ерөнхийлөгч Вилфорд Вудрафф ярьжээ. Уг цуглаан “14 орчим фут шоо дөрвөлжин хэмжээтэй нэг бяцхан байшинд болсон юм. Гэвч энэ цуглаанд Кертланд хотхонд байсан, Сионы Хуаранд явахаар хамтдаа цугларч байсан Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн санваартнууд бүгдээрээ ирсэн байлаа.” Уг ажлын тухай эрчүүдээс нэлээд хэд нь гэрчлэлээ хэлсний дараа Бошиглогч ярьсан нь:

“Ах нар аа, би өнөө орой энд та нарын хэлсэн гэрчлэлээс ихэд гэгээрч, зааварлагдлаа. Харин та нар энэ Сүм болон хаант улсын хувь тавилангийн талаар ээжийнхээ өвөр дээрх бяцхан хүүхэд шиг байх үеэс нь цаашыг мэдэхгүй байгааг Их Эзэний өмнө би та нарт хэлье. Та нар Сүмийг бүх талаас нь ойлгохгүй байгаа. . . Энэ бол өнөө орой энд та нарын харж байгаа санваартнуудын өчүүхэн хэсэг. Харин энэ Сүм Хойд, Өмнөд Америкийг дүүргэнэ. Энэ Сүм дэлхийг дүүргэнэ” (In Conference Report, 1898 оны 4-р сар, 57).

Сүнсээр өдөөгдсөний дагуу хичээлийн үеэр ярилцсан үнэнүүдийн тухай гэрчил.

Нэмэлт заах санаанууд

Та зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болгож дараах санаануудаас нэгийг буюу илүү олныг ашиглаж болно.

1. Сүмийн өсөлт хөгжилт

Хуудас 56 дээрх эцэг Петр Витмерийн дүнзэн байшингийн гэрэл зурагт ангийн гишүүдийн анхаарлыг хандуул. Гэрэл зураг дээрх байшин бол Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм албан ёсоор зохион байгуулагдсан байшингийн хуулбар гэдгийг тайлбарла. Эхлэлийг Сүмийн өнөөдрийн дэлхий даяарх өсөлт хөгжилттэй харьцуулан ярилц.

2. Бурхантай харилцах бидний харилцаа

Бурханы тухай мөн дэлхий дээрх Өөрийн хөвгүүд, охидтой тогтоосон Түүний харилцааны тухай үнэнүүдийг мэдэхийн тулд С ба Г 20:8-31-ийг уншихыг ангийн гишүүдээс хүс. Хэрэв эдгээр үнэнүүдийг тэд мэдээгүй бол амьдрал нь хэр зэрэг өөр байх байсныг авч үзэхэд ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Та нарын ярилцаж болох зарим үнэнүүдийг доор жагсаав:

- а. С ба Г 20:11. (Бурхан хүмүүст сүнслэгээр нөлөөлж, Өөрийн ажлыг хийлгэхийн тулд тэднийг дууддаг хэвээр байна)
- б. С ба Г 20:12. (Тэрээр өчигдөр, өнөөдөр мөн үүрд нэгэн адил байдаг)
- в. С ба Г 20:17. (Тэр бол хязгааргүй, мөнхийн болоод өөрчлөгдөшгүй юм)
- г. С ба Г 20:17. (Тэр тэнгэр, газрыг мөн тэдгээр дэх бүх зүйлийг бүтээсэн юм)
- д. С ба Г 20:18. (Тэр биднийг Өөрийнхөө дүр төрхөөр бүтээжээ)

- е. С ба Г 20:21-25. (Бурхан Бидний нүглийг цагаатгахын тулд Цорын Ганц Төрсөн Хүүгээ өгсөн юм)
- ё. С ба Г 20:29-31. (Хэрэв бид итгэж, наманчлан, Бурханыг хайрлаж, түүнд үйлчлэн, эцсийг хүртэл тэвчих юм бол бид Есүс Христийн ач ивээлээр дамжин зөвтгөгдөж, ариусгагдан Бурханы хаант улсад аврагдана)

**3. “Би та нартай хамт усан үзмийн модны жимснээс уух цаг ирнэ”
(С ба Г 27:5)**

- С ба Г 27:5-ыг унш. Энэ шүлэгт Их Эзэн ариун ёслолын талаар ямар амлалт хийсэн бэ? (Ирээдүйд нэгэн цагт Тэрээр дэлхий дээрх дагалдагчдынхаа хамт ариун ёслолоос хүртэнэ) Энэ үйл явдлаар Их Эзэн хэнтэй хамт байна гэж хэлсэн бэ? (С ба Г 27:5-14-ийг үз. “Эцэг минь дэлхийгээс надад өгсөн тэд бүгд” оролцох болно гэж шүлэг 14-т Тэрээр хэлснийг хэл)

4. “Сүм байгуулагдсан нь” видео танилцуулга

Хэрэв *Сургаал ба Гэрээ болон Сүмийн Түүхийн Видео танилцуулга* (53912) байдаг бол, “Сүм байгуулагдсан нь,” найман минутын хэсгийг үзүүлэхийг бод.

“Энэ бол бүгдэд хандах МИНИЙ ДУУ ХООЛОЙ БОЛОЙ”

Зорилго

Их Эзэн бусад хувь хүмүүст зориулж, судруудад илчилсэн заавруудыг амьдралдаа хэрэглэж сурахад нь ангийн гишүүдэд туслах.

Бэлтгэл

1. Сургаал ба Гэрээ 25 болон энэ хичээлийн бусад судрыг залбирч судал.
 2. Ангийн гишүүний Судлах Удирдамж (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.
 3. Эмма Смитийн зураг байвал хичээлийн үеэр ашиглахаар бэлтгэ (62509; Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 405).
-

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа

Хичээлээ эхлэхийн тулд дараах туршлагыг ярих буюу өөрийнхөө хамгийн тохиромжтой үйл ажиллагааг ашигла:

Далын Ахлагч Жей И.Женсен номлолын ерөнхийлөгчөөр үйлчилж байхдаа өөрт нь тулгарсан олон асуудлын улмаас дүүргийн чуулганы эцэст санаагаар унаж, сэтгэл гонсойсон тэр нэгэн үеийнхээ тухай дүрсэлжээ. Тэрээр гэр рүүгээ явж байхдаа судрынхаа хуудсуудыг эргүүлж, тайтгарал, удирдамж эрж байгаад Сургаал ба Гэрээний гурав дахь хэсэг дээр зогсчээ. Тэрээр хэлсэн нь:

“Би судрын шүлэг уншихдаа, өөрийнхөө нэрийг олонтаа оруулдаг. Шүлэг 5-д би ингээд, дүнсгэр баргар мэдрэмжийг зайлуулахад хэрэгтэй байсан тусламжийг олсон: ‘Болгоогтун, эдгээр зүйлүүдэд чамд [Жей Женсенд] итгэл найдвар хүлээлгэсэн болой, гэвч чиний зарлигууд хэр зэрэг чанд байсан бэ; мөн чамд [Жей Женсенд] өгөгдсөн амлалтуудыг бас санагтун’ (С ба Г 3:5).

“ ‘Амлалтуудыг бас санагтун’ гэдэг үгс ер бусын хүчээр намайг цочирдуулав. . . Нөгөөх асуудлууд дөрвөн хоногийн турш миний хувьд өдрийн бодол, шөнийн зүүд байв. Би өөртөө өгөгдсөн нэг ч амлалтыг орхилгүй бүгдийг нь авч үзэхээ зогссонгүй” (In Conference Report, 1992 оны аравдугаар сар, 112; *Ensign*, 1992 оны арваннэгдүгээр сар, 80).

Тэр үед Ахлагч патриархын адислалд мөн номлолын ерөнхийлөгчөөр онцгойлон адислагдахад нь бас судруудад өөрт нь өгөгдсөн амлалтуудыг оюун ухаандаа эргэцүүлэн бодож үзжээ. Ингэснээр, тэрээр өөрт нь хэрэгтэй байсан хүч чадал, тайтгарлыг олсон ажээ.

- Өөрсдийнхөө нэрсийг сударт оруулан тавих энэ санаа судруудыг унших үед бидэнд хэрхэн тусалж чадах вэ?
- 1 Нифай 19:23-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Судруудыг амьдралдаа хэрэгжүүлэхийн ач холбогдлын тухай Нифай юу заасан бэ?

Их Эзэн Сургаал ба Гэрээнд зарим Гэгээнтнүүдэд нэр заан өгсөн зөвлөгөөг бид хэрхэн хэрэгжүүлж болох тухай энэ хичээлээр ярилцахыг тайлбарла.

Ярилцах ба
хэрэгжүүлэх нь

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбиран сонгож ав. Судрын зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Сургаал ба Гэрээн дэх илчлэлтүүдээс ихэнх нь хувь хүмүүст өгөгдсөнийг хэл. Илчлэлтүүд дэх зөвлөгөө нь хэдийгээр хувь хүмүүст зориулагдсан, Сүмийн эдгээр гишүүд олон жилийн өмнө амьдарч байсан ч, “Би нэгд хэлснээ бүгдэд хэлнэ” (С ба Г 61:36; мөн С ба Г 25:16; 82:5; 93:49) гэж Их Эзэн дахин давтан хэлсэнчлэн, зөвлөгөөний ихэнх нь өнөөдөр бидэнд хамаатай юм.

1830 оны долдугаар сард, Их Эзэн Бошиглогч Иосеф Смитийн гэргий Эмма Смитэд нэг илчлэлт өгчээ (С ба Г 25). Эмма Смитийн зургийг үзүүл. Энэ хичээл Эммад өгсөн Их Эзэний илчлэлтээс гурван сэдэвт анхаарал төвлөрүүлдгийг тайлбарла.

1. Эхнэр, нөхрүүд бие биеэ дэмжиж, тайтгаруулах ёстой.

Эмма Смитэд өгсөн Их Эзэний илчлэлтэд нөхрийнхөө өмнө түүний хүлээх үүрэг хариуцлага орсон юм. Хэрэв та залуучуудад заадаг бол ирээдүйн нөхөр буюу эхнэрээ дэмжихийн ач холбогдлыг ойлгоход нь тэдэнд туслахын тулд энэ хэсэг дэх материалыг ашигла.

- С ба Г 25:5-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Энэ шүлэгт Их Эзэн Эмма Смитэд юу зөвлөсөн бэ? Хүнд үед эхнэр нөхрүүд ямар арга замаар бие биедээ тусалдаг вэ? (Энэ асуултыг ангийн гишүүд ярилцах үед хувийнхаа туршлагыг эсвэл бие биеэ тайтгаруулж дэмждэг өөр гэр бүлийн хосуудыг ажигласан туршлагаа хуваалцахад тэднийг урь.)

Эхнэр нь нөхөртөө “эелдэг ялдамхнаар, хайраар хандах ёстой. Эр хүн зовлон зүдгүүрийг даван туулж байгаа үедээ, санаа сэтгэлийн дарамт, саад бэрхшээлд түүртсэн үедээ, хэрүүл маргаан, дургүйцэл гомдлын оронд инээмсэглэл, эелдэг ялдамхан аашийг эхнэрээсээ олж харах юм бол, сэтгэл нь уужирч, санаа бодол нь гийх болно” (*Teachings of the Prophet Joseph Smith*, эмхтгэсэн, Жозеф Фиелдинг Смит [1976], 228) гэж Бошиглогч Иосеф Смит эхнэрүүдэд сургажээ.

“Эхнэрээ хайрлаж, баярлуулж, тэжээх нь, мөн өөр хэнтэй ч биш зөвхөн түүнтэй нэгдэн нийлэх нь нөхрийнх нь үүрэг юм. Тэрээр эхнэрээ өөр шигээ хүндлэх ёстой, мөн бодол санаанд нь эелдэг зөөлнөөр хандах ёстой” хэмээн Бошиглогч нөхрүүдэд сургажээ (*Elders' Journal*, 1838оны 8-р сар, 61).

- С ба Г 25:14-ийг ангийн гишүүдтэй хамт унш. Энэ шүлэгт Их Эзэн Эмма Смитэд юу гэж зөвлөсөн бэ? Бие биенээ дэмжин баярлуулдгаа эхнэр нөхрүүд хэрхэн харуулж чадах вэ?

Иосеф Смит, Эмма Смит хоёр өөрсдөд нь тулгарсан гай зовлонгийн цагт бие биендээ агуу түшиг тулгуур болдог байлаа. 1842 онд Иосефын амь нас аюулд учирсны улмаас нуугдаж байсан үед Эмма нөхрөө эргэж ирсэн аж. Иосеф хожим нь энэ тухай хэлсэн нь:

“Хайрт Эммагийнхаа–бүр залуу зандан наснаас гэргий минь байгаа, зүрх сэтгэлийн хайртай түүнийхээ гарыг атган байсан тэр шөнө ямар өгүүлшгүй

баяр баяслаар, ямар их баяр хөөрийн мэдрэмжээр цээж минь дүүрсэн гээч. Бид хоёрын туулж өнгөрөхөөр дуудагдсан олон үйл явдал, амьдралын маань замд энд тэндгүй тохиолддог шургаж унатлаа ядарсан туйлдагт, урхи занга, уй гашуу, гай зовлон, баяр баясал, сэтгэл амсхийх тайвшралыг хормын төдийд бясалган бодоход оюун санаа маань олонтаа доргих лугаа адил болдог байлаа. . . Ай тэр минь,. . . айж эмээсэн шинжгүй, бат бөх, гуйвшгүй–өөрчлөгдөшгүй хэвээрээ, хайр булаам Эмма минь дахиад энд байгаа нь агшин зуурт, оюун ухаанд минь хичнээн эгшиглэнтэй яруугаар бууна вэ!” гэж хэлжээ (*History of the Church*, 5:107).

Иосеф Эмма хоёр нялх үрсээ эндэж үрэгдэхэд бие биеэ дэмжиж тулан, тайтгаруулдаг байжээ. Дөрвөн жилийн дотор тэдний дөрвөн бяцхан үрс нас барсан аж. Арваннэгэн хүүхдээс (хоёр нь өргөмөл), зөвхөн гурван хүү, нэг охин л эсэн мэнд өсөж өндийсөн юм.

Огайогийн Көртландад Сүм өсөн хөгжиж байсантай холбоотой хүнд ачаа дарамтыг Бошиглогч үүрч байсан үед Эмма ихэр хүү охин төрүүлсэн нь цагийн дараа энджээ. Бараг л энэ үед ойролцоох Огайогийн Оранж хотод, Сүмийн шинэ хөрвөгчид Жон Мюрдок, Жюлия Мюрдок нар ихэр хүүхэд төрүүлсэн аж. Мюрдокийн ихэр хүүхэд төрснөөс хойш зургаан цагийн дараа Мюрдок эгч нас барав. Эмма Иосеф хоёр энэ тухай мэдээд, ихэр хүүхдийг бид өргөж авч болох уу гэж Мюрдок ахаас асуусан гэнэ. Удалгүй ихрүүд болох Жозеф Мюрдок, Жюлия Мюрдок хоёрыг Смитийнхний гэрт авчирчээ.

Иосеф Смитийн ээж Люси Мак Смит, хүнд үед нь Иосефыг тулан дэмжиж байсан Эммагийн зан чанарын зарим шинжийг дүрслэн:

“Ядарч туйлдах болон аливаа зовлон зүдгүүрийг өөрт нь ямагт байсаар ирсэн гандан бууршгүй эрэлхэг зориг, оргилуун хүсэл эрмэлзэл, сэтгэлийн хатаар сар бүр, жил бүр даван туулдаг түүн шиг нэг ч эмэгтэй хүнийг би амьдралдаа хэзээ ч үзээгүй. Учир нь би түүний тэвчиж тэсвэрлэсэн зүйлийг мэднэ. . . Тэрээр харгис хэрцгий мөрдлөг хавчлагыг хүлцэн тэвчсэн юм. Бас өөр ямар ч эмэгтэй хүний бараг дааж даахааргүй, хүмүүс хийгээд чөтгөрүүдийн улангассан хилэгнэлийг тэрээр тэсэн гарсан юм” гэжээ (*History of Joseph Smith*, хянан тохиолдуулсан, Престон Нибли [1958], 190-191).

- Иосеф Смит, Эмма хоёр бие биенээ илүү ихээр хайрлаж, тулан дэмжиж байсан үлгэр жишээнээс эхнэр, нөхрүүд юу сурч болох вэ?

2. Бид номхон дөлгөөн байж, бардамналаас зайлсхийх ёстой

“Номхон дөлгөөн байдлын сүнсэнд үргэлжлүүл, мөн бардамналаас болгоомжил” (С ба Г 25:14) хэмээн Их Эзэн Эмма Смитэд зарлиг болгожээ. Тэрээр үүнтэй адил заавруудыг Сүмийн бусад гишүүдэд өгсөн юм. Дараах шүлгүүдийг ангийн гишүүдтэй хамт унш:

- а. С ба Г 23:1 (Оливер Каудерид): “Чи уруу таталтанд орохгүйг тулд бардамналаас болгоомжил.”
- б. С ба Г 38:39 (Сүмийн чуулган дээрх Гэгээнтнүүдэд): “Та нар эртний нифайчуудын адил болохгүйн тулд бардамналаас болгоомжлогтун”
- в. С ба Г 90:17 (Сүмийн Тэргүүн Зөвлөлд): “Өөрсдийн бүхий л ихэмсэг зан хийгээд бардамналд сануулагдаж бай, учир нь энэ нь сүнсэнд тань занга тавьдаг билээ.”

г. С ба Г 98:19-20 (Көртландын Гэгээнтнүүдэд): “Көртланд дахь сүмд байгаа олон нь Их Эзэн миний таалалд үл нийцдэг билээ; учир нь тэд нүглүүдээ, мөн ёс бус замуудаа, зүрх сэтгэлийнхээ бардамналыг, мөн шунахай сэтгэлээ орхидоггүй”

- Бардамнал гэж юу вэ? Бардамналын тухай Их Эзэний сэрэмжлүүлэг яагаад ийм их хүчтэй, олон удаа давтагддаг гэж та нар боддог вэ?

Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон сургасан нь:

“Бидний олонх нь бардамнал бол амин хувиа хичээсэн үзэл, ихэмсэг зан, сагсуурал, биеэ ихэд тоосон зан эсвэл ихэмсэг зан гэж боддог. Энэ бүхэн бол нүглийн элементүүд юм, харин энд зүрх сэтгэл буюу үндсэн гол юм нь алга байна.

“Бардамналын үндсэн онцлог нь дайсагнал–Бурханд болоод бусад хүмүүст дайсагнах дайсагнал юм. *Дайсгнал* гэдэг нь үзэн ядах, өширхөх эсвэл эсрэг хандлага юм” (In Conference Report, 1989 оны 4-р сар, 3; *Ensign*, 1989 оны 5-р сар, 4).

- Бардамнал Бурхантай харилцах бидний харилцаанд хэрхэн нөлөөлдөг вэ?

Ерөнхийлөгч Бенсон тайлбарласан нь:

“Бардамнал бол уг мөн чанараараа өрсөлдөгч шинжтэй юм. Бид өөрсдийн хүслийг Бурханыхад сөргүүлэн тавихад . . . миний хүсэлд Таны хүсэл хэрэгждэггүй.’ . . гэсэнтэй агаар нэг юм.

“Бидний хүсэл Бурханы хүсэл таалалтай сөргөлдөх нь бидний хүсэл, дур таашаалыг хяналтгүй болгоход хүргэдэг (Алма 38:12; 3 Нифай 12:30-ийг үз). . . .

“Бурханы эсрэг чиглэсэн бидний дайсагнал нь эсэргүүцэл, үл тоомсорлох, гөжүүдлэх, наманчлахгүй байх, бардамнах, амархан гомддог байх, тэмдэг эрэлхийлэх зэрэг олон янзаар илэрдэг. Бурхан өөрсөдтэй нь санал нийлж эвлэрдэг байхыг бардамнагчид хүсдэг. Тэд өөрсдийн санал бодлыг Бурханы хүсэл таалалд нийцүүлэн өөрчлөхийг сонирхдоггүй” (In Conference Report, 1989 оны 4-р сар, 4; *Ensign*, 1989 оны 5-р сар, 4).

- Бусадтай харилцах бидний харилцаанд бардамнал хэрхэн нөлөөлдөг вэ?

Ерөнхийлөгч Бенсон хэлсэн нь:

“Бардамналын энэхүү өргөн дэлгэрсэн нүглийн өөр нэг зонхилох хэсэг бол бусад хүмүүст дайсагнадаг явдал мөн. Бид өөрсдийгөө бусдаас дээгүүрт тавьж, тэднийг басамжлан жижигрүүлэхэд өдөр бүр уруу татагддаг” (Хиламан 6:17; С ба Г 58:41-ийг үз). . . .

“Бардамнал нь . . . бусдын дутагдлыг олж харах, хов жив хөөцөлдөх, гомдоллох, өр тавьж, хэр чадлаасаа дээгүүр цамаан амьдрах, атаархал, шунал, өөр бусдыг өргөхийн тулд талархал магтаалын үг хэлдэггүй, уучилдаггүй, хар сэртэй байх зэрэг олон хэлбэрээр илрэн гардаг. . . .

“Амин хувиа хичээх үзэл бол бардамналын бүр их нийтлэг тохиолддог хэлбэр мөн. ‘Энэ бүх асуудлын гол гогцоо нь өөрийгөө дээгүүрт тавих, хувиа бодох, хар амиа хичээсэн дэлхийн хүслээ гүйцэлдүүлэх, зөвхөн өөрийгөө бодох явдал мөн. Энэ бүхэн надад нөлөөлдөг. . . .

“Бардамналын өөр нэг хэлбэр бол зөрчил сөргөлдөөн. Хэрүүл маргаан, хилс хэргээр эзэгнэх, нийгмийн үнэт зүйлс, үзэл бодлын талаар эцэг эх, хүүхдүүд хоорондоо таарахгүй байх, эхнэр буюу нөхөртэйгөө зүй бусаар харьцах, хэрцгий догшин авирлах, олон ааш-энэ бүгд бардамналын хэлбэрүүд мөн” (In Conference Report, 1989 оны 4-р сар, 4-5; *Ensign*, 1989 оны 5-р сар, 4-6).

- Бид хэрхэн бардамналыг даван туулж, номхон дөлгөөн байдлын сүнсийг хөгжүүлж чадах вэ?

Ерөнхийлөгч Бенсон зөвлөсөн нь: “Бардамналын эсрэг ерөндөг нь даруу зан-номхон дөлгөөн, үг дууламтгай хүлцэнгүй байдал мөн (Алма 7:23-ыг үз). Энэ бол харууссан зүрх, гэмшсэн сэтгэл юм. . . . Бид Бурханыг хайрласнаар, хүсэл таашаалаа Түүнд захируулснаар, амьдралдаа Түүнийг нэгдүгээрт тавьснаар, өөрсдийгөө даруусгаж чадна” (In Conference Report, 1989 оны 4-р сар, 6; *Ensign*, 1989 оны 5-р сар, 6-7).

- Дараах судрын хэсгүүдийг ангийн гишүүдтэй хамт унш: С ба Г 1:28, 19:23, 112:10, 124:97. Эдгээр хэсгүүдэд өгүүлснээр, бид номхон дөлгөөн, даруу байхаар сонгосон үед ямар адислалууд ирдэг вэ?
- Бардам байхын оронд даруу байхыг сонгосноор ямар адислалууд амьдралд тань ирсэн бэ?

3. Бид баяр баясгалантай, зоригтой байх ёстой

“Зүрх сэтгэлээ өргөж, мөн баясагтун” (С ба Г 25:13) хэмээн Их Эзэн Эмма Смитэд зөвлөсөн байдаг. Энэ эрин үеийн анхны Гэгээнтнүүдэд асар их гай зовлон тулгарч байсан ч, үүнтэй адил зөвлөгөөг Их Эзэн тэдэнд дахин даван өгч байлаа. Дараах шүлгүүдийг ангийн гишүүдтэй хамт унш:

- а. С ба Г 29:5 (Бошиглогч Иосеф Смит болон бусад хүмүүст): “Зүрх сэтгэлээ өргөж мөн баяртай байгтун, учир нь би та нарын дунд байна, мөн бибээр Эцэгийн өмнө та нарын өмгөөлөгч билээ”
 - б. С ба Г 61:36 (Бошиглогч Иосеф Смит болон бусад хүмүүст): “Зоригтой бай, бяцхан хүүхдүүд минь; учир нь би та нарын дунд байна, мөн бибээр та нарыг орхих нь үгүй”
 - в. С ба Г 68:6 (Оорсон Хайд, Лук С.Жонсон Лайман И.Жонсон Виллям И.МкЛеллин нарт): “Зоригтой бай, бүү эмээ, учир нь Их Эзэн бибээр та нартай хамт байна, мөн та нарын дэргэд зогсож байх болно”
 - г. С ба Г 78:18 (Бошиглогч Иосеф Смит болон бусад хүмүүст): “Эдүгээ та нар бүх зүйлийг дааж чадах нь үгүй; гэсэн хэдий ч, зоригтой бай, учир нь би та нарыг удирдах болно”
 - д. С ба Г 136:29 (Винтер Квортерс дахь Израилын Хуаранд): “Хэрэв чи уй гашуутай байх аваас, бодгаль чинь баяр хөөртэй байж болохын тулд Их Эзэн Бурханаа даруухан залбирлаар дуудагтун”
- Эдгээр хэсгүүдэд зоригтой байхын ямар шалтгаануудыг Их Эзэн заасан байна? Бид зоригийг хөгжүүлж, өөрийгөө зоригжуулахын тулд юу хийж болох вэ? Зоригтой байхад нь бид бусдад хэрхэн тусалж болох вэ?
 - Амьдралын сөрөг тал ноцтой, давамгайлсан байдалтайгаар аж төрөхийн зарим үр дагавар юу вэ?

Арванхоёрын Чуулгын Ахлагч Марвин Ж.Аштон зөвлөсөн нь:

“Бидний хэн нь ч эмгэнэлт явдал, зовлон зүдгүүрээс зайлж чадахгүй. Бид бүгд зовлон зүдгүүрт өөр өөрөөр хариулах нь лавтай. Гэвч ‘учир нь Их Эзэн бибээр та нартай хамт байна’ гэсэн Их Эзэний амлалтыг эргэн санах юм бол бид тулгарсан асуудлуудтай буурь суурьтай, зоригтойгоор нүүр тулах боломжтой байх болно. Дургүйцэж эгдүүцсэн, шүүмжилсэн, эсвэл санаа сэтгэл гутрангуй байхын оронд зоригтой байх хүч чадлыг бид олно. Бид амьдралын таагүй хэрэг явдлуудыг зохих ёсоор ойлгож, хүч чадал, бурханлиг хүчээр шийдвэрлэх боломжтой байх болно. . .

“Хэн нэгнийг зоригтой байхыг харах нь юутай баяр баясал билээ. Бусад хүмүүс таагүй хэрэг явдлын улмаас уур уцаараа нууж чимээгүйхэн явах эсвэл жигшил зэвүүцлээ сүржигнэн илэрхийлж амьдардаг бол, зоригтой хүн нөхцөл байдлыг эр зориг, сэтгэлийн хат тэвчээр, өөдрөг санаагаар угтан авдаг” (In Conference Report, 1986 оны 4-р сар, 84-85; *Ensign*, 1986 оны 5-р сар, 66).

Зоригтой байх тухай Аврагчийн олон зөвлөгөө нь нөхцөл байдал ямар байхаас үл хамааран амар амгалан, баяр баяслыг олж чадна гэдгийг бидэнд сануулдгийг онцлон тэмдэглэ.

Дүгнэлт

Олон жилийн өмнө өөр өөр Гэгээнтнүүдэд Их Эзэний нэр заан өгсөн зөвлөгөө өнөөдөр бидний амьдралыг их хэмжээгээр адисалж болохыг нотол. Захиасуудыг нь өөрсдийнхөө нөхцөл байдалд тохируулан хэрэглэх зорилготойгоор судруудыг уншихад ангийн гишүүнийг урамшуулан дэмж.

Нэмэлт заах санаа Судруудыг амьдралдаа хэрэглэх нь

Ангийн хэдэн гишүүний гэрэл зургийг урьдчилан олж бэлтгэ. Бас Эмма Смитийн зургийг үзүүлэхэд бэлтгэ (62509; Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 405).

Эмма Смитийн зургийг үзүүлж, С ба Г 25 нь түүнд өгсөн Их Эзэний заавруудыг агуулдаг гэдгийг тайлбарла. Ангийн гишүүдийн гэрэл зургийг Эммагийн зургийн дэргэд байрлуул. С ба Г 25:16-г ангийн гишүүдээр уншуул. Энэ илчлэлтэн дэх зөвлөгөө бидэнд хамаатайг тайлбарла. С ба Г 61:36, 82:5, 93:49-ийг ангийн гишүүдээр уншуул. Бид “бүх судруудыг өөрсөдтэйгөө адилтгаж” (1 Нифай 19:23) болохыг харахад нь тэдэнд тусал.

- Аль нэг хүнд нэр заан хандсан судрын зөвлөгөө та нарын амьдралд хэрхэн ашиг тусаа өгч болох вэ? Ийм зөвлөгөөг та нар өөрсдийнхөө нөхцөлд тохируулан хэрхэн хэрэглэсэн бэ?

Зорилго

Хичээнгүй үйлчлэл, ялангуяа номлогчийн ажлаар дамжуулан сайн мэдээг хуваалцсанаар Бурханы хаант улсыг бэхжүүлэхэд нь ангийн гишүүдэд туслах.

Бэлтгэл

1. Дараах судрууд болон бусад материалыг залбирч, судал:
 - а. Сургаал ба Гэрээ 4, 11, 12, 14, 15, 16, 18, 31, 33, 75, түүнчлэн энэ хичээлийн бусад судар.
 - б. *Бидний Өв*, хуудас 7-13.
 2. *Ангийн гишүүний Судлах Удирдамж* (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.
-

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа - Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

Самбар дээр *Самуел Смит* → *Файнхаз Янг*, *Жон П.Грийн* → гэж бич _____ . Сайн мэдээ сэргээгдсэний дараа энэхүү баярт мэдээг дэлхий дахинд дэлгэрүүлэхийн тулд Сүм номлолын ер бусын хүч чармайлт гаргаж эхэлсэн билээ. Олон шинэ хөрвөгчид номлогчийн дуудлагад бадрангуй хүсэл эрмэлзлээр хариулж байв. Эдгээр хөрвөгчдийн нэг нь Иосеф Смитийн дүү Самуел байв.

1830 оны дөрөвдүгээр сард Самуел Смит сайн мэдээг номлож, Мормоны Номыг хүмүүст танилцуулахын тулд Нью-Йоркийн зэргэлдээх хотхонуудаар аялж эхлэв. Тэрээр бага зэрэг амжилт олсон ч, нэг номыг Файнхаз Янг гэдэг хүнд зарсан аж. 1830 оны зургадугаар сард Бошиглогч Иосеф Самуелыг дорнодод аялах номлогч болгон онцгойлон адисалжээ. Тэр эхний өдрөө 40 км явж, олон айлын дэргэд зогссон ч хүмүүс түүнд найрсаг бусаар хандаж, үгийг нь сонсохгүй байв. Маргааш нь тэрээр нэг Мормоны Номыг методист тохинуулагч Жон П.Грийнд үлдээж. Жон Грийний эхнэр Рода бол Файнхазын эгч байв.

Самуел бараг уулзсан хүн болгоныхоо зүгээс эсэргүүцэлтэй тулгарч байсан болохоор номлолын ажил тун амжилтгүй болох юм байна гэдгийг мэдэрснээ. Гэвч Файнхаз Янг, Жон П.Грийн нарт үлдээсэн номууд тэднийг болон бусад олон хүмүүсийг хөрвүүлэгч рүү хөтөлжээ. Жишээ нь, Файнхаз Янг, Рода Грийн нар Бригам гэдэг ахтай байв. Тэр хүн хөрвөгдөж, хожим нь Сүмийн хоёр дахь Ерөнхийлөгч болсон билээ. Бригам Янгийн найз Хебер К.Кимбалл бас Сүмд нэгдэв. Хожим нь тэрээр Тэргүүн Зөвлөлд үйлчилж байв. Бригам Янг Хебер К.Кимбалл хоёул Нэгдсэн Улс, Англид мянга мянган хүмүүсийн хөрвүүлэгчт зэмсэг болсон билээ.

Хэрэв та самбар дээрх хоосон зайг Самуел Смитийн номлолын ажлаар нөлөөлөгдсөн бүх хүмүүсийн нэрсээр бөглөх юм бол сая сая нэрсийг бичих хэрэгтэй болно. Шууд нөлөөлөгдсөн зарим хүмүүс Сүмийн агуу удирдагчид болсон юм. Таны заадаг хүмүүс бүгдээрээ биш гэхэд, ихэнх нь ямар нэг байдлаар энэ үйлчлэлээр нөлөөлөгдсөн байгаа. Та өөрийнхөө нэрийг, ангийн зарим гишүүдийн нэрийг самбар дээр бичиж болно.

Түүний хаант улс дахь үйлчлэл, ялангуяа сайн мэдээг хуваалцах талаар Их Эзэний өгсөн гол чухал илчлэлүүдээс нэлээдийг нь энэ хичээлээр ярилцдаг. Самуел Смитийн номлолын хүч чармайлтууд Сүмийн гишүүдийн олон үеийнхнийг адисалсаар ирснийг, бид сайн мэдээг хуваалцсанаар эдүгээ олон хүмүүсийг, ирээдүйд хэдэн зуу, хэдэн мянган хүнийг адислах боломжтойг хэл.

Ярилцах ба
хэрэгжүүлэх нь

Энэ сэдэв нь нэг хичээлээр заах боломжтойгоос илүү их материалыг агуулдаг. Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбиран сонгож ав.

1829 оны хоёрдугаар сард Иосеф Смитийн эцэг эх хоёр Пеннсилльванийн Хармонид байсан Иосеф, Эмма нартай уулзахаар ирэв. Энэ үеэр Бошиглогч Их Эзэнээс асууж, аав Иосеф Смитэд нь зориулсан С ба Г 4 дэх илчлэлтийг хүлээн авчээ.

Аавд нь зориулсан энэ илчлэлтээс гадна, өөрсдийнх нь талаарх Их Эзэний хүсэл тааллыг Түүнээс асууж мэдэж өгөхийг хүссэн бусад олон хүмүүст зориулсан илчлэлтүүдийг Бошиглогч хүлээн авсан юм. Эдгээр илчлэлтүүдийн зарим нь С ба Г 11, 12, 14, 15, 16-д цэдэглэгджээ. Эдгээр илчлэлтүүд хувь хүмүүст өгөгдсөн ч зарчмууд нь Их Эзэний хаант улсад үйлчилдэг бүх хүмүүст хамаатай юм (С ба Г 11:27).

1. “Бүх зүрх сэтгэл, хүч чадал, оюун хийгээд чадлаараа Түүнд үйлчил”

- С ба Г 4:1-2-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Шүлэг 2-т өгүүлснээр, Түүний хаант улсад үйлчилдэг хүмүүсээс Их Эзэн юу шаарддаг вэ? Бүх зүрх сэтгэл, хүч чадал, оюун болон чадлаараа үйлчлэх гэж юу гэсэн үг вэ? (Энэ бол Их Эзэний үйлчлэлд бие сэтгэл бүхнээ зориулна гэсэн үг)
- Бид Их Эзэний үйлчлэлд бие сэтгэл бүхнээ зориулах нь яагаад чухал вэ? Яагаад бид зарим үед Их Эзэний үйлчлэлд хоёргүй сэтгэлээр ханддаггүй вэ? Бид бие сэтгэл бүхнээ зориулж Их Эзэнд үйлчлэх сэтгэлээ хэрхэн нэмэгдүүлж чадах вэ?

Иосеф Смитийн аав С ба Г 4-т зааварлагдсаны дагуу Их Эзэнд үйлчлэхэд амьдралаа зориулсныг тайлбарла. Тэрээр сайн мэдээнд гүнээ шийдвэр төгс байсныг харуулсан дараах шастирыг хуваалц:

“Эцэг Иосеф Смит үнэний тухай гэрчлэлээр дүүрэн байж, энэ гэрчлэлээ бусадтай хуваалцахад үргэлж санаа тавьдаг байв. Тэрээр сайн мэдээг аав, ээж, ах эгч нартаа хүргэхийн төлөө зүдэргээтэй аялал хийсэн үедээ бараг жар хүрсэн байжээ. Тэрээр [гэртээ] эргэж ирснээс хойш удалгүй арван дөрөвхөн долларын өчүүхэн өрний улмаас шоронд хоригдов. Хэрэв тэр Мормоны Номын бурханлиг чанарыг үгүйсгэсэн бол өрийг нь өршөөх байсан гэнэ! Түүнийг хүн амины хэрэгтэй ялантай хамт гянданд хорьж, дөрвөн хоног хоолгүй байлгасан ажээ. Хожим нь түүнийг шоронгийн ажлын

хашаанд шилжүүлэхэд тэнд тэр сайн мэдээг номлон хоёр хүнийг хөрвүүлж, хожим нь тэдэнд баптисм хүртээжээ. Гэрийхэн нь түүнийг чөлөөлүүлж авах хүртэл тэр бүтэн сар шоронд байсан аж” (И.Сецил МакГавин, *The Family of Joseph Smith* [1963], 68; мөн Люси Мак Смит, *History of Joseph Smith*, хянан тохиолдуулсан Престон Нибли [1958], 172-173, 179-186-г үз).

- Сайн мэдээг хуваалцахад эцэг Иосеф Смитийн харуулсан хоёргүй сэтгэлийг бид хэрхэн харуулж чадах вэ? Сайн мэдээг гэр бүл, хөршүүдтэйгөө, түүнчлэн сургууль буюу ажил дээрх хүмүүстэй, юманд явж байхад буюу бусад нөхцөлд танилцсан хүмүүстэй хуваалцахад ямар туршлага та нарт тохиолдсон бэ?

2. Их Эзэнд үйлчлэхээр бэлтгэ

Түүнд үйлчлэхэд өөрсдийгөө хэрхэн бэлтгэх талаар Их Эзэн Сургаал ба Гэрээнд бүхэлд нь зөвлөсөн байдаг. Энэхүү бэлтгэл бидний насан туршийн, байнгын хүч чармайлт байх ёстойг тайлбарла.

- Өөртөө үйлчилдэг хүмүүсээс ямар зан чанарыг Их Эзэн хүсэн хүлээдэг вэ? (Дараах судруудыг үз. Зан чанаруудыг самбар дээр дээр жагсааж, ярилцлагад урам дэм өгөх асуултуудыг ашигла)
 - а. С ба Г 4:3; 11:8. Хүсэл нь яагаад Их Эзэнд үйлчлэх чухал учир үндэслэл болдог вэ? Бид Түүнд үйлчлэх хүслээ хэрхэн дээшлүүлж чадах вэ?
 - б. С ба Г 4:5-6; 12:8; 18:19. Эдгээр шүлгүүдэд ямар учир үндэслэл хамгийн олон удаа давтагдсан байна вэ? Их Эзэнд үйлчлэх эдгээр учир үндэслэлийн ач холбогдлыг харуулсан туршлагыг хуваалцахад ангийн гишүүдийг урь.
 - в. С ба Г 11:6, 20. Их Эзэнд үйлчлэхэд дуулгавартай байдал яагаад чухал вэ?
 - г. С ба Г 4:7; 31:12. Их Эзэнд үйлчлэхэд залбирал та нарт хэрхэн тусалсан бэ?Эдгээр учир үндэслэлийн нэгийг сонгож, үүнийг улам сайжруулахын төлөө залбирч, хичээн чармайхад ангийн гишүүдийг урамшуулан дэмж.
- С ба Г 11:21-ийг ангийн гишүүдтэй хамт унш. Их Эзэнд үйлчлэхэд бэлтгэх талаар энэ шүлгээс бид юу сурч болох вэ? Энэ зөвлөгөөний мэргэн ухааныг та нарын туршлага хэрхэн харуулсан бэ?

3. “Талбай цагаан байна”

Сайн мэдээг дэлгэрүүлэх нь тулгамдсан зорилт болохыг Их Эзэн Сургаал ба Гэрээнд нэвт шувт өгүүлсэн байдаг. Учир юун гэвэл номлолын ажлын зорилго бол “бодгалиудын аврал” (С ба Г 100:4) юм.

- С ба Г 4:4, 11:3, 33:3-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Номлолын ажлыг хандахад бэлэн болсон талбайтай зүйрлүүлснээр Их Эзэн юу хэлсэн бэ? (Олон хүмүүс сайн мэдээг хүлээн авахаар бэлтгэгддэг нь хариулт байж болно)
- Залхуурахгүй байхыг Их Эзэн ахлагч нарт сануулж, тэд “хойш суухын” (С ба Г 60:13; 75:3) оронд “урагш одох” ёстой хэмээн хэлжээ. Энэ сэрэмжлүүлэг бидэнд хэрхэн холбогдох вэ? Бидний зарим нь яагаад сайн мэдээг хуваалцахаа хойшлуулдаг вэ?

Арванхоёрын Чуулгын Ахлагч Хенри Б.Айринг дараах туршлагыг өгүүлжээ:

“‘Зөв цаг нь болоогүй байна’ гэж хэлэх амархан. Гэвч энд хойш тавихын аюул байдаг. Би олон жилийн тэртээ Калифорнид нэг хүнд хөлсөөр ажил-

ладаг байв. Тэр надад найрсаг ханддаг байсан. Бас намайг өндрөөр үнэлдэг бололтой байв. Би бол түүний сайн таньдаг цорын ганцхан Хожмын Үеийн Гэгээнтэн байлаа. Сайн мэдээний тухай түүнтэй ярилцах аятай цагийг хүлээсээр байсан шалтгааныг би мэддэггүй. Тэр тэтгэвэрт гарч, намайг хол газар амьдардаг болсноос хойш эхнэртэйгээ хамт Калифорнийн Кармел дахь гэр рүүгээ машинаар явж байгаад осолд орж нас барсныг мэдээд уй гашуу болсноо л би санадаг. Тэр хүн эхнэртээ хайртай байсан. Тэр хүн хүүхдүүдээ хайрладаг байсан. Тэр эцэг эхдээ хайртай байсан. Тэр ач зээ нараа хайрладаг байсан. Бас тэрээр хүүхдүүд, ач зээ, гуч нараа хайрлаж, тэдэнтэй үүрд хамт байхыг хүсэх байсан.

“Тэр олон хүмүүс ирэх дэлхийд хэрхэн байраа олохыг би одоо мэдэхгүй байна. Гэвч би түүнтэй уулзана гэж боддог. Тэр хүн миний нүд өөд ширтэн хараад, ‘Хал, чи мэдэж байсан шүү дээ. Чи яагаад надад хэлээгүй юм бэ?’ гэсэн асуултыг би харцнаас нь олж харах болно” (In Conference Report, 1998 оны аравдугаар сар, 42; *Ensign*, 1998 оны арваннэгдүгээр сар, 33).

4. “Амаа нээгтүн мөн тэдгээр нь дүүргэгдэх болно”

Бид сайн мэдээг хуваалцахдаа *юуны* тухай заах, бас *яаж* заах тухай Их Эзэн Сургаал ба Гэрээнд чиглэл өгсөн байдаг. Бидэнд таагүй санагдсан үед Тэрээр туслахыг амлан, сайн мэдээг айхгүйгээр хуваалцахад биднийг урамшуулан дэмждэг билээ.

- Дараах шүлгүүдээс заримыг нь ангийн гишүүдтэй хамт унш: С ба Г 11:9, 15:6, 18:6, 31:3-4, 33:10-11, 42:12, 52:8-9. Их Эзэний үйлчлэгчид *юу* заах ёстой талаар эдгээр шүлгүүд юу илчилдэг вэ? Наманчлалын захиас яагаад чухал вэ? (С ба Г 18:10-14-ийг үз.)
- Дараах шүлгүүдийн заримыг нь ангийн гишүүдтэй хамт унш: С ба Г 18:20-21, 38:41, 42:6, 42:14, 75:4, 100:7-8. Их Эзэний үйлчлэгчид *юу* заах ёстой талаар эдгээр шүлгүүд юу илчилдэг вэ? Сайн мэдээг заахад зөрчил сөргөлдөөнөөс зайлсхийх нь яагаад чухал вэ? “Бүрэн дуу мэт дуу хоолойгоо [өргө] гэж юу гэсэн үг вэ”? (С ба Г 42:6; 75:4). Бид сайн мэдээг заахдаа хэрхэн зоригтой, номхон дөлгөөн байж чадах вэ? (Алма 38:10-12-ыг үз)
- Түүний сайн мэдээг тунхаглахын тулд амаа нээж, “хүний хийж чадах юмнаас айхгүй” (С ба Г 30:11; мөн С ба Г 30:5; 33:8-11-ийг үз) байхыг Их Эзэн ахлагчдад дахин давтан сануулж байлаа. “Хүнээс эмээсний улмаас . . . амаа нээхгүй байх” (С ба Г 60:2) хүмүүст Тэрээр баярладаггүй гэдгийг Их Эзэн хэлжээ. Энэ нь бидэнд хэрхэн хамаатай байж болох вэ? Бид сайн мэдээг хуваалцахдаа айдсыг хэрхэн даван туулж чадах вэ? (С ба Г 19:38; 33:12-14; 75:9-13-ыг үз.)
- Бидний зарим нь ярих, заах чадвартаа итгэл муутай байдгаас сайн мэдээг хуваалцахдаа эргэлздэгийг тайлбарла. Бид ийм асуудлыг хэрхэн даван туулж чадах вэ? (С ба Г 11:21; 14:8; 31:3-ыг үз.) Тэд сайн мэдээг хуваалцах үед Сүнс тэднийг өдөөсөн туршлагынхаа талаар ярихад ангийн гишүүдийг урь.
- Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаанд нэгтгэн дүгнэсэн Самуел Смитийн анхны номлолын шастырыг авч үз. Самуел Смит анхныхаа номлолын дараа яагаад амжилт олохгүй байх гэж бодсон бэ? Тэр ямар

арга замаар амжилт олсон бэ? Номлогчийн хүч чармайлтад маань тусалж чадах юуг бид түүний туршлагаас сурч болох вэ?

5. Түүний үйлчлэлд хөдөлмөрлөдөг хүмүүст Их Эзэн агуу адислалуудыг амласан билээ

- Түүний үйлчлэлд хичээнгүйлэн хөдөлмөрлөдөг хүмүүст Их Эзэн юу амладаг вэ? (Ангийн гишүүдтэй хамт уншихын тулд дараах судрын хэсгүүдээс заримыг нь сонго. Хэсэг бүр дэх амлалтуудыг ярилц. Самбар дээрх мэдээллийг нэгтгэн дүгнэж, хэрэгжүүлэхэд урамшуулсан ярилцлагын зөвлөмжүүдийг ашигла)
 - а. С ба Г 4:4; 11:3; 75:5.
 - б. С ба Г 18:15-16. Сайн мэдээг өөрсөдтэй нь хуваалцсан Сүмийн гишүүдийн талаар ямар сэтгэгдэлтэй байдаг, түүнчлэн сайн мэдээг хуваалцах үедээ ямар сэтгэгдэлтэй байдгаа дүрслэхийг ангийн гишүүдээс хүс.
 - в. С ба Г 31:5; 84:60-61.
 - г. С ба Г 31:7; 109:55-57. Их Эзэн хүмүүсийн зүрх сэтгэлийг сайн мэдээнд нээсэн талаарх туршлагыг хуваалцахад ангийн гишүүдийг урь.
 - д. С ба Г 31:11; 84:85; 100:5-6. Сайн мэдээг хуваалцах үед нь Сүнс хүч чармайлтуудыг нь удирдсан буюу тэдэнд сүнслэгээр нөлөөлсөн туршлагаа хуваалцахад ангийн гишүүдийг урь.
 - е. С ба Г 31:13; 75:9-13; 84:88. Сайн мэдээг хуваалцах үед Их Эзэн тэднийг дэмжсэн буюу өргөсөн туршлагыг хуваалцахад ангийн гишүүдийг урь.
 - ё. С ба Г 71:9-10. Сүм нэгэн урвагчийн хорон дайралтад өртсөн үед Их Эзэн энэ амлалтыг өгснийг хэл. Энэ амлалт өнөөдөр бидэнд хэрхэн тусалж чадах вэ?
 - ж. С ба Г 84:80. Сайн мэдээг номлосон үед нь Их Эзэн тэднийг оюун ухаан, бие бялдар, сүнслэг байдлын хувьд хэрхэн дэмжсэнийг ярихад ангийн гишүүдийг урь.
 - з. С ба Г 100:7-8. Сайн мэдээг хуваалцсан үед нь Ариун Сүнс гэрчлэхийг мэдэрсэн туршлагаа хуваалцахад ангийн гишүүдийг урь.

Дүгнэлт

Их Эзэнд үйлчлэхэд бие сэтгэл бүхнээ зориулахын төлөө ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Сайн мэдээг бусадтай хуваалцах үед нь Их Эзэн тэднийг адисална гэдгийг онцлон тэмдэглэ. Сүнсээр чиглүүлэгдсэний дагуу хичээлийн үеэр ярилцсан үнэнүүдийн тухай гэрчил.

Нэмэлт заах санаанууд

Та зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болгон дараах санаануудаас нэгийг эсвэл илүү олныг хэрэглэж болох юм.

1. Сургаалуудын давталт

С ба Г 6, 11, 12, 14 гэсэн дөрвөн өөр хэсэгт ангийн гишүүдийг ээлжлэн хандуул. Эдгээр хэсгүүдийн аль нэгнийх нь эхний зургаан шүлгийг нэг хүнээр уншуулж, бусад хэсгүүдийг дагаж харахыг ангийн бусад гишүүдээс хүс. Их Эзэн заавруудыг судруудад олонтаа давтдагийг тайлбарла.

- Их Эзэн эдгээр заавруудыг давтсанаас бид юу сурч болох вэ? Эдгээр заавруудыг ойлгох нь өнөөдөр бидэнд яагаад чухал вэ?

2. “Сионы ашиг сонирхлыг авчирч мөн төлөвшүүлэхийг эрэлхийлэгтүн” (С ба Г 6:6)

- Сионы ашиг сонирхлыг авчирч мөн төлөвшүүлэхийг эрэлхийлэхийг“ (С ба Г 6:6; 11:6; 12:6; 14:6). Их Эзэн үйлчлэгчдэдээ нэлээд хэдэн удаа зөвлөсөн байдаг. Сионы ашиг сонирхлыг төлөвшүүлэхэд бид хэрхэн тусалж чадах вэ? (Бид зөв шударгаар амьдрах замаар, номлолын ажлаар, түүнчлэн Ариун сүмийн ажлаар дамжуулан Бурханы хаант улсыг гэр бүл, гадас, тойрогтоо байгуулах нь хариулт байж болно) Сионы ашиг сонирхлыг төлөвшүүлэхээс биднийг хөндийрүүлж болох ямар шалтгаан байдаг вэ?

3. *Үйлчлэхээр дуудагдсан нь* видео танилцуулга

Хэрэв *Үйлчлэхээр дуудагдсан нь* видео хуурцаг байдаг бол (53072) нэг хэсгийг нь хичээлийн үеэр үзүүлэхийг бод (21 минут).

Зорилго

Хожмын үеийн Израил Сүмийн эхэн үед хэрхэн цугларсныг, өнөөдөр Израил хэрхэн цугларч байгааг мөн энэ цугларалтад ангийн гишүүд хэрхэн оролцож болохыг ойлгоход нь тэдэнд туслах.

Бэлтгэл

1. Дараах судрууд болон бусад материалыг залбирч судал:
 - а. Сургаал ба Гэрээ 29:1-8; 33:3-7; 37; 38:24-41; 52:2-5, 42-43; 57:1-3; 110:11; Итгэлийн Тунхаг 1:10; түүнчлэн энэ хичээлийн бусад судар.
 - б. *Бидний Өв*, хуудас 19-20, 26-27, 43-46.
 2. *Ангийн гишүүний Судлах Удирдамж* (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.
 3. *Бидний Өвийн* дараах шастируудыг нэгтгэн дүгнэхэд бэлтгэхийг ангийн гишүүдээс хүс:
 - а. Көртландад цугларахад хийсэн Ньюэл Найт, эцэг Жозеф Найт нарын золиослол (хуудас 18).
 - б. Люси Мак Смитээр удирдуулсан Гэгээнтнүүд Фейеттээс шилжин нүүсэн нь (хуудас 19).
 - в. Көртландад Бригам Янгийн хийсэн золиослол; хуудас 23).
 - г. Миссури руу хийсэн Колесвиллын Гэгээнтнүүдийн аян ба тэд тэнд суурьшсан нь (хуудас 37-39).
 4. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах бол хэдэн жижиг савааг хичээл дээр авчир.
-

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

Нэлээд хэдэн савааг өрөөн дотуур тараан тавь. Нэг савааг хугалах нь хэчнээн амархан болохыг харуул. Дараа нь саваануудыг бүгдийг цуглуулж багц болгон нэг удаагийн оролдлогоор хугалахыг ангийн гишүүдээс хүс.

- Өөрийн хүмүүсийг цуглуулах Их Эзэний зорилгын тухай энэ үйл ажиллагаа бидэнд юу зааж болох вэ?

Энэ хичээл Израилын цугларалт болон уг цугларалтад бидний гүйцэтгэх үүрэгт анхаарал төвлөрүүлдгийг тайлбарла.

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбирч, сонго. Өдөр тутмын амьдралд судрууд хэрхэн хэрэглэгддэгийг ярилц. Судрын зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахад ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Их Эзэн Өөрийн хүмүүсийг цуглуулж байна

Израилын цугларалт бол Сургаал ба Гэрээн дэх гол чухал сэдэв гэдгийг тайлбарла. Эрт дээр үед Израилын арванхоёр овог урвахад, Их Эзэн урьдчилан сэрэмжлүүлж байсны дагуу дайснууд нь тэднийг боолчлолд аваачиж, дэлхийн үндэстнүүдийн дунд тараасан юм. Хэдийгээр бошиглогчид хүмүүсийн ёс бусад харамсаж байсан ч, хожмын өдрүүд дэх нэгэн үед Израил дахин цугларна гэдгийг угтан харсандаа баярладаг байлаа (Судруудын Удирдамж, “Израилын цугларалт”-ыг үз). Энэхүү агуу үйл явц сайн мэдээний сэргээлт болон “агуу баяр баяслын баярт мэдээг энэ үеийнхэнд тунхаглах” (С ба Г 31:3) номлогчдын дуудлагаар эхэлсэн билээ.

“Бошиглогчдын . . . бичсэн бүх зүйл, зөв шударга Абелийн өдрүүдээс эхлэн эцсийн өдрүүд дэх Израилын авралын тухай өгүүлсэн, бидний анхаарч үзэх учиртай цэдэг нь, энэхүү сүүлчийн цэдгийг бидэнд үлдээсэн тэр хүнийг хүртэл доош дамжин ирсэн юм. Мөн эл цэдэг цугларалтын ажлын тухай өгүүлдэг нь яруу тодоор харагдсан билээ” гэж Бошиглогч Иосеф Смит хэлжээ (*Teachings of the Prophet Joseph Smith*, эмхтгэсэн Жозеф Фиелдинг Смит [1976], 83).

- Итгэлийн арав дахь тунхаг болон С ба Г 45:71-ийг ангийн гишүүдтэй хамт унш. Израилын цугларалт гэж юу вэ? (Израилын цугларалт нь дор өгүүлснээр Сүнслэг болон сүнслэг бус (бие махбодын) утгатай юм.)
 - а. *Сүнслэг цугларалт*. Сайн мэдээг хүмүүс мэдэж, Христэд ирж, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд баптисм хүртэж, гэрээнүүдээ сахидаг болсноор сүнслэг байдлын хувьд Израилын цугларалт тохиох болно. Ийм замаар хүмүүс дэлхийгээс Сүмд буюу Бурханы хаант улсад цугладаг.
 - б. *Сүнслэг бус (бие махбодын) цугларалт*. Сүмийн гишүүд онцгой нэгэн газар буюу дэлхий даяарх Сионы гадаснуудад хамтдаа цугласнаар Израилын цугларалт тохиодог.
- С ба Г 29:1-2, 7-8-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Бид цугларалтын зорилгын талаар эдгээр шүлгүүдээс юу сурч болох вэ? Их Эзэний Сүмд цугларч байгаа нь амьдралд чинь ямар адислал болдог вэ?
- Израилын цугларалтыг удирдах эрх мэдэл санваарын тусгай түлхүүрүүдээр дамжин хэрэгждэгийг тайлбарла. Израилын цугларалтын түлхүүрүүд дэлхий дээр хэзээ сэргээгдсэн бэ? (С ба Г 110:11 болон энэ хэсгийн тоймыг үз)
- Энэ эрин үед цугларалт Нью-Йоркт цөөхөн хүнтэй эхэлснийг тайлбарла. Эдүгээ цугларалт жил бүр мянга мянган хүмүүсийг Их Эзэний Сүмд авчран дэлхий даяар болж байна. Бид Их Эзэний Сүмд хүмүүсийг цуглуулахад туслахын тулд ямар үүрэг хариуцлага хүлээдэг вэ? (С ба Г 33:7; 38:40; 39:11; 88:81-ийг үз)

2. Гэгээнтнүүд Огайод цугласан нь

1830 оны арванхоёрдугаар сард Сүм зохион байгуулагдсанаас хойших ердөө наймхан сарын дараа энэ эрин үед Гэгээнтнүүдийг нэг дор цуглахад анх уриалан дууджээ. Гэгээнтнүүд Нью-Йоркийг орхин Огайод (С ба Г 37:3) цуглахыг Тэрээр Иосеф Смитэд илчилсэн юм. Та энэ гарын авлагын хуудас 314, 316 дээрх газрын зураг 1, *Ангийн гишүүний Судлах Удирдамж*, хуудас (29), (31) дээрх газрын зураг 3-ыг ашиглаж болно.

- Их Эзэн Өөрийн хүмүүсийг Огайо руу яв гэж зарлиг болгохдоо ямар зорилго тавьсан бэ? (С ба Г 38:31-32; 39:15-ыг үз.) Гэгээнтнүүд Огайод цугласныхаа дараа ямар арга замаар “дээрээс ирэх хүчээр хишиг хүртээгдсэн” бэ? (С ба Г 95:8; 105:33; 110:9-ийг үз. Гэгээнтнүүд хишиг хүртэлтийн энэ хүчийг Аврагч хүрч ирснээр дамжуулан бас Көртландын Ариун сүм дууссаны дараа санваарын түлхүүрүүд сэргээгдсэнээр хүлээн авсан юм.)
- С ба Г 38:24-27-г ангийн гишүүдтэй хамт унш. Их Эзэний хүмүүс Огайод цуглахаар бэлтгэж байх үед Тэрээр эдгээр шүлгүүдэд ямар зөвлөгөө өгсөн бэ? (Ариун журамтай байх, бие биеэ хайрлах, эв нэгдэлтэй байх нь хариулт байж болно) Сүмд эв нэгдэл яагаад чухал вэ? Сүмийн бусад гишүүдтэй эв нэгдэлтэй байх мэдрэмж амьдралд чинь хэрхэн адислал болсон бэ? Бид яаж улам эв нэгдэлтэй болж чадах вэ?
- С ба Г 38:34-39-ийг ангийн гишүүдтэй хамт унш. Их Эзэний хүмүүс Огайод цуглахаар бэлтгэж байх үед Тэрээр эдгээр шүлгүүдэд ямар зөвлөгөө өгсөн бэ? Энэ зөвлөгөө бидэнд хэрхэн хамаатай вэ? Цугларах зарлигт анхаарал тавьсан хүмүүст Их Эзэн юу амласан бэ? (С ба Г 38:39-ийг үз)

1831 оны нэгээс тавдугаар сарын хооронд Нью-Йорк дахь Сүмийн ихэнх гишүүд фермээ зарах буюу түрээсэлж эсвэл гэр орноо орхин Огайо руу 480 км аян хийснийг тайлбарла. Цугларах тухай Их Эзэний уриа дуудлагад анхаарал хандуулахын тулд Гэгээнтнүүд агуу золиослол хийсэн юм. Эдгээр золиослолын тухай *Бидний Өвөөс* (“Бэлтгэл,” зүйл 3-т эхний гурван хураангуйг жагсаасан байгаа) товчлол хийхийг даалгавар авсан ангийн гишүүдээс хүс.

- Огайод цугларах Их Эзэний дуудлагыг дуулгавартайгаар дагахын төлөө санхүүгийн болон бусад хэлбэрээр хохирол амсахад Сүмийн эдгээр гишүүд яагаад бэлэн байсан гэж та нар боддог вэ? Тэдний үлгэр жишээнээс бид юу сурч болох вэ? Түүний хаант улсыг байгуулахад туслахын тулд ямар золиослол хийхийг Их Эзэн биднээс хүсдэг вэ?

3. Гэгээнтнүүд Миссурид цугласан нь

Эхэн үеийн Гэгээнтнүүд Сионы хот буюу хожмын өдрүүдэд үндэслэн байгуулагдаж байсан Шинэ Иерусалимын тухай бошиглолуудыг уншсан байлаа (Исаиа 2:2-3; 3 Нифай 20:22; 21:22-28; Ифер 13:2-12; Мосе 7:61-62-ыг үз). Энэ хотын байршлыг тогтоож, байгуулах нь Сүмийн гишүүдийн үндсэн зорилго байв.

Гэгээнтнүүд Огайод цугларч эхэлснээс хойш удалгүй хэдэн сарын дараа Иосеф Смит Миссури руу очиж, Миссурийг Сионы хот байгуулагдах газраар тогтоосон илчлэлт хүлээн авчээ (С ба Г 57:1-3). Энэ илчлэлтээр Миссури энэ эрин үе дэх цугларалтын хоёр дахь газар болсон юм (С ба Г 63:24, 36-48). 1831–1838 онуудад Огайо, Миссури аль аль нь Сүмийн хувьд хүн ам суурьшсан төв газар байв. Та энэ гарын авлагын хуудас 315, 316

дээрх газрын зураг 2, 3, *Ангийн гишүүний Судлах Удирдамж*, хуудас 29, 31-г ашиглаж болно.

Дараах хугацаанууд нь Миссури дэх Сионы нутаг болон энд Сүмийг байгуулах тухай эхэн үеийн илчлэлтүүдийг товчоор харуулдаг. Хугацаануудыг ангийн гишүүдтэй хамт уншиж, хэрэгтэй бол самбар ашигла.

- а. 1830 оны есдүгээр сар (Нью-Йоркт): “Леменчүүдийн дэргэдэх зэлүүд газарт” Сионы хот байгуулагдана гэдгийг Их Эзэн илчлэхдээ, яг тодорхой газрыг хожим нь тогтооно гэжээ (С ба Г 28:9).
- б. 1830 оны ес, аравдугаар сар (Нью-Йоркт): Леменчүүдэд сайн мэдээг номлох дөрвөн номлогчийг Их Эзэн дуудав (С ба Г 30:5-6; 32:1-3). Энэ номлогчид бол Миссурид ирсэн Сүмийн анхны гишүүд байлаа.
- в. 1831 оны хоёрдугаар сар (Көртландад, Гэгээнтнүүд энд ирснээс хойш удалгүй): Их Эзэн Өөрийнхөө цагт Шинэ Иерусалимын байршлыг илчилнэ хэмээн хэлжээ (С ба Г 42:62).
- г. 1831 оны зургадугаар сар (Көртландад болсон анхны чуулганы дараа): Иосеф Смит, Сидней Ригдон, бусад ахлагчдыг Миссури руу номлолд явуулахаар Их Эзэн дуудав. Их Эзэн бас Миссури нутгийг Өөрийн хүмүүсийн өвийн нутаг болгон ариулан адислахыг амлажээ (С ба Г 52:2-5, 42-43).
- д. 1831 оны зургадугаар сар (Көртландад): Огайо руу аялж байсан Нью-Йорк дахь Колесвилл салбарын Гэгээнтнүүд Миссури руу цааш явах ёстой гэдгийг Их Эзэн (С ба Г 54:8) илчилжээ.
- е. 1831 оны долдугаар сар (Бошиглогчийг Миссурид ирсний дараа): Сионы хотын төв газар нь Индепенденс болж, Миссурид байх болно. Ариун сүм Индепенденст баригдана гэдгийг Их Эзэн илчилжээ (С ба Г 57:1-3).

Колесвиллын Гэгээнтнүүд Миссурид цуглахаар хамгийн түрүүнд очиж бусад олон хүмүүс тэдний араас удахгүй ирэх байв. Колесвиллын Гэгээнтнүүд Миссурид ирж, суурьшиж эхэлсэн туршлагыг товч ярихыг даалгасан ангийн сурагчдаас хүс (“Бэлтгэл,” 3-р зүйлийг үз).

- Колесвиллын Гэгээнтнүүдийн тухай эдгээр шастируудын талаар та нарт ямар сэтгэгдэл төрөв? (Нэн бэрхшээлтэй нөхцөлд эдгээр Гэгээнтнүүдийн харуулсан сайн чанаруудын заримыг нь нэгтгэн дүгнэхийг та хүсч болох юм) Бид тэдний үлгэр жишээнээс юу сурч болох вэ?

4. Гэгээнтнүүд эдүгээ өөрсдийнхөө нутагт Сионы гадаснуудад цугларч байна

Сүмийн гишүүд 1831-1838 оныг хүртэл Огайо, Миссурид бат бөхөөр суурьшиж байсан ч, мөрдлөг хавчлага тэдний олонхийг эдгээр нутгийг орхин явахад арга буюу хүргэсэн ажээ (хичээл 26-28-ыг үз). 1839 онд тэд Иллинойд цугларч Науву хотыг үндэслэн байгуулав. Тэд 1846 онд Наувуг орхин явахаар албадуулахад, 1847 онд Ерөнхийлөгч Бригам Янг тэднийг Их Солт Лейкийн ойролцоох Хадат Уулс дахь цугларалтын шинэ газар руу удирдсан билээ. Та энэ гарын авлагын хуудас 316 дээрх газрын зураг 3 болон *Ангийн гишүүний Судлах Удирдамжийн*, хуудас 31 -г харьцуулж болно.

Гэгээнтнүүд Ютад суурьшсанаас хойш олон жилийн туршид дэлхий даяарх Сүмийн гишүүдийг уг нутагт цуглахад урьсан уриа дуудлага хэвээр

үргэлжилсэн юм. Гэвч, цугларалтын энэ үе шат эдүгээ дуусч, амьдардаг газрынхаа Сионы гадаснуудад цуглахыг Сүмийн гишүүдэд зөвлөдөг. 1972 онд Мехико хотод болсон бүсийн чуулган дээр Ахлагч Брус Р.МкКонки хэлэхдээ:

“ . . . Их Эзэнийг дахин хүрч ирэхэд, өөр өөр хэлээр ярьдаг улс үндэстэн бүрд, мөн бүх хүмүүсийн дунд Их Эзэний гэрээт хүмүүсийн цугларалтууд байх болно гэдгийг . . . илчлэгдсэн ажил өгүүлдэг.

“Мексикийн Гэгээнтнүүдийн цугларах газар нь Мексик, Гватемалын Гэгээнтнүүдийн цугларах газар нь Гватемал, Бразилын Гэгээнтнүүдийн цугларах газар нь Бразил юм. Мөн энэ нь дэлхий даяар нэгэн адил юм. Япон бол япончуудын цугларах газар, Солонгос бол солонгосчуудын цугларах газар, Австрали бол австраличуудын цугларах газар. Улс үндэстэн бүр өөрийнхөө хүмүүсийн хувьд цугларах газар нь юм” (In Conference Report, Мексик, Төв Америкийн Бүсийн Чуулган 1972, 45).

1973 оны дөрөвдүгээр сард, Сүмийн 11 дэх Ерөнхийлөгч Харольд Б.Лий дээрх үгсийг ерөнхий чуулган дээр эш татжээ. Ингэхдээ тэрээр, “чухамдаа бол цугларалтын эхний үе шат эдүгээ дууссаныг зарласан юм. Одоо цугларалт нь улс үндэстэн бүр дэлхийгээс Сүмд ирэхээр байх ёстой” гэжээ (Бойд К.Пакер, In Conference Report, 1992 оны аравдугаар сар, 99; *Ensign*, 1992 оны арваннэгдүгээр сар, 71).

- Гишүүд төвлөрсөн нэг газарт биш харин өөрсдийнхөө орон бүрд цугларах ёстой гэсэн өөрчлөлтийг Сүм дэх ямар нөхцөл байдал авчирсан бэ? (Сүмийн гишүүнчлэл болон нөөц боломж нь дэлхийн олон бүс нутагт гадас, ариун сүмүүдийг барьж байгуулахад хангалттай болсон нь хариулт байж болно)
- Сүмийн хөгжлийн эхний үе шатанд нэг газарт төвлөрөн цуглахын зорилго нь гишүүд бие биенээ бэхжүүлэн дэлхийгээс толгой хоргодох газар, хамгаалалт олоход байсан юм. Өнөөдөр Сионы гадаснуудад цугларснаар дээрх зорилго хэрхэн биелэгдэж байна вэ? (С ба Г 115:6-г мөн дараах эшлэлийг үз. Сионы гадаснуудаар дамжуулан хэрхэн хамгаалагдаж, хэрхэн бэхэжсэн гэж бодлогийг нь хуваалцахад ангийн гишүүдийг урь) Манай гадаснууд толгой хоргодох газар, нүгэл хилэнцийн эсрэг хамгаалалт байхын тулд бид юу хийж чадах вэ?

Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон хэлсэн нь:

“Эдүгээ, Израил Сионы янз бүрийн гадаснуудад . . . цугларч байна. Гадас нь дөрвөн зорилготой юм:

“1. [Гадас нь] хилийнхээ дотор амьдардаг гишүүдэд Сүмийн хөтөлбөрүүд, сайн мэдээний ёслолууд болон зааврыг санал болгосноор тэднийг нэгтгэн, төгөлдөржүүлэх зорилготой.

“2. Гадасны гишүүд зөв шударга ёсны загвар буюу жишиг байх ёстой.

“3. Гадас нь нүгэл хилэнцийн эсрэг хамгаалалт байх ёстой. Гадас нь орон нутгийн санваарын албадын удирдлагаар гишүүдээ нэгтгэн нягтруулж, үүргээ биелүүлэх, гэрээнүүдээ сахихад нь тэднийг адислах ёстой. . .

“4. Гадас бол дэлхийд юүлэгдэн буух шуурганаас толгой хоргодох газар юм” (“Strengthen Thy Stakes,” *Ensign*, 1991 оны 1-р сар, 2, 4-5).

- Ариун сүмийг барих нь Миссурийн Көртланд, Науву, Юта дахь цугларалтын үндсэн зорилго байв. Энэ зорилго дэлхий даяар Гэгээнтнүүд Сионы

гадаснуудад цуглахад нэн чухал хэвээр байна. Ариун сүм барих нь яагаад цугларалтын нэн чухал хэсэг байдаг вэ? Ариун сүмийн ажил нь газар дээр болон сүнсний дэлхий дээрх цугларалтын агуу ажилд хэрхэн хувь нэмэр оруулдаг вэ?

“Дэлхийн аль ч эрин зуун дахь Бурханы хүмүүсийн цугларалтын . . . зорилго юу байсан бэ? Тэрээр Өргөөнийхөө ёслолууд болон хаант улсынхаа алдар сууг Өөрийн хүмүүст илчилж, авралын замыг хүмүүст зааж болохын тулд Их Эзэнд зориулж өргөө барих нь үндсэн гол зорилго юм. . . Эцсийн өдрүүдэд Бурхан Өөрийн хүмүүсийг хамтад нь цуглуулах тэрхүү зорилго нь ёслолууд болон хишиг, угаалга, тослолтоор тэднийг бэлтгэхийн тулд Их Эзэнд зориулж өргөө барих явдал мөн” хэмээн Бошиглогч Иосеф Смит заажээ (*History of the Church*, 5:423-24).

Дүгнэлт

Израилыг цуглуулах Их Эзэний амлалтууд манай өнөө үед биелэгдэж байгааг онцлон тэмдэглэ. Сүмд хүмүүс нэгдэж, дэлхий даяар 160 гаруй улсад Сионы гадаснуудад хамтдаа шүтэн биширч байгаа үед энэхүү агуу ажил улам түргэсч байна. Хүмүүсийг Сүмд цуглуулах, амьдарч байгаа газартаа Сүмийг байгуулж, бэхжүүлэхийн төлөө хичээнгүйлэн хөдөлмөрлөхөд нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Цугларалтаар дамжин ирдэг адислалуудын тухай гэрчил.

Нэмэлт заах санаанууд

Та зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болгож дараах санаануудаас нэгийг нь буюу хоёуланг нь ашиглаж болох юм.

1. “Сион энэ бүх дэлхий даяар . . . өргөжих болно”

Сионы төв газар хэдийгээр Миссурид байх боловч, Сион эцсийн эцэст бүх дэлхийг бүрхэнэ гэдгийг та тайлбарлаж болох юм. Ерөнхийлөгч Бригам Янг хэлсэн нь:

“Иосеф [Смит] Гэгээнтнүүдийн цугларах ёстой газрыг анх илчлэхэд бүх хүмүүсийг цугларахад Жаксон дүүрэг хангалттай хэмжээтэй байна гэж бид бодож байгаа эсэхийг нэг канад эмэгтэй асуусан ажээ. . . Би энэ асуултанд хариулья. . . Эцсийн эцэст Сион бүх дэлхийг бүрхэн өргөжинө. Дэлхий дээр Сионоос өөр тийм нам гүм газар эсвэл тийм өнцөг булан байхгүй болно. Дэлхий бүхлээрээ Сион байх болно. . .

“Бид чадах л хэрээрээ аль болох олноороо цуглаж, хүмүүсийг адислан, тэдэнд ариун сүмийн хишиг хүртээж, тэдэнд үнэнийг зааж, мөнх амьдралын зарчмуудыг тэдний өмнө тавьж, хийх хүч, эрх мэдэл нь бидэнд байгаа бүхнийг тэдний оюун ухаанд мэдээлэн, үнэний болон зөв шударгын замаар тэднийг удирдах болно” (in *Journal of Discourses*, 9:138).

2. “Иудагийн бутрагсдыг” (Исаиа 11:12) нэг дор цуглуулах Их Эзэний бэлтгэл

Аврагчийг нас барснаас хойш хэдхэн арван жилийн дараа иудейчүүд “бүх үндэстнүүдийн дунд тараагдсан” (2 Нифай 25:15; шүлэг 14-ийг үз) байлаа. Гэвч тараагдсан иудейчүүд хожмын өдрүүдэд дахин цуглаж, “тэдний өвийн нутгийн хувьд” Иерусалим тэдэнд өгөгдөнө” гэсэн олон амлалтыг судрууд

цэдэглэсэн байдаг” (3 Нифай 20:33; мөн 1Нифай 15:19-20; 2 Нифай 9:1-2; 10:8-ыг үз).

1836 оны гуравдугаар сарын 27-нд Көртландын Ариун сүмийг онцгойлон адислах залбиралд Бошиглогч Иосеф Смит иудейчүүдийн цугларалт болон Иерусалимын гэтэлгэл эхлэхийн төлөө залбирчээ (С ба Г 109:62-67). Иудейчүүдийн цугларалтын замыг бэлтгэсэн Их Эзэний нэг арга замыг харуулсан дараах мэдээллийг хуваалц:

“Цаг нь болоход Та Иерусалимд ирэх болно. . . . мөн Таны мутраар замыг бэлтгэж, тэр хүмүүсийг хамтдаа цуглахад үлэмж ихээр туслах агуу ажлыг Бүхний Дээд хийнэ” (*History of the Church*, 4:375) хэмээн Иосеф Смит, Оорсон Хайдыг Сүмд нэгдэх үед бошиглогсныг тэрээр дурсан ярьжээ. 1840 оны дөрөвдүгээр сарын ерөнхий чуулган дээр, тэр үед Арванхоёрын Чуулгын гишүүн асан Ахлагч Хайд Палестинд номлолд дуудагдсан байлаа (*History of the Church*, 4:106). Тэрээр 18 сар орчмын дараа очих ёстой газартаа ирсэн ажээ.

1841 оны аравдугаар сарын 24-ний ням гарагийн өглөө эрт, Ахлагч Хайд Чидуны Уулан дээр гарч, залбирал хэлэв. Тэрээр залбиралдаа, “Ариун бошиглогчдын зөгнөн хэлж байсны дагуу Иудагийн тараагдсан хүмүүсийн үлдэгдлийг хамтад нь цуглуулахын төлөө – Иерусалимыг дахин босгохын төлөө . . . түүнчлэн [Их Эзэний] нэрийг дээдлэн хүндэтгэх Ариун сүмийг барихын төлөө” уг нутгийг онцгойлон, ариулж адисалсан юм. Тэр бас Абрахам, Исаак, Иаковын үр удмыг Их Эзэн үүрд санаж байхын төлөө, “энэ нутгийг тэдэнд үүрдийн өв болгон өгөхийн төлөө залбирчээ” (*History of the Church*, 4:456).

Энэхүү үйл хэргийн гэрчлэл болгон, Ахлагч Хайд Чидуны Уулын орой дээр чулуугаар овоо босгов. Ариун сүм байсан газар, эрт үед Сионы Уул [Мориа Уул байж магадгүй] хэмээн нэрлэгддэг байсан уулан дээр” (*History of the Church*, 4:459) тэр бас чулуун овоо босгожээ.

“Энэ үеийнхэн миний үгийг чамаар дамжуулан хүлээн авах болно”

Хичээл
13

Зорилго

Энэ эрин үед Их Эзэний үгийг авчрах үүргийг гүйцэтгэсэн Бошиглогч Иосеф Смитэд талархахад ангийн гишүүдэд туслах.

Бэлтгэл

1. Энэ хичээлийн судрууд болон дараах материалыг залбирч, судал:
 - а. *Бидний Өв*, хуудас 27-28, 47, 48.
 - б. Судруудын Удирдамж, “Иосеф Смитийн Орчуулга,” х. 105
 2. *Ангийн гишүүний Судлах Удирдамж* (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг дүгнэ. Хичээлийн үед уг материалаас эш татах, хэрэглэх арга хэлбэрийг төлөвлө.
 3. Зарлигуудын Номын хуудсуудыг аварч үлдсэн тухай Мэри Элизабет, Каролин Роллинс нарын хэлсэн үгсийг (*Бидний Өв*, хуудас 47, 48) товчлон бэлтгэхийг ангийн гишүүнээс хүс.
 4. Зарлигуудын Номыг аварч буй Мэри, Каролин Роллинс нарын зураг (62605; Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 409) байвал хичээлийн үеэр ашиглахаар бэлтгэ.
 5. Хуудас 84 дээрх схемээс сонгож авсан хэсгүүдийг үзүүлэн болгон хувилж ав эсвэл самбар дээр бичихээр бэлтгэ.
-

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

Дараах сэдвүүдийн заримыг нь эсвэл бүгдийг нь хичээл эхлэхийн өмнө самбар дээр жагсаа.

Бурхан тэргүүтний бодит мөн чанар
Бид Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн нь
Төлөөлөгчид ба Бошиглогчид
Мелкизедек Санваар
Ароны Санваар
Баптисмын хэв маяг
Ариун Сүнсний бэлэг
Мөнх бус байдлын өмнөх оршихуй Нас барагсдын төлөөх баптисм
Амиуулалт
Алдар суугийн гурван хаант улс
Мөнхийн гэрлэлт
Тэнгэрлэг Эцэгтэй адилхан болох бидний чадавх

Бошиглогч Иосеф Смитээр илчлэгдээгүй зүйлийг самбар дээрээс арилгахыг ангийн гишүүнээс хүс. Самбар дээрээс арилгах юу ч байхгүй-эдгээр бүх үнэнүүд Бошиглогч Иосефоор дамжин сэргээгдсэнийг мэдэхэд нь ангийн гишүүдэд тусал. Энэ эрин үед Их Эзэний үгийг авчрахад Иосеф Смит хэрхэн зэмсэг болсныг энэ хичээлээр ярилцана.

Ярилцах ба
хэрэгжүүлэх нь

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбиран сонгож ав. Таны заах зарчмуудтай холбоотой болсон явдлаа хуваалцахад нь ангийн гишүүдийг дэмж.

1. Энэ эрин үеийн хүмүүс үгийг нь Иосеф Смитээр дамжуулан хүлээн авна гэдгийг Их Эзэн тунхагласан нь

С ба Г 5:10-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Энэ шүлэг дэх “энэ үеийнхэн” гэдэг нийлэмж үг нь энэ эрин үе болох бидний амьдарч байгаа үеийг хэлж байгааг тайлбарла. Дараа нь Ерөнхийлөгч Бригам Янгийн доорх мэдэгдлийг хуваалц:

“Би Их Эзэнээс хүлээж авсан зүйлээ Иосеф Смитээр дамжуулан хүлээж авсан юм” (*Discourses of Brigham Young*, эмхтгэсэн, Жон А.Видцөү [1941], 458).

- Энэ мэдэгдэл таны хувьд хэр зэрэг үнэн бэ? Хожмын үеийн бүх Гэгээнтнүүдийн хувьд энэ нь хэр зэрэг үнэн бэ?

Энэ эрин үед агуу үнэнүүд Бошиглогч Иосеф Смитээр дамжин ирснийг хэл. Жишээ нь: Хожмын үеийн судрууд, санваарын ёслолууд, санваарын зохион байгуулалт, ариун сүмүүдийг барьсан үйл хэрэг нь Бошиглогч Иосеф Смитээр дамжин Их Эзэнээс ирсэн юм.

2. Эртний болон хожмын үеийн олон судар Иосеф Смитээр дамжин ирсэн юм

- Мосе 1:40-41-ийг ангийн гишүүдийн хамт унш. Шүлэг 41 дэх бошиглол хэрхэн биелэгдэж байна вэ? (Олон хүмүүс үгсийг нь хөнгөмсгөөр үнэлсэн үед Их Эзэн Бошиглогч Иосеф Смитийг өндөрт гарган тавьсныг онцолж хэл. Их Эзэний үгс эдүгээ “хүмүүний үрсийн дунд дахин бий боллоо”)
- Бошиглогч Иосеф Смитээр дамжин бидэнд ямар судрууд ирсэн бэ? (Мормоны Ном, Сургаал ба Гэрээ, Агуу Үнэт Сувд, Иосеф Смитийн Библийн Орчуулга. Эртний судруудыг сэргээхэд Иосеф Смит Их Эзэний мутарт зэмсэг болсон бөгөөд хожмын үеийн судрууд болсон олон илчлэлт хүлээн авсныг онцолж хэл)

Арванхоёрын Чуулгын Ахлагч Ли Гранд Ричардс Иосеф Смитийн тухай өгүүлсэн нь: “Тэрээр дэлхий дээр урьд өмнө амьдарч байсан ямар ч бошиглогчоос илүү их илчлэгдсэн үнэнийг бидэнд өгснийг цэдгүүд маань харуулж байна” (In Conference Report, 4-р сарын 1981, 43; *Ensign*, 1981 оны тавдугаар сар, 33).

Мормоны Ном

2 Нифай 3:11-15-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Энэ хэсэг Иосеф Смитийн тухай нэг бошиглол агуулдгийг тайлбарла. Шүлэг 12-т дурдагддаг бичээсүүд бол Библи болон Мормоны Ном юм.

- Зөрчил сөргөлдөөнийг арилгаж, амар амгаланг тогтооход Мормоны Ном ямар арга замуудаар тусалдаг вэ? Их Эзэний гэрээнүүдийн тухай мэдлэгт хүмүүсийг Мормоны Ном ямар арга замуудаар авчирдаг вэ?
- Мормоны Ном амьдралыг тань хэрхэн адисалсан бэ?
- Мормоны Ном дахь ямар хэсгүүдэд та дуртай вэ?

Энэ ярилцлагын хэсэг болгож, өөрийн чинь хувьд онцгой учир холбогдолтой нэг буюу хоёр хэсгийг Мормоны Номоос та хуваалцаж болох юм.

Сургаал ба Гэрээ

1823–1831 онуудад Иосеф Смит Их Эзэнээс 60 гаруй илчлэлт хүлээн авсныг тайлбарла. Эдгээр илчлэлтүүдийн цөөхөн гар бичмэлийг номлогчид болон бусад хүмүүст өгсөн байж, харин Сүмийн гишүүдийн олонхид нь илчлэлтүүд байдаггүй байв. Илчлэлтүүдийг Зарлигуудын Ном гэсэн нэртэй боть болгон хэвлэхээр 1831 оны сүүлчээр Огайод болсон чуулган дээр Сүмийн удирдагчид шийдвэрлэв (С ба Г 67, 69-ийн хэсгийн тоймыг үз). Уг номыг хэвлэж, үдэх газар, ойролцоогоор 1609 км хол Миссурийн Индепенденст илчлэлтүүдийг хүргэхээр Оливер Каудери, Жон Витмер нарыг сонгожээ.

Оливер Каудери, Жон Витмер хоёр 1832 оны нэгдүгээр сард Индепенденст хүрч, 1833 оны долдугаар сард Виллям В.Фелпс Зарлигуудын Номын эхний 160 хуудсыг хэвлэсэн аж. Гэвч 1833 оны долдугаар сарын 20-нд танхайрагч бүлэг Фелпс ахын хэвлэх үйлдвэрийг, Зарлигуудын Номын үдээгүй олон хуудсыг устгажээ.

Мэри Элизабет, Каролин Роллинс нарын зоригийн тухай түүхийг ярихыг даалгвар хүлээн авсан ангийн нэг гишүүнээс хүс (Бидний Өв, хуудас 47, 48).



Зарлигуудын Ном. Энэ бол Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлтүүдийн анхны эмхтгэл юм. Эдгээр илчлэлтүүд хожим нь Сургаал ба Гэрээний хэсэг болжээ.

Устгагдахаас аварсан хуудсуудыг Зарлигуудын Номын цөөхөн хувьд оруулж үдсэн хэдий ч, илчлэлтүүд олон хувиар олодохгүй хэвээр байв. 1835 онд өөр 45 илчлэлт нэмэгдсэний дараа Зарлигуудын Ном Сургаал ба Гэрээ болон хэвлэгдсэн юм.

- Бид Сургаал ба Гэрээн дэх илчлэлтүүдийг хэрхэн үнэлэх талаар Мэри Элизабет, Каролин Роллинс нарын тухай түүх юу зааж байна вэ?
- Сургаал ба Гэрээг энэ жил судалж байгаа нь та нарыг хэрхэн адисалсан бэ?
- Сургаал ба Гэрээн дэх ямар хэсгүүдэд та нар дуртай вэ?

Энэ ярилцлагын нэг хэсэг болгон, өөрийн чинь хувьд онцгой учир холбогдол бүхий Сургаал ба Гэрээний нэг буюу хоёр хэсгийг хуваалцахыг та хүсч болно.

Агуу Үнэт Сувд

Агуу Үнэт Сувд гэсэн нь үнэхээр оносон нэр болохыг хэл. Энэ ном сувд лугаа адил багахан хэмжээтэй боловч үнэ цэнэ нь агуу юм. Агуу Үнэт Сувд хэмжээгээрээ ердөө 61 хуудас ч, үүрд мөнхийн олон асуудлыг, түүний доктор Тэнгэр дэх Их Зөвлөл, цаг хугацааны бүрэн байдлын эрин үе дэх сайн мэдээний сэргээлт, Аврагчийн Хоёр дахь Ирэлт, Мянган Жил, мөн үүрдийн амьдралыг хамарсан юм. Энэ ном Бүтээлт, Уналт, Цагаатгал, хүн төрөлхтний сонгох эрхийн талаар үнэ цэнэтэй сургаалуудыг агуулдаг. Уг Судар таван хэсэгтэй:

- а. Мосегийн Номоос авсан түүврүүд
- б. Абрахамын Ном
- в. Иосеф Смит–Матай
- г. Иосеф Смит–Түүх
- д. Итгэлийн Тунхаг

Агуу Үнэт Сувдын эхэн дэх Оршил тэмдэглэлийг гаргахыг ангийн гишүүдээс хүс. Судрын энэ номын хэсэг бүрийн үндэс суурийг тайлбарласан сүүлчийн таван догол мөрийг тэднээр нэгтгэн дүгнүүл.

- Агуу Үнэт Сувд дахь сургаалууд та нарт хэрхэн тусалсан бэ? Өөрсдийн чинь хувьд онцгой учир холбогдолтой ямар хэсгүүд Агуу Үнэт Сувдад байдаг вэ?

Энэ ярилцлагын нэг хэсэг болгон, таны хувьд онцгой учир холбогдолтой Агуу Үнэт Сувдын өөрийнхөө дуртай нэг буюу хоёр хэсгийг хуваалцахыг та хүсч болно.

Библийн Иосеф Смитийн орчуулга

- Итгэлийн найм дахь тунхгийг ангийн гишүүдтэй хамт унш. “Зөв орчуулагдсан байхын хэрээр” гэсэн нийлэмж үгийн утга юу вэ?

1 Нифай 13:24-28 ангийн гишүүдтэй хамт унш. (“Иудейн амнаас гарсан ном” гэдэг нь Библи болохыг тайлбарла. “Агуу хийгээд жигшүүрт сүм” гэдэг нь аль нэг тодорхой сүмийг биш, харин Бурханы эсрэг тэмцдэг бүх хүмүүсийг хэлдэг) Их Урвалтын улмаас сайн мэдээний бүрэн байдлыг Их Эзэн дэлхийгээс татан авсныг ангийн гишүүдэд сануул. Үүнээс хойших олон зууны туршид Библийн олон хэсэг өөрчлөгдөж, олон тодорхой бөгөөд эрхэм үнэ цэнэтэй үнэн алга болсон ажээ.

Сүм сэргээгдсэнээс хойш удалгүй, Библийн Хаан Жеймсийн Хувилбарт сүнсээр нөлөөлөгдсөн залруулга хийж эхлэхийг Бошиглогч Иосефт Их Эзэн зааварлажээ. Сургаал ба Гэрээнд эл зааврын олон эшлэл байдаг (Жишээ нь, С ба Г 35:20; 37:1; 45:60-61; 73:3-4; 93:53-ыг үз). Өнөөдөр бид Библийн Иосеф Смитийн Орчуулгыг Бошиглогчийн бүтээл гэж үздэг.

Библийн Иосеф Смитийн орчуулга нь ердийн байдлаар орчуулга гэж бидний нэрлэдэг зүйлээс ялгаатай юм. Бошиглогч Библийг нэг хэлнээс нөгөөд орчуулаагүй билээ. Түүний цорын ганц бичвэр нь Библийн Хаан Жеймсийн Хувилбар байсан бөгөөд залруулга хийж, бүрмөсөн алга болсон хэсгүүдийг сэргээхэд тэрээр Сүнсээр удирдагдсан ажээ.

Иосеф Смитийн Орчуулгаас авсан хоёр хэсэг Агуу Үнэт Сувдад (Мосегийн Ном ба Иосеф Смит-Матай) байдаг. Түүнээс гадна Иосеф Смитийн Орчуулгын товч хэсэг, Библийн Хаан Жеймсийн Хувилбарын хамт Хожмын Үеийн Гэгээнтний хэвлэлийн зүүвэр тайлбаруудад орсон байгаа. Илүү урт хэсгүүд нь Судруудын Удирдамжийн төгсгөл дэх хавсралтад орсон байгаа.

Иосеф Смитийн Орчуулгын төлөө улам их талархалтай болоход нь ангийн гишүүдэд туслахын тулд та зарим хэсгийг Библийн Хаан Жеймсийн Хувилбартай товчхон харьцуулахыг хүсч болно. Хоёр харьцууллыг доор өгөв:

- а. Енохын шастир болон сургаалууд бол Иосеф Смитийн Орчуулга дахь урт хэсгүүдийн сэргээлтийн нэг жишээ мөн. Енохын талаарх Библийн эшлэлүүд зөвхөн Эхлэл 5:18-24, Лук 3:37, Еврей 11:5, Иуда 1:14-15-д байдаг. Енохын талаарх Иосеф Смитийн Орчуулгын эшлэлүүд түүний сургаал, үзэгдэл, бошиглолуудыг хамран, Мосе 6:21-68, 7:1-69-т цэдэглэгджээ. Эдгээр шүлгүүдийг хичээл дээр уншиж, үнэ цэнийнх нь тухай ярилцахын тулд шүлгүүдээс заримыг нь сонгож ав.
- б. Матай 4-т хийсэн засвар нь Библи дэх зарим шүлгүүдэд хийсэн сүнсээр нөлөөлөгдсөн залруулгын нэг жишээ мөн. Хэрэв Библийн зүүвэр тайлбарууд дахь Иосеф Смитийн Орчуулгын хэсгүүд ангийн гишүүдэд байдаг бол Матай 4-ийн хэдэн зүүвэр тайлбарыг “ИСО”-аар эхэлсэн хэсгүүдийн хамт тэднээр нэгтгэн дүгнүүл. Эдгээр шүлгүүд Хаан Жеймсийн Хувилбар дахь шүлгүүдийг хэрхэн тодруулж байгааг ярилц.

Библийг орчуулах үйл явц нь зөвхөн Библи дэх сургаалуудыг залруулж, сэргээснээр хязгаарлагдаагүй юм. Энэ нь Сургаал ба Гэрээгээр дамжуулан сургаалуудын сэргээлтийг авчрахад тусалсан юм. Сургаал ба Гэрээн дэх олон илчлэлт нь Библийн орчуулгыг тунгаан бодох үеэрээ Бошиглогчийн асуусан асуултуудад өгсөн хариулт мөн. Иосеф Смитийн Орчуулгыг олон жилийн турш судалсан Сүмийн нэг гишүүн: “Иосеф Смитийн Орчуулга бол зөвхөн улам сайн Библи биш. Энэ бол энэ Сүмийг нялх балчир байх үе дэх сургаалын сэргээлтийн суваг буюу арга хэрэгсэл байжээ” хэмээн тэмдэглэжээ (Роберт Ж.Маттьюс, *The Capstone of Our Religion: Insights into the Doctrine and Covenants* [1989], 64).

Иосеф Смитийн Орчуулга хэрхэн “сургаалын сэргээлт” рүү хөтөлсний нэг жишээг харуулахын тулд, *Бидний Өвийн* хуудас 27, 28 дээрх хоёр дахь догол мөрийг бүтнээр нь унш. Та С ба Г 76-гийн хэсгийн тойм, мөн С ба Г 76-гийн шүлэг 15-19-ийг уншихыг хүсч болно.

Судрууд судлахдаа Иосеф Смитийн Орчуулгыг ашиглахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

3. Сайн мэдээний тодорхой бөгөөд эрхэм үнэт сургаалууд Иосеф Смитээр дамжин сэргээгдсэн нь

Доорх схем Бошиглогч Иосеф Смитээр дамжин сэргээгдсэн буюу тодруулагдсан сайн мэдээний зарим сургаалыг авч үзжээ. Зүүн талын багананд жагсаасан сэдвүүд анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааныхтай адил байгааг ажигла.

Схемийн дунд талын багананд, сургаал болон зарчмууд нь тодорхой бус, буруу эсвэл бүрэн биш Библийн шүлгүүдийг жагсаасан байна. Баруун талын багананд Иосеф Смитээр дамжин өгөгдсөн сургаал болон зарчмуудыг сударт хаана тайлбарласан буюу тодруулсныг харуулжээ.

Уг схемээс хэдэн сэдвийг сонгож, дагалдах судрын хэсгүүдийг ангийн гишүүдтэй хамт уншиж, нэгтгэн дүгнэ. Бошиглогчоор дамжин ирсэн илчлэлтүүд эдгээр сэдвийг хэрхэн тодруулсныг ярилц.

Сэдэв	Библи дэх судрууд	Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн судрууд
Бурхан тэргүүтний бодит мөн чанар	Матай 3:16-17; Иохан 4:24; Үйлс 7:55	Иосеф Смит-Түүх 1:17; С ба Г 130:1, 22
Бид Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн нь	Эхлэл 1:27	Моисе 6:8-9
Төлөөлөгчид ба Бошиглогчид	Ефес 2:20; 4:11-16	С ба Г 107:23, 33, 35, 39, 58; 112:30-32
Мелкизедек Санваар	Еврей 6:20; 7:17	С ба Г 84:19-25; 107:1-8, 18-19
Аароны Санваар	Еврей 7:11	С ба Г 13; 84:18, 26-27, 30; 107:1, 13-14, 20
Баптисмын хэв маяг	Матай 3:16	3 Нифай 11:22-26; Моронай 8:8-12; С ба Г 20:71-74
Ариун Сүнсний бэлэг	Үйлс 8:17	С ба Г 20:41, 43; 35:6; 121:46
Мөнх бус байдлын өмнөх оршихуй	Иеремиа 1:4-5	С ба Г 93:29; Абрахам 3:22-26
Нас барагсдын өмнөөс хийх баптисм	1 Коринт 15:29	С ба Г 128:16-18
Амилуулалт	Иов 19:25-26; Иохан 5:28-29; 1 Коринт 15:22	Алма 11:42-45
Алдар суугийн гурван хаант улс	1 Коринт 15:40-42	С ба Г 76:50-112; 131:1
Мөнхийн гэрлэлт	Эхлэл 2:24; 1 Коринт 11:11	С ба Г 131:1-4; 132:19
Тэнгэрлэг Эцэгтэй адилхан болох бидний чадавхи	Ром 8:17	С ба Г 88:107; 93:20; 132:20-24

Дүгнэлт

Их Эзэний үгийг бидэнд авчрахад гүйцэтгэсэн Иосеф Смитийн үүргийн төлөө талархлаа илэрхийл. Сүнсээр өдөөгдсөний дагуу хичээлийн үеэр ярилцсан үнэнүүдийн тухай гэрчил.

Зорилго Өргөлийн хууль болон түүний мөнхийн зорилгуудыг ойлгоход нь, түүнчлэн Бурханд үйлчлэхэд амьдралаа илүү бүрэн дүүрэн зориулахыг хүсэхэд нь ангийн гишүүдэд туслах.

Бэлтгэл

1. Дараах судрууд болон бусад материалыг залбирч судал:
 - а. Сургаал ба Гэрээ 42:30-42; 51; 78; 82; 104:11-18; мөн энэ хичээлийн бусад судар.
 - б. Бидний Өв, хуудас 29-30.
2. Ангийн гишүүний Судлах Удирдамж (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга замыг төлөвлө.
3. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах бол ангийн гишүүн бүрд хүрэлцэхүйц цаас, үзэг эсвэл харандаа авчир.

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

Ангийн гишүүн бүрд цаас, үзэг эсвэл харандаа өг. Өөрийнхөө эзэмшдэг үнэтэй материаллаг таван зүйлийг жагсаан бичихийг хүн бүрээс хүс. Дараа нь С ба Г 104:13-14-ийг ангийн гишүүдтэй хамт унш.

- Бидний эзэмшдэг юм бүхний жинхэнэ эзний тухай бид эдгээр шүлгүүдээс юу мэдэж авав? Дэлхий дээрх бүх юмс Их Эзэнийх гэдгийг ойлгосноор, эзэмшдэг зүйлүүдээ ашиглах талаар та нарт ямар бодол төрөв?

Эдгээр шүлгүүдэд заагддаг зарчмууд Өргөлийн хуулиар амьдрахад тулгуур болдгийг тайлбарла. Энэ хичээл нь уг хуулинд болон амьдралаа Их Эзэнд илүү бүрэн дүүрэн зориулж болох арга замуудад бидний анхаарлыг төвлөрүүлдэг.

Ярилцах ба хэрэгжүүлэх нь

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбиран сонгож ав. Судрын зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг дэмж.

1. Их Эзэн Өргөлийн хуулийг Гэгээнтнүүдэд илчилсэн нь

Гэгээнтнүүд Огайогийн Көртландад цугларч эхэлснээс хойш удалгүй 1831 оны хоёрдугаар сард, тэд өргөлийн хуулиар амьдарч эхлэх ёстойг Их Эзэн илчилжээ (С ба Г 42:30).

- *Өргөл болгох* гэж юу гэсэн үг вэ? (Энэ бол ямар нэг зүйлийг онцгойлон адислах буюу Их Эзэний үйлчлэлд зориулах гэсэн утгатай юм) Өргөлийн хууль гэж юу вэ? (Энэ бол Их Эзэний хаант улсыг байгуулж, Түүний хүүхдүүдэд үйлчлэхийн тулд хувь хүмүүс цаг зав, авьяас чадвар, эд хөрөнгөө Сүмд өргөл болгон өгөх зохион байгуулалттай арга зам мөн)
- Өргөлийн хуулийн зорилго юу вэ? (Дараах судруудыг ангийн гишүүдээр уншуулж, эдгээр нь Өргөлийн хуулийн зорилгын талаар юу зааж байгааг тогтоо. Эдгээр зорилгуудыг самбар дээр нэгтгэн дүгнэ. Ярилцлагыг урамшуулан дэмжихийн тулд дараах асуултуудаас заримыг нь сонго)
 - а. С ба Г 42:30. (Ядуучууд болон гачигдалтай хүмүүст анхаарал халамж тавих) Ядуучууд болон гачигдалтай хүмүүст анхаарал халамж тавих нь Өргөлийн хуулиар дамжин хэрхэн хэрэгждэг вэ? (С ба Г 42:31-34-ийг үз.)
 - б. С ба Г 42:35. (Газар худалдаж авах, ариун ёслолын байр болон Шинэ Иерусалимыг барих)
 - в. С ба Г 42:40. (Бардамналыг даван туулахад нь Их Эзэний хүмүүст туслах) Өргөлийн хуулиар амьдрах нь өөртөө байдаг бардамнал, шуналыг даван туулахад гишүүдэд хэрхэн тусалж чадах вэ?
 - г. С ба Г 42:42. (Ажилч хичээнгүй байж, залхуурлаас зайлсхийхэд Их Эзэний хүмүүст туслах)
 - д. С ба Г 51:9. (Нэгдмэл нэг байхад нь Их Эзэний хүмүүст туслах) Их Эзэн биднээс нэгдмэл нэг байхыг ямар арга замаар хүсэн хүлээдэг вэ? Нэг байхад Өргөлийн хууль Гэгээнтнүүдэд хэрхэн тусалж чадах вэ?
 - е. С ба Г 78:3-7. (Их Эзэний хүмүүсийг дэлхийн зүйлүүдэд адил тэгш болгох селестиел хаант улсад байртай болоход нь тэдэнд туслах) “Дэлхийн зүйлүүдэд” адил тэгш байх нь “тэнгэрийн зүйлүүдийг” (С ба Г 78:5) олж авахад бидэнд хэрхэн тусалдаг вэ?
 - ё. С ба Г 78:14. (“Бүх бүтээлийн дээр тусгаар байдалтай байхад” Сүмд туслах)
 - ж. С ба Г 82:17-19. (Бүх хүмүүсийн сайн сайхны төлөө авьяас чадвараа дээшлүүлж, хөршүүдийнхээ сонирхлыг мэдэж, бүх зүйлийг Бурханы алдар суугийн төлөө бие сэтгэлээ зориулж хийхэд Их Эзэний хүмүүст туслах) Өргөлийн хуулиар амьдрах нь илүү их энэрлийг хөгжүүлэхэд Их Эзэний хүмүүст хэрхэн тусалж чадах вэ?

Эдгээр зорилгуудаас харахад өргөлийн хууль нь зөвхөн эд материалын юм уу эдийн засгийн хөтөлбөр биш гэдгийг онцлон тэмдэглэ. Энэ бол сүнслэг байдлын хувьд өсч хөгжин мөнх амьдралд бэлтгэхэд нь гишүүдэд тусалдаг хууль юм (С ба Г 29:34-35).

Өргөлийн хуулийн зарчмууд Бошиглогч Иосеф Смитээр дамжин илчлэгдсэнээс хойш өөрчлөгдөөгүй байгааг тайлбарла. Гэвч эдгээр зарчмуудыг хэрэгжүүлэх хэлбэр үе үе өөрчлөгддөг. Эдгээр зарчмуудыг манай өнөө үед хэрхэн хэрэгжүүлэхийг ойлгоход одоогийн Бошиглогч бидэнд тусалдаг.

Өргөлийн хууль Сүмийн хөгжлийн эхэн үед хэрхэн гүйцэтгэгддэг байсныг тайлбарлахын тулд та дараах материалыг ашиглаж болох юм. Эхэн үеийн Гэгээнтнүүд Огайо, Миссури, Ютагийн үед эл хуулиар амьдрахыг хичээж байв. Зарим Гэгээнтнүүд уг хуулиар сайн амьдарч байсан ч, Сүм бүхэлдээ энэ хуулиар амьдарч чадаагүй юм (мөн *Бидний Өв*, хуудас 29, 30-ийг үз).

Эд хөрөнгийг өргөл болгосон нь

Сүмийн гишүүд өргөлийн хуулийн дагуу, өмчлөх эрхийн гэрчилгээгээр эд хөрөнгөө сайн дураараа Сүмд өргөл болгодог байв (С ба Г 42:30).

Ажил үүрэг хүлээн авдаг байсан нь

Сүмийн гишүүд эд хөрөнгөө өргөл болгосны дараа бишоп тэдэнд ажил үүрэг буюу хүлээж авсан бүх өмч хөрөнгөнөөс тодорхой хувийг олгодог байв. Ажил үүргийн хэмжээг тухайн гэр бүлийн байдал, хэрэгцээнээс хамааралтайгаар, ажил үүрэг хүлээн авч байгаа гишүүнтэй зөвлөлдсөний үндсэн дээр бишоп тогтоодог байв (С ба Г 42:32; 51:3). Гишүүн бүр хариуцуулж өгсөн өмч хөрөнгийг эрхлэхэд бүрэн хариуцлага хүлээхийн тулд ажил үүргийг өмчлөх эрхийн гэрчилгээтэй хамт өгдөг байжээ (С ба Г 51:4; 72:3-4; 104:11-13). Хэдийгээр бүх өмч хөрөнгө Бурханд төгс харьяалагддаг ч гэсэн, ажил үүргийг нийтийн буюу хамтын өмч хөрөнгө биш, хувийн өмч гэж үзэн ханддаг байв.

Илүүдэл бүтээгдэхүүн

Хэрэв гишүүд ажил үүргээрээ гэр бүлдээ шаардлагатайгаас илүү бүтээгдэхүүн үйлдвэрлэх юм бол жилийн эцэст үүнийг бишопын агуулахад хадгалахын тулд бишопт өгдөг байв (С ба Г 42:33; 51:13). Илүүдэл бүтээгдэхүүнийг ядуучуудад анхаарал халамж тавих, ариун ёслолын байр барих мөн бусад зохимжтой зорилгоор ашигладаг байжээ (С ба Г 42:34-35).

Нэгдсэн журам

Их Эзэн хүмүүсийн дунд Өргөлийн хуулийг удирдан, зохион байгуулах байгууллага байх ёстойг 1832 оны гуравдугаар сард илчилжээ (С ба Г 78:3). Тэрээр энэ байгууллагыг “нэгдсэн журам” (С ба Г 92:1) гэж нэрлэсэн Их Эзэн дараачийн илчлэлтүүдэд нэгдсэн журмын талаар нэмэлт заавар өгсөн байдаг (Жишээ нь: С ба Г 104-ийг үз).

2. Өргөлийн хууль бол мөнхийн хууль

Өргөлийн хууль бол Их Эзэн манай эрин үед дахин илчилсэн мөнхийн хууль юм. Энэ хуулиар амьдардаг байсан Их Эзэний хүмүүсийн шастирууд Агуу Үнэт Сувд, Шинэ Гэрээ, Мормоны Номд байдаг. Дараах судрын хэсгүүдийг ангийн гишүүдтэй хамт уншиж, нэгтгэн дүгнэ:

- а. Мосе 7:18. (Енохын хүмүүс.)
 - б. Үйлс 4:32, 34-35. (Гэгээнтнүүд Аврагчийн Амилалтын дараа.)
 - в. 4 Нифай 1:1-3, 12-13, 15. (Аврагч тэдэн дээр хүрч ирсний дараах Қифайчууд.)
- Хүмүүс өргөлийн хуулиар амьдардаг нийгэм дэх адислалууд юу байж болно гэж та нар боддог вэ?

3. Одоо бид амьдралаа Их Эзэнд зориулж чадна

Бурханы Гэгээнтнүүдийн хувьд бид Өргөлийн хуулиар бүрнээр нь амьдрахад бэлтгэгдсэн байх ёстой. Бас ийм хүсэлтэй байх ёстой. Гэвч бид ирээдүйн нэгэн өдөр Их Эзэнд амьдралаа зориулахаар хүлээх ёсгүй. Бид өнөөдөр өргөлийн хуулиар амьдрахын тулд чадах бүхнээ хийх юм бол Их Эзэн

үүнийг биднээс хүссэн үед, энэ хуулийн бүрэн байдлаар амьдрахад бид илүү сайн бэлтгэгдэнэ.

- Өнөөдөр бид ямар арга замуудаар Өргөлийн хуулиар амьдарч чадах вэ? (Дараах мэдээллийг ярилцлагад ашиглах эсвэл ангийн гишүүдийн хариулт дээр нэм. Мэдээллийг ярилцах үед толгой гарчгуудыг самбар дээр бич.)

Бидэнд байгаа юм бүхэн Их Эзэнийх гэдгийг ойлго

- Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашигласан бол үүн рүү буцаж оч. Хэрэв та үүнийг ашиглаагүй бол, ба Г 104:13-14, Дуулал 24:1-ийг ангийн гишүүдтэй хамт унш. Эдгээр шүлгүүдээс бид юу сурч болох вэ? Өөрсдийнхөө эд хөрөнгийг ажил үүрэг болгож хариуцна гэж юу гэсэн үг вэ? Энэ мэдлэг өмч хөрөнгөндөө хандах бидний хандлагад хэрхэн нөлөөлөх ёстой вэ? Юм бүхэн Их Эзэнийх гэдгийг ойлгох нь яагаад чухал вэ? Бид Түүний өгсөн зүйлүүдэд итгэлтэй даамлууд байх юм бол Их Эзэн ямар амлалт өгсөн бэ? (С ба Г 51:19; 78:22-ыг үз.)

Бидэнд байгаа юм бүхэн Их Эзэнийх гэсэн зарчимд бид “бүрэн дүүрэн нийцэх” хүртэл, “Өргөлийн хуулийг хүлээн авах нь бидний хувьд боломжгүй биш боловч, хэцүү байх болно. Бид энэ хуулиар амьдрахаар бэлтгэснээр дуудлага ирэх өдрийг агуу найдлагатайгаар хүсэн хүлээх болно. Нөгөө талаар, энэхүү хүсэн хүлээлт хойшилж болно. Иймээс бид материаллаг зүйлүүдийг хуримтлуулахын баяр жаргалыг эдэлнэ хэмээн найдах аваас, буруу зам дээр байгаа нь тэр” гэж Сүмийн Тэргүүлэх Бишоп асан, Бишоп Виктор Л.Браун хэлжээ (“*Law of Consecration*,” 1976 *Devotional Speeches of the Year* [1977], 439).

- С ба Г 19:26-г ангийн гишүүдтэй хамт унш. Энэ шүлэгт Их Эзэн Мартин Харрист ямар сэрэмжлүүлэг өгсөн бэ? Хэрэв бид амьдралаа Их Эзэнд зориулахдаа яагаад шуналыг даван туулах ёстой вэ? Бид шунаг сэтгэлийг хэрхэн даван туулж чадах вэ?

“Би тамын сүргээс бус, харин манай ахлагч нарын сувдаг шунахай сэтгэлээс илүү их айдаг. . . Дэлхий дэх бидний бүх дайсан . . . бас тэдэнтэй хамт бидний эсрэг хөл нийлүүлэн алхагчид, энэ хүмүүсийн зүрх сэтгэл дэх шуналын учруулж болох тийм хэмжээний хор хөнөөлийг бидэнд учруулж чадахгүй” хэмээн Ерөнхийлөгч Бригам Янг хэлжээ (in *Journal of Discourses*, 5:353).

Их Эзэний шаарддаг золиослолуудыг хий

Их Эзэн биднээс шаарддаг золиослолуудыг бид хийх хүсэлтэй байх ёстой. Ийм золиослол бол цаг зав, авьяас чадвар, эд хөрөнгөө зориулах явдал мөн. Өнөө үед бид Өргөлийн хуулийн зарчмуудыг хэрхэн хэрэгжүүлэх талаар Тэргүүн Зөвлөл, Арванхоёрын Чуулга бидэнд чиглэл өгдөг билээ.

- Бид өнөө үед Бурханы хаант улсыг байгуулахад туслахын тулд цаг зав, авьяас чадвар, эд хөрөнгөө хэрхэн зориулж болох вэ? (Доор жагсаасан зүйлүүд хариулт байж болно)
 - a. Аравны нэг, мацгийн өргөлөө төлж бай. Бусад хэлбэрээр гачигдалтай хүмүүст өгөөмрөөр өгч бай. Бид эдгээр зүйлүүдийг хийснээрээ, ядуучуудад анхаарал халамж тавихад нь, түүнчлэн дэлхий дээр Бурханы хаант улсыг байгуулахад шаардлагатай чухал үйл ажиллагаануудыг

хэрэгжүүлэхэд тусалж чадна. “Нэгдсэн Журмын дагуу илүү байгаа зүйлсээ өгөх ёстой байсан шиг тийм хэмжээгээр мацгийн өргөлөө өгөхөд бидэнд юу саад болдог вэ? Бид харам сэтгэлтэй байх юм бол юу ч биш” гэж Ахлагч Марион Г.Ромни хэлсэн байдаг (In Conference Report, 1966 оны 4-р сар, 100; *Improvement Era*, 1966 оны зургадугаар сар, 537).

- б. Сүмд чинхүү хүсэл эрмэлзэлтэйгээр үйлчил. Хүн бүр “өөрийн үүргийг мэдэж аваг, тэрээр томилогдсон албадаа бүхий л хичээл зүтгэлээр ажиллаг” (С ба Г 107:99) хэмээн Их Эзэн зөвлөжээ. Бид хүлээн авсан дуудлагаа чадварынхаа дээд хэмжээгээр биелүүлэх ёстой. Сүмийн тодорхой дуудлагуудаас гадна бид сайн мэдээг бусадтай хуваалцан, ариун сүмийн ажил хийж, итгэлээрээ шинэ буюу идэвх сул гишүүдийн гэрчлэлийг бэхжүүлэхэд туслахыг эрэлхийлж чадна.
- в. Бүрэн цагийн номлогчоор үйлчил. “Номлолын ажил өргөлийн хуулиар амьдрахыг та нарт заадаг. Энэ бол та нар бүх цаг зав, авьяас чадвар, нөөц боломжоо Их Эзэнд зориулах, амьдралд чинь ганцхан удаа тохиолдох үе байж болно. Хариуд нь Их Эзэн Өөрийн Сүнсийг та нартай хамт байлгахар адисална. Тэрээр та нарт ойр байж, та нарыг бэхжүүлнэ” хэмээн Арванхоёрын Чуулгын Ахлагч Роберт Д.Хейлс заасан байдаг (In Conference Report, 1996 оны 4-р сар, 50; *Ensign*, 1996 оны 5-р сар, 36).

Бусдыг хайрлах Христийнхтэй адил хайрыг хөгжүүл

- С ба Г 82:19, Иаков 2:17-г ангийн гишүүдтэй хамт унш. Бид бусдыг хайрлах хайраа хэрхэн харуулах тухай Их Эзэн эдгээр судруудад юу зааж байна вэ? Хэрэв бид өргөлийн хуулиар амьдрах юм бол, яагаад бусдыг хайрлах Христийнх шиг хайрыг хөгжүүлэх шаардлагатай вэ?

Бусдыг хайрлах Христийнх шиг хайртай байх чадвар бол өргөлийн хуулийн суурь юм гэдгийг тайлбарла. Бидний хайр өсөхийн хэрээр энэ хуулиар амьдрах бидний чадвар өснө. Хэрэгтэй цагт нь бусдад туслахын тулд ангийн гишүүд өөрсдөө буюу өөр хүмүүс цаг зав, нөөц боломжоо золиосолсон туршлагыг хуваалцахад ангийн гишүүдийг урь. Тохиромжтой бол та Ерөнхийлөгч Томас С.Монсоны ярьсан дараах түүхийг хуваалцаж болно:

“Бага насны маань олон дурдатгал надад байдаг. Ням гарагийн хоолыг хүлээдэг байсан нь эдгээр дурдатгалын нэг байлаа. Хүүхдүүд биднийг . . . шүлсээ залгин ширээнд дөнгөж суутал, шарсан махны үнэр өрөө дүүрэн ханхийв. ‘Томми, биднийг хоолоо идэхээс өмнө, миний хийсэн энэ тавагтай хоолыг гудамж уруудан Өвгөн Бобт аваачиж өгөөд хурдан эргэж ир’ гэж ээж надад хэлэв.

“Яагаад бид хоолоо эхлээд идэж, дараа нь түүнд тавагтай хоолыг нь хүргэж өгч болдоггүйг би ерөөсөө ойлгодоггүй байлаа. Би хэзээ ч чанга дуугаар асуудаггүй байсан, харин тэднийх рүү очиж, өндөр настай өвгөн Бобын хөлийн хүнд алхаа хаалганы цаана сонсогдохыг чагнан хүлээдэг байлаа. Тэгээд түүнд тавагтай хоолоо өгдөгсөн. Тэр өмнөх ням гарагт авчирсан тавгийг цэвэрхнээр нь надад өгөөд үйлчилсний минь төлөө арван центийг надад өгөх гэдэг байв. Миний хариулт үргэлж нэг л хэвийн: ‘Би мөнгө авч болохгүй. Ээж турсгыг минь хуулна’ гэдэг байлаа. Тэгэхэд тэр үрчлээтэй гараараа цайвар шаргал үсийг минь илээд, Хүү минь, чи гайхалтай сайхан ээжтэй хүү юм. Баярлалаа гэж ээждээ хэлээрэй’ гэдэгсэн . . . Би энэ үүрэгт ажлаасаа гэртээ эргэж ирсний дараа ням гарагийн хоол маань илүү сайхан

амттай юм шиг үргэлж санагддаг байж билээ” (“The Long Line of the Lonely,” *Ensign*, 1992 оны 2-р сар, 4).

Амьдралынхаа бүх талыг Их Эзэнд зориулахыг хичээ

Арванхоёрын Чуулгын Ахлагч Нийл А.Максвелл: “Өргөлийг зөвхөн өмч хөрөнгө, мөнгө төгрөг гэж бодох хандлага бидэнд байдаг. Гэтэл Их Эзэнд илүү ихийг өгөхөөс биднийг гар татуулдаг өдий төдий юм байдаг” гэж хэлжээ (In Conference Report, 1992 оны аравдугаар сар, 90; *Ensign*, 1992 оны арваннэгдүгээр сар, 66).

- Бурхан болон Түүний хүүхдүүдийн үйлчлэлд илүү ихийг зориулах бидэнд байгаа үед бид ямар байдлаар “гар татдаг” вэ? (Бид зарим үед өгөх ёстой өргөлөөсөө хэрхэн гар татдаг тухай Ахлагч Максвеллын дараах жишээнүүдийг болон С ба Г 64:34-ийг үз)
 - а. Их Эзэний хүсэл таалалд бүрэн захирагдах хүсэлгүй байх. “Хүлцэнгүй байх, дуулгавартай байж захирагдах хүсэл бол Бурханы тахилын ширээн дээр бидний тавих ёстой, хувь хүний цорын ганц онцгой зүйл мөн. Бидний “өгдөг” бусад олон зүйл бол . . . үнэндээ Тэрээр бидэнд өмнө нь өгсөн буюу бидэнд зээлүүлсэн зүйлс юм. Гэвч эцсийн эцэст та бид бүгдээрээ өөрсдийгөө захируулж, хувийнхаа хүслийг Бурханы хүсэл таалалд уусган шингээх юм бол, үнэхээр ямар нэг зүйлийг Түүнд өгч байгаа хэрэг! Энэ бол үнэхээр бидний өгөх ёстой цорын ганц өмч хөрөнгө мөн!” гэж Ахлагч Максвелл хэлжээ.” (In Conference Report, 1995 оны аравдугаар сар, 30; *Ensign*, 1995 оны арваннэгдүгээр сар, 24).
 - б. “Бидний үүрэг, бидний цаг зав, бидний амжилт ололт, бидний өмч хөрөнгө” гэхчлэн амин хувиа хичээсэн санаа бодлыг орхих хүсэлгүй байх (In Conference Report, 1995 оны аравдугаар сар, 28).
 - в. Сонирхдог юмс, ач холбогдол багатай зүйлүүдийг хэт шохоорхож, түүндээ хэт их цаг зарцуулах.
 - г. Иргэний магтууштай үйлчлэл үзүүлдэг хэрнээ “Есүсийн Ариун сүм болон Түүний ариун судруудын хувьд харьцангуй гадны хүн” хэвээр үлдэх (In Conference Report, 1995 оны аравдугаар сар, 27).
 - д. Гэр бүлийнхээ дотор үүрэг хариуцлагаа хүлээдэг боловч гэр бүлийн зарим гишүүдэд эелдэг уриалгахан хандахад Есүсийн үлгэр жишээг дуурайхгүй байх.
 - е. Бурханы хаант улсыг гэхээсээ илүүгээр юуны өмнө өөрсдийгөө бөөцийлөх.
 - ё. Авьяас чадвараа нийтийн өмнө хуваалцдаг хэрнээ ганцаархнаа байхдаа өвөрмөц бардамналд үлддэг.
 - ж. Сүмийн дуудлага хүлээн авахдаа зүрх сэтгэл нь дэлхийд тодорхой үүрэг гүйцэтгэсээр байхад илүүтэй чиглэсэн байх.
(Conference Report, 1992 оны аравдугаар сар, 88-92; *Ensign*, 1992 оны арваннэгдүгээр сар, 65-67; мөн Conference Report, 1995 оны аравдугаар сар, 27-30; *Ensign*, 1995 оны арваннэгдүгээр сар, 22-24-ийг үз.)
- Бид илүү бүрэн дүүрэн өргөлийн төлөө хичээн чармайсан үед хэрхэн адислагддаг вэ?

Дүгнэлт

Ангийн гишүүд өөрсдийгөө Их Эзэнд хэрхэн илүү бүрэн дүүрэн зориулж чадахыг тодорхойлохын тулд амьдралаа шалгаж үзэхэд тэднийг урамшуулан дэмж. Бидний эзэмшдэг бүхэн Их Эзэнийх гэдгийг ойлгож хүлээн зөвшөөрснөөр, эдүгээ биднээс шаардагдаж байгаа золиослолыг хийх хүсэлтэй байснаар, бусад хүмүүсийг хайрлах Христийнх шиг хайрыг хөгжүүлснээр бид эдгээр зүйлүүдийг хийж чадна гэдгийг тайлбарла.

Нэмэлт заах санаанууд

Та зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болгож дараах хоёр санаанаас нэгийг нь буюу хоёуланг нь ашиглаж болно.

1. Их Эзэний агуулах

Ядуучуудад анхаарал халамж тавихтай холбоотойгоор Их Эзэний агуулахын тухай Сургаал ба Гэрээнд нэлээд хэдэн удаа дурдсан байдаг (С ба Г 42:34; 78:3; 83:5-6-г үз). Их Эзэний агуулах гэж юу болох, өнөөдөр үүнийг хэрхэн ашигладаг тухай ойлгоход нь ангийн гишүүдэд туслахын тулд *Сүмийн Заавруудын Гарын Авлагын* дараах мэдээллийг хуваалц:

“Их Эзэний агуулах Гэгээнтнүүдийн өргөл болгосон зүйлүүдийг хүлээн авч, итгэлтэйгээр хадгалан, тарааж өгдөг. Агуулах нь энгийн эсвэл нөхцөл байдал шаардсаны дагуу нарийн байж болно. Агуулах нь боломжтой үйлчлэлүүдийн жагсаалт, дансан дахь мөнгө, агуулах дахь хүнс, барилга доторх эд хөрөнгө юм. Ядуучуудад анхаарал халамж тавих болон дэлхий дээр Бурханы хаант улсыг байгуулахын тулд итгэлтэй гишүүд цаг зав, авьяас чадвар, өрөвч сэтгэл, эд материал, мөнгөн хөрөнгөө бишопт өргөл болгосноор агуулах бий болдог.

“Иймээс Их Эзэний агуулах тойрог бүрд байдаг. Бишоп бол агуулахыг эрхэлдэг хүн мөн. Тэрээр Их Эзэний сүнсний нөлөөгөөр, Гэгээнтнүүдийн өргөлийг ядуучууд, гачигдалтай хүмүүст хуваарилдаг. Санваартны чуулгууд, Нийгмийн Халамжийн Бүлэг түүнд тусалдаг. Гадасны болон бүсийн удирдагчид” үүрэг хариуцлагынх нь талаар бишопт заавар өгч дэмжлэг үзүүлдэг (Ном 2: Санваартны болон Хавсралт Байгууллагуудын Удирдагчид [1998], 256).

- Бидний хүн нэг бүр манай тойрог дахь Их Эзэний агуулахад хэрхэн хувь нэмэр оруулж болох вэ?

2. “Дэлхийн зүйлүүдэд адил тэгш” (С ба Г 78:6)

Адил тэгш гэдэг үг материаллаг эд юмсын хувьд Сургаал ба Гэрээнд олон удаа хэрэглэгдсэн байдаг (С ба Г 51:3; 70:14; 78:6). Энэ нь бүх ажил үүрэг яг адилхан гэсэн хэрэг биш гэдгийг тайлбарла. Харин ажил үүргийг хүн бүр, гэр бүл бүрийн хэрэгцээнд тохируулан өгдөг байсныг тайлбарла (С ба Г 42:32; 51:3). Адил тэгш гэдэг нь бүх Гэгээнтнүүд хэрэгцээгээ хангахын тулд “өмч хөрөнгөнд адил тэгш” байх ёстой гэсэн утгатай юм (С ба Г 82:17).

“Та нар хамгийн шилдэг бэлгүүдийг хичээнгүйлэн эрэлхийл”

Зорилго

Сүнсний бэлгүүдийг таньж, олж авахыг эрэлхийлэх, тэрчлэн бусдад үйлчлэхэд эдгээр бэлгүүдийг ашиглахад ангийн гишүүдэд туслах.

Бэлтгэл

1. Дараах судрууд болон бусад материалыг залбирч судал:
 - а. Сургаал ба Гэрээ 46; Итгэлийн Тунхаг 1:7.
 - б. 1 Коринт 12-13; Моронай 10:8-18 (нэмэлт судрууд).
 - в. *Бидний Өв*, хуудас 49-50, 55-57, 72-76.
 2. *Ангийн гишүүний Судлах Удирдамж* (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.
 3. *Бидний Өвөөс* дараах хэсгүүдийг уншихад бэлтгэхийг ангийн гишүүдээс хүс:
 - а. Ньюел Найт Фило Дибблийг адисалсан нь (хуудас 49-50).
 - б. Аманда Смит шархдаж бэртсэн хүүгээ хэрхэн эдгээх тухай илчлэлт хүлээн авсан нь (хуудас 55-56).
 - в. Бошиглогч Иосеф Смит Дан Жөүнсний номлогчийн үйлчлэлийн тухай бошиглосон нь (хуудас 75).
-

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

Ангийн гишүүд цэцэрлэг тарьж байгаагаар өөрсдийгөө төсөөлөн бодохыг тэднээс хүс.

- Та нар цэцэрлэгтээ ямар үрийг тарих вэ?

Ангийн гишүүдэд бодох багахан хугацаа өгөөд, тэд цэцэрлэгтээ юутай байхыг хүсэхийг нь дүрслүүлэхээр хэдэн хүнийг урь. Ангийн гишүүдийн сонголтын ялгаанд анхаарал хандуул. Цэцэрлэг өөр өөр байж болох ч, бүгдээрээ гоё сайхан, ашигтай байх хэрэгтэйг хэл.

- Үр суулгасны дараа цэцэрлэг чинь сайн ургахын тулд та нар юу хийх хэрэгтэй вэ?

Ангийн гишүүдийг хариулсны дараа, энэ хичээл бол Сүнсний бэлгүүдийн тухай юм гэдгийг тайлбарла. Хүмүүс цэцэрлэгтээ өөр өөр ургамлууд тарьж болох ч, цэцэрлэг нь адилхан гоё сайхан, ашигтай байдаг. Үүнчлэн, Сүмийн гишүүд Сүнсний янз бүрийн бэлэг хүлээн авч болно. Харин эдгээр бүх бэлэг Бурханы хаант улсыг байгуулахад ашигтай юм. Бид үр болон

ургамлын нэгэн адил бүрэн хөгжиж, ашигтай байхын тулд сүнсний бэлгүүдийг тарьж, арчилж тордон, тэжээж байх ёстойг ангийн гишүүдэд сануул.

Ярилцах ба
хэрэгжүүлэх нь

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбиран сонгож ав. Судрын зарчмуудтай холбоотой туршлагыг хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Сүмийн итгэлтэй бүх гишүүд Сүнсний бэлгүүдийг хүлээн авч чадна

Сүнсний бэлгүүд бол сүнсний адислалууд буюу Ариун Сүнсээр дамжин өгөгддөг чадвар юм гэдгийг тайлбарла. Эдгээр бэлгүүд Их Урвалтын үед дэлхийгээс авагдсан ч, Бурхан энэ эрин үеийн эхний жилүүдэд бэлгүүдийг сэргээсэн юм. Эдгээр бэлгүүдийг хөгжүүлж, ашиглах нь биднийг адисалж, гэгээрүүлэн нэгтгэдэг.

Бидний Өвийн хэсгүүдийг уншихыг даалгавар авсан ангийн гишүүдээс хүс (“Бэлтгэл,” зүйл 3-ыг үз). Шастир бүрийг уншсаны дараа уг түүхэнд Сүнсний ямар бэлгүүд дүрслэгдсэнийг ярилц: Эдгээх итгэл Ньюэл Найтад байв (С ба Г 46:20); Фило Диббл, Алма Смит нар эдгээгдэх итгэлтэй байлаа (С ба Г 46:19); Аманда Смит илчлэлт хүлээн авчээ (Итгэлийн Тунхаг 1:7); Бошиглогч Иосеф Смитэд бошиглолын бэлэг байв (С ба Г 46:22); Дан Жөүнс заах бэлэг хүлээн авсан ажээ (Моронай 10:9-10).

- Их Эзэн сүнсний ямар бэлгүүдийг С ба Г 46-д өгүүлсэн бэ? (Дараах судруудыг ангийн гишүүдээр уншуулж, хэсэг тус бүрд дурдсан Сүнсний бэлгийг нэрлэ. Бэлгүүдийг самбар дээр нэгтгэн дүгнэ)
 - а. С ба Г 46:13. (“... Есүс Христ бол Бурханы Хүү бөгөөд дэлхийн нүглүүдийн төлөө цовдлогдсон тухай Ариун Сүнсээр өгөгдсөн мэдлэг.”)
 - б. С ба Г 46:14. (Аврагчийн тухай бусдын гэрчлэлд итгэх итгэл)
 - в. С ба Г 46:15. (“Үйлчлэлийн ялгаануудын тухай” мэдлэг) Энэ бэлэг бол “Сүмийг удирдан, зохион байгуулахад ашиглагддаг” бэлэг юм гэж Арванхоёрын Чуулгын Ахлагч Брус Р.МкКонки хэлжээ (*A New Witness for the Articles of Faith* [1985], 278).
 - г. С ба Г 46:16. (“Үйл ажиллагааны олон янз байдлыг эдгээр нь Бурханаас байна уу?” гэдгийг мэдэх мэдлэг. Аль нэг заалт буюу нөлөө нь Бурханаас уу? эсвэл өөр эх сурвалжаас уу? гэдгийг ялган танихад энэ бэлэг бидэнд тусалдаг)
 - д. С ба Г 46:17-18. (Мэргэн ухаан ба мэдлэг)
 - е. С ба Г 46:19. (Эдгэрэх итгэл)
 - ё. С ба Г 46:20. (Эдгээх итгэл)
 - ж. С ба Г 46:21. (Гайхамшгууд үйлдэгдэх нь)
 - з. С ба Г 46:22. (Бошиглол)
 - и. С ба Г 46:23. (Сүнснүүдийг ялган таних нь)
 - й. С ба Г 46:24. (Хэлнүүдээр ярих нь)
 - к. С ба Г 46:25. (Хэлнүүдийг хөрвүүлэх нь)

Сүнсний бэлгүүдийг 1 Коринт 12:4-12; 13:1-13; Моронай 10:8-18-д бас тодорхойлсон байдгийг та хэлэхийг хүсч болно.

- Сүнсний бэлгүүдийг хэн хүлээн авч чадах вэ? (С ба Г 46:8, 11-ийг үз. Ариун Сүнсний бэлэг хүлээн авсан Сүмийн итгэлтэй гишүүн бүрд эдгээр бэлгүүдийн нэгийг Бурхан өгдгийг хэл. Хэрэв та залуучуудад заадаг бол Сүнсний бэлэг тэдэнд байдгийг онцлон тэмдэглэ. Ариун Сүнсний бэлэг хүлээн аваагүй хүмүүс ч гэсэн бусдыг өргөж, бэхжүүлэх өвөрмөц чадвараар адислагдсан байж болно гэдгийг та хэлэхийг хүсч болно)

2. Бурхан хүүхдүүдийнхээ ашиг тусын төлөө Сүнсний бэлгүүдийг өгдөг

- С ба Г 46-д илчлэгдсэнээр Сүнсний бэлгийн зорилго юу вэ? (Гишүүдийн хариултыг ярилцах буюу дээр нь нэмэхийн тулд дараах мэдээллийг ашигла. Ярилцсан зүйлийнхээ тоймыг самбар дээр бич)

Бидний хүн нэг бүрийг бэхжүүлж, адислахын тулд

- С ба Г 46:9-ийг ангийн гишүүдтэй хамт унш. Сүнсний бэлэг ямар арга замаар бидэнд нэг бүрчлэн тусалж чаддаг вэ? Ямар бэлэг та нарын хувьд онцгой үнэ цэнэтэй байдаг вэ? (Сүнсний бэлэг ангийн гишүүдийг бэхжүүлж, адисалсан туршлагыг нь хуваалцахад та тэднийг урьж болно)

Сүнсний бэлэг “биднийг Бурхан руу удирдаж болно. Сүнсний бэлэг биднийг дайсны хүчнээс хамгаалж чадна. Сүнсний бэлэг бидний дутагдлыг арилгаж, бидний төгс бусыг засч залруулж чадна” гэж Арванхоёрын Чуулгын Ахлагч Даллин Х.Өүкс хэлжээ (“Сүнсний Бэлэг,” *Ensign*, 1986 оны 9-р сар, 72).

Бусдад үйлчлэхэд бидэнд туслахын тулд

С ба Г 46:11-12, 26-г ангийн гишүүдтэй хамт унш. Тэгээд дараах мэдэгдлийг хуваалц:

Бүх хүмүүс зохих ёсоор зааварлагдаж, батлагдан, төгөлдөржиж, аврагдахын тулд Сүнсний бэлэг Сүмийн гишүүдийн итгэл бишрэл, нөхцөл байдал, төрөлхийн чадвар, үүрэг хариуцлага, дуудлагын дагуу тэдний дунд хуваарилагддаг” гэж Арванхоёрын Чуулгын Ахлагч Оорсон Пратт хэлжээ (*Masterful Discourses and Writings of Orson Pratt*, Н.Б.Лундволл [1953], 571).

- Сүнсний аль нэг бэлэг бусдад үйлчлэхэд тань хэрхэн тусалсан бэ? Бусдын сүнсний бэлгээр дамжуулан та нар хэрхэн адислагдсан бэ?

Энэ ярилцлагын нэг хэсэг болгон та дараах түүхийг хуваалцаж болно:

“Бид Христийн Мэндэлсний баярын зоогт бэлтгээд завгүй байсан үед арваад настай байсан эмэгтэй дүү минь сэтгэл догдлон, шүүгээнд байсан мөнгөн хүрээтэй шаазан тавагнуудад хүрлээ. Ээж, аав хоёрт маань өгсөн эмээгийн хуримын бэлэг . . . энэ сайхан иж бүрдэл тавагнуудыг зөвхөн онцгой үйл явдлаар л хэрэглэдэг байлаа. Гэвч үнэ цэнэтэй тавгуудыг дүү маань шүүгээнээс гаргахдаа нэг тавгийг гараасаа алдаж, барьж авах гэсэн нь талаар болж, таваг унаж хагаран шалан дээрх хэлтэрхийнүүдийг дэмий л цуглуулах гэж оролдон, айсан хөөрхийлөлтэй харц нүдэнд нь илэрч байлаа.

“Хоол хийж байсан ээжийн гар тэр чигээрээ хөших шиг болж, гэрийнхний маань баярын хөхүүн яриа хөөрөө тэр дороо зогсож, бид бүгдээрээ айдас төрүүлэм таг дуугүй болов. Ээж хагарсан таваг руу эргэж ч харсангүй, өрөөнөөс сэмхэн гарч явлаа. Тэгэхэд нь . . . үлдсэн бид түр завсарласан баярын ажил үүрэгтээ дахин оров.

“Эмэгтэй дүүгээс маань бусад нь л тэр шүү дээ. Дүү маань хөдлөх ч үгүй зогсож, томоо гэгчийн нулимс хацрыг нь даган урсаж эхлэх нь тэр. Дахиад нэг нулимс доош унахад дүү минь зөнгөөрөө шүүр, хогийн тосгуур хоёр шүүрч аваад хагарсан хэлтэрхийнүүдийг шүүрдэн авч эхлэв. Тэгээд тэр том хагархайнуудыг авч, хогийн тосгуур дээр болгоомжтойгоор тавилаа.

“Хэдэн мөчийн дараа ээж гал тогооны өрөөнд эргэж ирээд, уй гашуу болон зогсож байсан охиноо тэврэн авав. Дүү маань чангаар эхэр татан уйлж гарлаа. . . ‘За яах вэ, охин минь, эд юмнаас хүмүүс илүү чухал шүү дээ’ гэж ээж түүнийг чимээгүйхэн тайвшруулж байлаа.

“Ээж залбирч, дүүг яаж тайтгаруулах талаар амар амгалангийн мэдрэмж, сүнсний нөлөөгөөр адислагдахын тулд өөр өрөөнд орсноо хожим нь надад ярьж билээ. Христийн Мэндэлсний баярын тэр өдөр ээжид өгөгдсөн сүнсний тэр бэлэг манай гэр бүлийн хувьд үнэлж баршгүй эрхэм үнэтэй бэлэг болж билээ.” Лоора Рассел Банкер, “The Art of Perspective,” *Ensign*, 1998 оны 12-р сар, 54-55).

Дараах нөхцөлүүдэд Сүнсний ямар бэлэг ашигтай байж болохыг ярилцахыг та хүсч болох юм. С ба Г 46:13-25-д ангийн гишүүдийг дахин хандуул.

- а. Гэрийн багш хариуцдаг гэр бүлүүдийнхээ нэгэнд нь санваарын адислал өгөхөөр дуудагджээ.
- б. Сүмийн гишүүдийн жижиг салбарыг номлогч тэргүүлдэг байж.
- в. Нэг залуу эмэгтэй ангидаа хичээл заах даалгавар авчээ.
- г. Аароны санваартан нэг зөвлөх диконуудын нэг бүлгийг хариуцдаг бөгөөд шөнө хоноглох зугаалгын аялал нь хүндрэлтэй болжээ.
- д. Нийгмийн Халамжийн Бүлгийн Ерөнхийлөгч тойрог буюу салбарынхаа эгч нарт айлчлагч багш нарыг томилж байлаа.

Мэхлэгдэхээс зайлсхийхэд бидэнд туслахын тулд

- С ба Г 46:8-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Хилэнцэт нөлөө буюу заль мэхнээс зайлсхийхэд Сүнсний бэлэг бидэнд хэрхэн тусалж чадах вэ?

3. Бид Сүнсний бэлгийг эрэлхийлж, хөгжүүлэх ёстой

“Та нар шилдэг бэлгүүдийг хичээнгүйлэн эрэлхийл, юуны төлөө тэдгээр нь өгөгддөгийг ямагт сана” (С ба Г 46:8) хэмээн Их Эзэн бидэнд хэлсэн билээ.

- Бурхан бидэнд өгсөн сүнсний бэлгүүдийг мэдэхийн тулд бид юу хийж болох вэ? (бид тунгаан бодож, залбиран мацаг барьж, патриархын адислалаа уншин зарлигуудыг дуулгавартай дагаж, бусдад үйлчилж болох нь хариулт байж болно. Дараах эшлэлийг бас үз) Өөрсдөдөө өгөгдсөн сүнсний бэлгүүдийг тордож, хөгжүүлэхийн тулд бид юу хийж болох вэ?

Мэргэн ухаан болон эдгээхийн бэлэг нь хэрэг болох хүртлээ мэдэгддэггүй гэж Бошиглогч Иосеф Смит заажээ. “Эдгээр бэлгийг үйл ажиллагаа болгоход зохих цаг хугацаа, нөхцөл байдлыг шаарддаг” (*Teachings of the Prophet Joseph Smith*, эмхтгэсэн Жозеф Фиелдинг Смит [1976], 246).

- Бид Сүнсний бэлгийг эрэлхийлэхийн тулд юу хийж болох вэ? (Дараах судруудыг ангийн гишүүдээр уншуулж, Сүнсний бэлгийг эрэлхийлэх талаар энэ судрууд юу зааж байгааг тогтоо. Мэдээллийг самбар дээр нэгтгэн дүгнэ)
 - а. С ба Г 46:7, 30. (Бурханаас асууж, Сүнсний удирдамжийг дага; мөн Ерөнхийлөгч Жорж К.Канноны дараах мэдэгдлийг үз)
 - б. С ба Г 46:9. (Амин хувиа хичээсэн шалтгааны төлөө бус, харин бусдын ашиг тусын төлөө бэлгийг эрэлхийл)
 - в. С ба Г 46:31. (Бүх зүйлийг Есүсийн нэрээр үйлд)
 - г. С ба Г 46:32. (Бидэнд түүний өгсөн бэлгүүдийн төлөө Бурханд таларх)
 - д. С ба Г 46:33. (Ариун журам, цэвэр ариун явдлыг байнга мөрд)

Ерөнхийлөгч Жорж К.Каннон сургасан нь: “Хэрэв бидний хэн нэгэн нь цэвэр ариун биш бол өөрсдийгөө төгөлдөржүүлэх бэлгийн төлөө залбирах нь бидний үүрэг мөн. Надад төгс биш зүйлүүд байдаг уу? Тэр чинь надаар дүүрэн байдаг. Миний үүрэг юу билээ? Эдгээр төгс бус чанарыг залруулах бэлгийг надад өгөхийн төлөө Бурханд хандан залбирах. Хэрэв би ууртай хүн байлаа гэхэд, тэсвэр тэвчээртэй, нинжин сэтгэлтэй байхын төлөө, энэрэл хайрын төлөө залбирах нь миний үүрэг мөн. Би атаа жөтөөч хүн байвал яах вэ? Атаархаж жөтөөрхдөггүй байх, хайр энэрлийг эрж хайх нь миний үүрэг мөн. Иймээс энэ бүхэн нь Сайн мэдээний бэлгүүдтэй холбоотой. Сайн мэдээний бэлгүүдийн зорилго нь энэ юм. ‘Өө, энэ ч харин бардаггүй хэрэг ээ. Энэ бол миний заяамал зан авир’ гэж хүн хэлэх ёсгүй. Тэр хүн ингэж хэлснээрээ зөвтгөгддөггүй. Учир нь Бурхан эдгээр дутагдлуудыг засч залруулах хүч чадлыг бас дутагдлыг арилгах бэлгийг өгөхөөр амласан билээ” (*Millennial Star*, 23 4-р сарын 1894, 260).

Сүнсний бэлгийг эрэлхийлэх зарчмыг ээж нь хэрхэн хэрэгжүүлдэг байсан тухай Ахлагч Даллин Х.Өүкс тайлбарласан нь: “Ээж минь хань нөхрөө алдан бэлэвсэрч, хагацлын гунигийг амссан билээ. Өөдсийн чинээ гурван үрээ өсгөн өндийлгөж, гарыг нь ганзганд, хөлийг нь дөрөөнд хүргэх үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэхэд өөрт нь хэрэгтэй байсан зүйлийн төлөө тэр хэрхэн залбирдаг байсан гээч! Ээж минь эрэл хайгуул хийж байлаа, зохистой байлаа, чухам ингэснээрээ л адислагдсан юм! Ээжийн минь залбирал олон арга замаар, түүний дотор сүнсний бэлгүүдийг хүлээн авснаар хариулагдсан юм. Ээжид олон бэлэг байсан, харин миний ой тойнд тод томруунаар үлдсэн нь итгэл, гэрчлэл, мэргэн ухааны бэлэг нь юм. Ээж минь Сионы нэгэн хүчирхэг эмэгтэй байлаа” (*Ensign*, 1986 оны 9-р сар, 72).

Дүгнэлт

Сүнсний бэлгийг эрэлхийлэх, өөрсдөд нь өгөгдсөн бэлгийг бусдад үйлчлэхэд ашиглахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Сүнсээр өдөөгдсөний дагуу, хичээлийн үеэр ярилцсан үнэнүүдийн тухай гэрчлэлээ хэл.

Нэмэлт заах санаанууд

Та зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болгож дараах хоёр санаанаас нэгийг нь буюу хоёуланг нь ашиглаж болно.

1. Бусдад үйлчлэхийн тулд Сүнсний бэлгийг ашиглах нь

Хэрэв дараах зургууд байдаг бол бүгдийг нь эсвэл заримыг нь ангид авчир: Сүм дээр үг хэлж байгаа өсвөр насны охин (Сайн мэдээний Уран Зургийн

Цуглуулга 607); Бишоп (Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 611); Номлогчид Есүс Христийн Сайн мэдээг зааж байгаа нь (Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 612); Өвчтөнгүүдийг адисалж байгаа нь (Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 613); Гэрийн багшлалт (Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 614); Бие биедээ үйлчлэх нь (Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 615). Зургуудыг нэг нэгээр нь үзүүлж, зураг бүр дэх жишээ нь сүнсний бэлгийн хэрэгцээг хэрхэн харуулж байгааг тайлбарлахыг ангийн гишүүдээс хүс.

Үүрэг хариуцлагынхаа талаар бодож үзэхийг ангийн гишүүдээс хүс. Жишээ нь: Тэд эцэг эх, ах эгч нар, санваарын эсвэл туслах бүлгийн удирдагчид, гэрийн багш, айлчлагч багш нарын хувьд үүрэг хариуцлага авч үзэж болно. Тэгээд дараах асуултыг чимээгүйгээр тунгаан бодохыг тэднээс хүс: Бусдад илүү сайн үйлчлэх боломжтой байхын тулд сүнсний ямар бэлгүүдийг та нар эрэлхийлж болох вэ?

2. Сүнсний нэмэлт бэлгүүд

- “Сүнсний бэлэг нь тооны хувьд төгсгөлгүй, төрөл зүйлийн хувьд хязгааргүй юм. Илчлэгдсэн үгэнд жагсаасан тэдгээр бэлгүүд бол ердөө л өчүүхэн хэсэг нь юм” гэж Ахлагч Брус Р.МкКонки заажээ: (*A New Witness for the Итгэлийн Тунхаг*, 371). С ба Г 46-д жагсааснаас гадна сүнсний ямар бэлгүүд байж болох вэ?

“Төдийлөн анхаарал татдаггүй бэлгүүдэд асуухын бэлэг; сонсохын бэлэг; анхааран сонсож, дагахын бэлэг, намуухан, зөөлөн дуу хоолойг сонсохын бэлэг; . . . зөрчил сөргөлдөөнөөс зайлсхийхийн бэлэг; эв нийцтэй байхын бэлэг; . . . зөв шударга зүйлийг эрэлхийлэхийн бэлэг; бусдыг шүүхгүй байхын бэлэг; Бурханаас удирдамж эрэлхийлэх бэлэг; сахилгатай байх бэлэг; бусдад анхаарал халамж тавих бэлэг; тунгаан бодох чадвартай байх бэлэг; залбирал хэлэх бэлэг; хүчирхэг гэрчлэл хэлэх бэлэг; Ариун Сүнс хүлээн авах бэлэг” багтдаг гэж Арванхоёрын Чуулгын Ахлагч Марвин Ж.Аштон хэлжээ (In Conference Report, 1987 оны аравдугаар сар, 23; *Ensign*, 1987 оны арваннэгдүгээр сар, 20).

3. Сүнсний жинхэнэ бэлгийг танин мэдэх нь

Сүнсний бэлгийг хуурамчаар дуурайж, хүмүүсийг мэхэлж болно гэдгийг тайлбарла. Сүмийн гишүүдийн доторх бэлгүүдийн зарим хуурамч илэрхийлэлтийн талаар Бошиглогч Иосеф Смит санаа нь зовниж, Их Эзэнээс асуунаар эдүгээ С ба Г 50-д цэдэглэгдсэн илчлэлтийг хүлээн авчээ.

Сүнсний үнэн болон хуурамч бэлгүүдийг ялган танихад нь ангийн гишүүдэд туслахын тулд та С ба Г 50:17-24-ийг нэгтгэн дүгнэж болно. Хэрэв бэлэг нь Бурханаас өгөгдсөн бол энэ нь гэгээрүүлэгч бөгөөд биднийг баяр баясалд хүргэнэ гэдгийг онцлон тэмдэглэ. Бурханаас өгөгдсөн бэлэг сайныг үйлдэх, Бурханыг хайрлаж, Түүнд үйлчлэх, Христэд итгэх итгэл рүү бидний хөтөлдөг. Хэрэв сүнсний илэрхийлэлт гэгээрүүлэхгүй байвал эсвэл энэ нь биднийг нүгэл үйлдэхэд хөтөлж байвал, сүнсний уг илэрхийлэлт Бурханаас биш байдаг. Мэхлэгдэхээс болон хилэнцэт нөлөөнөөс зайлсхийх сэдвийг хичээл 24-өөр илүү тодорхой ярилцах болно.

4. Сүнсээр заах нь

- Сайн мэдээг заах нь Сүнсний бэлэг юм гэдгийг тайлбарла (Моронай 10:9-10). Дараа нь С ба Г 42:13-14, 50:17-18-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Сүнсээр заах гэж юу гэсэн үг вэ? Сүнсээр заах нь яагаад чухал вэ? (2 Нифай 33:1; С ба Г 50:21-22; түүнчлэн дараах эшлэлийг унш)

Сүмийн Заавруудын Гарын Авлагд: “Хүн онцгой чухал үнэнүүдийг зааж болно, ангийн гишүүд ярилцлагад сонирхолтойгоор оролцож болно. Гэвч Сүнс байхгүй бол эдгээр зүйлүүд хүнд хүчтэй нөлөө үзүүлж чадахгүй” хэмээн заажээ (Ном 2: Санваартны болон Хавсралт байгууллагын Удирдагчид [1998], 300).

- Багш нар заахдаа Сүнсийг урихын тулд юу хийж болох вэ? (Энэ гарын авлагын хуудас viii-ыг үз.) Заалгуулж байгаа хүмүүс Сүнсийг урихын тулд юу хийж болох вэ?
- С ба Г 43:8, 88:122-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Эдгээр шүлгүүд манай ням гарагийн хичээлийн ангид хэрхэн холбогдох вэ? (Бие биендээ зааварлаж, гэгээрүүлэхийн ач холбогдлыг онцгойлон анхаар) Сүнсээр зааж, суралцах нь бие биенээ гэгээрүүлж, хамтдаа баяр баясал эдлэхэд бидэнд тусалдгийг та нар хэрхэн анзаарсан бэ?

5. “Уран үггүй хүн” видео танилцуулга

Хэрэв видео хуурцаг *Teachings from the Doctrine and Covenants and Church History* (53933) байдаг бол “Уран үггүй хүн” 6 минутын хэсгийг үзүүлэхэд анхаар. Хэрэв та үүнийг үзүүлэхээр шийдсэн бол хичээлийн хоёр дахь буюу гурав дахь хэсгийг үзүүл.

Энэ видео нь нэгэн даруухан багш сэргээгдсэн сайн мэдээнд хөрвөгдөхөд нь Бригам Янгд хэрхэн тусалсныг харуулдаг. Энэ видео нэгэн чуулган дээр Ерөнхийлөгч Янгийн хэлсэн үгнээс авсан хэсгээр эхэлдэг юм. Тэрээр хэлсэн үгэндээ: “Хүнийг итгүүлдэг юм юу вэ?” гэж асуужээ (in *Journal of Discourses*, 1:90). Видеог үзүүлэх үед дээрх асуултын хариуг эрж хайхад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Тэгээд дараах асуултуудыг асуу:

- Сайн мэдээний үнэнд хүмүүсийг юу итгүүлдэг вэ?
- Сайн мэдээг заахдаа Элеазер Миллерийн үлгэр жишээг дагахын тулд бид юу хийж болох вэ?

“Чи . . . миний ариун өдөр ариун ёслолуудаа өргөх ёстой”

Хичээл
16

Зорилго Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахих хүслийг нь бэхжүүлэхэд ангийн гишүүдэд туслах.

Бэлтгэл

1. Дараах судрууд болон бусад материалыг залбирч судал:
 - а. Сургаал ба Гэрээ 59 болон энэ хичээлийн бусад судар.
 - б. Судруудын Удирдамж, “Хүндэтгэлийн өдөр,” хуудас 224.
2. Ангийн гишүүний Судлах Удирдамж (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.
3. Гетсеманид залбирч байгаа Есүс зураг байдаг бол хичээлийн үеэр ашиглахаар бэлтгэ (62175; Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 227).

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

- Ариун сүмд ороход та нарт ямар санагддаг вэ? (Хэрэв ангийн гишүүд Ариун сүмд ороогүй бол тэдэнд ямар санагдаж болохыг асуу. Энэ ярилцлагын үед, Ариун сүм дэх уур амьсгалыг дэлхийн уур амьсгалтай харьцуулан жиш)
- С ба Г 109:13 ангийн гишүүдтэй хамт унш. Юу ариун сүмийг бусад газраас өөр болгодог вэ? (Их Эзэн ариун сүмийг ариусгасан юм. Энэ бол Түүний өргөө.)
- Эхлэл 2:1-3-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Энэ бол Их Эзэн Хүндэтгэлийн өдрийг бий болгосон тухай шастир юм гэдгийг тайлбарла. Уг шастирт өгүүлснээр Хүндэтгэлийн өдөр бусад өдрөөс юугаараа ялгаатай вэ? (Их Эзэн энэ өдрийг ариусгасан юм. Хүндэтгэлийн өдөр бол Түүний өдөр мөн.)

Энэ хичээл Хүндэтгэлийн өдрийн тухай заадгийг тайлбарла. Бид Ариун сүмд орохдоо мэдэрдэг тийм хүндэтгэлтэйгээр, олон арга замаар Хүндэтгэлийн өдөр бүрд “орж” болно гэдгийг онцлон тэмдэглэ. Их Эзэн Хүндэтгэлийн өдрийг ариусгасан бөгөөд Түүний өдрөөр Түүнд үйлчилж, шүтэн бишрэх нь бидний онцгой боломж юм гэдгийг бид санах ёстой.

Ярилцах ба хэрэгжүүлэх нь Энэ хичээл нэг хичээлээр заах боломжтойгоос илүү их материалыг агуулдаг. Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбиран сонгож ав.

1. Их Эзэн Хүндэтгэлийн өдрийг бий болгосон нь

Бурхан Бүтээлтийн үед Хүндэтгэлийн өдрийн загварыг бий болгосныг тайлбарла. Зургаан өдөр хөдөлмөрлөсний дараа, Тэрээр долоо дахь өдөр амарч, энэ өдрийг ариун өдөр болгон ариусгасан юм (Эхлэл 2:2-3). Бүр эрт үеэс эхлэн Тэрээр Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахихыг хүүхдүүддээ зарлиг болгожээ (Судруудын Удирдамж, “Хүндэтгэлийн өдөр,” х.224).

- Египетээс Гарсан нь 20:8-11, 31:13-17 ангийн гишүүдтэй хамт унш. Энэ зарлиг судруудад олон удаа давтагддагийг онцлон тэмдэглэ (Судруудын Удирдамж, “Хүндэтгэлийн өдөр” х.224-ийг үз). Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахих зарлиг яагаад амьдралын туршид ийм чухал байдаг гэж та нар боддог вэ?

Манай эрин үед Хүндэтгэлийн өдрийн ач холбогдлыг Их Эзэн дахин онцлон тэмдэглэсэн юм. Бид энэ өдөр Сүмд очиж, ариун ёслолоос хүртэн, ажил хөдөлмөрөөсөө амарч, Түүнд бүхнээ зориулах ёстойг Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Их Эзэн илчилсэн билээ (С ба Г 59:9-13).

2. Сүмийн ням гарагийн цуглаанууд дээр Бурханыг шүтэн бишрэхэд бүхнээ зориул

- “Миний ариун өдрөөр . . . чи залбирлын өргөөнд очих ёстой” (С ба Г 59:9) гэж Их Эзэн хэлсэн байдаг. Хүндэтгэлийн өдөр Бурханыг хамтдаа шүтэн бишрэх нь яагаад чухал гэж та нар боддог вэ? Ням гарагт Сүмийн цуглаануудад оролцох нь та нарт хэрхэн адислал болдог вэ?
- “Ариун ёслолын цуглаан бүр сүнслэг байдлын найр, ”сүнсний сэргэлтийн цаг“ байх ёстой” гэж Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлжээ (*Teachings of Gordon B. Hinckley* [1997], 563, 564). Үүнийг хэрэгжүүлэхэд бид хэрхэн тусалж чадах вэ? Бид ням гарагийн бусад цуглаануудад оролцсоноор сүнслэг байдлын хувьд хэрхэн илүү баялаг болж чадах вэ? (Шүтэн бишрэх санаа сэтгэлтэйгээр ирж байх, цагийг хатуу баримтлах, хичээл эхлэхээс өмнө хичээлийн хуваарьт материалыг судалсан байх, хичээлд идэвхтэй оролцох, анхааралтай сонсох, бусдыг бэхжүүлэхийг эрэлхийлж, үг хэлэгчид, багш нарыг шүүмжлэхгүй байх нь хариулт байж болно)

Сүмийн 12 дахь Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл хэлсэн нь: “Би зугаацаж цэнгэхээр эсвэл ганцаархнаа заавар авах гэж Хүндэтгэлийн өдрийн цуглаануудад очдоггүй. Бид Их Эзэнийг шүтэн бишрэхээр очдог. Энэ бол хувь хүний үүрэг хариуцлага юм. Индэр дээрээс юу ч хэллээ гэсэн, хэрэв хүн Их Эзэнийг сүнсээр болон үнэнээр шүтэн бишрэхийг хүсдэг бол цуглаанууддаа оролцсоноор, ариун ёслолоос хүртсэнээр, сайн мэдээний эрхэм сайхныг бясалган бодсоноор ийнхүү шүтэн биширдэг. Хэрэв та ням гарагийн үйлчлэлд очдоггүй бол шүтэн биширч чадахгүй. Хэн ч таны өмнөөс шүтэн бишрэхгүй” (“Sabbath—A Delight,” *Ensign*, 1978 оны 1-р сар, 4-5).

- Ням гарагийн цуглаануудад өөрсдийгөө бэлтгэхийн тулд бид юу хийж болох вэ? Ням гарагийн цуглаануудаас улам бүрэн дүүрэн ашиг тус олоход нь эцэг эхчүүд хүүхдүүддээ хэрхэн тусалж болох вэ? (Эдгээр асуултаудтай холбоотой туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урь)
- Ням гарагийн цуглаануудыг дуу хөгжим хэрхэн баяжуулж чадах вэ? (*Дууллууд*, хуудас ix-х-ийг үз.) Бид бүгд дууллуудыг дуулах нь яагаад чухал вэ? (С ба Г 25:12.) Дууллуудыг дуулснаар та нар хэрхэн адислагдсан бэ?

“Цугларалтын дуунуудыг дуулдаггүй манай удирдагчид, гишүүдийн тоо улам өссөөр байгаад” санаа нь зовдгоо Арванхоёрын Чуулгын Ахлагч Бойд К.Пакер илэрхийлээд, “Сионы тухай дуунуудыг бид дуулах ёстой. Эдгээр дуунууд бидний шүтлэг бишрэлийн зайлшгүй чухал хэсэг мөн” гэж зөвлөсөн байдаг (In Conference Report, 1991 оны аравдугаар сар, 29; *Ensign*, 1991 оны арваннэгдүгээр сар, 22).

- Ням гарагийн цуглаанууд дээрх цугларалтын залбиралд бид хэрхэн утга учиртайгаар оролцож чадах вэ?
- Сүмийн цуглаануудад хүндэтгэл яагаад чухал байдаг вэ?

“Сүнсний нарийн торгон харилцааг мэдрэхийн төлөө хүн чармайж байгаа үед” бид саад болохгүйн тулд шүтээний байранд хүндэтгэлтэй байх ёстой гэж Ахлагч Бойд К.Пакер хэлжээ. Энэхүү хүндэтгэл нь “ямар ч дуу чимээ гаргахгүй байна гэсэн хэрэг биш. Бид бяцхан хүүхдүүдэд, тэр ч байтугай хөлд орж байгаа жаахан хүүхэд дуу шуугиан хадаахад хүлээцтэй хандах ёстойг” тэр бас сануулжээ (In Conference Report, 1991 оны аравдугаар сар, 28; *Ensign*, 1991 оны арваннэгдүгээр сар, 22).

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли номлогч байхдаа өөрт нь тохиолдсон нэгэн ичмээр явдлын тухай өгүүлжээ:

“Бид цуглаануудаа . . . түрээсийн нэгэн танхимд хийдэг байлаа. Шал нь хатуу болохоор . . . сандлыг хөдөлгөх бүрд дуу чимээ гарна. Гэвч энэ нь бүр муу зүйл ч биш байлаа. Салбарын гишүүдийн яриа хөөрөө бүр дэндүү гээч.

“Бид нэг үйл явдлыг тохиолдуулан хаалга тогшиж явахдаа танилцсан нэг гэр бүлийг урьсан юм. Номлогчид бид тэдэнд баяр хүргэхээр тэсч ядан хүлээсээр хаалганы дэргэд зогсож байлаа. Гишүүд танхимд ихэвчлэн баяр баясгалантай, хөхүүн хөөртэй уур амьсгал дунд бие биетэйгээ чих дөжиртөл шуугилдан ярьдаг байлаа. Нөгөөх гэр бүл өрөөнд орж ирээд хэдэн сандлыг нааш цааш болгож, хэдэн хормын дотор өвдөг сөгдөн нүдээ анин, залбирав. Тэгээд тэд нөгөөх их чимээ шуугиан дунд хүндэтгэлтэйгээр суудлаа эзэллээ.

“Үнэнээ хэлэхэд, би ичсэн шүү. Шүтэн бишрэх үйлчлэл ямар байх ёстой вэ, тийм л газар ирсэн гэж тэр гэр бүл бодсон аж. Иймээс тэд биеэ тийм байдлаар авч явсан нь тэр.

“Цуглааны эцэст тэд чимээгүйхэн яваад өглөө. Харин дараагийн удаа биднийг уулзахад тэд харсан зүйлийнхээ талаар урам хугарснаа ярьж билээ. Би үүнийг хэзээ ч мартдаггүй” (*Teachings of Gordon B.Хинкли*, 557).

- Бид Сүмийн цуглаанууд дээр хүндэтгэлийг хэрхэн дээшлүүлж болох вэ?

3. Ариун ёслолоос хүртэх замаар Бурханд бүхнээ зориул

Гетсеманид залбирч байгаа Есүсийн зургийг үзүүл.

- Хүндэтгэлийн өдөр ариун ёслолоос хүртэхийг Их Эзэн бидэнд зарлиг болгосон юм (С ба Г 59:9, 12). Долоо хоног бүр ариун ёслолоос хүртэх нь яагаад чухал вэ? (С ба Г 59:9; 3 Нифай 18:6-7; мөн дараах эшлэлийг үз.)

Арванхоёрын Чуулгын Ахлагч Жозеф Б.Вөртлин: “Цонхыг угааж, тоос шоорооноос тогтмол цэвэрлэж байх ёстой. . . Дэлхийн цонхнуудад байнгын,

бүх талын цэвэрлэгээ хэрэгтэй байдаг шиг, бидний сүнсний цонхнуудад ч бас ийм байдаг. . . Бид баптисмын гэрээгээ шинэчлэхийн төлөө ариун ёслолоос зохистойгоор хүртсэнээр, амьдралын мөнхийн зорилго болон эн тэргүүнд баримтлах бурханлиг шинж чанарын талаарх үзэл баримтлалаа тодруулдаг. Ариун ёслолын залбирал нь өөртөө дүн шинжилгээ хийх, хувь хүний наманчлал, өөрийгөө шинээр зориулах болон бидний Аврагч, Христ болох Есүсийг дурсан санах хүслээ андгайлан тангараглахад хүнийг урьдаг билээ” гэж хэлжээ (In Conference Report, 1995 оны аравдугаар сар, 103; *Ensign*, 1995 оны арваннэгдүгээр сар, 77).

- Ариун ёслолоос хүртсэн нь амьдралд тань хэрхэн адислал болсон бэ?
- Ариун ёслолоос хүртэхийн тулд бид өөрсдийгөө хэрхэн бэлтгэж болох вэ? Энэ ёслолд бэлтгэхэд нь эцэг эхчүүд, хүүхдүүддээ хэрхэн тусалж болох вэ? (Янз бүрийн насны бүлгийн хүүхдүүдэд хэрхэн туслах тухай ярилцахыг та хүсч болох юм) Ариун ёслолын дууллыг дуулах нь бэлтгэхэд тань хэрхэн тусалдаг вэ? (С ба Г 20:77, 79-ийг үз.)
- Бид ариун ёслолоос хүртэхдээ яагаад зохистой байх ёстой вэ? (1 Коринт 11:28-29; 3 Нифай 18:29; Мормон 9:29-ийг үз.)
- Бид ариун ёслолоос хүртэхдээ оюун ухаан, зүрх сэтгэлээ Есүс дээр хэрхэн төвлөрүүлж болох вэ?
- Бид ариун ёслолыг амьдралдаа хэрхэн илүү утга учиртай болгож чадах вэ? (Энэ ёслол зүгээр л нэг улиг болсон, хэвшмэл зүйл болох ёсгүйг онцгойлон анхаар) Аврагчийн талаар хоёргүй чин хүсэл бодолтой байхыг хэрхэн бэхжүүлж болох вэ?
- Хүндэтгэлийн өдөр бид зөвхөн ариун ёслолоос хүртдэг төдийгүй, бас бид өөрсдийн ариун ёслол болон үүргүүдийг бас Их Эзэнд өргөх ёстой (С ба Г 59:9, 12). Энэ бол бид өөрсдийн өргөлүүд буюу золиослолуудыг хийж, бие сэтгэл бүхнээ Түүнд зориулдгаа харуулах ёстой гэсэн үг. Бид ямар золиослолуудыг өргөх ёстой вэ? (С ба Г 59:8; С ба Г 59:12-ын зүүвэр тайлбар 6-г үз; С ба Г 64:34; 97:8; мөн дараах эшлэлийг үз)

Арванхоёрын Чуулгын Ахлагч М.Рассел Баллард:

“Мөнх бус үйлчлэлийнхээ дараа, . . . Тэрээр цаашид шатаалт өргөлүүдийг хүлээж авахгүй болсноо, харин шавь нар нь ‘харууссан зүрх, гэмшсэн сэтгэлийг’ өргөл болгох ёстойг Нифайд Есүс хэлсэн юм (3 Нифай 9:19-20; мөн С ба Г 59:8, 12-ыг үз). Их Эзэн мал амьтад буюу үр тариа шаардахын оронд эдүгээ бүх бурханлиг бус зүйлийг хаяхыг биднээс хүсдэг. Золиослолын хуулийн энэхүү илүү дээд зуршил хүний дотоод сэтгэлд нэвтэрч байна. . .

“. . . Бид амин хувиа хичээсэн хүслээ даван туулсан үед, Бурханыг амьдралдаа нэгдүгээрт тавьсан үед, өртөг зардлыг харгалзахгүйгээр Түүнд үйлчлэхээр гэрээнд орсон үед, золиослолын хуулиар амьдарч байгаа нь тэр” хэмээн хэлжээ (“The Law of Sacrifice,” *Ensign*, 1998 оны аравдугаар сар, 10-11).

4. Ажил хөдөлмөрөөсөө амарч Бурханд бүхнээ зориул

- Хүндэтгэлийн өдөр бид “[хөдөлмөрүүдээсээ] амрах” ёстойг Их Эзэн С ба Г 59:10-т илчилжээ (мөн 13-ыг үз). Хөдөлмөрөөсөө амарна гэдэг нь юу гэсэн

үг вэ? Хөдөлмөрөөсөө амрах нь Бурханд бие сэтгэл бүхнээ зориулсан бидний чин сэтгэлийг хэрхэн харуулдаг вэ?

- Бид хөдөлмөрөөсөө амрахын нэг хэсэг болгон юм худалдаж авах, худалдах, үзвэрийн газруудаар явах, дэлхийн бусад ашиг сонирхлуудаас Хүндэтгэлийн өдөр татгалзах ёстой (Исаиа 58:13-ыг үз, “өөрийн таашаалыг үйлдэхээс. . . татгалзах,” “өөрийн замаар явалгүй” гэсэн нийлэмж үгсийг ажигла). Ямар үйл ажиллагаанууд таныг Хүндэтгэлийн өдрийн сүнснээс холдуулан хөндийрүүлдэг вэ? Хүндэтгэлийн өдөрт саад учруулж болох дэлхийн ямар ашиг сонирхол байдаг вэ? Бид эдгээр ашиг сонирхлуудаас өөрсдийгөө хэрхэн ангид байлгаж чадах вэ?

Тэргүүлэх Бишоп Х.Давид Бөөртөн хэлсэн нь: “Одоо үед, ням гарагт тогтмол хуваариар явагддаг тоглолтуудад оролцохыг ихэд хүсдэг спортын багууд Хүндэтгэлийн өдрийг сахихаар сонгох нь, ялангуяа манай залуу хүмүүсийн хувьд хэцүү байдгийг би мэднэ. Хүндэтгэлийн өдөр дэлгүүрээс ганц нэгхэн юм худалдаж авах хэрэгтэй олон хүнд энэ нь ердийн зүйл шиг санагддагийг би бас мэднэ. Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахихыг сануулах Сүнсний шивнээг хүлээн авагчид байхаар бэлтгэх нь бидний сахих хамгийн чухал нэг зарлиг мөн гэдгийг би мэднэ” (In Conference Report, 1998 оны аравдугаар сар, 9; *Ensign*, 1998 оны арваннэгдүгээр сар, 9).

- Хөдөлмөрөөсөө амрах гэдэг нь бид юу ч хийхгүй зүгээр байна гэсэн үг биш. Харин ч бид Аврагчийн үлгэр жишээг дагах ёстой. Бид “Хүндэтгэлийн өдөр сайныг үйлдэх” ёстой (Матай 12:12; мөн Лук 13:10-17; Иохан 5:1-19-ийг үз). Хүндэтгэлийн өдөр ямар үйл ажиллагаа явуулах нь сайн гэж та нар боддог вэ? (Хариултуудыг самбар дээр жагсаа) Хүндэтгэлийн өдөр бид хувь хүнийхээ шүтэн бишрэх цагийг хэрхэн нэмэгдүүлж болох вэ?

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл сургахдаа: “Хүндэтгэлийн өдөр бол зохистой, ариун зүйлсийг хийх ариун өдөр юм. Ажлаас татгалзаж, амралтыг эрхэмлэх нь чухал ч, энэ нь хангалтгүй юм. Хүндэтгэлийн өдөр бүтээлч санаа бодол, үйл ажиллагаанд уриалан дууддаг. Харин Хүндэтгэлийн өдөр юу ч хийлгүй зөвхөн амардаг хүн энэ өдрийг зөрчиж байгаа хэрэг. Хүндэтгэлийн өдрийг сахихын тулд хүн залбиралд өвдөг сөгдөн, хичээлдээ бэлтгэж, сайн мэдээг судлан, бясалгаж, өвчтэй болон зовж шаналсан хүмүүстэй очиж уулзан, бага унтаж, эрүүл саруул материал уншин, тэр өдөр оролцох ёстой бүх цуглаанд оролцох хэрэгтэй” гэжээ (*Ensign*, 1978 оны нэгдүгээр сар, 4).

- Бид Хүндэтгэлийн өдөр юу хийх нь тохиромжтойг хэрхэн тодорхойлж болох вэ? (Бурханд хүндэтгэл үзүүлэх бидний үйл ажиллагаанууд сүнслэг байдлын хувьд өргөх, итгэлийг тэтгэн, гэр бүлийг бэхжүүлэх, бусдад туслах буюу тэднийг адисална гэдэг нь тодорхой юм. Энэ өдөр дэлхийн өдөр тутмын үйл ажиллагаануудаас ялгаатай байх ёстой гэдэг нь хариулт байж болно.)
- Бид Хүндэтгэлийн өдрөөр гэр бүлүүдийг ямар хэлбэрээр бэхжүүлж болох вэ? Хүндэтгэлийн өдрийг баясан таалж, ариунаар сахихад эцэг эхчүүд, хүүхдүүдээ хэрхэн тусалж болох вэ? (Дараах эшлэлүүдийг үз. Эдгээр асуултуудад холбогдох хувийн туршлагаа хуваалцахад ангийн гишүүдийг урь. Хүндэтгэлийн өдрийг гэр бүлийнхээ хувьд илүү утга учиртай болгох нэг өвөрмөц арга хэлбэрийг сонгож авах зорилтыг ангийн гишүүдээр тавиул.)

“Хожмын үеийн Гэгээнтнүүд гэр орондоо байж, гэрийнхэндээ заан, судруудыг уншиж, эрүүл саруул, сайн сайхан юмсыг хийж, Хүндэтгэлийн өдөр Их Эзэнтэй харилцаатай байг” гэж Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлжээ (“Excerpts from Recent Addresses of President Gordon B. Hinckley,” *Ensign*, 1996 оны долдугаар сар, 73).

“Эдүгээ би хоосон уриалахыг хүсэхгүй байна. Хүүхдүүдээ гэртээ түгжиж, өдөржингөө Библийг тэдэнд уншиж өгөх хэрэгтэй гэж би та нараас хүсээгүй байна. Ухаалаг бай. Анхаарал соргог байцгаа. Харин та нар тэр өдрийг гэр бүлтэйгээ хамт сууж, ариун нандин хийгээд сайн сайхан зүйлсийн тухай ярилцдаг өдөр болгоцгоо” (*Teachings of Gordon B. Hinckley*, 559-560).

Тэргүүн Зөвлөл 1980 онд Ням гарагийн цуглааны тогтсон хуваарийг зарлахдаа дараах зөвлөгөөг өгсөн юм:

“Хүндэтгэлийн өдрийг зохих ёсоор сахихад гишүүд болон гэр бүлүүдэд агуу үүрэг хариуцлага ногддог. Судруудыг хувиараа судлах, сайн мэрдээг гэр бүл дээр төвлөрүүлэн судлахад илүү их цаг хугацаа олдоно. . .

“Цуглаан, үйл ажиллагаануудын энэ шинэ хуваарь Сүмийн гишүүдийн сүнслэг байдлын өсөлтөд үлэмж ихээр нөлөөлөх болно гэдгийг хүсэн хүлээж байна” хэмээн Ерөнхийлөгч Хинкли зөвлөсөн байдаг (*Church News*, 1980 оны хоёрдугаар сарын 2, 3).

- Хүндэтгэлийн өдөр бол залбирлын өдөр байх ёстой (С ба Г 59:14). Ямар арга замаар бид энэ өдөр илүү их залбиралтай байж чадах вэ? Бид залбирлаа хэрхэн улам бүр утга учиртай байлгаж чадах вэ?
- Хүндэтгэлийн өдрийг өөрийн чинь хүссэнээр утга учиртай болгоход ямар сорилт бэрхшээл тохиолддог вэ? Эдгээр сорилт бэрхшээлийг даван туулахын тулд та яаж ажиллаж байна вэ? Эдгээр сорилт бэрхшээлүүдийг арилгах буюу зохицуулахад нягт нямбай төлөвлөлт та нарт хэрхэн тусалж чадах вэ?

5. Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахидаг хүмүүсийг Их Эзэн адисалдаг

- С ба Г 59:9, 13, 15-17-г ангийн гишүүдтэй хамт унш. Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахидаг хүмүүст Их Эзэн ямар адислалууд амладаг вэ? (Хариултуудыг самбар дээр жагсаа)
- Хүндэтгэлийн өдрийг сахих нь “дэлхийгээс толботохгүй” байхад (С ба Г 59:9; наманчлах, баптисмын гэрээнүүдээ шинэчлэх, дэлхийн зүйлүүд дээр биш, харин Бурхан болон мөнхийн ач холбогдол бүхий асуудлууд дээр санаа бодлоо төвлөрүүлэхэд бидэнд тусалдаг гэдэг нь хариултуудад багтаж болно) бидэнд хэрхэн тусалдаг вэ?
- С ба Г 59:13-т Их Эзэн амласанчлан, Хүндэтгэлийн өдрийг сахих нь бүрэн баяр баяслыг хүлээж авахад бидэнд хэрхэн тусалдаг вэ? Хүндэтгэлийн өдрийг зохих ёсоор сахих нь бие бялдрын хувьд бас сүнслэг байдлын хувьд бэхэжсэнээ мэдрэхэд та нарт хэрхэн тусалсан бэ? Энэ нь долоо хоногийн бусад өдөр илүү үр бүтээлтэй байхад та нарт хэрхэн тусалдаг вэ?
- Хүндэтгэлийн өдрийг сахидаг хүмүүс “дэлхийн бүрэн байдал”, “дэлхийн. . . сайн зүйлүүдийг” (С ба Г 59:16-17; мөн Исаиа 58:14-ийг үз) хүлээн авах болно хэмээн Их Эзэн амласан билээ. Энэ амлалт биелэгдсэнийг та нар хэрхэн харсан бэ?

- Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахисан үед та нар өөрсдөө бас гэр бүл тань ямар арга замаар адислагдсан бэ?
- Хүндэтгэлийн өдөр “баяр баяслын” (С ба Г 59:14) өдөр байх ёстойг Их Эзэн илчилсэн юм. Бид “Амралтын өдрийг баясгалант хэмээн нэрлэх” (Исаиа 58:13) ёстой гэж Исаиа хэлсэн байдаг. Хүндэтгэлийн өдөр та нарын хувьд баяр баяслын гэхээсээ илүүгээр хязгаарлалтын өдөртэй илүү адилхан юм шиг санагдаж байсан уу? Бид Хүндэтгэлийн өдрийг амьдралдаа хэрхэн баяр баяслын болон “баясгалант” өдөр болгож чадах вэ? (Бид юу хийх ёсгүй вэ гэдгээс илүүгээр юу хийх ёстой вэ гэдэгт анхаарал төвлөрүүлэх нь нэг арга зам мөн)

Дүгнэлт

Хүндэтгэлийн өдрийг сахидгаа хэрхэн дээшлүүлж болохыг нягталж үзэхэд нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Тэд энэ ариун өдрийг сахих юм бол Их Эзэн тэднийг сүнсний илүү их хүч чадал, баяр баяспаар адисална гэдгийг гэрчил.

Нэмэлт заах санаанууд

Та зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болгож дараах санаануудаас нэгийг буюу хоёрыг ашиглаж болно.

1. Ням гарагт ажилладаг хүмүүст туслах зөвлөмж

Ням гарагт ажиллахыг шаарддаггүй ажил эрхлэлтийг сонгоход Сүмийн гишүүд бүх талаар чармайлт гаргах ёстойг тайлбарла. Гэвч ажил олгогчид ням гарагт ажиллахыг шаардах үе байж болно. Өөрт нь эсвэл гэр бүлийнх нь аль нэг гишүүнд ийм үе тохиолдож байсан эсэхийг нь ангийн гишүүдээс асуу. Ийм нөхцөлд Хүндэтгэлийн өдрийн уур амьсгалыг хэрхэн боломжийнхоо хэрээр сахих тухай ярилц. Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахих хүслийнхээ тухай ажил олгогчдоо хэлэхийг ангийн гишүүдэд зөвлөмж болго. (Хэрэв та залуучуудад заадаг бол *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө*, хуудас 32-33 [36550]-ыг үз.)

2. Бид Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахисан үед Их Эзэн биднийг хамтад нь адисалдаг

Бид хувиараа Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахисан үед ирдэг адислалаас гадна, Их Эзэн биднийг бас хамтад нь адисалдаг. Жишээ нь: Тэрээр биднийг Сүмийн хувьд эсвэл хамт олны хувьд адисалж болно. Энэ нь Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахихад бид нэгдмэл байх хэрэгтэйг онцгойлон анхаардаг.

- Судруудын Удирдамжийн хуудас 224 дээрх “Хүндэтгэлийн өдөр”-ийн сүүлчийн (гурав дахь) догол мөрийг бүхлээр нь уншихыг ангийн нэг гишүүнээс хүс. Хүндэтгэлийн өдрийг сахихад хайхрамжгүй байх нь юунд хүргэдэг вэ? Танай хамт олон Хүндэтгэлийн өдрөөс үүдэлтэй адислалуудаас хэрхэн ашиг тус хүртсэн бэ? Эсвэл эдгээр адислалуудыг авч чадаагүй юу?

Зорилго Аравны нэгээ бүрэн төлөх болон мацгийн хуулиар амьдрах хүслээ бэхжүүлэхэд нь ангийн гишүүдэд туслах.

Бэлтгэл

1. Дараах судруудыг залбирч судал:
 - а. Сургаал ба Гэрээ 59:13-14, 21; 119; 120.
 - б. Исаиа 58:6-12; Малахи 3:8-12; 3 Нифай 24:8-12; Матай 6:16-18; 3 Нифай 13:16-18 (нэмэлт судрууд).
2. Ангийн гишүүний Судлах Удирдамж (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.
3. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах бол, нэг мөнгөн дэвсгэртийг хичээл дээр авчир.

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

Авчирсан мөнгөн дэвсгэртээ үзүүл.

- Энэ мөнгө юуг төлөөлж болох вэ?

Товч хариулт өгөх боломжийг ангийн гишүүдэд олго. Хэрхэн ашиглахаас хамааран, мөнгө нь маш олон төрлийн юмс, санаа бодлыг төлөөлж болно гэдгийг хэл. Жишээ нь: Мөнгө нь материаллаг эд хөрөнгө, эрх мэдэл, хүч, шунал, амьдралын энгийн хэрэгцээт юмсыг төлөөлж чадна.

Энэ ярилцлагыг нэгтгэн дүгнэхийн тулд, хэрэв тодорхой арга замаар ашиглах юм бол, мөнгө цөөхөн тоотой байсан ч, Бурханы хаант улсыг байгуулахад туслах бидний хүслийг төлөөлж чадна. Мөнгө бас бусдын төлөө тавих бидний анхаарал халамжийг төлөөлж чадна. Мөнгө нь бидний итгэл, дуулгавартай байдал, Их Эзэнийг хайрлах хайрыг төлөөлж чадна. Бид аравны нэг болон мацгийн өргөлүүдийг төлснөөр хаант улсыг байгуулж, бусдад үйлчилж чадахыг энэ хичээлээр ярилцана гэдгийг тайлбарла.

Ярилцах ба хэрэгжүүлэх нь

Энэ хичээл нэг хичээлээр заах боломжтойгоос илүү их материалыг агуулдаг. Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох судрын хэсэг, асуултууд, түүнчлэн энэ хичээлийн бусад материалыг залбирч, сонго.

1. Аравны нэгийг төлж байхыг Их Эзэн бидэнд зарлиг болгосон билээ. Тэрээр энэ зарлигийг дуулгавартай дагадаг хүмүүст агуу адислалуудыг амласан юм.

Аравны нэгийн талаарх Их Эзэний тодорхойлолт

- Бошиглогч Иосеф Смит аравны нэгийн талаарх илчлэлтийг 1838 оны долдугаар сарын 8-нд Миссурин Фар Вестэд хүлээн авчээ. С ба Г 119:3-4-ийг ангийн гишүүдтэй хамт унш. Эдгээр шүлгүүдэд илчлэгдсэн аравны нэгийн талаарх Их Эзэний тодорхойлолт юу вэ?

Бүрэн аравны нэг гэж юу болохыг ойлгоход нь ангийн гишүүдэд туслахын тулд дараах тодорхойлолтуудыг хуваалц:

Аравны нэгийн дараах тодорхойлолтыг Тэргүүн Зөвлөл өгчээ: “Бидний мэддэг хамгийн энгийн тодорхойлолт бол, Сүмийн гишүүд орлого хэмээн ойлгогддог, ‘жил тутмын бүх ашгийнхаа аравны нэгийг’ төлөх ёстой гэсэн Их Эзэний өөрийнх нь тодорхойлолт юм. Үүнээс өөр ямар ч тодорхойлолт зөв биш” (Тэргүүн Зөвлөлийн захидал, 1970 оны 3-р сар).

Арванхоёрын Чуулгын Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит: “Аравны нэгийг юу бүрдүүлдэг тухай хичнээн олон тайлбар, учир үндэслэл байж болдог нь гайхмаар юм. . . . Гэвч, бид үүнийг хэмжих үед энэ нь бидэнд зориулагдан дахин хэмжигдэнэ. Хэрэв бид Их Эзэнээс харамлах юм бол, тэр биднээс харамлаж болно, өөрөөр хэлбэл, адислалуудаа татан авдаг” гэж тайлбарласан байдаг (*Church History and Modern Revelation*, 2 боть, [1953], 2:92).

Аравны нэгийг төлөгчдөд Их Эзэний өгсөн амлалтууд

- Малахи 3:8-9, эсвэл 3 Нифай 24:8-9-ийг ангийн гишүүдтэй хамт унш. Хэрэв бид аравны нэг буюу өргөлүүдийг төлөхгүй бол ямар байдлаар “Бурханыг дээрэмддэг” вэ? (Энэ асуултыг ярилцах үед та С ба Г 59:21, 104:14-ийг ангийн гишүүдээр уншуулж болно)
- Малахи 3:10-12, эсвэл 3 Нифай 24:10-12-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Аравны нэгийг төлдөг хүмүүст Их Эзэн ямар амлалт хийсэн бэ? (Ангийн гишүүдийн хариултуудыг самбар дээр жагсаа)

Арванхоёрын Чуулгын Ахлагч Жон А.Видцөү аравны нэгийг төлөхөд бидэнд ирдэг адислалын тухай өгүүлэхдээ:

“Аравны нэгийг төлөгч нь Их Эзэнтэй харилцах харилцааг бий болгодог. Энэ бол хамгийн сайхан шагнал юм. Бусад аливаа хуулийн адил аравны нэгийн хуулинд дуулгавартай байх нь дотоод сэтгэлийн гүнзгий баяр баясал, сэтгэл ханамж, өөр ямар ч арга замаар олж чадахгүй ойлголтыг авчирдаг. Хүн хэдийчинээ даруухан байвал, хүмүүний авралын төлөө бий болгосон үлэмж өргөн цар хүрээтэй, мөнхийн хөтөлбөрт Их Эзэний үнэнхүү хамтрагч нь болдог. Үнэний зарчмуудыг бүх талаас нь ойлгосноор улам тод томруун болдог. Ингэсэн тохиолдолд үнэний зарчмуудаар амьдрахыг хэрэгжүүлэхэд амар хялбар байдаг. Хүмүүн болон түүнийг Бүтээгчийн хооронд шинэ ойр дотно харилцаа бий болдог. Залбирал илүү амар хялбар болно. Эргэлзээ арилж үгүй болно; итгэл хөгжинө. Тодорхой байдал, зориг хүнийг хөхүүн баяртай болгоно. Сүнсний мэдрэмж хурц болно; мөнхийн дуу хоолой улам тод сонсогдоно. Хүн Тэнгэр дэх Эцэгтэйгээ улам адилхан болно” гэжээ (in *Deseret News*, 1936 оны 5-р сарын 16, Church Section, 5).

Бид аравны нэгийг төлсөн үед материаллаг адислалуудыг хэрхэн хүлээн авч чадахыг Арванхоёрын Чуулгын Ахлагч Даллин Х.Өүксийн ярьсан дараах түүх дүрсэлдэг:

“Дэлхийн II дайны үед, бэлэвсэрсэн ээж минь бага насны гурван хүүхдээ тэжээхэд сургуулийн багшийн цалин нь хүрэхтэй үгүйтэй байлаа. Бидэнд хангалттай мөнгө байгаагүй болохоор, хүслэн бослон зарим юмсыг авч чаддаггүй байсан. Яагаад цалингаасаа өдий ихийг аравны нэгд төлдөг байсныг нь нэг удаа ээжээсээ асууж билээ. ‘Даллин, аравны нэгийг төлөхгүй яваад байж чаддаг зарим хүмүүс байж болох юм. Гэвч бид ингэж чадахгүй. Их Эзэн аавыг чинь аваачиж, харин хүүхдүүд та нарыг өсгөн хүмүүжүүлэг гэж намайг үлдээхээр сонгосон юм. Би Их Эзэний адислалгүйгээр байж чадахгүй. Би эдгээр адислалыг аравны нэгийг шударгаар төлснөөрөө олж авдаг юм. Би аравны нэгээ төлсөн үед Их Эзэн биднийг адислах болно. Хэрэв бид ийм замаар явах юм бол адислалууд бидэнд байх болно гэсэн Их Эзэний амлалт надад байдаг” гэж ээжийнхээ тайлбарласныг би хэзээ ч мартдаггүй (In Conference Report, 1994 оны 4-р сар, 43-44; *Ensign*, 1994 оны 5-р сар, 33).

- Та нар аравны нэгийн хуулиар амьдарснаар хэрхэн адислагдсан бэ? (Сүнслэг байдлын хувьд, материаллаг аж байдлын хувьд хэрхэн адислагдсанаа ярихад ангийн гишүүдийг урь)

Аравны нэгийг төлдөг шалтгаан

Зөвхөн бидэнд адислал хэрэгтэй учраас төдийгүй бид Их Эзэнийг хайрладаг учраас, Түүнд итгэдэг учраас аравны нэгийг төлөх ёстой гэдгийг онцлон тэмдэглэ.

- Аравны нэгийг төлөх нь Их Эзэнийг хайрлах бидний хайрыг хэрхэн харуулдаг вэ? Түүнтэй харилцах бидний харилцаанд аравны нэг хэрхэн нөлөөлдөг вэ?
- Арванхоёрын Чуулгын Ахлагч Жозеф Б.Вертлин, “аравны нэгийг төлөх нь мөнгөтэй багаахан холбоотой, харин ихэнхдээ итгэлтэй холбоотой” гэж хэлжээ (In Conference Report, 1990 оны 4-р сар, 41; *Ensign*, 1990 оны 5-р сар, 32). Аравны нэг хэрхэн мөнгөнөөс илүүгээр итгэлийн асуудал байдаг вэ?
- Аравны нэгийг төлөх нь яагаад зарим үед сорилт байдаг вэ? Энэ сорилтыг даван туулахын тулд бид юу хийж болох вэ? (Аравны нэгийг төлөхөд тохиолддог сорилтыг даван туулахын тулд ангийн гишүүд өөрсдөө буюу таньдаг хэн нэгэн нь ямар нөхцөл байдалтай учирч байсан тухай ярихад тэднийг урь)

Аравны нэгийн санг ашиглах нь

- Аравны нэгийн санг юунд ашиглахыг хэн тодорхойлдог вэ? (С ба Г 120-ийг үз. Энэ илчлэлтэн дэх, “бишоп болон түүний зөвлөх” гэсэн нийлэмж үг Тэргүүлэх Бишопын Зөвлөлийг хэлж байгаа болно. “Дээд зөвлөх” гэсэн нийлэмж үг Арванхоёрын Чуулгын Төлөөлөгчдийг хэлж байна. Тэргүүн Зөвлөл, Арванхоёрын Чуулга, Тэргүүлэх Бишопын Зөвлөл нь Аравны Нэгийг Захиран Зарцуулах Зөвлөлийг бүрдүүлдэг)

Аравны нэгийн сангийн төлөө Аравны Нэгийг Захиран Зарцуулах Зөвлөл гүн хүндэтгэл хүлээдэг тухай Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлэхдээ:

“Бидний эрхлэх ёстой сангийн ариун чанарын сануулагч, байнгын сануулагч болсон бэлэвсэн эмэгтэйн сүүлчийн зоосыг олон жилийн тэртээ Иерусалимд надад өгснийг би ширээнийхээ ар дахь жижигхэн шүүгээнд

хадгалдаг. Зооснууд бэлэвсэн эмэгтэйнх байлаа. Эдгээр зоос баян хүний аравны нэгийн адил тэр эмэгтэйн өргөл бөгөөд эдгээр зоосыг Их Эзэний зорилгын төлөө анхааралтай, бодлого зорилготой ашиглах ёстой юм. Их Эзэний ажлыг өндөрт өргөж, хүмүүсийг төгөлдөржүүлэхийн төлөө аравны нэгийг Тэрээр яаж ашиглах байсан бол, тийм байдлаар түүний ашиглагдаж байгааг харж болох бүхий л арга замаар бид уг санд анхааралтай хандаж, хамгаалахыг хичээдэг билээ” (In Conference Report, 1996 оны аравдугаар сар, 69; *Ensign*, 1996 оны арваннэгдүгээр сар, 50).

- Аравны нэгийн санг юунд ашигладаг вэ?

“[Аравны нэгийн] санг Ариун сүм, шүтээний байрууд барих, дэлхий даяар номлолын ажлыг явуулах, судруудыг орчуулж, хэвлэх, нас барагсдыг гэтэлгэх эх үүсвэрээр хангах, шашны боловсролыг санхүүжүүлэх, түүнчлэн Их Эзэний томилогдсон үйлчлэгчдийн сонгож авсан, Сүмийн бусад зорилгыг дэмжихэд зарцуулдаг” гэж Ахлагч Даллин Х.Өүкс тайлбарлажээ (In Conference Report, 1994 оны 4-р сар, 46; *Ensign*, 1994 оны 5-р сар, 35).

Ахлагч Өүксийн мэдэгдлийг тунгаан бодоход ангийн гишүүдийг урьж, Ариун сүм, цуглааны байранд номлолын ажил, судрууд, нас барагсдыг гэтэлгэх ажил, семинар, институтын улмаас тэд хэрхэн адислагдсаныг авч үз. Бидний хүлээн авч чадах хамгийн агуу адислалууд аравны нэгийн хуульд дуулгавартай байхтай шууд холбоотойг онцлон тэмдэглэ. Бид эдгээр адислалуудыг тунгаан бодсоноор Их Эзэн үнэхээр “тэнгэрийн цонхнуудыг. . . нээж, үүнийг хүлээн авах хангалттай зай байхгүй болтол . . . адислалыг юүлдгийг ” (Малахи 3:10; мөн 3 Нифай 24:10-ыг үз) харж чадна.

2. Мацаг барьж байхыг, мацгийн өгөөмөр өргөл төлж байхыг Их Эзэн бидэнд зарлиг болгосон юм

Хожмын өдрүүдэд Их Эзэний сэргээсэн өөр нэг хууль бол мацгийн хууль юм гэдгийг тайлбарла. Энэ хуульд дуулгавартай байснаар бид Сүм дээр сар бүрийн эхний ням гарагт мацаг барьдаг. Мацгийн өдрийг зохих ёсоор баримтлахын тулд дараалсан хоёр хоол, унднаас татгалзаж, мацгийн болон гэрчлэлийн цуглаанд оролцохыг бидэнд зааварладаг. Мацгийн өдрүүдэд мацаг барихаас гадна тусгай хэрэгцээ гарсан ямар ч үед бид зохимжтой хугацаагаар мацаг барьж болохыг та хэлж болно.

Мацаг барих нь зүгээр л хоол ундгүй явахаас илүү чухал зүйл гэдгийг онцлон тэмдэглэ. Бид зорилготойгоор мацаг барьж, мацагт бэлтгэн залбирсан үед мацаг барилт нь баяр баясгалантай туршлага болж чадна. Самбар дээр *Зорилго, Бэлтгэл, Залбирал* гэсэн үгсийг бич.

- Мацаг барихын зорилго юу вэ? (Их Эзэнд илүү ойр дотно байх, удирдамж хүлээн авах, сүнсний хүч чадлаа өсгөн нэмэгдүүлэх, өөрсдийгөө даруусгах, бие махбодын дур таашаалаа сүнсэндээ захируулах, уруу таталт буюу сул дорой байдлыг даван туулах, бусдыг адислахыг Их Эзэнээс гуйх нь хариулт байж болно) Зорилготой мацаг барилт ямар арга хэлбэрээр мацгийг чинь илүү утга учиртай болгодог вэ?
- Мацаг барихад бэлтгэхийн тулд бидний хийж болох зүйл юу вэ? Бид мацаг барилтад бэлтгэсэн үед мацаг маань ямар байдлаар илүү утга учиртай болдог вэ?

- Бид мацгийн эхэнд, явц дунд мөн эцэст нь залбирах ёстой. Бид мацаг барихдаа залбирах нь яагаад чухал вэ?
- С ба Г 59:13-14; Матай 6:16-18, эсвэл 3 Нифай 13:16-18-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Эдгээр судруудад өгүүлснээр, бид мацаг барих үедээ яах ёстой вэ? Яагаад мацаг барилт баяр баясгалантай эн тэнцүү гэж та нар боддог вэ? Мацаг барилтыг баяр баясгалантай туршлага болгохын тулд та нар юу хийсэн бэ?

Мацгийн ням гараг дахь зохих ёсны мацаг нь гачигдалтай хүмүүст анхаарал халамж тавихад туслахын тулд мацгийн өгөөмөр өргөл өгөхийг багтаадгийг тайлбарла. Мацгийн өргөлийг гишүүдийн оршин суудаг тойрог, гадсан дахь гачигдалтай хүмүүст туслахад юуны өмнө ашигладаг. Бишопууд энэ мөнгийг хүнс, орон байр, хувцас, амьдралыг тэтгэх бусад тусламжийн зүйлүүдээр хангахад ашиглаж болдог.

- Мацгийн өргөлийг өгөх нь яагаад мацгийн өргөлийн хуулиар амьдрахын чухал хэсэг байдаг вэ? (Мацгийн өргөлийг өгснөөр бид бусдад үйлчилж, гачигдалтай хүмүүсийг хайрлах хайраа харуулдаг нь хариулт байж болно)
- Бид мацгийн өргөлийг төлөхдөө хэрхэн өгөөмөр байх ёстой вэ?

“Заримдаа бид нэлээд гар татуу [хуваалцах хүсэлгүй] байж, өглөөний хоолондоо ганцхан өндөг идэхээр бодож, үүнийгээ олон центийн үнэтэй гэж тооцоолоод, Их Эзэнд өгдөг. Биднээс нэлээд нь баян чинээлэг байгаа болохоор, мацаг барьсан хоёр хоолныхоо үнэний оронд үүнээс бүр илүү. . . бүр их, магадгүй, бидний амьдрал дахиас арав дахин ихийг өгвөл зохино гэж би боддог” гэж Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл хэлжээ (In Conference Report, 4-р сарын 1974, 184).

- Бид мацгийн өгөөмөр өргөл төлсний зарим үр ашиг юу вэ? (Исаиа 58:6-7, мөн дараах эшлэлийг үз)

“Хэрэв мацгийн өдрийн болон мацгийн өргөлийн зарчмуудыг дэлхий даяар сахидагсан бол юу болохыг. . . бодоод үз л дээ. Тэгвэл өлссөн хүмүүсийг хооллож, хувцасгүйг хувцаслаж, орох оронгүйчүүдийг орон гэртэй болгоно. Бидний татварын дарамт хөнгөрнө. Өргөл өгөгч хохирохгүй харин багахан юмнаас татгалзсанаараа адислагдах болно. Газар бүрийн хүмүүсийн зүрх сэтгэлд санаа тавилтын шинэ хэмжүүр, амин хувиа үл хичээх чанар өсөн нэмэгдэнэ” хэмээн Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлсэн байдаг (In Conference Report, 1991 оны 4-р сар, 73; *Ensign*, 1991 оны 5-р сар, 52-53).

- Исаиа 58:8-12-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Мацгийн хуулийг дуулгавартай дагадаг хүмүүст Их Эзэн юу амласан бэ? Мацаг барилт танд ямар арга замаар тусалсан бэ? Мацгийн хуулиар амьдрахад илүү шаргуу хичээнгүй болохын тулд бид юу хийж болох вэ?

Дүгнэлт

Бид аравны нэгийг итгэлтэйгээр төлөх юм бол Бурханы хаант улсыг байгуулахад хувь нэмрээ оруулж байгаа нь тэр гэдгийг онцлон тэмдэглэ. Мацгийн өгөөмөр өргөл өгөх нь, “Та нар эдгээр ах дүүсийн маань нэгэнд нь, тэр байтугай, хамгийн дордод нь тийнхүү хандсан бол, Надад хийсэн хэрэг” (Матай 25:40) гэж хэлсэн Аврагчийн шавь нар болохоо бид харуулж чадах нэг арга зам мөн.

Аравны нэгээ шударгаар төлж, мацгийн хуулиар амьдрахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Сүнсээр өдөөгдсөний дагуу гэрчлэлээ хэл.

Нэмэлт заах санаанууд

Та зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болгож дараах санаануудаас нэгийг буюу хоёуланг нь ашиглаж болно.

1. Бүлгээр хийх ярилцлага ба танилцуулга

Ангийн гишүүдийг дөрвөн жижиг бүлэгт хуваа. Хичээлийн хэсэг бүр дэх судрын хэсэг болон асуултууд дээр үндэслэсэн танилцуулга бэлтгүүлэхээр бүлгүүдийг томил.

2. Аравны нэг болон өргөлөө хандивлах нь бидний санхүүгийн эхний төлбөр байх ёстой

Арванхоёрын Чуулгын Ахлагч Марвин Ж.Аштоны дараах зөвлөгөөг хуваалц: “ХҮГ гэр орон бүрийн санхүүгийн амжилттай менежмент нь аравны нэгийг шударгаар төлөхөөс эхэлдэг. Хэрэв бидний аравны нэг, мацгийн өргөл нь цалингийн чек бүрийн дараа хийгддэг санхүүгийн эхний төлбөр байх юм бол, сайн мэдээний энэхүү чухал зарчимд хандах бидний хоёргүй сэтгэл бэхжиж, санхүүгийн буруу менежмент багасна. Сар бүр шалгаад байдаггүй Түүнд аравны нэгийг шуурхай төлөх нь харилцаа холбоотой байдаг хүмүүстэйгээ илүү үнэнч шударга байхыг бидэнд болон үр хүүхдэд маань заах болно” (*One for the Money: Guide to Family Finance* [товхимол, 1992], 3).

3. Авахаасаа илүү өгөх нь

Ангийн гишүүн бүрд хэсэг цаас, үзэг буюу харандаа өг. Мөнгөө ихэвчлэн яаж зардаг арга хэлбэрийг жагсаахыг тэднээс хүс. Дараагийн сард мөнгө зарцуулах зүйлсийн тэмдэглэл хөтлөх даалгаврыг тэдэнд өгч, гачигдалтай хүмүүст тэд хэрхэн илүү өглөгч байх тооцоог гаргуул.

- Сүмийн залуучууд ядуучууд, гачигдалтай хүмүүст хэрхэн тусалж чадах вэ? (Хэрэв та залуучуудад заадаг бол үйлчлэл үзүүлж, мацгийн өргөл төлөхөд нь тэднийг урамшуулан дэмж. Мацгийн өргөл цуглуулах зэрэг материаллаг асуудлуудад Аароны санваартнууд бишопт олонтаа тусалдгийг та бас хэлж болно) Ядуучууд, гачигдалтай хүмүүст туслахад нь хүүхдүүд дээ урамшуулан дэмжихийн тулд эцэг эхчүүд юу хийж болох вэ?

4. “Бурхан урамтайгаар өгөгчийг хайрладаг” (2 Коринт 9:7)

- 2 Коринт 9:6-8-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Бид энэ зөвлөгөөг аравны нэг болон өргөлөө төлөхөд хэрхэн дагаж болох вэ? Аравны нэг болон өргөлийг төлөхөд бидний хандлага, учир үндэслэл яагаад чухал байдаг вэ?

5. Бид мацаг барихдаа Аврагчийн үлгэр жишээг дагах нь

Аврагч цөлд мацаг барьсан үлгэр жишээнээс бид ихийг сурч болно гэдгийг тайлбарла:

- а. Есүс мацаг барьж байхдаа “Бурхантай харилцаж байжээ” (Иосеф Смит Орчуулга, Матай 4:2). Бидний хувьд мацаг барилт бол Бурхантай харилцах цаг юм.

б. Мацаг барилтаа дуусгах үеэр Аврагч Сатаны уруу таталтуудыг эсэргүүцэж, “Сүнсний хүч дотор Галилд буцаж ирсэн билээ” (Лук 4:2-14; мөн Матай 4:3-11-ийг үз). Мацаг барилтаар дамжуулан бид сүнсний хүч чадлыг олж авч чадна.

6. Талархал илэрхийлэхийн тулд мацаг барих нь

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли нэг ерөнхий чуулган дээр хэлсэн үгэндээ Их Эзэнд талархлаа илэрхийлсэн нэг эмэгтэйн бичсэн захидлыг уншжээ. “Миний мацгийн олонх нь ‘талархлын мацаг’ байдаг” гэж захидал бичигч хэлсэн байлаа” (In Conference Report, 1994 оны аравдугаар сар, 75; *Ensign*, 1994 оны арваннэгдүгээр сар, 54). “Талархлын” мацгийн дараах жишээнүүдийг хуваалц:

1842 оны арванхоёрдугаар сарын 26-нд Иллинойн Наувуд, Бошиглогч Иосеф Смит хилс хэргээр баривчлагдаж, Иллинойн Спрингфиелдэд зарлан дуудагджээ. Түүнд тулгасан хэргийг 1843 оны нэгдүгээр сарын 6-нд хэрэгсэхгүй болгож, Наувуд буцаж очихыг нь түүнд зөвшөөрөв. Үүнийг тэмдэглэхийн тулд, “доромжлолын, мацгийн, магтаалын, залбирлын, бас талархал илэрхийлэх өдрийг” Арванхоёрын Чуулга бий болгожээ (*History of the Church*, 5:209, 244, 248).

Бүрэн цагийн номлолд үйлчилж байсан хүү нь тулгарч болзошгүй хүнд хэцүү цагийг даван туулах хангалттай хүчирхэг гэрчлэлтэй болоогүйд нэг эх санаа нь зовж байжээ. Дараа нь тэр эх хүүгийнхээ номлолын амжилтынх нь тухай мэдээ хүлээн авчээ. Хүү нь үлгэр жишээ номлогч байхыг хүсч, Их Эзэнд талархал илэрхийлэх ганцхан зорилготойгоор тэр эх зүрх сэтгэлийнхээ талархлыг өргөн мацаг барьжээ. Хүү нь ээжийнхээ талархлын мацгийн тухай мэдээд, ээжийнхээ зөгнөсөн шиг тийм номлогч болохын тулд улам шаргуу ажиллахаар андгайлсан ажээ.

Хэрэв ангийн гишүүд Их Эзэнд талархал илэрхийлэх цорын ганц зорилготойгоор мацаг барих юм бол тэдний бодол санаа ямар байж болох талаар тунгаан бодохыг тэднээс хүс. Ирэх мацаг барилтыг Их Эзэнд талархал илэрхийлэхэд зориулахыг тэдэнд санал болго. Туршлагынхаа талаар өдрийн тэмдэглэлдээ хөтлөхийг нь урамшуулан дэмж.

7. Видео танилцуулга

Хэрэв *Doctrine and Covenants and Church History Video танилцуулгууд* (53912) байдаг бол, аравны нэгийн ярилцлагын үед “Тэнгэрийн Цонхнууд,” 11 минутын хэсгийг үзүүлэхэд анхаар.

Хэрэв *Гэр бүлийн Үдшийн Видео Нэмэлт хичээл* (53276) байдаг бол “Мацгийн Хууль,” 4 минутын хэсгийг үзүүлэхийг хичээ.

Зорилго Ариун сүмийн ач холбогдлыг ойлгоход нь ангийн гишүүдэд туслах, хувийн-хаа амьдралд ариун сүмийн адислалуудыг эрэлхийлэхэд тэднийг урам-шуулан дэмжих.

Бэлтгэл

1. Дараах судрууд болон бусад материалыг залбирч судал:
 - а. Сургаал ба Гэрээ 95; 109; 110.
 - б. *Бидний Өв*, хуудас 38-41.
2. *Ангийн гишүүний Судлах Удирдамж* (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.
3. Хэрэв дараах материалууд байдаг бол хичээлийн үед ашиглахаар бэлтгэ: Көртландын Ариун сүмийн зураг (62431; Сайн мэдээ Уран Зургийн Цуглуулга 500) мөн өөр нэг Ариун сүмийн зураг.
4. Хэрэв та “Бурханы Сүнс” дууллыг (*Сүмийн дуулал болон хүүхдийн дуу*, х. 28) хичээлийн үед ашиглахаар төлөвлөсөн бол энэ дууллыг ангийн гишүүдээр дуулуулахаар бэлтгэ. Эсвэл ангийн нэг гишүүнээр буюу хэсэг гишүүдээр дуулуулахаар бэлтгэ.

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

Дараах асуултуудыг ангийн гишүүд ангид орж ирмэгц харахаар самбар дээр бич:

Энэ эрин үеэс өмнө Их Эзэний гэрээт хүмүүс хичнээн Ариун сүм барьсан бэ?

Бошиглогч Иосеф Смитийн үед хэдэн Ариун сүм баригдсан буюу баригдахаар төлөвлөгдсөн бэ?

Эдгээр асуултуудыг ярилцахаасаа өмнө энэ эрин үеэс өмнө Их Эзэний гэрээт хүмүүсийн барьсан ердөө дөрвөн Ариун сүмийг л бид мэддэгийг тайлбарла. Анхны ариун сүм Соломоны үед баригдсан байв. Энэ Ариун сүм Зеруббабелын Ариун сүм, Херодын Ариун сүм хэмээн нэрлэгдэж, өөр өөр үед хоёр дахин баригдсан ажээ (Судруудын Удирдамж, “Ариун сүм,” 20). Бусад гурван Ариун сүм нь Мормоны Номд дурдагддаг: Нифайн барьсан Ариун сүм (2 Нифай 5:16), Хаан Бенжамин эндээс сүүлчийн үгээ хэлсэн Зарахемла нутгийн Ариун сүм, (Мозая 1:10; 2:1), мөн амилсан Их Эзэн хүрч ирэхийн өмнө энд хүмүүс цугласан Өгөөмөр нутаг дахь Ариун сүм юм (3 Нифай 11:1).

Бошиглогч Иосеф Смитийн амьдралын үед таван Ариун сүм баригдсан буюу баригдахаар төлөвлөгдөж байсныг тайлбарла. Үүнд: Индепенденсийн, Көртландын, Фар Вестийн, Адам-ондай-Аманы болон Наувугийн Ариун сүм.

- Одоо хичнээн Ариун сүм баригдсан буюу баригдаж байгаа вэ?

Бошиглогч Иосеф Смит бол Ариун сүмийн барилгачин байсныг онцлон тэмдэглэ. Елиа эргэж ирэх тухай Малахийн бошиглол түүгээр дамжин гүйцэлдсэн юм (Малахи 4:5-6; С ба Г 110:13-16-г үз). Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүд Ариун сүм барихаа үргэлжлүүлж байна.

Энэ хичээлээр энэ эрин үед баригдсан анхны Ариун сүм–Көртландын Ариун сүмийн тухай ярилцана.

Ярилцах ба хэрэг-
жүүлэх нь

Энэ хичээл нэг хичээлээр заах боломжтойгоос илүү их материалыг агуулдаг. Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбиран сонгож ав.

1. Көртландын Ариун сүмийг барихыг Их Эзэн Гэгээнтнүүдэд зарлиг болгосон нь

С ба Г 9-ийг зааж, ярилц. Ариун сүм бол Есүс Христийн сайн мэдээний нэн чухал хэсэг гэдгийг тайлбарла. 1832 оны арванхоёрдугаар сард, Огайогийн Көртландад Ариун сүм барихыг Их Эзэн Гэгээнтнүүд зарлиг болгожээ (С ба Г 88:119; 109:2; Көртландын Ариун сүмийн зургийг үзүүл). Энэ зарлигийг биелүүлэхийн тулд Гэгээнтнүүд таван сар өнгөрөөд байхад чамлалттай бага ажил хийсэн учир, наманчилж, ажлаа түргэвчлэхийг Их Эзэн тэдэнд уриалжээ (С ба Г 95). Дөрөв хоногийн дараа эрчүүд чулуу зөөж, Ариун сүмийг барих бэлтгэл болгон нүх ухаж эхлэв.

- С ба Г 95:3-4, 8-9, 16-17; 109:5, 8-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Көртландын Ариун сүмийг барих зорилгын тухай эдгээр шүлгүүд юу зааж байна вэ? (Ангийн гишүүдийн хариултуудыг самбар дээр дээр нэгтгэн дүгнэ. Көртландын Ариун сүм амьд байгаа хүмүүс болон нас барагсдын өмнөөс авралын ёслолууд хийдэг өнөөдрийн ариун сүмүүдтэй адилгүй байсныг тайлбарла. Их Эзэн ариун сүмийн ёслолуудыг хэдэн жилийн дараа Гэгээнтнүүдийг Наувуд байхад сэргээсэн ажээ)
- Көртландын Ариун сүмийг яаж барих талаар Их Эзэн Иосеф Смитэд юу илчилсэн бэ? (С ба Г 95:13-17 болон дараах эшлэлүүдийг үз)

Зарим ажилчид Ариун сүмийг дүнз буюу банзаар барихыг санал болгож байв. Гэвч Иосеф Смит: “Бурханыхаа өргөөг бид. . . дүнзээр барих гэж үү? Үгүй ээ. . . Их Эзэн өөрөө өгсөн, өргөөний төлөвлөгөө надад бий. Юмсын талаарх бидний тооцоо, түүний санаа хоёрын хоорондох ялгааг та нар удахгүй харна” хэмээн хариулжээ (Люси Мак Смит, *History of Joseph Smith*, эмхтгэсэн Дрестон Нибли [1958], 230-аас эш татжээ).

Их Эзэн Көртландын Ариун сүмийн талаарх Өөрийн төлөвлөгөөг Тэргүүн Зөвлөлд (Иосеф Смит, Сидней Ригдон, Фредерик Г.Виллямс) үзэгдлээр илчилсэн юм. Тэднийг залбиралд хамтдаа өвдөг сөгдөхөд, барилгын загвар “харагдах зайд гарч ирэв. . . . Бид гадна талыг сайтар харсны дараа, барилга бидний яг чанх орой дээр гарч ирсэн” гэж Ерөнхийлөгч Фредерик Г.Виллямс хэлжээ. Ариун сүм дуусахад, үзэгдэлд байсантайгаа

яг ижилхэн харагдаж байсан гэж Фредерик Г.Виллямс хэлжээ. (In *The Revelations of the Prophet Joseph Smith*, эмхтгэсэн Линдон В.Кук [1981], 198.)

Өнөөдөр Тэргүүн Зөвлөл илчлэлтээр дамжуулан, Ариун сүмүүдийг хаана, хэзээ барихыг тогтоодгийг хэлэхийг та хүсч болно.

2. Гэгээнтнүүд Ариун сүмийг барихад хийсэн агуу золиослолынхоо төлөө адислагдсан нь

- Көртландын Ариун сүм бол энэ эрин үед баригдсан анхны ариун сүм байсныг тайлбарла. Ариун сүмийг барихтай холбоотой ямар бэрхшээл, золиослолууд байсан бэ? (С ба Г 109:5, *Бидний Өв*, хуудас 38-40-ийг үз.)
- Көртландын Ариун сүмийг барихад хийсэн золиослолынхоо төлөө Гэгээнтнүүд хэрхэн адислагдсан бэ? (*Бидний Өв*, хуудас 39-41-ийг үз.)
- Ариун сүмийн адислалууд хүлээн авах эсвэл ариун сүмийн ажилд оролцохын тулд Сүмийн гишүүд ямар золиослол хийснийг та нар харсан бэ?



Көртландын Ариун сүм. Энэ бол энэ эрин үед баригдаж, 1836 онд онцгойлон адислагдсан, анхны Ариун сүм юм.

3. Иосеф Смит Көртландын Ариун сүмийг онцгойлон адисалсан нь

1836 оны гуравдугаар сарын 27-нд Бошиглогч Иосеф Смит Көртландын Ариун сүмийг онцгойлон адисалжээ. Их Эзэний илчилсэн онцгойлон адислах залбирал С ба Г 109-д байдаг. Онцгойлон адислах үйлчлэл долоон цаг үргэлжилсэн бөгөөд Сүнсний агуу юүлэлт үйлчлэлийг дагалдсан ажээ. Үйлчлэлд онцгойлон адислах залбирал, дуулал дуулах, гэрчлэл хэлэх, ариун ёслолыг түгээж, номлол айлдан, гишүүд хүндэт хуралдайгаар Иосеф Смит болон Сүмийн бусад удирдагчдыг дэмжин баталсан нь багтжээ. Гэгээнтнүүд гараа толгой дээрээ өргөн, “Бурханд болон Хурганд Хозанна, Хозанна, Хозанна, амен, амен, амен” хэмээн гурвантаа хашгирснаар үйлчлэл дуусав (*History of the Church*, 2:427-428).

Көртландын Ариун сүмийн онцгойлон адислалт дээр дуулсан “Бурханы Сүнс” (Сүмийн дуулал болон хүүхдийн дуу, х. 28) дууллыг та ангийн гишүүд дээр дуулуулахыг хүсч болох юм. Эсвэл даалгавар авсан ангийн нэг гишүүн буюу хэсэг гишүүдээр энэ дууллыг дуулуул.

- Бид яагаад ариун сүмүүдийг онцгойлон адисалдаг вэ? Ариун сүмүүд онцгойлон адислагдсаныхаа дараа хэрхэн өөр болдог вэ? Ариун сүмийн онцгойлон адислалтад оролцсон ангийн гишүүд байвал, туршлагынх нь талаарх санаа бодол, сэтгэгдлээ хуваалцахад тэднийг урь.
- Көртландын Ариун сүмийн онцгойлон адислалтын үед Сүнсний ямар илэрхийллүүд тохиосон бэ? (Бидний Өв, хуудас 39-40-ийг үз.)
- Бошиглогч ариун сүмийн талаарх Сүмийн гишүүдийн үүрэг хариуцлагыг онцгойлон адислах залбиралд онцлон тэмдэглэснийг тайлбарла. Тэрээр ямар үүрэг хариуцлагыг тэрээр онцлон тэмдэглэсэн бэ? (Эдгээр үүрэг хариуцлагын заримыг нь дараах судрын хэсгүүдэд тоймлон авч үзсэн байгаа. Ангийн гишүүдээр уншуулж, ярилцахын тулд хэдэн хэсгийг сонгож ав. Хариултыг самбар дээр нэгтгэн дүгнэ)
 - а. С ба Г 109:7, 14. (Бид судлахаар бас итгэлээр суралцахыг хичээнгүйлэн эрэлхийлэх ёстой) Ариун сүмийн талаарх энэ үүрэг хариуцлага яагаад чухал вэ?
 - б. С ба Г 109:9, 17-19. (Бидэнд ирж байгаа юмс, биднээс гарч байгаа зүйлүүд болон мэндчилгээ нь Их Эзэний нэрээр байх ёстой) Энэ үүрэг хариуцлагыг бид хэрхэн биелүүлж чадах вэ?
 - в. С ба Г 109:20-21. (Ариун сүмд орохын тулд бид цэвэр ариун байх ёстой) Яагаад бид Ариун сүмд орохдоо зохистой байх нь зайлшгүй чухал байдаг вэ? (С ба Г 97:15-17-г үз.) Бид Их Эзэний өргөөнд орох зохистой байдлаа хэрхэн шалгадаг вэ? (Ариун сүмийн зөвшөөрлийн бичиг авах ярилцлагаар дамжуулан)
 - г. С ба Г 109:23. (Бид ариун сүмээс гарч явахдаа сайн мэдээний баярт мэдээг дэлхийн төгсгөл хүртэл тэвчээртэйгээр авч явахаар шийдвэр төгс болсон байх ёстой) Ариун сүмд орох нь ийм бболоход хэрхэн сүнслэгээр нөлөөлж чадах вэ?
- Бошиглогч онцгойлон адислах залбиралд олон агуу адислалын төлөө залбирсныг тайлбарла. Тэр ямар адислалын төлөө залбирсан бэ? (Эдгээр адислалын заримыг нь дараах судрын хэсгүүдэд тоймлон авч үзсэн байгаа. Ангийн гишүүдээр уншуулж, ярилцахын тулд хэдэн хэсгийг сонгож ав. Хариултыг самбар дээр нэгтгэн дүгнэ)
 - а. С ба Г 109:15. (Их Эзэний хүмүүс Ариун Сүнсийг бүрэн байдлаар нь хүлээн авах ёстой) Ариун сүмд орсон нь тэдний амьдралд Сүнсний нөлөөг хэрхэн өсгөн нэмэгдүүлсэн тухай ярихад ангийн гишүүдийг урь.
 - б. С ба Г 109:22. (Их Эзэний хүмүүс Ариун сүмээс гарч явахад тэнгэрийн хүчээр зэвсэглэсэн байдаг бас тэнгэр элчүүд тэднийг дээрээс нь харж байдаг) Ариун сүмд орсны дараа тэнгэрийн хүчээр зэвсэглэгдсэнээ мэдэрсэн туршлагаа хуваалцахад ангийн гишүүдийг урь.
 - в. С ба Г 109:25-26. (Их Эзэний хүмүүсийг ялах ямар ч зэвсэг эсвэл ёс бус явдал гэж байхгүй) Ариун сүмд орох нь нүгэл хилэнцээс биднийг хэрхэн хамгаалдаг вэ?

- г. С ба Г 109:32-33. (Их Эзэн Өөрийн хүмүүсээс гай зовлонгийн буулгыг эвдлэн хаяна) Ариун сүмд орсон нь гай зовлонг даван туулах буюу тэвчихэд тань хэрхэн тусалсан бэ?
- д. С ба Г 109:36-37. (Пентекостын өдрийнхтэй адилаар Сүнсний юүлэлт байх болно; Үйлс 2:1-4-ийг үз.) Залбирлын энэ хэсгийн нэг гүйцэлдэлт онцгойлон адислалтын үдэш болсон санваартны хурлын үеэр тохиожээ. Ариун сүмд хүчтэй салхины чимээ дуулдаж, олон ах нар олон хэлээр ярьж, бошиглон, үзэгдлийг харсан ажээ (*History of the Church*, 2:428).
- е. С ба Г 109:54-58. (Их Эзэн сайн мэдээний захиасын төлөө өөрсдийгөө бэлтгэхэд нь хүмүүсийн зүрх сэтгэлийг зөөллөн, дэлхийн үндэстнүүдэд нигүүлсэнгүй байх болно)
- ё. С ба Г 109:61-64, 67. (Израилын тараагдсан хүүхдүүд цуглуулагдаж, гэтэлгэгдэж эхэлнэ) Энэ адислалыг авчрахад Ариун сүмийн ажил хэрхэн тусалдаг вэ?
- ж. С ба Г 109:72-74. (Их Эзэний Сүм бүх дэлхийг дүүргэнэ) Энэ адислалыг авчрахад Ариун сүмийн ажил хэрхэн тусалдаг вэ?

Сүмийн 14 дэх Ерөнхийлөгч Ховард В.Хантер, Көртландын Ариун сүмийн онцгойлон адислах залбирал дахь амлалтуудыг “сэтгэл догдлом, гайхалтай” хэмээн дүрсэлжээ (“The Great Symbol of Our Membership,” *Ensign*, 1994 оны аравдугаар сар, 5). “Их Эзэний ариун сүмүүдийг ашиглахын төлөө Тэрээр бидэнд өгсөн санваарын хүчний улмаас, энэ залбирал хувь хүний хувьд, гэр бүлийн хувьд мөн хүмүүсийн хувьд бидэнд үргэлж хариулагдсаар байх болно” (*Ensign*, 1994 оны аравдугаар сар, 4).

4. Их Эзэн Көртландын Ариун сүмийг хүлээн авч, эртний бошиглогчид санваарын түлхүүрүүдийг сэргээсэн нь

С ба Г 110-ыг зааж, ярилц. Их Эзэн Өөрийн үйлчлэгчдэд дээрээс ирэх хүчээр хишиг хүртээх амлалтаа Көртландын Ариун сүм дуусах үед биелүүлснийг тайлбарла (С ба Г 95:8). Тэнгэрийн хүчээр ийнхүү хишиг хүртээсэн үйл явдалд Аврагч энэ Ариун сүмд хүрч ирсэн, Сүнсний юүлэлт, олон илчлэлт, Мосе, Елиас, Елиа нар санваарын түлхүүрүүдийг сэргээсэн нь орно. Их Эзэний үйлчлэгчид эдгээр ариун туршлага болон түлхүүрүүдээр Түүний ажлыг илүү их хүч, эрх мэдлээр урагш ахиулах боломжтой болсон билээ.

- Аврагч Көртландын Ариун сүмд хүрч ирснийг Бошиглогч Иосеф Смит хэрхэн дүрсэлсэн бэ? (С ба Г 110:1-3-ыг үз.) Аврагч Өөрийнхөө тухай юу хэлсэн бэ? (С ба Г 110:4-ийг үз.) Тэрээр Ариун сүмийн талаар Иосеф Смит, Оливер Каудери хоёрт юу хэлсэн бэ? (С ба Г 110:6-10-ыг үз.)
- Елиас, Елиа нар санваарын ямар түлхүүрүүдийг сэргээсэн бэ? (С ба Г 110:11-16-г үз.) Мосе Израилын цугларалтын түлхүүрүүдийг, Елиас Абрахамын сайн мэдээний түлхүүрүүдийг, Елиа лацдалтын хүчний түлхүүрүүдийг сэргээсний улмаас өнөөдөр бидэнд ямар адислалууд болон үүрэг хариуцлага байдаг вэ? (Дараах схем ярилцлагад тань тусалж болно. Та энэ мэдээллийг самбар дээр нэгтгэн дүгнэхийг хүсч болно.)

Хүн	Түлхүүрүүд сэргээгдсэн нь	Адислал ба үүрэг хариуцлага өнөөдөр
Моше	Израилын цугларалт	Израилыг цуглуулахын тулд сайн мэдээг номлох эрх мэдэл (номлолын ажил).
Елиас	Абрахамын сайн мэдээний эрин үе	Абрахамын гэрээний адислал ба уг гэрээтэй холбоотой үүрэг (эдгээр адислал бо лон үүргийгнэгтгэн дүгнэхийн тулд Абрахам 2:9-11-ийг үз).
Елиа	Лацдалтын хүч	Санваарын ёслолуудыг тэнгэрт хүчинтэй болгодог хүч. Лацдалтын хүч нь ариун сүмийн гэрлэлт, хүүхдүүд болон өвөг дээдэстэй нь лац дан холбох, мөнхийн гэр бүл, түүнчлэн нас ба рагсдын өмнөөс хийх ариун сүмийн ёслолын ажлыг боломжтой болгодог.

5. Ариун сүмүүдийг барих болон Ариун сүмийн ажил өнөө үед хурдассан нь

- Нэг ариун сүмийн зураг үзүүл. Ариун сүм барих ажил өнөө үед хэрхэн хурдассан бэ? (1980 онд Сүм 19 ариун сүм, 1997 оны эцэс гэхэд 51 ариун сүмтэй байлаа. 1997 оны аравдугаар сарын ерөнхий чуулган дээр Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли жижиг ариун сүмүүд барих төлөвлөгөөг зарлав. 1998 оны дөрөвдүгээр сарын чуулган дээр 2000 оны эцэс гэхэд 100 ариун сүмтэй болох төлөвлөгөөг тэрээр зарласан нь, Сүм зохион байгуулагдсанаас хойших 167 жилд барьсан ариун сүмүүдийг 3 жилийн дотор барина гэсэн үг байлаа.)
- Ариун сүм барих ажил хурдассантай холбоотойгоор, Сүмийн удирдагчид ариун сүмийн ажилд оролцоход шинэ байдлаар онцгой анхаарал хандуулсан юм. С ба Г 138:53-56-г ангийн гишүүдтэй хамт унш. “Ариун сүм барих, ариун сүмд ёслолуудыг. . . гүйцэтгэхэд оролцохын тулд цаг хугацааны бүрэн байдалд гарч ирэхээр хадгалагдсан сонгомол сүнснүүдийн” дунд Сүмийн зохистой гишүүд байдгийг тайлбарла. Ариун сүмийн ажил түргэсэхэд бид хэрхэн тусалж чадах вэ?

“Ариун сүмд ордог, Ариун сүмийг хайрладаг хүмүүс байцгаая. Цаг зав, мөнгө төгрөг, хувийн нөхцөл байдал боломж олгохын хэрээр ариун сүмд аль болох олон удаа явцгаая. Зөвхөн нас барсан төрөл төрөгсдийнхөө төлөө биш, Ариун сүмийн шүтлэгийн хувийнхаа адислалын төлөө, тэрхүү ариун, ариулан адислагдсан ханануудын дотор хангагддаг ариун чанар, аюулгүй байдлын төлөө бас явдаг байцгаая. Ариун сүм бол үзэсгэлэн төгөлдөр газар мөн. Энэ бол илчлэлтийн газар, амар амгалангийн газар мөн. Энэ бол Их Эзэний өргөө юм. Ариун сүм бол Их Эзэнд зориулагдсан ариун газар мөн. Ариун сүм бидний хувьд ариун газар байх ёстой” гэж Ерөнхийлөгч Ховард В.Хантер хэлжээ (*Ensign*, 1994 оны аравдугаар сар, 5).

Дүгнэлт

Амьдралаа залбирлаар бүрэн дүүрэн шалгаж, ариун сүмийн ажилд хэрхэн оролцож болохоо шийдэхэд нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Кертландын Ариун сүмийг барихад Гэгээнтнүүд золиослол хийж байсны адилаар, ариун сүмийн ажилд туслахад бид золиослол хийх ёстойг хэл.

Хэрэв та ариун сүмд ойр байдаг бол ариун сүмд ороход нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Бид энэхүү агуу ажилд оролцох юм бол Их Эзэн биднийг адисална гэдгийг гэрчил.

**Нэмэлт
заах санаа**

Та зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болгож дараах санааг ашиглаж болно.

Ариун сүмүүдийн зураг

Ариун сүмүүдийн зургийг гэрийнхэндээ үзүүлэхийг ангийн гишүүдэд санал болго. “Ариун сүмийн зургийг хүүхдүүд чинь харж болохоор газарт гэр орондоо байлга. Их Эзэний өргөөний зорилгын тухай тэдэнд заа. Бүр бага наснаас нь эхлэн ариун сүмд явахаар, бас ариун сүмийн адислалд зохистой байхыг тэднээр төлөвлүүл” гэж Ерөнхийлөгч Ховард В.Хантер хэлжээ (In Conference Report, 1994 оны аравдугаар сар 8; *Ensign*, 1994 оны арваннэгдүгээр сар, 8).

Зорилго

Авралын төлөвлөгөөний агуу цар хүрээг ойлгоход нь ангийн гишүүдэд туслах, уг төлөвлөгөөний тухай мэдлэгийнхээ дагуу амьдрахад тэднийг урамшуулан дэмжих.

Бэлтгэл

1. Энэ хичээлийн судруудыг залбирч судал.
 2. *Ангийн гишүүний Судлах Удирдамж* (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.
 3. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах бол, сэтгүүлийн зураг гэхчлэн нэг зураг олж ав. Зургийг хэдэн жижиг хэсэг болгон хэрч. Ангийн гишүүд жижиг хэсгүүдийг хараад ямар зураг болохыг хэлэх боломжгүй байхад анхаар.
-

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа

Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

Ангид авчирсан зургийнхаа хэрчмэл жижиг хэсгүүдийг үзүүл, гэвч зургийг бүтнээр нь бүү үзүүл (“Бэлтгэл,” зүйл 3-ыг үз). Эдгээр жижиг хэсгүүд бол нэг том зургийн хэсгүүд гэдгийг ангийн гишүүдэд хэл. Зурган дотор юу байгааг хурдан таахад тэднийг урь. Дараа нь жижиг хэсгүүдийг байранд нь тавьж, зургийг үзүүл.

Хэдийгээр жижиг хэсгүүд чухал ч гэсэн, эдгээр жижиг хэсгүүд том зургийн хэсэг биш бол, утга учир багатай байх байсныг хэл. Бидний туршлага, бидний гаргадаг шийдвэрүүд, бидний сурч мэддэг үнэнүүд нь том зургийн жижиг хэсгүүдтэй адил юм гэдгийг тайлбарла. Хэрэв эдгээр нь нэг том зураг: Авралын төлөвлөгөөнд хамтдаа цогц болон тавигдахгүй бол утга учир багатай юм. Авралын төлөвлөгөөний тухай мэдлэг нь зөв шийдвэр гаргах, мөнх бус байдалд баяр баяслыг олох, улмаар мөнх амьдралд бэлтгэхэд бидэнд тусалж чадна. Энэ хичээлээр авралын төлөвлөгөөг ярилцдаг.

Ярилцах ба хэрэгжүүлэх нь

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбиран сонгож ав. Судрын зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. **Авралын төлөвлөгөө бол “хүн төрөлхтөнд соёрхогдсон тэнгэрийн шилдэг бэлгүүдийн нэг мөн”**

Тэнгэрлэг Эцэгийн _____ *төлөвлөгөө* гэж самбар дээр бич.

Өгүүлбэрийг гүйцээхийг ангийн гишүүдээс хүс. Чадах чинээгээрээ судруудаас аль болох олон хариултыг бодож олоход нь тэднийг урамшуулан дэмж. Хариултуудыг нь самбар дээр бич. Нэг буюу хоёр минутын дараа дараах хариултуудаас тэдний хэлээгүй аль нэг хариултыг хуваалц:

Аврал (Алма 24:14; 42:5; Мосе 6:62)

Сэргээлт (Алма 41:2)

Аз жаргал (Алма 42:8, 16)

Нигүүлсэл (Алма 42:15, 31)

Гэтэлгэл (Иаков 6:8; Алма 12:25-33)

- Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний тухай эдгээр үгс юу заадаг вэ?
- Бошиглогч Алма Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг “аз жаргалын агуу төлөвлөгөө” гэсэн байдаг (Алма 42:8). Авралын төлөвлөгөө бидэнд аз жаргалыг хэрхэн авчирч чадах вэ?
- “Авралын агуу төлөвлөгөө бол бидний онцгой хүндэтгэлтэй анхаарлыг татах ёстой сэдэв бөгөөд уг төлөвлөгөөг хүн төрөлхтөнд соёрхогдсон тэнгэрийн шилдэг бэлгүүдийн нэг гэж үзэх ёстой” хэмээн Бошиглогч Иосеф Смит сургажээ (*Teachings of the Prophet Joseph Smith*, эмхтгэсэн Жозеф Фиелдинг Смит [1976], 68). Авралын төлөвлөгөөнд “онцгой хүндэтгэлтэй анхаарлаа” хандуулахын тулд бид юу хийж болох вэ?

Энэ хичээл бол авралын төлөвлөгөөний тойм юм гэдгийг тайлбарла. Сайн мэдээний зарчмууд нэгэн агуу төлөвлөгөөний хэсэг болон бие биетэйгээ хэрхэн холбогддогийг энэ хичээл харуулдаг.

2. Мөнх бус байдлын өмнөх амьдрал

Авралын төлөвлөгөө: мөнх бус байдлын өмнөх амьдрал, мөнх бус амьдрал, үхлийн дараах амьдрал гэсэн гурван хэсэгт хуваагддагийг тайлбарла.

Мөнх бус байдлын өмнөх амьдрал гэж самбар дээр бич. Сэргээлтийн нэг чухал адислал бол мөнх бус амьдралын тухай бидний мэдлэг өсөн нэмэгдсэн явдал мөн гэдгийг хэл. Энэ мэдлэг амьдралын зорилго болон Бурханы авралын төлөвлөгөөн дэх өөрсдийнхөө байр суурийг ойлгоход бидэнд тусалдаг. Дараах асуултуудыг ангийн гишүүд ярилцах үед, санал болгосон судрын хэсгүүдийг уншуул.

- Бид бол Бурханы хөвгүүд, охид бөгөөд мөнх бус байдлын өмнөх оршихуйд Түүний Сүнсэн хүүхдүүд болж амьдарч байсан билээ (С ба Г 76:24; 93:29). Бурханы хүүхэд гэдгээ мэдсэн нь танд хэрхэн нөлөөлдөг вэ?
- Дэлхий бүтээгдэхээс өмнө Тэнгэрлэг Эцэг тэнгэрт их зөвлөлийг зарлан хуралдуулж, бүх сүнсэн хүүхдүүдийнхээ авралын төлөвлөгөөг танилцуулжээ. Мөнх бус байдлын өмнөх дэлхийд Тэнгэрлиг Эцэгийн танилцуулсан төлөвлөгөөний зарим бүрэлдэхүүн хэсэг юу вэ? (2 Нифай 2:24-26; Алма 34:8-9; Абрахам 3:24-25-ыг үз. Есүс Христийн Цагаатгал; дэлхийн Бүтээлт; Уналт; бид мөнх бус бие хүлээн авч, дэлхий дээр соригдох үе; мөн сонгох эрх буюу сайныг, эсвэл мууг сонгох хүч нь хариулт байж болно)
- Эцэгийн Ууган Хүү Иехова авралын төлөвлөгөөнд хэрхэн хариулсан бэ? (Мосе 4:2-ыг үз.) Эцэгийн хүслийг Аврагч хэрхэн дуулгавартай дагасныг харуулахын тулд та С ба Г 19:16-19, 76:40-42-ыг уншиж болох юм. Есүс Христийн Цагаатгал авралын төлөвлөгөөг боломжтой болгосон юм. Аврагч бол бидний авралын төлөөх Бурханы төлөвлөгөөнд гол хүн юм)

- Люсифер бидний сонгох эрхийг устгаж, Тэнгэрлэг Эцэгийн хүчийг олж авахыг санаархан, авралын төлөвлөгөөг эсэргүүцэж бослого гаргасан билээ (Мосе 4:1, 3; С ба Г 29:36). Тэрээр Сатан болж, тэр өөрөө бас дагалдагчид нь Эцэгийн оршихуйгаас хөөгдөж, мөнх бус байдал тэдэнд үгүй болсон юм (С ба Г 29:36-38; 76:25-27; Мосе 4:4; Абрахам 3:26). Сатан болон түүнийг дагалдагчид байдаг тухай мэдэх нь бидэнд яагаад чухал вэ?
- Авралын төлөвлөгөөнд бид хэрхэн хариулсан бэ? (Иов 38:4-7-г үз. Энэ хэсэг дэх шүлэг 7 нь мөнх бус байдлын өмнөх оршихуйд авралын төлөвлөгөөг хүлээж авах үед бид бүгдийн мэдэрсэн баяр баясалд холбогддогийг тайлбарла)

Мөнх бус байдлын өмнөх дэлхийд Тэнгэрлэг Эцэг дэлхий дээр ажлаа хийлгэхээр сайн сүнсүүдийг сонгож, урьдчилан томилсныг тайлбарла (С ба Г 138:55-56; Абрахам 3:22-23; мөн *Teachings of the Prophet Joseph Smith*, 365-ыг үз).

- Мөнх бус байдлын өмнөх амьдралын тухай бидний мэдлэг ямар арга замаар бидний өдөр тутмын шийдвэрүүдэд нөлөөлж болох вэ? Мөнх бус байдлын өмнөх амьдралын тухай бидний мэдлэг хүнд сорилттой тулгарсан үед бидэнд хэрхэн тусалж чадах вэ?

3. Мөнх бус амьдрал

Бид мөнх бус байдлын өмнөх амьдралд Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг хүлээж авсан үед “нэг дэх байдалдаа” байсныг хэл. Бид итгэлтэй байсан учраас дэлхийд ирэх боломжийг бидэнд олгосон нь бидний “хоёр дахь байдал” (Абрахам 3:26) юм.

Мөнх бус амьдрал гэж самбар дээр бич. Адам Ева хоёрын Уналтын улмаас, мөнх бус байдалд бид уналтын байдалтай байдгийг тайлбарла (С ба Г 29:40). Бид бие махбодын үхэл, бас сүнсний үхлийн эрхшээлд буюу Бурханы оршихуйгаас таслагдсан байдаг (С ба Г 29:41-42; Алма 42:9, 14; биеийн үхэл болон сүнсний үхлийг хожуу нэг хичээлээр ярилцах болно). Уналт бол бидний мөнхийн дэвшилд зайлшгүй шаардлагатай алхам болохыг бид хожмын үеийн илчлэлтээс мэддэг билээ. Ева уналтын адислалын тухай өгүүлэхдээ: “Хэрэв бидний зөрчил байгаагүй бол бид үүрд үр удамгүй байх байсан. Мөн сайн ба мууг, гэтэлгэлийнхээ баяр баясгаланг, бас дуулгавартай бүх хүмүүст Бурханы өгсөн мөнх амьдралыг хэзээ ч мэдэхгүй байх байсан” (Мосе 5:11) гэжээ.

Дараах асуултуудыг ярилцах үед, санал болгосон судрын хэсгүүдийг ангийн гишүүдээр уншуул.

- Мөнх бус амьдралын зорилго юу вэ? (Ангийн гишүүдийн хариултыг самбар дээр бич. Доор жагсаасан зүйлүүд хариулт байж болно)
 - а. Бие махбод хүлээж авахын тулд “Бид бие махбодтой болж, үүнийгээ селестиел хаант улсад Бурханы өмнө цэвэр ариун авч очихын тулд энэ дэлхийд ирсэн юм” гэж Бошиглогч Иосеф Смит хэлжээ (*Teachings of the Prophet Joseph Smith*, 181).
 - б. Бид Бурханы зарлигуудад дуулгавартай байхаар дамжуулан итгэл бишрэлээ нотлон харуулахын тулд (Абрахам 3:25-26). Бид нүглээ наманчилж, авралын ёслолуудыг хүлээн авах нь үүнд багтана (Алма 12:24; С ба Г 29:42-43; Итгэлийн Тунхаг 1:3).

в. Гэр бүлүүдэд амьдарч, ариун сүмийн ёслолуудаар дамжуулан хүүхдүүдийг эцэг эхтэй нь лацдан холбуулахын тулд (Моисе 2:28; С ба Г 93:40; 131:1-4; 138:48).

Тэргүүн Зөвлөл болон Арванхоёрын Чуулгын Төлөөлөгчид, “эрэгтэй, эмэгтэй хүний хоорондын гэрлэлтийг Бурханаас томилдог бөгөөд гэр бүл нь Түүний хүүхдүүдийн мөнхийн хувь заяаны төлөөх Бүтээгчийн төлөвлөгөөний төвд байдгийг тунхагласан билээ. . . . Аз жаргалын бурханлиг төлөвлөгөө нь нас эцэслэсний дараа гэр бүлийн холбоог мөнхжих боломж олгодог. Ариун сүмүүдэд гүйцэтгэдэг ариун ёслолууд болон гэрээнүүд нь хувь хүмүүс Бурханы оршихуйд эргэж очих, гэр бүлүүд үүрд мөнхөд нэгдэх боломжийг олгодог” (“Гэр бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг,” *Ensign*, 1995 оны арваннэгдүгээр сар, 102).

- Мөнх бус байдлын зорилгуудыг ойлгосноор амьдралд тань ямар өөрчлөлт гарсан бэ? Эдгээр зорилгуудыг ойлгосон нь гаргадаг шийдвэрүүдэд тань хэрхэн нөлөөлдөг вэ?
- Бидний мөнх бус амьдралын хэсэг болж, биднийг уруу татахыг Сатанд зөвшөөрсөн юм (С ба Г 29:39). Яагаад? (С ба Г 29:39; мөн 2 Нифай 2:11-13-ыг үз.) Сонгох эрх яагаад авралын төлөвлөгөөний чухал хэсэг байдаг вэ? (С ба Г 58:27-28; 101:78; 2 Нифай 2:25-27-г үз.)

4. Үхлийн дараах амьдрал

Бие махбодын үхлээр амьдрал дуусдаггүйг онцлон тэмдэглэ. *Үхлийн дараах амьдрал* гэж самбар дээр бич. Дараах асуултуудыг ярилцах үед, санал болгосон судрын хэсгүүдийг ангийн гишүүдээр уншуул.

- Нас барахад бидний сүнс Сүнсний дэлхийд очдог (*Teachings of the Prophet Joseph Smith*, 309-10-ыг үз.) Мөнх бус байдлын үе дэх бидний ажил үйлс мөнх бус байдлын дараах сүнсний дэлхий дэх бидний амьдралд хэрхэн нөлөөлөх вэ? (Алма 34:34; 40:11-14-ийг үз.)
- Дэлхий дээр сайн мэдээг хүлээн аваагүй хүмүүст энэхүү боломж Сүнсний дэлхий дээр олдох болно (С ба Г 137:7-9; 138:30-34). Авралын төлөвлөгөөний бүх адислалыг хүлээн авахад нь тэдэнд туслахын тулд бид юу хийж болох вэ? (С ба Г 128:6-8, 15-ыг үз. Бид гэр бүлийн түүхийн ажил хийж, Ариун сүмд тэдний өмнөөс санваарын ёслолуудыг гүйцэтгэж болох нь хариулт байж болно)
- Уналт нь бие махбодын болон сүнсний үхлийг дэлхийд авчирсныг ангийн гишүүдэд сануул. Бие махбодын үхлээс бид яаж чөлөөлөгдөх вэ? (Алма 11:42; С ба Г 88:14-16; 93:33-ыг үз. Есүс Христийн Цагаатгалаар дамжин, бүх хүмүүс амилуулагдана, эсвээс “энэхүү зуурдын үхлээс босч ирэх болно.” Бидний сүнс бие махбодтойгоо дахин нэгдэнэ. Ингэснээр бид “баяр баяслын бүрэн байдлыг” хүлээн авах боломжтой болно.) Бид Сүнсний үхлээс яаж чөлөөлөгдөж чадах вэ? (Алма 42:11-13, 15; Итгэлийн Тунхаг 1:3-ыг үз.)

Бид амилуулагдсаны дараа, ажил үйлсийнхээ дагуу шүүгдэхээр Бурханы оршихуйд буцаж очно (Алма 11:43-45; С ба Г 76:111). “Есүсийн тухай гэрчлэлийг хүлээн авсан” бидний байдал дээр тулгуурлагдсан Селестиел хаант улс, Террестриел хаант улс, эсвэл Телестиел хаант улсад бид нэг байрыг өвлөн авах болно (С ба Г 76:51; мөн шүлэг 50, 79-82-ыг үз).

Дараагийн хичээлээр энэ гурван хаант улсын алдар суугийн тухай ярилцана.

- Үхлийн дараах амьдралын тухай мэдлэг ямар арга замаар мөнх бус байдлын үед бидэнд тусалдаг вэ?

Дүгнэлт

Арванхоёрын Чуулгын Ерөнхийлөгч Боид К.Пакерын дараах үгсийг ангийн гишүүдээр уншуул:

“Төлөвлөгөө гурван хэсэгтэй. Та нар хоёр дахь буюу дундах хэсэгт нь, уруу таталт, хүнд сорилт, магадгүй эмгэнэлт явдлаар соригдох тэр хэсэгт байна. . .

“Үүнийг санагтун! ‘Тэгээд бүгд амар сайхандаа жаргажээ’ хэмээн үлгэр төгсдөг шиг [жүжгийн] хоёрдугаар үзэгдлийн тухай нэг ч мөр хэзээ ч бичигдээгүй билээ. Нууцлаг зүйлүүд шийдвэрлэгдэж, бүх юм зөвөөр тавигдсан үед энэ мөр *гуравдугаар* үзэгдэлд хамаарах болно. . .

“[Төлөвлөгөөний] мөнхийн мөн чанарын тухай өргөн ойлголт өөрсдөд тань бий болохыг хүртэл, та нар амьдрал дахь тэгш бус байдлыг төдийлөн мэдрэхгүй байх болно. Зарим хүмүүс маш бага юмтай төрсөн байхад нөгөө хэсэг нь маш их юмтай байдаг. Зарим хүмүүс ядуу тарчиг, бие эрхтний гажигтай, өвчтэй, зовлон зүдгүүртэй байдаг. Зарим нь, тэр ч байтугай гэм зэмгүй балчирхан үрс өсч насанд хүрэхээсээ өмнө хорвоог орхидог. Байгалийн энэрэлгүй хахир хатуу хүчнүүд, хүн хүндээ харгис бурангуй хандах явдал байдаг. Саяхан бид ийм явдал олныг үзлээ.

“Бурхан Өөрийнхөө зорилгын учир ийм зүйлд зориудаар хүргэдэг, үүнийг зөвшөөрдөг гэж бүү бод. Төлөвлөгөөг мөн үүний зорилгыг та нар мэдсэн үед, бүр эдгээр зүйлүүд ч гэсэн хайраар дүүрэн Тэнгэр дэх Эцэгийг харуулах болно” (*The Play and the Plan* [хиймэл дагуулын нэвтрүүлэг, 1995 оны 5-р сарын 7], 1-2).

Авралын төлөвлөгөөний тухай мэдлэг нь зөв шийдвэр гаргах, мөнх бус байдалд баяр баяслыг олох, мөнх амьдралд бэлтгэхэд бидэнд тусалж чадна гэдгийг онцлон тэмдэглэ. Авралын төлөвлөгөөн дэх Есүс Христийн үүргийн тухай бодол санаагаа илэрхийл. Сүнсээр өдөөгдсөний дагуу, хичээлийн үеэр ярилцсан үнэнүүдийн тухай гэрчил.

Нэмэлт заах санаанууд

Та зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болгож дараах санаануудаас нэгийг буюу хоёрыг ашиглаж болно.

1. “Авралын төлөвлөгөө” видео танилцуулга

Хэрэв видео хуурцаг *Teachings from the Doctrine and Covenants and Church History* (53933) байдаг бол “Авралын Төлөвлөгөө” дөрвөн минутын хэсгийг үзүүлэхэд анхаар. Видеог үзүүлсний дараа доорх асуултуудыг бүгдийг нь буюу заримыг нь ашиглахыг бод:

- Бидний мөнх бус амьдрал, жүжгийн хоёрдугаар үзэгдэлд тайзан дээр байгаа залуу хүний туршлагатай хэр зэрэг адилхан бэ?
- Нэгдүгээр үзэгдлийн (мөнх бус байдлын өмнөх амьдрал) тухай илчлэгдсэн мэдлэг хоёрдугаар үзэгдэлд (мөнх бус байдал) бидэнд хэрхэн тусалдаг

вэ? Гуравдугаар үзэгдлийн (үхлийн дараах амьдрал) тухай мэдлэг хоёрдугаар үзэгдэлд бидэнд хэрхэн тусалдаг вэ?

- Тайзан дээр гарсан залуу хүн, хэн нь өөдгүй муу хүн эсвэл хэн нь баатар болохыг мэдэхгүй байлаа. Хэрэв бид амьдралдаа хэн нь өөдгүй муу хүмүүс, хэн нь баатрууд болохыг мэдэхгүй байвал, ямар асуудлууд гарч ирж болох вэ?
- Жүжгийн тухай мэдэхийн тулд залуу хүн юу хийсэн бэ? Бидний амьдралд “сануулах бичсэн үгс” ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?

2. Эцэг эхчүүдэд зориулсан зөвлөгөө

Алма 12:32-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Энэ шүлэг дэх *тэдэнд* гэдэг үг Адам Ева хоёрт холбогддогийг уншихын өмнө тайлбарла.

Адам Ева хоёр зарлигуудыг хүлээн авахдаа гэтэлгэлийн төлөвлөгөөний тухай өмнө нь мэддэг байсныг онцлон тэмдэглэ. Тэгээд дараах асуултуудыг асуу:

- Бид зарлигуудыг хүлээн авахдаа гэтэлгэлийн төлөвлөгөөний тухай мэдлэгтэй байх нь яагаад хэрэгтэй вэ? Заах энэ загварыг эцэг эхчүүд хүүхдүүдийнхээ тухайд хэрхэн баримталж болох вэ?

Зорилго

Алдар суугийн гурван хаант улс дахь мөнхийн өвийг анхааралтай авч үзэхэд нь ангийн гишүүдэд туслах, селестиел алдар сууг өвлөх боломжтой болох арга замаар амьдрах, түүнчлэн Тэнгэрлэг Эцэгийн оршихуйд гэр бүлээрээ хамт амьдрахад нь тэднийг урамшуулан дэмжих.

Бэлтгэл

1. Сургаал ба Гэрээ 76; 131; 132:19-24; 137-г залбирч судал.
2. *Ангийн гишүүний Судлах Удирдамж* (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Энэ материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа

Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг ангийн гишүүдэд товчхон сануул. Бидний мөнхийн оршихуйн гурван хэсэг: мөнх бус байдлын өмнөх амьдрал, мөнх бус амьдрал, үхлийн дараах амьдралыг ангийн гишүүд санахад анхаар.

Энэхүү товч дүгнэлтийн дараа хэрэв С ба Г 76, 131, 137 дахь илчлэлтүүд бидэнд байгаагүй бол амилуулагдсаны дараа бидний байдал ямар байх талаар бид маш бага мэдлэгтэй байх байсныг тайлбарла. Тэгээд С ба Г 76-д цэдэглэгдсэн, Сүмийн дөрөв дэх Ерөнхийлөгч Вилфорд Вудраффын дараах мэдэгдлийг хуваалц:

“Бидний өмнө нь уншсан аль ч бусад номонд агуулагддаг аливаа илчлэлтээс илүү их гэрлийг, илүү их үнэнийг, илүү зарчмыг өгсөн илчлэлт хэмээн би ‘Үзэгдлийг’ дангаар нь хэлнэ. Энэ нь бидний одоогийн нөхцөл, бид хаанаас ирсэн, яагаад энд байгаа бас эндээс хаашаа явах тухай бидний ойлголтыг тод томруун болгосон билээ. Энэ илчлэлтээр дамжуулан ямар ч хүн өөрийнх нь хувь тавилан, нөхцөл байдал ямар байхыг мэдэж болно” (*The Discourses of Willford Woodruff*, эмхтгэсэн Г.Хомер Дурхам [1946], 47-48).

Ярилцах ба хэрэгжүүлэх нь

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбиран сонгож ав. Хичээлийн төгсгөлд Селестиел хаант улсын тухай учир утгатайгаар ярилцахад хангалттай цаг үлдээхэд анхаар.

1. Алдар суугийн хаант улсууд ба “Христийн тухай гэрчлэл”

С ба Г 76:11-24, 40-43, 119-ийг зааж, ярилц.

- Ямар нөхцөл байдал С ба Г 76-д цэдэглэгдсэн үзэгдэл рүү хөтөлсөн бэ? (С ба Г 76:11-19-ийг үз; мөн С ба Г 76-гийн хэсгийн тоймыг үз. Хуудас

131 дээрх зураг Бошиглогч Иосеф Смит, Сидней Ригдон хоёр энэ үзэгдлийг хүлээн авсан өрөөг харуулсныг ажигла)

Үзэгдэл бүхэлдээ Есүс Христ болон Түүний хязгааргүй Цагаатгалын тухай гэрчилж байгааг онцлон тэмдэглэ. Уг үзэгдлийн тухай Иосеф Смитийн дүрслэл Аврагчийн тухай гэрчлэлээр эхэлж, үүгээр төгсдөг. С ба Г 76:20-24-ийг ангийн нэг гишүүнээр, С ба Г 76:119-ийг өөр нэг гишүүнээр чангаар уншуул. Та бас С ба Г 76:40-43-ыг ангийн гишүүдээр уншуулж болно.

Ихэнх хүмүүс амилуулагдсаныхаа дараа амьдрах алдар суугийн гурван хаант улс: Телестиел хаант улс, Террестриел хаант улс, Селестиел хаант улсыг Тэнгэрлэг Эцэг бий болгосныг Сургаал ба Гэрээ 76 харуулдаг. “Есүсийн тухай гэрчлэлийг хүлээн авсан” (С ба Г 76:51) байдал дээр тулгуурлагдсан аль нэг алдар суугийн хаант улсыг бид бүгд өвлөн авах болно. Энэ илчлэлтийг ярилцах үед уг ойлголтыг санахад ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

2. Мөхөл

С ба Г 76:25-39, 44-49-ийг зааж, ярилц. *Мөхөл* гэж самбар дээр бичсэнээр эхэл. *Мөхөл* гэдэг үг алдар суугийн хаант улсыг алдсан буюу устгалын байдлыг заадгийг тайлбарла. Үүнийг биеэр үзсэн хүмүүс “мөхлийн хөвгүүд” хэмээн нэрлэгддэг. Учир нь тэд Мөхөл гэгддэг Сатаныг дагадаг (С ба Г 76:25-26, 31-32). Энэ ярилцлагыг дэлгэрүүлэхээс зайлсхийж, товчхон байлгах, селестиел хаант улсын тухай энэ хичээлээр хожуу ярилцах хангалттай цаг үлдэхэд анхаар. Бусад сэдвийн нэгэн адил зөвхөн судруудад болон хожмын үеийн бошиглогчдын заасан зүйлст анхаарал төвлөрүүл.

- Люцифер Тэнгэр дэх Зөвлөл дээр бослого гаргаж, дэлхий рүү доош хаягдсан ажээ (Илчлэлт 12:7-9; С ба Г 29:36-37; 76:25-28; Мосе 4:1-3). Тэр хөөгдсөн үеэсээ юу хийж эхэлсэн бэ? (С ба Г 76:29; Мосе 4:4-ийг үз.) Бид Сатаны эсрэг дайнд ялахын тулд амьдралдаа юу хийж болох вэ? (Энэ асуултын зарим хариуг 1 Нифай 14:14; С ба Г 10:5; 27:15-18-аас үз)
- Мөхлийн хөвгүүдийн гай зовлонгийн талаар Их Эзэн юу илчилсэн бэ? (С ба Г 76:32-34, 36-38, 44-49.) Мөхлийн хөвгүүд яагаад ийм их гай зовлон үзэхээр зүхэгдсэн бэ? (С ба Г 76:30-31, 35-ыг үз. Ариун Сүнснийг үгүйсгэх нь ямар утга учиртай болох тухай тайлбарыг дараах эшлэлээс үз)

“Уучлагдашгүй нүгэл үйлдэхийн тулд хүн юу хийх ёстой вэ? Ариун Сүнснийг хүлээн авч, тэнгэрийг өөртөө нээлгэн Бурханыг мэддэг болсны дараа Түүний эсрэг нүгэл үйлдсэн байх ёстой. Хүн Ариун Сүнсний эсрэг нүгэл үйлдсэний дараа, түүний хувьд наманчлал гэж байдаггүй. Тэр нарыг харж байгаа атлаа нар гийхгүй байна гэж хэлдэг. Тэнгэр түүнд нээгдсэн байхад тэрээр Есүс Христийг үгүйсгэдэг, авралын төлөвлөгөөний үнэнд нүд нь нээгдсэн байтал тэр үүнийг үгүйсгэдэг. Ингээд тэр энэ үеэс эхлэн дайсан болдог” гэж Бошиглогч Иосеф Смит хэлжээ (*Teachings of the Prophet Joseph Smith*, эмхтгэсэн Жозеф Фиелдинг Смит [1976], 358).

3. Телестиел хаант улс

С ба Г 76:81-90, 98-106, 109-12-ыг зааж, ярилц. *Телестиел Хаант улс* гэж самбар дээр бичиж, хажууд нь од зурснаар эхэл. Телестиел хаант улс бол алдар суугийн хамгийн доод хаант улс болохыг тайлбарла. Их Эзэн энэ

хаант улсын алдар сууг оддын сүр жавхлантай зүйрлэсэн байна (С ба Г 76:81, 98; Коринт 15:40-41, түүний дотор Иосеф Смитийн орчуулга, зүүвэр тайлбар 40а-г үз).

- Телестиел хаант улсыг хэн өвлөх вэ? (С ба Г 76:81-83, 98-101, 103-ыг үз)
- Телестиел хаант улсыг өвлөх хүмүүст ямар болзол эсвэл ямар хязгаарлалтууд тавигдах вэ? (С ба Г 76:84-86, 102, 104-6, 112-ыг үз.)

Шүлэг 84, 106 дахь “там” гэдэг үг бол сүнсний шорон, үхэл, амилуулалтын хоорондох түр зуурын байдал гэдгийг та тайлбарлах хэрэгтэй байж болно. Сайн мэдээг хүлээн аваагүй, сүнсний шорон дахь эдгээр хүмүүс эцэстээ амилуулагдаж, Телестиел алдар сууг өвлөх болно. Шүлэг 85, 106-г, мөн Судруудын Удирдамж дахь *там* гэдэг үгийн тодорхойлолтын хоёр дахь догол мөрийг ангийн гишүүдээр уншуул (хуудас 185 дээрх эхний бүтэн догол мөр).

4. Террестриел хаант улс

С ба Г 76:71-80, 91, 97-г зааж, ярилц. *Террестриел Хаант улс* гэж самбар дээр бичиж, хажууд нь сар зурснаар эхэл. Их Эзэн террестриел хаант улсын алдар сууг сарны сүр жавхлантай зүйрлэснийг тайлбарла (С ба Г 76:78, 97; мөн 1 Коринт 15:40-41-ийг үз).

- Террестриел хаант улсыг хэн өвлөх вэ? (С ба Г 76:71-75, 79-ийг үз. Эдгээр шүлгүүдийг ойлгоход нь ангийн гишүүдэд туслахын тулд дараах эшлэлийг хуваалц)

“Террестриел хаант улсыг өвлөх хувь тавилантай хүмүүс бол: (1) ‘хуульгүйгээр’ нас барсан хүмүүс—энэ амьдралд сайн мэдээг сонсоогүй бөгөөд үнэн Бурханыг мэддэггүй хүмүүс, бөө мөргөлтнүүд, мөн бүх зүрх сэтгэлээрээ сайн мэдээг хүлээн аваагүй боловч, үүнийг сонсох ёстой хүмүүс; (2) энэ амьдралд сайн мэдээг сонсоод, эсэргүүцсэн боловч сүнсний дэлхийд сайн мэдээг хүлээн авсан хүмүүс; (3) ‘хүмүүний башир аргаар харалган болсон, дэлхийн алдар хүндтэй хүмүүс’; (4) гэрчлэлтэй боловч бүх зүйлд үнэнч, итгэлтэй байдаггүй, үнэн Сүмийн хайхрамжгүй гишүүд юм” хэмээн Арванхоёрын Чуулгын Ахлагч Брус Р.МкКонки тайлбарлажээ (*A New Witness for the Articles of Faith* [1985], 146).

- Террестриел хаант улсыг өвлөх хүмүүст ямар болзол буюу хязгаарлалтууд тавигдах вэ? (С ба Г 76:76-78-ыг үз)
- Бид “хүмүүний башир аргаар харалган” болохоос өөрсдийгөө хэрхэн хол байлгаж чадах вэ? (Энэ асуултын зарим хариултыг Ефес 4:11-15; 1 Нифай 15:24; Хиламан 5:12; С ба Г 3:78; 21:4-6; 52:14-20-иос үз)

5. Селестиел хаант улс

С ба Г 76:50-70, 92-96; 131:1-4; 132:19-24; 137-г зааж, ярилц. *Селестиел Хаант улс* гэж самбар дээр бичиж, хажууд нь нар зур. Селестиел хаант улс бол алдар суугийн хамгийн дээд хаант улс гэдгийг тайлбарла. Их Эзэн Селестиел хаант улсын алдар сууг нарны сүр жавхлантай зүйрлэжээ (С ба Г 76:70, 78, 96; мөн 1 Коринт 15:40-41-ийг үз).

- Селестиел хаант улсыг хэн өвлөх вэ? (С ба Г 76:50-53, 68-69-ийг үз. Шүлэг 53-ыг ойлгоход нь ангийн гишүүдэд туслахын тулд, та Амлалтын

Ариун Сүнс бол бидний хүлээн авсан санваарын ёслолууд, бидний хийсэн гэрээнүүд Бурханы хувьд хүлээн зөвшөөрөхүйц байгааг баталдаг Ариун Сүнс юм гэдгийг тайлбарлахыг хүсч болно. Энэхүү баталгаа нь бидний итгэл бишрэлээс хамааралтай байдаг)

- С ба Г 76 дахь үзэгдэл илчлэгдсэнээс хойш дөрвөн жил орчмын дараа Иосеф Смит ах Алвиныгаа Селестиел хаант улсад байгааг нь харсан үзэгдэл хүлээн авчээ (С ба Г 137:1-5). Алвин 1823 онд Сүм сэргээгдэхээс өмнө нас барсан ажээ. Алвиныг селестиел хаант улсад харснаас Иосеф юу мэдсэн бэ? (С ба Г 137:7-9-ийг үз) Селестиел алдар сууг ямар хүмүүс өвлөх талаар Бошиглогч өөр юу мэдсэн бэ? (С ба Г 137:10-ыг үз.) Эдгээр үнэнүүд бидэнд тайтгарлыг хэрхэн авчирч болох вэ?
- Хэрэв бид селестиел хаант улсыг өвлөвөл, ямар адислалууд хүлээн авах вэ? (С ба Г 76:54-67, 94-95.)
- Бид нас барсныхаа дараа өвлөн авах хаант улсыг Есүсийн тухай гэрчлэл хэрхэн тодорхойлдог вэ? (С ба Г 76:31, 35 [мөхөл]; С ба Г 76:82, 101 [телестиел]; С ба Г 76:79 [террестриел]; С ба Г 76:51-53, 69; 121:29 [селестиел]-ийг үз.) “Есүсийн тухай гэрчлэлд зоригтой” байх (С ба Г 76:79) гэдэг нь таны хувьд ямар учир утгатай вэ?

Ангийн гишүүдийн хариултыг ярилцахаас гадна та Ахлагч Брус Р.МкКонкийн дараах үгсийг хуваалцаж болно:

“Есүсийн тухай гэрчлэлд зоригтой байх гэж юу гэсэн үг вэ?

“ Энэ бол дэлхийтэй тэмцэхэд зоригтой, зоримог байх; бүх хүч чадал, эрч хүч болон чадвараа ашиглах; итгэл бишрэлийн зөв тэмцлээр тэмцэх явдал мөн. . . . Зөв шударга ёсны зарчимд зоригтой байхын агуу эх сурвалж нь сайн мэдээний бүхий л хуулинд дуулгавартай байх явдал мөн.

“Есүсийн тухай гэрчлэлд зоригтой байх нь ‘Христэд ирэх, мөн түүгээр төгөлдөржих’ явдал мөн. Энэ бол ‘бүх бурханлиг бусаас өөрсдөө татгалзаж,’ улмаар ‘Бурханыг өөрсдийн бүх хүч, оюун, мөн чадлаар хайрлах’ (Моронай 10:32) явдал мөн.

“Есүсийн тухай гэрчлэлд зоригтой байх нь Христ болон түүний сайн мэдээнд гуйвшгүй итгэл бишрэлээр итгэх явдал мөн. Энэ бол дэлхий дээрх Их Эзэний ажлын үнэн болоод бурханлиг шинж чанарыг мэдэх явдал мөн.

“Гэвч энэ нь бүгд бус. Энэ бол итгэх болон мэдэхээс илүү зүйл. Бид үгийг зөвхөн сонсогчид биш, харин хэрэгжүүлэгчид байх ёстой. Энэ бол зөвхөн ярих биш; энэ бол Аврагч бурханлиг Хүү болохыг зүгээр л амаараа хүлээн зөвшөөрөх явдал биш. Энэ бол дуулгавартай байдал, хувь хүний тохирол болон зөв шударга зан төлөв мөн. . .

“ Есүсийн тухай гэрчлэлд зоригтой байх нь ‘найдварын төгс гэрэлтэйгээр, мөн Бурханыг болон бүх хүмүүнийг хайрлах хайрыг агуулан, Христэд тууштайгаар итгэн урагш тэмүүлэх’ явдал мөн. Энэ бол ‘эцсийг хүртэл тэвчих’ (2 Нифай 31:20) явдал мөн. Энэ бол бид сүсэг бишрэлээрээ амьдран, номлодог зүйлээ практикт хэрэгжүүлж, зарлигуудыг сахих явдал мөн. Энэ бол хүмүүний амьдралд ‘цэвэр сүсэг бишрэлийг’ харуулах явдал мөн. Энэ бол ‘зовж зүдрэх цагт нь өнчин хүмүүс, бэлэвсэн эхнэрүүдийг эргэн тойрч,’ өөрсдийгөө ‘дэлхийгээс бохирдуулалгүй’ (Иаков 1:27) байлгах явдал мөн.

“Есүсийн тухай гэрчлэлд зоригтой байх нь бид хүслээ хазаарлаж, дур таашаалаа хянан, дэлхийн болон хилэнцэт зүйлсийн дээгүүр гарах явдал мөн. Энэ бол бидний Эцэгийн бүх хүүхдүүдээс хамгийн зоригтой нь байсан түүний, мөн бидний даган дуурайх загвар болсон Түүний нэгэн адилаар дэлхийг ялах явдал мөн. Энэ бол ёс суртахууны хувьд цэвэр ариун байх, аравны нэг болон өргөлөө төлдөг байх, Хүндэтгэлийн өдрийг дээдлэн сахидаг байх, зүрх сэтгэлийн бүрэн зорилготойгоор залбирдаг байх, хэрэв ийнхүү үйлдэхээр дуудагдсан бол бид бие сэтгэл бүхнээ тахилын ширээн дээр тавих явдал мөн.

“ Есүсийн тухай гэрчлэлд зоригтой байх нь юм болгоноор Их Эзэний талд байна гэсэн үг юм. Энэ бол тэрээр санал өгдөг байсны адилаар түүнд санал өгөх явдал мөн. Энэ бол түүний боддогийг бодож, түүний итгэдэгт итгэн, түүний хэлж болохыг хэлж, яг ижил нөхцөл байдалд түүний хийж болохыг хийх явдал мөн. Энэ бол Есүсийн оюун ухаантай байж, тэрээр Эцэгтэйгээ нэг байсны адилаар, түүнтэй нэг байх явдал мөн” (In Conference Report, 1974 оны аравдугаар сар, 45-46; *Ensign*, 1974 оны арваннэгдүгээр сар, 35).

- С ба Г 76 дахь үзэгдэл илчлэгдсэнээс хойш арваннэгэн жилийн дараа Селестиел хаант улсын дотор гурван зэрэглэл байдгийг Бошиглогч Иосеф заажээ (С ба Г 131:1). Селестиел хаант улсын хамгийн дээд зэрэглэлд хэн өргөмжлөгдөх вэ? (С ба Г 131:1-3; 132:19-ийг үз.)
- Зөвхөн Селестиел хаант улсын хамгийн дээд зэрэглэлд өргөмжлөх хүмүүст ямар адислал боломжтой вэ? (С ба Г 131:4; 132:19-20-ийг үз. “Өсөн нэмэгдэх,” “үүрд мөнхөд үр удмынх нь үргэлжлэл” гэсэн нийлэмж үгс нь, гэрээгээр амьдардаг бөгөөд селестиел хаант улсын хамгийн дээд зэрэглэлд өргөмжлөгдөх хүмүүс үүрд мөнхөд сүнсэн хүүхдүүд байх болно гэсэн утгатайг та тайлбарлахыг хүсч болно)
- Арванхоёрын Чуулгын Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит: “ Сургаал ба Гэрээний хэсэг 76-г . . . Сүмийн бүх гишүүд үнэлж баршгүй өв болгож, эрхэмлэн дээдлэх ёстой. Энэ хэсэг тэдний итгэлийг бэхжүүлж, үнэнч шударга бүх хүмүүст амлагдсан өргөмжлөлийг эрэлхийлэхэд тэдэнд хөшүүрэг болох ёстой” хэмээн хэлжээ (*Church History and Modern Revelation*, 2 боть, [1953], 1:279). Энэ илчлэлт бидний итгэлийг хэрхэн бэхжүүлж, өргөмжлөлийг эрэлхийлэхэд бидэнд хэрхэн сүнслэгээр нөлөөлж чадах вэ? Бид Селестиел алдар суугийн төлөө хичээн чармайх үед өөрсдийхөө мэдэрч болох аливаа цөхрөлийг хэрхэн даван туулж чадах вэ?

Дүгнэлт

Селестиел хаант улс дахь өргөмжлөлийн агуу адислалууд бүх хүмүүст боломжтойг онцлон тэмдэглэ. Есүс Христээр дамжин бид бүгд Селестиел хаант улсын хамгийн дээд зэрэглэлд гэр бүлтэйгээ хамт өргөмжлөгдөж чадна. Бид энэхүү агуу адислалыг хүлээн авч чадахын тулд зарлигуудыг сахиж, авралын ёслолуудыг хүлээн авахад С ба Г 76 дахь илчлэлт биднийг урамшуулан дэмждэг.

Сүнсээр өдөөгдсөний дагуу хичээлийн үеэр ярилцсан үнэнүүдийн тухай гэрчил.

Нэмэлт заах санаа Ангийг дөрвөн бүлэгт хуваа. Дараах судрын хэсгүүдийн аль нэгийг бүлэг бүрд даалга. Судрын хэсгүүдийг уншиж ярилцах цагийг бүлгүүдэд өг. Хичээлийн үед тохиромжтой цагаар, даалгасан хэсгүүдээс юу мэдсэнийг нь бүлгүүдээр хуваалцуул.

С ба Г 76:25-49 (мөхөл)

С ба Г 76:81-86, 88-90, 98-112 (Телестиел алдар суу)

С ба Г 76:71-80, 87, 91, 97 (Террестриел алдар суу)

С ба Г 76:50-70, 92-96 (Селестиел алдар суу)



Жон Жонсоны Гэр. Бошиглогч Иосеф Смит, Сидней Ригдон хоёр энэ гэрт Библийн орчуулга дээр ажиллаж байхдаа эдүгээ С ба Г 76-д цэдэглэгдсэн илчлэлтийг бусад илчлэлтүүдийн хамт хүлээн авчээ.

“Их Эзэний Аугаа өдөр ирэхийг хүсэн хүлээх нь”

Зорилго

Хоёр дахь Ирэлтийн зорилгыг ойлгож, танихад, мөн “Их Эзэний аугаа өдөр ирэхэд” (С ба Г 45:39) бэлтгэхэд нь ангийн гишүүдэд туслах.

Бэлтгэл

1. Сургаал ба Гэрээ 29:9-29; 34:5-12; 45:16-75; 88:86-99; 101:22-34; 133; түүнчлэн энэ хичээлийн бусад судрыг залбирч, судал.
2. *Ангийн гишүүний Судлах Удирдамж* (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.
3. Хэрэв Хоёр дахь Ирэлтийн зураг байвал, хичээл дээр ашиглахаар бэлтгэ (62562; Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 238).
4. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах бол дараах бэлтгэлийг ханга:
 - а. Дээр дурдсан зургаас гадна дараах зургуудыг ашиглахаар бэлтгэ: Христийн Төрөлт (62116; Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 200); Гетсеманид залбирч байгаа Есүс (62175; Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 227); Цовдлолт (62505; Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 230).
 - б. “Jesus, Once of Humble Birth” (*Дууллууд*, д. 196) дууллыг ангийн гишүүдээр дуулуулахаар бэлтгэ. Эсвэл ангийн нэг гишүүнээр буюу ангийн хэсэг гишүүдээр дуулуулахаар бэлтгэ.

Багшид өгөх анхааруулга: Та энэ хичээлийг заахдаа Сургаал ба Гэрээн дэх Их Эзэний илчлэгдсэн үгст анхаарал төвлөрүүл. Хоёр дахь Ирэлтийн цаг мэтийн тодорхой биш асуудлуудыг бүү ярилц.

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа

Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

Есүсийн төрөлт, Цагаатгал, Хоёр дахь Ирэлтийн зургуудыг үзүүл (“Бэлтгэл,” зүйл 3, 4а-г үз).

“Jesus, Once of Humble Birth” дууллыг ангийн гишүүдээр дуулуулах буюу даалгавар авсан ангийн нэг гишүүн эсвэл хэсэг гишүүдээс уг дууллыг дуулахыг хүс. Дууллын үг болон үзүүлсэн зургуудынхаа хоорондын уялдаа холбоог эрж олохыг ангийн гишүүдээс хүс.

Дууллын дараа, Есүс Христийн төрөлт болон Түүний Хоёр дахь Ирэлт бол дэлхийн түүхэн дэх хамгийн алдар суутай хоёр үйл явдал болохыг тайлбарла. Аврагч дэлхийд анх ирэхдээ даруухан нөхцөлд байсан бөгөөд Мессиа болох нь ерөнхийдөө танигдаагүй юм. Гэвч Тэрбээр хоёр дахь удаад сүр

хүч агуу алдар суутайгаар ирнэ. Энэ хичээл бол Аврагчийн Хоёр дахь Ирэлт, дэлхий дээрх Түүний мянган жилийн хаанчлалын тухай юм.

Ярилцах ба
хэрэгжүүлэх нь

Энэ хичээл нэг хичээлээр заах боломжтойгоос илүү их материалыг агуулдаг. Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбиран сонгож ав.

1. Аврагч сүр хүч, алдар суутайгаар дэлхийд эргэж ирнэ

Хоёр дахь Ирэлт, үүний өмнө тохиох үйл явдлуудын тухай, Аврагчийг дахин ирэхэд эхлэх амар амгалангийн мянган жилийн тухай агуу үнэнүүдийг хожмын үеийн илчлэлт бидэнд зааж байгаа цаг хугацааны бүрэн байдлын эрин үед аж төрөх онцгой боломж бидэнд тохиосныг тайлбарла. Эдгээр чухал сэдвүүдийн талаар Сургаал ба Гэрээнд арвин их мэдээлэл байдаг.

Аврагчийн төрөлттэй холбоотой бүх бошиглол биелэгдсэний нэгэн адил, Түүний Хоёр дахь Ирэлттэй холбоотой бошиглол бүхэн бас биелэгдэх болно. Ангийн гишүүдтэй хамт уншихын тулд дараах бошиглуудаас заримыг нь сонгож ав. Аврагчийн Хоёр дахь Ирэлтийн тухай хэсэг бүр нь юу зааж байгааг ярилц. Мэдээллийг самбар дээр нэгтгэн дүгнэ. Та ангийг жижиг бүлгүүдэд хувааж, бүлэг бүрд тодорхой хэсгүүдийг даалган судлуулж, илтгэхийг хүсч болно. Эсвэл та судрын тодорхой хэсгүүдийг судалж, илтгэхийг зарим гишүүдэд нэр заан даалгаж болно.

- а. С ба Г 29:9-11; 45:44. (Есүс сүр хүч, алдар суутайгаар дэлхийд ирнэ. Бардамнагчид, ёс бусчууд шатаагдаж, ёс бус явдал дэлхий дээр байхгүй болно)
- б. С ба Г 34:7, 12; 43:17; 110:16. (Хоёр дахь Ирэлт ойрхон байна)
- в. С ба Г 34:8, 11; 63:34. (Аврагчийг ирэхэд бүх үндэстнүүд дагжин чичирнэ. Хэрэв бид итгэлтэй байвал, Түүний хүч, Түүнийг иртэл бидэнд байна)
- г. С ба Г 45:45-54; 88:96-99. (Нас барсан Гэгээнтнүүд амилуулагдаж, Аврагчийг угтахаар гарч ирнэ. Дэлхий дээр амьд байгаа Гэгээнтнүүд Түүнийг угтахаар цугларна. Түүнийг Чидуны Уулан дээр гарахаар ирэхэд энэ уул хуваагдана. Иудейчүүд Аврагчаа таньж, Түүнийг мөрдөн хавчиж байснаа мэдээд уйлах болно. Дараа нь сүнсний шоронд сайн мэдээг хүлээн авсан хүмүүс амилуулагдана)
- д. С ба Г 49:6. (Аврагч бүх дайснаа өвдөг дороо сөхрүүлнэ)
- е. С ба Г 49:7. (Нэг ч хүн, тэр ч байтугай, тэнгэр элчүүд ч Аврагчийн ирэх өдөр, цагийг мэдэхгүй)
- ё. С ба Г 133:46-53. (Аврагч улаан хувцастай ирнэ. Түүний ирэлт нь ёс бусчуудаас өшөө авах цаг, зөв шударга хүмүүсийн гэтэлгэлийн цаг байх болно)

2. Мянган Жил баяр баясал, амар амгалангийн үе байх болно.

Аврагч Хоёр дахь Ирэлт нь Мянган Жил хэмээн нэрлэгддэг нэг мянган жилийн хугацааг эхлүүлнэ. Энэ үед “Христ дэлхий дээр өөрийн биеэр хаанчилна.” бас “дэлхий шинэчлэгдэж, диваажингийн алдар суугаа хүлээн авах болно” гэж итгэлийн арав дахь тунхагт тунхаглажээ. Сургаал ба Гэрээ 101-д Мянган Жилийн үед бидний хүсэн хүлээж болох сайн сайхан байдал, баяр хөөрийг дүрсэлдэг.

- Мянган жилийн үед дэлхий дээрх амьдрал ямархуу байх вэ?

Энэ асуултанд хариулахын тулд судрын хэсгүүдээс ангийн гишүүдтэй хамт уншихын тулд заримыг нь сонгож ав. Мянган жилийн тухай хэсэг бүр нь юу зааж байгааг ярилц. Мэдээллийг самбар дээр нэгтгэн дүгнэ. Та ангийг жижиг бүлгүүдэд хувааж, даалгасан судрын хэсгүүдийг судалж, илтгэхийг бүлэг бүрээс хүсч болно. Эсвэл та эдгээр хэсгүүдийг судалж, илтгэхээр зарим гишүүдийг нэр заан томилж болно.

- а. С ба Г 101:23. (Хүн бүр Аврагчийг харах боломжтой байна)
 - б. С ба Г 101:24. (Ёс бусчууд бүгдээрээ устгагдана)
 - в. С ба Г 101:25. (Дэлхий шинэчлэгдэнэ)
 - г. С ба Г 101:26. (Хүмүүс болон амьтад амар амгалан амьдрах болно)
 - д. С ба Г 101:27. (Зөв шударгаар хүссэн зүйл нь хүмүүст биелэгдэнэ)
 - е. С ба Г 101:28; мөн С ба Г 45:55; 88:110-ыг үз. (Сатан хүлэгдэж, хэнийг ч уруу татах хүчгүй болно)
 - ё. С ба Г 101:29. (Уй гашуу, үхэл хагацал байхгүй болно)
 - ж. С ба Г 101:30-31. (Хүн өндөр насалж, дараа нь мөнх бус байдлаас үхэшгүй байдалд хурдан шилжинэ)
 - з. С ба Г 101:32-34. (Газар, тэнгэрийн тухай бүх зүйлийг, түүний дотор дэлхий хэрхэн бүтээгдсэн болон газар ямар болох тухай Их Эзэн бүх зүйлийг илчилнэ)
 - и. С ба Г 45:58. (Хүүхдүүд нүгэлгүйгээр өснө)
 - й. С ба Г 45:59; 133:25. (Бүх дэлхийд Их Эзэн хаан, хууль тогтоогч болно)
- Мянган жилдээ тухай энэ мэдлэг эдүгээ бидний амьдралд хэрхэн адислал болж чадах вэ? Зөв шударга ёс эцсийн бүлэгт ёс бус явдлыг ялна гэдгийг мэдэхэд энэ мэдлэг та нарт хэрхэн тусалдаг вэ?

3. Бид Хоёр дахь Ирэлтэд бэлтгэх ёстой

Бид Түүний ирэлтэд бэлтгэх ёстойг Их Эзэн удаа дараа онцлон тэмдэглэсэн байдаг (С ба Г 133:4, 10-11). Зарим хүмүүс өөрсдийгөө хэзээ ч хангалттай сайн байдаггүй эсвэл зохих ёсоор хангалттай сайн бэлтгэж огт чаддаггүй гэж боддог байж болох юм. Ийм хүмүүс зориг нь мохож, ийн бэлтгэх нь боломжгүй гэж бодож болно. Гэвч, бид өдөр тутмын амьдралынхаа хэсэг болгон энэ чухал үйл явдалд бэлтгэж болно гэдгийг заахын тулд Их Эзэн Сургаал ба Гэрээн дэх зөвлөгөөг бидэнд өгсөн билээ.

- Бид Хоёр дахь Ирэлтэд одоо бэлтгэхийн тулд амьдралдаа юу хийж болох вэ? (Дараах мэдээллийг ярилцлагад ашиглах буюу ангийн гишүүдийн хариулт дээр нэмэхийн тулд ашигла)

Аврагчийн ирэлтийн тэмдгүүдийг ажигла

Түүний Хоёр дахь Ирэлтийн өмнө тохиох олон тэмдгийг Их Эзэн Сургаал ба Гэрээнд илчилснийг, бас “сонор сэргэг” (С ба Г 61:38) байхыг бидэнд урамшуулан дэмжсэнийг тайлбарла.

- Аврагчийн Хоёр дахь Ирэлтийн өмнө тохиох тэмдгүүдийн тухай мэдэх нь яагаад бидэнд чухал вэ? С ба Г 45:36-39 ангийн гишүүдтэй хамт унш. Эдгээр тэмдгүүд яагаад бидэнд өгөгдсөн талаар бид энэ сургаалт зүйрлэлээс юу мэдэж болох вэ?
- Аврагчийн Хоёр дахь Ирэлтийн өмнө тохионо хэмээн бошиглогдсон ямар тэмдгүүд байдаг вэ?

Энэ асуултанд хариулахын тулд гишүүдтэй хамт уншихаар дараах судрын хэсгүүдээс заримыг нь сонгож ав. Хэсэг бүрд дурдсан тэмдгүүдийг нэрлэ. Тэмдгүүдийг *Эерэг тэмдгүүд*, *Сөрөг тэмдгүүд* гэсэн хоёр гарчгийн дор самбар дээр нэгтгэн дүгнэ. Ангийн хоёр жижиг бүлэгт хувааж, даалгагдсан судрын хэсгүүдийг судалж, илтгэхийг та хэсэг бүрд даалгаж болно. Эсвэл судрын хэсгүүдийг судалж, илтгэх гишүүдийг нэр заан томилж болно.

Эерэг тэмдгүүд

- а. С ба Г 45:9; 133:57-58 (Сайн мэдээний бүрэн байдал сэргээгдэнэ)
- б. С ба Г 45:66-71. (Шинэ Иерусалим баригдах болно. Энэ нь эцсийн өдрүүдэд зөв шударга хүмүүсийн хувьд амар амгалан, аюулгүй байдлын газар байна)
- в. С ба Г 65:2-6. (Бурханы хаант улс дэлхий дээр байгуулагдана)
- г. С ба Г 110:11-16. (Санваарын түлхүүрүүд сэргээгдэнэ)
- д. С ба Г 133:8-9, 36-39. (Сайн мэдээ дэлхий даяар номлогдоно)

Сөрөг тэмдгүүд

- а. С ба Г 29:15; 88:91. (Үлэмж их гашуудал, цөхрөл, айдас байх болно. Хүмүүний зүрх сэтгэл мохно)
- б. С ба Г 29:16; 45:31; 112:24. (Өлсгөлөн, гай зовлон, өвчин эмгэг, эзгүйрэл байх болно)
- в. С ба Г 34:9; 45:40-42; 88:87. (Тэмдгүүд болон гайхамшгууд тэнгэрт бас газарт байх болно)
- г. С ба Г 45:26; 63:33. (Дайнууд, дайны тухай цуурхлууд гарна, мөн дэлхий бүхэлдээ үймээн самуунд автагдана)
- д. С ба Г 45:27. (Хүмүүний хайр хөрч, алдас газар авна)
- е. С ба Г 45:33; 88:89-90. (Газар хөдлөлт, хүчтэй салхи, далайн асар их давалгаа байх болно. Хүмүүс Бурханы эсрэг зүрх сэтгэлээ хатууруулж, бие биенийхээ эсрэг тулалдана)

Эдгээр бошиглолын зарим нь аль хэдийн биелэгдснийг, зарим нь биелэгдэх явцдаа байгааг, бас зарим нь биелэгдэхээр хүлээгдэж байгааг хэл.

- Эцсийн өдрүүдийн гай зовлон дунд “бүү тэвдэн сандар” (С ба Г 45:35) гэж Их Эзэн бидэнд зөвлөсөн билээ. Бид эцсийн өдрүүдийн ёс бус явдал, гай зовлонгоор хүрээлэгдсэн үед хэрхэн найдвараа хадгалж, сэтгэл санаагаар унахаас зайлсхийж чадах вэ? (С ба Г 38:30-ийг үз.)

Ариун газруудад бай

Хоёр дахь Ирэлтийн тэмдгүүдийн талаар сонор сэргэг байхыг Их Эзэн бидэнд зөвлөснөөс гадна бас зөв шударга байснаар бэлтгэхийг зөвлөсөн билээ. Ангийн гишүүдтэй хамт уншихын тулд дараах судрын хэсгүүдээс заримыг нь сонго. Аврагчийн Хоёр дахь Ирэлтийн тухай хэсэг бүр нь юу зааж байгааг ярилц. Мэдээллийг самбар дээр нэгтгэн дүгнэ.

- а. С ба Г 27:15; 33:17. (Зөв шударга байдалд гуйвшгүй бай)
- б. С ба Г 34:6; 39:19-20; 43:20-23. (Наманчлалыг тунхагладаг бас наманчилдаг бай.) Хоёр дахь Ирэлтэд бэлтгэхэд наманчлал яагаад чухал вэ?
- в. С ба Г 45:32; 87:8; 101:22-23. (Ариун газруудад бай) “Ариун газруудад бай гэдэг нь юу гэсэн үг вэ”? Эдгээр ариун газруудаас заримыг нь нэрлэнэ

үү. (Манай ариун сүмүүд, ариун ёслолын байрнууд, бидний гэр орон, Сионы гадаснууд бол ариун газар мөн.) Бид бүхэн дэлхийн орчинд ч гэсэн, өөрсдийгөө зохистой, цэвэр ариун байлгахын тулд юу хийж чадах вэ?

г. С ба Г 45:56-57. (Ариун Сүнснийг хөтчөө болго)

“Та Хоёр дахь Ирэлтэд хэрхэн бэлтгэдэг вэ? Та энэ тухайд санаа зовсны хэрэггүй. Хоёр дахь Ирэлт маргааш ирлээ гэхэд та түүнд бэлэн байх тийм л байдлаар амьдар. Хоёр дахь Ирэлт хэзээ тохиохыг хэн ч мэдэхгүй. . . Бидний үүрэг хариуцлага бол өөрсдийгөө бэлтгэх, Аврагчтай нийцэн зохистойгоор амьдрах явдал юм. Хэрэв Тэр бидний дунд хүрээд ирвэл ичиж зовохгүй байх тийм л байдлаар бид өөрсдийгөө авч явах ёстой. Энэ бол өнөө үед, бас урт удаан хугацаанд байх зорилт мөн” гэж Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли сургажээ (*Church News*, 1999 оны 1-р сар, 2).

Арванхоёрын Чуулгын Ахлагч Бойд К.Пакер дараах зөвлөгөөг өгчээ:

“Өсвөр насныхан зарим үед, ‘Юунд хэрэгтэй юм бэ? Дэлхий удахгүй юу ч үгүй сөнөж, төгсгөл ирэх юм чинь’ гэж боддог. Ийм мэдрэмж итгэлээс бус, айдсаас ирдэг. цаг, өдрийг хэн ч мэдэхгүй (С ба Г 49:7-г үз), гэвч Их Эзэний бүх зорилго биелэгдэх хүртэл төгсгөл ирэхгүй. Илчлэлтүүд болон амьдралын туршлагаасаа би олон юм сурсан хүн. Урт удаан амьдралд анхааралтайгаар бэлтгэх цаг хугацаа та нарт хангалттай байгааг энэ бүхэн надад итгүүлсэн билээ.

“Нэг л өдөр өсвөр насны үр хүүхэдтэйгээ ажиллах цаг та нарт ирнэ. Энэ нь та нарыг тойрч гарахгүй, харин дайрч гарах болно. Хожим нь та нар ач зээ нараа эрхлүүлэх болно. Тэд ч бас ач зээ нараа эрхлүүлнэ. Хэрэв хэн нэгэнд нь төгсгөл эрт ирэх аваас, харин ч энэ нь түүний хувьд зөв юмсыг хийх бүр ч чухал шалтгаан болно” (In Conference Report, 1989 оны 4-р сар, 72; *Ensign*, 1989 оны 5-р сар, 59).

Дүгнэлт

Дэлхийн түүхэн дэх аль ч бусад үеэс илүү их мэдээллийг Их Эзэн Хоёр дахь Ирэлт болоод Мянган Жилийн тухай бидэнд илчилснийг хэл. Түүний бошиг-полууд хаа сайгүй биелэгдэж байгаа болохоор бид энэ мэдээллийн тусламжтайгаар бэлтгэж, зөв шударга байдалд гуйвшгүй тууштай байж чадна. Аврагч эргэж ирэн, амар амгалангийн болон зөв шударга ёсны мянган жилийн хаанчлалын үеийг эхлэхийг бид баяр баясгалантайгаар хүсэн хүлээх ёстой.

Сүнсээр өдөөгдсөний дагуу хичээлийн үеэр ярилцсан үнэнүүдийн тухай гэрчил.

Нэмэлт заах санаанууд

Зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр дараах материал нэмэгдэж байна. Та хичээлийн нэг хэсэг болгож, эдгээр санаануудаас нэгийг эсвэл хоёрыг нь ашиглаж болно.

1. Улаан буудай ба зэрлэг өвсний тухай сургаалт зүйрлэл

Сургаал ба Гэрээ 86-д Хоёр дахь Ирэлтийн тухай нэмэлт ойлголт байдаг. Улаан буудай ба зэрлэг өвсний тухай сургаалт зүйрлэлийн зарим утгыг тодруулсан нэг илчлэлийг Иосеф Смит хүлээж авсан юм. Эл илчлэлийг судрын энэ хэсэгт цэдэглэсэн байдаг. Аврагч мөнх бус үйлчлэлийнхээ үед өмнө нь энэ сургаалт зүйрлэлийг өгчээ (Матай 13:24-30).

- С ба Г 86 дахь сургаалт зүйрлэлийг ангийн гишүүдтэй хамт нэгтгэн дүгнэ. Энэ сургаалт зүйрлэлийн бүрэлдэхүүн хэсгүүд юуг төлөөлдөг вэ?

Их Эзэний үйлчлэгчид бол сайн үр таригчид юм. Харин Сатан болон түүний дагалдагчид бол зэрлэг өвс таригчид. Сайн үр нь Есүсийн дагалдагчдыг төлөөлдөг. Харин зэрлэг өвснүүд нь хилэнцэд найр тавин бууж өгдөг хүмүүсийг төлөөлдөг. Улаан буудай болон зэрлэг өвснүүдийг дэлхийн төгсгөл хүртэл хамт ургахыг зөвшөөрдөг. Тэр үед зөв шударга хүмүүс ёс бусчуудын дундаас цуглуулагдаж, ёс бусчууд шатаагдана.

- Энэ сургаалт зүйрлэл Хоёр дахь Ирэлттэй холбоотой үйл явдлуудын тухай бидэнд юу заадаг вэ?

2. Видео танилцуулга

Хэрэв видео хуурцаг *Teachings from the Doctrine and Covenants and Church History* (53933) байвал, дараах хэсгүүдийн нэгийг буюу хоёуланг нь үзүүлэхийг бод:

“Бүү тэвдэн сандар” (таван минут). Эцсийн өдрүүдэд тохиох гай гамшгаас айх буюу тэвдэн сандрах хэрэггүйг ойлгоход энэ видео ангийн гишүүдэд тусалж чадна. Хэрэв та энэ видеог үзүүлэх бол, хичээлийн гурав дахь хэсгийн үеэр үзүүл...

“Мэргэн хүмүүс” (зургаан минут). Энэ видео арван онгон охины тухай Аврагчийн сургаалт зүйрлэлийг үзүүлдэг (Матай 25:1-13; мөн С ба Г 45:56-59-ийг үз). Хэрэв та үүнийг үзүүлэх бол, хичээлийн гурав дахь хэсгийн үеэр үзүүл.

“Мэргэн хүмүүс” видеог үзүүлэхийн өмнө, арван онгон охины тухай сургаалт зүйрлэл эртний Иудейн хуримын зан үйл дээр тулгуурласныг тайлбарла. Есүсийн үед, хүргэн болон түүний найз нар бэрийг гэрээс нь хүргэний гэрт хүртэл дагалдан явдаг байжээ. Замын дагуу бэрийн найз нар тэдэнтэй нэгдэхээр хүлээж байдаг байв. Тэд хүргэний гэрт ирээд, хурим найранд бүгдээрээ дотогшоо ордог байв. Хурим нь ихэвчлэн үдэш болдог байсан учир бэрийг хүлээж байсан хүмүүс тосоор асдаг жижигхэн дэнлүүнүүд барьж явдаг байж. Уг сургаалт зүйрлэлд хүргэн нь Аврагч юм. Онгон охид бол Сүмийн гишүүд юм. Хурим нь Аврагчийн Хоёр дахь Ирэлтийг төлөөлдөг. Дэнлүүний тос нь Хоёр дахь Ирэлтийн бэлтгэлийг төлөөлдөг.

Видеог үзүүлсний дараа С ба Г 45:56-59-ийг ангийн гишүүдээр уншуул. Тэгээд дараах асуултыг асуу:

- Эдгээр шүлгүүд Аврагчийн Хоёр дахь Ирэлтэд бэлтгэх талаар юу заадаг вэ?

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбаллын дараах үгсийг хуваалцахыг та хүсч болно.

“Энэ сургаалт зүйрлэлд, тосыг зах дээрээс худалдан авч болно. Бидний амьдралд бэлтгэлийн тос зөв шударга амьдралд дусал дуслаар хуримтлагдаг. Ариун ёслолын цуглаануудад оролцох нь олон жилийн туршид бидний дэнлүүнд дусал дуслаар тос нэмдэг. Мацаг барилт, гэр бүлийн залбирал, гэрийн багшлалт, бие махбодын хүсэл таашаалыг хянах, сайн мэдээг номлох, судруудыг судлах зэрэг үйлдэл бүр нь мөн дуулгавартай байдал нь бидний агуулахад нэмэгдсэн дусал тос юм. Нинжин сэтгэлийн үйлс, аравны нэг болон өргөлийг төлөх нь, цэвэр ариун бодол санаа болон үйл ажиллагаа, үүрд мөнхийн гэрээгээр гэрлэх...энэ бүгд нь бид тос нь дууссан дэнлүүгээ шөнө дунд дахин асаахын тулд тос нэмж байгаа хэрэг юм” (*Faith Precedes the Miracle* [1972], 256).

Мэргэн Ухааны Үг: “Амлалт бүхий зарчим”

Зорилго

Мэргэн Ухааны Үгэн дэх зөвлөгөө, түүнчлэн бие бялдрын эрүүл мэндийн тухай Их Эзэний бусад зөвлөгөөг дуулгавартай дагахад ангийн гишүүдийг урамшуулан дэмжих.

Бэлтгэл

1. Дараах судрууд болон бусад материалыг залбирч судал:
 - а. Сургаал ба Гэрээ 89 (Мэргэн Ухааны Үг).
 - б. Сургаал ба Гэрээ 49:19-21; 59:15-21; 88:124 (нэмэлт судрууд).
 - в. *Бидний Өв*, хуудас 29.
2. Ангийн гишүүний Судлах Удирдамж (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.
3. Мэргэн Ухааны Үгийн түүхэн үндэс суурийг нэгтгэн дүгнэхэд бэлтгэхийг ангийн гишүүдээс хүс (*Бидний Өв*, хуудас 29).
4. Та хичээлийн гурав дахь хэсэгт ашиглахын тулд эрүүл мэндэд тустай хүнснүүдийн зургийг авчирч болно.

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа ХДараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

Ерөнхийлөгч Гордон Б.Хинклийн ярьсан дараах түүхийг хуваалц:

“[Ариун сүмийн] зөвшөөрлийн бичиг авахаар ирсэн нэг эмэгтэйн тухай нэг бишопын ярьсан зүйлийг би санадаг. Мэргэн Ухааны Үгийг сахидаг уу гэж түүнээс асуухад нөгөөх эмэгтэй үе үе нэг аяга кофе уучихдаг гэж хариулсан гэнэ. Тэгээд тэр эмэгтэй ‘ Бишоп оо, үүнээс болоод та намайг Ариун сүмд явуулахаас татгалзахгүй биз дээ, тийм үү?’ гэж хэлжээ. Ингэхэд нь бишоп, ‘Эгч ээ, Их Эзэний өргөө болон өөрийнхөө хооронд аяга кофе байлгахыг та зөвшөөрөхгүй нь лавтай’ ” гэж хариулсан гэдэг (In Conference Report, 1990 оны 4-р сар, 67; *Ensign*, 1990 оны 5-р сар, 51).

Мэргэн Ухааны Үг бол энгийн, шууд тодорхой хууль юм гэдгийг тайлбарла. Энэ хуулийг дагахгүй байхаас бие махбодод учрах аюулыг олон хүн мэддэг. Эдгээр үр дагаврыг санах нь чухал, гэвч бид Мэргэн Ухааны Үгийг дуулгавартай дагасан үед бидний хүлээн авдаг бие бялдрын болон сүнсний адислалуудыг бас санах нь чухал юм. Энэ хичээлээр эдгээр агуу амлалтуудыг ярилцах болно.

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбиран сонгож ав. Судрын зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Мэргэн Ухааны Үг яагаад илчлэгдсэн бэ?

Тэнгэрлэг Эцэг бурханлиг зорилгоор бидэнд бие махбод өгснийг тайлбарла. Бидний бие махбод бол бидний мөнхийн дэвшлийн төлөөх Түүний төлөвлөгөөний зайлшгүй чухал хэсэг юм. Бие махбод чухал учраас, биеийнхээ төлөө анхаарал халамж тавьж байх үүрэг хариуцлагыг Тэнгэрлэг Эцэг бидэнд ногдуулсан билээ. Бие махбодоо цэвэр ариун авч явахад бидэнд туслах сайн эрүүл мэндийн зарчмуудыг Тэрээр эрт дээр үеийн нэгэн адил манай эрин үед илчилсэн юм. Бид эдгээр зарчмуудад дуулгавартай байснаар Түүнийг хайрлах хайраа харуулж, талархлаа илэрхийлдэг.

Мэргэн Ухааны Үгийн түүхэн үндсийг *Бидний Өв*, хуудас 29-өөс нэгтгэн дүгнэхийг даалгавар авсан ангийн нэг гишүүнээс хүс. Та энэ гарын авлагын хуудас 146 дээрх Ньюел К.Витнейн дэлгүүрийн зургийг үзүүлж болно. Бошиглогч Иосеф Смит Мэргэн Ухааны Үгийг энэ дэлгүүрт хүлээн авчээ.

- 1 Коринт 3:16-17, 6:19-20-ийг ангийн гишүүдтэй хамт унш. Эдгээр шүлгүүдэд өгүүлснээр, бид бие махбоддоо анхаарал тавих нь яагаад чухал вэ? (Бидний бие махбод бол ариун сүм бөгөөд Их Эзэнд ариун юм гэдгийг тайлбарла. Бие махбод бол Бурханы үр удам бидний сүнс орших газар учраас бид биеэ цэвэр ариун авч явах ёстой. Бие махбодоо Бурханы ариун сүм гэж үзэн хүндлэх нь бид бол Бурханы хүүхдүүд гэдэг гэрчлэлийг маань харуулдаг. Энэ нь бидний махбодыг Ариун Сүнс орших газар болгодог. Бие махбоддоо анхаарал халамж тавих нь сүнслэг байдлын хувьд бидэнд хэрхэн нөлөөлдгийг онцлон тэмдэглэ)
- С ба Г 89:4-ийг ангийн гишүүдтэй хамт унш. Их Эзэн Мэргэн Ухааны Үгийг өгсний учир шалтгааны талаар энэ шүлэг юу зааж байна вэ? Мэргэн Ухааны Үгэнд дурдсан хортой бодисуудын талаарх “хуйвалдагч хүмүүсийн зүрх сэтгэлд байгаа хилэнц хийгээд бодлуудын . . . ” зарим жишээ юу вэ? (Эдгээр бодисуудыг ашиглах нь аз жаргал, амжилт бүтээлтэй холбоотой мэтээр зар сурталчилгаа, үзвэр цэнгүүн явуулдаг буруу ойлголт нь үүний жишээ байж болно)
- Биднийг хайрладаг Бурханы хайрыг Мэргэн Ухааны Үг хэрхэн харуулдаг вэ? Энэ нь Иосеф Смитийн бошиглогч, үзмэрчийн дуудлагыг хэрхэн харуулдаг вэ? (Мэргэн Ухааны Үгийн зарчмууд зөв болох нь шинжлэх ухааны судалгаагаар бүрэн нотлогдохоос бүр өмнө Их Эзэн үүнийг Бошиглогч Иосеф Смитэд илчилснийг тайлбарла. Энэ илчлэлт одоо үед бодисыг буруугаар ашиглаж байгаа тахлын байдалтай гамшгийг угтан харсан юм. Эл илчлэлт өнөө үеийн өвөрмөц асуудлуудаас биднийг урьдчилан сэрэмжлүүлж, хамгаалдаг билээ)

2. Биед юу сайн биш болох тухай Их Эзэний зөвлөгөө

Багшид өгөх анхааруулга: Та энэ хичээлийн хоёр, гуравдугаар хэсгийг заахдаа, Их Эзэний илчилсэн эрүүл мэндийн үндсэн зарчмууд дээр анхаарал төвлөрүүл. Эрүүл мэндийн зуршил, тусгай хоол хүнс, өөр нэр төрлийн ундааны тухай ярилцахаас зайлсхий. Бид юу идэж уух эсвэл юу идэж уух ёсгүй талаар Их Эзэн бүх зүйлийг нэг бүрчлэн тоочоогүйг онцлон

тэмдэглэ. “Ийм илчлэлт шаардлагагүй юм. Мэргэн Ухааны Үг бол ерөнхий зарчмын хууль. Энэ хууль арга замыг зааж, хүнс ундаа хоёрын аль алиных нь талаар хангалттай зааврыг бидэнд өгдөг билээ. . . Хэрэв бид Их Эзэний Сүнсний тусламжтайгаар бичигдсэн зүйлийг чин сэтгэлээсээ дагах юм бол, . . . бие махбодод юу сайн болохыг бас юу муу болохыг мэдэх болно” гэж Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит хэлжээ (“Your Question: Word of Wisdom,” *Improvement Era*, 1956 оны 2-р сар, 78-79).

Бие махбодод зориулагдаагүй гэсэн нийлэмж үгийг бас дараах судрын эшлэлүүдийг самбар дээр бич. Судрын эшлэл бүрийг ангийн гишүүдтэй хамт унш. Дараа нь уг эшлэл дээр дүрсэлсэн бодисыг жагсаа.

а. С ба Г 89:5-7. (Дарс буюу хүчтэй ундаа)

б. С ба Г 89:8. (Тамхи)

в. С ба Г 89:9. (Цай, кофе гэж тодорхойлсон халуун ундаанууд)

Дээрх бодисуудаас гадна бид:

а. Хууль бус мансууруулах бодис агуулсан аливаа бодис.

б. Мэргэжлийн эмчийн хяналтаар ашиглахгүй бол хэрэглэх зуршил буюу донтолт бий болгодог бусад бодис.

в. Эмийн жороор олгодог болон өөр бусад бодисуудыг хэрэглэх ёсгүй.

- Эдгээр хортой бодисуудыг хэрэглэсний зарим үр дагавар юу вэ? (Бие махбодын болон сүнсний үр дагавруудыг ярилц. Архи, тамхины тухай дараах догол мөрүүд бол жишээ нь юм. Хэрэв та залуучуудад заадаг бол, *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* товхимлын хуудас 36-37 [36550]-г эш татахыг хүсч болно).

“Хүчтэй ундаа уудаг хүмүүс ухаан бодлоо уудаг, Тэдний зөвлөгөөг хэн ч хэрэгсдэггүй, Эрүүл ухаан, зөн билиг нь тэднээс зайлан зугтдаг. . . Архи дэлхийн үзэж өнгөрүүлсэн бүх дайн дажнаас илүү их гай зовлон авчирч, түм буман зүрх сэтгэлийг шархлуулан, үй олон гэр орныг сүйрүүлж, өгүүлшгүй олон гэмт хэрэг өдүүлэн, тоо томшгүй олон хүнийг үхэл рүү илгээж байна” хэмээн Тэргүүн Зөвлөл мэдэгджээ (In Conference Report, 1942 оны аравдугаар сар, 8).

Тамхи татах нь дэлхий даяар жил бүр 2.5 сая хүний амь нас цаг бусаар үрэгдэхэд хүргэж байна. Тамхи татах нь бас гэм зэмгүй сая сая хүний эрүүл мэндийг хохироож байна. Жишээ нь жирэмсэн эхчүүд тамхи татах нь үр хөврөлийн хөгжилд саад учруулдаг химийн хортой бодисуудыг жил бүр 3 сая нярай хүүхдэд дамжуулан, тэднийг хордуулж байна. Ийм хүүхдүүд төрөхдөө жин багатай, сэтгэцийн болон оюуны хөгжил удаашрах, цаг бусаар нас барах эрсдэл ихтэй байдаг. Гэм буруугүй бусад хохирогчид бол бусдын тамхины утаагаар тогтмол амьсгалж байдаг тамхи татдаггүй хүмүүс юм. Ийм хүмүүс бусдын тамхины утаагаар амьсгалдаггүй хүмүүсээс амьсгалын замын өвчнөөр өвчлөх хувь хэмжээ илүү, уушигны хавдраар нас барах нь гурав дахин их байдаг ажээ. Утаагүй тамхи нь мөн л янжуурын адил донтуулдаг бөгөөд утаагүй тамхи хэрэглэгчид тамхи татдаггүй хүмүүсээс хавдраар өвчлөх нь тавь дахин их байдаг. (Жеймс О.Масон, “I Have a Question,” *Ensign*, 1986 оны 9-р сар, 59-61-ийг үз)

- Мэргэн Ухааны Үгэнд хориглосон бодисуудыг хэрэглэх нь дэлхийн олон хэсэгт, ялангуяа залуучуудын дунд улам өсөн нэмэгдэж байна. Зар сурталчилгаа эдгээр бодисуудыг хэрэглэхэд хүмүүсийг хэрхэн уруу татдаг вэ? (Ийм зар сурталчилгааны хуурмаг үг хэллэгийн тухай ярилц) Үе тэнгийнхэн болон бусад хүмүүс эдгээр бодисуудыг хэрэглэхэд хүмүүсийг яаж уруу татдаг вэ? (“Ийм жаахныг хэрэглэхэд ямар хор хөнөөл байдаг юм,” “Ганцхан удаа үзэхэд юу нь хортой юм,” “Хүн бүр л ингэдэг шүү дээ,” “Өөр хэн ч мэдэхгүй шүү дээ” гэхчлэнгийн ятгалгыг хэрхэн эсэргүүцэх тухай ярилцахыг та хүсч болно) Эдгээр бодисуудыг хэрэглэхэд хүмүүсийг уруу татдаг өөр ямар хэлбэрүүд байдаг вэ?
- Мэргэн Ухааны Үгийг бага хэмжээгээр ч гэсэн зөрчих нь ямар хор хохирол учруулж болох вэ?
- Хортой бодисуудыг хэрэглэх уруу таталтын эсрэг бид өөрсдийгөө хэрхэн бэхжүүлж чадах вэ? (Мэргэн Ухааны Үгийг зөрчих уруу таталтыг хэрхэн эсэргүүцсэн тухай туршлагаа ярихад ангийн гишүүдийг урь) Мэргэн Ухааны Үгийг дуулгавартай дагахад залуучууд хэрхэн бие биеэ дэмжиж болох вэ?
- Эцэг эхчүүд хүүхдүүддээ Мэргэн Ухааны Үгийн тухай хэрхэн үр ашигтайгаар зааж, үүнийг дуулгавартай дагахад нь тэдэнд хэрхэн тусалж болох вэ? (*Family Home Evening Resource Book* [31106], хуудас 228-231-ийг үз.)
- Мэргэн Ухааны Үгэнд хориглосон хортой бодисууд донтолтод хүргэдэг. Эдгээр бодисуудад донтох нь яагаад аюултай вэ? Мансууруулах бодисууд болон бусад хортой бодисуудад донтох явдлыг хүмүүс хэрхэн даван туулж болох вэ?

Донтолттой тэмцдэг хүмүүст найдвар байдгийг онцлон тэмдэглэ. Донтолтыг даван туулах нь ихэвчлэн хувь хүний шантаршгүй хүсэл, сахилга, наманчлал, мөн Их Эзэний тусалцааг шаарддаг. Гэр бүл, найз нөхөд, Сүмийн удирдагчид тусалж чадна. Бас зарим тохиолдолд мэргэжлийн тусламж шаардлагатай байж болно. Хортой бодисуудад донтох явдлыг хүмүүс хэрхэн даван туулсан туршлагыг хуваалцахад ангийн гишүүдийг урь.

3. Бие махбодод юу сайн болох тухай Их Эзэний зөвлөгөө

Бие махбодод сайн гэсэн үг болон дараах судрын эшлэлүүдийг самбар дээр бич. Судрын эшлэл бүрийг ангийн гишүүдтэй хамт унш. Дараах нийлэмж үгийг эшлэлийн хажууд хураангуйлан тэмдэглэ. Хэрэв та эрүүл мэндэд тустай хүнснүүдийн зураг авчирсан бол, үзүүл (“Бэлтгэл,” зүйл 4-ийг үз).

- а. С ба Г 89:10. (Эрүүл мэндэд тустай ургамлууд–тэжээллэг хүнсний ногоо болон ургамлууд)
 - б. С ба Г 89:11. (Жимс)
 - в. С ба Г 89:12; мөн С ба Г 49:19-ийг үз. (Ан амьтдын болон шувууны мах)
 - г. С ба Г 89:14-17. (Үр тариа)
 - д. С ба Г 88:124. (Эрт унтаж, эрт босч байх, тохиромжтой хугацаагаар унтаж байх.)
- Хүнснийг “хэрсүү ухаанаар” хэрэглэх гэж юу гэсэн үг вэ? (С ба Г 89:11; мөн С ба Г 59:18-20-ийг үз; бид бие махбоддоо тэжээл болох хоол хүнсийг идэж байх ёстой, иддэг хоол хүнснийхээ нэр төрөл, хэмжээг тохируулдаг байх ёстой нь хариулт байж болно). Хоол хүнсийг “талархалтайгаар”

хэрэглэх гэж юу гэсэн үг вэ? (С ба Г 89:11). Бидэнд өгсөн хоол хүнсний төлөө бид Их Эзэнд талархлаа хэрхэн харуулж болох вэ?

- Махыг хэрэглэх талаар Их Эзэн ямар удирдамж өгсөн бэ? (С ба Г 89:12; мөн С ба Г 49:19, 21-ийг үз) Үр тариа хэрэглэх талаар Их Эзэн ямар удирдамж өгсөн бэ? (С ба Г 89:14, 16-г үз)
- Унтах талаар Их Эзэн ямар зөвлөгөө өгсөн бэ? (С ба Г 88:124-ийг үз.) Тохиромжтой хэмжээгээр унтах нь бие махбодын хувьд мөн сүнслэг байдлын хувьд бидэнд хэрхэн нөлөөлдөг вэ?

“Нэг өдөрт хоёр өдрийн ажил хийхийн оронд, хэрэв тэд урт насалж, сайн эрүүл мэндтэй байхыг хүсвэл, хангалттай хүч чармайлт гаргасны дараа, бүрэн сульдан ядрахаас нь өмнө амрах боломжийг бие махбоддоо олгож байх нь [Гэгээнтнүүдийн хувьд] мэргэн ухаан байх болно. Ядарсан үед ...сэргээш хэрэгтэй гэж зарим хүмүүс мэтгэдэг. Гэвч тэд ийм сэргээшийн оронд амралтаар хүч тамираа дахин олж авах ёстой” хэмээн Ерөнхийлөгч Бригам Янг хэлжээ (*Discourses of Brigham Young*, эмхтгэсэн Жон А.Видцөү [1941], 187).

4. Мэргэн Ухааны Үгийг дуулгавартай дагасны төлөө амлагдсан адислалууд

Мэргэн Ухааны Үгийг Их Эзэн “амлалт бүхий зарчим” (С ба Г 89:3) болгон илчилсэн юм. *Амлагдсан Адислалууд* гэсэн үгийг болон дараах судрын эшлэлүүдийг самбар дээр бич. Судрын эшлэл бүрийг ангийн гишүүдтэй хамт унш. Дараа нь амлалт бүрийг эшлэлийн дэргэд жагсаа.

- а. С ба Г 89:18. (Бие бялдрын эрүүл мэнд)
- б. С ба Г 89:19. (Мэргэн ухаан ба мэдлэгийн агуу эрдэнэсийн сан)
- в. С ба Г 89:20. (Гүйхдээ болон алхахдаа ядрахгүй, сул дорой байхгүй чадвар)
- г. С ба Г 89:21. (Тэнгэр элчийн устгалаас хамгаалагдана)

- Та нар Мэргэн Ухааны Үгийг дуулгавартай сахиснаараа хэрхэн адислагдсан бэ? (Хүлээн авсан бие бялдрын болон сүнсний адислалуудынхаа талаар ярихад ангийн гишүүдийг урь)

Мэргэн Ухааны Үгийг дуулгавартай дагадаг хүмүүс үүнийг дагадаггүй хүмүүсээс ерөнхийдөө илүү урт насалдаг, амьдралын чанар нь ч илүү сайн байдгийг та онцлон хэлж болно. Гэвч зарим хүмүүс Мэргэн Ухааны Үгийг дагаснаас хамаарахгүйгээр ноцтой өвчинтэй эсвэл бие эрхтний гажигтай байдаг. Эдгээр хүмүүсийн бие махбодын бэрхшээл үргэлжиллээ ч гэсэн, Мэргэн Ухааны Үгийг дуулгавартай дагаснаас ирдэг адислалыг хүлээн авч чадна гэдгийг тайлбарла. Түүнээс гадна, Их Эзэний амлалтууд үүрд мөнхийнх байдаг бөгөөд амлагдсан бүх адислалыг энэ амьдралд хүлээн аваагүй хүмүүс адислалуудыг дараа нь хүлээн авах болно.

- “Мэргэн ухаан болон мэдлэгийн агуу эрдэнэсийн сан, бүр нуугдмал эрдэнэсийн санг олж авахад” (С ба Г 89:19) Мэргэн Ухааны Үгийг дуулгавартай дагасан нь бидэнд тусалсан зарим жишээ юу вэ? (Мэргэн Ухааны Үгийг дуулгавартай дагах нь хүний оюуны чадварт хэрхэн тусалдаг тухай ярилц. Энэ нь гэрчлэл, бурханлиг үнэнүүдийн тухай мэдлэг, хувийн илчлэлт, патриархын адислал, түүнчлэн ариун сүмийн ёслол болон гэрээнүүд зэрэг сүнслэг мэдлэгийн эрдэнэсийн санг хүлээн авахад хүнд хэрхэн тусалдгийг ярилц)

Арванхоёрын Чуулгын Ахлагч Боид К.Пакер: “ Мэргэн Ухааны Үгийн тулгуур зорилго нь...илчлэлтэй холбоотойг би мэдсэн. . . Хэрэв хүн [хортой бодисуудын] ‘нөлөөнд орсон бол’ энгийн ойлгомжтой үг яриаг сонсох нь тэдэнд хэцүү байдаг байхад, хамгийн нарийн мэдрэмжүүдэд нь нөлөөлдөг Сүнсний өдөөлтүүдэд тэд хэрхэн хариулж чадах билээ? Мэргэн Ухааны Үг нь эрүүл мэндийн хуулийн хувьд үнэ цэнэтэйн адил, энэ нь бие махбодынхоос илүүгээр сүнслэг байдлын хувьд та нарт бүр ч үнэ цэнэтэй юм” гэж хэлсэн байдаг (In Conference Report, 1979 оны аравдугаар сар, 28-29; *Ensign*, 1979 оны арваннэгдүгээр сар, 20).

- С ба Г 89:20 дахь Их Эзэний амлалт бие махбодын хувьд бидэнд хэрхэн хамаатай байж болох вэ? (Бидний оюун ухаан, сэтгэл хөдлөлийн хүч чадал, өөрийгөө эзэмдэх, өөртөө сэтгэл ханамжтай байх чадвар өсөн нэмэгдэнэ гэдэг нь хариулт байж болно) Энэ амлалт сүнслэг байдлын хувьд бидэнд хэрхэн хамаатай байж болох вэ? (Еврей 12:1-3-ыг үз. Уруу таталтыг эсэргүүцэх, мөнх амьдрал өөд “уралдаанд тэвчээртэйгээр гүйх” бидний хүч чадал өсөн нэмэгдэнэ гэдэг нь хариулт байж болно.)
- С ба Г 89:21 дэх Их Эзэний амлалт бидэнд хэрхэн холбогдох вэ?

Эрт үед Израилын хүүхдүүд Египетээс гарахын өмнөхөн хүмүүс бошиглогч Мосег дуулгавартай дагаж, хаалгануудаа хурганы цусаар тэмдэглэсэн учраас устгагч тэнгэр элч израилчуудын ууган хөвгүүдийн дээгүүр өнгөрснийг тайлбарла (Египетээс Гарсан нь 12). Яг үүнчлэн, бид зарлигуудад, түүний дотор Мэргэн Ухааны Үгэнд дуулгавартайгаар амьдрах юм бол, устгагч тэнгэр элч бидний дэргэдүүр өнгөрөх болно. Ингэснээр бид сүнсний үхлээс аврагдаж, Христийн цагаатгагч цусаар дамжин мөнх амьдралаар адислагдана. (Боид К.Пакер, In Conference Report, 1996 оны 4-р сар 24; *Ensign*, 1996 оны 5-р сар, 19)

Дүгнэлт

Их Эзэн бидэнд хайртай бас бидний бие махбодын болон сүнсний сайн сайхны төлөө анхаарал халамж тавьдаг учраас Тэрээр Мэргэн Ухааны Үгийг өгснийг онцлон тэмдэглэ. Мэргэн Ухааны Үг бол зүгээр нэг бие бялдрын эрүүл мэндийн хуулиас илүү чухал зүйл юм. Энэ бол Сүнсний агуу адислалын түлхүүр мөн гэдгийг тайлбарла. Эрүүл мэндийн тухай Их Эзэний зөвлөгөөнд нийцүүлэн, ангийн гишүүд чадах чинээгээрээ бие махбоддоо анхаарал тавьдаг эсэхдээ үнэлэлт дүгнэлт өгөхийг тэдэнд зөвлөмж болго. Бид энэ зөвлөгөөг дагах юм бол биднийг бие бялдар, сүнслэг байдлын хувьд адислах амлалтаа Их Эзэн биелүүлнэ гэдгийг гэрчил.

Нэмэлт заах санаанууд

Та зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болгож дараах санаануудаас нэгийг буюу илүү олныг нь ашиглаж болно.

1. Мэргэн Ухааны Үгийг дагаснаар дэлхийн эдийн засгийн асуудлыг шийдвэрлэж болно

- Сүмийн долоо дахь, Ерөнхийлөгч Хебер Ж.Грант, “Хэрэв дэлхийн хүмүүс Мэргэн Ухааны Үгийг дуулгавартай дагах юм бол улс орон бүрийн эдийн засгийн асуудлуудыг шийдвэрлэж чадна” (In Conference Report, 1936 оны 4-р сар, 48). Яагаад ийм байж болно гэж та нар бодож байна?

Хортой бодисуудыг үйлдвэрлэх, сурталчлах, худалдаж авахад ашигладаг газар, мөнгө, бусад эх үүсвэр, тэрчлэн хортой бодисуудыг хэрэглэсний үр дагаврыг авч үз. Жишээ нь 1985 онд Америкийн эрүүл мэндийн зардал, тамхи хэрэглэсний улмаас буурсан хөдөлмөрийн бүтээмжийн алдагдал ойролцоогоор 65 тэрбум ам. доллар байжээ (*Ensign*, 1986 оны 9-р сар, 61-ийг үз). Архи үйлдвэрлэх, хэрэглэх зардал бас л асар их байна. Эдгээр эх үүсвэрүүдийг сүйрүүлэгч зорилгоор биш, ашиг тустай зүйлүүдэд хэрэглэхийн эдийн засгийн үр өгөөжийг авч үз.

2. Мэргэн Ухааны Үгийг дуулгавартай дагаснаар нэмэлт ашиг тусыг олно

Сайн мэдээгээр, түүний дотор Мэргэн Ухааны Үгээр амьдардаг Сүмийн гишүүд гэрлэлтдээ илүү аз жаргалтай, гэр бүлийнхээ амьдралд илүү сэтгэл хангалуун байдгийг нийгмийн шинжлэх ухааны эрдэмтэд нотолжээ. Тэд гэрлэхээсээ өмнө эсвэл гэрлэсний дараа эхнэр буюу нөхрөөсөө өөр хүнтэй бэлгийн харилцаанд орох, гутарч цөхрөх, хэрэг төвөгт орооцолдох, гаж буруу буюу нийгмийн эсрэг авир араншин гаргах нь ховор байдаг ажээ. (Роберт Л.Миллет, Ноел Б.Рейнольдс, *Latter-day Christianity: 10 Basic Issues* [товхимол, 1998], 46-47)

3. Мэргэн Ухааны Үгийг дуулгавартай дагах нь тэнгэрийн хүчээр заахад номлогчид тусална

Мэргэн Ухааны Үгийг дуулгавартай дагасан нь нэг номлогчийг санаанд оромгүй арга замаар адисалсан ажээ. Мэргэн Ухааны Үгийг тэр нэг хүнд зааж байтал нөгөөх хүн түүний өөдөөс эгцлэн ширтэж, асуусан нь, “Та хэзээ ч мансууруулах бодис туршиж үзээгүй, янжуур татаж үзээгүй, ямар ч төрлийн архи амсаж үзээгүй гэж хэлэх гээд байна уу даа?” Номлогч тэр хүн рүү эгцлэн харж, шийдэмгий дуугаар, “Үгүй ээ, ноёнтон. Хэзээ ч үзээгүй” гэжээ.

Сайхь номлогч дараах үгсийг хожим нь ярьсан ажээ: “Тэр агшинд нэгэн хүч биеийг минь төөнөх лүгээ адил болоход, би Мэргэн Ухааны Үгийг яагаад үргэлж сахидгаа мэдсэн. Би амьдралынхаа тэрхүү агшинд хүрч ирэхдээ Мэргэн Ухааны Үгэнд үргэлж дуулгавартай байсан учраас ач холбогдлынх нь талаар хүчирхэг гэрчлэл хэлэх боломжтой байсандаа талархаж явдаг”

4. “Өөртөө байгаа хүч чадлаас илүү хурдан гүйх буюу илүүгээр бүү хөдөлмөрлө” (С ба Г 10:4)

- С ба Г 10:4-т Их Эзэн Иосеф Смитэд ямар зөвлөгөө өгсөн бэ? (Мозая 4:27-г үз) Энэ зөвлөгөө бидний эрүүл мэндэд хэрхэн хаматай вэ? Энэ зөвлөгөөг үл ойшоохын аюул юу вэ?

5. Шивээс ба биеийг гаж буруу байдлаар цоолох нь

Бидний бие махбод Их Эзэнд ариун бөгөөд Ариун Сүнс энд оршиж чадах ариун сүм мөн хэмээн Төлөөлөгч Паул сургасан билээ (1 Коринт 3:16; 6:19-20). Бид хортой бодисуудыг хэрэглэж, бие махбодоо бузарлах ёсгүйн нэгэн адилаар, биен дээрээ шивээс хийлгэх буюу гаж буруу байдлаар цоолж бохирлох ёсгүй. Шивээс болон биеийг цоолох нь бие махбодын нийгмийн, сүнслэг байдлын үр дагавартай юм. (Давид А.Бөөртн, “I Have a Question,” *Ensign*, 1999 оны 2-р сар, 52-53-ыг үз)

“Чи . . . миний ариун өдөр ариун ёслолуудаа өргөх ёстой”

Хичээл
23

Зорилго “Судлахаар мөн тэрчлэн итгэлээр” (С ба Г 88:118) насан туршдаа суралцахад ангийн гишүүдийг урамшуулан дэмжих.

Бэлтгэл

1. Энэ хичээлийн судруудыг залбирч судал.
2. *Ангийн гишүүний Судлах Удирдамж* (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.
3. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах бол суралцахаас ирсэн адислалуудынхаа талаарх хувийн туршлагаа хуваалцахад бэлтгэж ирэхийг ангийн нэг гишүүнээс хүс.

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа Хичээлээ дараах үйл ажиллагаагаар эсвэл өөрийнхөө илүү тохиромжтой үйл ажиллагаагаар эхэл.

Амьдралд нь суралцахаас ирсэн адислалуудын тухай товч ярихыг ангийн нэг гишүүнээс хүс (“Бэлтгэл,” зүйл 3-ыг үз).

Энэ гишүүнийг ярьсны дараа насан туршид суралцахын ач холбогдлыг энэ хичээлээр ярилцана гэдгийг тайлбарла.

Ярилцах ба хэрэгжүүлэх нь

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбиран сонгож ав. Суралцахтай холбоотой туршлагаа хуваалцахад ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Бошиглогчдын Сургууль хичээл сурлагадаа баримтлах загвараар биднийг хангадаг

Их Эзэн сүнсний болон дэлхийн боловсролын хэрэгцээг энэ эрин үед ихэд онцгойлон анхаарсныг хэл.

Огайогийн Көртландад Бошиглогчдын Сургуулийг эхлүүлэхийг Их Эзэн Бошиглогч Иосеф Смитэд зааварлажээ. Бошиглогчдын Сургууль 1833 оны нэгдүгээр сард Көртланд дахь Ньюэл К.Витнейн Дэлгүүрийн дээд давхар дахь жижиг өрөөнд цугласнаар эхэлжээ (хуудас 146 дахь зургийг үз). Энэ сургуульд Сүмийн удирдагчдыг сайн мэдээний сургаал, Сүмийн ажил хэрэг, бусад асуудлаар зааварладаг байжээ. Тэднийг Сүмийн удирдлага, номлолын үйлчлэлд бэлтгэдэг байв (С ба Г 88:77-80).

Эдгээр цуглаанууд сүнслэг туршлага, сайн мэдээний зарчмуудыг гүнзгийгээр, бүх талаас нь цогц байдлаар авч хэлэлцдэг байжээ. Нэлээд хэдэн илчлэлт хүлээн авсан аж. “Бошиглогчдын Сургуулийн өнгө төрхөнд агуу баяр баясал,

сэтгэл ханамж байнга гийдэг байлаа. Мөн Гэгээнтнүүд илчлэгдсэн зүйлс дээр тулгуурлан, . . . Бурханы тухай мэдлэгт өсч байлаа” хэмээн Сүмийн Түүхэнд цэдэглэжээ (*History of the Church*, 1:334).

- Бидэнд суралцах ямар боломжууд Сүмд байдаг вэ? Бид Сүмийнхээ цуглаанууд дээр суралцахад өөрсдийгөө илүү сайн бэлтгэхийн тулд юу хийж чадах вэ?
- С ба Г 88:122-25-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Их Эзэн Бошиглогчдын Сургууль дээр юу хийхийг ах нарт зарлиг болгосон бэ? Юу хийхгүй байхыг Тэр тэдэнд зарлиг болгосон бэ? (Ангийн гишүүдийн хариултыг самбар дээр жагсаа) Бие биедээ заах тухай эдгээр шүлгүүдээс бид юу сурч болох вэ? Бид бие биеэсээ суралцах талаар эдгээр шүлгүүд юу өгүүлж байна вэ?



Ньюэл К.Витней ба Компанийн дэлгүүр. Огайогийн Көртланд дахь энэ дэлгүүрийн дээд давхарт Бошиглогчдын Сургууль хичээллэдэг байжээ. Мэргэн Ухааны Үг (С ба Г 89) хэмээн нэрлэгддэг илчлэлт бусад илчлэлтийн хамт энд хүлээн авагдсан юм.

2. Бид “судлахаар бас итгэлээр” суралцах ёстой

- С ба Г 88:118-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Суралцах хүч чармайлтад судлах, итгэл хоёр яагаад шаардлагатай байдаг вэ? (Доорх эшлэлийг үз) Итгэл бидний суралцах чадварыг хэрхэн дээшлүүлдэг вэ? Бурханд итгэх итгэлгүйгээр, зарлигуудыг нь дагахгүйгээр суралцахын аюул юу вэ? (2 Тимот 3:7; 2 Нифай 9:28-29-ийг үз)

Тэргүүн Зөвлөлийн Ерөнхийлөгч Марион Г.Ромни: “Би судлахад итгэдэг. Судлахаар дамжуулан хүмүүс ихийг мэддэгт би итгэдэг. . . Гэвч судлах замаар суралцах нь итгэлээр их хэмжээгээр түргэсдэг гэдэгт би итгэдэг, бас үүнийг мэддэг” хэмээн хэлжээ (*Learning for the Eternities*, түүвэрлэсэн Жорж Ж.Ромни [1977], 72).

- Бид сайн мэдээг судлахаас гадна түүх, шинжлэх ухаан, сайн утга зохиол зэрэг бусад салбарт суралцахыг эрэлхийлэх ёстой. Эдгээр салбарыг судалсан нь амьдралыг тань хэрхэн баялаг болгосон бэ?
- Ямар төрлийн мэдлэг хамгийн үнэ цэнэтэй вэ? Сайн мэдээг судлах, бусад үнэ цэнэтэй салбарыг судлахын хооронд ямар харьцаа байх ёстой вэ?

Сүмийн гурав дахь Ерөнхийлөгч Жон Тейлор хэлэхдээ: “Бид боловсрол болон оюуны бүх төрлийн чадамжийг хөхүүлэн дэмжих ёстой. Бичиг номын сонирхол таашаалыг хөгжүүл, тэгвэл бичиг номын болон шинжлэх ухааны авъяас билэгтэй хүмүүс тэрхүү авъяас билгээ хөгжүүлнэ. Бас бүх хүмүүс өөрсдөд нь Бурханы өгсөн бэлгүүдийг улам өгсөн хөгжүүлэх ёстой. . . Ёс суртахуун, шүтлэг бишрэл, шинжлэх ухаан, эсвэл хүнийг өргөмжилж, сайн сайхан болгоход чиглэсэн ямар нэг юм байвал, бид түүний хойноос тэмүүлдэг. Харин бид өөрсдийн олж мэдсэн бүхэнтэйгээр ойлголтыг, Бурханаас ирдэг тэрхүү ойлголтыг олж авахыг хүсдэг” гэжээ (*The Gospel Kingdom*, эмхтгэсэн Г.Хомер Дурхам [1943], 277).

Ахлагч Гордон Б.Хинкли Арванхоёрын Чуулгад үйлчилж байхдаа “Надаас суралц” (Матай 11:29) гэсэн Аврагчийн тушаалыг эш татсан нэг үг хэлжээ. Тэгээд тэрээр “Бурханы Хүүгийн өгсөн энэ тушаалыг та нар дага хэмээн би зөвлөмж болгохыг хүсч байна. Суралцах бүхий л чармайлтаараа түүнээс суралц. Бүхий л судлах хүч чармайлтаараа Эзэний тухай мэдлэгийг эрэлхийл. Энэ мэдлэг та нарын хүлээн авах шашны бус сургалт дээр гайхалтай арга замаар нэмэлт болж, өөр ямар ч замаар ирж чадахгүй бүрэн байдлыг амьдралд чинь, зан төлөвт чинь өгдөг” хэмээн хэлсэн ажээ (In Conference Report, 1964 оны аравдугаар сар, 118; *Improvement Era*, 1964 оны 12-р сар, 1092).

- Бурханы зүйлүүдийн тухай энэ мэдлэг, мэдлэгийн хамгийн чухал төрөл болохыг та нар хэрхэн харсан бэ?

3. Бид насан туршдаа үргэлж суралцах ёстой

Их Эзэн болон Түүний бошиглогчид суралцахын ач холбогдлыг үргэлж онцгойлон авч үздэг байсныг хэл. Бид насан туршдаа үргэлж суралцах ёстой.

Арванхоёрын Чуулгын Ахлагч Рассел М.Нелсон хэлэхдээ: “Бид хүн бүрийн оюун ухааныг ариун гэж үздэг учраас, боловсролтой болохыг бидний шүтлэг бишрэлийн үүрэг хариуцлага гэж үздэг. . . . Биднийг Бүтээгч газар бүр дэх Өөрийнх нь хүүхдүүд өөрсдийгөө боловсруулдаг байхыг хүсэн хүлээдэг” гэжээ (In Conference Report, 1992 оны аравдугаар сар, 5; *Ensign*, 1992 оны арваннэгдүгээр сар, 6).

Дараах асуултуудыг самбар дээр бич:

Яагаад бид суралцах ёстой вэ?

Юуг бид сурах ёстой вэ?

Бид яаж сурч болох вэ?

Дараах судрын хэсгүүдийг ангийн гишүүдтэй хамт унш. Самбар дээрх асуултуудын хариуг ангийн гишүүдээр олуул. Тэдний хариултыг холбогдох асуултын дор бич.

С ба Г 6:7

С ба Г 88:76-80, 118

С ба Г 130:18-19

С ба Г 11:21-22

С ба Г 90:15

С ба Г 131:6

С ба Г 19:23

С ба Г 93:36-37, 53

С ба Г 136:32-33

- Олон зүйлд суралцахыг бидэнд яагаад зарлиг болгосон гэж та нар боддог вэ?

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли боловсролын үнэ цэнийг залуу хүмүүст заахдаа: “Залуу эрэгтэйчүүд, залуу эмэгтэйчүүд та нар чадах чинээгээрээ боловсролтой болох нь туйлын чухал юм. Өөрийнх нь хүмүүс боловсролоор дамжуулан улс орнуудын болон хаант улсуудын тухай, дэлхийн зүйлүүдийн тухай мэдлэгийг судлахаар бас итгэлээр олж авах ёстойг Их Эзэн маш энгийн тодорхойгоор хэлсэн юм. Боловсрол бол та нарын хувьд боломжуудын хаалгыг нээдэг түлхүүр юм. Боловсрол бол золиос хийвэл зохих үнэ цэнэтэй зүйл. Боловсрол бол үүн дээр ажиллавал зохих үнэ цэнэтэй зүйл. Хэрэв та нар оюун ухаанаа, гараа хөгжүүлэх юм бол, та нар өөрсдөө нэг хэсэг нь байдаг нийгэмдээ их хувь нэмэр оруулах боломжтой болно. Ингэснээр та нар гишүүн нь байгаа Сүмийнхээ талаар хүндэтгэлтэйгээр эргэцүүлэн бодох боломжтой болно. Эрхэм хүндэт залуу ах, эгч нар минь ээ, чадах чинээгээрээ боловсрол олж авах боломж бүрийг ашигла. Аав, ээжүүд та нар, амьдралыг нь адислах боловсролтой болоход нь хөвгүүд, охидоо дэмж” гэжээ (“Inspirational Thoughts,” *Ensign*, 1999 оны зургадугаар сар, 4).

- Албан боловсролын хувьд бидэнд ямар боломж байдаг вэ? (Дунд сургууль, мэргэжлийн сургууль, коллеж, их сургуулиуд хариулт байж болно) Албан боловсрол бидний амьдралд ямар ашиг тустай вэ? Бидэнд байдаг албан боловсролын боломжийг илүү сайн ашиглахын тулд бид юу хийж болох вэ?
- Ерөнхийлөгч Бригам Янг, “Боловсрол оюун ухааныг маань хөгжүүлж, өгөх ашиг тус нь өсөн нэмэгдэж байх учиртай. Хүмүүний гэр бүлд илүү сайн үйлчлэх боломжийг боловсрол бидэнд олгодог” (*Discourses of Brigham Young*, эмхтгэсэн Жон А.Видцөү [1941], 255). Гэр бүлдээ үйлчлэхэд боловсрол бидэнд хэрхэн тусалдаг вэ? Бусдад үйлчлэхэд боловсрол бидэнд хэрхэн тусалдаг вэ? Бурханы хаант улсыг байгуулахад туслах бидний хүч чармайлтад боловсрол хэрхэн тусалж чадах вэ? Үйлчлэх хүч чармайлтад нь боловсрол тусалсан туршлагаа хуваалцахад ангийн гишүүдийг урь.
- С ба Г 90:15-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Сайн номнуудыг судалснаар амьдрал тань хэрхэн баялаг болсон бэ?
- Хүүхдүүддээ заах талаар эцэг эхчүүд ямар үүрэг хариуцлагууд хүлээдэг вэ? (С ба Г 68:25-28-ыг үз. Сайн мэдээнд суралцахад нь үр хүүхэддээ туслах хүндтэй ариун үүрэг эцэг эхчүүдэд байдгийг онцлон тэмдэглэ. Сайн эрүүл мэндийг сахих, хичээнгүй ажиллах, бусад хүмүүстэй зөв харьцах, мөнгөө зөв зарцуулах, сайн боловсролтой болох зэрэг практик ур чадварыг эцэг эхчүүд заах ёстой)
- Насан туршдаа суралцахыг эрхэмлэх чанарыг хөгжүүлэхэд эцэг эхчүүд хүүхдүүддээ хэрхэн урамшуулан дэмжиж болох вэ?

Ахлагч Гордон Б.Хинкли Арванхоёрын Чуулгад үйлчилж байхдаа хүүхдийг уншиж сурахад урамшуулан дэмжихийн ач холбогдлыг онцлон тэмдэглэж: “Хүүхдүүд чинь уншиж сурах болно гэдгийг та нар мэддэг. Тэд ном уншина, сэтгүүл, сонин уншина. Хамгийн сайн сайхан зүйлийг шимтэн шохоорхох сонирхлыг тэдэнд хөгжүүл. Хүүхдийг бүр бага байхад нь сайхан түүхүүдийг тэдэнд уншиж өг. Эдгээр түүхийн заадаг ариун журам, сайн сайхан үйл явдал урт удаан хугацааны туршид мартагдахгүй байх болно. Сайн номнуудыг тэдэнд үзүүлж бай. Гэрийнхээ хаа нэгэнтээ бүр жижигхэн ч гэсэн нэгэн буланг бий болго. Агуу оюун ухааныг амтархан олж үзэх цөөхөн ч гэсэн номыг хүүхдүүд чинь тэндээс харж байг” гэж хэлжээ (In Conference Report, 1975 оны аравдугаар сар, 57; *Ensign*, 1975 оны арваннэгдүгээр сар, 39).

Бага насны хүүхдүүд судрууд дахь сургаалыг ойлгож чаддагийг Ерөнхийлөгч Томас С.Монсон бидэнд сануулан: “Аз жаргалтай гэр бүлийн . . . шинж тэмдэг нь энэ гэрт суралцах номын сан байгаагаар илэрдэг. . . . ‘Мэргэн ухааны үгсийг шилдэг номнуудаас эрэлхийлэгтүн та нар; бүр судлахаар мөн тэрчлэн итгэлээр суралцахыг эрэлхийлэгтүн’ (С ба Г 88:118) хэмээн Их Эзэн зөвлөжээ. Жишиг бүтээлүүд бол миний өгүүлсэн суралцах номын сан юм. Бурханы үгийг уншиж, ойлгох хүүхдийн чадварыг бид дутуу үнэлэхгүй байхыг анхаарах ёстой” гэж хэлжээ (In Conference Report, 1988 оны аравдугаар сар, 81–82; *Ensign*, 1988 оны арваннэгдүгээр сар, 70).

Хэрэв та хүүхдэд заах асуудлыг илүү нарийвчлан ярилцахыг хүсвэл, *Teaching, No Greater Call* (36123) номын 1999 оны хэвлэлийн хуудас 127-143-ыг үзэж болно. Энэ гарын авлага дахь хичээл 45 нь хүүхэддээ заах эцэг эхчүүдийн үүрэг хариуцлагын тухай ярилцдаг.

- Бид ямар зүйлийг уншихаас зайлсхийх ёстой вэ?


Арванхоёрын Чуулгын Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон: “Ном элбэг болсон өнөө үед юуг уншихгүй байхыг мэдэх нь жинхэнэ боловсролтой хүний шинж юм. . . Зөвхөн хамгийн сайн номнуудыг унш. Жон Вислигийн ээж түүнд зөвлөсөнчлөн: ‘Хүсэл эрмэлзлийг чинь бууруулдаг, ухамсрын чинь уян зөөлнийг эвдэн бусниулдаг, Бурханы тухай мэдрэмжийг чинь бүдэгрүүлдэг, Сүнсний зүйлүүдийн төлөөх урам зоригийг чинь мохоодог . . . бие махбодын сонирхлыг оюун ухаанаас дээгүүрт тавьдаг’ юунаас ч болов, зайлсхий” гэж сургажээ (“In His Steps,” in *1979 Devotional Speeches of the Year* [1980], 61).

- Албан боловсрол олж авах болон сайн номнуудыг уншихаас гадна, насан туршдаа байнга суралцахын тулд бид юу хийж болох вэ?

4. Бид ариун сүмд үүрд мөнхөд хамаатай боловсролыг олдог

Бошиглогч Иосеф Смит Сионы хотыг байгуулах төлөвлөгөөг 1833 оны зургадугаар сарын сүүлчээр Миссурийн Индепенденс дэх Гэгээнтнүүдэд илгээснийг тайлбарла.

Доор өгсөн Сионы хотын төлөвлөгөөг үзүүл. Гэгээнтнүүд хотын төвд ариун сүм барих ёстой байсныг тайлбарла. Сионы хотыг байгуулах боломж Гэгээнтнүүдэд олдоогүй ч, тэд Солт Лейк хотыг байгуулахдаа энэ үзэл санааг баримталсан юм.



Сионы хотын газар. Ариун сүмийн газар төвд нь байна.

- Ариун сүмийг Сионы хотын төвд барих байсан төлөвлөгөөнөөс бид юу мэдэж болох вэ? (Ариун сүм бол Сүмийн гишүүдийн хувьд суралцах төв юм. Бид ариун сүмийг амьдралынхаа төвд тавих ёстой нь хариулт байж болно.)
- С ба Г 88:119-ийг ангийн гишүүдтэй хамт унш. Ариун сүм бол “суралцах өргөө” мөн гэдгийг онцлон тэмдэглэ. Ариун сүмд орох үед Их Эзэн бидэнд ямар арга замаар заадаг вэ? Ариун сүмд олж авдаг мэдлэгийг хүлээн авахын тулд бид юу хийж болох вэ?

Арванхоёрын Чуулгын Ахлагч Жон А.Видцөү: “Ариун сүм бол зааврын газар мөн. Энд сайн мэдээний зарчмууд нэгтгэгдэн дүгнэгдэж, Бурханы хаант улсын онцгой чухал үнэнүүд нээгддэг. Хэрэв бид ариун сүмд зөв санаа бодолтой, анхааралтайгаар орох юм бол эндээс гарахдаа сайн

мэдээний тухай мэдлэгээр мөн мэргэн ухаанаар баяжсан байдаг” гэж сургажээ (“Looking toward the Temple,” *Ensign*, 1972 оны 1-р сар, 56-57).

Арванхоёрын Чуулгын Ахлагч Бойд К.Пакер хэлсэн нь:

“Ариун сүм бол агуу сургууль юм. Энэ бол суралцахын өргөө. Гүнзгий сүнслэг асуудлаар төгс заавар өгөх уур амьсгал ариун сүмд оршдог . . .

“Ариун сүмийн ёслол эхний удаад бүрэн ойлгогдохгүй. Ёслолын зөвхөн зарим нь л ойлгогдоно. Ариун сүмд дахин дахин ор. Сурахын тулд эргэж ир. Ойлгогдохгүй юмс, толгой эргэм зүйл эсвэл нууцлаг зүйлс та нарт мэдэгдэх болно. Эдгээр зүйлээс олон нь нам гүмхэн байдаг. Өөр хүнд тайлбарлаж болохгүй хувийн юмс танд байх болно. Гэвч өөрийн тань хувьд бол эдгээр юмс мэдэгдсэн зүйл байдаг. . .

“Иймээс Ариун сүм өөд хар. Ариун сүмийг үр хүүхэддээ үзүүл. Бүр бага балчраас нь тэдний анхаарлыг нь ариун сүм рүү чиглүүл. Улмаар ариун сүмд орох бэлтгэлийг нь эхэл.

“Ингэхийн хамт, өөрөө үг дуулдаг бай, хүндэтгэлтэй бай. Сургаалуудаас суралц, зөвхөн ариун сүмд байдаг бэлэгдлүүдийг, гүнзгий сүнслэг зүйлүүдийг сайн мэдэж ав” гэжээ (*Ариун Сүм* [товхимол, 1982], 6-8).

Ариун сүмд хийгддэг ёслолууд бол ариун нандин юм гэдгийг ангийн гишүүдэд сануул. Бид эдгээр ёслолуудын өвөрмөц онцлог зүйлүүдийг ариун сүмээс гадуур ярих ёсгүй. Дараах асуултанд хариулахдаа энэ зарчмыг санаж байхыг ангийн гишүүдээс хүс:

- Ариун сүмд орсноор дамжуулан та нарын сурч мэдсэн зарим үнэн юу вэ?

Ариун сүмд боломжийнхоо хэрээр аль болох олон удаа орж байхад ангийн гишүүдийг урамшуулан дэмж. “Бид ариун сүмийн байнгын шүтлэг бишрэлээс ирдэг хувийн адислалуудыг хүлээн авахын тулд ариун сүмд очдог уу? Их Эзэний Ариун сүмд залбирал хариулагдаж, илчлэлт ирэн Сүнсний заавар өгөгддөг юм” гэж Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон хэлсэн байдаг (*In Conference Report*, 1988 оны 4-р сар, 98; *Ensign*, 1988 оны 5-р сар, 85).

Дүгнэлт

Оюун санаа нь баян болохын тулд, бусдад илүү сайн үйлчлэхийн тулд насан туршдаа сурахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж. “Суралцахаар мөн тэрчлэн итгэлээр . . . суралцахыг эрэлхийлэгтүн” (С ба Г 88:118) гэсэн Их Эзэний зарлигийг тэдэнд сануул.

Сүнсээр өдөөгдсөний дагуу, хичээлийн үеэр ярилцсан үнэнүүдийн тухай гэрчил. Та өөртөө олдсон суралцах боломжуудын төлөө талархал илэрхийлж болно.

Нэмэлт заах санаанууд

Та зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болгож дараах санаануудаас нэгийг буюу илүү олныг нь ашиглаж болно.

1. Сургаал ба Гэрээ 88:121-26 дахь зөвлөгөөг хэрэгжүүлэх нь

- С ба Г 88:121-26-г ангийн гишүүдтэй хамт унш. Судрын энэ хэсэг дэх зарчмууд бидний амьдралын бүх талд тусалж чадна гэдгийг хэл. Эдгээр

зарчмуудын ач холбогдлыг харуулсан ямар туршлага та нарт тохиолдож байсан бэ?

2. Бүх зүйлд нэг зэрэг самгардалгүйгээр суралцахыг мэдэх нь

- Бид бүх зүйлд нэг зэрэг самгардалгүйгээр хэрхэн суралцаж болох вэ?

“Та нар бүх зүйлийг нэг дор сурч чадахгүй байгаадаа сэтгэлээр бүү уна. Нэг удаа нэг л зүйлийг сур. Гэхдээ үүнийг сайн сур. Сурсан зүйлээ хадгал. Дараа нь өөр нэг үнэнийг мэдэж, үүнийг нөөцөл. Ингээд хэдхэн жилийн дотор, зөвхөн танд өөрт чинь болон үр хүүхдэд чинь төдийгүй, найз нөхдөд чинь агуу адислал болох ашигтай мэдлэгийн их сан бий болно” гэж Ерөнхийлөгч Вилфорд Вудрафф зөвлөжээ (*The Discourses of Wilford Woodruff*, эмхтгэсэн Г.Хомер Дурхам [1946], 269).

Та энэ ярилцлагын нэг хэсэг болгон С ба Г 78:17-18-ыг ангийн гишүүдтэй хамт уншиж болно.

3. Семинар, институтын ангиудад сайн мэдээнд суралцах нь

Ерөнхийлөгч Гордон Б.Хинклийн дараах мэдэгдлийг хуваалц: “Манай Сүмийн боловсролын агуу хөтөлбөр урагш ахиж байна. Семинар, институтийн хөтөлбөрөөр дамжуулан оюутныг сургах ажил байнга өргөжиж байна . . . Семинар институтийн хөтөлбөрийн давуу талыг ашиглахыг бид боломжтой бүх хүмүүсээс хүсч байна. Сайн мэдээний тухай та нарын мэдлэг өсөн нэмэгдэж, итгэл тань бэхжинэ, ингэснээр та нар гайхалтай сайхан хэлхээ холбоо, нөхөрлөлийг хөгжүүлнэ гэдгийг амлахдаа бид эргэлзэхгүй байна” (In Conference Report, 1984 оны 4-р сар, 69; *Ensign*, 1984 оны 5-р сар, 47).

Танай бүсэд семинар, институтын ангиуд байдаг бол, залуучууд болон залуу насанд хүрэгчдийг семинар институтэд элсэхэд нь урамшуулан дэмжихийн тулд энэ ярилцлагын үеэр та цаг гаргахыг хүсч болох юм. Дараах асуултуудыг асуу:

- Өөрт чинь тусалсан ямар туршлага семинарт (эсвэл институтэд) танд тохиолдсон бэ? Семинарт (эсвэл институтэд) явахад бусдыг бид хэрхэн дэмжиж болох вэ?

4. Боловсролоор дамжуулан авьяасаа хөгжүүлэх нь

Талантын тухай сургаалт зүйрлэлийг нэгтгэн дүгнэ (Матай 25:14-30; мөн С ба Г 82:18-ыг үз). Өөрсдийн авьяас, сонирхлыг цаасан дээр бичихийг ангийн гишүүдээс хүс. Шашны бус болон шашны боловсрол авьяас сонирхлоо хөгжүүлэхэд нь тэдэнд хэрхэн туслах тухай ярилц.

“Бүү мэхлэгд, харин гуйвшгүй байдалд үргэлжлүүл”

Хичээл
24

Зорилго Мэхлэгдэхээс болон урвалтаас хэрхэн зайлсхийхийг ойлгоход нь ангийн гишүүдэд туслах.

Бэлтгэл

1. Сургаал ба Гэрээ 26; 28; 43:1-7; 50; 52:14-19; түүнчлэн энэ хичээлийн бусад судрыг залбирч судал.
2. Ангийн гишүүний Судлах Удирдамж (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.
3. Сүмийн сэтгүүлийн сүүлчийн чуулганы дугаараас одоогийн Ерөнхий эрх мэдэлтнүүдийн нэрсийн жагсаалтыг олж ав.
4. Та хичээлийн эхний хэсэгт түүхийг танилцуулах ангийн гишүүдийг томилж болно. Түүхийн хувийг тэдэнд урьдчилан өг.

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа Хичээлээ дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар эхэл.

Дараах нийлэмж үгсийг самбар дээр бич:

Нэг пинт (0.57л) цөцгий

Буруу бичсэн нэр

Көртландын Ариун сүмийг онцгойлон адислахад суудал хүрэлцэхгүй байв

Эдгээр нийлэмж үгст бүгдэд нь ямар нэг адил нийтлэг зүйл байгааг ангийн гишүүдэд хэл. Энэ бол Сүмээс урвасныхаа төлөө эхэн үеийн Сүмийн зарим гишүүдийн хэлж байсан шалтгаан юм.

Өнөөдрийн хичээлээр хувь хүн урвалтаас хэрхэн зайлсхийх тухай ярилцана гэдгийг тайлбарла. Эдгээр нийлэмж үгс болон эдгээртэй холбогдсон түүхийг хичээлийн сүүлчээр тайлбарла.

Ярилцах ба хэрэгжүүлэх нь

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбиран сонгож ав. Сонгосон материал өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэгийг ярилц.

1. Урвалт уруу удирдаж болох Сатаны мэхлэлтүүдийг бид таньдаг байх ёстой

Сүмийн эхэн үеийн жилүүдэд зарим гишүүд Сатанд мэхлэгдэж, урвалт буюу Бурханыг эсэргүүцэхэд хөтлөгддөг байсныг тайлбарла. Урвасан цөөн гишүүн Сүмийн дайсан болж, Огайо, Миссурид Гэгээнтнүүдийг мөрдөн

хавчихад хувь нэмрээ оруулсан юм. Өнөөдөр Сүмийн бүх гишүүд мэхлэгдэхгүйн тулд итгэлтэй, сонор сэрэмжтэй байх ёстой.

- С ба Г 50:2-3; 2 Нифай 2:18, 27-г ангийн гишүүдтэй хамт унш. Сатан яагаад биднийг мэхлэхийг хүсдэг вэ? Сатан биднийг ямар арга замаар мэхэлж, урвалт уруу хөтлөхийг хичээдэг вэ? (Дараах мэдээллийг ярилцахад ашиглах буюу ангийн гишүүдийн хариулт дээр нэм. Гарчгуудыг самбар дээр бич.)

Бошиглогч бол Сүмд зориулсан илчлэлтийн эх сурвалж гэдгийг эс хүлээн зөвшөөрсөн нь

Зарим гишүүд хуурамч бошиглогчдод мэхлэгдэж байв. Эхэн үеийн нэлээд Гэгээнтнүүд хуурамч илчлэлтээр хэрхэн түр зуур мэхлэгдэж байсныг дараах шастир харуулдаг.

1830 онд Мормоны Номын Найман Гэрчийн нэг Хайрам Пейж Сионыг байгуулах тухай, түүнчлэн Сүмийн дэг жаягийн тухай илчлэлтүүдийг нэг чулуугаар дамжуулан хүлээж авдаг мэтээр мэдэгдсэн аж. Ийм нэг чулуу түүнд байжээ. Оливер Каудери, Витмерийнхэн тэрчлэн бусад хүмүүс түүний энэ мэдэгдэлд итгэдэг байв. Гэвч, энэхүү мэдэгдэл нь “Шинэ Гэрээнд, түүнчлэн бүр саяхны илчлэлтүүдэд үндэслэгдсэн Бурханы өргөөний дэг жаягийн эсрэг бүхэлдээ чиглэсэн юм” гэж Бошиглогч Иосеф Смит хэлжээ (*History of the Church*, 1:110).

Бошиглогч энэ асуудлын талаар залбирч, Сүмд зориулсан илчлэлтүүдийг зөвхөн Сүмийн Ерөнхийлөгч хүлээн авах эрхтэйг Их Эзэн тодорхой болгосон нэг илчлэлт (С ба Г 28) хүлээн авчээ. Нөгөөх чулуугаар дамжин ирсэн илчлэлтүүд Сатанаас байсныг Хайрам Пейжид хэлэхийг Их Эзэн Оливер Каудерид зааварласан аж (С ба Г 28:11). Их Эзэний заавруудыг сонссоны дараа, “Пейж ах, түүнчлэн энд байсан Сүмийнхэн бүгдээрээ нөгөөх чулуу, бас үүнтэй холбоотой бүх зүйлээс татгалзав” (*History of the Church*, 1:115).

Бардамнал

Зарим гишүүд бардам зангаасаа болж мэхлэгдэж байв. Арванхоёрын Чуулгын Ерөнхийлөгч асан Томас Б.Марш, түүний эхнэр Элизабет нарыг бардамнал хэрхэн урвалт уруу хөтөлснийг дараах түүх харуулж байна.

Марш эгч, Харрис эгч хоёр Миссурийн Фар Вестэд амьдарч байхдаа арай ахиухан бяслаг хийхийн тулд бие биендээ сүүгээ ээлжлэн өгч байхаар шийджээ. Үүнээс өөр арга байхгүй байж. Тэр хоёр сүүгээ цөцгийтэй нь хамт өгч байхаар тохиролцов. Гэвч Марш эгч үнээ бүрийнхээ сүүнээс нэг пинт цөцгийг нь авч үлдэн, цөцгийгүй сүүгээ Харрис эгчид явуулдаг байж.

Хэрүүл маргаан дэгдэж, уг асуудал бишопт хүрсэн гэдэг. Марш эгч тохиролцоогоо зөрчсөнийг бишоп тогтоосонд тэрээр нөхрийнхөө хамт ихэд уурлаж, улмаар Дээд зөвлөлд, дараа нь Тэргүүн Зөвлөлд давж заалдав. Хоёр зөвлөл хоёул Марш эгчийг буруутай гэж үзсэн анхны шийдвэрийг хэвээр баталжээ.

Томас Б.Марш эхнэрийнхээ зан төлөвийг дэмжинэ гэдгээ мэдэгджээ. Үүнээс хойш удалгүй тэрээр Сүмийн эсрэг эргэж, засгийн газрын ажилтны өмнө очиж, Хожмын Үеийн Гэгээнтнүүд Миссури мужид дайсагнаж байгаа мэтээр мэдэгдсэн ажээ. (Жорж А.Смит, *Journal of Discourses*, 3:283-284)

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли энэ хэрэг явдлын тухай өгүүлэхдээ: “Аяга цөцгийнөөс болж хоёр эмэгтэй маргасан нь хичнээн өчүүхэн, хичнээн шалихгүй

зүйл билээ. Гэвч энэ нь хамгийн багаар бодоход л Гэгээнтнүүдийг Миссури мужаас хөөн тухай Захирагч Боггс сүйрүүлэгч тушаал гаргах шалтаг болсон юм. Энэ хэргээс улбаалан аймшигтай гай зовлон, үхэл хагацал тохиосон билээ. Энэхүү тулга тойрсон өчүүхэн хэрүүл маргааныг шийдвэрлэх ёстой байсан хүн, харин ч үүнийг бүр дэвэргэж...Сүм дэх албаа алдсан юм. Тэрээр сайн мэдээний тухай гэрчлэлээ алдсан юм” гэжээ (In Conference Report, 1984 оны 4-р сар, 111; *Ensign*, 1984 оны 5-р сар, 83).

Харанхуйн болон гансрал цөхрөлийн 19 жилийн дараа Томас Б.Марш өрөвдөлтэйгөөр Солт Лейкийн Хөндийг зорин ирж, өөрийгөө уучлахыг бас Сүмд дахин баптисм хүртэхийг зөвшөөрөөч гэж Бригам Янгаас гуйсан юм. Тэрээр Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр зөвлөх Хебер К.Кимбаллд бичихдээ: “Би нөхцөл байдлаа ухаарч эхэллээ; . . . Би Тэнгэрийн эсрэг таны нүдэн дээр нүгэл үйлдсэнээ мэдэж байна” гэжээ. Тэгээд тэрээр өөртөө тохиолдсон гацуун сургамжийг дүрслэн: “Их Эзэн надгүйгээр бүхнийг маш сайн хийж чадаж байлаа. Намайг урваснаас болоод Тэр юу ч алдсангүй. Харин, ай хөөрхий, би юу алдсан гээч?! Асар их баялагийг, энэ дэлхий эсвээс үүнтэй адилхан олон гарагийн өгч чадахаас илүү их баялагийг би алдсан юм” гэжээ (1996 оны 4-р сар, 6; *Ensign*, 1996 оны 5-р сар, 7-д Жеймс И.Фауст эш татжээ).

- Бид энэ түүхээс юу сурч болох вэ? Бардам зан хүмүүсийг мэхлэлт, урвалт уруу хөтлөхийг та нар хэрхэн харсан бэ? Их Эзэний өмнө өөрсдийгөө даруусгадаг хүмүүст Тэрээр юу амладаг вэ? (С ба Г 112:2-3, 10; Ифер 12:27-г үз. С ба Г 112 бол Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Томас Б.Маршт өгсөн илчлэлт гэдгийг ажигла.)

Удирдагчдын төгс биш байдлын талаар шүүмжилдэг байсан нь

Зарим гишүүд Сүмийн удирдагчдын төгс биш байдлыг шүүмжилдэг учраас мэхлэгддэг. Саймондс Райдер ийм замаар хэрхэн мэхлэгдсэнийг дараах түүх харуулж байна.

Тэр 1831 онд Сүмд хөрвөгджээ. Райдер Сайн мэдээг номлох нь Их Эзэний хүсэл бөгөөд Сүнсээр илэрхийлэгдсэнийг өөрт нь мэдэгдсэн, Бошиглогч Иосеф Смит, Сидней Ригдон нар гарын үсэг зурсан захидлыг Саймондс Райдер хожим нь хүлээн авсан ажээ. Хүлээж авсан захидал, албан итгэмжлэл аль алинд нь түүний нэрийг *Ryder* гэхийн оронд *Rider* гэж бичсэн байв. “Хэрэв тэрээр ‘Сүнсээр’ дамжин номлохоор дуудагдсан юм бол, нэрийг яагаад алдаатай бичдэг юм бэ? Тэгвэл өөрийг нь үйлчлэлд дуудсан нь ч бас алдаа байж таарна гэж Саймондс Райдер бодсон аж. Өөрөөр хэлбэл, нэрийг нь алдаатай бичсэнээс тэрээр эцсийн эцэст Бурханы Сүнсээр дуудагдсан гэдэгт эргэлзсэн хэрэг!” (*History of the Church*, 1:261). Саймондс Райдер хожим нь Сүмээс урважээ.

- Энэ түүхээс бид юу сурч болох вэ? Сүмийн удирдагчдыг шүүмжилдэг байх нь биднийг мэхлэлтэнд хэрхэн илүү өртөмтгий болгодог вэ?

Гомдсоноос болоод

Сүмийн зарим гишүүд бусад гишүүдийн үйлдлээр гомдож, гомдол нь бугласаар урвалт уруу хөтлөгддөг байв. Үүний нэг жишээг дараах болсон явдал харуулж байна.

Көртландын Ариун сүм дуусахад онцгойлон адислалтад оролцох гэж олон Гэгээнтэн цугласан ажээ. Ариун сүмийн суудал түргэн дүүрч, олон хүмүүс зогсож байсан боловч, хүн болгон ариун сүмийн дотор орж чадаагүй аж. Ариун сүмийн барилгад зориулж 700 доллар өгсөн Ахлагч Фразиер Ийтон сүм пиг дүүрсэний дараа ирсэн учир онцгойлон адислалтад дотогшоо орох боломжгүй болжээ. Эхний өдөр дотогшоо орж чадаагүй хүмүүст зориулж онцгойлон адислалтыг маргааш нь дахин хийсэн ч, Фразиер Ийтоны сэтгэл ханасангүй. Үүнээс болж тэр урвасан ажээ. (Жорж А.Смит, in *Journal of Discourses*, 11:9-ийг үз)

- Энэ түүхээс бид юу сурч болох вэ? Өнөөдөр бусад хүмүүс бидэнд гомдох явдлыг бид хэрхэн бий болгодог вэ? Гомдох нь хэрхэн урвалт уруу хөтөлж болох вэ? Бид гомдлын мэдрэмжийг хэрхэн даван туулж болох вэ?
- С ба Г 64:8-11, 82:1-ийг ангийн гишүүдтэй хамт унш. Хэнийг уучлахыг Их Эзэн биднээс шаарддаг вэ? Уучлах нь яагаад зарим үед хэцүү байдаг вэ? Хүнийг уучлахгүй байхын үр дагавар юу вэ? Хараахан уучлаагүй байгаа хэн нэгнийг уучлахад туслах юу бид хийж болох вэ?

Дуулгаваргүй байдлыг өмгөөлөн хаацайлах нь

Өмгөөлөн хаацайлах гэдэг нь хүлээн зөвшөөрч боломгүй зан авирыг өмөөрөх буюу хамгаалах явдал мөн. Энэ бол буруу гэдгийг нь мэдсээр байж, бид ямар нэг юм хийснийхээ төлөөх сэтгэлийн зовнилоо хөнгөвчлөх арга замыг эрж хайх явдал мөн.

- Өмгөөлөн хаацайлах нь хэрхэн мэхлэлтийн хэлбэр болдог вэ? Заримдаа бид зан авираа хэрхэн өмөөрч хаацайлахыг хичээдэг вэ? Энэ нь яагаад аюултай вэ? Бид өмгөөлөн хаацайлахыг хэрхэн таньж, даван туулж болох вэ?

Дэлхийн хуурамч сургаалыг хүлээн авах нь

- Гишүүдийг мэхэлж, тэднийг урвалт уруу хөтөлж болох дэлхийн зарим хуурамч сургаал юу вэ? (Бурханы зарлиг хэрээс ахадсан хатуу хязгаарлалт тавьдаг, үхэшгүй байдлыг хүлээн зөвшөөрөх боломжгүй, материаллаг эд зүйлс сүнсний зүйлүүдээс илүү чухал гэдэг хуурамч санаанууд жишээ байж болно)

Тэргүүлэх Бишоп Х.Давид Бөөртн: “[Сатаны] хор хөнөөлтэй стратегийн нэг нь, юу зөв, юу буруу болох тухай бидний мэдрэмжийг аажим аажмаар сулруулдаг явдал мөн. Худал хэлж, залилан мэхлэх нь зуршил болсон гэдэгт биднийг үнэмшүүлэхийг Сатан хичээх болно. Тэрээр порнографи үзэхийг бидэнд өдөөн хатгахдаа, энэ нь биднийг бодит ертөнцөд бэлтгэж байгаа хэрэг гэж хэлдэг. Ёс суртахуунгүй байх гэдэг чинь амьдралын сэтгэл булаам хэв маяг юм, Тэнгэр дэх бидний Эцэгийн зарлигуудад дуулгавартай байх нь хоцрогдол гэдэгт биднийг итгүүлэхийг тэр хичээх болно. Сэтгэл татмаар өнгөлөн далдалж, хянуур болгоомжтойгоор зүсээ хувиргасан хуурмаг суртал ухуулгаар Сатан биднийг байнга бөмбөгддөг” хэмээн сургажээ (In Conference Report, 1993 оны 4-р сар, 60; *Ensign*, 1993 оны 5-р сар, 46).

2. Бид гэрчлэлдээ зоригтой байвал мэхлэгдэхээс зайлсхийж чадна

Гэрчлэлдээ зоригтой байж, мэхлэгдэхээс зайлсхийхэд туслахын тулд Их Эзэн бидэнд олон адислал, зарлиг өгснийг тайлбарла.

- Бид мэхлэгдэхээс, урвалт уруу хөтлөгдөхөөс өөрсдийгөө хол байлгахын тулд юу хийж болох вэ? (Энэ ярилцлагыг явуулахын тулд дараах мэдээллийг ашигла)

Их Эзэн Сүмийг удирдуулахаар хэнийг дуудсаныг бид тодорхой мэдэж болно

- Сүмийн эхний жилүүдэд Сүмийг удирдах талаар эсвэл Бошиглогч Иосеф Смитийн дутагдлыг засч залруулах илчлэлт хүлээн авсан мэтээр олон хүмүүс мэдэгддэг байжээ. Эдгээр мэдэгдлийн хариуд Их Эзэн юу илчилсэн бэ? (С ба Г 28:2, 6-7; 43:1-3-ыг үз. Сүмд бүхэлд нь зориулсан илчлэлтүүд хүлээн авсан мэтээр Хайрам Пейж мэдэгдэхэд С ба Г 28 хүлээн авагдсаныг, мөн бусад хүмүүс үүнтэй адил мэдэгдэл хийх үед С ба Г 43 хүлээн авагдсаныг хэл)

- Өнөөдөр Сүмд бүхэлд нь зориулагдсан илчлэлт, зарлигуудыг хэн хүлээж авдаг вэ?

Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит болон Тэргүүн Зөвлөл дэх түүний зөвлөхүүд сургасан нь: “Сүмийн бүх байгууллага, эрх мэдэлтнүүд, ёслол болон сургаалын талаар Сүмийн нийт бие бүрэлдэхүүнд зориулсан илчлэлтийн түлхүүрүүдийг дэлхий дээр тодорхой цаг үед эзэмшүүлэхээр Их Эзэн нэг хүнийг томилж ирсэн юм. Сүнсний нөлөөг хүлээн авах хувь гишүүн бүрийн ашиг тус, гэгээрлийн төлөө бас түүний хөдөлмөрлөхөөр дуудагдсан нөхцөл байдлын дагуу илчлэлтийн сүнс Сүмийн бүх гишүүдэд өгөгддөг. Гэвч Сүмд бүхэлд нь бол тэргүүнд байгаа хүн зарлигийн замаар, мөн маргааныг таслахын тулд илчлэлтийг ганцаараа хүлээн авахаар томилогддог” гэжээ (Жеймс Р.Кларк эмхтгэсэн, *Messages of the First Presidency of The Church of Jesus Christ of Latter-day Saints*, боть 6, [1965-1975], 4:270).

- Сүмд зориулсан илчлэлт хүлээн авдаг мэтээр хуурамчаар мэдэгддэг хүмүүст мэхлэгдэхээс бид хэрхэн зайлсхийж чадах вэ? (С ба Г 43:4-7-г үз)
- С ба Г 26:2, 28:13-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Нийтийн дэмжлэгийн зарчим юу вэ? (С ба Г 20:65; 42:11-ийг үз. Энэ бол бид Сүмд үйлчлэхээр дуудагдсан хүмүүсийг ихэвчлэн баруун гараа өргөн, дэмжихийг хүсч байгаагаа харуулдаг практик юм) Нийтийн дэмжлэгийн зарчим мэхлэгдэхээс биднийг хэрхэн хамгаалж чадах вэ? (Энэ нь Сүмд тэргүүлэх болон удирдан зохион байгуулахаар хэн дуудагдсаныг мэдэх боломжийг бидэнд олгодог. Ингэснээр бид зохих ёсоор дуудагдаагүй хүмүүсийн мэдэгдлээр мэхлэгдэхээс хол байж чадна)

Одоогийн Ерөнхий эрх мэдэлтнүүдийн нэрсийн жагсаалтыг үзүүл (“Бэлтгэл,” зүйл 3-ыг үз). Эдгээр удирдагчдыг дэмжин баталснаас мөн тэдний зөвлөгөөг дагаснаас бидэнд ирдэг адислалыг онцлон тэмдэглэ.

Бид судрууд болон Сүмийн сургаалыг судлах ёстой

- С ба Г 1:37, 33:16-г ангийн гишүүдтэй хамт унш. Сургаал ба Гэрээний эхнээс эцэс хүртэл, судар судлахын ач холбогдлыг Их Эзэн заадгийг тайлбарла. Судруудыг болон хожмын үеийн бошиглогчдын үгсийг судлах нь мэхлэгдэхээс зайлсхийхэд бидэнд хэрхэн тусалж болох вэ? (Доор жагсаасан зүйлс хариулт байж болно)
 - а. Бид аль нэг үзэл санааны үнэн эсэхийг судруудаас мэдэж болно. Бас өнөө үеийн удирдагчдын заадаг үнэнүүдтэй эдгээр санааг харьцуулснаар илүү сайн ялган таньж чадна.

Ерөнхийлөгч Харольд Б.Лий сургасан нь: “Хэрэв [хүн] Сүмийн жишиг бүтээлүүдэс өөрийн чинь олж чадахгүй ямар нэг юмыг бичсэн буюу ярьж байвал, тэр хүн бошиглогч, үзмэрч, илчлэгч биш байвал та тэр даруйд татгалзаж, ‘За, энэ бол түүний хувийн санаа байна’ гэж хэлж болно. Мөн хэрэв тэрээр Сүмийн жишиг бүтээлүүдэд байдагтай зөрчилдсөн ямар нэг зүйлийг ярьж байвал, та мөн тэр тэмдгээр нь энэ бол хуурамч юм байна гэдгийг мэдэж болно” (*The Teachings of Harold B.Lee*, хянан тохиолдуулсан Клайд Ж.Виллямс [1996], 540-541).

б. Судар судлах нь бидний гэрчлэлийг бэхжүүлдэг. Ингэснээр бид зөв шударга байдалд сэтгэл хангалуун байж, хуурамч сургаалаар нөлөөлөгдөх нь бага байна.

“Хэрэв бид судруудыг өдөр бүр уншихгүй бол, гэрчлэл маань нимгэрч, сүнслэг байдал маань өсч гүнзгийрэхгүй” гэж Ерөнхийлөгч Лий сургажээ (*The Teachings of Harold B.Lee*, 152).

- Судруудыг судлах нь мэхлэгдэхээс та нарыг хэрхэн хамгаалдаг вэ?

Бурханы зүйлүүд биднийг үргэлж гэгээрүүлэх болно гэдгийг бид ойлгох ёстой

Гэгээнтнүүд Көртландад суурьшсанаас хойш их удалгүй “олон хуурамч сүнс гарч ирэн, олон хачирхмаар үзэгдэл харагдаж, хачин сонин, шохоорхол татсан төсөөллүүд рүү хэт хошуурч байлаа. Ийм сүнсний нөлөөгөөр хүмүүс гэрээсээ гүйн гарч, зарим нь модны хожуул дээр гарч, хашгиран, бас янз янзын хачирхмаар зүйлүүдийг харуулж байлаа ... Бурханы Сүмийг гутаах, Бурханы Сүнснийг зайлуулахад чиглэсэн, инээдтэй, олон хөгийн хачин юмс гарч ирж байлаа” хэмээн Бошиглогч Иосеф Смит тайлбарлажээ (*History of the Church*, 4:580). Сүнсний эдгээр хэт гажуу хачирхалтай үзэгдлүүдэд санаа нь зовнисон Бошиглогч Их Эзэнээс асуусан аж. С ба Г 50 дахь илчлэлт бол Их Эзэний хариу юм.

- С ба Г 50:17-24-ийг ангийн гишүүдтэй хамт унш. Бид Бурханы зүйлүүдийг Сатаны зүйлүүдээс хэрхэн ялгаж таних талаар эдгээр шүлгүүд юу зааж байна вэ? (Бурханы зүйлүүд бидний оюун ухааныг гэгээрүүлж, сүнслэг байдлын хувьд өсч хөгжихөд туслан биднийг сэнхрүүлнэ. Бурханы зүйлүүд биднийг Аврагчийг дагаж, амьдралаа дээшлүүлэх хүсэлтэй болгодог. Сатаны зүйлүүд үүний эсрэг юм.)

“Сэнхэрдэггүй тэр нь Бурханаас бус болой хэмээн хэлснээс илүү агуу үнэн гэж үгүй билээ. Мөн Бурханаас бус тэр нь, шашин, ёс зүй, философи, эсвэл илчлэлт гэсэн ов мэхээр халхавч хийсэн ч ялгаагүй, харанхуй юм. Бурханаас ирдэг илчлэлт сэнхрүүлэхгүй байна гэж үгүй” хэмээн Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит сургажээ (*Church History and Modern Revelation*, боть 2, [1953], 1:201-202).

Бид мэхлэгдэхээс өөрсдийгөө хамгаалахын тулд Их Эзэний загварыг хэрэглэх ёстой

Көртландад болсон чуулганы маргааш нь Их Эзэн С ба Г 52-ыг илчилжээ. Энэ илчлэлтэд Тэрээр мэхлэгдэхээс зайлсхийж болох загварыг бидэнд өгсөн юм.

- С ба Г 52:14-19-ийг ангийн гишүүдтэй хамт унш. Эдгээр шүлгүүдэд өгүүлснээр “Бурханых” болох багш нар ямар зан чанартай байдаг вэ? Судрын энэ хэсэгт өгөгдсөн загвар мэхлэгдэхээс зайлсхийхэд бидэнд хэрхэн тусалж чадах вэ?

Дүгнэлт

Урвалт руу хөтөлж болох Сатаны заль мэхийг нэгтгэн дүгнэ. Заль мэхнээс биднийг хамгаалахын тулд Их Эзэний өгсөн зөвлөгөөг нэгтгэн дүгнэ. Энэ зөвлөгөөг дагасан үед Их Эзэний Сүнс биднийг зөв зам дээр байлгана гэдгийг онцлон тэмдэглэ. Сүнсээр өдөөгдсөний дагуу, хичээлийн үеэр ярилцсан үнэнүүдийн тухай гэрчил.

Нэмэлт заах санаанууд

Та зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болгож дараах санаануудаас нэгийг буюу хоёуланг нь ашиглаж болно.

1. Хичээлийн эхний хэсгийг заах үйл ажиллагаа

Ангийн гишүүн бүрд нэг зурвас бэлтгэ. Зурвас бүр нь талархлын богинохон захиас буюу хичээл дээр аль нэг судар унших, эсвэл ямар нэг өөр байдлаар хичээлд оролцох даалгавар байж болно. Харин хүн бүрийн нэрийг ялиггүй буруу бич. Хичээлийн эхний хэсгийн эхэнд Саймондс Райдерын тухай түүх мөн бусад түүхийг танилцуулахын тулд зурвасуудыг тарааж өг.

2. Урвалтын эсрэг өөрсдийгөө хэрхэн бэхжүүлэх тухай нэмэлт зөвлөгөө

Урвалтын эсрэг бид өөрсдийгөө бэхжүүлж чадах дараах зүйлүүдийг Далын Ахлагч Карлос И.Асей санал болгожээ:

- “1. Итгэлийг чинь нурааж мэдэх хүмүүсээс зайлсхий. . .
- “2. Зарлигуудыг сахь. . .
- “3. Амьд Бошиглогчдыг дага. . .
- “4. Сургаалын үзэл баримтлалтай бүү зөрчилд, бүү марга. [3 Нифай 11:29-ийг үз]
- “5. Судруудыг судал. . .
- “6. Сүмийн үүрэг зорилгоос бүү няц эсвэл бүү гуйвж дайв. . .
- “7. Дайснуудынхаа төлөө залбир. . .
- “8. “Цэвэр ариун шашныг” шүт [Иаков 1:27, Алма 1:30-ийг үз] . . .
- “9. Бид ариултыг нь мэдэхгүй олон асуулт байж болно. Бас зарим зүйлийг зөвхөн итгэлээр хүлээж авах ёстойг сана” (In Conference Report, 1981 оны аравдугаар сар, 93-94; *Ensign*, 1981 оны арваннэгдүгээр сар, 67-68).

Зорилго Санваарын тухай улам сайн ойлголттой болох, санваарыг зөв шударгаар хэрэглэснээс ирдэг адислалуудыг эрэлхийлэхэд нь ангийн гишүүдэд туслах.

Бэлтгэл

1. Дараах судрууд болон бусад материалыг залбирч судал:
 - а. Сургаал ба Гэрээ 84:33-44; 121:34-46.
 - б. Сургаал ба Гэрээ 107 (нэмэлт судрууд).
 - в. *Бидний Өв*, хуудас 30-31.
2. *Ангийн гишүүний Судлах Удирдамж* (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа Хичээлээ эхлэх үед дараах үйл ажиллагааг буюу өөрийнхөө тохиромжтой аль нэг үйл ажиллагааг хэрэглэ.

Сүмийн гишүүн байгаадаа талархалтай байдаг шалтгаанаа хуваалцахад ангийн гишүүдийг урь. Тэдний хариултыг самбар дээр бич.

- Эдгээр зүйлүүдээс аль нь санвааргүйгээр боломжтой байж болох вэ?

Ангийн гишүүдийн жагсаасан зүйлүүдээс аль нь ч санвааргүйгээр боломжгүй байх магадлалтай. Жишээ нь хэрэв ангийн гишүүд мөнхийн гэрлэлтийн төлөө талархал илэрхийлсэн бол энэ нь санваарын лацдах хүчгүйгээр боломжгүй юм гэдгийг хэл. Бүр Сүм дэх эв нэгдэл мэт ангийн зүйл ч гэсэн, “итгэлийн нэгдлийг” (Ефес 4:13; мөн шүлэг 10-12-ыг үз) олоход бидэнд тусалдаг Бошиглогчид, Төлөөлөгчид, санваартны бусад удирдагчидгүйгээр боломжгүй юм.

Энэ хичээлээр санваар болон үүнтэй холбоотой гэрээ, адислалуудын тухай ярилцана гэдгийг тайлбарла.

Ярилцах ба хэрэгжүүлэх нь

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбиран сонгож ав. Судрын зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Санваарын сэргээлтэн дэх дэг жаяг ба албууд

Аароны болон Мелкизедек санваар 1829 онд дэлхий дээр сэргээгдсэн юм (хичээл 8-ыг үз). 1830 онд Сүм зохион байгуулагдсаны дараа Их Эзэн санваарын алба, чуулга болон зөвлөлүүдийг Сүмийн өсөлт хөгжилтийн дагуу шаардлагатай удирдлагаар хангахын тулд алгуураар илчилсэн билээ.

Доорх цаг хугацааны дараалал эл сэргээлтийг харуулж байна. Цаг хугацааны дарааллыг самбар дээр бичиж, ангийн гишүүдтэй хамт нэгтгэн дүгнэ. Судрын эшлэлүүдийг самбар дээр бичихгүй байж болно.

Аароны санваар: 1829 оны тавдугаар сарын 15 (С ба Г 13)

Мелкизедек санваар: 1829 оны тав буюу зургадугаар сар (С ба Г 128:20)

Төлөөлөгч, ахлагч, санваартан, багш нар, диконууд: 1830 оны дөрөвдүгээр сар (С ба Г 20:3860)

Бишоп: 1831 оны хоёрдугаар сарын 4 (С ба Г 41:9-10)

Дээд пристүүд: 1831 оны зургадугаар сар (С ба Г 52-ын хэсгийн тойм)

Тэргүүн Зөвлөл: 1832-1833 он (С ба Г 81; 90)

Патриарх: 1833 оны арванхоёрдугаар сарын 18 (*Teachings of the Prophet Joseph Smith* [1976], 38-39)

Дээд Зөвлөл: 1834 оны хоёрдугаар сарын 17 (С ба Г 102)

Арванхоёрын Чуулгын Төлөөлөгчид: 1835 он (С ба Г 107:23-24)

Далууд: 1835 он (С ба Г 107:25)

Далын Нэгдүгээр Чуулга: 1835 он (С ба Г 107:26, 93-97)

Сүмийн өсөлт хөгжилтийг удирдах санваартны байгууллага болон үүрэг хариуцлагын тухай илчлэлтүүдийг Их Эзэн манай өнөө үед үргэлжлүүлэн өгсөөр байгааг тайлбарла. Үүний нэг жишээ нь 1997 онд Бүсийн Эрх Мэдэлтэй Далуудыг дуудаж, үүний хамт Далын Гурав, Дөрөв, Тавдугаар Чуулгуудыг байгуулсан явдал мөн (хичээл 42, хуудас 283-84-ыг үз).

2. Санваарын тангараг ба гэрээ

“Санваарын тангараг ба гэрээ” гэж самбар дээр бич. Их Эзэн санваарын албууд болон удирдлагын тухай илчлэлтүүдээс гадна санваар хүлээж авах болон ашиглах тухай зарчмуудыг илчилснийг тайлбарла. Жишээ нь, Тэрээр С ба Г 84:33-44-т байдаг санваарын тангараг ба гэрээг илчилсэн юм. Эдгээр шүлгүүд (1) Мелкизедек санваарыг хүн хүлээж авах үед Их Эзэнтэй түүний хийдэг гэрээнүүдийг, (2) итгэлтэй Мелкизедек санваар зэмшигчидтэй Их Эзэний хийдэг гэрээнүүдийг тоймлон авч үздэг.

Далын Ахлагч Карлос И.Асей хэлсэн нь: “Есүс Христийн сайн мэдээнд хамаатай бүх ариун гэрээнүүдээс, хэрэв байдаг бол цөөхөн нь л санваарын тангараг ба гэрээнд холбогдолгүй байх. Энэ бол хамгийн ариун гэрээнүүдийн нэг гэдэг нь тодорхой. Учир нь энэ бол Тэнгэрлэг хүч болон мөнхийн зорилгууд өөд дээшээ тэмүүлэх хүний эрмэлзэл тэмүүллийг хуваалцах явдал мөн” (In Conference Report, 1985 оны аравдугаар сар, 56; *Ensign*, 1985 оны арваннэгдүгээр сар, 43).

Санваарын тангараг ба гэрээг ярилцах үедээ та, “санваарын адислалууд дан ганц эрэгтэйчүүдээр хязгаарлагддаггүй. Эдгээр адислалууд бас Сүмийн итгэлтэй бүх эмэгтэйчүүд дээр ирдэг. . . Их Эзэн охиддоо Сүнсний бүх бэлгийг мөн хөвгүүдийнхээ олж авч чадах адислалыг санал болгодог. Учир нь Их Эзэний дотор эр хүнгүйгээр эмэгтэй хүн байхгүй, бас эмэгтэй хүнгүйгээр эр

хүн байдаггүй” (Жозеф Фиелдинг Смит, In Conference Report, 1970 оны 4-р сар, 59; *Improvement Era*, 1970 оны зургадугаар сар, 66; мөн Алма 32:23-ыг үз).

- *Санваар эзэмшигчид гэрээнд ордог нь* гэж самбар дээр бич. Санваарын тангараг ба гэрээний хэсэг болгож санваар эзэмшигчид ямар амлалт авдаг вэ? (С ба Г 84:33, 36, 39-44-ийг үз. Ангийн гишүүдийн хариултыг самбар дээр нэгтгэн дүгнэ)

Санваар эзэмшигчид дараах зүйлүүдээр гэрээнд ордог:

- а. Аароны болон Мелкизедек санваар авахад итгэлтэй байх (шүлэг 33).
 - б. Дуудлагадаа хичээл зүтгэл гарган ажиллах (шүлэг 33).
 - в. Их Эзэний үйлчлэгчдийг хүлээн авах (шүлэг 36).
 - г. Мөнх амьдралын үгсэд хичээнгүйлэн анхаарал тавих (шүлэг 43-44).
- Дуудлагадаа хичээл зүтгэл гарган ажиллах гэж юу гэсэн үг вэ? (С ба Г 107:99; Иаков 1:17-19)
“Бид зохих эрх мэдлээр дуудагдсан үүрэгт ажилдаа хичээл зүтгэл, урам зориг гарган үйлчилсэн үед санваараа өндөрт өргөж, дуудлагаа өргөжүүлдэг. . . Бид гай зовлонд учирсан хүмүүст хүрч туслан, итгэл нь буурсан хүмүүст хүч чадлыг өгсөн үед дуудлагаа өндөрт өргөж, санваарынхаа чадамжийг өргөжүүлдэг билээ. . . Бид шударга ёс, ариун журмаар амьдарсан үед дуудлагаа өндөрт өргөдөг” гэж Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлжээ (In Conference Report, 1989 оны 4-р сар, 63; *Ensign*, 1989 оны 5-р сар, 4849).
 - Дуудлагаа өндөрт өргөн эрхэмлэдэг хэн нэгнээр та нар хэрхэн адислагдсан бэ?

Бид дуудлагаа өндөрт өргөн эрхэмлэсэн хэрнээ гэр бүлээ хайхрахгүй, зөнд нь орхихгүйн тулд зөв тэнцвэрт харьцааг олох нь чухал гэдгийг тайлбарла. Арванхоёрын Чуулгын Ахлагч Нийл А.Максвелл хэлсэн нь:

“Зарим үед сайтар бодолгүйгээр зохион байгуулсан Сүмийн хөтөлбөрийн зарим нэмэлт үйл ажиллагаа гэр бүлийн амьдралд саад учруулж болно. “Та нар гэр гэртээ харьцгаа, мөн миний хэлсэн зүйлүүдийг тунгаан бодож, “бас залбиран”, маргаашийн тулд” (3 Нифай 17:3) бэлтгэ хэмээн Есүс амилсаныхаа дараа нифайчуудад хэлсэн нь сургамжтай юм. Та нарыг иргэний клуб, хотын цуглаанууд эсвэл гадасны төвүүд уруу яв гэж Есүс хэлээгүй шүү дээ!” (Conference Report, 1994 оны 4-р сар, 120; *Ensign*, 1994 оны 5-р сар, 89).

- Их Эзэний үйлчлэгчдийг хүлээж авах гэж юу гэсэн үг вэ? (С ба Г 84:36). Бид Их Эзэний үйлчлэгчдээс сайн мэдээний захиас болон ёслолуудыг хүлээн авдаг нь Их Эзэнийг хүлээн авч байгаа хэрэг юм гэдгийг тайлбарла.
- *Их Эзэн гэрээ хийдэг нь* гэж самбар дээр бич. Санваарын тангараг ба гэрээний хэсэг болгож, Их Эзэн ямар адислалууд амладаг вэ? (С ба Г 84:33-34, 38, 42-ыг үз. Ангийн гишүүдийн хариултыг самбар дээр бич)

Их Эзэн дараах зүйлүүдээр гэрээ хийдэг:

- а. Сүнсээр биднийг цэвэршүүлэх (шүлэг 33).
- б. Бидний бие махбодыг шинэчлэх (шүлэг 33).
- в. Абрахам болон түүний үр удамд амлагдсан адислалуудыг бидэнд өгөх (шүлэг 34).

- г. Биднийг өрийн сонгогдогсод буюу сонгосон хүмүүс болгох (шүлэг 34).
 д. Эцэгт байдаг бүхнийг бидэнд өгөх (шүлэг 38).
 е. Биднийг захирах эрхийг Тэнгэр элчүүддээ олгох (шүлэг 42).

- Хэрэв итгэлтэй байх юм бол, бид “Абрахамын үр удам . . . Бурханы сонгогдогсод байх” болно (С ба Г 84:33-34) гэдгийг Их Эзэн амласан билээ. Абрахамын үр удмын адислал, үүрэг хариуцлагууд юу вэ? (Абрахам 2:9-11-ийг үз.) Санваараар дамжин “дэлхийн бүх гэр бүл адислагдана” гэдгийг Абрахам 2:11 харуулдаг. Энэ амлалт хэрхэн хэрэгжиж болох вэ?
- Санваарын тангараг ба гэрээний оргил амлалт нь “Эцэгт байгаа бүхнийг” (С ба Г 84:38) бид хүлээн авч болох явдал мөн. Энэ амлалтыг мэдэх нь бэрхшээлийн үед бидэнд хэрхэн тусалж чадах вэ? Энэ амлалт элбэг дэлбэг байх үед бидэнд хэрхэн тусалж чадах вэ?

3. Санваарыг ашиглах зарчмууд

С ба Г 121:34-46-г зааж, ярилц. Эдгээр шүлгүүдэд Их Эзэн санваарыг ашиглах зарчмуудыг илчилжээ. Тэрээр санваарыг зөв шударгаар ашигладаг хүмүүст зориулсан амлалтуудыг илчилсэн юм. Санваар эзэмшигчид эдгээр зарчмыг хэрэглэхээс гадна, уг зарчмууд нь ерөнхийдөө хүмүүний бүх харилцаанд хэрэглэгддэг. Тиймээс эдгээр зарчим санваар эзэмшдэггүй хүмүүст ч чухал юм.

- Санваар эзэмшигч зарим хүмүүс яагаад санваарын хүчийг ашиглах боломжгүй байдгийг Их Эзэн С ба Г 121:34-40-д илчилсэн юм. Эдгээр шүлгүүдэд өгүүлснээр, санваарын хүчийг ашиглахад нь юу тэдэнд саад болдог вэ? (Тэдний санаа сэтгэл дэлхийн зүйлүүдэд хоргодон, хүмүүний хүндэтгэл хүлээхийн хүслэн болж, нүглээ хаацайлахыг хичээдэг, бардамнал буюу хоосон санаархалдаа хөтлөгдөн, эрх мэдлээ хилс хэргээр урвуулан ашигладаг нь хариулт байж болно)
- “Энэ дэлхийн зүйлүүдэд” (С ба Г 121:35) хэт шунан хамаг анхаарлаа хандуулахын зарим жишээ юу вэ? Дэлхийн санал болгодог зүйлүүдийг эрэлхийлэх нь Их Эзэний санал болгодог зүйлүүдээс биднийг хэрхэн хөндийрүүлдэг вэ? Энэ асуудлыг хүн хэрхэн даван туулж болох вэ?
- Хүмүүс “шударга бус эрх мэдлийг ашигладаг”? (С ба Г 121:39; мөн шүлэг 37-г үз) зарим хэлбэр юу байдаг вэ? Ингэснээс ямар үр дагавар гардаг вэ? Эрх мэдлийг хилс хэргээр урвуулан ашиглах хандлагыг хүн хэрхэн даван туулж болох вэ?

Санваарыг зөвхөн зөв шударга байдлаар ашиглах ёстойг мөн хайрын сүнс бол бусдад үйлчилж, тэднийг адислах арга хэрэгсэл мөн гэдгийг онцлон тэмдэглэ. Арванхоёрын Чуулгын Ахлагч М.Рассел Баллард хэлсэн нь:

“Санваарын эрх мэдлийг гэр бүлд эсвэл Сүмийн дуудлагад бусдын толгой дээр буулгах бороохой мэтээр ашиглах эрх байхгүйг санваар эзэмшигчид хэзээ ч мартаж ёсгүй... Санваарыг Сүмд буюу гэр оронд ямар нэг хэмжээгээр хилс хэргээр ашиглахыг эрэлхийлдэг...хэн ч гэсэн эрх мэдлийнхээ мөн чанарыг ойлгодоггүй. Санваар бол боолчлол бус, үйлчлэл юм, албадлага биш, өрөвч сэтгэл юм; хянах биш, анхаарал халамж тавих юм” гэжээ (In Conference Report, 1993 оны аравдугаар сар, 105; *Ensign*, 1993 оны арваннэгдүгээр сар, 78).

- Санваарын хүчийг ашиглахад нь санваар эзэмшигчдэд туслах зарчмуудыг С ба Г 121:41-42-т Их Эзэн илчилжээ. Эдгээр зарчмууд юу вэ? Бид гэр бүлийн гишүүд, хөршүүд, ажил дээрээ харьцдаг хүмүүс, мөн бусад хүмүүстэй харилцан ажиллахад эдгээр зарчмуудын хэрхэн хэрэглэж болох вэ?

Шийдвэр гаргах буюу ажил даалгаврыг гүйцэд биелүүлэхэд нь хүүхдэд туслах, Сүмийн зөвлөлд шийдвэр гаргах, хэн нэгэн нь ажил үүргээ биелүүлээгүй үед, эсвэл ноцтой санал зөрөлдөөн гарсан үед гэхчлэн тодорхой нөхцөл байдалд эдгээр зарчмуудыг хэрхэн хэрэглэх тухай ярилцахыг та хүсч болох юм.

- Алдааг залруулах буюу сахилгажуулах ямар зарчмууд С ба Г 121:43–44-т илчлэгдсэн бэ? (*Цагаа олж* гэдэг нь “шуурхай,” “түргэн” гэсэн утгатайг тайлбарла. Энэ хэсгийн хам сэдэвт, *хурц тодоор* гэдэг нь “хатуу хахир” буюу “ширүүн” биш, “тодорхой” эсвэл “оновчтой” гэсэн утгатай юм.) Ямар туршлага эдгээр зарчмуудын ач холбогдлыг амьдралд чинь нотолсон бэ? Хайраар сахилгажуулахын үр дагавар нь уураар сахилгажуулахын үр дагавраас ямар ялгаатай вэ?
- “Бодол санааг чинь ариун журам зогсолтгүй чимэн гоёг” гэсэн нь юу гэсэн үг вэ? (С ба Г 121:45). Бид хилэнц буюу цэвэр ариун биш санаа бодлыг оюун ухаанаасаа хэрхэн хол байлгаж чадах вэ? (С ба Г 27:15-18-ыг үз.) Бид ариун журамтай санаа бодлоор оюун ухаанаа хэрхэн илүү идэвхтэйгээр дүүргэж чадах вэ?
- Хэрэв бид “энэрлээр дүүрэн” байж, “бодол санаагаа ариун журмаар зогсолтгүй чимэн гоёх” юм бол, Их Эзэн бидэнд юу амласан бэ? (С ба Г 121:45-46-г үз) Бурханы оршихуйд итгэлтэй байна гэж юу гэсэн үг вэ? (Дараах эшлэлийг үз) Ариун Сүнс бидний байнгын хамтрагч болсон үед бид ямар адислал хүлээн авах вэ?

Ахлагч Гордон Б.Хинкли Арванхоёрын Чуулгад үйлчилж байхдаа хэлсэн нь: “Нэгдсэн Улсын Ерөнхийлөгчид болон бусад засгийн газруудын чухал хүмүүстэй янз бүрийн тохиолдлоор ярилцах онцгой боломж надад тохиосон билээ. Ийм тохиолдол бүрийн төгсгөлд миний бие нэрд гарсан удирдагчтай хамт байсан тэрхүү урамшуулагч туршлагынхаа талаар эргэцүүлэн боддог билээ. Тэгээд дараа нь, Бурханы оршихуйд айлгүй, ичиж зоволгүй, итгэл дүүрэн зогсох нь ирсэн гайхалтай сайхан, ер бусын зүйл вэ? хэмээн би боддог. Энэ бол ариун журамтай эрэгтэй, эмэгтэй хүн бүрд зориулагдсан амлалт юм” (In Conference Report, 1970 оны аравдугаар сар, 66; *Improvement Era*, 1970 оны арванхоёрдугаар сар, 73).

Дүгнэлт

Санваарын ач холбогдлын тухай гэрчлэлээ хэл. Санваарын тангараг ба гэрээний төлөө, түүнчлэн, хэрэв итгэлтэй байх юм бол бидэнд амласан Их Эзэний адислалуудын төлөө талархлаа илэрхийл. Санваарын адислалуудыг илүү бүрэн дүүрэн эрэлхийлэхэд нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Нэмэлт заах санаанууд

Та зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болгож дараах санаануудаас нэгийг эсвэл хоёрыг нь ашиглаж болно.

1. Сүм дэх тэргүүлэх чуулгууд

Санваарын эрх мэдлийн сэргээлтийн чухал хэсэг нь Сүмд тэргүүлэх чуулгуудыг зохион байгуулсан явдал мөн. Бошиглогч Иосефт туслах зөвлөхүүдийг 1832 оны гуравдугаар сард дууджээ (С ба Г 81:1), тэрчлэн нэг жилийн дараа Тэргүүн Зөвлөлийг албан ёсоор зохион байгуулсан юм (С ба Г 90-ийн хэсгийн тоймыг үз). 1835 оны хоёрдугаар сард, арванхоёр хүн Төлөөлөгчөөр дуудагдаж, ингээд Арванхоёрын Чуулга бий болжээ. Бошиглогч үүнээс хойш удалгүй Далын Нэгдүгээр Чуулгыг зохион байгуулав.

- Тэргүүн Зөвлөлийн гишүүд ямар үүрэг хариуцлагатай вэ? (С ба Г 107:9, 22, 65-66, 78-81, 91-92; 112:30-32-ыг үз)
- Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүд ямар үүрэг хариуцлагатай вэ? (С ба Г 107:23, 33, 35, 39, 58; 112:30-32-ыг үз.)
- Далын Чуулгын гишүүд ямар үүрэг хариуцлагатай вэ? (С ба Г 107:25-26, 34, 38, 97-г үз.)
- Сүмийн тэргүүлэх албатнуудын үйлчлэлээр бидний амьдрал хэрхэн адислагддаг вэ?

2. Санваарын үйлчлэлийн ач холбогдол

Гэрээсээ гарах боломжгүй хүнд ариун ёслолыг гүйцэтгэх, санваарын адислалд туслах, номлолд үйлчлэх зэрэг санваартны туршлагаа ангитай хуваалцахад тойргийн нэг санваартныг урь. Энэ үйлчлэлийг хийх үед түүнд төрдөг бодол санааг нь уг санваартнаар яриул. Санваарын тухай мөн бусдад үйлчлэхийн тулд санваарыг ашиглахын ач холбогдлын тухай гэрчлэлийг нь тэр хүнээр хуваалцуул.

“Бүх дэлхий рүү явагтун та нар, мөн сайн мэдээг номлогтун”

Зорилго

Сайн мэдээг хуваалцахын төлөө агуу золиослолууд хийж, бэрхшээлийн үед гуйвшгүй хэвээр үлдсэн Көртландын Гэгээнтнүүдийн үлгэр жишээг дагахад нь ангийн гишүүдэд сүнслэгээр нөлөөлөх.

Бэлтгэл

1. Энэ хичээлийн судрууд болон *Бидний Өв*, хуудас 34-38, 41-42-ыг зал-бирч судал.
2. *Ангийн гишүүний Судлах Удирдамж* (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.
3. *Бидний Өвийн* дараах хэсгүүдийг нэгтгэн дүгнэхэд бэлтгэхийг ангийн гишүүдээс хүс:
 - а. “Огайогийн анхны хөрвөгчдийн номлол”, “Арванхоёрын Чуулгын Төлөөлөгчдийн номлол” (хуудас 34-36).
 - б. “Англи дахь номлол” (хуудас 37-38).
 - в. “Көртландаас дүрвэсэн нь” (хуудас 41-42).

Та энэ хичээлийн бусад түүхийг ярихыг ангийн гишүүдэд даалгаж болно.

4. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах бол, дараах юмсыг жижиг чемодан эсвэл цүнхэнд хийж тавь: Судрууд, хос оймс, таван жижиг зоос, дараах захиасуудыг бичсэн цаас (төгсгөл дэх эшлэлүүдийг орхи):

Энэ чемодан Ахлагч Эраст Снөүгийнх. Би баруун Пеннсилванид номлолд үйлчлэхээр Бошиглогч Иосеф Смитээр дуудагдаад байна. 1836 оны хавар явахыг надад зааварласан. Би Көртландаас ганцаараа явган явна. Би дэлхийн бүх баялгаа авч яваа нь энэ. (*Бидний Өв*, хуудас 36; “*Autobiography of Erastus Snow,*” *Utah Genealogical and Historical Magazine*, 1923 оны долдугаар сар, 106)

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

Бэлтгэсэн чемодан эсвэл цүнхийг үзүүл (“Бэлтгэл,” зүйл 4-ийг үз). Цүнх буюу чемоданыг онгойлгож, цаасан дээр бичсэн зүйлийг уншихыг ангийн нэг гишүүнээс хүс. Тэгээд энэ номлогч юу авч явсныг үзүүл. Үүнд: судрууд, оймс, таван жижиг зоос. *Золиослол*, *Зориг*, *Итгэл* гэсэн гурван үгийг самбар дээр бич. Их Эзэн чиглүүлсний дагуу номлолын энэхүү аяллыг хүлээн авсан Ахлагч Снөүгийн золиослол, эрэлхэг зориг, итгэлийг эргэцүүлэн бодохыг ангийн гишүүдээс хүс.

Огайогийн Көртландад аж төрж байсан Гэгээнтнүүдийн агуу золиослолоор хэрэгжсэн номлолын ажлын тухай ярилцлага энэ хичээлд орж байгааг тайлбарла. Эдгээр номлогчид залуу Сүмийг бэхжүүлэх, сайн мэдээнд хөрвөхөд нь олон хүнд тусалсан юм.

Ярилцах ба
хэрэгжүүлэх нь

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбиран сонгож ав. Ярилцаж байгаа зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг дэмж.

1. Көртландын үед Их Эзэн агуу адислалуудыг юүлсэн нь

Сүүлчийн 13 хичээлийн ихэнх нь Гэгээнтнүүдийг Огайогийн Көртландад байх үед илчлэгдсэн сургаалууд мөн энэ үед тохиолдсон үйл явдлууд дээр анхаарал төвлөрүүлдгийг тайлбарла. Энэ үед Их Эзэн Өөрийн хүмүүсийг агуу ихээр адисалсан юм. Көртландын үеийн чухал үйл явдлуудыг товчхон нэгтгэн дүгнэхэд дараах асуултуудыг ашигла. Шаардлагатай бол өмнөх хичээлүүд болон *Бидний Өв* номыг үз.

- Их Эзэн Көртландын үед ямар чухал сургаалуудыг илчилсэн бэ? (Өргөлийн хууль, аравны нэгийн хууль, алдар суугийн хаант улсууд, Мэргэн Ухааны Үг, Хоёр дахь Ирэлт, санваарын талаарх илчлэлт нь хариулт байж болно)
- Көртландын үе дэх зарим чухал үйл явдал, ажлын амжилтууд юу байсан бэ?

2. Көртланд дахь Гэгээнтнүүд сайн мэдээг хуваалцахын тулд үлэмж золиослол хийсэн нь

Көртландын үеийн өөр нэг чухал тал бол Нэгдсэн Улс, Канад, Англид сайн мэдээг номлох номлогчдыг дуудсан явдал байсныг тайлбарла. Тэдний олонх нь хувиараа агуу золиослол хийж үйлчилсэн юм.

- С ба Г 42:6, С ба Г 88:81-ийг ангийн гишүүдтэй хамт унш. Их Эзэн эдгээр шүлгүүдэд ямар захиас өгсөн бэ? Көртландад өгөгдсөн олон илчлэлтийн дотор сайн мэдээг номлох зарлиг байсныг тайлбарла.

Бидний Өв, хуудас 34-37-гоос “Огайогийн анхны хөрвөгчдийн номлол”, “Арванхоёрын Чуулгын Төлөөлөгчдийн номлол” хэсгүүдийг нэгтгэн дүгнэхийг даалгавар авсан ангийн гишүүнээс хүс.

- Гэгээнтнүүд Сайн мэдээг хуваалцахын тулд ямар золиослол хийсэн бэ?

Та дараах туршлагыг ярьж болно:

Арванхоёрын Чуулгын Ахлагч Парли П.Пратт 1836 онд Канадад номлолд үйлчлэхээр дуудагджээ. Канадын Торонто уруу явах замд нь, “нэг танихгүй хүн Торонто дахь мэргэжлийн бус методист номлогч Жон Тейлорт өөрийг нь танилцуулах захидлыг түүнд өгчээ. Тухайн үеийн Сүмүүд Шинэ Гэрээн дэх Христийн шашинтай нийцэхгүй байна гэдэгт итгэдэг байсан бүлэгтэй Тейлор холбоотой байжээ. Шашны аливаа бүлгээс тусдаа энэ бүлэг үнэнийг эрж хайх зорилгоор хоёр жилийн турш долоо хоногт хэдэн удаа уулздаг байсан аж. Торонтод, Тейлорынхон Ахлагч Праттыг найрсаар хүлээн авав. Харин эхний үед түүний захиас тэдний сонирхлыг татсангүй.

“Номлох найдвартай газарт байх боломжгүйдээ урам нь хугарсан Парли Торонтогоос явахаар шийдээд байв. Тэрээр явахынхаа өмнө ачаа тээшээ авч

Тейлорынхонтой салах ёс гүйцэтгэхээр тэднийхээр орсон байв. Түүнийг тэднийд байхад Леонора Тейлор найз хатагтай Изабелла Валтонд Парлигийн асуудлын тухай ярьсанд хатагтай түүнийг явах болсонд харамсчээ. “Тэр бол Бурханы хүн байж болох хүн шүү” гэж хатагтай Изабелла хэлэв. Ахлагч Пратт гэрт нь байж, номлохыг хүссэн учраас хатагтай Валтон тэр өглөө Тейлорынхоор орсон ажээ. Тэр үед тэрээр сүнслэгээр нөлөөлөгдсөн хэмээн ярив. Пратт зөвшөөрч, тэгээд Жон Тейлорын бүлгийн цуглаанд уригдсан гэнэ. Самарид номлож байсан Филиппийн тухай Шинэ Гэрээний шастирыг Жон цуглаан дээр уншжээ. “Ингэхэд, манай Филип хаана байна вэ? Бид үгийг баяртайгаар хүлээн авч байгаа нь, *бид итгэсэн үедээ* баптисм хүртэж байгаа нь хаана байна вэ? Манай Петр, Иохан, манай Төлөөлөгчид хаана байна вэ? Гар тавилтаар ирдэг Ариун Сүнс хаана байна вэ? . . .” хэмээн тэр асуужээ. Парлиг үг хэлэхийг урихад, Жон Тейлорын асуултуудын хариу өөрт нь байгааг тэр мэдэгдэв.

“Жон Тейлор гурван долоо хоногийн турш Ахлагч Праттын цуглаануудад оролцож, номлолынх нь нарийвчилсан тэмдэглэлийг хөтөлж, судруудтай нягтлан харьцуулжээ. Есүс Христийн үнэн сайн мэдээ сэргээгдсэнд тэрээр аажмаар итгэн үнэмшив. Тэрээр гэргий Леонорагийн хамт 1836 оны тавдугаар сарын 9-нд баптисм хүртжээ” (*Church History in the Fullness of Times* [Church Educational System manual, 1993], 157; мөн Парли П.Пратт, *Autobiography of Parley P.Pratt* [1975], 134-40, 151-ийг үз).

Жон Тейлор ахлагчаар томилогдож, номлогчоор итгэлтэй үйлчилж байв. Хожим нь тэр Сүмийн гурав дахь Ерөнхийлөгч болсон билээ.

- Ахлагч Пратт сайн мэдээг номлохыг хүсч байхад нь Их Эзэн түүнийг хэрхэн адисалсан бэ?

Ливай Ханкок 1830 оны арваннэгдүгээр сард баптисм хүртсэнээсээ хойш удалгүй Көртландыг орхин, Миссурид номлолд үйлчлэхээр дуудагджээ. Тэрээр хамтрагч Зебедий Колтринтай хамт хэдэн зуун бээр газрыг явган туулж, аяллынхаа үеэр сайн мэдээг номлоход амжилт олов. “Гэвч тэд аяллынхаа үеэр олон зовлон бэрхшээлтэй тулгарсан ажээ. Ливай хөлөндөө халдвар авсны улмаас өвчилж, түүнийг эдгээхээр хүлээн авсан нэг гэр бүлтэй хамт хэсэг хугацааг өнгөрүүлэхэд Зебедий хамтрагчгүйгээр цааш явав. Хожим нь тэрээр Миссурид өвчинтэйгөө тэмцэлдэж, хүссэн бүхнээ хийх чадваргүй болсондоо зарим үед унтууцдаг байжээ. Гэвч тэрээр үйлчлэхдээ баяртай байж: “Би Бурханы өмнө үнэнч байж, энэ хаант улсын төлөө сайн бүхнийг хийнэ. Эс тэгвэл намайг хараал идэг. Дэлхий юу гэх бол эсвэл хүмүүс юу гэж хэлэх бол гэдгээс би айхгүй байна. Хүмүүс Миний Гэрчлэлийг Шүүлтийн суудал дээр хүлээн зөвшөөрөх болно. Миний үгст хүмүүс зайлшгүй итгэх тийм байдлаар би биеэ авч явах болно. Их Эзэн надад тусална” хэмээн бичжээ.

Хожим нь Ливай Сионы Хуаранд бие сэтгэлээ зориулж, зоригтойгоор үйлчилсэн ажээ. 1835 оны хоёрдугаар сард тэрээр Далын Ерөнхийлөгчдийн нэгнээр сонгогдсон юм. (Дон Л.Сөөрл, “It Is the Truth, I Can Feel It,” *Ensign*, 1999 оны долдугаар сар, 48-50-ийг үз)

- Бид эдгээр түүхээс номлолын ажлын талаар юу мэдэж болох вэ? Бид номлолын ажил дахь бэрхшээлийг даван туулах талаар юу мэдэж болох вэ?

- Бид бүрэн цагийн номлогчоор үйлчлэхийн тулд ямар золиослол хийх хэрэгтэй вэ? Бид сайн мэдээг найз нөхөд, хөршүүдтэйгээ хуваалцахын тулд ямар золиослол хийх хэрэгтэй вэ?

3. Арванхоёрын Чуулгын гишүүд Англид мянга мянган хүмүүст заав

Сүмийн эсрэг ажилладаг хүчнүүд сүм өсч хөгжихийн хэрээр улам идэвхжиж байсныг тайлбарла. Зарим Гэгээнтнүүд итгэл бишрэлдээ гуйвж дайвж байлаа. Их Эзэн энэхүү хүнд бэрх цагт “Өөрийнхөө Сүмийн авралын төлөө ямар нэг шинэ зүйл хийхийг” Бошиглогч Иосеф Смитэд илчилжээ” (*History of the Church*, 2:489).

Бидний Өв, хуудас 37-38-аас “Англи дахь номлол” хэсгийг нэгтгэн дүгнэж, ямар ажил хийгдсэнийг тайлбарлахыг даалгавар авсан ангийн гишүүнээс хүс.

- Мөрдлөг хавчлага, хүнд сорилтын энэ үед Их Эзэн Сүмийг хэрхэн адисалсан бэ? Бид Ахлагч Хебер К.Кимбаллын үлгэр жишээнээс юу сурч болох вэ?

Ийм хүнд үед Көртландыг орхих зарлигийг Их Эзэн дээрх ах нарт өгсөн нь ойлгоход хэцүү байж болох юм. Гэвч итгэлтэй ах нарын хийсэн золиослол Сүмийг бэхжүүлэхэд үлэмж ихээр нөлөөлсөн билээ.

1837 оны долдугаар сарын 23-нд номлогчид Англид сайн мэдээг анх номлосон тэр өдөр Арванхоёрын Чуулгын Ерөнхийлөгч Томас Б.Маршид зориулсан нэг илчлэлтийг Бошиглогч Иосеф Смит хүлээн авчээ. Энэ илчлэлт бол эдүгээ С ба Г 112 юм. Шүлэг 12-34 нь Томас Б.Марш Арванхоёрт өгөх ёстой байсан зааврыг агуулдаг.

- С ба Г 112:19-22-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Их Эзэн эдгээр шүлэгт Арванхоёр Төлөөлөгчид ямар амлалтууд өгсөн бэ?

С ба Г 112:19-д өгөгдсөн амлалт түргэн биелэгдсэнийг тайлбарла. Эдгээр номлогчдын хүч чармайлтаар найман сарын дотор 2000 хүн Сүмд нэгдэж, 26 салбар зохион байгуулагдсан байлаа.

Хэрэв тэд “[Түүний] өмнө өөрсдийгөө даруусгаж . . . [Түүний] үгээр амьдран, мөн [Түүний] Сүнсний дуу хоолойг анхааран дагах” (С ба Г 112:21-22) юм бол сайн мэдээг үндэстнүүдэд номлох хүчийг тэдэнд өгөх болно хэмээн Их Эзэн Арванхоёрт амласан юм. Их Эзэн энэ амлалтаа цаашид биелүүлснийг харуулахын тулд та Ерөнхийлөгч Томас С.Монсоны ярьсан дараах түүхийг хуваалцаж болно:

“1968 онд Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улсад намайг анх очиход хурцадмал байдал намжаагүй байлаа. Итгэл, ойлголт байсангүй. Дипломат харилцаа тогтоогүй байв. Үүлэрхэг, бороо цутгасан нэг өдөр би Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улсын гүнд орших Герлиц хотод очиж, Гэгээнтнүүдтэй хамт анх удаа цуглаанд оролцов. Бид эртний нэг жижигхэн барилгад цуглав. Гишүүд Сионы тухай дууллуудыг дуулахад танхим тэдний итгэл, бие сэтгэлээ зориулсан итгэл бишрэлээр дүүрэн байлаа.

“Гишүүдэд патриарх, тойрог буюу гадас байхгүй ердөө л салбаруудтай болохыг мэдээд зүрх сэтгэл минь харууслаар дүүрч билээ. Тэд ариун сүмийн адислал, хувийн хишиг, лацдан холболтыг алиныг нь ч хүлээн авч чаддаггүй байлаа. Сүмийн төв байгууллагуудаас албан ёсны зочин ирээгүй их уджээ. Гишүүд улс орноосоо гадагш явж болдоггүй байв. Гэвч тэд Их Эзэнд бүх зүрх сэтгэлээрээ итгэдэг байлаа.

“Индэр дээр зогсож байхад нүд минь нулимсаар дүүрч, сэтгэл хөдөлснөөс хоолой зангиран: “Хэрэв та нар Бурханы зарлигуудад үнэнч, итгэлтэй хэвээр байх юм бол аль ч орны Сүмийн ямар ч гишүүний эдэлдэг адислал та нарт ирэх болно” гэсэн амлалтыг би тэр хүмүүст өгч билээ. Дараа нь би юу хэлснээ ойлгосон. Би тэр шөнө өвдөг сөгдөн, “Аав аа, би Таны зараалаар явна. Энэ сүм Таны Сүм. Би өөрийнхөө үгсийг биш харин Таны, бас Таны Хүүгийн үгсийг ярилаа. Эрхэм хүндэт энэ хүмүүсийн амьдралд өгсөн амлалтаа Та биелүүлнэ үү” хэмээн Тэнгэрлэг Эцэгээсээ гуйж билээ. Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улсад хийсэн миний айлчлал тийн өндөрлөв.”

Найман жилийн дараа Ахлагч Монсон энэ нутагт онцгойлон адислах залбирал хэлжээ:

“1975 оны дөрөвдүгээр сарын 27-ны ням гарагийн өглөө би Дрезден, Мейззен хотын хооронд, Элба мөрнөөс дээш өндөрт байдаг өнчин хадан дээр зогсон, энэ нутаг болон эндхийн хүмүүсийн талаар залбирал хэлж билээ. Энэ залбиралд гишүүдийн итгэлийг хэлсэн юм. Ариун сүмийн адислалыг олж авах гэсэн олон хүний зүрх сэтгэлийн эрхэм нандин, оргилуун хүсэл эрмэлзлийг онцгой анхаарсан юм. Энх тайвны төлөөх гуйлт илэрхийлэгдэж, бурханлиг тусламж хүссэн билээ. ‘Эрхэм хүндэт Эцэг минь, энэ нутаг дахь Таны Сүмийн гишүүдийн хувьд шинэ үеийн эхлэл байх болтугай’ гэсэн үгсийг би хэлсэн юм.

“Тэртээ доорх хөндийгөөс сүмийн шовх орой дээрх хонх гэнэт дуугарч, азарган тахианы чанга дуу өглөөний нам гүмийг цочоон эвдсэн нь шинэ үеийн эхлэлийг зарлан тунхагласан хэрэг байлаа. Нүд минь аниастай байсан хэдий ч, нүүр, гар, мөрийг минь ээж байсан нарны бүлээхэн илчийг би мэдэрч байлаа. Яагаад ингэдэг билээ? Өглөөжингөө бороо тасралтгүй орж байсан биш бил үү.

“Залбирлын эцэст би тэнгэр өөд ширтэн харлаа. Өтгөн үүлний цоорхойгоор нарны туяа гийн тусч байныг ажиглав. Энэ туяа бидний бяцхан бүлгийн зогсож байсан газар дээр тусчээ. Бурханлиг тусламж ойрхон байгааг би тэр үеэс мэдсэн юм.”

Сүнсээр нөлөөлөгдсөн залбирлын дараа энэ оронд Сүм түргэн өссөн юм. Дүүргийн зөвлөлүүд зохион байгуулагдаж, дараа нь гадаснууд бий болов. Санваартны удирдагчид, патриархууд дуудагдав. Германы Фрайбергийн Ариун сүм 1985 онд онцгойлон адислагдав. 1989 онд бүрэн цагийн номлогчдыг тус оронд илгээхийг засгийн газар нь Сүмд зөвшөөрлөө. (In Conference Report, 1989 оны 4-р сар, 66-69; *Ensign*, 1989 оны 5-р сар, 50-53)

4. Көртландад олон Гэгээнтнүүд мөрдлөг хавчлагыг эс хайхран зоригтой байсан нь

1838 он гэхэд Көртланд дахь Гэгээнтнүүдийн үе дуусах дөхөж байсныг тайлбарла. Мөрдлөг хавчлага гаарч, энд байх нь аюултай болж эхлэв. *Бидний Өв*, хуудас 41-42 дахь “Көртландаас дүрвэсэн нь” хэсгийг нэгтгэн дүгнэхийг даалгавар авсан ангийн гишүүнээс хүс.

Сүмийн зарим гишүүд Көртландад урвасан үед гишүүдийн ихэнх нь итгэлтэй хэвээр үлдэж, агуу хүч чадал болж байлаа. Бригам Янгийн амьдралаас дараах туршлагыг ярь:

Бригам Янг Көртландад амьдарч байхдаа урвагчдын нэгэн бүлгийн, түүний дотор Бошиглогч Иосеф Смитийг авч хаян, оронд нь өөр хэн нэгнийг тавихаар хуйвалдсан, Сүмийн зарим нэрд гарсан удирдагчдын нэг цуглаанд дээр байсан гэдэг. Бригам Янг энэ явдлын тухай өгүүлэхдээ:

“Би босч, энгийн атлаа хүчтэй нөлөө үзүүлсэн хэлбэрээр, Иосеф бол Бошиглогч мөн, би үүнийг мэднэ. Та нар түүнийг зэмлэн, гүжирдэн гүтгэж, өөрсдийгөө хүссэнээрээ баярлуулж болох юм. Харин та нар түүний Бурханы Бошиглогчийнх нь томилолтыг устгаж чадахгүй. Та нар зөвхөн өөрсдийнхөө эрх мэдлийг устгаж, Бошиглогчтой болон Бурхантай өөрсдийгөө холбосон шижим холбоог тасдаж, өөрсдийгөө там уруу живүүлнэ гэж би хэлсэн. Олон хүн миний эрс шийдэмгий эсэргүүцэлд дэлбэрэх шахтлаа уурлан хилэгнэв. . . Энэ цуглаан урвалтгүйгээр, эсэргүүцлийн санаа бодол замхран арилж, эв нэгдэлд хүрснээр дууссан юм” гэжээ (“History of Brigham Young,” *Deseret News*, 1858 оны 2-р сарын 10, 386).

- Бригам Янг тэр цуглаан дээр ямар чанарыг харуулсан бэ? Сүмийн удирдагчдаа дэмжих нь биднийг хэрхэн бэхжүүлдэг вэ?

Дүгнэлт

Көртландад аж төрж байх үед нь Гэгээнтнүүдэд агуу адислалууд ирснийг онцлон тэмдэглэ. Тэднээс олон нь номлолд үйлчлэхээр дуудагдаж, сайн мэдээг хуваалцахын тулд золиослолыг хүсэл эрмэлзэлтэйгээр хийж байлаа. Түмэн бэрхшээл зовлонгийн үед гишүүдийн олонх нь итгэлтэй хэвээр үлдсэн юм. “Тэд амьдралын үлгэр жишээгээрээ . . . Их Эзэний тослогдсон удирдагчдад итгэлтэй, дуулгавартай байж, Их Эзэний ажилд хувиараа золиослол хийх байнгын өвийг үлдээсэн юм” хэмээн Сүмийн эдгээр гишүүдийн талаар *Бидний Өвд* (42) өгүүлжээ.

Их Эзэний ажлын төлөө агуу золиослол хийж, бэрхшээлийн үед итгэлтэй хэвээр үлдсэн Көртландын Гэгээнтнүүдийн үлгэр жишээг дагахад ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Сүнсээр өдөөгдсөний дагуу хичээлийн үеэр арилцсан үнэнүүдийн тухай гэрчил.

“Тэд бүр Абрахамын адилаар гэсгээн цээрлүүлэгдэж, мөн соригдох ёстой нь шаардлагатай байна”

Зорилго

Миссурид Сионы хотыг байгуулах эхэн үеийн Гэгээнтнүүдийн хүч чармайлтыг мэдэх, өнөө үед Сионыг байгуулахад туслахад ангийн гишүүдийг урамшуулан дэмжих.

Бэлтгэл

1. Дараах судрууд болон бусад материалыг залбирч судал:
 - а. Сургаал ба Гэрээ 101; 103; 105.
 - б. *Бидний Өв*, хуудас 30-34, 43-55.
 2. *Ангийн гишүүний Судлах Удирдамж* (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.
 3. *Бидний Өв* дэх дараах хэсгүүдийг нэгтгэн дүгнэхэд бэлтгэхийг ангийн гишүүдээс хүс:
 - а. “Жаксон дүүрэг дэх мөрдлөг хавчлага”, “Бишоп Партрижийг давирхайдаж, өд наасан нь” (хуудас 46-47, 48-49).
 - б. “Клей дүүрэгт толгой хоргодсон нь” (хуудас 50-51).
 - в. “Сионы Хуаран дахь удирдагчдын сургалт,” “Сионы Хуаранг мөрдөн хавчсан нь” (хуудас 31-32, 51-52).
-

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

- Гэр бүлээ орхин, хүнд бэрх нөхцөлд 1600 км газар явган явж, дайсагнасан нутагт байгаа Сүмийн гишүүдэд туслахыг та нараас хүсвэл хэрхэн санагдах вэ? (Та 1600 км хол орших сайн мэдэх газрыг сонгож, уг аялал хэр зэрэг хол болохыг харуулахын тулд газрын зураг авчрахыг хүсч болно) Энэ нь та нараас ямар золиослол шаардаж болох вэ? Хэрэв та нар хүрэх ёстой газартаа хүрч иртэл, туслахын тулд юу ч хийлгүйгээр буц гэвэл та нарт ямар санагдах вэ?

Миссурийн Жаксон дүүрэг дэх Гэгээнтнүүд гэр орноосоо хөөгдөхөд Иосеф Смит тэдэнд туслахын тулд 207 хүнтэй бүлэг–Сионы Хуаранг зохион байгуулж, Огайогоос бараг 1600 км хол газар уруу хээрийн аянаар хөдөлгөснийг тайлбарла. Сионы Хуаранд оролцогчдод тулгарч байсан зарим бэрхшээлийг ойлгоход өмнөх асуултууд та нарт тусалж болно.

1. Гэгээнтнүүд Миссурийн Жаксон дүүрэгт суурьшиж, хожим эндээс хөөгдсөн нь

Дараах түүхэн мэдээллийг товчхон нэгтгэн дүгнэ. 1831-1838 оныг хүртэл, хүн ам суурьшсан хоёр төв Сүмд байсны нэг нь Огайогийн Көртландад, нөгөө нь баруун Миссурид байсныг ангийн гишүүдэд сануул. Энэ хоёр газрын аль алинд нь чухал үйл явдлууд болсон юм. Хичээл 27, 28 нь Миссури дэх Сүмтэй холбоотой сургаал болон үйл явдлуудад анхаарал төвлөрүүлдэг.

1831 оны долдугаар сард Иосеф Смит анх удаа Миссури руу явав. Тэнд тэрээр Миссурийг Сионы хотын газар, Индепенденсийг түүний төв газар байхаар тогтоосон илчлэлт хүлээн авчээ (С ба Г 57:1-3). Сидней Ригдон наймдугаар сарын 2-нд Гэгээнтнүүдийн цугларалтын газрыг онцгойлон адислав. Маргааш нь Бошиглогч Иосеф Смит Индепенденс дэх Ариун сүмийн газрыг онцгойлон адисалжээ.

Нью-Йорк дахь Колесвилл салбарын гишүүд бол Миссурид суурьшсан анхны Гэгээнтнүүд байсан бөгөөд бусад хүмүүс энд удалгүй цугларч, Сионы хотыг байгуулахад туслахыг ихэд хүсч байв (С ба Г 63:24, 36). 1832 он гэхэд 800 гаруй Гэгээнтнүүд Индепенденс, түүнчлэн Жаксон дүүргийн эргэн тойрон дахь нутгуудад таван салбар болж цугласан байв.

Жаксон дүүрэг дэх Гэгээнтнүүдэд энэ үе бол амар амгалан, урам зоригийн цаг байлаа. Гэвч 1832 оны сүүлчээр олон асуудал дараа дараалан босч ирэх нь тэр. Зарим гишүүд Сүмийн орон нутгийн удирдагчдыг хүлээн зөвшөөрөхгүй байв. Бусад нь Көртландад буцаж ирсэн Бошиглогч Иосефыг шүүмжилж байлаа. Зарим гишүүд зөрчил сөргөлдөөнтэй, хомхой сувдаг сэтгэлтэй, амин хувиа хичээсэн, итгэлгүй байв.

Түүнээс гадна, тус нутаг дахь бусад суурьшигчдын дунд ч хурцадмал байдал өсөн нэмэгдэж байлаа. 1833 оны долдугаар сарын 20-нд энэхүү хурцадмал байдал хүчирхийлэл болон өргөжив. “Жаксон дүүрэг дэх мөрдлөг хавчлага,” (*Бидний Өв*, хуудас 46-47), “Бишоп Партрижийг давирхайдаж, өд наасан нь” (*Бидний Өв*, хуудас 48-49) хэсгүүдийг нэгтгэн дүгнэхийг даалгавар авсан ангийн гишүүнээс хүс.

1833 оны долдугаар сараас арваннэгдүгээр сарын хооронд Гэгээнтнүүдийн эсрэг мөрдлөг хавчлага улам хүчтэй болов. Танхайрагч бүлгүүд тэдний үр тариаг шатааж, гэр орныг нь түйвээн, эрчүүдийг зодож занчин, эмэгтэйчүүд, хүүхдийг айлган сүрдүүлж байлаа.

Арваннэгдүгээр сарын 4-нд, Биг Влүү голын ойролцоо танхайрагч бүлгийн гишүүд Хожмын Үеийн Гэгээнтэн эрчүүд, хөвгүүдийн жижигхэн бүлгийн эсрэг тулалдав (*Бидний Өв*, хуудас 42-43). Дараагийн хоёр өдрийн турш 1000 гаруй Гэгээнтнүүд хөхөө өвлийн хүйтнээр Жаксон дүүргээс хөөгджээ. Ядарч зүдэрсэн тэдний олонх нь Миссури мөрнийг гаталж, Клей дүүрэгт түр зуур толгой хоргодох газар олжээ. *Бидний Өв*, хуудас 50-51-ээс “Клей дүүрэгт толгой хоргодсон нь” хэсгийг нэгтгэн дүгнэхийг ангийн нэг гишүүнд даалгавар өгч хүс.



Миссури дэх мөрдлөг хавчлага. Гэгээнтнүүд Миссурийн Жаксон дүүрэг дэх гэр орноосоо хөөгдөв.

2. Жаксон дүүргээс хөөгдсөн Гэгээнтнүүдэд Их Эзэн заавар өгсөн нь

Миссури дэх гай зовлонгийн тухай үг Көртландад байсан Иосеф Смитэд хүрч, тэрээр санаа нь маш их зовсныг тайлбарла. Тэрээр Сионы гэтэлгэлийн талаар залбирч эдүгээ С ба Г 101 болох илчлэлтийг хүлээн авчээ.

- Миссури дэх Гэгээнтнүүд дээр гай зовлон ирэхийг зөвшөөрсөн ямар учир шалтгаануудыг Их Эзэн хэлсэн бэ? (Дараах шүлгүүдийг ангийн гишүүдтэй хамт унш. Мэдээллийг самбар дээр нэгтгэн дүгнэ. Ярилцлагад дэм үзүүлэхийн тулд асуултуудаас заримыг нь сонгож ав)
 - а. С ба Г 101:2, 6 мөн С ба Г 103:4-ийг үз (Тэдний зөрчлүүдийн улмаас).
 - б. С ба Г 101:4. (Бүр Абрахамын нэгэн адил тэднийг “зэмлэж, сорих нь” хэрэгтэй байсан учраас) Ямар зорилгоор Их Эзэн Өөрийн хүмүүсийг буруутган зэмлэсэн бэ? (С ба Г 95:1; 105:6; Хиламан 12:3; Еврей 12:11-ийг үз) Их Эзэний зэмлэл биднийг хайрлах Түүний хайрыг хэрхэн харуулдаг вэ? Дуулгавартай байдалд суралцах, Түүнийг дурсан санахад Их Эзэний зэмлэл бидэнд хэрхэн тусалдаг вэ?
 - в. С ба Г 101:7-8. (Их Эзэнийг сонсон дагахад Гэгээнтнүүд удаан хойрго байсны улмаас) Хүмүүс яагаад зарим үед “амар амгалангийнхаа өдөрт” Бурханыг мартаж, зөвлөгөөг нь үл ойшоодог вэ? Бурханы зөвлөгөөг дагах хүсэл эрмэлзэлтэй байхад өөрсдөдөө туслахын тулд бид юу хийж болох вэ?
- Их Эзэн Гэгээнтнүүдийг зэмлэсний дараа өрөвч сэтгэлийг тэдэнд хэрхэн харуулсан бэ? (Дараах шүлгүүдийг ангийн гишүүдтэй хамт унш. Мэдээллийг самбар дээр нэгтгэн дүгнэ.)

- а. С ба Г 101:9. (Тэднийг хаяхгүй гэдгийг, мөн “уур хилэнгийн өдөрт” нигүүлсэнгүй байх болно гэдгийг Тэрээр амласан билээ)
- б. С ба Г 101:10. (Түүний зэвүүцэл дайснууд дээр нь буух болно гэдгийг Тэр амласан юм)
- в. С ба Г 101:11-15. (Өөрийн Гэгээнтнүүдийг аварч, цуглуулан, тайтгаруулна гэдгийг Тэр амласан юм)
- г. С ба Г 101:16-19. (Ирээдүйд Сион гэтэлгэгдэнэ гэдгийг Тэр амласан байлаа)

Онцгой хэрэгцээ гарсан үед Их Эзэний хайр, нигүүлслийг мэдэрсэн туршлагаа хуваалцахад ангийн гишүүдийг урь.

- С ба Г 101:35-38-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Бид мөнх бус амьдралаа зохих хэтийн төлөвт нь байлгахад өөрсдөдөө туслахын тулд юу хийж болох талаар эдгээр шүлгүүдээс бид юу сурч болох вэ? Хүнд сорилтын үед Их Эзэний мөнхийн амлалтуудыг мэдэх нь та нарт хэрхэн тусалдаг вэ?

3. Сионы Хуаран зохион байгуулагдаж, Миссури уруу хээрийн аянд гарсан нь

Гэгээнтнүүд Жаксон дүүргээс хөөгдсөний дараа тэд гэр орныг нь сэргээх болон хамгаалалт эрж Миссурийн Захирагч Даниел Данклинд өргөдөл гаргасан байв. Хэрэв Гэгээнтнүүд өөрсдийгөө хамгаалахын тулд эрчүүдийн бүлгийг зохион байгуулах юм бол тусалж болохоо захирагч илэрхийлжээ.

1834 оны хоёрдугаар сард, Иосеф Смит Огайогийн Көртландад энэ саналыг хүлээн хүлээн авав. Миссури дэх Гэгээнтнүүдэд газрыг нь эргүүлэн олгоход туслах, цаашид тэднийг хамгаалахын тулд бараг 1600 км газар хээрийн аян хийх эрчүүдийн бүлгийг зохион байгуулснаар тэрээр уг саналд хариулжээ. Сионы Хуаран хэмээн нэрлэгдсэн энэхүү хээрийн аяны талаар чиглэлүүдийг өгсөн илчлэлт С ба Г 103-т цэдэглэгдсэн байдаг.

Сионы Хуарангийн тухай *Бидний Өв*, хуудас 31-34, 51-53-ыг нэгтгэн дүгнэхийг даалгавар авсан ангийн гишүүнээс хүс. Көртланд, Миссурийн хоорондох зайг харуулахын тулд та энэ гарын авлагын хуудас 316, мөн *Ангийн гишүүний Судлах Удирдамжийн* хуудас 31 дээрх газрын зураг 3-ыг үзүүлж болно.

- С ба Г 103-т Их Эзэнээр чиглүүлэгдсэний дагуу, гэр орон, газраа эргүүлэн авахад нь Жаксон дүүрэг дэх Гэгээнтнүүдэд туслахын тулд Иосеф Смит Сионы Хуаранг зохион байгуулсан юм. Энэ зорилгын талаас нь авч үзвэл Сионы Хуарангийн үр дүн юу болсон бэ? (Хуаран Жаксон дүүргийн ойролцоох Фишинг гол руу бараг 1600 км аян хийсний дараа, Сионы гэтэлгэлийн төлөө Гэгээнтнүүд хүлээх хэрэгтэй байгаа тухай Их Эзэн илчилжээ. Бошиглогч үүнээс хойш удалгүй хуаранг тараажээ)
- Сионы Хуарангийн дараа Бригам Янг Көртландад буцаж ирэхэд, “Энэ аянаас та юу олов?” гэж түүнээс асуужээ. “Юуны төлөө явсан, түүнийгээ л оллоо . . . Би аяны үед олж авсан мэдлэгээ [энэ] Дүүргийн бүх юмаар ч солихгүй” гэж хариулсан гэдэг (in *Journal of Discourses*, 2:10). Сионы Хуаран ямар чухал зорилгыг хэрэгжүүлсэн бэ? (Доор жагсаасан зүйлс хариулт байж болно)
 - а. Их Эзэний хүч хэдэн удаа гайхалтайгаар үзүүлэгдсэнээр хуаранд оролцогчид хүчирхэгжсэн байлаа (нэг жишээ болгон *Бидний Өв*, хуудас 51-52-ыг үз).

- б. Их Эзэний хүслийг биелүүлэхийн тулд шаардлагатай бол бүх зүйлийг золиослон Түүнийг дуулгавартай дагах боломжийг оролцогчдод олгон, итгэлийг нь сорих боломжоор хуаран хангасан юм.
- в. Хуаран нь Сүмийн удирдлагын албан тушаалуудад ямар хүмүүс итгэлтэйгээр үйлчлэхийг тодорхойлох хөрс суурь болж өгсөн билээ.
- г. Хуаран Бошиглогчтой ойр дотно харилцах боломжийг оролцогчдод олгож, ирээдүйн удирдлагын үүрэг хариуцлагад тэднийг бэлтгэсэн юм. Сионы Хуаран амжилтгүй болсон гэж зарим хүмүүс бодож байхад, дээрх зорилгыг гүйцэлдүүлсэн нь Сүмд их ач холбогдолтой болсныг тайлбарла. Сионы Хуаран бол тухайн үед бидний ойлгож чадахгүй арга замаар Бурханы зорилго хэрхэн хэрэгжиж болдгийн нэг жишээ мөн.
- Сионы Хуарангийн туршлага Сүмийн ирээдүйн удирдагчдыг хэрхэн бэлтгэсэн бэ?

1835 оны хоёрдугаар сард хуаранг тарааснаас хойш таван сарын дараа Арванхоёрын Чуулгын Төлөөлөгчид болон Далын Нэгдүгээр Чуулга зохион байгуулагдав. Арванхоёр Төлөөлөгчийн ес нь, Далын Чуулгын 70 гишүүн бүгдээрээ Сионы Хуаранд үйлчилж байжээ. Эдгээр удирдагчдыг бэлтгэхэд хуаран хэрхэн тусалсан тухай Иосеф Смит өгүүлж, хэлэхдээ:

“Ах нар аа, Миссурид тулалдаагүйн улмаас та нарын зарим нь надад уурлаж байгаа. Харин Бурхан та нарыг тулалдахыг хүсээгүйг би хэлье. Тэрээр сайн мэдээний үүд хаалгыг дэлхийн үндэстнүүдэд нээхийн тулд Абрахамын нэгэн адилаар агуу золиослол хийж, амь насаа өгөхөд бэлэн байсан хүмүүсээс энэ Арванхоёр хүнийг, бас тэдний замналаар замнаж, удирдлагыг нь дагах Далан хүнийг авахгүйгээр Тэрээр хаант улсаа зохион байгуулж чадахгүй байсан юм” гэжээ (*History of the Church*, 2:182).

Сионы Хуаран Сүмийн ирээдүйн удирдагчдыг хэрхэн бэлтгэснийг Жорж А.Смитийн туршлага харуулж байна. Тэр 16 настай, хуаранд хамгийн залуу нь бас туршалагагүй, итгэл дутмаг байжээ. Тэр ядуу зүдүү байдлынхаа талаар дургүйцэж, гомдоллодог байсан олон хүнийг бодвол, Иосеф Смитийн бүх зааврыг дуртайяа дагадаг байв. Жорж Бошиглогчийн майханд унтдаг байсан бөгөөд зөвлөгөө заавраас нь маш ихийг сонсдог байжээ. Жорж Бошиглогчтой ойр дотно харьцдаг байсан учир удирдлагын ур чадварт суралцан, насан туршдаа удирдагч байхад нь бэлтгэсэн хүч чадлыг өөртөө хөгжүүлсэн юм. Жорж А.Смит Сионы Хуарангаас хойш таван жил бололгүй Төлөөлөгчөөр томилогдов. Хожим нь тэрээр Бригам Янгийн үед Тэргүүн Зөвлөлийн гишүүнээр үйлчилж байлаа.

- Бид амьдралдаа хэрэглэж болох юуг Сионы Хуарангийн туршлагаас сурч болох вэ? (Ярилцлагыг урамшуулан дэмжих асуултуудын хамт зарим боломжит хариултыг доор өгөв)
- а. Хүнд сорилтуудын шалтгааныг ойлгох нь. Сионы Хуарантай холбоотой зарим хүнд сорилт юу вэ? Бидний амьдралд тохиолддог хүнд сорилтуудын шалтгааны талаар Сионы Хуарангийн туршлага бидэнд юу зааж чадах вэ? (С ба Г 103:12-ыг үз)
- б. Дуулгавартай байдлын ач холбогдол. Дуулгавартай байдлын талаар бид Сионы Хуарангаас юу мэдэж болох вэ? (С ба Г 103:7-10, 36-г үз)
- в. Их Эзэний төлөө бүх зүйлийг золиослох хүсэлтэй байх хэрэгцээ. Бид золиослолын тухай Сионы Хуарангаас юу сурч болох вэ? (С ба Г

103:27-28-ыг үз.) Их Эзэн яагаад Өөрийнхөө төлөө бүх юмыг золиослох хүсэлтэй байхыг биднээс шаарддаг вэ? Бид ийм хүсэл эрмэлзлийг хэрхэн хөгжүүлж чадах вэ? Эдүгээ бид ийм хүсэл эрмэлзлийг хэрхэн харуулж чадах вэ?

- г. Их Эзэний ажилд эв нэгдэлтэй байхын ач холбогдол. Бүр хэдхэн хүн дургүйцэж, эсэргүүцэхэд, бүлэг бүхэлдээ сулардгийг хэл.
- д. Бошиглогчийн зөвлөгөөг нь дагахад хэцүү байгаа эсвэл шалтгааныг нь бүрэн ойлгохгүй байгаа үед түүнийг дэмжиж, зөвлөгөөг нь дагахын ач холбогдол.

4. Их Эзэний хүмүүс “Сионы гэтэлгэлийг багахан хугацаагаар хүлээх” ёстойг Тэрээр илчилсэн нь

Сионыг гэтэлгэж, Өөрийн хүмүүсийг Миссурийн Жаксон дүүрэг дэх нутгуудад нь сэргээхээр Их Эзэн амласныг тайлбарла. Гэвч, энэ амлалт Гэгээнтнүүдийн дуулгавартай байдлаас хамааралтай байв (С ба Г 103:5-8, 11-14). Дуулгаваргүй байсныхаа улмаас эртний Израил 40 жилийн турш амлагдсан нутагт орж чадаагүйн адил, дуулгаваргүй байдал болон зарим Гэгээнтнүүдийн хэрүүл зөрчилдөөний улмаас өнөө үеийн Израил “багахан хугацаагаар хүлээх” болно гэдгийг Их Эзэн илчилсэн билээ (С ба Г 105:9, 13).

- С ба Г 105:1-13-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Эцсийн эцэст Сионыг байгуулахад Их Эзэн ямар шаардлагуудыг тавьдаг вэ? (Доор жагсаасан зүйлүүд хариулт байж болно. Эдгээр шаардлагууд бидний амьдралд хэрхэн хэрэгждэгийг ярилц.)
 - а. Гэгээнтнүүд дуулгавартай байдалд суралцах ёстой (С ба Г 105:3, 6; мөн шүлэг 37-г үз).
 - б. Тэд ядуучууд болон гачигдалтай хүмүүст анхаарал халамж тавих ёстой (С ба Г 105:3).
 - в. Тэд “селестиеп хаант улсын хуулиар шаардагддаг эв нэгдлийн дагуу нэгдсэн” (С ба Г 105:4; мөн шүлэг 5-ыг үз) байх ёстой.
 - г. Тэд илүү төгс байдлаар заалгуулж, илүү их туршлагатай болж, үүргээ илүү төгс мэддэг байх ёстой (С ба Г 105:10).
 - е. Тэд дээрээс ирэх хүчээр хишиг хүртээгддэг байх ёстой (С ба Г 105:11-12; мөн шүлэг 33-ыг үз).
- Амар амгаланг эрэлхийлэхийг, тэр тусмаа өөрсдийг нь мөрдөн хавчдаг хүмүүсийн хувьд амар амгаланг эрэлхийлэхийг Их Эзэн Гэгээнтнүүдэд С ба Г 105:38-40-д зөвлөжээ. Тэрээр үүнийг “бүх зүйл та нарын сайн сайхны төлөө хамтдаа ажилласны” (С ба Г 105:40) хариуд амласан юм. Та нар амар амгаланг эрэлхийлэх зөвлөгөөг хэрэгжүүлснээр хэрхэн адислагдсан бэ?

Дүгнэлт

Сион гэтэлгэгдэнэ гэдгийг Их Эзэн амлаж, тэр өдөрт бэлтгэхийн тулд бид юу хийх ёстойг Тэрээр өгүүлсэн билээ. Бид өнөөдөр гэр бүлдээ, гадсандаа Сионыг байгуулахад туслахыг бүх зүрх сэтгэлээрээ хичээх ёстойг ангийн гишүүдэд сануул. Сүнсээр өдөөгдсөний дагуу, хичээлийн үеэр ярилцсан үнэнүүдийн тухай гэрчил.

Та зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болгож дараах санаануудаас нэгийг буюу илүү олныг нь ашиглаж болно.

1. Миссурийн үе

Миссури дэх үйл явдлуудын дараах хугацаа нь энэ хичээлийг заахад танд хэрэгтэй байж болох юм. Чухал газруудыг олохын тулд та энэ гарын авлагын хуудас 315 дээрх Газрын зураг 2, *Ангийн гишүүний Судлах Удирдамжийн* хуудас (30) дээрх газрын зургийг ашиглаж болно.

1831 оны нэгдүгээр сар: Анхны номлогчид Миссурид ирэв.

1831 оны долдугаар сар: Их Эзэн Миссурийг Сионы хот байх газраар тогтоов.

1831 оны наймдугаар сар: Иосеф Смит Миссурийн Индепенденст Ариун сүмийн газрыг онцгойлон адислав.

1833 оны долдугаар сар: Танхайрагч бүлэг Миссурийн Индепенденс дэх Гэгээнтнүүдийг дайрав.

1833 оны арваннэгдүгээр сар: Биг Блүүгийн тулалдаан болов. Гэгээнтнүүд Миссурийн Жаксон дүүргээс Клей дүүрэг рүү хөөгдөв.

1834 оны тав-зургадугаар сар: Сионы Хуаран Огайогийн Көртландаас Миссурийн Клей дүүрэг рүү хээрийн аян хийв.

1836 оны зургадугаар сар: Клей дүүргийн иргэд тус дүүргээс гарч явахыг Гэгээнтнүүдээс хүсэв.

1836 оны есдүгээр сар: Гэгээнтнүүд Фар Вест Миссурийн Калдвелл, Давиесс дүүргүүд болон бусад газрууд руу шилжиж эхлэв.

1838 оны гуравдугаар сар: Огайогийн Көртланд дахь танхайрагч бүлгүүдээс зугтсаны дараа Иосеф Смит гэр бүлийнхээ хамт Миссурийн Фар Вестэд хүрч ирэв.

1838 оны аравдугаар сар: Крукед голын тулалдаан болов. Миссурийн захирагч Богтс харгис хэрцгий захирамж гаргав.

1838 оны аравдугаар сараас-1839 оны дөрөвдүгээр сар: Иосеф Смит болон Сүмийн бусад удирдагчдыг Миссурид хоригдлууд болгон саатуулав.

1839 оны дөрөвдүгээр сар: Гэгээнтнүүд Миссуригээс Иллиной руу шилжин нүүв.

2. Цөлөгдсөн Гэгээнтнүүдэд өгсөн Их Эзэний заавар

Гэгээнтнүүд Жаксон дүүргээс хөөгдсөний дараа, тэд юу хийх ёстой талаар Их Эзэн тусгай заавар өгчээ. Та дараах зааврыг нэгтгэн дүгнэж болно:

- а. Сионы гэтэлгэлийг эрэлхийл (С ба Г 101:43-62). Дуулгаваргүй байдал нь Гэгээнтнүүдийн байр суурийг сулруулж, тэднээс илүү хүчтэй болох боломжийг дайснуудад нь олгосныг Их Эзэн эдгээр шүлгүүд дэх сургаалт зүйрлэлээр сануулсан байна. Гэвч Сион Түүний өөрийнх нь цагт гэтэлгэгдэнэ гэдэгт Тэрээр тэднийг итгүүлжээ.
- б. Цугларалтын ажлыг үргэлжлүүл (С ба Г 101:63-75). Хэдийгээр Сионы газар дайсны гарт байсан ч, Түүний томилсон газруудад цуглахаа үргэлжлүүлнэ гэдгийг Их Эзэн Гэгээнтнүүдэд тодорхой ойлгуулсан юм (шүлэг 67). Манай өнөө үед эдгээр газрууд бол дэлхий даяарх Сионы гадаснууд юм. Бид манай гадаснуудыг “ариун газар” (С ба Г 101:21-22) болгох ёстой.

- в. Бурууг залруулахыг эрэлхийл (С ба Г 101:76-95). Буруу зүйлийг залруулж, нөхөн төлбөр олгох болон шударга ёсыг сэргээхийн төлөө өргөдөл гаргахыг Гэгээнтнүүдэд зарлиг болгосон байлаа. Нэгдсэн Улсын Үндсэн Хуулиар шүтэн бишрэх болон өмч хөрөнгөтэй байх эрхийг тэдэнд баталгаатай болгосон байлаа. Эдгээр эрхүүд Миссури мужид зөрчигдөж байв. Гэгээнтнүүд Их Эзэний зөвлөгөөг дагаж, орон нутаг, мужийн болон үндэсний түвшинд бурууг залруулахыг хичээж байв. Тэдэнд туслахаас татгалзсан учир, тэд шүүлтийн хариуцлагыг Их Эзэний мутарт үлдээж, цааш явсан билээ.
- г. Жаксон дүүрэг дэх өмч хөрөнгөө буцааж өгөхийг шаард (С ба Г 101:96-101).

3. “Сионы Хуаран” видео танилцуулга

Хэрэв *Teachings from the Doctrine and Covenants and Church History* (53933) видео хуурцаг байдаг бол “Сионы Хуаран” 19 минутын хэсгийг та энэ хичээлийн гурав дахь хэсгийн ярилцлага болгон үзүүлэхэд анхаар.

Зорилго

Аврагчид хандсанаар бэрхшээлийг илүү хатуужилтайгаар тэвчиж даван туулахад нь ангийн гишүүдэд туслах.

Бэлтгэл

1. Дараах судрууд болон бусад материалыг залбирч судал:
 - а. Сургаал ба Гэрээ 121:1-33; 122; түүнчлэн энэ хичээлийн бусад судар
 - б. *Бидний Өв*, хуудас 53-69.
 2. Ангийн гишүүний Судлах Удирдамж (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.
 3. Бэрхшээлээс юу сурч, хэрхэн өсч хөгжсөн тухай товч ярихыг ангийн нэг буюу хоёр гишүүнээс урьдчилан хүс. Энэ даалгавар тэдэнд таалагдах ёстойг анхаар.
 4. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах бол ангийн гишүүн бүрд хэсэг цаас, үзэг эсвэл харандаа авчир.
-

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа

Хичээлээ дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар эхэл.

Ангийн гишүүн бүрд хэсэг цаас, үзэг эсвэл харандаа өг. Тохиолдсон бэрхшээлийнхээ талаар бичихийг тэднээс хүс. Бичиж дуусахад нь тэд уг бэрхшээлээс юу сурсан, хэрхэн өсч хөгжсөнийг нь бичүүл.

Аврагчид хандсанаар бэрхшээлийг тэвчиж, даван туулах тухай энэ хичээлээр ярилцана гэдгийг тайлбарла. Бичсэн зүйлээ дараа нь хичээл дээр хуваалцах болно гэдгийг ангийн гишүүдэд хэл.

Ярилцах ба хэрэгжүүлэх нь

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбиран сонгож ав. Судрын зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Миссуринд болсон дараах үйл явдлуудыг товчхон нэгтгэн дүгнэ. *Бидний Өв*, хуудас 53-69; энэ гарын авлагын хуудас 178 дээрх хугацаануудын жагсаалт; мөн гарын авлагын хуудас 275, Ангийн гишүүний Судлах Удирдамжийн хуудас (30) дээрх Газрын зураг 2-ыг та үзүүлж болно.

1833 оны сүүлчээр Гэгээнтнүүд Жаксон дүүргээс хөөгдсөний дараа, Клей дүүрэгт толгой хоргодох газар олж, 1836 онд эндээс явахыг тэднээс хүсэх хүртэл энд байжээ. Тэд Клей дүүргээс хойд зүгт 96 км орчим нүүж, Фар Вестийн суурин, бусад жижиг суурингуудыг үндэслэн бий болгов.

Хойд Миссурид Сүм хэсэг хугацаанд цэцэглэн хөгжсөн юм. Хүн ам түргэн өсч, Фар Вест, Адам-ондай-Аманд Ариун сүмийн газрууд онцгойлон адислагджээ. Гэвч зарим Гэгээнтнүүдийн дунд зөрчил сөргөлдөөн байсаар байв. Хэд хэдэн удирдагч, түүний дотор Оливер Каудери, Давид Витмер нар гишүүнээс хөөгдсөн байлаа.

Сүмийн зарим гишүүдийн дотор байсан зөрчил сөргөлдөөнөөс гадна, хойд Миссурийн оршин суугчидтай сөргөлдөх нь үргэлжилсээр байв. 1838 онд, танхайрагч бүлгүүд болон орон нутгийн цагдаагийн гишүүд улам олон дайралт хийж эхлэв. Аравдугаар сарын 25-нд, Крукед гол дээр болсон тулалдаанд Сүмийн гурван гишүүн, түүний дотор Төлөөлөгч Давид В.Паттен алагджээ. Хоёр өдрийн дараа Миссурийн захирагч Лилбөрн В.Боггс “Мормончуудыг дайсан гэж үзэж, хүйс тэмтрэн үстгах буюу мужаас хөөн зайлуулах ёстой гэсэн захирамж гаргав” (*History of the Church*, 3:175).

Аравдугаар сарын 30-нд ойролцоогоор 200 хүнтэй танхайрагчдын бүлэг 17 эрэгтэйчүүд, хөвгүүдийг Хауны тээрэм дээр алжээ. Маргааш нь Иосеф Смит болон ойролцоогоор Сүмийн бусад 50 удирдагчийг хилс хэргээр баривчлав. Эдгээр удирдагчдын олонх нь гурван долоо хоногийн дотор суллагджээ. Тэднээс зургааг нь түүний дотор ямар ч буруугүй Иосеф Смит, Хайрум Смит хоёрыг үлдээсэн аж. Арваннэгдүгээр сард тэд эхлээд Индепенденс рүү, дараа нь Ричмонд руу, тэгээд Либерти рүү явганаар очиход, тэнд тэднийг Либертийн Шоронд 1839 оны дөрөвдүгээр сар хүртэл хорьсон юм.

Либерти Шорон дахь нөхцөл байдал туйлын хүнд байв. Хоригдлуудыг гяндантай адилхан харанхуй, хүйтэн бохир заваан газар давхарт хорьдог байлаа. Хоол нь муу, бохир байв. Бошиглогч болон түүний хамтрагчид чулуун шалан дээр жижигхэн сүрэл дэвсэж, хөнжлийн оронцогоор хучиж хэвтдэг байж. Зарим ах нар, түүний дотор Иосеф Хайрум нар босоогоороо зогсож чадахааргүй тааз нь тийм намхан байв. Тэд бас амь насанд нь халдах байнгын заналхийлэл дор байжээ.



Либерти Шорон. Бошиглогч Иосеф Смит 1838-1839 онуудад энд хилсээр хоригдож байхдаа эдүгээ С ба Г 121, 122, 123-т цэдэглэгдсэн илчлэлтүүдийг хүлээн авчээ.

Бошиглогчийг шоронд байхад захирагчийн харгис хэрцгий захирамжийн балгаар Миссури дэх 8000 орчим Гэгээнтнийг орон гэрээс нь албадан хөөн зайлуулсан билээ. Тэднийг Иллиной муж руу зугтахад улайрсан танхайрагч бүлгүүд олныг нь дээрэмдэж, зодон, амь насыг нь хохироосон юм. Гэгээнтнүүдийн зовлон зүдгүүрийн тухай илтгэлийг Бошиглогч сонсож, Их Эзэнээс тусламж гуйв. Хариуд нь Их Эзэн хүчирхэг илчлэлтүүдийг өгчээ. Миссуригээс Гэгээнтнүүдийн дүрвэлтийг удирдаж байсан Иллинойн Квинси дэх Сүмийн удирдагчдад бичсэн захидлууддаа Бошиглогч эдгээр илчлэлтийг оруулжээ. Илчлэлтийн зарим хэсэг нь эдүгээ Сургаал ба Гэрээний хэсэг 121, 122, 123 юм.

1. Либерти шорон дахь Иосеф Смитийн залбирал ба Их Эзэний хариулт

- С ба Г 121:1-6-г ангийн гишүүдтэй хамт унш. Энэ үед Иосеф Смитийн бодож, сэтгэж байсан зүйлийн талаар эдгээр шүлгүүд юу харуулдаг вэ? Их Эзэнээс тэр юу хүссэн бэ? Эдгээр шүлгүүдэд Их Эзэнээс Иосеф Смитийн хүссэн гуйлтуудыг уншихад та нарт ямар бодол төрдөг вэ?
- Иосеф Смитийн залбиралд Их Эзэний өгсөн хариу С ба Г 121:7-33, С ба Г 122-г байдаг. С ба Г 121:7-10-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Эдгээр шүлгүүдэд Их Эзэн Иосефт юу заасан бэ? Хэрэв эдгээр үгс өөрт чинь хэлэгдсэн бол танд ямар санагдах вэ? Бид энэ хариунаас Их Эзэний тухай юу мэдэж болох вэ?

Эдгээр илчлэлтүүд Либерти шоронг түр хугацаагаар зааврын төв болгосныг хэл. Гэгээнтнүүд энэ шоронг урам зориг, зөвлөгөө, Их Эзэний үг ирдэг газар гэж үзэн тийшээ хараа тавьж байлаа. Бошиглогч энд удаан хугацаагаар байсан болохоор Либерти шорон түүний хувьд шорон гэхээсээ илүүтэй Ариун сүм болж байв. Энэ шорон бясалгал, залбирлын газар болж байв . . . Иосеф Смит харанхуй бүдүүлэг энэ шоронд Бурханыг эрж, Түүнийг олсон юм“ (Б.Х.Робертс, *A Comprehensive History of the Church*,1:526).

- Либерти Шоронд өгөгдсөн илчлэлтүүд (С ба Г 121, 122) амьдралыг тань хэрхэн адисалсан бэ?

2. Аврагч бидний зовлон бэрхшээлийг төгс ойлгодог нь

- Нэг хүн С ба Г 122:5-8-ыг унших хооронд тохиолдсон хүнд сорилтынхоо тухай бодохыг ангийн гишүүдээс хүс. Аврагч ямар байдлаар бүх зүйлээс “доогуур бууж ирсэн” бэ? (Алма 7:11-12; С ба Г 19:16-19-ийг үз)

Аврагч бүх зүйлээс доогуур бууж ирсэн учраас Тэрээр бидэнд тохиолддог бүх хүнд сорилтыг төгс ойлгодгийг тайлбарла. Арванхоёрын Чуулгын Ахлагч Нийл А.Максвелл Аврагчийн хэрээс хэтэрсэн зовлон шаналлын тухай өгүүлэн, хэлсэн нь:

“Есүс . . . төгсгөлгүй цагаатгалынхаа хэсэг болгон, эрэгтэй, эмэгтэй хүн, хүүхэд бүрийн нүгэл, золгүй явдал, уй гашуу, өвчин зовлонг үүрсэн юм хэмээн Иаков хэлсэн билээ (2 Нифай 9:21-ийг үз). Есүс бодол санаа мэдрэмждээ төгөлдөржсөн учраас бидэнд хэрхэн туслахыг мэддэг. . . Түүний гэтэлгэл хүрэхгүй газар гэж үгүй. Түүний бодол санаа мэдрэмжээс гадуур үлдэх зүйл гэж нэг ч үгүй. Тиймээс бид өргөст титэм өмссөн түүнийг санах үед амьдрал маань сарнайн цэцэрлэг лүгээ адил болохгүй байгаад

гомдоллох ёсгүй!” гэжээ (In Conference Report, 1987 оны 4-р сар, 89; *Ensign*, 1987 оны 5-р сар, 72).

- Аврагчийн тайтгаруулж чадахгүй тийм хүнд сорилт бидэнд тохиолддог гэж үү? (Еврей 4:15-ыг үз) Аврагчийн зовлон шаналлыг мэдэх нь зовлон зүдгүүрийнхээ үед итгэлтэй байхад бидэнд хэрхэн тусалдаг вэ?
- Цагаатгалаараа дамжуулан Есүсийн санал болгодог тайтгарал, хүч чадлаас илүү бүрэн дүүрнээр хүртэхийн тулд бид юу хийж болох вэ? (Еврей 4:16; 1 Петр 5:6-11-ийг үз) Залбирал, даруу зан, Есүс Христэд итгэх итгэл, бэрхшээлийн үед хүч чадал хүлээн авахад бидэнд хэрхэн тусалдаг вэ?

3. Бэрхшээлийн шалтгаан

Бэрхшээл бол биднийг сорих, мөнх бус байдлын үе дэх бидний өсөлт хөгжилтөд туслах Бурханы төлөвлөгөөний хэсэг юм гэдгийг тайлбарла. Өвчин зовлон, хүнд сорилт, бусад бэрхшээлүүд бидэнд тохиолдоно гэдгийг бид дэлхийд ирэхдээ мэддэг байсан.

Бошиглогч Иосеф Смит түмэн зовлон амссан тухайгаа хэлэхдээ, зовлон зүдгүүр “амьдралын минь бүх өдрүүдэд миний нийтлэг хувь заяа байсан юм . . . мөн бибээр гай зовлонгоороо Паулын адил, бахархмаар санагдана” (С ба Г 127:2) гэжээ. Либерти Шоронд Их Эзэн Бошиглогчид өгсөн тайтгарал, зөвлөгөөнөөс гадна, бэрхшээлийн тухай түүнд заасан бусад олон тохиолдол байжээ. Энэ хичээлийн үлдсэн хэсэгт Сургаал ба Гэрээн дэх эдгээр сургаалыг ярилц.

- Их Эзэн бэрхшээлийн шалтгааны талаар Сургаал ба Гэрээнд юу илчилсэн бэ? (Дараах шүлгүүдийг ангийн гишүүдтэй хамт унш. Мэдээллийг самбар дээр нэгтгэн дүгнэ.)
 - а. С ба Г 98:12, 14-15; 101:4; 136:31. (Биднийг сорихын тулд бас бид Түүний гэрээгээр амьдарч байгаа эсэхийг харахын тулд Их Эзэн бидний амьдралд бэрхшээл тохиолдохыг зөвшөөрдөг) Их Эзэн яагаад Түүний хүмүүс “бүх зүйлд соригдохыг” хүсдэг вэ?
 - б. С ба Г 101:1-2. (Зарим бэрхшээл нь бидний зөрчлийн үр дүн байдаг)
 - в. С ба Г 122:7 (Биднийг туршлагажуулж, өсч хөгжихөд туслахын тулд Их Эзэн бэрхшээлийг зөвшөөрдөг)
- Бэрхшээлийн эдгээр шалтгааныг ойлгох нь “үүнийг дажгүй давахад”(С ба Г 121:8) бидэнд хэрхэн тусалж чадах вэ?
- Бүх гай зовлон бол Бурханы шийтгэл юм гэж зарим хүмүүс итгэдэг нь буруу юм. Ингэж итгэхийн аюул юу вэ? Яагаад зөв шударга хүмүүсээс бэрхшээлийг зайлуулдаггүй вэ?

Бэрхшээлийн нэг эх сурвалж нь зөрчил мөн боловч энэ бол цорын ганц эх сурвалж биш гэдгийг онцлон тэмдэглэ. “Бүх зүйлд сөрөг тал байдаг” (2 Нифай 2:11) учраас бүр зөв шударга хүмүүст ч гэсэн зарим бэрхшээл тохиолддог. Зарим бэрхшээл мөнх бус махбодын мөхөс дорой, арчаагүй байдлын жам ёсны үр дагавар болж ирэх нь бий. Зарим бэрхшээл ослын улмаас ирдэг. Учир нь бидний сонголт зөрчилд хүргэдэггүй ч гэсэн, бусад хүмүүсийн сонголтын улмаас бидэнд бэрхшээл тохиолддог. Бурхан биднийг үүнээс хамгаалж чадах ч гэсэн, “сайн мэдээний гол хууль бол чөлөөтэйгөөр сонгох эрх болон мөнхийн өсөлт хөгжилт” (Спенсер

В.Кимбалл, *Faith Precedes the Miracle* [1973], 96) учраас зарим үед ингэж хамгаалдаггүй. Бэрхшээл бас “сорилтоос ирдэг сайжралтыг бид хүлээн авч болохын тулд бидний амьдралд Их Эзэний хувийн зорилго хэрэгжихийн үүднээс ирж болно” (Ричард Г.Скотт, In Conference Report, 1995 оны аравдугаар сар, 18; *Ensign*, 1995 оны арваннэгдүгээр сар 16).

Ахлагч Харольд Б.Лий Арванхоёрын Чуулганд үйлчилж байхдаа, “Есүс Христийн сайн мэдээгээр амьдрах нь бидний амьдралд бэрхшээл тохиолдохгүй гэсэн баталгаа биш. Харин сайн мэдээгээр амьдрах нь бэрхшээлийг даван туулах хүч чадал, итгэл, тэнгэрийн хүчийг бидэнд өгдөг. Учирсан бэрхшээл зовлонг үл тоомсорлон, илүү гэрэл гэгээтэй өдрийг өөдрөгөөр харах боломжийг бидэнд олгодог” гэжээ (эш татсан А.Теодор Таттл, In Conference Report, 1967 оны аравдугаар сар 15; *Improvement Era*, 1967 оны арванхоёрдугаар сар 47).

Бэрхшээлийн шалтгааны тухай судрын бусад сургаалыг 2 Нифай 2:11; Алма 32:5-6; 62:41; Хиламан 12:1-3-аас үзэж болно.

4. Бэрхшээл тулгарсан хүмүүст Их Эзэний өгсөн зөвлөгөө

- Бэрхшээл тулгарсан үед бидэнд туслах ямар зөвлөгөөг Их Эзэн Сургаал ба Гэрээнд өгсөн бэ? (Дараах шүлгүүдийг ангийн гишүүдтэй хамт унш. Мэдээллийг самбар дээр нэгтгэн дүгнэ. Ярилцлагыг урамшуулан дэмжихийн тулд асуултуудаас заримыг нь сонгож ав.)
 - а. С ба Г 24:8; 31:9; 54:10; 121:7. (Гай зовлон тохиолдоход тэвчээртэй бай, гай зовлон “байх боловч богино хугацаатай байна”; мөн Алма 17:11-ийг үз) Бид хүнд сорилтыг тэсэн гарахын тулд тэвчээр хатуужлаа яаж нэмэгдүүлж чадах вэ? Иосеф Смитэд тохиолдсон гай зовлон ямар утгаар зөвхөн “богино хугацаагаар” үргэлжилсэн бэ? Бид бэрхшээлийг Их Эзэний мөнхийн хэтийн төлөвөөс хэрхэн харж чадах вэ?
 - б. С ба Г 98:1. (Баярлаж, талархал илэрхийл) Бидэнд хүнд сорилт тохиолдсон үед ч гэсэн бид яагаад Бурханд талархал илэрхийлэх ёстой вэ? Бүр хамгийн хүнд бэрхшээл зовлонгийн үед ч гэсэн ямар адислалууд бидэнд байсаар байх вэ?
 - в. С ба Г 98:11. (Бид дуулгавартай хэвээр байж, “сайн бүхэнтэй нэгдэн нийлэх” ёстой) Бидэнд бэрхшээл тохиолдсон үед дуулгавартай хэвээр байх нь заримдаа яагаад хэцүү байдаг вэ?
 - г. С ба Г 101:36-38. (Бие махбоддоо биш, сүнсэндээ анхаарал тавь, мөн Их Эзэнийг эрэлхийл) Бид энэ зөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлж болох вэ?
 - д. С ба Г 122:9. (Бид хүний хийж чадах юмнаас айх ёсгүй. Учир нь Бурхан бидэнтэй үүрд хамт байх болно; мөн С ба Г 98:13-ыг үз)
- Хүнд сорилтын үед бусад нь өсч хөгжин, бэхэждэг байхад зарим хүмүүс яагаад гутаж гуныдаг вэ? Бид хүнд сорилт, бэрхшээлийг хэрхэн улам амжилттайгаар даван туулж чадах вэ? (Алма 62:49-51-ийг үз) Судрууд дахь ямар шастирууд бэрхшээлийн үед та нарт тусалсан буюу сүнслэгээр нөлөөлсөн бэ?
- Бэрхшээл тохиолдсон үед танд туслахын тулд бусад хүмүүс юу хийсэн бэ? Хүнд сорилт тулгарсан үед нь бид бусдад хэрхэн тусалж болох вэ? Хүнд сорилтын үед сурч мэдсэн зүйлээ бид бусдад туслахад хэрхэн ашиглаж болох вэ? Хүнд сорилтын үед бусдад үйлчилснээс бидэнд ямар ашиг тус ирж болох вэ? (Лук 9:24; Галат 6:2-ыг үз)

- Бэрхшээлийн улмаас бид санаа сэтгэлээр унаж, цөхрөнгөө барвал юу хийж болох вэ? (Алма 36:3-ыг үз) Илүү хүнд бэрхшээл зовлон тохиолдож мэдэх ирээдүйд хүчтэй байхын тулд одоо бид хэрхэн бэлтгэж болох вэ?

5. Бэрхшээл тохиолдоход итгэлтэй байдаг хүмүүст өгсөн Их Эзэний амлалтууд

- Бэрхшээл зовлонгийн үед итгэлтэй байдаг хүмүүст Их Эзэн Сургаал ба Гэрээнд ямар амлалтууд өгсөн бэ? (Дараах шүлгүүдээс заримыг нь ангийн гишүүдтэй хамт унш. Мэдээллийг самбар дээр нэгтгэн дүгнэ. Ярилцлагыг хөхүүлэн дэмжихийн тулд асуултуудын заримыг нь сонгож ав.)
 - а. С ба Г 3:8; 24:8; 112:13; 122:4. (Их Эзэн бидэнтэй хамт байж, бидний дэргэд зогсон, гай зовлонгоос маань биднийг эдгээх болно; мөн Иаков 3:1; Мозая 24:13-14; Алма 36:27-г үз) Гай зовлон тохиолдсон үед Их Эзэн бидэнтэй хамт байх болно гэдгийг мэдэх нь яагаад чухал вэ? Хүнд сорилтын үед Их Эзэн та нартай хамт байдгийг ямар туршлага харуулсан бэ?
 - б. С ба Г 58:2-4; 101:35-36; 103:12; 121:29; 127:4; 136:31. (Гай зовлон тохиолдсон үед итгэлтэй байдаг хүмүүс алдар суу, баяр баясгалан, бусад адислал хүлээн авах болно)
 - в. С ба Г 98:3; 122:7. (Бүх зүйл сайн сайхан байдал, Их Эзэний алдар суугийн төлөө хамтдаа ажиллах болно; мөн С ба Г 90:24; 100:15; 2 Нифай 2:2; Ром 8:28-ыг үз.) Бэрхшээл хэрхэн бидний сайн сайхны төлөө байж болдог вэ?

Бэрхшээлээс юуг сурсан болон хэрхэн өсч хөгжсөнийг нь ангийн гишүүдэд даалгавар өгч, товчхон яриулахыг хүс ("Бэлтгэл," зүйл 3-ыг үз). Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашигласан бол ангийн бусад гишүүд юу бичсэнийг нь хуваалцахад урь. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг хэрэглээгүй бол бэрхшээлээс юуг сурч, хэрхэн өсч хөгжсөнийг нь ярихад ангийн бусад гишүүдийг урь.

Ахлагч Жеймс И.Фауст Арванхоёрын Чуулгад үйлчилж байхдаа: "Бид өвчин эмгэг, зовлон зүдгүүр, амьдралын баатарлаг хүч чармайлтад цэвэршүүлэгчийн галаар дамжин гардаг. Ингэхэд ялих ялихгүй, ач холбогдолгүй юмс хог новш лугаа адил арилан үгүй болж, итгэлийг маань гэрэл гэгээтэй, гуйвшгүй, хүчтэй болгодог... Энэ бол зарим хүмүүсийн хувьд Бурханыг мэдэхэд шаардлагатай үйлдлүүдийн хэсэг байдаг. Бид амьдралын зовлон зүдгүүр тохиолдсон үед Тэнгэрлэг Хоньчны бурханлиг шивнээг илүү сайн сонсдог бололтой" хэмээн хэлжээ (In Conference Report, 1979 оны 4-р сар, 77; *Ensign*, 1979 оны 5-р сар, 53).

Арванхоёрын Чуулгын Ахлагч Марион Г.Ромни хэлсэн нь:

"Хүнд сорилтын үед Бурханыг зүхэж, сүнслэг байдлын хувьд үхмэл болсон хүмүүсийн амьдрал дахь гэмшил харуусал, цөхрөл гутралыг би харсан. Бас дааж давшгүй хүнд ачаа мэт санагдаж байсан зүйлээс бүр илүү өндөрт гарсан хүмүүсийг би харсан.

"Эцэст нь, өөртөө гай зовлон тохиолдсон үед би Их Эзэнийг эрж хайдаг байсан. Ийнхүү бэрхшээл, гай зовлонгийн үед өвдөг сөгдөн залбирдаг байсан учир бодгаль минь агуу өсөлтөд хүрснийг би мэдсэн." (In Conference Report, 1969 оны аравдугаар сар, 60; *Improvement Era*, 1969 оны арванхоёрдугаар сар, 69).

г. С ба Г 121:8; 127:2. (Гай зовлонгийн үед итгэлтэй байсан хүмүүс өргөмжлөгдөх болно)

- С ба Г 121:7-д Их Эзэний өгүүлсэн амар амгаланг илүү бүрэн дүүрнээр мэдрэхийн тулд бид хүнд сорилтын үед юу хийж болох вэ? (мөн С ба Г 19:23-ыг үз)

Дүгнэлт

1839 оны дөрөвдүгээр сард, Бошиглогч болон түүний хамтрагчдыг Либерти Шоронд бараг таван сар хорьсоны дараа, тэднийг шүүх хурлаар оруулах гэж Давиесс дүүрэг рүү, дараа нь Бүүн дүүрэг рүү явуулав. Тэднийг Бүүн дүүрэг рүү шилжүүлэх үед харгалзагчид нь оргох боломжийг тэдэнд олгосон аж. Учир нь тэднийг шүүх хурлын үеэр прокурорын хамгаалалт амжилт олохгүй гэдэг дүгнэлтийг зарим албан тушаалтнууд хийж байжээ. Иосеф Смит болон бусад хоригдлууд Иллиной руу явж, тэнд гэрийнхэнтэйгээ бас Гэгээнтнүүдийн үлдсэн хэсэгтэй нийлжээ.

Бэрхшээл зовлонгийн үед Либерти шоронд өгөгдсөн илчлэлтүүдийг уншихад ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Есүс Христ Цагаатгалаар дамжуулан бидний уй гашууг үүрснийг гэрчил. Хэрэв бид Түүнд хандах юм бол бүр бидний хамгийн харанхуй өдрүүдэд ч гэсэн Тэр биднийг тайтгаруулж, өргөх болно. Бэрхшээлийг даван туулсан Иосеф Смитийн үлгэр жишээнээс суралцан, бэрхшээлийг тэвчиж, даван туулахад бидэнд туслах Есүсийн хүсэл эрмэлзлийн төлөө талархлаа илэрхийл.

Нэмэлт заах санаанууд

1. Итгэл үнэмшлийнхээ төлөө тууштай зогсох зориг

Иосеф Смит болон түүний хамтрагчдыг Либерти Шоронд хорихоос өмнө тэднийг гинжилж, харгалзагчдын хяналтан дор Миссурийн Ричмондод эзгүй байшинд хоёр долоо хоног гаруй хамтад нь саатуулан хорьсон ажээ. *Бидний Өв*, хуудас 58-60-д (сүүлчийн догол мөр) өгүүлсэн Ричмонд дахь шоронгийн хүчирхийлэгч харгалзагчдад Иосеф Смитийн өгсөн хариултын тухай шастирыг нэгтгэн дүгнэ.

- Хүнд бэрхшээл тулгарсан үед хэрэг болох зоригийг бид хэрхэн хөгжүүлж чадах вэ? Ямар нөхцөлд зориг өдөр тутам хэрэгтэй байдаг вэ? (Сайн мэдээний зарчмуудыг өндөрт өргөсөн зоригийг өөрсдөө буюу таньдаг хүмүүс нь харуулсан тухай туршлагыг хуваалцахад ангийн гишүүдийг урь)

2. Хүү Алмадаа туслах сүнсний нөлөөг Аманда Смит хүлээж авсан нь

Хауны Тээрэм дээр хүмүүсийг олноор нь хөнөөх үед шархадсан хүү Алмадаа туслахад сүнсний нөлөөг хүлээн авсан Аманда Смитийн тухай шастир *Бидний Өвд* байдаг (хуудас 55-57). Хэрэв та энэ шастирыг хичээл 15 дээр нэгтгэн дүгнээгүй бол энэ хичээл дээр үүнийг хийж болно.

Иллинойн Наувуд Бурханы хаант улсыг байгуулсан нь

Хичээл
29

Зорилго Наувуд Бурханы хаант улсыг байгуулахын тулд эхэн үеийн Гэгээнтнүүд хэрхэн ажиллаж байсан тухай заах, тэдний үлгэр жишээг дагахад ангийн гишүүнийг урамшуулан дэмжих.

Бэлтгэл

1. Дараах судрууд болон бусад материалыг залбирч судал:
 - а. Сургаал ба Гэрээ 124:1-21, 87-90, 97-110; 126.
 - б. *Бидний Өв*, хуудас 58-59, 60-62, 63-68, 71-72.
2. *Ангийн гишүүний Судлах Удирдамж* (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.
3. *Бидний Өвөөс* дараах шастируудыг нэгтгэн дүгнэхэд бэлтгэхийг ангийн гишүүдээс хүс:
 - а. Жон Хаммер болон түүний гэр бүл Иллинойд толгой хоргодох газар хайж байсан үед тэдэнд тохиолдсон хүнд сорилтууд (“Иллиной уруу дүрвэсэн нь,” хуудас 60-62).
 - б. “Наувугийн номлогчдын золиослол” (хуудас 63-68).
 - в. “Нийгмийн Халамжийн Бүлэг” (хуудас 71-72).
4. Хэрэв та Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч эсвэл түүний зөвлөхүүдийн нэгнээр Нийгмийн Халамжийн Бүлгийн зорилгын тухай яриулахыг хүсвэл, урилгыг урьдчилан өг.1999 онд Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхий цуглаан дээр танилцуулсан Нийгмийн Халамжийн Бүлгийн тунхаглалыг уншиж бэлтгэсэн байхыг түүнээс хүс. Уг тунхаглал энэ гарын авлагын хуудас 190-91 дээр байгаа, бас бие даасан зүйл болж (36175, 36185, 36195) хэвлэгдсэн байдаг.

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа Хичээлээ дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар эхэл.

Дараах өгүүлбэрүүдийг самбар дээр бич:

Нас барагсдын өмнөөс хийх баптисмын сургаал илчлэгдэв.

Ариун сүмийн хишиг хүртээлт анх удаа гүйцэтгэгдэв.

Нийгмийн Халамжийн Бүлэг зохион байгуулагдав.

- Эдгээр үйл явдлууд хаана болсон бэ?

Эдгээр болон бусад олон чухал үйл явдал Иллинойн Наувуд болсныг тайлбарла. Наувугийн эхэн үеийн Гэгээнтнүүд Бурханы хаант улсыг байгуулахын

төлөө хэрхэн ажиллаж байсныг мөн бид өнөөдөр Бурханы хаант улсыг байгуулахын төлөө хичээн чармайхдаа тэдний үлгэр дуурайлаас хэрхэн суралцаж болох талаар энэ хичээлээр ярилцах болно.

Ярилцах ба
хэрэгжүүлэх нь

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбиран сонгож ав. Судрын зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Гэгээнтнүүд Иллинойд толгой хоргодох газар эрсэн нь

Иосеф Смитийг Миссурин Либерти шоронд байх үед Гэгээнтнүүдийг Миссуригээс нүүлгэн шилжүүлэх ажлыг удирдах хариуцлага Арванхоёрын Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч Бригам Янгд оногдсоныг тайлбарла. Гэгээнтнүүд мөрдөн хавчигчдаас зугтаахын тулд 1838 оны сүүлчээр Миссипи мөрнийг гатлан, Иллинойг зорьж эхлэв. Энэ гарын авлагын хуудас 316, мөн *Ангийн гишүүний Судлах Удирдамжийн* хуудас 31 дээрх Газрын зураг 3 нь Гэгээнтнүүд Миссуригээс хөөгдөх үед тэдний явсан замын чиглэлийг харуулдаг.

Жон Хаммер гэр бүлийнхээ хамт Иллинойд толгой хоргодох газар эрж хайсан үед тэдэнд тохиолдсон хүнд сорилтын тухай ярихыг даалгавар авсан ангийн нэг гишүүнээс хүс (*Бидний Өв*, хуудас 60).

Гэгээнтнүүд эхлээд Иллинойн Квинсид цугларчээ. Иосеф Смитийг Либерти Шоронгоос эргэж ирсний дараа тэд Миссипи мөрнийг өгсөн 56 км орчим явж, тэр үед жижигхэн тосгон байсан Коммерсэд хүрэв. Гэгээнтнүүд намагтай газрыг түргэн хатааж, тариа тарин, гэр орон барьж эхэлжээ. 1839 оны зун Бошиглогч уг газрын нэрийг Науву болгож өөрчилжээ. “Манай хотын (Науву) нэр еврей гаралтай бөгөөд үзэсгэлэнт сайхан, эсвэл амрахад аятай сайхан гэсэн утгатай юм” гэж тэр хэлжээ (*Teachings of the Prophet Joseph Smith*, эмхтгэсэн Жозеф Фиелдинг Смит [1976], 182).

Цагдаагийн газар, хотын шүүх, их сургууль байгуулах зөвшөөрлийг 1840 оны арванхоёрдугаар сард Иллиной муж Наувуд олгов. Сүм түргэн өсч, шинэ хөрвөгчид энд цуглахын хэрээр Науву Иллинойн хоёр дахь том хот болсон юм.

Науву дахь тэдний үүрэг хариуцлагуудын талаар Их Эзэн Гэгээнтнүүдэд өгсөн зарлигууд дотор нь байсан нэг илчлэлтийг 1841 оны нэгдүгээр сарын 19-нд Бошиглогч Иосеф Смит хүлээн авчээ. Энэ илчлэлт С ба Г 124-т цэдэглэгдсэн байдаг. С ба Г 124-ийг, түүнчлэн Наувугийн эхэн үеийн Гэгээнтнүүдийн үлгэр жишээг судалснаар, Бурханы хаант улсыг байгуулахад хүн бүрийн гүйцэтгэх чухал үүргийг бид илүү тодорхой ойлгож чадна гэдгийг тайлбарла.

2. Хөрвөгдсөн мянга мянган хүмүүсийг номлогчид Наувугаас явуулсан нь

Науву дахь Сүмийн олон гишүүн, түүний дотор Арванхоёрын Чуулгын гишүүд номлолд үйлчлэхээр дуудагдсаныг тайлбарла. Наувугийн Гэгээнтнүүдийн номлолын талаар илтгэхийг даалгавар авсан ангийн нэг гишүүнээс хүс (*Бидний Өв*, хуудас 63-67).

Англид ирснээс хойш хэдхэн сарын дотор Ахлагч Вилфорд Вудрафф олон хүнд баптисм хүртээж, тэндийг гишүүнээр батлуулав. Тэр үед дараах явдал түүнд тохиосон ажээ:

“Гэгээнтнүүд болон гадны хүмүүсийн том цугларалтад би оролцож байлаа ... Эхний дууллыг дуулж байх үед Их Эзэний Сүнс над дээр оршиж, Бурханы дуу хоолой надад хэлсэн нь, “Энэ бол эдгээр хүмүүстэй чи олон өдрийн турш хамт байсан үеийн сүүлчийн цуглаан.” Би үүнд их гайхлаа. Учир нь энэ дүүрэгт товлосон олон уулзалт надад байсан юм. Би хүмүүст хандаж үг хэлэхээр бослоо, энэ бол олон өдрийн турш тэдэнтэй хамт байсан үеийн сүүлчийн цуглаан гэдгийг тэдэнд хэлэв. Миний нэгэн адил тэд ч бас гайхахын ихээр гайхав. Цуглааны төгсгөлд баптисм хийлгэхээр дөрвөн хүн урагш гарч ирлээ. Тэдэнд баптисм хүртээхээр бид доош ус руу оров.

“Өглөөгүүр би Их Эзэний өмнө нууцгайгаар очиж, миний талаарх Түүний хүсэл юу болохыг асуув. Миний хүлээж авсан хариу гэвэл би өмнөд рүү явах ёстой болов. Учир нь тэнд олон хүмүүс Түүний үгийг хүлээж байсан болохоор надаар гүйцэтгүүлэх их ажил Их Эзэнд байжээ.”

Дараагийн хоёр өдөр тэрээр өмнөдийг чиглэн явж, Херефордшир дахь Жон Бенбөүгийн ферм дээр хүрч ирэв. Ноён Бенбөү гэргий Жейнийхээ хамт түүнийг баяртайгаар хүлээн авч, Нэгдсэн Ах дүүс хэмээн нэрлэгдсэн, өөрсдийн цугларалт бүхий 600 гаруй эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хамт олон тэнд байгааг ярьжээ. Ахлагч Вудрафф өгүүлэхдээ:

“Энэхүү Нэгдсэн Ах дүүсийн бие бүрэлдэхүүн аврагдах жинхэнэ үнэн замыг мэдэхийн тулд гэрэл болон үнэнийг эрж байсан бөгөөд тэд чадах чинээгээрээ урагш ахисан байв. Мөн өөрсдийнхөө өмнө замыг нээж өгөхийг, гэрэл болон үнэнийг илгээхийг Их Эзэнд хандан үргэлж гуйдаг байжээ. Би эдгээр зүйлийг сонсоод, намайг Ханли хотод байхад ажлынхаа байрыг орхин өмнөд рүү явахыг Их Эзэн надад яагаад зарлиг болгосныг тодруунаар харж чадлаа. Учир нь энд Херефордширт агуу ургацын талбай-Бурханы хаант улсад цугларах олон Гэгээнтэн байжээ” гэсэн байна.

Английн энэ нутаг дахь Ахлагч Вудраффын хүч чармайлт “Бурханы адислалаар дамжуулан, найман сарын дотор найман зуу гаруй хүнийг, түүний дотор ганцхан хүнийг эс тооцвол Нэгдсэн Ах Дүүсийн бүх зургаан зуун хүнийг Сүмд авчрах” боломжийг түүнд олгосон ажээ (in *Вилфорд Вудрафф: History of His Life and Labors*, хянан тохиолдуулсан Маттиас Ф.Каули [1909], 116-119).

- Ахлагч Вудраффын туршлагаас бид юу сурч болох вэ?

Англид үйлчилж байсан номлогчдын золиослол болон хүч чармайлтаар Сүм бэхэжсэнийг ярь. Энэхүү гайхалтай цаг үед тохиосон зүйлийг Ахлагч Харольд Б.Лий нэгтгэн дүгнэхдээ:

“1840-1841 онд нэг жил арван дөрөв хоногт, бүр тодорхой хэлбэл Арванхоёрын есөн гишүүн Британийн Номлолд хөдөлмөрлөхөөр дуудагдсан юм. Хэрэв та [Науву дахь] түүхийг эргэн санах юм бол, энэ эрин үед Сүмийн туулж өнгөрүүлсэн хамгийн хүнд хэцүү мөрдлөг хавчлагын жилүүд ялгаран харагдана. Арванхоёрын есөн гишүүн энэ нэг жил арван дөрвөн хоногт хэлхээ холбоотой байдаг хүмүүсийнхээ хамт Их Британийн хаант улсын голлох бүх хот болон хотхонуудад Сүмийг үндэслэн байгуулсан билээ. Тэд 7000-8000 хөрвөгчид баптисм хүртээжээ. Тэд Мормоны Номыг 5000 хувь, дууллын номыг 3000 хувь, жижиг товхимлуудыг 50.000 хувиар хэвлэж... мөн [тэд] 1000 хүнийг Америкт цагаачлуулсан юм” гэжээ (In Conference Report, 1960 оны 4-р сар, 108).

3. Наувугийн Гэгээнтнүүдийн зөв шударга үлгэр жишээ эцсийг хүртэл тэвчихийн ач холбогдлыг харуулсан нь

Наувугийн үед амьдарч байсан хувь хүмүүст өгсөн олон заавар болон амлалт С ба Г 124-т байдгийг тайлбарла. Дараах шүлгүүдийн заримыг ангийн гишүүдтэй хамт уншиж, заавар болон амлалтуудыг нэрлэ:

- а. С ба Г 124:12-14 (Роберт Б.Томпсонд).
- б. С ба Г 124:16-17 (Жон К.Беннеттэд).
- в. С ба Г 124:18-19 (Лайман Вайтад).
- г. С ба Г 124:87-90, 97-102 (Виллям Лоод).
- д. С ба Г 124:103-10 (Сидней Ригдонд).

Наувугийн үед Гэгээнтнүүдийн ихэнх нь итгэлтэй хэвээр үлдэж, агуу ихээр адислагдсан юм. Гэвч Жон К.Беннет, Лайман Вайт, Виллям Лоо, Сидней Ригдон нар урвагч болж, адислалуудынхаа олныг нь алдсан ажээ.

- Зөв шударга байдалд эцсийг хүртэл тэвчихийн төлөөх та нарын хүч чармайлтад юу хамгийн ихээр тусалсан бэ?
- С ба Г 124:15-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Их Эзэн Хайрум Смитийн ямар зан чанарыг магтсан бэ? (Мөн дараах эшлэлийг үз.) Бид зүрх сэтгэлийн ариун нандин чанарыг хэрхэн хөгжүүлж чадах вэ? Бид зөв зүйлийг хайрлах хайрыг хэрхэн хөгжүүлж чадах вэ?

Бошиглогч Иосеф Смит ах Хайрумынхаа тухай, “хурганых шиг уян зөөлөн сэтгэлтэй, Иов шиг чигч шударга, товчоор өгүүлбэл, Есүс шиг номхон дөлгөөн, даруу, хайрт ах Хайрумтай минь бүх ах нар адилхан байгаасай хэмээн би зүрх сэтгэлдээ залбирнам. Бибээр ахдаа алд бие, амь наснаасаа илүү хайртай. Учир нь ахыгаа зэмлэсэн удаа надад хэзээ ч байгаагүй, бас ах маань ч намайг зэмлэсэн нь үгүй” хэмээн ярьжээ (*History of the Church, 2:338*).

4. Наувуд Нийгмийн Халамжийн Бүлэг зохион байгуулагдсан нь

Гэгээнтнүүд Наувуд аж төрж байхдаа Сүмийн шинэ байгууллагаар адислагдсаныг тайлбарла. Бошиглогч Иосеф Смит санваарын эрх мэдлээр Нийгмийн Халамжийн Бүлгийг зохион байгуулсан юм. *Бидний Өв*, хуудас 71-72-оос “Нийгмийн Халамжийн Бүлэг” хэсгийг нэгтгэн дүгнэхийг даалгавар авсан ангийн гишүүнээс хүс.

Нийгмийн Халамжийн Бүлгийн зорилгыг онцлон тэмдэглэхийн тулд, 1999 онд Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхий цуглаан дээр танилцуулсан дараах тунхаглалыг унш. Хэрэв та Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч буюу түүний зөвлөхүүдийн нэгнээр энэ видеог хийлгэхийг хүсвэл, одоо түүнийг урь.

“Бид Бурханы хайрт сүнсэн охид бөгөөд бидний амьдрал утга учир зорилго, чиглэлтэй билээ. Даян дэлхийн эгч дүүс бид өөрсдийн Аврагч, мөн Жишээ Үзүүлэгч, Есүс Христэд итгэх сүсэг бишрэлээрээ нэгдсэн билээ. Бид

“Зарбирч, судраас суралцан Есүс Христэд итгэл итгэлээрээ нэмэгдүүлж,

“Ариун Сүнсний өдөөлтийг даган сүнслэг эрч хүчийг эрэлхийлж,

“Гэрлэлт, өрх гэр ахуй байдлаа батжуулахад өөрсдийгөө зориулж,
 “Эхийн нинжин сэтгэл, эмэгтэй хүний баяр баясгаланг олж,
 “Үйлчлэл болон сайн үйлсэд баясаж,
 “Амьдралыг хайрлаж, сурч мэдэх дуртай,
 “Үнэн ба зөв шударга ёсны төлөө зогсож,
 “Санваарыг дэлхий дээрх Бурханы эрх мэдэл хэмээн дэмжиж,
 “Ариун сүмийн адислалд баярлаж, өөрсдийн тэнгэрлэг хувь заяагаа ойлгон,
 өргөмжлөлийг хүртэхээр чармайж явдаг итгэл, ариун журам, зөн совин,
 энэрэх сэтгэлтэй эмэгтэйчүүд билээ. гөмжлөлийн төлөө хичээн зүтгэдэг”
 (Мэри Эллен Смут, “Rejoice, Daughters of Zion,” *Ensign*, 1999 оны арваннэг-
 дүгээр сар, 92-93).

- Нийгмийн Халамжийн Бүлэг итгэлийг хэрхэн төлөвшүүлж, гэрчлэлийг хэрхэн бэхжүүлдэг вэ? Тус бүлэг гэрлэлт, гэр бүлийг хэрхэн бэхжүүлдэг вэ? Нийгмийн Халамжийн Бүлэг гачигдалтай хүмүүст хэрхэн тусалдаг вэ?
- Нийгмийн Халамжийн Бүлгийн ачаар амьдралд чинь ямар адислал ирсэн бэ?

Дүгнэлт

Науву дахь эхэн үеийн Гэгээнтнүүд номлолын ажлаар дамжуулан, бас өөр олон арга замаар үйлчлэхээр дамжуулан Бурханы хаант улсыг байгуулахын төлөө амьдралаа зориулж байсныг онцлон тэмдэглэ. Бид тэдний үлгэр жишээг дагаснаар өнөөдөр Бурханы хаант улсыг байгуулахад илүү их итгэлтэйгээр тусалж чадна.

Сүнсээр өдөөгдсөний дагуу хичээлийн үеэр ярилцсан үнэнүүдийн тухай гэрчил.

Нэмэлт заах санаанууд

Та зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болгож дараах санаануудаас нэгийг буюу илүү олныг нь ашиглаж болно.

1. Эхэн үеийн Гэгээнтнүүд Миссурид Ариун сүм барихаас чөлөөлөгдсөн нь

- Ариун Сүмийг Индепенденс болон Фар Вестэд барихыг Их Эзэн Гэгээнтнүүдэд зарлиг болгосон ч, тэд Миссурид нэг ч Ариун сүм бариагүй ажээ (С ба Г 57:1-3; 97:10-12; 115:7-12). Их Эзэн С ба Г 124:49-53-т ямар зарчмыг Гэгээнтнүүдэд заасан бэ? Өнөөдөр энэ зарчим бидэнд хэрхэн хамаатай вэ?

2. Их Эзэний үгсийг хэрэгжүүлэх Төлөөлөгчдийн хүч чармайлт

Арванхоёр Төлөөлөгч “Их усыг” гаталж, сайн мэдээг номлох тухай Их Эзэний заавар С ба Г 118-т байдгийг тайлбарла. Ах нар 1839 оны дөрөвдүгээр сарын 26-нд Миссурин Фар Вест дахь Ариун сүмийн газар дээрээс явах ёстой байв. Гэвч 1839 оны гуравдугаар сар гэхэд Гэгээнтнүүдийн олонх нь Миссуригээс Иллиной руу шилжин нүүсэн байлаа. Танхайрагч бүлгүүд Фар Вестэд эргэж ирэх ямар ч удирдагчид заналхийлж байв.

Бригам Янг бусад дөрвөн Төлөөлөгч мөн өөр хэдэн хүн энэхүү заналхийллийг эс хайхран, Фар Вестийн ариун сүмийн газар дээр 1839 оны дөрөвдүгээр сарын 26-ны үүрээр, шөнө дундаас хойхно эргэж иржээ. Тэнд тэд дахиад хоёр Төлөөлөгч Вилфорд Вудрафф, Жорж А.Смит нарыг томилов. Тэд дуулж, залбиран, нэг том чулууг Ариун сүм барихаар төлөвлөж буй газрын булан руу өнхрүүлж аваачжээ. Төлөөлөгчид үүнээс хойш удалгүй Англи дахь номлолдоо явсан билээ.

3. Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг

- С ба Г 124:1-7-г ангийн гишүүдтэй хамт унш. Их Эзэн юу бичихийг Бошиглогч Иосеф Смитэд зарлиг болгосон бэ?

1844 онд Бошиглогчийг алагдах хүртэл Бошиглогч Иосеф Смит болон бусад хүмүүс энэ тунхаг дээр ажиллаж байсныг тайлбарла. Арванхоёрын Чуулга уг баримт бичгийг дуусгаж, 1845 оны дөрөвдүгээр сарын 6-нд хэвлүүлжээ.

Тунхгийг дэлхийн хаад, Нэгдсэн Улсын ерөнхийлөгч, бүх улс орны жолоодогчид болон хүмүүст хандан гаргажээ. Бурхан тэнгэрээс дахин ярьж эхэлснийг, Аврагчийн Хоёр дахь Ирэлтийн замыг бэлтгэхийн төлөө Бурханы хаант улс болон ариун санваар сэргээгдсэнийг Сүмийн удирдагчид тунхагласан юм.Тэд бас:

“Дээд тэнгэрээс өгөгдсөн эрх мэдлээр бид та нарт хандаж, Ариун нэгэний сүр жавхлангийн өмнө наманчилж, бяцхан хүүхдүүд лүгээ адил өөрсдийгөө даруусгахыг, харууссан зүрх, гэмшсэн сэтгэлтэйгээр Есүст ирэхийг; мөн нүглээсээ ангижрахын тулд түүний нэрээр баптисм хүртэж, хүмүүний хувьд нигүүлсэнгүй энэхүү аугаа, сүүлчийн эрин үед Төлөөлөгчид, ахлагчдын гар тавилтаар дамжуулан Ариун Сүнсний бэлэг хүлээн авахыг та бүгдэд зарлиг болгож байна.

“Бидний гэрчлэл үнэнийг энэ Сүнс та нарт гэрчилж, оюун ухааныг тань гэгээрүүлж, та нарын дотор бошиглолын болон илчлэлтийн сүнс лугаа адил байх болно. Энэ Сүнс өнгөрсөн юмсыг та нарын ойлголт болон дурсамжид тань авчирна; мөн ирэх юмсыг та нарт үзүүлнэ.

“Энэ нь бас Есүсийн нэрээр гар тавилтаар өвчтөнийг эдгээх болон эдгээгдэхийн; чөтгөрийг хөөхийн; бүр үзэгдэл харахын, тэнгэр элчүүд болон үл үзэгдэх ертөнцийн сүнстэй харилцахын бэлгийг та нарт илэрхийлэх болно.

“Ёслопуудыг гүйцэтгэхээр дамжуулан хүлээн авсан энэ сүнсний гэрлээр Ариун Төлөөлөл болон Санваарын хүч, эрх мэдлээр ойлгох боломж, гэрлийн хүүхдүүд байх боломж та нарт олдоно. Ингэснээр дэлхийд тохиох бүх зүйлээс зайлсхийхэд, Хүний Хүүгийн өмнө зогсоход бэлтгэгдэх болно.

“Дээр дурдсан сургаал бол Есүс Христийн сургаал буюу бүрэн байдлаараа байгаа сайн мэдээ юм. Мөн энэ бол цорын ганц үнэн, үүрдийн, өөрчлөгдөшгүй сайн мэдээ юм. Мөн хүмүүн дэлхийд илчлэгдсэн цорын ганц энэхүү төлөвлөгөөгөөр аврагдаж чадна” хэмээн тунхаглажээ (Жеймс Р.Кларк, эмхтгэл, *Messages of the First Presidency of The Church of Jesus Christ of Latter-day Saints*, боть 6, [1965-1975], 1:252-254).

1975 онд Арванхоёрын Чуулгын Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон энэ баримт бичгийн зарим хэсгийг ерөнхий чуулган дээр эш татаж, эдгээр үнэнийг Сүм дэлхийд дахин тунхаглаж байгааг мэдэгдсэн билээ. Тэрээр хэлсэн нь:

“Бурханы өмнө өөрсдийгөө даруусгахыг, түүний сүнслэг нөлөө болон удирдамжийг эрэлхийлэхийг улс үндэстнүүдийн удирдагчдад бид Их Эзэний даруухан үйлчлэгчдийн хувьд уриалж байна. Бид жолоодогчид болон хүмүүсийг хилэнцэт арга замаа нэгэн адил наманчлахыг уриалан дуудаж байна. Их Эзэнд хандаж, түүний өршөөлийг эрэлхийлэн, өөрсдийгөө түүний хаант улстай даруу байдалд нэгтгэгтүн. Үүнээс өөр зам байхгүй. Хэрэв та нар ингэх юм бол, нүгэл тань арилгагдах болно, энх тайван тогтож, батжих болно. Мөн та бүгд Христийн Хоёр дахь Ирэлтэд бэлтгэхэд Бурханы хаант улсын нэг хэсэг байх болно. Гэвч та бүгд наманчлахаас эсвэл сүнсээр нөлөөлөгдсөн түүний элчүүдийг хүлээж авахаас, өөрсдийгөө Бурханы хаант улстай нэгтгэхээс татгалзвал, ёс бусчуудад амлагдсан аймшигт шүүлт болон сүйрлүүд та нар дээр тохиох болно” (In Conference Report, 1975 оны аравдугаар сар, 48; *Ensign*, 1975 оны арваннэгдүгээр сар, 34).

4. “Зүрх сэтгэл ба эрмэлзэгч оюун” видео танилцуулга

Teachings from the Doctrine and Covenants and Church History (53933) видео хуурцаг байдаг бол “Зүрх сэтгэл ба эрмэлзэгч оюун ухаан” нэртэй найман минутын хэсгийг үзүүлэхэд анхаар. Энэ танилцуулга бол сайн мэдээг номлосноор Их Эзэнд үйлчлэх хүслээ харуулсан Ахлагч Хебер К.Кимбаллын намтар юм. Тэрээр Англид үйлчлэхийн тулд Көртланд, Науву хоёрыг орхин явахад нь дэмжиж байсан гэргий, хүүхдүүдийнх нь төлөө бие сэтгэл бүхнээ зориулсныг бас харуулдаг.

Та энэ видеог хичээлийн хоёр дахь хэсгийн үеэр үзүүлж болно. Видеог ангийн гишүүдтэй хамт үзэхийн тулд дараах асуултуудыг ашигла:

- С ба Г 64:33-34-ийг ангийн гишүүдтэй хамт унш. Ахлагч Кимбалл зүрх сэтгэлээ Их Эзэний ажилд зориулснаа хэрхэн харуулсан бэ? “Эрмэлзэгч оюун” өөрт нь байсныг тэр хэрхэн харуулсан бэ? Зөвхөн дуулгавартай байх, дуулгавартай бас хүсэл эрмэлзэлтэй байхын хоорондох ялгаа юу вэ?
- Ахлагч Кимбалл болон түүний гэр бүл Сионы зарчмыг урагш ахиулахад туслахын тулд золиослол хийх хүсэлтэй байгаагаа харуулсан юм. Бид Их Эзэний ажилд үйлчлэхийн тулд өнөөдөр хийх хэрэгтэй ямар золиослол байдаг вэ? Бидний золиослол тэднийхээс ямар ялгаатай вэ? Бидний золиослол ямар талаараа тэднийхтэй адил вэ?

5. Бошиглогч Иосеф Смитийн улаан тоосгон дэлгүүр

Бошиглогч Иосеф Смитийн улаан тоосгон дэлгүүр бол Наувугийн бүх үеийн туршид Сүмийн хамгийн чухал нэг барилга байлаа (доорх зургийг үз). Энэ барилга төрөл бүрийн барааны дэлгүүрээс гадна шашин, нийгэм, иргэний үйл ажиллагааны төв байлаа. Гэгээнтнүүд энд улсын нэг сургуулийг байгуулсан аж. Тэд уг барилгыг Сүмийн болон иргэний цуглаан, залуучуудын цугларалтад зориулан ашигладаг байв. 1842 оны гуравдугаар сарын 17-нд Нийгмийн Халамжийн Бүлэг энэ дэлгүүрт зохион байгуулагджээ. Ариун сүм дуусахаас өмнө, дээд давхрыг нь ёслолын өрөө болгон ашигладаг байв. Энэ эрин үеийн анхны хишиг хүртээлтүүд энд болсон юм.



Бошиглогч Иосеф Смитийн улаан тоосгон дэлгүүр. Энэ бол Навугийн бүх үеийн туршид Сүмийн нэг чухал барилга байв.

“Хоригдлууд чөлөөтэйгөөр явах болно”

Хичээл
30

Зорилго Нас барагсдын өмнөөс ёслолууд хийлгэх боломждоо баярлахад нь ангийн гишүүдэд туслах.

- Бэлтгэл**
1. Дараах судрууд болон бусад материалыг залбирч судал:
 - а. Сургаал ба Гэрээ 2; 124:25-55; 127; 128; Иосеф Смит Түүх 1:36-39.
 - б. *Бидний Өв*, хуудас 68-71, “Наувугийн Ариун сүм” хэсэг дэх мэдээлэл
 2. *Ангийн гишүүний Судлах Удирдамж* (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.
 3. Дараах даалгаврыг урьдчилан өг:
 - а. Наувугийн Ариун сүм баригдсан тухай ярихад бэлтгэхийг ангийн нэг гишүүнээс хүс. *Бидний Өвийн* хуудас 68-71 дахь “Наувугийн Ариун сүм”-ийн эхний дөрвөн догол мөр дээр танилцуулгаа үндэслэхийг түүнд хэл.
 - б. Нас барагсдын өмнөөс баптисм гүйцэтгэсэн туршлагаа товчхон хуваалцахад бэлтгэхийг ангийн хоёр гишүүнээс хүс. Нас барагсдын өмнөөс хийх баптисмаар дамжуулан, авралыг хүлээн авахад нь бусдад тусалж чадахыг мэдсэн нь ямар санагдсанаа ярихыг тэднээс хүс. Хэрэв тэд нас барсан өвөг дээдсийнхээ өмнөөс баптисм гүйцэтгэсэн бол, уг туршлага нь зүрх сэтгэлээ өвөг дээдэс рүүгээ эргүүлэхэд нь тэдэнд хэрхэн тусалсан тухай ярихыг хүс.
 - в. Нас барсан гэр бүлийнхээ гишүүдийнхээ өмнөөс баптисм хүртэж болно гэдгийг анх мэдэхэд тэдэнд хэрхэн санагдсаныг тайлбарлахад бэлтгэхийг нэг буюу түүнээс дээш хөрвөгчдөөс хүс.
 4. Дараах зургууд байдаг бол, хичээлийн үеэр ашиглахаар бэлтгэ:
Наувугийн Ариун сүм (62432; Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 501), Ариун сүмийн баптисмын сан (62031; Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 504).

Багшид анхааруулах нь: Сайн мэдээг хүлээж авахаасаа өмнө нас барсан өвөг дээдсийнхээ талаар яаж мэдэх тухай асуултыг ангийн гишүүд асууж болно. Тойргийн гэр бүлийн түүхийн зөвлөхтэй ярилцах буюу *Ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажлын* (34697) гишүүний удирдамжийн нэг хувийг олж авахыг тэдэнд зөвлө. Тэд Сүмийн Гэр бүлийн түүхийн төвүүдийн аль нэгэнтэй холбоо барьж болно. Та ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажилд Сүмийн гишүүд оролцож болох хэлбэрүүд дээр анхаарал төвлөрүүлж болно.

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

Бошиглогч Иосеф Смит ах Алвиныхаа тухай өгүүлсэн дараах дүрслэлийг унш:

“Ах минь . . . эцгийн минь гэр бүлээс хамгийн уужуу сайхан сэтгэлтэй нь байсан юм. Ах минь бас хүмүүний хөвгүүдээс хамгийн уужуу сайхан сэтгэлтэй нэгэн байлаа... Заль мэх гэгч түүнд байсангүй... Тэр бол хамгийн эрүүл саруул ухаан бодолтой хүмүүсийн нэг байсан. Ахыг минь нас барахад Их Эзэний тэнгэр элч сүүлчийн мөчид нь түүн дээр хүрч ирсэн юм” (*History of the Church*, 5:126-127).

Алвин 1823 онд, Анхны Үзэгдлийн тухай Иосефын гэрчлэлийг хүлээж авснаас хойш гурван жилийн дараа, харин санваар сэргээгдэхээс таван жилийн өмнө нас барсныг тайлбарла.

- Сайн мэдээний бүрэн байдлыг хүлээн авахаасаа өмнө танай гэр бүлээс нас барсан эрэгтэй, эмэгтэй ямар хүмүүс байдаг вэ? Гэр бүлийнхээ эдгээр гишүүдийн тухай та нар юу мэдэх вэ?

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүд бидэнд сайн мэдээний бүрэн байдал болон санваарын ёслолууд байдгийг хэл. Нас барагсдын өмнөөс хийх ариун сүмийн ажил байгаа учраас мөнх бус амьдралдаа эдгээр ёслолыг ерөөсөө хүлээж аваагүй олон тэрбум эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн төлөө бид ёслолыг нь хийлгэж болно.

Энэ хичээл бол нас барагсдыг гэтэлгэх ажлын тухай юм гэдгийг тайлбарла. Энэ хичээлээр үндсэндээ нас барагсдын өмнөөс хийх баптисмын тухай ярилцдаг.

Ярилцах ба хэрэгжүүлэх нь

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох судрын хэсэг, асуултууд, хичээлийн бусад материалыг залбиран сонгож ав. Судрын зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Их Эзэн Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан нас барагсдын өмнөөс хийх санваарын ёслолуудын сургаалыг илчилсэн нь

- Бид юуны учир нас барагсдын өмнөөс ёслол гүйцэтгэдэг вэ? (Сайн мэдээг сонсож, санваарын аврагч ёслолуудыг хүлээн авах боломж бүх хүмүүст байх ёстойг тайлбарла. Мөнх бус байдлын үед эдгээр адислалыг хүлээж аваагүй хүмүүст энэ боломж сүнсний дэлхийд тэдэнд байх болно. Сүнсний дэлхийд тэдэнд бие махбод байдаггүй учраас тэд эдгээр ёслолыг өөрсдөө хүлээж авч чаддаггүй. Гэвч бид тэдний өмнөөс ёслолуудыг хүлээн авч болно. Сүнсний дэлхий дэх хувь хүмүүс тэр үед өөрсдийнх нь төлөө үйлдэгдсэн ёслолуудыг хүлээн авах буюу эсэргүүцэхийг сонгодог)

Бошиглогчийн үйлчлэлийн бүр эхний үед нас барагсдын өмнөөс хийх ажлын тухай Их Эзэн Иосеф Смитэд зааж эхэлснийг хэл (Иосеф Смит Түүх 1:36-39; С ба Г 2-ын хэсгийн тойм; С ба Г 2:1-3-ыг үз). Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли энэ заалтыг тайлбарлаж хэлэхдээ:

“Ялтсуудыг гүвээнээс авахыг түүнд зөвшөөрөхөөс дөрвөн жилийн өмнө Иосеф хөвгүүнд өгөгдсөн, нас барагсдын өмнөөс хийх ажлын талаарх Малахийн гайхалтай үгсийн энэхүү давталт . . . миний хувьд онцгой учир холбогдолтой юм. Энэ нь түүнийг Аароны эсвэл Мелкизедек санваар аль алиныг нь хүлээн авахаас өмнө, баптисм хүртэхээс нь өмнө түүнчлэн Сүм зохион байгуулагдахаас нэлээд өмнө өгөгдсөн юм. Энэ нь Их Эзэний төлөвлөгөөн дэх энэ ажлын тэргүүлэх байр суурийн талаар ихийг өгүүлдэг билээ” гэжээ (“A Century of Family History Service,” *Ensign*, 1995 оны 3-р сар, 61).

1840 оны наймдугаар сарын 15-нд Бошиглогч Иосеф Сеймоур Брансон гэгч Сүмийн гишүүний оршуулга дээр номлосныг тайлбарла. Тэрээр номлолынхоо нэг хэсэг болгон 1 Коринт 15-ын ихээхэн хэсгийг уншсаны дотор нас барагсдын баптисмын тухай нэг илчлэлт оржээ (шүлэг 29). Сайн мэдээг хүлээн аваагүйгээр нас барсан найз нар, садан төрлүүдийнхээ өмнөөс Гэгээнтнүүд баптисм хүртэж болохыг дараа нь тэр зарлав. Авралын төлөвлөгөө бол Бурханы хуулийн шаардлагыг дуулгавартай сахих хүсэлтэй хүн бүрийг аврах зорилготойг тэрээр зарлажээ. Энэ номлолын дараа Сүмийн гишүүд ойролцоох Миссипи мөрөнд нас барагсдын өмнөөс баптисм гүйцэтгэж эхлэв. (*Journal History of The Church of Jesus Christ of the Latter-day Saints*-ыг үз, 1840 оны 8-р сарын 15.)

2. Наувуд Ариун сүм барихыг Их Эзэн Гэгээнтнүүдэд зарлиг болгосон нь

- Гэгээнтнүүд нас барагсдын өмнөөс баптисм гүйцэтгэж эхэлснээс хойш хэдэн сарын дараа Наувуд Ариун сүм барихыг Их Эзэн 1841 оны нэгдүгээр сарын 19-нд зарлиг болгожээ (С ба Г 124:25-27). Их Эзэн энэ зарлигийн шалтгааныг юу гэсэн бэ? (Энэ асуултын хариултыг олохын тулд дараах судруудыг ангийн гишүүдтэй хамт унш. Боломжит хариултыг доор жагсаасан байгаа.)
 - а. С ба Г 124:28, 40-41. (Санваарын нэмэлт ёслолуудыг илчлэх.)
 - б. С ба Г 124:29-30, 33. (Нас барагсдын өмнөөс хийх баптисмыг гүйцэтгэх газрыг бий болгох)
 - в. С ба Г 124:55. (Тэрээр Гэгээнтнүүдийг хүндэтгэл, үхэшгүй байдал, мөнх амьдралаар адислахын тулд Түүний зарлигуудыг сахих итгэл бишрэлийг нь нотлуулах)

Наувугийн Ариун сүм бол энэ эрин үед баригдсан хоёр дахь Ариун сүм гэдгийг хэл. Ариун сүмийн үндсэн нэг зорилго нь нас барагсдын өмнөөс хийх баптисм, гишүүний баталгаа, ариун сүмийн хишиг, ариун сүмийн гэрлэлт зэрэг ёслолуудыг Гэгээнтнүүд хийлгэх газар байх ёстой байлаа. Эдгээр ёслолуудыг Көртландын Ариун сүмд гүйцэтгэдэггүй байв.

Наувугийн Ариун сүмийн зургийг үзүүл. Гэгээнтнүүд энэ ариун сүмийг барих зарлигийг дуулгавартай биелүүлэхийн тулд их золиослол хийснийг тайлбарла. *Бидний Өв* (хуудас 68-70, “Наувугийн Ариун сүм”-ийн эхний дөрвөн догол мөрөнд өгүүлсний дагуу Наувугийн Ариун сүмийн барилгын тухай илтгэхийг даалгавар авсан ангийн нэг гишүүнээс хүс).

- Наувугийн Ариун сүмийг барихад эхэн үеийн Гэгээнтнүүдийн хийсэн олон золиослолын тухай юу нь та нарт онцгой сэтгэгдэл төрүүлдэг вэ?



Наувугийн Ариун сүм. Энэ бол 1848 онд ариун сүмийг шатаахаас өмнөх үзэсгэлэн төгөлдөр эх загвар юм.

Нас барагсдын өмнөөс хийх баптисмыг Миссипи мөрөнд түр хугацаагаар хийхийг Их Эзэн Гэгээнтнүүдэд зөвшөөрснийг тайлбарла (С ба Г 124:31-32). Гэвч, “Ёслол Их Эзэний Өргөөнд гүйцэтгэгдэх хүртэл, нас барагсдын өмнөөс хийх нэг ч баптисм тэнд болохгүйг” (*History of the Church*, 4:426) Бошиглогч Иосеф 1841 оны аравдугаар сарын 3-нд зарласан ажээ. Дуусаагүй Ариун сүмийн газар давхарт модоор маш сайхан ур гаргаж хийсэн түр хугацаагаар ашиглах баптисмын санг Бригам Янг 1841 оны арваннэгдүгээр сарын 8-нд онцгойлон адисалсан аж (*History of the Church*, 4:446-447). Өнөөдөр нас барагсдын өмнөөс хийх бүх ёслол Ариун сүмүүдэд гүйцэтгэгдэх ёстой.

- Ариун сүм дуусахаас өмнө баптисмын сан барих талаарх Гэгээнтнүүдийн шийдвэр төгс байдлаас бид юу сурч болох вэ? (Энэ асуултыг ангийн гишүүд ярилцах үед нас барагсдын гэтэлгэлийн талаарх санаа бодлоо эргэцүүлэн бодоход тэднийг урь. Хэрэв тэд эхэн үеийн Гэгээнтнүүд байсан бол уг ажилд хэрхэн санаа тавих байсныг өөрсдөөсөө асуухыг тэдэнд санал болго.)

3. Бид нас барагсдын өмнөөс баптисм гүйцэтгэх хүч чармайлтдаа урамтай, баяр баясгалантай байх ёстой

Есүсийн Амилалтын дараа Шинэ Гэрээний үед нас барагсдын өмнөөс нэлээд баптисм хийгдсэнийг тайлбарла (1 Коринт 15:29). Гэвч, нас барагсдын өмнөөс аврагч ёслолууд хийлгэх агуу ажил бол эдүгээ энэ эрин үеийн Сүмийн гишүүдийн үүрэг хариуцлага юм. Ариун сүмийн баптисмын сангийн зургийг үзүүл.

12 болон түүнээс дээш настай Сүмийн гишүүд, түүний дотор шинэ хөрвөгчид нас барагсдын өмнөөс баптисм хүртэж болно гэдгийг онцлон тэмдэглэ. Нас барагсдын өмнөөс баптисм хүртэх боломжтой байхын тулд тухайн гишүүн Ариун сүмийн хүчинтэй зөвшөөрлийн бичигтэй байх ёстой. Эрэгтэй гишүүд санваар эзэмшсэн байх ёстой.

- С ба Г 128:15-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Нас барсан хүмүүс авралынхаа талаар ямар замаар биднээс хамааралтай байдаг вэ? Бидний аврал ямар байдлаар нас барагсдын авралаас хамааралтай байдаг вэ? (С ба Г 128:17-18 болон дараах эшлэлүүдийг үз)

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли: “Их Эзэний Өргөөнд болдог зүйл нь . . . миний мэдэх аливаа бусад үйл ажиллагаанаас илүүгээр Их Эзэний золиослолын сүнстэй илүү ойрхон байдаг. Яагаад гэвэл хүмүүс ямар ч талархал эсвэл хариу шагнал хүлээлгүйгээр, өөрсдийнхөө төлөө хийж чадахгүй зүйлийг нь бусдад зориулж хийхэд цаг зав, хөрөнгө мөнгөө зориулдаг юм” гэж хэлжээ (*Ensign*, 1995 оны 3-р сар, 62-63).

Арванхоёрын Чуулгын Ахлагч Жон А.Видцөү хэлсэн нь: “Бидний өмнөх оршихуйд, их зөвлөгөөний өдөр бид Бүхнийг Чадагчтай нэгэн гэрээ хийсэн билээ. Их Эзэн өөрөө зохиосон нэгэн төлөвлөгөөг танилцуулсан юм. Бид төлөвлөгөөг хүлээж авсан. Энэ төлөвлөгөө бүх хүмүүст зориулагдсан учраас бид хүмүүсийн авралын төлөө үүрэг хүлээх болсон билээ. Бид чухам тэр үед зөвхөн өөрсдийгөө аврагчид байх төдийгүй, бас хүмүүний бүх гэр бүлийн аврагчид байхыг зөвшөөрч, Их Эзэнтэй хамтран ажиллах болсон билээ. Төлөвлөгөө боловсруулах нь тэр үед зөвхөн Эцэгийн ажил, Аврагчийн ажил байсангүй, бас бидний ажил болсон юм. Авралын мөнхийн төлөвлөгөөний зорилгыг гүйцэлдүүлэхэд бидний хамгийн өчүүхэн нь, бүр хамгийн даруухан нь Бүхнийг Чадагчтай хамтран ажилладаг” (“The Worth of Souls,” *Utah Genealogical and Historical Magazine*, 1934 оны аравдугаар сар, 189).

- С ба Г 2-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Нас барагсдын өмнөөс баптисм гүйцэтгэх нь зүрх сэтгэлээ өвөг дээдэс уруугаа эргүүлэхэд бидэнд хэрхэн тусалж болох вэ?

Нас барагсдын өмнөөс хийх баптисмаар дамжуулан, авралыг хүлээж авахад нь бусдад тусалж чадна гэдгийг мэдэх нь тэдэнд ямар санагддаг тухай товчхон ярихыг даалгавар авсан ангийн гишүүдээс хүс (“Бэлтгэл,” зүйл 3б-г үз).

Хэрэв та залуучуудад заадаг бол, сайн мэдээг хүлээн авалгүйгээр нас барсан хүмүүсийн нэрсийг олох судалгаа хийсэн хэсэг залуу эмэгтэйчүүдийн тухай дараах түүхийг хуваалцахыг хүсч болох юм:

“Меридианы [Айдоха] 15 дугаар тойргийн залуу эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн 400 гаруй нэрэнд судалгаа хийсний дараа, Бойзын [Айдоха] Ариун сүмд баптисм гүйцэтгэхийн тулд өөрсөдтэйгээ хамт явахад тойргийнхоо залуу эрэгтэйчүүдийг урьсан ажээ. Ариун сүм тэдний тойргийн файлд дээрх нэрсийг оруулан хадгалахыг зохион байгуулжээ. 15 настай Хеадер Беннетт, “Хамгийн сайхан нь хүмүүсийн төлөө баптисм хүртэх байлаа. Нэрс нь надад танил юм шиг санагдаж байв. Энэ бол бүх төслийн хамгийн эрхэм ариун хэсэг байлаа. Өөр байдлаар хийгдэж чадахгүй ажлыг бид хүмүүсийн төлөө хийсэн. Тэр хүмүүс мартагдаж болох байв” гэж ярьжээ.

Бүлгийн өөр нэг гишүүн Кори Крисченсен, “Бид Ариун сүмийн баптисмын санд сууж байх үед санаа сэтгэл тун сайхан байсан шүү. Энэ бол амжилтын агуу мэдрэмж байлаа. Бид тэр хүмүүст боломж олгосон доо” гэж хэлэв (“Names and Faces,” *New Era*, 1994 оны 2-р сар, 32).

- С ба Г 128:19, 22-24-ийг ангийн гишүүдтэй хамт унш. Эдгээр шүлэгт өгүүлснээр сайн мэдээний талаар, нас барагсдын өмнөөс хийх баптисмын талаар бид ямар бодол санаа хандлагатай байх ёстой вэ? Нас барагсдын өмнөөс хийх баптисмын сэдэв нь амьд байгаа хүмүүс, нас барагсад аль алинд нь яагаад ийм их баяр баясгаланг авчирдаг вэ?

Гэр бүлийнхээ нас барсан гишүүдийн өмнөөс баптисм хүртэж болохыг анх удаа мэдэхэд тэдэнд ямар санагдсаныг тайлбарлахыг даалгавар авсан ангийн гишүүдээс хүс. (“Бэлтгэл,” зүйл 3в-г үз).

Дүгнэлт

С ба Г 128:17-г ангийн гишүүдтэй хамт унш. Нас барагсдыг гэтэлгэх ажлыг “Үүрдийн сайн мэдээнд хамаарах бүх сэдвээс хамгийн эрхэм дээд нь” хэмээн Бошиглогч Иосеф Смит нэрлэснийг онцлон тэмдэглэ. Нас барагсдын өмнөөс баптисм гүйцэтгэхийн тулд чадах бүхнээ хийхэд нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Сүнсээр өдөөгдсөний дагуу, хичээлийн үеэр ярилцсан үнэнүүдийн тухай гэрчил.

Нэмэлт заах санаанууд

Та зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болгож дараах санаануудаас нэгийг буюу хоёрыг нь ашиглаж болно.

1. Сургаал ба Гэрээ 127, 128-ын түүхэн үндэс

С ба Г 127, 128-ын түүхэн үндсийг гаргахын тулд дараах мэдээллийг ашигла:

1842 оны зун Бошиглогч Иосеф Смитийг хилс хэргээр шоронд хориулахыг санаархаж байв. Энэ мөрдлөг хавчлагын улмаас Бошиглогч Наувуг орхин явсан юм. “Энэ газрыг түр хугацаагаар орхин явах нь миний өөрийн аюулгүй байдал, энэ хүмүүсийн аюулгүй байдлын төлөө миний хувьд зайлшгүй шаардлагатай хийх зүйл, мэргэн ухаан мөн гэж би бодно” гэж тэр хэлжээ (С ба Г 127:1). Тэрээр ийм хүнд нөхцөл байдлыг эс хайхран Гэгээнтнүүдэд бичсэн захидалдаа хөгжилтэй үгсийг бичдэг байжээ.

- Мөрдлөг хавчлагын энэ үед Бошиглогчийн оюун ухааныг эзэмдэж, өдрийн бодол, шөнийн зүүд болж байсан сэдэв юу вэ? (С ба Г 128:1-ийг үз.)

2. Цэдэг хөтлөхийн ач холбогдол

Их Эзэн Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан, нас барагсдын баптисмын цэдгийг нягт нямбай хөтлөхийг Гэгээнтнүүдэд зарлиг болгожээ (С ба Г 127:5-9; 128:1-9). Эдгээр цэдэг эдүгээ компьютерт хадгалагддаг.

- Бид яагаад нас барагсдын өмнөөс хийдэг баптисмын цэдгийг хөтлөх ёстой вэ? (С ба Г 128:6-8, 24-ийг үз. Дэлхий дээр хөтлөгддөг эдгээр цэдэг тэнгэрт бас хийгддэг. Ингэснээр нас барагсад эдгээр номуудаар шүүгдэнэ. Бид Хоёр дахь Ирэлтийн үед эдгээр цэдгийг Их Эзэнд өргөх өргөлөө болгон Түүнд толилуулна).

“Энэ амьдралд болон бүх үүрд мөнхөд... лацдан холбогдох нь”

Хичээл
31

Зорилго

Мөнхийн гэрлэлт бол Тэнгэрлиг Эцэгийн төлөвлөгөөний нэн чухал хэсэг гэдгийг ойлгоход нь ангийн гишүүдэд, мөнхийн гэрлэлтэд бэлтгэхэд нь залуучуудад туслах, гэрлэлтийн гэрээгээрээ амьдрахад нь гэрлэсэн хосуудыг урамшуулан дэмжих.

Бэлтгэл

1. Сургаал ба Гэрээ 131:1-4; 132:4-33; түүнчлэн энэ хичээлийн бусад судрыг залбирч судал.
2. *Ангийн гишүүний Судлах Удирдамж* (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.
3. Хэрэв та залуучуудад заадаг бол, *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* (36550) товхимлын нэг эсвэл хоёр хувийг ангид авчир. Та ангийн гишүүн бүрд нэг товхимлыг авчирч болно эсвэл өөрсдийнхөө номыг ангид авчрахыг ангийн гишүүдээс хүсч болно.
4. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах бол Ариун сүмд гэрлэсэн тойргийнхоо аль нэг гишүүнтэй холбоо барь. Ариун сүмд гэрлэсэн өдрийнхөө талаар хичээлийн эхэнд дөрвөөс таван минут ярьж өгөхөд бэлтгэхийг түүнээс хүс. Хуримын тухай гэрэл зураг эсвэл дурсгалын өөр ямар нэг зүйл авчрахыг та түүнээс хүсч болно. Дараах асуултуудыг бэлтгэлдээ анхаарч үзэхийг түүнээс хүс:
 - Ариун сүмийн гэрлэлтэд бэлтгэхийн тулд та юу хийсэн бэ?
 - Ариун сүмд гэрлэх нь ямар онцлог ялгаатай вэ?
 - Ариун сүмд хараахан гэрлээгүй байгаа гишүүдэд бэлтгэхэд нь туслахын тулд та ангийн гишүүдэд ямар зөвлөгөө өгч чадах вэ?

Багшид анхааруулах нь: Та энэ хичээлийг заахдаа, ганц бие эцэг эх, уламжлалт гэр бүлийн харилцаанаас гадуур байгаа бусад хүмүүсийн хувьд анхаарал болгоомжтой, мэдрэмтгий бай (эхний нэмэлт заах санааг үз). Гэр бүл салалтын тухай эсвэл анхаарал болгоомжтой, мэдрэмтгий байвал зохих асуултыг ангийн гишүүд асуух юм бол, ийм асуултыг ангид ярилцахгүй, харин бишоптой ганцаарчлан ярилцахад нь тэднийг дэмж.

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

Ариун сүмд гэрлэсэн өдрийнхөө тухай яриулахаар даалгавар авсан тойргийн гишүүнийг урь (“Бэлтгэл,” зүйл 4-ийг үз). Танилцуулгын дараа, тухайн хүний ярьсан зүйлсийг товч тайлбарла. Энэ хичээлээр мөнхийн гэрлэлтийн тухай ярилцана гэдгийг тайлбарла.

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбиран сонгож ав. Судрын зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Мөнхийн гэрлэлт Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөнд амин чухал

С ба Г 131:1-4; 132:4-33-ыг зааж, ярилц. Их Эзэнээс Бошиглогч Иосеф Смитэд өгсөн мөнхийн гэрлэлтийн тухай илчлэлтүүд судрын эдгээр хэсэгт байдгийг тайлбарла. Энэ эрин үе дэх Арванхоёрын Чуулгын анхны гишүүдийн нэг Ахлагч Парли П.Пратт, Бошиглогч Иосеф эдгээр сургаалыг зааж байхыг нь анх удаа сонсоод төрсөн сэтгэгдлийнхээ тухай дурсан ярьсан нь:

“Би урьд нь хайрладаг байсан. Гэвч яагаад гэдгийг мэддэггүй байлаа. Харин одоо бол би чин сэтгэлээсээ, санаа сэтгэлийг минь өргөж буй, эрч хүчтэйгээр өргөж, өргөн дээдэлж буй мэдрэмжээр хайрлаж байлаа... Бурхан бол үнэхээр миний Тэнгэрлэг Эцэг гэдгийг ; Есүс бол миний ах, мөн хайрт гэргий минь миний үхэшгүй, үүрд мөнхийн хамтрагч мөн гэдгийг би мэдэрч байлаа... Товчхон өгүүлбэл, одоо би Сүнсээр бас ойлголтоор хайрлаж чаддаг боллоо” (*Autobiography of Parley P. Pratt* [1975], 298).

- Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга “Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын гэрлэлт [Бурханы] мөнхийн төлөвлөгөөний төвд байдгийг” тунхаглажээ (“Гэр бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг,” *Ensign*, 1995 оны арваннэгдүгээр сар, 102; мөн С ба Г 49:15-ыг үз). Гэрлэлт яагаад Бурханы мөнхийн төлөвлөгөөний төвд байдаг вэ? (С ба Г 131:1-4; 1 Коринт 11:11-ийг үз)

Дараах хэлсэн үгсээс нэгийг буюу илүү олныг хуваалц. Нэг мэдэгдлийг хуваалцсаны дараа, утгыг нь болон амьдралд хэрхэн хэрэглэх тухай ярилцахад ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Арванхоёрын Чуулгын Ахлагч Жозеф Б.Вертлин: “Мөнхийн гэрлэлт дэх ханийн жаргал бол Бурхан хүүхдүүддээ соёрхсон хамгийн агуу адислал мөн. Хайрт ханьтайгаа миний хуваалцсан олон жил амьдралд минь хамгийн гүнзгий баяр баясгаланг авчирсан нь тодорхой юм. Цаг хугацааны эхлэлээс эхнэр, нөхөр хоёрын гэрлэлт бидний Тэнгэрлэг Эцэгийн аз жаргалын агуу төлөвлөгөөнд төв суурийг эзэлсээр ирсэн билээ. Бидний амьдрал сайн сайхан байж, гэр бүлийнхээ хайртай гишүүдтэй харилцан холбоотой байх агуу адислалыг хүртэгчийн хувьд бид хоёр хоёул гэгээрч, уужуу өгөөмөр сэтгэлтэй болсон юм” гэж хэлсэн байдаг (In Conference Report, 1997 оны аравдугаар сар, 42; *Ensign*, 1997 оны арваннэгдүгээр сар, 32).

Арванхоёрын Чуулгын Ерөнхийлөгч Боид К.Пакер сургасан нь: “Бидний заадаг бүх зүйлийн эцсийн зорилго бол эцэг эх, үр хүүхдийг Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлд нэгтгэх, тэд гэр орондоо аз жаргалтай байж, мөнхийн гэрлэлтээр лацдагдан, үе үеийнхэнтэйгээ холбогдож, Тэнгэрлэг Эцэгийнхээ оршихуйд өргөмжлөгдөхөд бат итгэлтэй байх явдал мөн” (In Conference Report, 1995 оны 4-р сар, 8; *Ensign*, 1995 оны 5-р сар, 8).

Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит хэлэхдээ: “Хожмын үеийн Гэгээнтнүүдийн ойлгодгоор гэрлэлт бол үүрд байхаар томилогдсон гэрээ юм. Энэ бол мөнхийн өргөмжлөлийн суурь юм. Учир нь гэрлэлтгүйгээр Бурханы хаант улс дахь мөнхийн өсөлт дэвшилт байж чадахгүй ” гэжээ (*Doctrines of Salvation*, эмхтгэсэн Брус Р.МкКонки, боть 3, [1954-1956], 2:58).

- Хэрэв нөхөр, эхнэр хоёр Ариун сүмд энэ амьдралд болон үүрд мөнхөд гэрлээгүй бол, тэдний нэг нь нас барахад гэрлэлтийнх нь байдал ямар болох - (С ба Г 132:7, 15-18-ыг үз. Тэд бүр үүрд хамт байх ам тангараг тавьсан байлаа ч, гэрлэлт нь “хүчин төгөлдөр биш байх болно.”)
- Эрэгтэй эмэгтэй хоёр Ариун сүмд энэ амьдралд болон үүрд мөнхөд гэрлэсэн бол тэд Их Эзэнтэй гэрээ хийсэн байдаг. Хэрэв тэд гэрээндээ үнэнч байх юм бол ямар адислалууд хүлээж авах вэ? (С ба Г 131:1-4; 132:19-24, 30-1-ийг үз. Дараах хуудсан дээр жагсаасан зүйлүүд хариулт байж болно)
 - а. Тэд “Энэ амьдралд бас бүх үүрд мөнхийн туршид” (С ба Г 132:19) хамтдаа байх болно. Хүүхдүүд нь ч бас мөнхийн гэр бүлийн хэсэг байж болно. (Амлалтын Ариун Сүнс бол бидний хүлээж авсан санваарын ёслолуудыг болон Бурханы хувьд хүлээн зөвшөөрөгдөж болохуйц бидний хийсэн гэрээнүүдийг баталдаг Ариун Сүнс юм гэдгийг та тайлбарлахыг хүсч болно. Энэхүү баталгаа бидний итгэл бишрэлийн байдалаас хамааралтай юм.)
 - б. Тэд Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христтэй хамт селестиел хаант улсын хамгийн дээд зэрэглэлд өргөмжлөгдөх болно (С ба Г 131:1-3; 132:23-24).
 - в. “Хаан ширээнүүд, хаант улсууд, вант улсууд... хүчнүүд, [мөн] эзэгнэлүүдийг” (С ба Г 132:19) тэд өвлөх болно.
 - г. Тэд үүрд мөнхийн туршид үр удамтай эсвэл сүнсэн хүүхдүүдтэй байх болно (С ба Г 132:19, 30-31; мөн С ба Г 131:4-ийг үз).
 - е. “Тэдэнд бүх хүч байх учраас тэд бурхад байх болно” (С ба Г 132:20-21).
- Мөнх бус байдалд Ариун сүмийн гэрлэлт ямар адислал авчирдаг вэ? (Ариун сүмд гэрлэх тухай бодол санаагаа хуваалцахад ангийн гишүүдийг урь. Хэрэв та хуудас 202 дээрх Ахлагч Жозеф Вертлиний үгийг уншаагүй бол та одоо үүнийг уншиж болно).

2. Залуучууд мөнхийн гэрлэлтэд одооноос бэлтгэх ёстой

Хэрэв та залуучуудад заадаг бол ариун сүмийн гэрлэлтэд бэлтгэхэд нь тэднийг урамшуулан дэмжихийн тулд хичээлийн энэ хэсгийг ашигла. Хэрэв та насанд хүрэгчдэд заадаг бол энэ хэсгийг орхих буюу зөвхөн багахан хэсгийг нь ашиглаж болно.

- Ариун сүмийн гэрлэлт Сүмийн залуучуудын хувьд яагаад ийм чухал гэж та нар боддог вэ? (Ариун сүмд гэрлэх шийдвэр гаргах нь хүний гаргаж болох хамгийн чухал шийдвэрүүдийн нэг гэдгийг ойлгоход нь ангийн гишүүдэд тусал. Сүмийн гишүүд залуугаасаа мөнхийн гэрлэлтэд бэлтгэж эхлэх ёстой)

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл хэлсэн нь: “Гэрлэлт бол бүх шийдвэрээс хамгийн чухал нь байж болох . . . бөгөөд нэн урт удаан үргэлжлэх үр дагавартай юм. Учир нь гэрлэлт аз жаргалыг тэр даруйд авчирдаггүй төдийгүй, бас мөнхийн баяр баясгаланг ч тэр даруйдаа бий болгодоггүй. Гэрлэлт нь зөвхөн оролцож байгаа хоёр хүнд төдийгүй, бас тэдний гэр бүл, ялангуяа тэдний үр хүүхэд, хүүхдийнх нь хүүхдүүдэд олон үеийн туршид нөлөөлдөг” (“Oneness in Marriage,” *Ensign*, 1977 оны 3-р сар, 3).

- Ариун сүмд гэрлэхээр бэлтгэхийн тулд залуу эрэгтэйчүүд, залуу эмэгтэйчүүдийн хийж болох зарим зүйл юу вэ?

- Өсвөр насанд болзох хожим нь гэрлэхэд хэрхэн нөлөөлдөг вэ? (Хэрэв та *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* товхимлуудыг авчирсан бол хуудас 24-25 дээрх “Болзоог” ангийн гишүүдээр уншуул)
- Цаг нь болоход ямархуу хүнтэй гэрлэхийг чи хүсдэг вэ? (Та ангийн гишүүн бүрээр нэг шинж чанарыг нэрлүүлж, яагаад энэ нь чухал болохыг яриулахыг хүсч болох юм. Хариултыг самбар дээр жагсаа. Бусад санаануудад зориулж дараах эшлэлүүдийг ашигла) Ийм хүнтэй гэрлэхэд бэлтгэхийн тулд чи яаж амьдрах ёстой вэ? (Энэ асуултанд чангаар хариулах биш, харин тунгаан бодоход ангийн гишүүдийг урь)

“Өөрийнхөө Сүмээс ханиа сонго. Ингэвэл та илүү аз жаргалтай байхвий. Өөрөө цаг үргэлж хүндлэн дээдэлж явах, амьдралд чинь дутуу дундуурыг тань гүйцээн дүүргэх хүнийг, өөрөө бүх зүрх сэтгэлээ, хайраа, чин үнэнч шударга зан чанараа зориулах тийм хүнийг сонго” гэж Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли зөвлөжээ (“Life’s Obligations,” *Ensign*, 1999 оны 2-р сар, 2).

Арванхоёрын Чуулгын Ахлагч Ричард Г.Скотт хэлсэн нь:

“Сайхан царай зүс, биеийн гоолиг галбир төрх биш, харин мөнхийн гэрлэлтийн суурь илүү чухал юм. Нэрд гарсан эсвэл олны дунд алдар хүндтэй болсноос илүү ихээр анхаарч үзэх зүйл байдаг. Та нар мөнхийн ханиа эрэхдээ Их Эзэнийг болон Түүний зарлигуудыг хайрлах гүнзгий хайр, зарлигуудаар амьдрах хоёргүй сэтгэл, бусдыг нинжин сэтгэлээр ойлгож, уучлах, сайхан үр хүүхэдтэй, өнөр өтгөн гэр бүлтэй байх хүсэлтэй байж, үүнд өөрийгөө зориулах, гэр орондоо үнэний зарчмуудыг үр хүүхэддээ заахад шийдвэр төгс байх зэрэг аз жаргалыг авчирдаг нэн чухал шинж чанаруудыг хөгжүүлдэг хүнийг эрж хай.

“Ирээдүйн гэргийн эн тэргүүний нэг шинж чанар бол гэргий байх, эх хүн байх хүсэл эрмэлзэл юм. Бурханаас Өөрийн охидод өгсөн гэргий болон эх хүн байх эрхэм ариун шинж чанарууд гэвэл: тэрээр ажил мэргэжлийн ашиг сонирхлыг эрэлхийлэхээс илүүгээр тэвчээр, нинжин сэтгэл, үр хүүхдээ хайрлах хайр, тэдний төлөө анхаарал халамж тавих чин хүслийг хөгжүүлдэг байх ёстой. Эх хүн байх шаардлагад бэлтгэхийн тулд эмэгтэй хүн сайн боловсрол олж авах ёстой.

“Ирээдүйн нөхөр нь санваартаа хүндэтгэлтэй ханддаг, бусдад үйлчлэхэд санваарыг ашигладаг байх ёстой. Амьжиргааны хэрэгцээт зүйлсээр гэр бүлээ хангах үүргээ хүлээн зөвшөөрч өөртөө авдаг, энэхүү хариуцлагаа биелүүлэхэд өөрийгөө бэлтгэхийн төлөө хүч чармайлтаа дайчлан ажилладаг, үүргээ биелүүлэх чадвартай хүнийг эрж хай” (In Conference Report, 1999 оны 4-р сар, 31; *Ensign*, 1999 оны 5-р сар, 26).

- Мөнхийн гэрлэлтэд бэлтгэхэд нь эцэг эхчүүд, насанд хүрсэн бусад хүмүүс залуучуудад хэрхэн тусалж чадах вэ? Мөнхийн гэрлэлтэд бэлтгэхэд нь тэд бага насны хүүхдүүдэд хэрхэн тусалж чадах вэ?

3. Нөхөр эхнэр хоёр Ариун сүмд лацдан холбуулсны дараа, амлагдсан адислалуудыг хүлээн авахын тулд гэрээгээр амьдрах ёстой

Дараах эшлэлийг ангийн нэг эмэгтэй гишүүнээр уншуул. Дараа нь эшлэлийг ямар хүн хэлснийг таахыг ангийн гишүүдээс хүс.

“Эхний арван жилд л аз жаргалтай байдаг гэдэгт би итгэдэг байлаа. Гэвч зохицуулах олон зүйл байгааг хамтын амьдралынхаа эхний жил л . . . би олж мэдэв. Мэдээжийн хэрэг эдгээр нь, эцэг эхчүүдтэйгээ ярилцахыг та нараас албадан шаардах зүйл биш л дээ. Гэвч би дэрээ норготол дахин дахин уйлсаар байлаа. Асуудал нь гэвэл үргэлж өөр хүний ажлын хуваарийн дагуу амьдарч сурах, юмсыг өөр хүний арга замаар хийж сурахтай холбоотой байлаа. Бид хоёр бие биендээ хайртай байсан, үүнд ямар ч эргэлзээ байгаагүй. Гэвч бид хоёр бие биендээ дасан зохицох шаардлагатай байлаа. Гэр бүлийн хос бүр бие биендээ дасан зохицож амьдрах ёстой гэж би боддог.”

Эдгээр үгсийг Ерөнхийлөгч Гордон Б.Хинклийн гэргий, Маржори П.Хинкли эгч хэлснийг ангийн гишүүдэд хэл (Sheri L. Dew, *Go Forward with Faith: The Biography of Gordon B. Hinckley* [1996], 118). Гэрлэлт амжилттай байхын тулд хайр, ажил хөдөлмөр, бүхнээ зориулсан хоёргүй сэтгэл шаардлагатайг онцлон тэмдэглэ. Эрэгтэй, эмэгтэй хоёр хүн Ариун сүмд лавдан холбуулсны дараа, тэд зөвхөн “гэрээг дагах” (С ба Г 132:19) юм бол амлагдсан адислалыг хүлээн авна. “Гэрээг дагахын” тулд нөхөр, эхнэр хоёрын хийх ёстой зүйлүүдийг ойлгоход нь ангийн гишүүдэд туслахын тулд хичээлийн энэ хэсэг дэх асуулт, судар, эшлэлүүдийг ашигла.

- С ба Г 42:22-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Энэ зарлиг эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд адилхан хамаатайг тайлбарла. Эхнэр буюу нөхрөө бүх зүрх сэтгэлээрээ хайрлана гэдэг юу гэсэн үг вэ? Өөр хэнтэй ч биш, зөвхөн эхнэр буюу нөхөртэйгөө нэгдэн нийлнэ гэсэн нь юу гэсэн үг вэ?

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл тайлбарласан нь:

“Их Эзэн бүх зүрх сэтгэлээ гэж хэлэхдээ энэхүү сэтгэл зүрхийг хуваалцах, хуваах эсвэл эргүүлэхгүй байх гэсэн утгыг илэрхийлжээ. . .

“Өөр хэнтэй ч биш гэсэн үгс нь нөхөр буюу эхнэрээс өөр хүн бүрийг, бас юм бүрийг үгүйсгэдэг. Ийм үед эхнэр, нөхөр нь аль нэгнийхээ нийгмийн амьдралд, ажил мэргэжлийн болон улс төрийн амьдралд, эсвэл аливаа бусад ашиг сонирхол, өөр хүн буюу ямар нэг зүйлд бусдаас онцгой давуу байдалтай байж, нөхөр буюу эхнэрээ эн тэргүүнд тавьдаг байх ёстой. . .

“Гэрлэлт бол чин үнэнч, хоёргүй сэтгэлийг зайлшгүй шаарддаг. Эхнэр буюу нөхөр бүр нь бүх зүрх сэтгэл, хүч чадал, чин үнэнч сэтгэл, хүндэтгэл, хайр энэрэл, нэр төрөө өөрт нь зориулдгийг хань нь ойлгодог байх ёстой. Аливаа хазайлт бол нүгэл мөн. Аливаа хэлбэрээр зүрх сэтгэлээ өөр хэн нэгэнтэй хуваалцах нь зөрчил мөн. Бид “Бурханы алдар суугийн төлөө бүхнээ зориулах” ёстой байдаг шиг, бид нүд, чих, зүрх сэтгэлээ гэрлэлт, гэр бүл, нөхөр буюу эхнэртээ зориулах ёстой” (*Faith Precedes the Miracle* [1972], 142-43).

“Бие биедээ дээдийн дээдээр чин үнэнч бай” гэсэн энэхүү энгийн зөвлөгөөг Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли гэрлэсэн хосуудад өгчээ (*Ensign*, 1999 оны 2-р сар, 4).

- Эрэгтэй эмэгтэй хоёр хүн Ариун сүмд гэрлэснээр тэд бие биедээ үнэнч байх, бас Их Эзэнд үнэнч байх гэрээнд ордог. Бие биенээ хайрлах Их Эзэнийг хайрлах хайраа бэхжүүлэхийн тулд гэрлэсэн хосуудын хийж болох зүйл юу вэ? (Ангийн гишүүдийн хариултыг самбар дээр бич. Хамтдаа залбирч, хамт судар судлах, Сүнсээр хамтдаа удирдуулахыг эрэлхийлэх,

гэр бүлийн үдшийг хийж байх, болзоонд хамтдаа явж байх, бие биедээ зориулж цаг гаргах, гэрийнхээ ажилд бие биедээ туслах, ариун сүмд хамт орох зэрэг нь хариулт байж болно. Та энэ ярилцлагын нэг хэсэг болгон хоёр дахь нэмэлт заах санааг ашиглаж болно)

Дүгнэлт

Хэрэв та залуучуудад эсвэл Ариун сүмд хараахан гэрлээгүй байгаа бусад хүмүүст заадаг бол мөнхийн гэрлэлтэд бэлтгэхэд нь тэднийг урамшуулан дэмж. Ариун сүмд гэрлэсэн гишүүдийг гэрлэлтийн гэрээгээ сахихад нь урамшуулан дэмж.

Сүнсээр өдөөгдсөний дагуу хичээлийн үеэр ярилцсан үнэнүүдийн тухай гэрчил.

Нэмэлт заах санаанууд

Та зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болгож дараах санаануудаас нэгийг буюу илүү олныг нь ашиглаж болно.

1. Итгэлтэй Гэгээнтнүүд үүрд мөнхийн адислалуудаас ангид үлдэхгүй

Ганц бие хүмүүсийн талаарх дараах үгсийг хуваалц.

Арванхоёрын Чуулгын Ахлагч Даллин Х.Өүкс зөвлөсөн нь:

“Эдүгээ зохистой, гайхалтай Хожмын Үеийн олон Гэгээнтэн өсөлт хөгжилтийнхөө төгс боломж, зайлшгүй чухал шаардлагаар дутагдаж байгааг бид мэднэ. Ганц бие буюу үр хүүхэдгүй байх, үхэл хагацал, гэр бүл салалт өв тэгш байдалд чөдөр тушаа болж, амлагдсан адислалууд гүйцэлдэхийг хойшлуулдаг. Түүнээс гадна, гэр орондоо байнга байж үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлж, гэр орноо айлын дайтай айл шиг авч явахыг хүсдэг эмэгтэйчүүд харин ч бүр бүрэн цагийн ажилчид байхаас аргагүйд хүрдэг. Гэвч тэдний энэ байдал цаг зуурдынх юм. Зарлигуудыг сахидаг, гэрээнүүддээ үнэнч байдаг, зөв зүйлийг хүсдэг хөвгүүд охиддоо адислалуудыг үүрд мөнхөд өгөхөөс татгалзахгүй гэдгээ Их Эзэн амласан билээ.

“Мөнх бус байдал дахь хамгийн ноцтой гажиг согогын олон нь бидний Эцэгийн зохистой бүх хүүхдийн аз жаргалын агуу төлөвлөгөөн дэх дутуу дундуур бүхнийг дүүргэн биелүүлэх цаг үе болох мянган жилд зөв байрандаа орно. Ариун сүмийн ёслолуудын хувьд энэ нь үнэн байх болно гэдгийг бид мэднэ. Энэ нь бас гэр бүлийн харилцаа, гэр бүлийн туршлагын хувьд үнэн байна гэдэгт би итгэдэг” (In Conference Report, 1993 оны аравдугаар сар, 101; *Ensign*, 1993 оны арваннэгдүгээр сар, 75).

Арванхоёрын Чуулгын Ахлагч Ричард Г.Скотт зөвлөсөн нь: “Хэрэв та ганц бие бөгөөд селестиел гэрлэлтийн хувьд бат найдвартай хэтийн төлөв байхгүй ч гэсэн, энэхүү хэтийн төлөвийн төлөө амьдар. Үүний төлөө залбир. Их Эзэний товлосон цагт үүнийг хүлээ. Хөшигний наана бас хөшигний цаана энэхүү адислалаас хөндийрүүлж мэдэх аливаа хэлбэрээр жишгүүдээсээ бүү ухар. Зүрх сэтгэлийн чинь бодлыг Их Эзэн мэддэг. Уг адислалд байнга нийцэхээр амьдарсан үед та түүнийг хүлээн авах болно гэдгийг Түүний Бошиглогчид нотолдог билээ. Адислал хөшигний наана эсвэл цаана тохиохыг бид мэдэхгүй. Гэвч тэрхүү адислалын төлөө амьдар. Түүний төлөө залбир” (In Conference Report, 1999 оны 4-р сар, 33; *Ensign*, 1999 оны 5-р сар, 27).

2. Ариун сүмийн аз жаргалтай, өнө удаан үргэлжлэгч гэрлэлтийн жишээ

Залбирч үзсэний дараа, Ариун сүмийн амжилттай гэрлэлтийн сайн үлгэр дуурайл болсон, тойргийнхоо нэг эрэгтэй, нэг эмэгтэй хүнтэй холбоо барь. Аз жаргалтай, өнө удаан үргэлжлэгч гэрлэлтийн тухай зөвлөмжийг хичээлийн үеэр хоёр буюу гурван минут хуваалцахад бэлтгэж ирэхийг тэднээс хүс.

Эдгээр танилцуулгын дараа бусад зөвлөмжийг хуваалцах боломжийг та ангийн гишүүдэд олгож болно.

3. Залуучууд болон залуу насанд хүрэгчдэд өгөх даалгавар

Хэрэв та залуучуудад буюу залуу насанд хүрэгчдэд заадаг бол гэртээ хариад ирээдүйнхээ нөхөр буюу эхнэр болох хүнд хайраа илэрхийлсэн захидал бичихэд нь ангийн гишүүн бүрийг урамшуулан дэмж. Захидлаа гэрлэх хүртлээ хадгалж, эхнэр буюу нөхөртэйгээ хуваалцаж болохыг ангийн гишүүдэд зааварла.

4. Дэлхийн хандлагаас зайлсхийх нь

- Гэрлэлтийн талаарх Бурханы жишгүүдийг хүмүүс үл тоомсорлодог ямар хандлага байдаг вэ? Бид Их Эзэний жишгүүдэд үнэнч хэвээр байхын тулд юу хийж болох вэ?

5. “Ариун сүм ба гэр бүл” видео

Doctrine and Covenants and Church History Video (53912) байдаг бол “Ариун сүм ба гэр бүл,” есөн минутын хэсгийг үзүүлэхэд анхаар.

6. Олон эхнэр авах ёс

Олон эхнэр авах ёсны талаар ангийн гишүүд асуулт асуувал танд туслахын тулд дараах мэдээллийг өглөө. Энэ мэдээлэл хичээл дээр анхаарал төвлөрүүлэх гол зүйл байх ёсгүй.

Олон эхнэр авах ёсны практикийг Өөрийн хүмүүст зарлиг болгосон Их Эзэний зорилго

Мормоны Номонд Бошиглогч Иаков сургасан нь: “Өөрөөр хэлбэл та нарын дунд хэн боловч нэгээс илүү эхнэртэй байж үл болно. . . [Гэвч] хэрэв би, Түмний Их Эзэн, надад үр удмыг өсгөхийг хүсвэл, би өөрийн хүмүүст зарлиг болгох болно; өөрөөр бол тэд эдгээр зүйлийг анхааран сонсох болно хэмээн хэлэв” (Иаков 2:27, 30). Их Эзэн Библийн түүхийн янз бүрийн үед олон эхнэр авах ёсыг хүмүүст зарлиг болгож байжээ. Жишээ нь, Абрахам, Исаак, Иаков, Мосе, Давид, Соломон нарт Тэрээр энэ зарлигийг өгсөн юм (С ба Г 132:1).

Энэ эрин үе дэх олон эхнэр авах ёсны талаар өгөгдсөн илчлэлт

Энэ эрин үед, олон эхнэр авах ёсыг Их Эзэн эхэн үеийн зарим Гэгээнтнүүдэд зарлиг болгосон юм. Бошиглогч Иосеф Смит болон түүнд хамгийн ойр дотно байдаг хүмүүс түүний дотор Бригам Янг, Хебер К.Кимбалл нар энэ зарлигаар соригдож, дуулгавартай дагажээ. Сүмийн удирдагчид уг практикийг зохицуулж байв. Энэхүү практикийг хүлээн авсан хүмүүст үүнийг үйлдэх эрх мэдэл байх ёстой бөгөөд санваарын лацдан холбох хүчээр дамжуулан гэрлэлтийг гүйцэтгэх ёстой байлаа.

Олон эхнэр авах ёсны талаарх Сүмийн өнөө үеийн байр суурь

Олон эхнэр авах ёсыг Сүмийн удирдагчид заахаа зогсоох ёстой гэсэн илчлэлтийг Ерөнхийлөгч Вилфорд Вудрафф 1890 онд хүлээн авчээ (Албан Тунхаг 1, Сургаал ба Гэрээ, хуудас 406-407; Албан Тунхаг 1-ийн дараах Ерөнхийлөгч Вудраффын хэлсэн үгнээс авсан хэсгийг үз).

Олон эхнэр авах ёсны талаарх Сүмийн байр суурийн тухай Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли 1998 онд дараах мэдэгдлийг хийжээ: “Олон эхнэр авах ёсыг хэрэгжүүлж байгаа хүмүүстэй энэ Сүм ямар ч хамаагүй. Тэд энэ Сүмийн гишүүд биш. . . Хэрэв манай гишүүдээс хэн нэгэн нь олон эхнэр авах ёсыг хэрэгжүүлж байгаа нь мэдэгдвэл, Сүмээс оногдуулж болох хамгийн дээд арга хэмжээгээр тэд гишүүнээс хөөгдөх болно. Тэд зөвхөн иргэний хуулийг шууд зөрчдөг төдийгүй, бас энэ Сүмийн хуулийг зөрчдөг” (In Conference Report, 1998 оны аравдугаар сар, 92; *Ensign*, 1998 оны арваннэгдүгээр сар, 71).

Зорилго Бошиглогч Иосеф Смит алагдсан тухай ангийн гишүүдэд зааж, Бурханы Бошиглогч болох түүний дуудлагын талаарх гэрчлэлийг нь бэхжүүлэх.

- Бэлтгэл**
1. Дараах судрууд болон бусад материалыг залбирч судал:
 - а. Сургаал ба Гэрээ 135.
 - б. *Бидний Өв*, хуудас 72-77.
 2. *Ангийн гишүүний Судлах Удирдамж* (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.
 3. *Бидний Өв* (хуудас 72-74)-өөс “Аллага” хэсгийн эхний таван догол мөрийг товчлон бэлтгэж ирэхийг ангийн нэг гишүүнээс хүс.
 4. Хэрэв дараах зургууд байдаг бол хичээлийн үеэр ашиглахаар бэлтгэ: Бошиглогч Иосеф Смит (62002; Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 401), Иосеф ах (62161).
 5. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах бол дээр дурдсанаас гадна дараах зургуудыг ашиглахаар бэлтгэ: Цөлд номлож буй Иохан (62132; Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 207), Абинадай Хаан Ноагийн өмнө (62042; Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 308).
-

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

“Бэлтгэл” хэсэг, зүйл 4, 5-д дурдсан зургуудыг үзүүл. Эдгээр зургууд дээрх хүмүүс юугаараа адил нийтлэг байгааг бодохыг ангийн гишүүдээс хүс. Хэсэг хугацааны дараа, үнэнд итгэл төгс байсныхаа улмаас тэд бүгдээрээ алагдсан нийтлэг зүйл тэдэнд байгааг хэл.

Судрууд болон Сүмийн түүхээс бусад аллагыг олохыг ангийн гишүүдээс хүс. Хариулт нь Захариа (Матай 23:35), Стефен (Үйлс 7:56-60), Хайрум Смит (С ба Г 135:1) нар байж болно.

Энэ хичээлээр Бошиглогч Иосеф Смит, түүний ах Хайрум нарын аллагын тухай ярилцах болно гэдгийг тайлбарла. Хичээлээр Бошиглогч Иосефийн хувь нэмрийн тухай ярилцдаг.

Ярилцах ба хэрэгжүүлэх нь

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбиран сонгож ав. Судрын зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Бошиглогч Иосеф Смит өөрийн гэрчлэлийг цусаараа лацадсан нь

Гэгээнтнүүд Наувуд цөөхөн жил цэцэглэн хөгжиж байсныг тайлбарла. Сүм болон хот хурдан хөгжиж, ариун сүмийн ажил урагш ахин, Бошиглогч Иосеф Смит олон илчлэлт хүлээн авчээ. Гэвч 1843, 1844 оны үед, Сүмийн эсрэг дайсагнах нь улам гаарч байв. Сүмийн гаднах, доторх дайснууд сүмийг устгахыг эрэлхийлж эхлэв. Энэхүү эсэргүүцэл 1844 оны зургадугаар сарын 27-нд оргилдоо хүрсэн юм.

Бидний Өв, хуудас 72-74-өөс “Аллага” хэсгийн эхний таван догол мөрөөр илтгэл бэлтгэж ирэхийг даалгавар авсан ангийн нэг гишүүнээс хүс. Бас С ба Г 135:4-5-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Бошиглогч Иосефыг дайрах үед шархадсан Ахлагч Жон Тейлор С ба Г 135-ыг бичсэнийг тайлбарла.

- Картейжид алагдаж болзошгүйгээ мэдсэн үед Бошиглогч Иосеф Смит яагаад “Зуны өглөө лүгээ адил тайван” байсан гэж та нар бодож байна? Ифер 12:36-38-аас ямар тайтгарлыг Иосеф, Хайрум хоёр хүлээж авсан байж болно гэж та нар бодож байна?

С ба Г 135:1-2-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Аллагын тухай Ахлагч Виллард Ричардсын дараах шастирыг унших буюу ангийн нэг гишүүнээс үүнийг уншихыг хүс. Ахлагч Ричардс бол Бошиглогчийн найз бөгөөд Арванхоёрын Чуулгын гишүүн байсныг тайлбарла. Тэрээр Бошиглогчийг алагдахад Картейж Шоронд байжээ. Танхайрагч бүлэг 1844 оны зургадугаар сарын 27-ны үдээс хойш яг оройн 5:00 цагт хүрч иржээ.



Бошиглогч Иосеф Смит

“Хоёрдугаар давхарт байсан шоронгийн хаалганы өдөөс харсан шат өөдүй олон сумаар мөндөр мэт шүршиж, араас нь олон хөлийн хурдан алхаа сонсогдов. . . .

“ . . . Нэг сум хаалгыг нэвтэлж, бидний хоорондуур нисэн өнгөрсөн нь дайсан улайрсан, харгис хэрцгий болохыг харуулав. . . .

“ . . . Иосеф Смит, ноён Тейлор бид гурав өрөөний өмнөд тал руу ухасхийж, харин . . . Хайрум Смит өрөөн дундуур гуравны хоёрыг нь ухран явж өнгөрөөд, шууд урагшаа хаалга руу тулж очив.

“Хаалгыг нэвтлэн орж ирсэн нэг сум Хайрумын хамрын хажуу талыг оноход, тэр гэдрэгээ харж сунан унаад, хөл нь хөдлөхгүй болов.

“Түүний [хувцсан] дахь нүхнүүдээс харвал, гаднаас цонхоор буудсан сүм баруун талаас нь нуруунд нь тусч, халаасан дахь цагийг оносон нь илт байлаа. . . . Яг тэр мөчид хаалгаар орж ирсэн сум хамрыг нь оносон байв.

“Тэр шалан дээр унахдаа, ‘Би үхлээ’ гэж өрөвдөлтгэйгөөр дуу алдав. Иосеф түүн рүү хараад, ‘Ай, хайран ах минь, Хайрум минь!’ гэж дуу алдаад, хаалгыг хоёр, гурван инч зайтай зүүн гараараа онгойлгоод, зургаа үсэрдэг буугаар (гар буу) орц руу таамгаар галлав. . . . [Танхайрагчдын үүрдэг бууны олон сумнаас]

нэг сум Хайрумын цээжинд тусан, хоолойгоор нэвтрэн толгой уруу нь орсон бол, түүн рүү онилсон бусад олон сумнаас хэд хэд нь түүнийг оножээ.


“Иосеф хаалганы хавиас эхлэн өмнөх зай руу. . . , ноён Тейлор таягтайгаа хүрч ирэн дэргэд нь зогсох хүртэл, орох хаалгаар зогсолтгүй буудаж байсан жад болон үүрдэг буунуудын өөдөөс гар буугаараа галлаж байлаа. . . .

“Гар бууны сум дууссан учир бид цаашид буудсангүй. Тэгээд танхайрагчдын бүлэг тэр даруйд дайран орж ирэхийг хүлээж байв. Тэгтэл орох хаалга, өрөө рүү нэвтрэх зам дээр үүрдэг буу үй олноороо харагдахад, ямар ч найдваргүй болж, эндээ үхэхээс өөр замгүй болов.

“Газраас арван тав буюу хорин фут зайтай байсан цонх руу ноён Тейлор ухасхийн очив. Тэр тэнцвэрээ олж ядан байтал хаалгаар орж ирсэн нэг сум түүний хөлийг, гаднаас ирсэн нэг сум зүүн талынх нь цээжинд ойрхон . . . , хантаазных нь халаасан дахь цагийг оножээ. . . . Сумны хүч түүнийг арагш нь шалан дээр шидэхэд тэр хажуудаа байсан орон доогуур өнхрөн оров. . .

“Иосеф эцсийн хүчээ шавхан, ноён Тейлор өрөө рүү гэдрэг унасан нөгөөх цонхоор үсрэх гэж оролдтол, хаалгаар буудсан хоёр сум түүнийг онож, цонхоор гаднаас буудсан нэг сум баруун цээжинд нь тусч, ‘Ай Их Эзэн, Бурхан минь!’ . . . гэж тэрээр дуу алдаад цонхоор гадагш уналаа. Тэр амьсгалаа хураан зүүн талаараа хэвтэж байлаа” (*History of the Church*, 6:619-20).

Ахлагч Жон Тейлор дөрвөн удаа буудуулсан боловч, шарх нь эдгэрчээ. Жилийн өмнө Бошиглогчийн хийсэн нэгэн бошиглол биелэгдэж, Ахлагч Виллард Ричардс шархадсангүй. “Сум мөндөр лүгээ адил түүний хажуугаар нисч өнгөрөх цаг ирнэ. Ийнхүү тэрээр баруун талд нь бас зүүн талд нь найз нар нь унасныг харна. Харин түүний хувцсанд ганц ч нүх байхгүй байна” хэмээн Бошиглогч эл бошиглолд түүнд хэлснийг Ахлагч Ричардс дурссан байдаг (*History of the Church*, 6:619).



Картейж Шорон. Энд Бошиглогч Иосеф Смит, ах Хайрумынхаа хамт 1844 оны зургадугаар сарын 27-нд алагджээ.

- С ба Г 135:6-г ангийн гишүүдтэй хамт унш. Сайн мэдээний гэрчлэлийнхээ төлөө Бошиглогч болон ах Хайрумынх нь хийсэн золиослолын талаар бодох үед та нарт ямар сэтгэгдэл төрдөг вэ?

Эцэг Иосеф Смит нас барахаасаа өмнө Бошиглогчид нэг адислал өгч, түүнд: “Чи бүр ажлаа дуустал амьд явна. . . . Бурхан чамаар хийлгэхээр өгсөн бүх ажлын төлөвлөгөөг биелүүлэхийн тулд чи амьд явна” гэж хэлснийг тайлбарла (Люси Мак Смит, *History of Joseph Smith*, хянан тохиолдуулсан Престон Нибли [1958], 309-310-аас эш татжээ). Иосеф Смит Бурхан өөрөөр нь хийлгэхийг хүссэн бүхнийг бас өөрийн үүргийг эрэлхэг зоригтойгоор гүйцэд биелүүлсэн билээ.

- Бошиглогч Иосеф Смитийн амьдралын тухай мэдсэн зүйлээс чинь юу та нарт хамгийн гүнзгий сэтгэгдэл төрүүлэв?

2. Бошиглогч Иосеф Смит хүмүүний авралын төлөө Есүсийг эс тооцвол энэ дэлхий дээрх аль ч бусад хүнээс илүү ихийг хийсэн юм

- С ба Г 135:3-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Энэ шүлэгт өгүүлснээр, Бошиглогч Иосеф Смитийн гол амжилт юу байсан бэ? Ямар арга замаар тэр “Энэ дэлхийд хүмүүний авралын төлөө, зөвхөн Есүс Христийг эс тооцвол, үүн дээр амьдарч асан аль ч бусад хүнээс илүү ихийг” хийсэн бэ?

Түүний ажил зөвхөн энэ эрин үеийн Гэгээнтнүүдийг төдийгүй, сайн мэдээний адислал буюу санваарын аврагч ёслолуудыг хүлээн авалгүйгээр бусад бүх үед аж төрж асан олон тэрбум хүмүүсийг адисалсан нь хариулт байж болно. Энэхүү олон хувь нэмрийг нарийвчлан ярилцахын тулд дараах материалыг ашигла. Гарчгуудыг самбар дээр бич. Түүний олон хувь нэмэр бидний өдөр тутмын амьдралыг хэрхэн адисалж байгаад болон үүрд мөнхөд адислахынх нь төлөө Бошиглогчийн амьдрал, үүрэг зорилгын төлөө бид хэрхэн илүү ихээр талархаж болохыг тайлбарла.

Бурхан Тэргүүтний тухай үнэн

- Бурхан тэргүүтний тухай ямар үнэнүүд Бошиглогч Иосеф Смитээр дамжин сэргээгдсэн бэ? (С ба Г 130:22-23; Иосеф Смит–Түүх 1:17; тэрчлэн дараах эшлэлийг үз.)

1844 оны дөрөвдүгээр сарын 7-нд Ахлагч Кинг Фоллеттын оршуулга дээр өгсөн номлолд Бошиглогч Иосеф Смит: “Нэгэн цагт Бурхан өөрөө одоогийн бидэн шиг байсан ажээ. Мөн эдүгээ тэр бол өргөмжлөгдсөн хүн бөгөөд тэртээ дээд тэнгэрт хаан сэнтийд залардаг бөлгөө! Энэ бол агуу нууц. Хэрэв хөшиг өнөөдөр нээгдвэл, энэ дэлхийг үүний тойрогт барьж байдаг мөн өөрийн хүчээр бүх дэлхийг дээр барьж байдаг Бурхан өөрийгөө үзүүлэх юм бол–та нар өнөөдөр түүнийг харж болохсон. Тэр бол хэлбэрээрээ хүнтэй адилхныг–бие, дүр төрх,, бас галбираараа яг л та нартай адилхан хүн шиг болохыг та нар харна хэмээн би хэлнэ. Учир нь Адам яг энэ байдлаар, Бурхантай адил дүр төрхөөр бүтээгдсэн бөгөөд яг л нэг хүн нөгөөтэйгөө ярилцаж байгаа юм шигээр түүнээс заавар хүлээн авч, түүнтэй хамт алхлан, түүнтэй ярилцаж, үг хөөрөлдөж байсан юм” гэж сургажээ (*Teachings of the Prophet Joseph Smith*, эмхтгэсэн Жозеф Фиелдинг Смит [1976], 345).

- Иосеф Смитээр дамжин сэргээгдсэн Бурхан тэргүүтний тухай үнэнүүд яагаад бидэнд чухал вэ?

Арванхоёрын Чуулгын Ахлагч Брус Р.МкКонки: “Бурханы тухай мэдлэг бол бүх үүрд мөнхөд хамгийн агуу үнэн юм. . . . Бараг нийтээрээ сүнсний харанхуйд байсан үед шүтэн бишрэх Хүмүүн Биеийнхээ мөн чанар, шинж байдлыг огт мэдэхгүй байсан үед Иосеф Смит Бурханыг илчлэхээр ирсэн билээ” гэж хэлжээ (“This Generation Shall Have My Word through You,” *Ensign*, 1980 оны зургадугаар сар, 55).

Санваарын эрх мэдэл

Тэнгэрлэг элчүүд Иосеф Смитээр дамжуулан Аароны санваар, Мелкизедек санваар, санваарын түлхүүрүүдийг сэргээснийг хэл (С ба Г 13; 110:11-16). Сэргээлт нээгдсэн үед санваарын алба, гэрээнүүд, санваартны байгууллага, санваарын ёслолууд, үүрэг ба адислалын тухай илчлэлтүүдийг Их Эзэн өгсөн юм. Эдгээр илчлэлтүүдгүйгээр санваар хэрхэн ажилладгийг бид ойлгохгүй байж болох байв.

- Санваарын улмаас та нар амьдралдаа ямар адислал хүртсэн бэ? Бид санваарын адислалын төлөө талархлаа хэрхэн илэрхийлж болох вэ?

Санваарын тухай дэлгэрэнгүй мэдээллийг хичээл 8, хичээл 25-аас үз.

Бидний гарал үүсэл ба Бурхантай харилцах харилцааны тухай үнэн

- Бидний гарал үүсэл ба Бурхантай харилцах харилцааны тухай ямар үнэнүүд Бошиглогч Иосеф Смитээр дамжин сэргээгдсэн бэ? (Бид бол үнэхээр Бурханы Сүнсэн хүүхдүүд бөгөөд дэлхий дээр төрөхөөсөө өмнө Түүнтэй хамт амьдарч байсан нь хариулт байж болно. С ба Г 76:23-24; Абрахам 3:22-28-ыг үз.)
- Чи үнэхээр Бурханы хүүхэд болохоо мэдэх нь амьдралд чинь хэрхэн адислал болдог вэ?

Судрууд

Бошиглогч Иосеф Смит “Урьд өмнө амьдарч байсан аль ч бошиглогчоос илүү олон ариун судрыг өнөөгийн дэлхийд өгсөн юм” гэж Ахлагч Брус Р.МкКонки хэлжээ (In Conference Report, 1976 оны 4-р сар, 142; *Ensign*, 1976 оны 5-р сар, 95). Эдгээр судрууд бол Мормоны Ном, Сургаал ба Гэрээ, Агуу Үнэт Сувд, Библийн Иосеф Смитийн орчуулга юм.

Ахлагч Гордон Б.Хинкли Арванхоёрын Чуулгад үйлчилж байхдаа хэлсэн нь: “[Иосеф Смит] 522 хуудастай боть, Мормоны Номыг орчуулж, хэвлүүлсэн билээ. Энэ ном тэр үеэс хойш [олон] хэлэнд орчуулагдаж, дэлхий даяар сая сая хүмүүс Бурханы үг хэмээн хүлээн зөвшөөрөөд байна. Түүний хүлээж авсан илчлэлтүүд болон бичсэн бусад зүйлс олон сая хүмүүсийн хувьд судар гэж үнэлэгддэг билээ. Энэ номны хуудсууд Библийн Хуучин Гэрээтэй бараг бүхэлдээ дүйх зүйлийг агуулдаг бөгөөд энэ бүгд хэдхэн жилийн дотор ганцхан хүнээр дамжин ирсэн юм” (In Conference Report, 1977 оны 4-р сар, 96; *Ensign*, 1977 оны 5-р сар, 65).

- Бошиглогч Иосеф Смитээр дамжин гарч ирсэн судрууд та нарын амьдралд хэрхэн адислал болсон бэ?

Эдгээр судруудын тухай дэлгэрэнгүй мэдээллийг хичээл 1, 4, 13-аас үз.

Авралын төлөвлөгөөний тухай үнэн

- Авралын төлөвлөгөөний тухай ямар үнэн Бошиглогч Иосеф Смитээр дамжин сэргээгдсэн бэ? (Та хичээл 19, 20-ийн зарим материалыг үүнтэй холбогдуулан дахин авч үзэж болно)
- Эдгээр үнэнүүдийг мэдсэн нь амьдралд чинь хэрхэн адислал болсон бэ?

Нас барагсдын авралын тухай үнэн

- Нас барагсдын авралын тухай ямар үнэн Бошиглогч Иосеф Смитээр дамжин сэргээгдсэн бэ? (Энэ ёслолыг хүлээн авалгүйгээр нас барсан хүмүүсийн өмнөөс бид төлөөлөх баптисмыг ариун сүмд хийж болно гэдэг нь хариулт байж болно. С ба Г 128:18-ыг үз) Эдгээр үнэн яагаад чухал вэ?

Нас барагсдын аврал бол Бошиглогч Иосеф Смитээр дамжин сэргээгдсэн хамгийн өргөн цар хүрээтэй, хамгийн сүнслэгээр нөлөөлөгч сургаалуудын нэг мөн гэдгийг тайлбарла. Дэлгэрэнгүй мэдээллийг хичээл 29, 39-өөс үз.

Ариун сүм барих болон ариун сүмийн ёслолыг гүйцэтгэх нь

- Ариун сүмүүд болоод ариун сүмийн ёслолын улмаас амьдралд чинь ирсэн адислалууд юу вэ? (Ариун сүмийн лацдан холбох ёслолоор боломжтой болдог мөнхийн гэр бүлийн адислалын тухай та ярилцаж болно)

Бусад хувь нэмэр

Бошиглогч Иосеф Смитийн бусад хувь нэмрээс заримыг нь мөн эдгээрийн бидний амьдралд авчирсан адислалын тухай товч нэгтгэн дүгнэхийг та хүсч болно:

- а. Сүм түүгээр дамжин сэргээгдэв (Хичээл 9-ийг үз).
 - б. Энэ эрин үед сайн мэдээг бүх үндэстнүүдэд хүргэх болон Израйлын цугларалтын ажлыг тэрээр эхэлсэн юм (Хичээл 12-ыг үз).
 - в. Өргөлийн хууль түүгээр дамжин илчлэгдэв (хичээл 14-ийг үз).
 - г. Мэргэн Ухааны Үг түүгээр дамжин илчлэгдэв (хичээл 22-ыг үз).
 - д. Хожмын үеийн Сионыг байгуулах тухай мэдээлэл түүгээр дамжин илчлэгдсэн юм (хичээл 27, 46-г үз).
 - е. Тэрээр Итгэлийн Тунхагийг бичив (эхний нэмэлт заах санааг үз).
- Иосеф Смит бол Бурханы Бошиглогч байсан тухай гэрчлэл бидний хүн нэг бүрд байх нь яагаад чухал вэ? Иосеф Смитийн дуудлагын тухай та нарын гэрчлэл хэрхэн хөгжсөн бэ? Сургаал ба Гэрээг энэ жил судалсан нь гэрчлэлийг тань хэрхэн бэхжүүлсэн бэ?
 - Бид Бошиглогч Иосеф Смитийн амьдрал, үүрэг зорилгын төлөө талархлаа хэрхэн илэрхийлж болох вэ?

Дүгнэлт

Бидний амьдралд оруулсан Бошиглогч Иосеф Смитийн хувь нэмрийн ач холбогдлыг онцлон тэмдэглэ. Бурханы Бошиглогч болсон түүний дуудлагын тухай та хувийн гэрчлэлээ хэлж болно.

Нэмэлт заах санаанууд

Та зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болгож дараах санаануудаас нэгийг буюу илүү олныг нь ашиглаж болно.

1. Итгэлийн Тунхаг

Итгэлийн Тунхаг Сүмийн олон үндсэн сургаалыг нотолдогийг тайлбарла. Сүмийн түүх болон итгэл бишрэлийн тухай мэдэгдлийг хүссэн Чикагогийн нэг сонины эрхлэгч Жон Вентвөртэд бичсэн захидлынхаа хэсэг болгон Итгэлийн Тунхагийг Бошиглогч Иосеф Смит бичжээ. Хожим нь үүнийг судар болгон Агуу Үнэт Сувдад оруулжээ.

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл: “Итгэлийн Тунхагийг та нараас хэд нь мэддэг вэ? . . . Энэ тунхгийг та нар мэддэг үү? Та нар үүнийг давтан хэлж үзсэн үү? Та нар Итгэлийн Тунхагийг мэдсэнээр номлолд үргэлж бэлтгэгддэг. Энэ бол үндсэн сургаал биш гэж үү? Хэрэв [бид] үүнийг цээжлэх юм бол тунхаг нь бидний хувьд гайхалтай зүйл байх болно гэж би боддог. Энэ чинь юу гэсэн үг вэ? гэвэл та нар үүнээс юуг ч орхихгүй байх болно, та нар үүнийг мартажгүй байх болно гэсэн үг” хэмээн хэлжээ (In Conference Report, 1975 оны аравдугаар сар, 119; *Ensign*, 1975 оны арваннэгдүгээр сар, 79).

- Бид Итгэлийн Тунхагийг мэддэг байх нь яагаад чухал вэ? Итгэлийн Тунхаг тусалсан туршлагынх нь тухай ярихад ангийн гишүүдийг урь.

2. “Тэр хүнийг магъя”

“Тэр хүнийг магъя” (Сүмийн дуулал болон хүүхдийн дуу, х.50) дууллыг дуулахад ангийн гишүүдийг бэлтгүүл. Энэ дууллыг ангийн нэг гишүүнээр эсвэл хэсэг гишүүдээр дуулуул. Виллям В.Фелпс Бошиглогч Иосеф Смитэд хүндэтгэл үзүүлэн, энэ дууллын үгийг бичсэнийг тайлбарла.

3. Видео танилцуулга

Хэрэв *Teachings from the Doctrine and Covenants and Church History* (53933) видео хуурцаг байдаг бол “Иосеф Смит: Сэргээлтийн Бошиглогч,” 13 минутын хэсгийг үзүүлэхэд анхаар.

Хэрэв *Doctrine and Covenants and Church History Video танилцуулгууд* (53912) байдаг бол “Иосеф Смитийн Аллага,” 2 минутын хэсгийг үзүүлэхэд анхаар.

Ерөнхийлөгч Бригам Янг Гэгээнтнүүдийг удирдсан нь

Зорилго

Сүмийн удирдлага дахь залгамжлалын үйл явцыг ойлгоход нь ангийн гишүүдэд туслах, өрнөд рүү хийсэн аянд Бригам Янг Гэгээнтнүүдийг хэрхэн бэлтгэж эхэлснийг харуулах.

Бэлтгэл

1. Дараах судрууд болон бусад материалыг залбирч судал:
 - а. Сургаал ба Гэрээ 107:22-24.
 - б. *Бидний өв*, хуудас 77-79.
 2. *Ангийн гишүүний Судлах Удирдамж* (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.
 3. *Бидний өв* дэх дараах хэсгүүдийг нэгтгэн дүгнэхэд бэлтгэж ирэхийг ангийн гишүүдээс хүс:
 - а. “Ерөнхийлөгчийн Зөвлөл дэх залгамжлал” (хуудас 77-79).
 - б. “Наувуг орхин явахаар бэлтгэсэн нь”, “Өвлийн аяны бэрхшээлүүд” (хуудас 81-83).
 4. Хэрэв дараах зургууд байдаг бол заримыг нь хичээлийн үеэр ашиглахаар бэлтгэ: Наувугийн Ариун сүм (62432; Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 501); Наувугаас Шилжин Нүүсэн нь, 1846 оны хоёрдугаар сараас-тавдугаар сар (62493; Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 410); Наувугаас шилжин нүүсэн нь (Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 411).
-

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

Бошиглогч Иосеф Смитийг нас барахад Сүм цаашид оршин тогтнохоо болино гэж олон хүн урьдчилан таамаглаж байсныг тайлбарла.

- Эдгээр хүмүүс Сүмийн удирдлагын тухай юуг ойлгохгүй байсан бэ?

Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смитийн дараах үгсийг унш:

“Энэ Сүмийг ямар ч хүн ганцаархнаа удирдаж чадахгүй. Энэ бол Их Эзэн Есүс Христийн Сүм; Тэрээр сүмийг тэргүүлдэг...”

“Тэрээр хүмүүсийг сонгож, зорилгоо хэрэгжүүлэхийн тулд тэднийг өөрийнхөө мутарт зэмсгүүд байлгахгаар дууддаг, тэднийг ажил үүргээ биелүүлэхэд нь удирдан чиглүүлдэг. Гэвч хүмүүс бол ердөө л Их Эзэний мутар дахь зэмсгүүд юм. Харин түүний үйлчлэгчдийн хэрэгжүүлдэг бүх зүйлийн төлөөх алдар, хүндэтгэл үүрд түүнийх байх ёстой.”

“Хэрэв энэ ажил хүмүүний ажил байсан бол нурж унах байсан. Гэвч энэ бол Их Эзэний ажил юм. Иймээс тэрээр алдаж эндэхгүй” (In Conference Report, 1970 оны 4-р сар, 113; *Improvement Era*, 1970 оны зургадугаар сар, 26).

Бошиглогч Иосеф Смитийг алагдсаны дараа Сүмд өнөөдрийг хүртэл үргэлжилж байгаа сүнсээр нөлөөлөгдсөн залгамжлалын үйл явцаар Бригам Янг Сүмийн удирдагч болсныг тайлбарла. Энэ хичээл Сүмийн Ерөнхийлөгчийн Зөвлөл дэх залгамжлалын тухай ярилцаж, Бригам Янг өрнөдөд Солт Лейкийн хөндий рүү хийсэн аянд Гэгээнтнүүдийг хэрхэн бэлтгэснийг өгүүлнэ.

Ярилцах ба
хэрэгжүүлэх нь

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбиран сонгож ав. Судрын зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахад ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Бошиглогч Иосеф Смит хаант улсын түлхүүрүүдийг Арванхоёрт өгч, Ерөнхийлөгчийн Зөвлөл дэх залгамжлалын зарчмыг заасан нь

1843-1844 оны өвөл Бошиглогч Иосеф Смит Наувуд Арванхоёрын Чуулгад ариун сүмийн хишгийг нь хүртээж, үүрэг хариуцлагынх нь тухай зааж хэдэн өдрийг өнгөрөөснийг тайлбарла. Тэрээр хаант улсын түлхүүрүүдийг бусдад шилжүүлж өгөлгүйгээр удахгүй хорвоог орхихвий гэж санаа нь зовж байснаа Арванхоёрт ярьсан аж. Тэр үед Арванхоёрын Чуулгын гишүүн асан Вилфорд Вудрафф, Бошиглогч Иосефын дараах үгсийг дурссан байдаг:

“Ингэхэд ах нар аа, та нарт ариун сүмийн хишгийг тань өгөх энэ өдрийг харахаар амьд сэрүүн явсандаа би Бурханд талархдаг. Аароны болон Мелкизедек санваарын түүнчлэн Төлөөлөгчдийн бүх хүчийг дээрх хоёр санваарын бүх түлхүүрийн хамт би та нарын тэргүүн дээр лацадлаа. Эдгээрийг Бурхан надад лацадсан юм. Ингэснээр энэ Сүмийн болон Бурханы Хаант улсын талаарх бүх ажил хөдөлмөр, үүрэг хариуцлага, санаа тавилтыг би та нарын мөрөн дээр шилжүүлж, өөрсдийгөө бэхжүүлж, бэлтгэхийг мөн энэ Сүм болоод Бурханы Хаант улсыг удирдахыг та нарт тэнгэр, газар, Бурханы өмнө, тэнгэр элчүүд болон хүмүүсийн өмнө Их Эзэн Есүс Христийн нэрээр зарлиг болгож байна” (Жеймс Р.Кларк, *Messages of the First Presidency of The Church of Jesus Christ of Latter-day Saints*, боть 6, [1965-1975], 3:134).

- Ерөнхийлөгчийн Зөвлөл дэх залгамжлалтай холбоотой нэг чухал зарчим С ба Г 107:22-24-т цэдэглэгдсэн байдаг. Эдгээр шүлгийг ангийн гишүүдтэй хамт унш. Тэргүүн Зөвлөл болон Арванхоёрын Төлөөлөгчийн Чуулгын харилцааны тухай эдгээр шүлэг юу заадаг вэ? (Тэргүүн Зөвлөл, Арванхоёр Төлөөлөгч тус тусдаа нэг чуулга болдгийг тайлбарла. Эрх мэдэл, хүчээр энэ хоёр чуулга адил тэгш боловч, Тэргүүн Зөвлөл нь тэргүүлэхээр дуудагддаг)
- Сүмийн тэргүүлэх энэ хоёр чуулгын харилцааг ойлгох нь яагаад чухал вэ?

“Ерөнхийлөгч байхгүй бол Тэргүүн Зөвлөл байхгүй” гэж Бошиглогч Иосеф Смит хэлсэн юм. Ерөнхийлөгчийг нас барсан тэр даруйд Сүмийн Ерөнхийлөгч албан ёсоор томилогдож, албан тушаалдаа дэмжигдэн батлагдах хүртэл Арванхоёрын Төлөөлөгчийн Чуулга тэргүүлэх эрх мэдэлтэй болж, Арванхоёрын Ерөнхийлөгч Сүмийн гүйцэтгэх Ерөнхийлөгч болдог” хэмээн Ерөнхийлөгч Харольд Б.Лий хэлжээ (In Conference Report, 1970 оны 4-р сар, 123; *Improvement Era*, 1970 оны зургадугаар сар, 28).

Залгамжлалын талаарх нэмэлт мэдээллийг нэг дэх нэмэлт заах санаанаас үз.

2. Иосеф Смитийг алагдсаны дараа Бригам Янг Ерөнхийлөгчөөр дэмжигдэн батлагдах хүртэл Арванхоёр Сүмийг тэргүүлсэн нь

Иосеф Смитийг нас барахад Тэргүүн Зөвлөл тарж, Арванхоёрын Чуулга Сүм дэх тэргүүлэх эрх мэдэлтэй байгууллага болсныг тайлбарла. *Бидний Өв*, хуудас 77-79 дэх “Ерөнхийлөгчийн Зөвлөл дэх залгамжлал” хэсгийг нэгтгэн дүгнэхийг даалгавар авсан ангийн гишүүнээс хүс.



Ерөнхийлөгч Бригам Янг

- Сидней Ригдон Сүмийн удирдлагын талаар юуг ойлгохгүй байсан бэ? Сүмийг хэн удирдах тухай асуулганд Бригам Янг анх юу гэж хариулсан бэ? (*Бидний Өв*, хуудас 78-ыг үз. Тэрээр энэ асуудлаарх Их Эзэний хүслийг мэдэхийг хүсч байв) Бригам Янгийн үлгэр жишээнээс бид юу сурч болох вэ?
- Сүмийн удирдлагын талаар хэлэлцсэн хурлын үдээс хойшхи хуралдаан дээр, Арванхоёр Төлөөлөгчийг дагаагүй хүмүүс амжилт олохгүйг мөн гагцхүү Төлөөлөгчид л Бурханы хаант улсыг байгуулж чадна (*Бидний Өв*, хуудас 79) гэдгийг Бригам Янг бошигложээ. Энэ нь үнэн гэдгийг Сүмийн түүхэнд болон манай өнөө үед хэрхэн нотлон харуулсан бэ?

Хурлын эцэст Гэгээнтнүүд Арванхоёрын Чуулгыг Сүмийн удирдагчдаар санал нэгтгэйгээр дэмжин баталсныг (*Бидний Өв*, хуудас 79) тайлбарла. Бригам Янг Ерөнхийлөгч нь байсан Арванхоёрын Чуулга гурван жил хагасын туршид Сүмийг тэргүүлсэн юм. 1847 оны арванхоёрдугаар сарын 27-нд Тэргүүн Зөвлөл албан ёсоор өөрчлөн зохион байгуулагдаж Бригам Янг Ерөнхийлөгч нь болсон билээ.

3. Гэгээнтнүүд Наувуг орхин явахын өмнө ариун сүмийн ёслолыг хүлээн авсан нь

Наувугийн Ариун сүмийн зургийг үзүүл. Тэр үед Гэгээнтнүүд Наувуг орхин явахаар бэлтгэж, Ариун сүмийг дуусгахын төлөө шаргуу ажиллаж байсныг тайлбарла. Ариун сүм бэлэн болмогц ариун сүмийн ёслолуудаа хүлээн авахын тулд Гэгээнтнүүд үй олноороо цуглажээ. Тэд эдгээр ёслолуудыг хүлээн авах хичнээн их хүсэлтэй байсныг Ерөнхийлөгч Бригам Янгийн дараах тэмдэглэл харуулдаг:

“Өнөө өглөө дотогшоо орох гэсэн маш олон хүн хүлээн авах өрөөнд ирсэн байлаа... Зуун хорин нэгэн хүн ёслолыг хүлээн авав” (*History of the Church*, 7:565).

“[Ариун сүмийн] ёслолуудыг хүлээн авах гэсэн Гэгээнтнүүдийн санаа тавилт ийм байлаа. Мөн ёслолыг тэдэнд гүйцэтгэх гэсэн бидний санаа тавилт ч бас л ийм байв. Иймээс миний бие өдөрт дунджаар дөрвөн цагаас илүүгүй унтаж, долоо хоногт нэг л удаа гэртээ харьж, Ариун сүм дэх Их Эзэний ажилд өдөржин шөнөжин зүтгэж байлаа.

“Ахлагч Хебер К.Кимбалл, Арванхоёр Төлөөлөгчийн бусад нь байнга энд байдаг байв. Гэвч хэт шахуу ажиллаж байсан болохоор амарч, эрүүл мэнддээ анхаарал тавихын туд тэдний зарим нь Ариун сүмээс явахаас аргагүйд хүрдэг байлаа” (*History of the Church*, 7:567).

Гэгээнтнүүдийн эсрэг мөрдлөг хавчлага 1846 оны нэгдүгээр сард улам гаарав. Гэгээнтнүүд Наувуг орхин явах болсон учир Ариун сүмийн ёслол зогсоно гэдгийг Ерөнхийлөгч Янг 1846 оны хоёрдугаар сарын эхээр зарлажээ. Гэвч ёслол хүлээн аваагүй хүмүүс явахыг бодохгүй байв. Ерөнхийлөгч Янг дараах зүйлийг 1846 оны хоёрдугаар сарын 3-нд тэмдэглэжээ:

“Бид ёслол гүйцэтгэхээр ирэхгүй гэж миний бие зарласан ч, Их Эзэний Өргөө өдөржингөө хөл үймээнд дарагдсаар байлаа. Ёслол хүлээн авах хүсэл өгүүлшгүй их байснаас ах нар биднийг энд байлгаж, дайсан бидний замыг хааж, саатуулах хүртэл хишиг хүртээлтийг үргэлжлүүлэхийг хүсч байлаа. Гэвч энэ бол ухаалаг биш гэдгийг, бид улам олон ариун сүм барих болно, иймээс Гэгээнтнүүд Их Эзэний адислалуудыг хүлээн авахад бэлэн болмогц адислал хүлээн авах боломж хойшид бидэнд үргэлж байх болно гэдгийг миний бие ах нарт мэдээлэв. Энэ Ариун сүмд бид дахиад ёслол хүлээж авахгүй ч гэсэн, элбэг дэлбэгээр адислагдсан билээ. Би аяны мухлаг тэргүүдэд бэлтгэж, явахад бэлэн болж байгаагаа ах нарт мэдэгдэв. Цугласан хүмүүс тарж явах болов уу гэж бодоод би Ариун сүмээс нэлээд холдон явсан ч, өргөө пиг дүүрэн хүнтэй байхыг хараад буцлаа.

“Бид цугласан олныг харж, тэд үгийн төлөө өлсөж, цангаж байсныг, санаа тавилтыг нь мэдээд, Их Эзэний Өргөөн дэх ажлаа хичээнгүйлэн үргэлжлүүлж билээ. Хоёр зуун ерэн таван хүн ёслол хүлээн авав” (*History of the Church*, 7:579).

- Ариун сүмийн ёслол хүлээн авах Гэгээнтнүүдийн эгээрэл хүслээс бид юу сурч болох вэ? Гэгээнтнүүд Наувугаас шилжин явах аянаа эхлэхээс өмнө ариун сүмийн ёслол хүлээн авах нь яагаад чухал байсан гэж та нар боддог вэ? (Нэмэлт мэдлэг, хүч чадал нь тулгарч болох хүнд сорилтуудыг тэсэн гарахад тэдэнд туслах байсан нь хариулт байж болно) Ариун сүм ямар арга замаар та бидэнд хүч чадлын эх сурвалж, удирдамж болдог вэ?

Ариун сүмийн ажил тэр долоо хоногийн үлдсэн хугацаанд үргэлжилж, дараа нь Ариун сүм хаагдсаныг тайлбарла. Нийтдээ 6000 шахам Гэгээнтэн өрнөдийг зорьсон аянаа эхлэхээс өмнө ариун сүмийн хишгээ хүлээн авчээ.

4. Гэгээнтнүүд өрнө зүгт хийсэн аяндаа хүнд сорилтуудыг амсч, гайхамшгуудыг үзсэн нь

Наувугаас Шилжин Нүүсэн нь зургийг үзүүл. Гэгээнтнүүдийн зарим нь 1846 оны хоёрдугаар сарын 4-нд Наувуг орхин явж эхэлснийг тайлбарла. “Наувуг орхин явахаар бэлтгэсэн нь,” “Өвлийн аяны бэрхшээлүүд” хэсгүүдийг *Бидний Өв*, хуудас 81-83-аас нэгтгэн дүгнэхийг даалгавар авсан ангийн гишүүнээс хүс.

Гэгээнтнүүд Наувуг өвөл орхин явж эхэлсэн, бэлтгэлийг албадлагаар яаруу сандруу хийснээс тэдний аян маш хүнд байв. Наувугаас ойролцоогоор 11 километрт Миссиппи мөрний Айовагийн тал дээр Шугар Грийкэд хоёрдугаар сарын эхээр нэгэн онцгой явдал болжээ. Шугар Грийкэд буудалласан

анхны шөнө есөн хүүхэд төржээ. Цаг агаар маш хүйтэн бас толгой хоргодох олигтой оромж Гэгээнтнүүдэд байсангүй. Элиза Р.Снөү тэмдэглэлдээ:

“Эхчүүд дасч дадсанаасаа шал ондоо, төсөөлөхийн аргагүй хүнд нөхцөлд; зарим нь майханд бусад нь мухлаг тэрэгнүүдэд усан шамарга, цасан шуургаанаар хүүхдээ төрүүлэв. Газарт зоосон шургааганд бэхэлсэн хөнжлөөр ханыг нь босгосон, холтсон дээвэртэй, түүгээр нь борооны ус гоожсон нэг болхи тагзанд нэг хүүхэд төрсөн гэж би сонссон билээ. Нинжин сэтгэлт эгч нар гоожиж байгаа борооны усыг тосч авахаар түмпэн савнууд барин зогсож, төрсөн хүүхэд, эх хоёрыг усанд шалба норохоос хамгаалж байсан гэдэг...

“Ийм зэлүүд газар төрсөн хүүхдийн эхчүүд... ойгоор тэнүүчлэх, салхи шуургатай тэмцэлдэхэд дасаагүй байлаа... Тэдний олонхи нь Дорнод мужуудад төрж, өсөн хүмүүжсэн, Есүс болон түүний Төлөөлөгчдийн заадаг сайн мэдээг баяртайгаар хүлээн авсан байлаа. Тэгээд итгэл бишрэлийнхээ төлөө тэнд Гэгээнтнүүдтэй хамт цугларан, сорилтын нөхцөлд, “үзэсгэлэнт” хэмээх нэртэй Науву хотыг бий болгоход итгэл, тэвчээр, эрч хүч нь тусалсан ажээ. Тэнд тэд цэцгээр чимсэн, охь болсон жимсний модтой, тохилог сайхан гэр оронтой болж, элбэг дэлбэг ургац хурааж эхэлж байлаа.

“Ийм л гэр оронтойгоо . . . тэд эцсийн удаа салах ёс гүйцэтгэж, нэг хоёр, зарим тохиолдолд гурван мухлаг тэргэнд ойр зуурын юмаа чихэж аваад, зэлүүд буй нутгийг зорин хөдөлсөн юм даа ” (Эдвард В.Таллиж, *The Women of Mormonism* [1877], 307-308).

- Гэгээнтнүүдийн тухай энэ түүхийн юу нь та нарт гүнзгий сэтгэгдэл төрүүлэв?

1846 оны есдүгээр сар гэхэд Гэгээнтнүүдийн ихэнх нь Наувуг орхин, Айова даяар тархан суурьшиж, айсуй өвөлд бэлтгэж байлаа. Гэгээнтнүүдийн үлдсэнийг Наувугаас хөөж явуулахаар улайрсан танхайрагч бүлгүүд гэр орныг нь тонон дээрэмдэж, тэднийг мөрөн рүү шахан хөөжээ. Зарим хүмүүс мөрнийг гатлан зугтаасан боловч эд хогшил, илүү хувцас хунараа авч чадаагүй аж. Зугтааж амжаагүй хүмүүсийг танхайрагч бүлэг зодож, заримыг нь мөрөн рүү шидсэн гэдэг.

Гэр оронгүй тав, зургаан зуун эрэгтэй, эмэгтэйчүүд, хүүхдийн орогнох буудал мөрний эргийн дагуу гурван километр гаруй үргэлжилж байв. Ихэнх нь зөвхөн хөнжилтэй, бут ширэнгээр оромж хийж, хомс тарчигхан хоол хүнс тэй байлаа. Тэдний олонх нь холын аян даахааргүй өвчтэй байснаас зарим нь нас баржээ. Бишоп Ньюэл Витней бэл бэнчингийнхээ хэрээр нэлээд гурил худалдаж авсан ч хүмүүсийг хооллоход хүрэлцэхгүй байв. Тэгтэл Их Эзэн гайхалтай арга замаар тэднийг хүнсээр хангажээ:

Аравдугаар сарын 9-нд хүнс бүр дуусах шахаад байтал хэд хэдэн том сүрэг бөднө шувуу буудал руу нисэн ирж, газар дээр тэр ч байтугай бүр ширээн дээр буужээ. Өлссөн Гэгээнтнүүд шувуунаас олныг барьж аван, хоол хийж, иджээ. Итгэлтнүүдийн хувьд энэ нь эртний Израилд тохиолдсон хэрэг явдлын нэгэн адил өнөө үеийн Израилд харуулсан Бурханы нигүүлслийн тэмдэг байв. (Б.Х.Робертс, *A Comprehensive History of the Church*, 3:135-136-г үз)

- Үүнтэй адил ямар гайхамшгийг Их Эзэн эртний израилчуудад үйлдсэн бэ? (Египетээс Гарсан нь 16:12-15-ыг үз) Гачигдалтай үед чинь Их Эзэн та нарыг хэрхэн хангадаг вэ?

Дүгнэлт

Сүнсээр өдөөгдсөний дагуу хичээлийн үеэр ярилцсан үнэнүүдийн тухай гэрчил.

Нэмэлт заах санаанууд

Зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр дараах материал нэмэгдэж байна. Эдгээр санаануудаас та нэгийг буюу илүү олныг хичээлийнхээ хэсэг болгон ашиглаж болно.

1. Сүмийн Ерөнхийлөгчийн Зөвлөл дэх залгамжлалын талаарх нэмэлт мэдээлэл

Сүмийн Ерөнхийлөгчийн Зөвлөл дэх залгамжлалын үйл явц олон удаа тохиосон бөгөөд эдүгээ хуудас 217 дээр тодорхойлогдсон загварыг баримталдаг. Хэрэв энэхүү үйл явцыг нарийвчлан тайлбарлах нь ангийн гишүүдэд ашиг тустай байх болно гэж үзвэл дараах шат дараалсан алхмуудыг тэдэнтэй хамт нэгтгэн дүгнэ.

1. Нэгэн цагт Сүмийг тэргүүлэхээр урьдчилан томилогдсон хүн Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүнээр илчлэлтээр дуудагддаг.
2. Тэрээр Чуулгын болон Тэргүүн Зөвлөлийн гишүүдтэй харилцсанаар бас ажил үүргээрээ дамжуулан ирээдүйн дуудлагадаа сургагдан бэлтгэгддэг. Тэрээр Чуулгын бусад гишүүдээс насаар ахмад болсон үед Арванхоёрын Чуулгын Ерөнхийлөгч болж дэвших бөгөөд зөвхөн Сүмийн Ерөнхийлөгч л түүнээс илүү удаан хугацаагаар Төлөөлөгчөөр үйлчилсэн байна.
3. Сүмийн Ерөнхийлөгч нас барахад Тэргүүн Зөвлөл тарна. Тэргүүн Зөвлөлийн зөвлөхүүд Арванхоёрын Чуулга дахь байрандаа буцаж очно (хэрэв тэд уг чуулгын гишүүд байсан бол). Арванхоёрын Чуулга Сүмийн тэргүүлэх чуулга болно. Арванхоёрын Ерөнхийлөгч Сүмийн тэргүүлэх эрх мэдэлтэн болдог.
4. Арванхоёрын гишүүд мацаг барилт, залбирлын сүнсээр Ариун сүмд хуралдана. Тэд илчлэлтээр удирдагдан Тэргүүн Зөвлөлийг дахин зохион байгуулах талаар нэгдмэл шийдвэр гаргадаг. Энэ шийдвэрийн дагуу тэд Арванхоёрын хамгийн ахмад настай гишүүнийг Сүмийн Ерөнхийлөгчөөр дэмжин батална. Дараа нь тэд түүний тэргүүн дээр гараа тавьж, түүнийг Сүмийн Ерөнхийлөгчөөр томилж, онцгойлон адисалдаг.
5. Шинэ Ерөнхийлөгч хоёр хүнийг (ихэвчлэн Арванхоёрын Чуулгын гишүүдээс) зөвлөхөө болгон сонгож авна.
6. Арванхоёрын Чуулга дахь сул орон тоог Ерөнхийлөгчийн Зөвлөлийн өөрчлөн зохион байгуулалтаар нөхнө.

Залгамжлалын сэдвийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг “ ‘The Kingdom of God Will Roll On: Succession in the Presidency,’ ” Брент Л.Топ, Лоренс Р.Флейк, *Ensign*, 1996 оны наймдугаар сар, хуудас 22-35-аас үз.

2. Ариун сүмийн ажлыг дайсан эсэргүүцсэн нь

Науву дахь Гэгээнтнүүд Ариун сүмийг дуусгахаар ажиллаж байхдаа асар их эсэргүүцэлтэй тулгарсан юм. Гэгээнтнүүд Ариун сүмийг барих гэж оролцох

бүрдээ мөрдлөг хавчлагатай тулгарч байсан тухай өгүүлж, Арванхоёрын Чуулгын Ахлагч Бойд К.Пакер хэлсэн нь:

“Ариун сүмээс айж байсан учир дайсны эсэргүүцэл тэмцэл Гэгээнтнүүд рүү чиглэсэн юм. Ариун сүмийг барихад саад тотгор учруулахын тулд тэд юу ч хийхээс буцахгүй байв” (*Ариун Сүм* [1980], 175).

- Дайсан яагаад Ариун сүм болон ариун сүмийн ажлаас айж байсан бэ? Бид саад бэрхшээлийг эс хайхран Ариун сүмд орох шийдвэр төгс байдлаа бэхжүүлэхийн тулд юу хийж болох вэ?

3. “Ирцгээ, ирцгээ, Гэгээнтнүүд ээ”

“Ирцгээ, Ирцгээ, Гэгээнтнүүд ээ” (*Сүмийн Дуулал болон Хүүхдийн дуу*, х.2) дууллыг ангийн гишүүдээр дуулуулахаар бэлтгэ. Эсвэл уг дууллыг ангийн нэг гишүүн эсвэл хэсэг гишүүдээр дуулуулахыг хүс. Дууллын дараа үүнийг бичихэд Виллям Клейтонд сүнслэгээр нөлөөлсөн үйл явдлын тухай нэгтгэн дүгнэ (*Бидний Өв*, хуудас 83).

Зорилго

Солт Лейкийн Хөндий рүү хийсэн анхдагч нарын аян Тэнгэрлиг Эцэгтээ эргэж очих бидний аялалтай хэрхэн адилхан болохыг ойлгоход нь, түүнчлэн анхдагч нарын хийсэн олон золиослолд талархахад нь ангийн гишүүдэд туслах.

Бэлтгэл

1. Дараах судрууд болон бусад материалыг залбирч судал:
 - а. Сургаал ба Гэрээ 136.
 - б. *Бидний Өв*, хуудас 84-87.
2. *Ангийн гишүүний Судлах Удирдамж* (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.
3. *Бидний Өв* дэх дараах хэсгүүдийг нэгтгэн дүгнэхэд бэлтгэхийг ангийн гишүүдээс хүс:
 - а. “Винтер Квортерс” (хуудас 84-85).
 - б. “Бруклины Гэгээнтнүүд” (хуудас 87-88).
 - в. “Цугларалт үргэлжлэв ” (хуудас 88-90).
 - г. “Энэ бол зөв газар” (хуудас 90-91).
4. Хэрэв дараах зургууд байдаг бол хичээлийн үеэр ашиглахаар бэлтгэ: Хээр талыг туулж яваа Мэри Фиелдинг Смит, Жозеф Ф.Смит нар (62608; Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 412) Анхдагч нар далайн хөлөг онгоцоор Сан Франциско Буланд ирсэн нь (Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 421).

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

Амлагдсан нутаг гэж самбар дээр бич. Их Эзэн бүлэг хүмүүсийг амьдарч байсан газраас нь “Амлагдсан нутаг” руу судруудад олон удаа удирдсаныг тайлбарла. Судрууд ийм газрыг сонгомол нутаг, амар амгалангийн нутаг эсвэл өвийн нутаг хэмээн олонтаа нэрлэсэн байдаг (1 Нифай 2:20; С ба Г 45:66; 103:11).

- Амлагдсан нутаг руу аянд удирдагдсан аль нэг бүлгийг та нар судруудаас нэрлэж чадах уу? (Ангийн гишүүдийн хариултыг самбар дээр бич. Жаредчууд, Лихайн гэр бүл, Хуучин Гэрээн дэх Израилын хүүхдүүд, Бригам Янг болон анхдагч нар хариулт байж болно)

Бидний мөнх бус амьдрал бол Селестиеп хаант улсын “Амлагдсан нутаг руу” хийж байгаа аянтай адил болохыг тайлбарла. Энэ эрин үеийн суурийг тавьсан анхдагч нарын тухай өгүүлж, Арванхоёрын Чуулгын Ахлагч М.Рассел Баллард хэлсэн нь:

“Тэдний аян биднийхтэй адил юм. Тэдний хийсэн алхам бүр хайр, эрэлхэг зориг, шийдвэр төгс байдал, бие сэтгэл бүхнээ зориулсан хоёргүй сэтгэл, тэвчээр хатуужил, итгэл бишрэлийн сургамж нь *бидэнд* хамгаас чухал юм” (In Conference Report, 1997 оны 4-р сар, 81; *Ensign*, 1997 оны 5-р сар, 59).

Энэ хичээлээр түүхэн дэх хамгийн агуу аян–Солт Лейкийн Хөндий уруу хийсэн анхдагч нарын аяны тухай ярилцдаг. Хичээлийн үеэр анхдагч нарын аяныг мөнх амьдрал өөд хийдэг өөрсдийнх нь аянтай харьцуулахад ангийн гишүүдийг урь.

Ярилцах ба
хэрэгжүүлэх нь

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбиран сонгож ав. Судрын зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Аян хийх бие бялдрынх нь бэлтгэлийн талаар Их Эзэн Гэгээнтнүүдэд заавар өгсөн нь

Бидний Өв, хуудас 84-85-аас Винтер Квортерс дахь Гэгээнтнүүдийн тухай шастирыг нэгтгэн дүгнэхийг даалгавар авсан ангийн гишүүнээс хүс.

- Гэгээнтнүүд Винтер Квортерст өвчин эмгэг, бусад түмэн бэрхшээлээс их зовлон зүдгүүр амссан ч, шаргуу ажиллаж, аян замынхаа бэлтгэлийг хангасаар байлаа. Гэгээнтнүүд болон бусад хүмүүс шийдвэр төгс байдлаасаа няцаагүйн төлөө ямар замаар адислагдсан бэ? (Бэлтгэл нь тэдний аяныг илүү хөнгөвчилж, араасаа ирэх хүмүүст тусалсан нь хариулт байж болно.) Та нар бэрхшээлийн үед зориулж нөөц бий болгосноор хэрхэн адислагддаг вэ? Нөөц бий болгох нь бэрхшээлийн үед бидний араас замнах хүмүүст хэрхэн тусалж чадах вэ?

1847 оны нэгдүгээр сард Ерөнхийлөгч Бригам Янг Гэгээнтнүүдийн өрнөд рүү хийх аяны талаар нэг илчлэлтийг Винтер Квортерст хүлээн авсныг тайлбарла. Энэ илчлэлт С ба Г 136-д цэдэглэгдсэн байдаг.

- Аян замдаа бэлтгэх талаар нь Их Эзэн Гэгээнтнүүдэд ямар заавар өгсөн бэ? (Дараах шүлгүүдийг ангийн гишүүдтэй хамт уншиж, хэсэг бүр дэх зааврыг ол. Эдгээр зааврыг ярилцаж, амьдралдаа хэрэглэхэд нь ангийн гишүүдэд туслах зарим асуултыг сонгож ав.)
 - а. С ба Г 136:2. (“Их Эзэний бүх зарлиг болон дүрмүүдийг сахих гэрээ болон амлалтыг” хий) Яагаад энэ заавар Гэгээнтнүүдэд тийм их чухал байсан бэ? Бид энэ зааврыг өөрсдийнхөө аянд хэрхэн хэрэглэж болох вэ?
 - б. С ба Г 136:3. (Арванхоёрын Чуулгын удирдлага дор бүлгүүдийг ерөнхийлөгч, хоёр зөвлөх, зуут, тавьт, аравтын ахмадтайгаар зохион байгуул) Энэ зохион байгуулалт нь тойрог, гадас зохион байгуулагддаг хэлбэртэй хэрхэн адилхан байна вэ?
 - в. С ба Г 136:5. (“Бүлэг бүр чадлынхаа хэрээр . . . бүх зүйлээр өөрсдийгөө хангаг.”) Бид бие даах чадвартай байхын төлөө хичээн чармайх нь яагаад чухал вэ?

- г. С ба Г 136:6. (“Үлдэх [ард үлдэх] тэдний төлөө бэлтгэ.”) Гэгээнтнүүд ардаа үлдэх хүмүүст зориулж ямар бэлтгэл хийсэн бэ? (С ба Г 136:7-9-ийг үз.) Энэ заавар бидэнд хэрхэн холбогдох вэ?
- д. С ба Г 136:8. (“Ядуучууд, бэлэвсэн эмэгтэйчүүд, [бас] эцэггүй хүүхдүүдэд анхаарал халамж тавь.”) Өнөөдөр бид эдгээр үүрэг хариуцлагаа хэрхэн биелүүлж болох вэ?
- е. С ба Г 136:10. (“Энэ хүмүүсийг . . . Сионы гадсанд байршуулахын тулд хүн болгон бүх нөлөө болон өмч хөрөнгөө ашиглаг”) Энэ заавар бидэнд хэрхэн хамаатай вэ?

2. Их Эзэн Гэгээнтнүүдэд биеэ авч явах талаар заавар өгсөн нь

С ба Г 136:17-33-ыг зааж, ярилц. Материаллаг бэлтгэлээс гадна сүнсний асуудлаар мөн тэд бие биедээ хэрхэн хандах талаар Их Эзэн Гэгээнтнүүдэд заавар өгч байсныг тайлбарла.

- Их Эзэн Гэгээнтнүүдэд биеэ авч явах талаар ямар заавар өгсөн бэ? (Дараах шүлгүүдийг ангийн гишүүдтэй хамт уншиж, хэсэг бүр дэх зааврыг ол. Эдгээр зааврыг ярилцаж, амьдралдаа хэрэглэхэд нь ангийн гишүүдэд туслах зарим асуултыг сонгож ав.)
 - а. С ба Г 136:19. (“Ямар ч хүн өөрөө өөрийгөө төлөвшүүлэхийг эрэлхийлж, мөн миний зөвлөгөөг үл эрэлхийлэх аваас, түүнд хүч байх нь үгүй.”) Гэгээнтнүүдийн даруу байдал аянд нь яагаад чухал байсан бэ? Зарим үед хүмүүс яагаад өөрөө өөрсдийгөө төлөвшүүлэх гэж хүсдэг вэ? Бид өөрсдийгөө биш, харин Их Эзэний алдар сууг хэрхэн бүрэн дүүрнээр эрэлхийлж болох вэ?
 - б. С ба Г 136:21. (“Их Эзэний нэрийг дэмий хоосноор хэрэглэх нүгэл хилэнцээс өөрсдийгөө хол байлга.” Мөн Египетээс Гарсан нь 20:7-г үз.) Бид Их Эзэний нэрийг хүндэтгэлтэйгээр хэрэглэх нь яагаад чухал вэ?
 - в. С ба Г 136:23-24. (“Бие биентэйгээ сөргөлдөхөө эцэслэ; бие биенийхээ тухай хилэнцэгийг ярихаа эцэслэ... Үгс чинь бие биенээ сэнхрүүлэхэд чиглэг”) Зөрчил сөргөлдөөн болон хилэнцэт зүйлийг ярих нь бидэнд ямар саад тотгор учруулдаг вэ? Бие биетэйгээ зөрчилдөхийг хэрхэн даван туулж болох вэ? Бид бие биенээ гэгээрүүлэхийн тулд юу хийж чадах вэ?
 - г. С ба Г 136:25-26. (Зээлсэн буюу хаясан зүйлийг эргүүлж өгдөг бай)
 - д. С ба Г 136:27. (“Өөртөө байгаа юмыг хамгаалахад хичээнгүй бай”) “Мэргэн даамал” байх гэдэг нь юу гэсэн утгатай гэж та нар боддог вэ? Материаллаг эд юмсыг хариуцах чадвар бидний сэтгэл санааны өөдрөг байдалд хэрхэн нөлөөлж болох вэ?

Их Эзэн С ба Г 136:28-д зөв зохистой амрах талаар заавар өгсөн байдаг. Ахлагч Давид О.МкКей энэ сэдвээр сургаж хэлсэн нь:

“Нэг өдөр аян хийсний дараа хээр талд мухлаг тэрэгнүүдээ тойрог болгон зогсоож, хийл хөгжимтэй нэг хүн түүдэг галын дэргэд байраа эзлэн, хүч чадалтай чийрэг Анхдагч нар залбирлаар эхэлсэн бүжигт гар гараасаа барилцан нэгдэж, сайн мэдээний сүнсээр хөхүүлэн дэмжигдсэн инээд баясал хээр талд өрнөв . . . Ерөнхийлөгч Бригам Янг . . . нэг удаа үг хэлэхдээ: ‘Хэрэв аль нэг ахлагч өвчтэй хүнийг адислахаар бүжиглэгчдийн дундаас дуудагдсан бол тэрээр ахлагчдын чуулгын цуглаанаас явж байгаа ном шиг тийм л сүнсстэйгээр

явдаг байсан нь бүжгийн уур амьсгал байлаа' ” гэжээ (In Conference Report, 1920 оны 4-р сар, 117).

- Бид энэ зөвлөгөөг хэрхэн хэрэглэж болох вэ?
- Мэргэн ухаанд суралцахын тулд юу хийхийг Их Эзэн Гэгээнтнүүдэд зааварласан бэ? (С ба Г 136:32-33-ыг үз.) Эдгээр заавар үнэн болохыг та нар амьдралдаа ямар арга замаар мэдсэн бэ?

3. Ерөнхийлөгч Бригам Янгийн удирдлагаар Гэгээнтнүүд Солт Лейкийн Хөндий рүү аялсан нь

Энэ гарын авлагын хуудас 316, *Ангийн гишүүний Судлах Удирдамжийн* хуудас 31 дээрх газрын зураг 3-ыг үз. Бошиглогч Иосеф Смит нас барахаасаа хоёр жилийн өмнө “Гэгээнтнүүд их гай зовлон амсаж, Хадат Уулсын зүг хөөгдөнө,” бас тэдний зарим нь “Суурин газрууд бий болгож, хот байгуулахад туслахаар явахын тулд амьдарч, Гэгээнтнүүд Хадат Уулсын дунд хүчирхэг хүмүүс болсныг харна” хэмээн бошиггосныг тайлбарла (*Teachings of the Prophet Joseph Smith*, эмхтгэсэн Жозеф Фиелдинг Смит [1976], 255). Энэ бошиглолын биелэлт болж, 1847-1869 оны хооронд дэлхий дахинаас Сүмийн 70.000 орчим гишүүн Юта руу аян хийжээ.

Сан Францискод ирж байгаа Мэри Фиелдинг Смит, Жозеф Ф.Смит болон бусад Гэгээнтнүүдийн зургийг үзүүл. Юта руу аян хийсэн үеийн итгэл бишрэл, эрэлхэг зоригийн тухай олон түүх байдгийг тайлбарла.



Өрнөд рүү шилжин нүүсэн нь. 1846 оны хоёрдугаар сарын 4-нд өрнөд рүү хийсэн түүхт аяныг эхэлсэн анхны мухлаг тэргүүд Миссиппи мөрнийг гаталжээ.

Бидний Өвийн дараах хэсгүүд: “Бруклины Гэгээнтнүүд” (хуудас 87-88), “Цугларалт үргэлжлэв” (хуудас 88-90), “Энэ бол зөв газар” (хуудас 90-91)-ыг нэгтгэн дүгнэж ирэхийг даалгавар авсан ангийн гишүүдээс хүс. Цаг гарвал сүнслэгээр нөлөөлөгдсөн анхдагч нарын бусад түүхийг та ярьж болно (жишээ болгож, нэг дэх нэмэлт заах санааг үз). Та тэдний хувьд сүнслэгээр нөлөөлсөн анхдагч нарын тухай түүхийг ярихад ангийн гишүүдийг урьж болно. Анхдагч нарын эдгээр түүхийг Сүмийн түүхийн бусад тогтмол хэвлэлээс мөн Сүм байгуулагдсан бусад орны Сүмийн түүхээс үзэж болно.

- Анхдагч нар болон бусад Гэгээнтнүүдээс бидэнд үлдээсэн итгэл, золиослолын өвийг авч үзэх үед та нарт ямар бодол төрдөг вэ? Танай бүс дэх Сүмийн анхдагч нар хэн бэ? Бидний араас дагах хүмүүст иймэрхүү маягийн өвийг бид хэрхэн дамжуулж болох вэ?
- Бурханы оршихуй руу буцах аянд туслах ямар сургамжийг бид анхдагч нарын аянаас авч болох вэ? (Хариулах боломжийг ангийн гишүүдэд олгосны дараа, Ахлагч М.Рассел Баллардын дараах үгсийг унш)

“Амьдрал хэзээ ч амар хялбар байдаггүй. Айоваг гатлах үед анхдагч нар өвдгөө хүртэл шаварт шигдэж, мөрөөдлийнхөө заримыг замдаа булшлахаас аргагүйд хүрч байсан шиг тийм мэдрэмж өөрсдийнхөө аяныг хийж байгаа бидэнд зарим нугачаан дээр төрдөг шүү дээ. Хадат хяр, нүүр нүдгүй балбах шуурга, айсуй өвлийн тэсгим хүйтнийг бид бүгд нүүр тулан утгдаг. Зарим үед тоос шороо нүд хорсгож, харанхуйлан хуйлрах нь эцэс төгсгөлгүй юм шиг санагдах нь бий. Цөхрөл гутрал гэгч сүрхий тээг бидний хөлийг тушчих шиг болж, ургаа хад мэт урагшаа хөдлөхгүй болно. . . Амьдралд заримдаа бид анхдагч нарын адил нэг оргилд гараад иртэл, дөнгөж саяхан арайхийн авирч гарч ирсэн нөгөөх оргилоос бүр өндөр, бүр хэцүү уулын олон оргил цаана нь харагддаг. Бид өвөг дээдсийнхээ нэгэн адил итгэл бишрэл, тэвчээрийн үл харагдах эх сурвалжийг ашиглан, ‘Бүх зүйл сайн! Бүх зүйл сайн!’ хэмээн дуулж, итгэлээр жигүүрлэн саад бэрхшээл бүхнийг даван туулсан анхдагч нарын дуу хоолойтой бидний дуу хоолой нэгдэн нийлэх тэр үе рүү ямх ямхаар урагшлан дөхөж чадна” (In Conference Report, 1997 оны 4-р сар, 82; *Ensign*, 1997 оны 5-р сар, 61).

Дүгнэлт

Мөнх амьдрал руу хийдэг бидний аян Америкийг хөндлөн туулсан анхдагч нарын аянтай олон талаараа адил төстэйг онцлон тэмдэглэ. Анхдагч нар олон хатуу ширүүн зовлон зүдгүүрийг туулж, хувиараа агуу золиослол хийж хээр талыг туулсан юм. Тэд агуу итгэл бишрэл, эрэлхэг зориг, тэвчээр хатуужлыг харуулснаараа бидний даган дуурайх үлгэр жишээг бий болгосон билээ.

Өнөө үе бол дэлхий дээрх Бурханы хаант улсын түүхэн дэх бидний үе гэдгийг тайлбарла. Анхдагч нар суурийг нь тавьсан боловч, уг ажлыг дуусгах нь бидний үүрэг юм. “Ирээдүйн алхам бүр дэх итгэл нь энэ Сүмийн алдар суут хувь тавилангийн талаарх бошиглолын үзэгдлийг гүйцэлдүүлэх болно” хэмээн Ерөнхийлөгч Жеймс И.Фауст гэрчилжээ (In Conference Report, 1997 оны аравдугаар сар, 58; *Ensign*, 1997 оны арваннэгдүгээр сар, 42).

Ахлагч М.Рассел Баллард хэлсэн нь: “Бид бол үлэмж агуу өвийг залгамжлагчид мөн. Үргэлжилж байгаа үйл явцын сэргээлтийн хэсэг байх нь бидний

онцгой боломж, үүрэг хариуцлага юм. Тэрчлэн өнөө үед бичигдвэл зохих итгэлийн агуу, баатарлаг түүхүүд байгаа. Энэ нь бидэнд тулгарах саад бэрхшээлүүдийг даван туулахад бидний хүч чадал, мэргэн ухаан, эрч хүчний хэсэг бүрийг шаардах болно. Гэвч энэ ч хангалттай биш байх болно. Бид анхдагч өвөг дээдсийнхээ нэгэн адил, гагцхүү итгэлд *бодит* итгэлд, бүрэн дүүрэн соригдож, туршигдсан итгэлд амьдралынхаа туршид аюул ослоор дүүрэн замыг туулахдаа аюулгүй байдал, итгэл найдварыг олох болно гэдгийг бид мэдэх болно” (In Conference Report, 1997 оны 4-р сар, 83; *Ensign*, 1997 оны 5-р сар, 61).

Аян замдаа бэлтгэхэд нь анхдагч нарт С ба Г 136-д өгсөн зөвлөгөөн дэх арга замуудаас олон нь өнөөдөр бидний амьдралд холбогдохыг гэрчил. Тэдний итгэлийн өвийг үргэлжлүүлэх замаар анхдагч нарт талархлаа илэрхийлэхэд нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Нэмэлт заах санаанууд

Та зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болгож дараах санаануудаас нэгийг буюу хоёуланг нь ашиглаж болно.

1. Анхдагч нарын хийсэн золиослол

Гэгээнтнүүдээс олон нь Хадат Уулст агуу хүмүүс болох хүртэл амьдрах болно гэдэг бошиглолоос гадна, Иосеф Смит тэдэнд тохиолдох зовлон зүдгүүрийг угтан хэлсэн юм. Зарим хүмүүс “Биднийг мөрдөн хавчигсдаар үхэлд хүргэгдэх буюу гай зовлон, үхэл хагацлаар амьдралаа алдах болно” гэдгийг тэрээр хэлсэн юм (*Teachings of the Prophet Joseph Smith*, 255).

Арванхоёрын Чуулгад үйлчилж байхдаа Ахлагч Томас С. Монсоны ярьсан дараах шастирыг хуваалц:

“Мухлаг тэргүүд, багаар дутагдсан Мормоны зарим анхдагч нар хэдэн зуугаараа өвчин, гай зовлон, өлсгөлөнг биеэрээ амсан туулж, уулсыг даван, гар тэргээ нэг түрж, нэг чирж гулдарсаар 1300 бээр газрыг хээр талаар явганаар туулсан юм. Эдгээр бүлгүүдээс зургаан хүн бүрийн нэг нь амь эрсэдсэн билээ.

“Олон хүмүүсийн хувьд аян нь Көртландын Науву, Фар Вест, Нью-Йоркоос эхлээгүй юм. Харин алс холын Англи, Шотланд, Скандинав, Германаас эхэлсэн юм. . . Гэр орны аюулгүй байдал болон Сионы амлалтын хооронд сүрлэг Атлантын далайн хязгааргүй их ус хөндөлдөн байсан шүү дээ. Тэрхүү аюул ослоор дүүрэн их далайг гатлах үед төрсөн айдсыг хэн эргэн санаж чадах юм бэ? Тэд Сүнсний нам гүмхэн шивнэлтээр өдөөгдөн, энгийн атлаа зүрх сэтгэлд нь оршсоор байсан итгэл бишрэл нь хөшүүрэг олон дэмжин, Бурхандаа итгэж, аян замдаа далайгаар хөвсөөр байсан юм. . .

“Пиг дүүрэн хүнтэй чахарсан хөлөг онгоцон дээр миний өнгөрсөн үеийн элэнц хуланц өвөг дээдэс, эцэг эхчүүд, гэр бүлийнхэнтэйгээ хэд гуравхан юмтайгаа байсан юм. Далайн давалгаа мөн ч ширүүн байлаа, зүдэргээт аян ч урт байлаа, цаг хугацаа ч өнгөрөхгүй байлаа. Бяцхан Мэри [тэдний охин] ч эмзэгхэн байлаа. Гэвч эдүгээ өдөр хоног өнгөрөх тусам үхтэл үр харам гэгчээр бяцхан үр минь улам сульдан доройтож байгаад эх нь санаа зовон түгшиж явлаа. Охинд хүнд өвчин тусчээ. . . Санаа нь зовсон эцэг эх нь өдөр бүр газрын бараа харагдах нь уу гэж ширтэн хүлээсээр байсан авч, газар харагдахгүй л байлаа. Одоо ч Мэри тэсэхээ өнгөрлөө дөө. . . Амьсгалаа

хураах нь хэзээ хэзээгүй болжээ. Ингээд өөдсийн чинээхэн Мэри мөнх бус оршихуйгаас халин амар амгаланг олсон юм.

“Гэр бүл, найз нөхөд нь хөлгийн задгай тавцан дээр цуглахад, хөлгийн ахмад үйлчлэлийг удирдаж, тэрхүү хайр хүрэм, өөдсийн чинээхэн бяцхан цогцсыг урагддаггүй бөх ёрог даавуунд энхрийлэн ороож, уурсах мэт давалгаалах их далайн усанд тавьж билээ. Сэтгэлийн тэнхээт эцэг нь уймарсан сэтгэлээ барьж, уй гашуу болсон эхийг тайтгаруулан, ‘Их Эзэн өгсөн юм, Их Эзэн өгснөө аваад явчихлаа. Их Эзэний нэр адислагдаг. Бид Мэритэйгээ дахин учрах болно!’ хэмээн дахин дахин хэлж байлаа” (In Conference Report, 1967 оны 4-р сар, 55-56; *Improvement Era*, 1967 оны зургадугаар сар, 55).

2. “Алхам тутам дахь итгэл” видео танилцуулга

Teachings from the Doctrine and Covenants and Church History (53933) видео хуурцаг байвал, “Алхам тутам дахь итгэл,” 16 минутын хэсгийг үзүүлэхэд анхаар.

Зорилго

Есүс Христийн сайн мэдээ бол авралын захиас юм гэдгийг харуулж, гачигдалтай хүмүүсийг аврахад туслахад ангийн гишүүдийг урамшуулан дэмжихийн тулд Мартины болон Виллигийн гар тэрэгтэй бүлгүүдийг аварсан тухай заах.

Бэлтгэл

1. Дараах судрууд болон бусад материалыг залбирч судал:
 - а. Сургаал ба Гэрээ 4:3-7; 18:10-16; 52:40; 81:5-6; 138:58.
 - б. 3 Нифай 18:31-32; Моронай 7:45-48 (нэмэлт судрууд).
 - в. Энэ хичээл дэх судрын эшлэлүүд.
 - г. *Бидний Өв*, хуудас 91-94.
 2. *Ангийн гишүүний Судлах Удирдамж* (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.
 3. Хэрэв дараах зургууд байвал хичээлийн үеэр үзүүлэхээр бэлтгэ: Мартины гар тэрэгтэй бүлэг, Виттер Грийк, Вайоминг, 1856 (62554; Сайн мэдээний уран зургийн Цуглуулга 414), Гурван залуу эр Мартины гар тэрэгтэй бүлгийг аварсан нь (Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 415).
 4. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах бол дараах зургуудыг дээр дурдсан зургуудтай хамт ашиглахаар нэмж бэлтгэ: Наувугаас дүрвэсэн нь (62493; Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 411); Гар тэрэгтэй бүлэг (62528); Хээр талыг туулж буй Мэри Фиелдинг Смит, Жозеф Ф.Смит хоёр (62608).
-

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа

Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

“Бэлтгэл” хэсгийн 3, 4-р зүйлд дурдсан зургуудыг үзүүл.

- Эхэн үеийн Хожмын Үеийн Гэгээнтний анхдагч нарын туршлагын тухай түүх давтагдах нь яагаад чухал вэ?

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлсэн нь: “Зовлон зүдгүүр туулсан Гэгээнтнүүдийн түүх, гай зовлон, үхэл хагацлынх нь тухай түүх давтагдсаар байх болно. . . . Аврах хэрэгцээ шаардлагынх нь тухай түүх давтагдсаар байх болно. Есүс Христийн сайн мэдээний үнэн бодит мөн чанарын тухай тэдгээр түүх өгүүлдэг” (In Conference Report, 1996 оны аравдугаар сар, 118; *Ensign*, 1996 оны арваннэгдүгээр сар, 86).

Ерөнхийлөгч Хинкли анхдагч нарын тухай өгүүлж, хэлэхдээ: “Бид тэдэнд баярлан талархахаа хэзээ ч орхихгүй. Та бүгд тэдэнд баярлан талархахаа

хэзээ ч орхихгүй гэдэгт би найдна. Бид тэднийг үргэлж дурсан санана гэдэгт би найдна. . . Тийм их гай зовлон амссан тэдний түүх шастирыг дахин дахин уншицгаая, хүүхдүүддээ эсвэл ач зээ нартаа уншиж өгдөг байцгаая” гэжээ (*Church News*, 1999 оны долдугаар сарын 31, 5).

Энэ хичээлээр Мартин, Вилли нарын гар тэрэгтэй бүлэгт учирсан гай зовлон, үхэл хагацал, тэднийг аварсан тухай шастирыг ярилцана гэдгийг тайлбарла.

Ярилцах ба
хэрэгжүүлэх нь

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбиран сонгож ав. Заасан зарчмуудтайгаа холбоотой туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Ерөнхийлөгч Бригам Янг Мартин, Вилли нарын гар тэрэгтэй бүлгийг аврах ажлыг удирдсан нь

Мартин гар тэрэгтэй бүлгийн зургийг үзүүл. *Бидний Өв*, хуудас 91 дэх “Гар тэрэгтэй анхдагчууд”-ын эхний догол мөрийг нэгтгэн дүгнэ. Тэгээд Ерөнхийлөгч Гордон Б.Хинклийн өгүүлсэн дараах шастирыг хуваалц:

“Би та нарыг 1856 оны аравдугаар сарын ерөнхий чуулган дээр аваачъя. Тэр чуулганы бямба гарагт Франклин Д.Ричардс бас цөөн нөхөд нь Солт Лейкийн Хөндийд хүрч ирэв. Тэд Винтер Квортерсоос хүч тамиртай морьд, шар хөллөсөн хөнгөн мухлаг тэргүүдээр гарч, зам зууртаа сааталгүй иржээ. Ричард ах ирсэн даруйдаа Ерөнхийлөгч Янгийг олж уулзав. Замын дагуу олон зуун эрэгтэй, эмэгтэй хүүхэд цувран тарсныг тэрээр илтгэсэн аж. . . Морьд, луус нь эцэж туйлдсан байлаа. Өвөл эрт болжээ. Өндөрлөг газруудад салхи шуурч, хунгар тогтсон байв. . . Манай хүмүүс өлсөж, гар тэрэг, мухлаг тэрэг нь эвдэрсэн байв. Тэрэгний шарууд нь үхэж байлаа. Хүмүүс ч өөрсдөө амь нас нь эрсдэхэд тулаад байна. Тэднийг аврахгүй бол бүгдээрээ амь үрэгдэж болох байв.

“Ерөнхийлөгч Янг тэр шөнө унтаагүй гэж би боддог. Тэдгээр ядарч зүдэрсэн, даарч бээрсэн, амь нас нь хутганы ирэн дээр байсан хүмүүс санаа сэтгэлийг нь эзэмдэж, нүдэнд нь харагдсаар байсан гэж би боддог. Маргааш өглөө нь тэр энэ талбай дээр байсан хуучин Табернеклд хүрч ирэв. Тэрээр хүмүүст хандаж хэлсэн нь:

“ ‘Би эдгээр хүмүүст сэдвийг, ахлагч нарт хэлэх үгсийг хэлж өгье. . . Юу гэвэл. . . ах эгч нараас маань олон нь гар тэргээ түрж чирсээр тэртээ хол хээр талд ирж явна. Тэднээс олон нь эндээс долоон зуун бээр хол явна. Иймээс тэднийг энд авчрах ёстой. Бид тэдэнд тусламж илгээх ёстой. Хамгийн гол нь, ”тэднийг энд авчрах“ хэрэгтэй байна . . .

“ Ингэхийг шүтлэг бишрэл минь надад шавдуулж байна. Ингэхийг надад байдаг Ариун Сүнс шахан сануулж байна. Энэ бол хүмүүсийг аврах явдал мөн. . .

“ ‘Би өнөөдөр бишопуудад уриалах болно. Тэргэнд хөллөх 60 сайн луус, 12 эсвэл 15 мухлаг тэрэг гаргах гэж маргааш, нөгөөдрийг хүртэл хүлээх арга надад алга. Тэрэг хөллөх үхэр явуулахыг би хүсэхгүй байна. Хүлэг морьд, чадал тэнхээтэй лууснууд явуулахыг би хүсч байна. Хүлэг морьд, лууснууд энэ нутагт бий. Иймээс бид морьд, луус явуулах ёстой. 11 тонн гурил, одоо мухлаг тэрэг жолоодож байгаа хүмүүсээс гадна мухлаг тэрэгний 40 сайн жолооч хэрэгтэй байна. . .

“Эдүгээ миний сургамжилж байгаа эдгээр зарчмуудыг та бүгд хэрэгжүүлэхгүй бол итгэл бишрэл, шүтлэг тань Бурханы селестиеп хаант улсад нэг ч бодгалийг хэзээ ч аварч чадахгүй. *Явж, хээр талд байгаа хүмүүсийг энд авчир'* (ЛиРой Р.Хафен, Анн В.Хафен, *Handcarts to Zion* [1960], 120-121).

“Тэр үдээс хойш эмэгтэйчүүд их хэмжээний хүнс, ор дэрний хэрэглэл, хувцас хунар цуглуулав. Маргааш өглөө нь морьдыг тахлан, мухлаг тэргүүдийг засварлаж, ачаа ачлаа. Маргааш өглөө нь. . . 16 луусыг тэргэнд хөллөж, дорно зүгийг зорин хөдлөв. Аравдугаар сарын сүүлч гэхэд тусламж үзүүлэхээр тэрэг хөллөсөн 250 морь, луус замд гарсан байв” (In Conference Report, 1996 оны аравдугаар сар, 117-118; *Ensign*, 1996 оны арваннэгдүгээр сар, 85-86).

Мартин, Вилли нарын гар тэрэгтэй бүлгүүд Солт Лейкийн Хөндийд хүрэхийн тулд чадах бүхнээ хийсэн боловч цааш явж чадахгүй болсныг хэл. Тэднийг аврах хэрэгтэй байлаа. Аврах бүлгүүд зохион байгуулагдаагүй бол тэд бүгдээрээ амь үрэгдэж болох байв.

- Өөрийг чинь аварсан ямар туршлага чамд тохиолдсон бэ? Тусламж хэрэгтэй болсон үед чамд юу бодогддог вэ? Хэн нэгэн нь туслахаар ирсэн үед чамд ямар санагдсан бэ?
- Аврах бүлгүүд тэдэн дээр хүрч ирэхэд гар тэрэгтэй Гэгээнтнүүдэд ямар санагдсан байж болох вэ?

Тэднийг аварсан тухай дараах шастирыг Ерөнхийлөгч Хинкли хуваалцжээ:

“Аврах бүлэг гар тэрэгтэй бүлгүүд дээр хүрч ирэхэд тэд өлсөж, шургаж унатлаа ядарч, нимгэн, уранхай цоорхой хувцастай, нүд халтирмаар, аймшигтай байв. Аврагчид замын дагуух цасыг хага яран, тэнгэрийн хаяанд баруунтаа гарч ирэхэд тэд нигүүлслийн тэнгэр элчүүд лүгээ адил санагдсан гэдэг. Үнэхээр ч тийм байсан юм. Зовж зүдэрсэн шилжин нүүгчдийн зарим нь баяр хөөр болон хашгиралдаж байхад, хашгирч чадахааргүй туйлдаж ядарсан бусад нь тувт уйлсаар, дахин дахин уйлсаар байжээ.

“Одоо тэд идэх хоолтой, өмсөх дулаан хувцастай болжээ. Гэвч зовлон бэрхшээл дууссангүй, ер нь ч мөнх бус байдалд зовлон бэрхшээл дуусдаггүй шүү дээ. Хүмүүсийн хөл гар хөлдөж, хөлдсөн газрын арьс нь илжирч, яснаасаа хуурсан байлаа.

“Гар тэрэгнүүдийг хаяж, хүмүүс аврагчдын мухлаг тэрэгнүүдэд шахцалдан суужээ. Тэдний байсан газар, Солт Лейкийн хөндийн хоорондох 483 км, 644 км, тэр ч байтугай 805 км хол газрыг туулсан энэхүү хүнд бэрх аян шуурганы улмаас бүр ч удаан, ихэд зүдэргээтэй болсон юм. Зовж зүдэрсэн хүмүүсийг суулгасан 104 мухлаг тэрэг арваннэгдүгээр сарын 30-нд Солт Лейкийн Хөндийд хүрч ирэв. Тэдний ирж байгаа сураг өмнө нь дуулдсан байлаа. Ням гараг байсан болохоор Гэгээнтнүүд Табернеклд дахин цуглажээ. Бригам Янг цугларагсдын өмнө зогсож хэлсэн нь:

“Энэ цуглаан тармагц гэртээ харихыг би ах эгч нараас хүсч байна. . .

“Үдээс хойших хуралдаан болохгүй. Учир нь гэвэл дөнгөж саяхан ирсэн хүмүүст хоол унд хийж өгөх, тэднийг усанд оруулж, асарч тойлоход бэлтгэхийг би эгч нараас хүсч байна. . .

“Зарим хүмүүсийн хөл шагайгаа хүртэл, заримынх нь хөл өвдгөө хүртэл хөлдсөнийг бас заримынх нь гар хөлдсөнийг та нар харах болно . . .

Тэднийг үр хүүхдийнхээ адил хүлээн авахыг, тэдэнд эцэг эхийн энэрэл хайраар хандахыг бид хүсч байна' (Хафен, *Handcarts to Zion*, х. 139-өөс иш татжээ)" (In Conference Report, 1991 оны аравдугаар сар, 76-77; *Ensign*, 1991 оны арваннэгдүгээр сар, 54).

- Гар тэрэгтэй анхдагч нарыг аврах хүч чармайлтын юу нь та нарт гүнзгий сэтгэгдэл төрүүлэв?

2. Аврагч цагаатгагч золиослоороо дамжуулан биднийг аварна

Есүс Христийн сайн мэдээ бол авралын захиас юм гэдгийг хэл. Гар тэрэгтэй бүлгүүдийг аварсан тухай түүхийг хуваалцсаны дараа Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли нэг чуулган дээр хэлсэн үгэндээ Аврагчийн аврах үүрэг зорилгын тухай ийн гэрчилсэн байдаг:

“Дэлхийн Аврагчийн үйлдсэн золиослогч гэтэлгэлийн улмаас мөнхийн сайн мэдээний агуу төлөвлөгөө бидэнд хүртээмжтэй болсон юм. Энэ төлөвлөгөөний дагуу Их Эзэн дотор нас барсан хүмүүс үхлийг амсахгүй, харин Селестиеп болон мөнхийн алдар сууг хүртэх боломжтой байх болно.

“Бидэнд тусламж хэрэгтэй болсон үед Тэрээр биднийг зүхлээс авран, мөнх амьдралд авчирч, бидний аврагч болно.

“Тэрээр цөхрөл гутралын үед, ганцаардал, айдас хүйдсийн үед тусламж, тайтгарал, баталгаа, итгэлийг авчран тэнгэрийн хаяанд гарч ирдэг билээ. Тэр бол бидний Хаан, Аврагч, Чөлөөлөгч, Их Эзэн, Бурхан” гэжээ (In Conference Report, 1991 оны аравдугаар сар, 78; *Ensign*, 1991 оны арваннэгдүгээр сар, 54).

- Аврагч ямар арга замаар биднийг авардаг вэ? Яагаад Аврагч биднийг аварч чаддаг вэ? (Алма 7:11-13; С ба Г 18:11-12-ыг үз.) Бид Түүний авралын саналыг бүрэн дүүрэн хүлээж авахын тулд юу хийх ёстой вэ?

3. Бид Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн хувьд гачигдалтай хүмүүсийг аврах ёстой

Гар тэрэгтэй анхдагч нарыг аварч байгаа гурван залуу эрийн зургийг үзүүл. Ерөнхийлөгч Томас С.Монсоны хуваалцсан дараах түүхийг унш:

“Ахмад Эдвард Мартин болон түүний удирдсан гар тэрэгтэй бүлэгтэй бид түр зуур нэгдэж үзэцгээе. Тэдэнд тохиолдсон өгүүлшгүй бэрх өлсгөлөн, ядарч туйлдсан биеийг нь нэвт жиндүүлж байсан тэсгим хүйтнийг бид биеэр мэдрэх боломжгүй ч, туулсан түмэн зовлонг нь, харуулсан эрэлхэг зоригийг нь, биеллээ олсон итгэлийг нь дээдлэн үнэлэх үнэлэмжтэйгээр бид энэ айлчлалаас гарч ирнэ. ‘Би дүүгийнхээ харгалзагч юм уу?’ гэсэн асуултын эмгэнэлт хариут бид айдас дүүрсэн нүдээр гэрчилнэ.

“Гар тэрэгнүүд арваннэгдүгээр сарын 3-нд дүүрэн цөн түрсэн [Свийтвотер] гол дээр хүрч ирж, голыг гатлах нь хүний хүч чадал даахаас илүү их зориг, сэтгэлийн хат шаардаж байлаа. Эмэгтэйчүүд зүрх шимшрэн халширч, эрчүүдийн зүрхэнд шар ус хурж байлаа. Зарим нь зориг шулуудавч, бусад нь дааж давшгүй хүнд сорилтын өмнө хүчин мөхөсдсөнөө ухаарч байв.

“Туслах бүлгийн арван найман настай гурван залуу аврахаар ирэв. Харсан бүхний гайхлыг төрүүлсэн нь гэвэл, тэр гурав түмэн зовлон туулсан гар тэрэгтэй бүлгийн бараг хүн бүрийг хунгар цасаар дүүрсэн горхиор үүрч

гаргажээ. Сэтгэлзүйн ачаалал хэт их, хүч чармайлт бүр ч хэрээс хэтэрснээс хожим нь хэдэн жилийн дараа энэ гурван залуу гурвуул нас барсан ажээ. Ерөнхийлөгч Бригам Янг энэхүү баатарлаг үйл хэргийн талаар сонсоод, хүүхэд шиг цурхиран уйлсан гэдэг. Тэгээд хожим нь, "Энэхүү үйл хэрэг дангаараа К.Аллен Ханнигтон, Жорж В.Грант, Давид П.Кимбалл нарыг төгсгөлгүй ертөнц, Бурханы селестиел хаант улсад үүрдийн авралыг баттайяа олох болгож байна" хэмээн нийтийн өмнө мэдэгджээ' (ЛиРой Р. Хафен, Анн В.Хафен, *Handcarts to Zion* [Глендейл, Калифорни: The Arthur N. Clark Company, 1960], х. 132-133).

"Бусдад үзүүлэх бидний үйлчлэл ийм эмгэнэлтэй байхгүй ч, бид хүмүүний сэтгэл санаанд урам хайрлаж, даарсан биеийг нь хувцаслаж, өлссөн хүмүүсийг хооллож, уй гашууд автсан зүрх сэтгэлийг тайтгаруулж, эрхэм үнэ цэнэтэй бодгалиудыг шинэ өндөрлөгт өргөн гаргаж чадна" (In Conference Report, 1990 оны 4-р сар, 61-62; *Ensign*, 1990 оны 5-р сар, 46-47).

Есүс Христийн Сүмийн гишүүд бид аврах үүрэгтэйг онцлон тэмдэглэ. "Амьдрал дахь бидний үүрэг бол Их Эзэн Есүс Христийн дагалдагчдын хувьд авралын номлогч байх ёстой" гэж Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлжээ (In Conference Report, 1991 оны аравдугаар сар, 78; *Ensign*, 1991 оны арваннэгдүгээр сар, 59). Ерөнхийлөгч Томас С. Монсоны хэлсэнчлэн бидний үйлчлэл дээрх болсон явдалд гурван залуу эрийн хийсэн золиослол шиг тийм эмгэнэлтэй байх шаардлагагүй. Гэвч бид гэр бүлийн гишүүд, найз нар, бусад хүмүүсийг хайрлах, тэдэнд үйлчлэх, заах зэрэг өдөр тутмын энгийн хүч чармайлтаар дамжуулан тэднийг аврахад тусалж чадна.

- Гачигдалтай хүмүүсийг аврахын тулд бидний хийж чадах зарим зүйл юу вэ? (Ангийн гишүүдийн хариултыг самбар дээр бич. Ярилцлагын нэг хэсэг болгон дараах эшлэлийг хуваалц)

Мартин, Вилли нарын гар тэрэгтэй бүлгийн тухай Ерөнхийлөгч Хинкли өгүүлж, ярьсан нь:

"Анхдагч нарын тэр өдрүүд бидний ард үлдсэнд би баяртай байдаг. Бид ах эгч нараа уулсын дундах энэхүү Сиондоо хүрч ирэх гэж чармайн даарч осгож, үхтэлээ туйлдан ядарч, цасан дунд хөсөр хаягдахад хүргээгүйд би баяртай байдаг. Гэвч нөхцөл байдал нь тэсэхүйеэ бэрх, тусламж, хөнгөвчлөл үзүүлэхийг хүсч байгаа хүмүүс цөөн биш байна.

"Тусламж хэрэгтэй байгаа, өлсгөлөн, ядуу зүдүү хүмүүс дэлхий даяар үй олон байна. . . . Тэдэнд хүрч, туслан, хэрэв өлсч байвал тэднийг хооллох, хэрэв үнэн болон шударга ёсоор цангаж байгаа бол тэднийг сүнслэг байдлын тувьд тэжээн тэтгэх нь бидний агуу, эрхэм ариун үүрэг мөн.

"Зорилгогүйн улмаас урсгалаар хөвж яваа, мансууруулах бодис, гэмт хэрэг, ёс суртахуунгүй явдлыг араасаа дагуулдаг, энэ бүгдийг төрүүлдэг эмгэнэлт амьдралтай залуу хүмүүс өдий төдий байна. Нөхөрсөг дуу хоолой, хайраар нэвт шингэсэн анхаарал халамжийн эгээрэл хүслэн болсон бэлэвсэн эмэгтэйчүүд байдаг. Нэгэн цагт итгэл бишрэлээр гал цогтой явсан ч, итгэл нь хөрсөн хүмүүс байна. Тэднээс олон нь Сүмд эргэж ирэхийг хүсдэг ч, чухам яаж гэдгээ мэддэггүй. Нөхөрсөгөөр гараа сунган, тэдэнд туслах хэрэгтэй байна. Тэднээс олныг нь багаахан хүч чармайлт гаргаж Их Эзэний Сүмд эргүүлэн авчирч болно.

“Ах эгч нар аа, тусламж хэрэгтэй байгаа хүмүүсийг, ядуу зүдүү, хүнд нөхцөл байдалд амь зууж яваа хүмүүсийг эрж олоход, Сүмийг баяртай хүлээн авах хайраар тэднийг өргөхөд бид бүгд хоёргүй сэтгэлээр хандах ёстойд би найдна. Үүний төлөө би залбирах болно. Зөвхөн Сүм дээр л туслан дэмжигч гар, хайрлагч зүрх сэтгэл тэднийг бүлээцүүлж, тайтгаруулан, дэмжиж, аз жаргалтай, бүтээлч амьдралын зам дээр гаргана” (In Conference Report, 1996 оны аравдугаар сар, 118; *Ensign*, 1996 оны арваннэгдүгээр сар, 86).

Дараах судруудыг ангийн гишүүдээр уншуулж, бид гачигдалтай хүмүүсийг аврахын тулд юу хийж болох тухай зөвлөгөөг эрж ол. Ярилцах болон хэрэгжүүлэхийг нь урамшуулан дэмжихийн тулд доорх асуултуудыг ашигла.

- а. С ба Г 4:3-7; Моронай 7:45-48. Эдгээр шүлгүүдэд жагсаасан шинж чанар гачигдалтай хүмүүсийг аврахад бидэнд хэрхэн тусалж чадах вэ?
- б. С ба Г 18:10-16. Сайн мэдээг зааж, бусдыг наманчлалд хөтлөх ямар боломж бидэнд байдаг вэ?
- в. С ба Г 52:40. “Ядуус хийгээд гачигдагсад, өвчтөнүүд болон зовж шаналагсад” туслахын тулд бид юу хийж болох вэ? Хэрэв бид гачигдагсад туслахгүй бол яагаад Аврагчийн шавь нар байдаггүй вэ?
- г. С ба Г 81:5-6. “Доош унжсан гарнуудыг өргөгтүн, мөн сул дорой өвдөгнүүдийг хүчирхэг болгогтун” гэсэн нь ямар утгатай вэ? Энэ зарлиг сүнслэг болон материаллаг хэрэгцээнд хэрхэн хамаатай байж болох вэ?
- д. С ба Г 138:58. Бид Ариун сүмийн ажлаар дамжуулан хүмүүсийг хэрхэн авардаг вэ?
- е. 3 Нифай 18:31-32. Урвасан хүмүүст “үргэлжлүүлэн тохинуулахын тулд” бид юу хийж болох вэ?
- Мартин, Вилли нарын гар тэрэгтэй бүлгийг аварсан тухай эргэцүүлэн бодохыг ангийн гишүүдээс хүс. Бид бусдыг аврахыг хичээхдээ Ерөнхийлөгч Бригам Янг болон хээр талд хүчин мөхөсдсөн гар тэрэгтэй бүлгийг аварсан Гэгээнтнүүдийн үлгэр жишээнээс юу сурч болох вэ? (Бид туслах хүч чармайлтаа хойшлуулах ёсгүй, бид бусдын хэрэгцээнд анхаарал тавихын тулд өөрсдийнхөө хэрэгцээг хойш тавих ёстой. Мөн бид итгэл бишрэлээ ашиглах ёстой нь хариулт байж болно)

Дүгнэлт

Энэ хичээл дээр ярилцсан зарчмуудыг хэрэгжүүлэх арга хэлбэрийг олоход нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Бид аврах хэрэгцээтэй хүмүүст туслахыг хичээхдээ найдвараа хэзээ ч орхих ёсгүйг онцлон тэмдэглэ. Бид амин хувиа хичээх үзлийг орхиж, хайраар бусдад хандах ёстой. Сүнсээр өдөөгдсөний дагуу энэ хичээлийн үеэр ярилцсан үнэнүүдийн тухай гэрчил.

Нэмэлт заах санаанууд

Та зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмж дараах санаануудаас нэгийг буюу илүү олныг нь ашиглаж болно.

1. “Бид зовсон үедээ л [Бурхан] байгааг санадаг”

Бидний Өв, хуудас 91-92-оос Нелли Пуселлын тухай түүхийг хуваалцахад бэлтгэж ирэхийг ангийн нэг гишүүнээс хүс. Тэр болон гар тэрэгтэй анхдагч

нар “гай зовлонгийнхоо үед [Бурханыг] санасан” (*Бидний Өв*, хуудас 92) тухай гэрчилсэн нэг хүний түүхийг хуваалцахаар бэлтгэхэд ангийн өөр нэг гишүүнийг урь.

- Бид эдгээр түүхээс юу сурч болох вэ? Бид хүнд сорилтыг тэсэн гарсан үед Бурханыг илүү сайн санаж чаддагийг та нар хэрхэн харсан бэ?

Та энэ ярилцлагын нэг хэсэг болгон С ба Г 122:5-8-ыг ангийн гишүүдээр уншуулж болно.

2. “Хэрэв дэлхий аврагдвал, бид л түүнийг аврах ёстой”

Гачигдалтай хүмүүсийг аврах бидний үүрэг хариуцлагыг онцлон тэмдэглэхийн тулд Ерөнхийлөгч Гордон Б.Хинклийн дараах мэдэгдлийг хуваалц:

“Аврал, дэлхийн үүрд мөнхийн авралыг энэ Сүм мөрөн дээрээ үүрч явааг та нар бодоод үз л дээ. Ингэж ойлгох юм бол бидний захиас амин чухал юм. Эцсийн эцэст, хэрэв дэлхий аврагдвал, бид л түүнийг аврах ёстой. Үүнээс зайлах арга байхгүй. Дэлхийн түүхэн дэх өөр бусад ямар ч хүмүүс бидний хүлээж авсан шиг ийм бүрэн эрхийг хүлээж аваагүй юм. Бид дэлхий дээр амьдарч асан бүх хүмүүсийн төлөө хариуцлага хүлээдэг. Энэ бол манай гэр бүлийн түүхийн болон ариун сүмийн ажил юм. Бид эдүгээ дэлхий дээр аж төрж байгаа бүх хүмүүсийн төлөө хариуцлага хүлээдэг. Энэ нь манай номлолын ажил юм. Бид бас дэлхий дээр ирээдүйд амьдрах бүх хүмүүсийн төлөө хариуцлага хүлээх болно” (*Church News*, 1999 оны долдугаар сарын 3, 3).

3. “Бүх зүйлээр соригдсон нь” видео танилцуулга

Хэрэв *Teachings from the Doctrine and Covenants and Church History* видео хуурцаг (53933) байдаг бол “Бүх зүйлээр соригдсон нь,” дөрвөн минутын хэсгийг үзүүлэхэд анхаар.

“Зэлүүд газар, цөл баярлан, замар цэцэг мэт дэлгэрнэ”

Хичээл
36

Зорилго

Солт Лейкийн Хөндий дэх эхэн үеийн Гэгээнтнүүдийн золиослолоор тэд хэрхэн адислагдсаныг ойлгоход нь ангийн гишүүдэд тусалж, тэдгээр итгэлтэй гишүүдийн үлгэр жишээг дагахад нь тэднийг урамшуулан дэмжих.

Бэлтгэл

1. *Бидний Өв*, хуудас 109-112-ыг залбирч судал.
2. *Ангийн гишүүний Судлах Удирдамж* (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.
3. *Бидний Өвөөс* дараах хэсгийг нэгтгэн дүгнэхэд бэлтгэхийг ангийн гишүүдээс хүс:
 - а. “Хөндий дэх анхны жил,” “Судалгаа шинжилгээ” (хуудас 96-99).
 - б. “Эзэмших дуудлага” (хуудас 86-89).
 - в. “Номлогчид дуудлагад хариулав” (хуудас 99-101).
 - г. “Номлолын ажил” (хуудас 109-112).
4. Хэрэв дараах зургууд байвал хичээлийн үеэр үзүүлэхээр бэлтгэ: Солт Лейкийн Ариун сүм (62433; Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 502; энэ гарын авлагын хуудас 239; Бригам Янг (Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 507); Жон Тейлор (Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 508).

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа

Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

Солт Лейкийн Ариун сүмийн зургийг үзүүл. Ариун сүмийн доор газарт гүнзгий суулгасан бат бөх чулуун гулдмайн суурь байдгийг тайлбарла. Уг суурь энэхүү гайхамшигт Ариун сүмийг 150 гаруй жил дороос нь бат бөх тулж байгаа билээ.

- Барилгын суурь бат бөх, гүнзгий байх нь яагаад чухал вэ?

Барилгад бат бөх суурь шаардлагатай байдаг шиг бидний амьдрал ч бас ийм байдгийг тайлбарла. Солт Лейкийн Ариун сүмийг барьсан болон шинэ нутгийг эзэмших, сайн мэдээг дэлгэрүүлэх анхдагч нарын хүч чармайлтын талаар энэ хичээлээр ярилцах болно. Энэ хичээлээр бид эхэн үеийн Гэгээнтнүүдийн амьдралаа төвхнүүлдэг байсан зарим суурь зарчим, тэдний үлгэр жишээнээс хэрхэн суралцаж болох тухай ярилцдаг.

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбиран сонгож ав. Ярилцаж байгаа зарчмуудтай холбоотой туршлагыг хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. “Бидний Бурханы Ариун сүм яг энд сүндэрлэн босно”

1847 оны долдугаар сарын 28-нд Солт Лейкийн Хөндийд ирснээс хойш дөрвөн өдрийн дараа, Ерөнхийлөгч Бригам Янг эдүгээ Солт Лейкийн Ариун сүм байгаа газар дээр зогсож байсныг тайлбарла. Тэр таягаараа газар дээр хатгаж, “Яг энд бидний Бурханы Ариун сүм баригдана” гэж хэлжээ (Вилфорд Вудрафф, *Deseret Evening News*, 1888 оны долдугаар сарын 25, 2). Тийнхүү өөр нэгэн ариун сүм барих золиослол ба адислал эхэлсэн юм.

Арванхоёрын Чуулгын Ахлагч Жон А. Видцөү хэлсэн нь, “Анхдагч нар өлсөж, ядарч байлаа. Тэдэнд хоол хүнс, амралт хэрэгтэй байв. Хахир хатуу зэлүүд нутаг тэднийг угтсан юм. Гэвч бие махбодын хэрэгцээ шаардлагын хажуугаар тэд ариун сүмийн өгдөг сүнсний тэжээл, хүч чадлын төлөө ариун сүм барихаар хамгийн түрүүнд ханцуй шамлан орсон юм” (In Conference Report, 1943 оны 4-р сар, 38).

Ерөнхийлөгч Янг Ариун сүмийн газрыг тэмдэглэснээс хойш ганцхан долоо хоногийн дотор Гэгээнтнүүд төвдөө Ариун сүмтэй шинэ хотын төлөвлөгөө гаргах ажилд шамдан оржээ. Хотын төлөвлөгөө хүмүүсийн анхаарлыг Ариун сүм дээр төвлөрүүлсэн байлаа.

- Ариун сүм яагаад бидний амьдралд төв байр эзлэх ёстой вэ? (Дараах эшлэлийг үз) Бид Ариун сүмийг хэрхэн амьдралынхаа хамгийн чухал хэсэг болгож чадах вэ?

Ерөнхийлөгч Ховард В. Хантер сургасан нь:

“Бид . . . Ариун сүмийн шүтлэгээс ирдэг хувийн адислал, эдгээр ариун ханануудын дотор бий болдог ариусгал, аюулгүй байдалд онцгой анхаарал тавьдаг. Энэ бол Их Эзэний өргөө, илчлэлт, амар амгалангийн газар юм. Бид Ариун сүмд орсноор амьдралын зорилго болон Их Эзэн Есүс Христийн цагаатгагч золиослолын ач холбогдлыг улам илүү баялаг агуулгатайгаар, гүн гүнзгий ойлгож мэддэг. Ариун сүм, ариун сүмийн шүтлэг бишрэл, ариун сүмийн гэрээнүүд, ариун сүмийн гэрлэлтийг дэлхийн амьдралынхаа эрхэм дээд зорилго, мөнх бус байдлын эрхэм дээд туршлага болгоцгооё. . .

“Та бүгд Ариун сүмийн утга учир, үзэсгэлэнт сайхныг болон амар амгаланг өдөр тутмынхаа амьдралд улам бүр шууд ирэхээр болгогтун” гэжээ (In Conference Report, 1994 оны аравдугаар сар, 118; *Ensign*, 1994 оны арваннэгдүгээр сар, 87-88).

Солт Лейкийн Ариун сүмийн зургийг үзүүл. Асар том суурийг гараар ухахад олон мянган ажлын цаг шаардсаныг тайлбарла. Суурийн чулууг 1853 оны дөрөвдүгээр сарын 6-нд тавьжээ. Гэгээнтнүүд суурийн ажлыг хэдэн жил хийсний дараа Нэгдсэн Улсын засгийн газартай үүсэн бий болоод байсан асуудлын улмаас ажлаа зогсоов. Гэгээнтнүүд засгийн газрын эсрэг бослого гаргах гэж байна гэсэн худал мэдээллийг Нэгдсэн Улсын ерөнхийлөгч сонссон байж, иймээс тэрээр Солт Лейкийн Хөндий рүү цэрэг

илгээсэн аж. Хариуд нь Ерөнхийлөгч Янг Гэгээнтнүүдээр суурийг шороогоор даруулж, энгийн талбай шиг харагдах болгожээ.

Хожим нь Гэгээнтнүүд элсэн чулуун суурийг ил гаргахад чулуу хагарсныг ажиглажээ. Тэд элсэн чулууг зайлуулж, хатуу боржин гулдмайнуудаар орлуулсан аж. Ариун сүмийн барилгад зөвхөн хамгийн сайн материал, хамгийн шилдэг ур чадварыг ашиглахыг Ерөнхийлөгч шаарддаг байв.

“Ариун сүм мянган жилийн туршид тэсэн зогсож байхаар тийм бат бөх баригдсан байхыг би хармаар байна. Энэ бол бидний барих ганцхан Ариун сүм биш. Бид хэдэн зуун ариун сүм барьж, Их Эзэнд зориулан онцгойлон адисална. . . Тэгээд мянган жил дуусахад . . . энэ Ариун сүм арван есдүгээр зууны үе дэх, уулсын дундах Бурханы Гэгээнтнүүдийн итгэл бишрэл, амьдрах чадвар, нөр хичээнгүй хөдөлмөрч чанарын хөшөө болон сүндэрлэж байхыг би хүснэ” гэж тэр хэлжээ (*Discourses of Brigham Young*, эмхтгэсэн Жон А.Видцөү [1941], 395).

Чулуу бэлтгэх, тээвэрлэх, Ариун сүмийн барилгад зориулж боржин гулдмайнуудыг засч янзлахад Гэгээнтнүүд олон жилийг зориулжээ. Энэ үед тэд амьд мэнд тэсэн үлдэхийн төлөө тэмцэж, ган гачгийн улмаас ургац алдаж, алс холын орнуудад номлолд үйлчлэн, гэр орноо орхин, алслагдсан бөглүү нутагт хүн суурьшуулах дуудлагыг хүлээн авч байлаа. Гэгээнтнүүд эдгээр олон сорилтыг эс хайхран, тэсэн гарч, Их Эзэний тусламжтайгаар бэрхшээл зовлонг ялан дийлсэн юм. Солт Лейкийн Ариун сүм суурийнх нь чулуу тавьснаас хойш 40 жилийн дараа 1893 онд онцгойлон адислагджээ.



Солт Лейкийн Ариун сүм. 1893 онд онцгойлон адислагдсан энэ Ариун сүм 40 жил баригджээ.

- Солт Лейкийн Ариун сүмийг барих үед Гэгээнтнүүд амьдралын бэрх хатууг даван туулж, тэсэн гарснаас бид юу сурч болох вэ? Гэгээнтнүүдийн амьдрах чадварын үлгэр жишээ бидэнд хэрхэн тусалж чадах вэ?

Жеффри Р.Холланд Бригам Янгийн Их сургуулийн ерөнхийлөгч байхдаа бидний амьдралын төлөвшилтийг Солт Лейкийн Ариун сүмийн барилгатай зүйрлүүлж хэлсэн нь:

“Нэр хүндтэй *Scientific America* (*Шинжлэх Ухааны Америк*) сэтгүүл [Солт Лейкийн Ариун сүмийг] “Мормоны амьдрах чадварын хөшөө дурсгал” хэмээн үзжээ. Үнэхээр ч тийм байлаа. Цус, хүнд хүчир хөдөлмөр, нулимс, хөлс. Хамгийн шилдэг юмс ямагт сайн сайхан төгсгөлтэй байдаг. “Та нар өөрсдөө Бурханы ариун сүм гэдгээ мэддэггүй юм уу?” (1 Коринт 3:16.) Бид Бурханы ариун сүм гэдэг нь нэн тодорхой. Удаан хугацаанд уйгагүй хүч чармайлт гаргасан үед бидний амьдрал ариун сүм барихтай адил юм.’ Бид суралцах, өсч хөгжих, мөрөөдөх, үзэгдэл харах боломж бүрийг мөн энэ бүхнийг хэрэгжүүлэхийн төлөө ажиллах боломж бүрийг ашиглах ёстой. Бидэнд өөр сонголт байхгүй болсон үед тэвчээртэйгээр хүлээхийн хамт зөв шударгаа амьдрахыг хичээн чармайх ёстой. . . Бид агуу ажлын суурийг–үнэлж баршгүй ирээдүйнхээ суурийг тавьж байна” (*However Long and Hard the Road* [1985], 127).

2. Солт Лейкийн Хөндий болон эргэн тойрны нутагт суурьшиж, шинэ нутгийг эзэмшихэд Гэгээнтнүүд дуулгавартай байсан нь

Солт Лейкийн Хөндий болон эргэн тойрны нутаг дахь сууршилтын ажлыг эхлэхэд Гэгээнтнүүдэд их бэрхшээл тулгарсныг тайлбарла. *Бидний Өв*, хуудас 96-99-өөс “Хөндий дэх анхны жил,” “Судалгаа шинжилгээ” хэсгүүдийг нэгтгэн дүгнэхийг даалгавар авсан ангийн гишүүнээс хүс.

- Солт Лейкийн Хөндий дэх анхны жилүүдэд тэдэнд учирсан түмэн бэрхшээлийг даван туулахад зан төлөвийн ямар шинж чанар Гэгээнтнүүдэд тусалсан бэ? Өнөөдөр бидний амьдрал дахь ямар нөхцөл байдал зан төлөвийн ийм шинж чанарыг шаардаж болох вэ?
- Саад бэрхшээлийн үед Гэгээнтнүүд хэрхэн адислагдсан бэ? Их Эзэн саад бэрхшээлийн үед та нарыг хэрхэн адисалсан бэ?

Бидний Өв, хуудас 101-105-аас “Эзэмших дуудлагууд” хэсгийг нэгтгэн дүгнэхийг даалгавар авсан ангийн гишүүнээс хүс.

- Чарльз Лаувелл Вокер, Чарльз К.Рич нарын түүхийн юу нь та нарт хамгийн гүнзгий сэтгэгдэл төрүүлэв?

Энэ хоёр ах, тэдний гэр бүлүүд бол дуулгавартай байдлын агуу жишээ юм гэдгийг тайлбарла. Сүмийн түүхийн нэг агуу сургаал бол Их Эзэнийг болон Түүний Бошиглогчдыг дуулгавартай дагасан үед бид адислагддаг явдал мөн. Сургаал ба Гэрээ дуулгавартай байдлаас ирдэг адислалын тухай олон сургаалыг агуулдаг. Дараах судруудыг ангийн гишүүдтэй хамт унш. Доор харуулсан байдлаар, аль хэсэг нь дуулгавартай байдлын тухай зааж байгааг ярилц.

- a. С ба Г 58:2-4. (Хэрэв бид зарлигуудыг сахиж, “гай зовлон тохиолдоход итгэлтэй” байх юм бол “их алдар суугийн титэм” өмсөх болно)

- б. С ба Г 64:33-34. (Хүсэл эрмэлзэлтэй, дуулгавартай хүмүүс эцсийн өдрүүдэд Сионы нутагт адислагдана)
- в. С ба Г 82:10. (Бид Их Эзэний хэлсэн зүйлийг хийхэд Тэрээр хариуд нь үүрэг хүлээдэг. Бид Түүний зарлигуудыг дуулгавартай дагахад Тэрээр биднийг адисална)
- г. С ба Г 93:1. (Наманчилдаг хүмүүс Аврагчид ирж, Түүний зарлигуудыг сахин, Түүний нүүрийг харна)
- д. С ба Г 130:19-21 (Энэ амьдралд дуулгавартай байдлаар дамжуулан илүү мэдлэг, оюун билгийг олж авдаг хүн ирэх дэлхийд давуу байдалтай байх болно. Бид Бурханы хуулиудыг дуулгавартай дагаснаар адислалуудыг олж авдаг)
- Дуулгавартай байдлын ач холбогдлыг заасан ямар туршлагыг та нар зохих ёсоор хуваалцаж чадах вэ? Бид хэдийгээр шинэ газар нутаг эзэмшихээр дуудагдахгүй ч, өнөөдөр Бошиглогчийг ямар арга замаар дагахыг биднээс хүсдэг вэ? Бурханы хүслийг дуулгавартай дагасан үед та нарт ямар мэдрэмж төрдөг вэ?

3. Дэлхий дахинд сайн мэдээг заахад номлогчид золиослол хийсэн нь

Гэгээнтнүүд Солт Лейкийн Хөндийд суурьшсан үед Ерөнхийлөгч Бригам Янг дэлхий даяар үйлчлэх олон номлогчийг дуудсаныг тайлбарла. *Бидний Өв*, хуудас 99-101-ээс “Номлогчид дуудлагад хариулав” хэсгийг нэгтгэн дүгнэхийг даалгавар авсан ангийн гишүүнээс хүс.

- Ерөнхийлөгч Бригам Янг Сүмийг удирдаж байх үед Гэгээнтнүүд дэлхийн ямар бүсүүдэд сайн мэдээг номлосон бэ? Эхэн үеийн эдгээр Гэгээнтнүүд сайн мэдээг дэлхий дахины хүмүүстэй хуваалцахын тулд ямар золиослол хийсэн бэ?
- Ахлагч Лорензо Снөүгийн итгэл, залбирал Итали дахь хүмүүсийн зүрх сэтгэлийг сайн мэдээний захиаст нээхэд хэрхэн тусалсан бэ?
- Бид Ахлагч Эдвард Стивенсон, Элизабет Вүд, Чарльз Вүд, Ахлагч Жозеф Ф.Смит нарын үлгэр жишээнээс юу сурч болох вэ?

Ерөнхийлөгч Бригам Янг Сүмийг 33 жил удирдсан юм. Ерөнхийлөгч Янг 1877 онд нас барсны дараа Жон Тейлор Арванхоёрын Чуулгын Ерөнхийлөгчийн хувьд Сүмийг гурван жил удирдаад, дараа нь 1880 оны аравдугаар сарын 10-нд Сүмийн Ерөнхийлөгчөөр дэмжигдэн батлагджээ (*Бидний Өв*, хуудас 106-107).

Гэгээнтнүүд Ерөнхийлөгч Тейлорын удирдлагаар дэлхий даяар сайн мэдээг номлохоо үргэлжлүүлсэнийг тайлбарла. *Бидний Өв*, хуудас 109-112-оос “Номлолын ажил” хэсгийг нэгтгэн дүгнэхийг даалгавар авсан ангийн гишүүнээс хүс.

- Ерөнхийлөгч Жон Тейлор Сүмийг удирдаж байх үед Гэгээнтнүүд дэлхийн ямар бүсүүдэд сайн мэдээг номлож байсан бэ?
- Милтон Трехо Бурханы хаант улсыг байгуулахад насан туршдаа оролцох боломжоор хэрхэн удирдуулсан бэ? Бид Бурханы хаант улсыг байгуулахад өөрсдийгөө хэрхэн илүү сайн бэлтгэж болох вэ?

- Ахлагч Томас Байзенгер, Ахлагч Кимо Пелио, Самуела Маноа, Ахлагч Дийн, Дийн эгч, Жонатан Напела, Китти Напела нарын тухай түүхээс бид юу сурч болох вэ?

Дүгнэлт

Солт Лейкийн Хөндийд Гэгээнтнүүд Их Эзэний Ариун сүмийн болон амьдралынхаа бат бөх суурийг тавьсныг хэл. Эхэн үеийн Гэгээнтнүүдийн итгэл бишрэл, амьдрах чадвар дуулгавартай байдал, сайн мэдээг хуваалцсан үлгэр жишээг дагахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Сүнсээр өдөөгдсөний дагуу хичээлийн үеэр ярилцсан үнэнүүдийн тухай гэрчил.

“Бурхан минь, Бошиглогч илгээсэн Танд талархъя”

Хичээл
37

Зорилго

Бидэнд амьд Бошиглогч хэрэгтэйг хүлээн зөвшөөрч, үүргийг нь ойлгох, зөвлөгөөг нь илүү их итгэлтэйгээр дагахад ангийн гишүүдэд туслах.

Бэлтгэл

1. Энэ хичээлийн судрууд болон *Бидний Өв*, хуудас 145, “Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл”-ын сүүлчийн хоёр догол мөрийг залбирч судал.
2. *Ангийн гишүүний Судлах Удирдамж* (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.
3. Ахлагч Спенсер В.Кимбалл нисэх онгоцны буудал дээр нэгэн эх, түүний хүүхдэд тусалсан тухай түүхийг ярихаар бэлтгэхийг ангийн нэг гишүүнээс хүс (*Бидний Өв*, хуудас 152-53).
4. “Бурхан минь, Бошиглогч илгээсэн Танд талархъя” дууллыг ангийн гишүүдээр дуулуулахад бэлтгэ (*Сүмийн дуулал болон хүүхдийн дуу*, х.36). Хэрэв та энэ дууллыг ашиглахаар төлөвлөсөн бол хичээлийн эхэнд ашигла. Эсвэл дууллыг дуулахад бэлтгэхийг ангийн нэг гишүүнээс эсвэл хэсэг гишүүнээс хүс.

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа

Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

Тэргүүн Зөвлөлийн Ерөнхийлөгч Хью Б.Брауны ярьсан дараах түүхийг хуваалц:

Ерөнхийлөгч Браун Ерөнхий Эрх мэдэлтнээр дуудагдахаасаа өмнө Англид хуульч өмгөөлөгчөөр ажиллаж хэсэг хугацааг өнгөрүүлсэн ажээ. Тэрээр Британийн дээд шүүхийн шүүгч мөн Нийтийн Танхимын гишүүн асан нэгэн нэрд гарсан англи хүнтэй найз байв. Энэ хоёр хүн янз бүрийн сэдвээр, түүний дотор шашны тухай олонтаа ярилцдаг байжээ.

1939 онд, Дэлхийн II Дайн дэгдэх нь тодорхой болоод байсан үед нөгөөх англи хүн Браун ахыг албан өрөөндөө дууджээ. Тэрээр Хууль зүйн асуудлыг ярилцдаг байдлаараа сүсэг бишрэлээ хамгаалахыг Браун ахаас хүссэн гэнэ. Ерөнхийлөгч Браун нэг ерөнхий чуулган дээр хэлсэн үгэндээ тэдний хооронд болсон ярианы хэсгийг дурсчээ:

“ Ноёнтоон, таныг би Христийн шүтлэгтэн гэж боддог, энэ үнэн үү? гэж асууснаар би эхлэв.”

“ Тийм ээ.”

“ ‘ Библи, Хуучин Гэрээ, Шинэ Гэрээнд таныг итгэдэг гэж би боддог?’

“ Тийм ээ, тэгдэг!”

Бошиглогчдод хандан ярьсан Их Эзэний шастируудад итгэдгээ англи эр ярив. Гэвч ийм харилцаа Христийн Амилалтын дараа удалгүй зогссон гэдэг санааг тэр илэрхийллээ. “Ийм харилцаа яагаад зогссон гэж та боддог вэ?” гэсэн асуултыг Браун ах асууснаар яриа хөөрөө цааш үргэлжилсэн ажээ.

“ ‘Би хэлж чадахгүй юм даа.’

“ ‘Тэр үеэс хойш Бурхан яриагүй гэж та боддог уу?’

“ ‘Миний мэдэхээр үгүй.’

“ ‘Бурхан яагаад ярихаа больсон байж болох шалтгаануудыг би нэрлэе л дээ. Магадгүй Тэр ярьж чадахгүй болсон юм бил үү. Тэр хүчгүй болсон байж мэднэ.’

“ ‘Ингэж бодох нь Түүнийг гутаан дормжилсон хэрэг болно шүү дээ’ гэж тэр хэллээ.

“ ‘За тэгвэл, хэрэв та үүнийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа бол Тэр биднийг нэгэнт хайрлахаа больсон болохоор хүмүүстэй ярихаа больсон байж болох юм. Тэрээр хүмүүний хэрэг явдлыг сонирхохоо больсон хэрэг биш үү.’

“ ‘Үгүй хаанаас даа, Бурхан бүх хүмүүст хайртай, тэр чинь хүмүүсийг ялгаварладаггүй шүү дээ’ гэж тэр хэллээ.

“ ‘За тэгвэл . . . миний бодож байгаагаар өөр ганцхан боломжит хариу байгаа нь бид түүнд хэрэггүй болсон юм байна. Бид боловсрол, шинжлэх ухаанд маш түргэн ахиц дэвшил гаргалаа, ингэхлээр Бурхан бидэнд ерөөсөө хэрэггүй болсон юм биш үү.’

“Тэгтэл тэрээр хоолой нь чичрэн, заналхийлж буй дайны тухай бодсон бололтой, ‘Ноён Браун, Бурханы дуу хоолой одооных шиг хэрэгтэй байсан цаг үе дэлхийн түүхэнд хэзээ ч байгаагүй юм. Тэрээр яагаад ярихгүй байгааг та надад хэлж өгч чадах юм биш үү’ гэв.

“ ‘Бурхан ярьдаг, тэр ярьсаар байгаа. Харин түүнийг сонсох итгэл л хүмүүст хэрэгтэй’ гэж би хариулж билээ” (In Conference Report, 1967 оны аравдугаар сар, 117-118; *Improvement Era*, 1967 оны арванхоёрдугаар сар, 36-37).

Их Эзэн өнөөдөр амьд Бошиглогчоор дамжуулан ярихаа үргэлжлүүлж байгааг онцлон тэмдэглэ. Энэ хичээлээр амьд Бошиглогчоор удирдуулснаас ирдэг адислал болон түүний зөвлөлгөөг дагах бидний үүргийн тухай ярилцдаг.

Ярилцах ба
хэрэгжүүлэх нь

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбиран сонгож ав. Ярилцаж байгаа зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Бидэнд Бошиглогч хэрэгтэй

- Өнөөдөр бидэнд яагаад амьд Бошиглогч хэрэгтэй вэ? (Амьд Бошиглогчийн зөвлөгөө манай өнөө үеийн бүх асуудалд хариулахад бидэнд тусалдгийг та онцлон тэмдэглэж болно)

Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон Арванхоёрын Чуулгын Ерөнхийлөгчөөр үйлчилж байхдаа хэлсэн нь: “Бидний мэдэхээр хамгийн чухал бошиглогч бол манай үе, манай эрин зуунд амьд байгаа бошиглогч юм. Амьд бошиглогч өнөө үед Бурханы зааврыг бидэнд авчирч байна. Адамд өгсөн

Бурханы илчлэлт хөвөгч авдрыг хэрхэн босгохыг Ноад зааварлаагүй шүү дээ. Хүн төрөлхтний үе үеийнхэн эрт үеийн судар дээр нэмж тухайн үеийнхээ судрыг амьд Бошиглогчоос хүлээж авах хэрэгцээтэй байдаг. Тиймээс, та нарын уншиж, тунгаан бодвол зохих хамгийн чухал, шийдвэрчлэгч ач холбогдолтой зүйл бол Их Эзэний амнаас гарсан сүнслэг нөлөө бүхий хамгийн сүүлчийн үгс юм” (In Conference Report, Korea Area Conference 1975, 52).

- Өнөөдөр дэлхий дээр амьд бошиглогч байгаагийн улмаас та нар хэрхэн адислагдсан бэ?

2. Манай амьд Бошиглогчийн үүрэг

Тэргүүн Зөвлөлийн болон Арванхоёрын Төлөөлөгчийн Чуулгын гишүүд бол бүгдээрээ бошиглогч, үзмэрч, илчлэгчид мөн гэдгийг тайлбарла. Гэвч зөвхөн Сүмийн Ерөнхийлөгч л Сүмд бүхэлд нь зориулсан илчлэлтийг хүлээн авч, Сүмийг удирдахад шаардлагатай санваарын бүх түлхүүрийг хэрэглэх эрх мэдэлтэй байдаг.

Амьд Бошиглогчийн үүргийн тухай чухал мэдээлэл Сургаал ба Гэрээнд байдаг. Налуу бичлэгээр бичсэн дараах судрын эшлэлүүдийг ангийн гишүүдээр уншуул. Тэгээд амьд Бошиглогчийн үүргийн тухай эдгээр судрууд юу заасныг тэднээр олуул. Зөвлөмж болгосон хариултууд хаалтан дотор байгаа. Хариултыг самбар дээр нэгтгэн дүгнээд дараа нь ярилц.

А. Сургаал ба Гэрээ 1:38; 21:4-5; 43:2; 68:3-4. (Бошиглогч Их Эзэнийг төлөөлөн ярьж, Их Эзэний хүслийг илчилдэг)

- Бид бошиглогчдоос ямар сэдвээр саяхан удирдамж хүлээн авсан бэ? (Бат бөх гэр бүлийг төлөвшүүлэх, Ариун сүмийн ажил хийх, Сүмийн шинэ гишүүдэд туслах, өргүй байх, Мормоны Номыг унших нь хариулт байж болно)

Б. Сургаал ба Гэрээ 20:21-26; Мозая 13:33. (Бошиглогч Есүс Христийн тухай гэрчилж, сайн мэдээг заадаг)

- Аврагчийн тухай гэрчлэл чинь амьд Бошиглогчийн үгсээр хэрхэн бэхэжсэн бэ?

В. Сургаал ба Гэрээ 21:1; Мозая 8:13-18. (Бошиглогч бол үзмэрч мөн)

- Үзмэрч гэж хэн бэ? (Үзмэрч бол өнгөрсөн болон ирээдүйг мэдэх их хүчийг Бурхан түүнд өгсөн Бошиглогч юм. Тэрээр мэдэгдээгүй буюу нуугдмал зүйлийг мэдэж чадна. Бас эртний цэдгүүдийг орчуулах хүч түүнд байж болно)
- С ба Г 101:43-54-ийг ангийн гишүүдтэй хамт унш. Энэ сургаалт зүйрлэлд, зарц нар эзнийхээ ямар зарлигийг дагаагүй вэ? (С ба Г 101:46-50-ийг үз.) Хэрэв зарц нар цамхгийг барьсан бол юунаас зайлсхийж чадах байсан бэ? (С ба Г 101:51-54-ийг үз.) Энэ нь бид Сүмийн Ерөнхийлөгчийн үгст анхаарал тавихад хэрхэн холбогдох вэ?
- Сүмийн Ерөнхийлөгч дайсныг “хол байхад нь” (С ба Г 101:54) харж чаддаг. Хожмын Үеийн Бошиглогчид ямар аюулыг угтан харж, энэ талаар биднийг сэрэмжлүүлдэг вэ?

Г. Сургаал ба Гэрээ 107:91-92. (Бошиглогч Сүмийг тэргүүлдэг)

- Бурханаар сонгогдон, Түүгээр удирдуулдаг Бошиглогч үнэн Сүмийг удирддаг учраас бид ямар адислал хүлээн авдаг вэ?
- Бид Бошиглогчийг Сүмийн Ерөнхийлөгчийн үүрэгт ажилд нь хэрхэн дэмждэг вэ? (С ба Г 107:22-ыг үз)

3. Амьд Бошиглогчийн үгст анхаарал хандуулах нь

- С ба Г 21:4-6-г ангийн гишүүдтэй хамт унш. Бошиглогчийг сонсох бидний үүргийн тухай эдгээр шүлгүүд юу зааж байна вэ? Хэрэв бид Бошиглогчийн зөвлөгөөг дуулгавартай дагавал Их Эзэн бидэнд ямар амлалт өгдөг вэ?

Ерөнхийлөгч Харольд Б.Лий сургасан нь: “Сүмийн гишүүд бидэнд байдаг цорын ганц аюулгүй байдал бол Сүм зохион байгуулагдсан өдөр Сүмд хандан Их Эзэний хэлсэн үгийг ширхэгчлэн биелүүлэх явдал мөн [С ба Г 21:4-5-ыг үз]. . . Тэвчээр, итгэл бишрэл шаардах зарим зүйл байх болно. Сүмийн эрх мэдэлтнээс ирдэг зүйлд та нар дургүй байж мэднэ. Энэ нь та нарын улс төрийн үзэл бодолд харшилж болно. Энэ нь та нарын нийгмийн үзэл бодолд харшилж болно. Энэ нь та нарын нийгмийн амьдралын зарим талд саад учруулж болно. Гэвч та нар эдгээр зүйлсийг Их Эзэний өөрийнх нь амнаас гарсан гэж бодон, тэсвэр тэвчээр, итгэл бишрэлтэйгээр сонсох юм бол ‘тамын үүд та нарыг дийлэх нь үгүй’ [С ба Г 21:6] гэсэн амлалт гүйцэлдэнэ” (In Conference Report, 1970 оны аравдугаар сар, 152; *Improvement Era*, 1970 оны 12-р сар, 126).

- Бид Бошиглогчийн сүнсээр нөлөөлөгдсөн зөвлөгөөнөөс хэрхэн суралцаж болох вэ? (Ерөнхий чуулган дээр хэлсэн үгс, Тэргүүн Зөвлөлийн захиас бичгүүд, түүнчлэн Сүмийн сэтгүүлүүд дэх бусад өгүүллийг судалснаар, Сүмийн цуглаанууд дээр уншдаг Тэргүүн Зөвлөлийн захидлуудыг сонсох замаар)

Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон нэг ерөнхий чуулганы төгсгөлд, “Дараагийн зургаан сард та нар *Ensign* сэтгүүлийн чуулганд зориулсан дугаарыг жишиг бүтээлүүдийнхээ хамт байнга ашиглах хэрэгтэй” хэмээн хэлжээ (In Conference Report, 1988 оны 4-р сар, 97; *Ensign*, 1988 оны 5-р сар, 84).

Ахлагч Харольд Б.Лий Арванхоёрын Чуулгад үйлчилж байхдаа ерөнхий чуулганы үед үүнтэй төстэй мэдэгдэл хийсэн юм. Чуулганы илтгэл “Дараагийн зургаан сард [бидний] амьдралыг удирдаж, чуулганы тухай өгүүлсээр байх болно” гэж тэр хэлжээ (In Conference Report, 4-р сарын 1946, 68).

- Ерөнхий чуулган дээр Бошиглогчийн хэлсэн үгийг бид хувиараа болон гэр бүлээрээ хэрхэн илүү сайн судалж, илүү сайн ашиглаж болох вэ?
- Та нар Бошиглогчийн зөвлөгөөг дагаснаар хэрхэн адислагдсан бэ?

Далын Ахлагч Брус Д.Портерын өгүүлсэн дараах түүхийг хуваалц:

“Тэргий бид хоёр дөнгөж гэрлэсэн залуу хос байхдаа Бостоны бүсэд амьдарч, би тэнд сургуульд явдаг байлаа. Биднийг тэнд очсоноос хойш удалгүй өөр нэг залуу гэр бүл манай тойрогт шилжиж ирэв. Тэд хөрвөгчид болоод хоёр жил орчим болж байсан . . Би тэдний гэрийн багшийн

дуудлага хүлээн авсандаа нэг талаар баяртай байсан ч, нөгөө талаар тэд юу гэж бодох бол гэж санаа зовниж байлаа. Сайн мэдээний тухай тэдний гэрчлэлийг бэхжүүлэхэд тусална даа хэмээн хүлээж байв.

“Нэг орой би хамтрагчтайгаа тэдэнд заахаар даруухан сууцанд нь хүрч очлоо. Тэд бяцхан хүүгийнхээ хамт гэр бүлийн үдшээ дуусч байв. Гэргий бид хоёр хүүхэдтэй болсон үедээ . . . гэр бүлийн үдшээ эднийх шиг хийж заншвал догь болно доо гэж би дотроо бодож билээ. Тэгээд тэд хоёр талынхаа гэр бүлийн өвөг дээдсийн олон нэрсийг цуглуулсан Дурсамжийн Номоо бидэнд дуртайяа үзүүлэв. Би ийм Дурсамжийн Номыг харснаас хойш урт удаан хугацаа өнгөрснийг саналаа.

“Хичээлийн дараа тэд улаан буудай, элсэн чихэр, гурил бусад хүнсний зүйлийн бүтэн жилийн хэрэгцээний хүнсээр дүүргэсэн, зайрмагны хувингуудаар зайгүй чигжсэн, дундуураа хаалттай ар талын жигүүр рүү биднийг аваачив. Яагаад ч юм, энэ зөвлөгөө оюутан бидэнд хамаагүй юм шиг санагдаж байж билээ! Харин одоо бол би ихэд даруухнаар бодож байна. Би тэдэнд заахаар ирсэн байтал харин тэд надад юм бүхнийг заах нь тэр. Бид тэдний өмгөр орон сууцыг орхин гарахдаа, хаалганых нь ойролцоо ариун сүмийн нэг зураг өлгөөтэй байхыг ажиглав. Хожмын Үеийн Гэгээнтэн гэр бүл болгон гэр орондоо хамгийн түрүүнд харагдах газарт Ариун сүмийн зурагтай байх ёстой гэж Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл хэлснийг би саналаа. Бас бидэнд ариун сүмийн зураг байхгүйг санав. . .

“Миний бие наманчлалын сүнсээр дүүрч, гэр рүүгээ явлаа. Тэгээд номлогчийн товхимол дотроос Швейцарийн Ариун сүмийн жижигхэн зураг олов. Би үүнийг хайчилж аваад ханан дээрээ наалаа. Тэр үеэс хойш бид Ариун сүмийн зургийг гэртээ үргэлж байлгадаг болсон. Би энэ зургийг харах бүрд, “Бошиглогчийг дагах” нь ямар утга учиртай болохыг бидэнд заасан, нөгөөх хөрвөгч залуу гэр бүлийн хосыг санадаг билээ” (Баунтифул Мьюеллер Парк Гадасны чуулган дээр хэлсэн үг, 1999 оны нэгдүгээр сарын 17).

4. Хожмын Үеийн Бошиглогчдын Христийнх шиг хайрын үлгэр жишээ

Сүмийн Ерөнхийлөгчид амь бие хайргүйгээр, агуу хайраар бусдад үйлчилдгийг хэл. Бид тэдний үлгэр жишээнээс ихийг сурч болно.

Бошиглогч Иосеф Смитийн амьдралын дараах шастирыг ярьж өг:

Жон Лайман Смит гэр бүлийнхээ хамт Гэгээнтнүүд Наувуд анх суурьшиж байх үед энд иржээ. Эхний үед эднийхний амьдарч болох цорын ганц газар нь дүнзээр барьсан морины жүчээ байсан гэнэ. Ээжээс нь бусад энэ гэр бүлийн хүн бүр намагтай газарт амьдарсны уршгаар халуурдаг ханиад хүрч хэвтсэн ажээ. Жон Лайман Смит энэ явдлын тухай өгүүлсэн нь:

“Бошиглогч Иосеф Смит, ах Хайрумтайгаа бидэн дээр ирж, биднийг бүгдийг нь адислав. Тэр үед аав маань халуурч, дэмийрч байлаа. “Та нар бүгдээрээ эдгэрнэ” гэж тэр хоёр Их Эзэний нэрээр хэлэхэд, тэдний үгс биднийг үлэмж ихээр тайтгаруулж билээ. Иосеф урцнаас явахдаа гэрийнхээ шаахайг аавын хөлд углаж орхиод үүдний зам дээрээс мориндоо үсрэн мордож, гэр рүүгээ хөл нүцгэн давхиад явчихав. Маргааш нь аавыг маань гэртээ аваачиж, эдгэртэл нь асарч тойлсон юм” (quoted in *Stories about Joseph Smith the*

Prophet: A Collection of Incidents Related by Friends Who Knew Him, эмхтгэсэн Эдвин Ф.Парри [1934], 33-34).

Нисэх онгоцны буудал дээр бага насны хүүхэдтэй эхэд тусалсан Ахлагч Спенсер В.Кимбаллын тухай түүхийг хуваалцахыг даалгавар авсан ангийн гишүүнээс хүс (Бидний Өв, хуудас 152-153).

Ангийн энэ гишүүний танилцуулгын дараа Ерөнхийлөгч Гордон Б.Хинклийн тухай дараах түүхийг ярь:

1998 онд нэгэн сүйрүүлэгч хар салхи Төв Америкт үлэмж их эвдрэл сүйтгэл учруулсан юм. Сүм их хэмжээний тусламжийн хүнс хангамжийн зүйлс илгээв. Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли тэндхийн хүмүүстэй уулзаж, урам дэм өгөхийн тулд Гондурас, Никарагуа руу явах хэрэгтэй гэж боджээ. Байгалийн энэхүү гамшгийн үеэр өнчирсөн хоёр настай охинтой уулзсан тухайгаа Христийн Мэндэлсний Баярын нэгэн онцгой цугларалт дээр хожим нь Ерөнхийлөгч Хинкли ярьсан юм. Хар салхинаас хэдэн сарын өмнө охины ээж нас барсан гэнэ. Хар салхи болоход аав нь усны түвшин нэмэгдэхээс хамгаалж, гэрийнхээ тавилгыг овоолсон аж.

Аав нь “нэг жижиг гудас авч, овоолсон тавилгынхаа орой дээр тавиад дээр нь [охиноо] суулгасныг Ерөнхийлөгч Хинкли ярьжээ. Ийнхүү тэрээр балмагдан сандарч, аргаа барсан хүч чармайлт гаргаж байгаад, давалгаанд цохиулан, амь эрсэдсэн аж. . . Хоёр өдрийн дараа нэг залуу эр эзгүй хаягдсан байшинд охин амьд байгааг харсан ч, түүний тухай хэн ч юу ч мэдэхгүй байв. Тэрээр охиныг зөөлхөн буулгаж, бишоп, бишопын гэргий хоёрт хүргэж өгчээ. Тэгээд бид энэ охиныг харсан нь тэр. . .

“Христийн Мэндэлсний Баярын энэ үеэр өгөх бэлэг гай зовлонд нэрвэгдсэн энэ хүмүүст байхгүй байлаа. Бяцхан өнчин охин ядахдаа хэдэн чихэр, ямар нэг амттай сайхан юм амсаасай билээ гэж би бодож байв. Ингэхийг би харах ёстой байлаа.

“Хүмүүсийн зүрх сэтгэл нээгдэж, гачигдаж, зовогсдод туслахын тулд... гараа сунгахад нь Бурхан газар бүрийн хүмүүсийг адисалдаг юм” (*Church News*, 1998 оны 12-р сарын 12, 4).

- Бошиглогчдын үйл ажиллагааны юу нь та нарт гүнзгий сэтгэгдэл төрүүлдэг вэ? Бид бошиглогчийн үлгэр жишээнээс юу сурч болох вэ?

Дүгнэлт

Өөрийнхөө Бошиглогчоор дамжуулан өгсөн Бурханы үгээр бид удирдуулдгийг онцлон тэмдэглэ. Бид Бошиглогчийн зөвлөгөөг дагаж, түүний заавраар ажилласнаар, манай өнөө үеийн хүнд сорилтуудыг шийдвэрлэхэд хэрэгтэй удирдлага, хүч чадлыг хүлээн авах болно. Сүнсээр өдөөгдсөний дагуу хичээлийн үеэр ярилцсан үнэнүүдийн тухай гэрчил.

“Бурхан минь, Бошиглогч илгээсэн Танд талархъя” (*Сүмийн дуулал болон хүүхдийн дуу*, х.36) дууллыг ангийн гишүүдээр дуулуулахаар бэлтгэ. Эсвэл дууллыг дуулахад бэлтгэхийг ангийн нэг гишүүнээс эсвэл хэсэг гишүүнээс хүс.

Нэмэлт заах санаанууд

1. Бошиглогч биднийг хэзээ ч буруу удирдахгүй

Бурханаас томилогдсон Бошиглогч биднийг ямагт зөв удирдана гэдэгт бүрэн дүүрэн итгэлтэй байж болно гэдгийг онцлон тэмдэглэ.

Ахлагч Эзра Тафт Бенсон Арванхоёрын Чуулгад үйлчилж байхдаа, “Бошиглогчид анхаарлаа байнга хандуул. Учир нь Их Эзэн өөрийнх нь Бошиглогч энэ Сүмийг буруу удирдахыг хэзээ ч хүлцэхгүй” гэж сургажээ (In Conference Report, 1966 оны аравдугаар сар, 123; *Improvement Era*, 1966 оны арванхоёрдугаар сар, 1145).

Ерөнхийлөгч Жозеф Ф. Смит Тэргүүн Зөвлөлийн зөвлөхөөр үйлчилж байхдаа сургасан нь: “Хэрэв [Сүмийн Ерөнхийлөгч] шударга биш болох юм бол Бурхан түүнийг байрнаас нь зайлуулна. Сүмийн тэргүүнд зогсохоор түүний сонгосон хүн хуулиудыг нь зөрчиж, урвахыг Тэрээр хүлцэхгүй гэдгийг би Израилын Бурханы нэрээр гэрчилж байна. Тэр хүн урвалт уруу хөтөлж мэдэх алхмыг богинохон хугацаагаар ч гэсэн хийвэл Бурхан түүнийг зайлуулна. Яагаад? Эх нь булингартай бол адаг нь булангартай гэдэгчлэн, уг албан тушаалыг ёс бус хүн эзэлж байгааг Их Эзэн хэзээ ч хүлцэн тэвчиж чадахгүй юм” (*Gospel Doctrine*, 5 дахь хэвлэл, [1939], 44-45).

2. Дайны талаарх бошиглол ба илчлэлт

Та Бошиглогчийн үүргийн тухай ярилцахдаа С ба Г 87-г ангийн гишүүдтэй хамт уншиж болно. Энэ илчлэлтийг Иосеф Смитээр дамжуулан 1832 онд өгчээ. 1861 онд эхэлсэн Нэгдсэн Улсын Иргэний Дайныг энэ илчлэлт угтан харж хэлсэн юм.

3. “Цамхаг дээрх харуулууд” видео танилцуулга

Teachings from the Doctrine and Covenants and Church History видео хуурцаг (53933) байвал, “Цамхаг дээрх харуулууд,” дөрвөн минутын хэсгийг үзүүлэхэд анхаар.

4. Сүмийн Хожмын Үеийн Ерөнхийлөгчдийн хувь нэмэр

Сүмийн Хожмын Үеийн Ерөнхийлөгчдийн зургийг үзүүл (62575; Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 401, 507-520; мөн хуудас 219. Хэрэв та цуглааны байрны номын сангийн зургуудыг эсвэл Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулгыг ашиглах бол хуудас 219 дээр харуулсны дагуу Бошиглогч бүрийн зургийг нэр, Сүмийн Ерөнхийлөгчөөр үйлчилсэн оны хамт үзүүлж болох юм.

Энэ гарын авлага дахь “Сүмийн Түүхийн Он дараалал” (хуудас 312-313 мөн *Ангийн гишүүний Судлах Удирдамжийн* хуудас 27-28) дээр очихыг ангийн гишүүдээс хүс. Эдгээр нь Сүмийн Ерөнхийлөгч бүрийн гол хувь нэмрийг мэдэхэд ашиг тустай эх сурвалж гэдгийг тайлбарла.




Иосеф Смит
1830-1844 он



Бригам Янг
1847-1877 он




Жон Тейлор
1880-1887 он




Вилфорд Вудрафф
1889-1898 он




Лорензо Снөү
1898-1901 он



Жозеф Ф.Смит
1901-1918 он



Хебер Ж.Грант
1918-1945 он



Жорж Альберт Смит
1945-1951 он



Давид О.МкКей
1951-1970 он



Жозеф Фиелдинг Смит
1970-1972 он



Харольд Б.Лий
1972-1973 он



Спенсер В.Кимбалл
1973-1985 он



Эзра Тафт Бенсон
1985-1994 он



Ховард В.Хантер
1994-1995 он



Гордон Б.Хинкли
1995-

Зорилго

Сүнсний болон материаллаг халамжийн зарчмуудыг ойлгоход нь, бие даах илүү чадвартай болохын төлөө өөрсдийгөө дайчлах, ядуучууд, гачигдалтай хүмүүст үйлчлэхэд нь ангийн гишүүдэд туслах.

Бэлтгэл

1. Дараах судрууд болон бусад материалыг залбирч судал:
 - а. Сургаал ба Гэрээ 38:30; 42:30-31, 42; 58:26-28; 104:13-18; энэ хичээлийн бусад судрууд.
 - б. *Бидний Өв*, хуудас-125-129, 129-134.
 2. *Ангийн гишүүний Судлах Удирдамж* (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.
 3. *Бидний Өвөөс* дараах мэдээллийг нэгтгэн дүгнэхэд бэлтгэхийг ангийн гишүүдээс хүс:
 - а. Халамжийн хөтөлбөрийг бий болгосон нь (хуудас 127-128).
 - б. Дэлхийн II Дайны дараа Европын хүмүүст үзүүлсэн халамжийн тусламж (хуудас 131 дээрх сүүлчийн догол мөрөөс хуудас 134-ийн талыг дуустал).
 4. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах бол нэг үүргэвч эсвэл цүнхийг ангид авчир. Бас дээр нь дараах үгсийг бичсэн хэдэн том чулуу авчир: *Итгэл дутагдах, Залхуурал, Боловсрол дутагдах, Өр, Ирээдүйд бэлтгэхгүй байх.*
-

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа

Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

Ангид авчирсан үүргэвчээ эсвэл цүнхийг өргөж үзүүлэхийг ангийн нэг гишүүнээс хүс (“Бэлтгэл,” зүйл 4-ийг үз). Биднээс олон хүн хүнд ачааг насан туршдаа ямар ч хэрэггүйгээр тээж явдгийг тайлбарла. Үүргэвч буюу цүнхэнд хэсэг чулууг нэг нэгээр нь нэмж хийсээр ачаа бүр нь яагаад ачаа дарамт болдгийг ярилц. Та хамгийн сүүлчийн чулууг нэмж хийхдээ үүргэвч эсвэл цүнх хичнээн их хүнд болсныг ангийн гишүүдээр ажиглуул.

Одоо чулуунуудыг нэг нэгээр нь гаргаж тавь. Бид эдгээр ачаа дарамтын заримаас нь чөлөөлөгдөх үүргийг өөртөө авснаар амьдрал маань илүү сайн болно гэдгийг тайлбарла.

Бие дааж амьдрах чадвартай байх, гачигдалтай хүмүүст туслахын чухлыг Хожмын Үеийн Бошиглогчид үргэлж зааж ирснийг тайлбарла. Эдгээр зарчмуудыг хэрэгжүүлэхэд гишүүдийг урамшуулан дэмждэг Сүмийн халамжийн хөтөлбөрийн тухай энэ хичээлээр ярилцана.

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбиран сонгож ав. Ярилцаж байгаа зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Сүнслэг байдлын хувьд бие даах чадварыг хөгжүүлэх нь

- С ба Г 38:30-ийг ангийн гишүүдтэй хамт унш. Бие даах чадварын ач холбогдлын талаар энэ хэсэг юу заадаг вэ? Та нар энэ зөвлөгөө үнэнийг амьдрал дээр яаж мэдсэн бэ?
- Сүнсний зүйлсийн хувьд бие даах чадвартай байна гэж юу гэсэн үг вэ? (Амьдралд тохиолддог хэцүү асуудлыг шийдвэрлэх боломжийг бидэнд олгодог сүнсний хүч чадлыг хөгжүүлэхийг мөн сүнслэг байдлыг бусад хүмүүст бэхжүүлэхийг бид хичээн чармайх ёстой) Сүнслэг байдлын хувьд бие даах чадвартай байх нь яагаад чухал вэ?

Арванхоёрын Чуулгын Ахлагч Бойд К.Пакер хэлсэн нь:

“Нэг жилийн хэрэгцээний хоол хүнс, хувцас хунар, хэрэв боломжтой бол түлшийг *гэртээ* нөөцлөхийг бидэнд заадаг . . . Мөн энэ зарчим сүнсний нөлөө болон илчлэлт, асуудлыг шийдвэрлэх, зөвлөгөө, удирдамж хүлээн авахад хамаатайг бид харж чадахгүй гэж үү? *Айл бүрд* ийм *нөөцийн* эх үүсвэр байх хэрэгтэй. . .

“Хэрэв бид сэтгэл хөдлөлийн болон сүнсний бие даасан байдлаа, бие даах чадвараа алдах юм бол магадгүй бид матераиллаг байдлын хувьд бие даахаас илүү ихээр сулран доройтож болно” (In Conference Report, 1978 оны 4-р сар, 136-137; *Ensign*, 1978 оны 5-р сар, 91-92).

- Бид сүнслэг зүйлүүдэд хэрхэн илүү бие даасан чадвартай болох вэ?
- Эцэг эхчүүд сүнслэг байдлын хувьд бие даах чадварт хүүхдэдээ хэрхэн тусалж болох вэ?

2. Материаллаг зүйлст бие даах чадварыг хөгжүүлэх нь

- Материаллаг зүйлст бие даах чадвартай байх гэдэг нь юу гэсэн үг вэ? (Бид өөрсдийнхөө төлөө, гэр бүлийнхээ төлөө анхаарал халамж тавих талаар Их Эзэний өгсөн адислалуудыг ашиглах ёстой. Бид бие бялдар, сэтгэл санааны хувьд чадварлаг байж, өөрсдийнхөө болон гэр бүлийнхээ ачаа дарамтыг өөр хүнд үүрүүлэх ёсгүй) Материаллаг байдлын хувьд бие даах чадвартай байх нь яагаад чухал вэ?
- Бид материаллаг зүйлст хэрхэн илүү бие даасан чадвартай болж чадах вэ? (Үр ашигтайгаар ажиллаж сурах, хүнс болон эн тэргүүний хэрэгцээт бусад зүйлийг шаардлага гарсан үед ашиглахаар нөөцлөх, мөнгөө зөв зарцуулах, сайн боловсрол олж авах нь хариулт байж болно. Ярилцах буюу ангийн гишүүдийн хариулт дээр нэмэхийн тулд дараах мэдээллийг ашигла. Сайн боловсролтой болох тухай мэдээллийг хичээл 23-аас үз)

Ажил

Ерөнхийлөгч Бригам Янг Солт Лейкийн Хөндийд ирснийхээ дараахан энэ бүс нутгийг *Дезерет*, “балт зөгий” (Ифер 2:3) гэсэн утгатай Мормоны Номны нэг үгээр нэрлэжээ. Шинэ эх нутагтаа ажилч хичээнгүй байж, нийтийн сайн сайхны төлөө балт зөгийнүүд лүгээ адил нэгэн зорилгод

нэгдэн ажиллахыг Ерөнхийлөгч Янг Гэгээнтнүүдээс хүсдэг байв. Бид амьдрал, ажил хөдөлмөртөө ийм байдлаар хандах ёстой.

- С ба Г 42:42, 56:17-г ангийн гишүүдтэй хамт унш. Залхуу хүмүүст Их Эзэн ямар сэрэмжлүүлэг өгсөн бэ? (Дараах эшлэлийг үз) Амьдралд чинь ажил хөдөлмөр хэрхэн адислал байдаг вэ? Та нар ажлын үнэ цэнийг яаж мэдсэн бэ? Насанд хүрэгчид ажлын үнэ цэнийг хүүхдэд хэрхэн зааж болох вэ?

“Хүн бие даах чадвартай болохын тулд ажиллах ёстой. Ажил бол бие махбодын, оюуны бас сүнсний хүч чармайлт юм. Ажил бол аз жаргал, өөрийгөө дээдлэх болон цэцэглэл хөгжилтийн үндсэн эх сурвалж юм. Хүмүүс амьдралдаа олон сайн сайхан зүйлийг ажлаар дамжуулан хэрэгжүүлдэг” (Сүмийн Заавруудын Гарын Авлага, Ном 2: Санваартны болон Туслах бүлгийн удирдагчид [1998], 257).

- Арванхоёрын Чуулгын Ахлагч Нийл А.Максвелл, “Ажил бол ямагт сүнсний зайлшгүй хэрэгцээ байдаг. Тэр ч байтугай, зарим хүмүүсийн хувьд ажил бол эдийн засгийн зайлшгүй хэрэгцээ биш байдаг” гэж хэлжээ (In Conference Report, 1998 оны 4-р сар, 50; *Ensign*, 1998 оны 5-р сар, 38). Сүнслэг байдлын хувьд ч, материаллаг аж байдлын хувьд ч ажил яагаад бидэнд чухал байдаг вэ?

Хүнс болон эн тэргүүний хэрэгцээт зүйлсийг нөөцлөх нь

Боломжтой газарт хүнс болон эн тэргүүний бусад хэрэгцээт зүйлсийн нэг жилийн нөөцтэй байх талаар Хожмын Үеийн Бошиглогчид олон жилийн туршид бидэнд хандан ярьсаар байгааг тайлбарла. Бид энэ зөвлөгөөг дагаснаар бие даах илүү чадвартай болно. Учир нь шаардлага гарсан үед бид өөрсдийгөө тэтгэн хангах боломжтой байна.

Сүмийн Заавруудын Гарын Авлагад тайлбарлахдаа:

“Юу нөөцлөх тухайд яг тогтсон томъёолол Сүмийн удирдагчдад байдаггүй. Өөр идэх юм юу ч үгүй болсон тохиолдолд, амьд мэнд үлдэхийн тулд хүмүүст юу шаардлагатай байна, түүнээс эхлэхийг тэд Сүм гишүүдэд зөвлөмж болгодог. . .

“Нягт нямбай төлөвлөх замаар Сүмийн ихэнх гишүүд амьдралыг тэтгэхэд хэрэгтэй үндсэн зүйлсийн жилийнхээ хэрэгцээг нөөцөлж болно. Гэвч ийм нөөц бүрдүүлэх мөнгө буюу байр сав зарим гишүүдэд байдаггүй. Бас жилийн хэрэгцээний хүнс нөөцлөхийг зарим хүмүүст хуулиар хориглодог. Эдгээр гишүүд нөхцөл байдалдаа тохируулан чадах чинээгээрээ нөөцлөх хэрэгтэй. Гишүүд үндсэн хэрэгцээт хүнсний зүйлийг үйлдвэрлэж, бэлтгэж сурснаар аюулгүй байдлаа илүү найдвартай хангаж чадна” (Ном 2, 258).

- Танай бүсэд нэн чухал ямар хүнсний зүйлсийг нөөцөлж болох вэ? Та өөрөө эсвэл бусад хүмүүс хүнсний нөөц бий болгохын тулд юу хийсэн бэ? Хүнсний зохих нөөцтэй байх нь хэрхэн сүнсний адислал, материаллаг аж байдлын адислал байж болох вэ?

Санхүүгийн аюулгүй байдал

Бид бие даах чадвартай байхын тулд мөнгөө хэрхэн зарцуулахыг мэдэх нь чухал юм. Мөнгийг үрэлгэнээр зарцуулах нь хувь хүмүүсийн болон гэр бүлийн амьдралд олон асуудал бий болгож болно.

- Бид мөнгө санхүүгийнхээ хувьд илүү бие даасан байдалтай болохын тулд юу хийж болох вэ? Мөнгө санхүүгийн хувьд бие даасан байдалтай болоход нь эцэг эхчүүд хүүхдэдээ хэрхэн зааж болох вэ?

Сүмийн Заавруудын Гарын Авлагад тайлбарлахдаа: “Сүмийн гишүүд нөөцийг эрхлэн зарцуулахад бие даах чадвартай болохын тулд аравны нэг болон өргөлийг төлж, шаардлагагүй өрөөс зайлсхийн, ирээдүйд зориулан хадгалж, амласан үүргээ биелүүлдэг байх ёстой. Гишүүд бас нөөц боломжоо арвич хямгачаар ашигладаг байх ёстой, цаг зав, нөөц боломжоо дэмий үрэхээс зайлсхийдэг байх ёстой” гэжээ (*Book 2, 258*).

- Аравны нэгийг төлөх нь нөөц боломжоо илүү үр ашигтайгаар эрхлэн зарцуулахад бидэнд хэрхэн тусалж чадах вэ?
- Бид шаардлагагүй өрөөс зайлсхийх нь яагаад чухал вэ? Өр тавихаас зайлхийх буюу өрнөөс гарахад ямар зуршил та нарт тусалсан бэ?

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли өрийн аюулын талаар сэрэмжлүүлж хэлсэн нь:

“Та бүгд үрлэг зарлагандаа үлэмж гар татуу байхыг би та нараас ихэд хичээнгүйлэн гуйж байна. Өрөөс аль болохоор зайлсхийхийн тулд худалдаж авдаг юмстаа хэрсүү ухаанаар ханд. Боломжийнхоо хэрээр өрөө түргэн төлж барагдуул. Боолчлолоос өөрсдийгөө чөлөөл. . . .

“ . . . Хэрэв та өрөө төлсөн бол, хэрэв танд өчүүхэн бага ч гэсэн нөөц бий болсон бол, аюул дэргэдүүр чинь өнгөрнө. Таны эхнэр хүүхдүүд орон байртай байна, зүрх сэтгэлд чинь амар амгалан байх болно” гэжээ (*In Conference Report, 1998 оны аравдугаар сар, 72; Ensign, 1998 оны арваннэгдүгээр сар, 54*).

3. Гачигдалтай хүмүүст анхаарал халамж тавих нь

Гачигдалтай хүмүүст анхаарал халамж тавихын чухлыг Их Эзэн Сургаал ба Гэрээнд дахин давтан онцлон тэмдэглэсэн байдаг. Дараах шүлгүүдийг ангийн гишүүдтэй хамт унш. Гачигдалтай хүмүүст анхаарал халамж тавих бидний үүргийн талаар судрын хэсэг бүр юу зааж байгааг тогтоо.

- а. С ба Г 42:30-31. (Бид эд хөрөнгөө ядуучуудад өгснөөр, үүнийг Их Эзэнд зориулдаг)
- б. С ба Г 44:6. (Бид “ядуус хийгээд гачигдагсад зочлон мөн тэднийг хөнгөвчлөхийн тулд туслах ёстой”)
- в. С ба Г 52:40. (Хэрэв бид ядуус болон гачигдагсад, өвчтэй хүмүүс болон зовж шаналагсдыг санаж байхгүй бол бид Аврагчийн шавь нар биш байдаг)
- г. С ба Г 56:16. (Хэрэв бид баян атлаа ядуустай хуваалцдаггүй бол бидний баялаг бодгалиудыг маань ялзруулна)
- д. С ба Г 88:123. (Бид бие биеэ хайрлаж, сайн мэдээ шаарддагийн дагуу бие биедээ өгөх ёстой)
- е. С ба Г 104:18. (Хэрэв бид өөрсдөдөө байгаа элбэг дэлбэг зүйлийг ядуустай хуваалцдаггүй бол ёс бусчуудын дунд тарчлалд орших болно)
- С ба Г 104:13-18-д Их Эзэн Өөрийн хүүхдүүдийн материаллаг аж байдлын хэрэгцээг хангах арга замаа тайлбарлажээ. Ядуучуудыг хангах Их

Эзэний “өөрийнх нь арга зам” юу вэ? Их Эзэнээс бид элбэг дэлбэгээр хүлээн авсан тохиолдолд бидний үүрэг юу вэ? (Иаков 2:17-19-ийг үз)

Ядуучууд болон гачигдалтай хүмүүсийг Их Эзэний “өөрийнх нь арга замаар” хангах гэдэг нь Бурханаас бид хүлээж авсан зүйлийнхээ дагуу тэдэнд өгснөөр гачигдалтай хүмүүст туслах ёстой гэсэн утгатайг тайлбарла. Энэ нь Тэнгэрлэг Эцэг бол бүх адислалын эх сурвалж бөгөөд бид бусдад үйлчлэхэд эдгээр адислалуудыг ашиглах үүрэгтэйгээ хүлээн зөвшөөрч, үнэгүйгээр, хайраар өгдөг байх ёстой гэсэн үг юм. Энэ тусламжийг хүлээн авдаг хүмүүс талархалтайгаар хүлээж авах ёстой. Тэд хэрэгцээнийхээ дутууг хангахад ашиглаж, бүрэн чадавхиараа бие даан амьдрах боломжтой болохын тулд тусламжийг ашиглах ёстой. Улмаар тэд бусдад туслах түвшинд хүрэх хэрэгтэй.

- Бид гачигдалтай бусад хүмүүст өгснөөр хэрхэн адислагддаг вэ? Хэрэгцээ гарсан үед бусад хүмүүс та нарт өгөхөд та нар хэрхэн адислагдсан бэ?

Бид гачигдалтай хүмүүст тусалж болох олон арга зам байдгийг тайлбарла. Тусламж өгч болох зохион байгуулалттай арга замаар Сүм биднийг хангадаг. Бид хувиараа эргэн тойрныхоо хүмүүст мэдэгдэлгүйгээр анхаарал халамж тавьж болно.

- Бид гачигдалтай хүмүүст тусалж болох нэг арга зам бол мацгийн өргөлөө хандивлах явдал мөн. Ядуучуудад анхаарал халамж тавихын тулд мацгийн өргөлийг хэрхэн ашигладаг вэ? (Бишоп мацгийн өргөлийг гачигдалтай хүмүүст хүнс, орон байр, хувцас хунар, бусад тусламж үзүүлэхэд ашигладаг.)
- Мацгийн өргөлөөр бид хэдий хэмжээний мөнгө хандивлах ёстой вэ? (Дараах эшлэлийг үз.) Бид мацгийн өргөлийг хандивлах нь яагаад чухал вэ?

“Сүм сар бүрийн нэг ням гарагийг мацгийн өдөр болгон тогтоосон билээ. Сүмийн гишүүд энэ өдөр дараалсан хоёр хоол, унд идэж, уудаггүй. Тэд . . . хамгийн багадаа идээгүй хоолныхоо үнэтэй тэнцэх мацгийн өргөлийг Сүмд өгдөг. Хэрэв боломжтой бол гишүүд илүү өглөгч байж, хоёр хоолны үнээс илүүг хандивлах хэрэгтэй” (Сүмийн Заавруудын Гарын Авлага, Ном 2, 256).

Мацаг болон мацгийн өргөлийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг хичээл 17-гоос үз.

Гачигдалтай хүмүүст туслахад Сүм бидэнд тусалдаг өөр нэг арга бол хүмүүнлэгийн зохион байгуулалттай тусламж юм. Сүм дэлхий даяар хүмүүнлэгийн тусламж болон бие даах чадварыг хөгжүүлэх хүч чармайлтад олон жилийн турш оролцож байна. Энэ тусламжийг ядуурал, дайн, байгалийн гамшгийн сүйрүүлэгч үр дагаврыг хөнгөвчлөхөд туслахын тулд гишүүд болон гишүүн бус хүмүүст нэгэн адил үзүүлдэг.

- Гишүүд хувиараа Сүмийн хүмүүнлэгийн тусламжийн санд хэрхэн хандив оруулж болох вэ? (Аравны нэгийн хандивын хуудсан дахь холбогдох хэсгүүдийг бөглөснөөр. Та ийм нэг хуудсыг ангийн гишүүдэд үзүүлж болно) Сүмийн хүмүүнлэгийн тусламж гачигдалтай хүмүүсийг ямар арга замаар адисалдаг вэ? Ерөнхийлөгч Томас С.Монсон Сүмийн хүмүүнлэгийн тусламжийн зарим үр дүнгийн талаар өгүүлэхдээ:

“1992 онд гамшигт хар салхи . . . Флоридагийн зүүн эргийг нэрвэж, гэр орныг орвонгоор нь эргүүлж, байшингийн дээвэр авч хаян, хүмүүсийг өлсгөлөнд оруулж, эвдрэл сүйтгэлийн хар мөрийг ардаа үлдээв. Манай гишүүд хүмүүст тусалж байлаа. Гэр орныг цэвэрлэж, үнэ хөлсгүйгээр засварлаж байв. Шашин шүтлэг, арьсны өнгөөр ялгалгүй бүх хүмүүст тусалж байлаа. . .

“Алс холын Кени Уулын баруун бэлийн толгод дахь уудам Рифт Хөндийн хөвөөнд цангасан хүмүүст цэвэр ус ирж байна. Ундны усны төсөл 1.100 гаруй гэр бүлийн амьдралыг өөрчилсөн юм. Бид цэвэр усны хэрэгцээг анх мэдэрснээр, хувийн сайн дурын байгууллага ТехноСервтэй хамтран ажиллаж, нэг төсөл санхүүжүүлэхэд туслах боломжтой болсон билээ. Тосгоныхон хөдөлмөрлөснөөр 15 тосгоныг хамарсан нутагт ус хүлээсэн айлуудад 40 орчим км-ийн цаанаас ундны ус хоолойгоор ирж байна. Найдвартай ундны усны энэхүү адислал нь ‘Намайг цангаж байхад та нар уух юм өгсөн’ [Матай 25:35]” гэсэн Их Эзэний үгсийг сануулдаг билээ (“Our Brothers’ Keepers,” *Ensign*, 1998 оны зургадугаар сар, 37).

- Сүмийн хангадаг боломжуудаас гадна бид эргэн тойрныхоо гачигдалтай хүмүүсийг адислах бусад арга хэлбэрийг эрж хайх ёстой. С ба Г 58:26-28-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Бид ядуучууд, гачигдалтай хүмүүст үйлчлэх хүч чармайлтдаа энэ судрыг хэрхэн хэрэглэж болох вэ?
- Ядуучууд, гачигдалтай хүмүүст анхаарал халамж тавихад бидэнд тохиолдог зарим саад тотгор юу вэ? Бид эдгээр саад тотгорыг яаж даван туулж болох вэ?

4. Сүмийн халамжийн хөтөлбөр

Бие даах чадварыг урамшуулан дэмжих, гачигдалтай хүмүүст туслах зохион байгуулалттай арга зам болгон Сүмийн халамжийн хөтөлбөрийг Их Эзэнээс ирсэн сүнслэг нөлөөний үр дүнд Тэргүүн Зөвлөл 1936 онд үндэслэн бий болгосныг тайлбарла. *Бидний Өв*, хуудас 127-128-аас халамжийн хөтөлбөрийг үндэслэн бий болгосон тухай илтгэхийг даалгавар авсан ангийн гишүүнээс хүс.

Сүмийн халамжийн хөтөлбөрийн зорилгыг онцлон тэмдэглэхийн тулд Тэргүүн Зөвлөлийн дараах мэдэгдлийг та хуваалцаж болно:

“Бидний үндсэн зорилго тодорхойлогдсоны хэрээр, бас үүний үр дүнд, залхуурлын зүхэл үгүй болж, ажилгүйн тэтгэмжийн хилэнц устгагдан, бие даасан байдал, ажилч хичээнгүй чанар, цэцэглэл хөгжил, өөрийгөө хүндлэх нь манай хүмүүсийн дунд эгнэгт төлөвшин бий болох боломжтой юм. Сүмийн зорилго бол өөрсдөдөө туслахад нь хүмүүст туслах явдал мөн. Манай Сүмийн гишүүдийн амьдралд ажил хөдөлмөр тэргүүлэх зарчим байх ёстой ” (In Conference Report, 1936 оны аравдугаар сар, 3).

- Эдгээр зорилгыг хэрэгжүүлэхэд Сүмийн халамжийн хөтөлбөр хэрхэн тусалдаг вэ?

Дэлхийн II Дайны дараа Европ дахь хүмүүст үзүүлсэн Сүмийн тусламж бол Сүмийн халамжийн хөтөлбөр олон хүмүүсийг адисалж чадахын сүнслэг нөлөө бүхий жишээ мөнийг тайлбарла. Европ дахь гачигдалтай хүмүүсийг халамжийн хөтөлбөр хэрхэн адисалсан тухай *Бидний Өв*, хуудас 131 дээрх сүүлчийн догол мөрөөс эхлэн хуудас 134-ийн талыг дуустал илтгэн мэдээлэхийг даалгавар авсан ангийн гишүүнээс хүс.

- Эдгээр төслүүдэд оролцсон хүмүүсийн хүч чармайлтаас юу нь та нарт гүнзгий сэтгэгдэл төрүүлэв? Бид ямар арга замаар тэдний үлгэр жишээг дагаж болох вэ?

Дүгнэлт

Бие даах чадвартай байх, ядуучууд, гачигдалтай хүмүүст анхаарал халамж тавихын ач холбогдлыг онцлон тэмдэглэ. Та эдгээр зарчмуудад дуулгавартай байснаар амьдрал чинь хэрхэн адислагдсан тухай гэрчлэлээ хуваалцахыг хүсч болно.

Нэмэлт заах санаанууд

Та зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болгож дараах санаануудаас нэгийг буюу хоёуланг нь ашиглаж болно.

1. Бие дааж амьдрах чадварт боловсрол нэн чухал

Бүхий л боломжоороо өөрсдийгөө хүмүүжүүлж, боловсруулахыг Сүмийн гишүүдэд үргэлж зөвлөдгийг хэл. Эхэн үеийн Гэгээнтнүүд боловсролоо ахиулах маш их сонирхолтой байсан юм. Солт Лейкийн Хөндийд ирсэн анхны жилд, хүүхдэд зориулсан сургууль майханд хичээллэж байжээ. Хожим нь тойрог бүр сургууль байгуулах хэрэгтэйг Сүмийн удирдагчид чиглүүлж байв. 1850 онд Дезеретийн Их Сургууль байгуулагдав. Бие даах чадварыг хөгжүүлэхэд боловсролын үнэ цэнийн тухай нэмэлт мэдээллийг хичээл 23-аас үз.

2. “Гачигдалтай хүмүүст анхаарал халамж тавих нь” видео танилцуулга

Хэрэв Teachings from the Doctrine and Covenants and Church History Video танилцуулгууд (53912) байвал, “Гачигдалтай хүмүүст анхаарал халамж тавих нь,” долоон минутын хэсгийг үзүүлэхэд анхаар.

“Хүүхдүүдийн зүрх сэтгэл эцгүүд уруугаа эргэх болно”

Зорилго

Өвөг дээдсээ эрж олон, тэдний өмнөөс санваарын ёслолууд хүлээн авах хэрэгцээг ойлгоход нь ангийн гишүүдэд туслах.

Бэлтгэл

1. Дараах судрууд болон бусад материалыг залбирч судал:
 - а. Сургаал ба Гэрээ 2; 110:13-16; 138; Иосеф Смит-Түүх 1:37-39.
 - б. *Бидний Өв*, хуудас 116-117, 119-120, 123-125.
2. Ангийн гишүүний Судлах Удирдамж (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.
3. Дараах даалгавруудыг урьдчилан өг:
 - а. *Бидний Өв*, хуудас 116-117-гоос бишоп Хенри Баллард болон охиных нь тухай түүхийг товчлон бэлтгэж ирэхийг ангийн нэг гишүүнээс хүс.
 - б. Бид гэр бүлийн түүхээ хөтөлж, хүүхдүүдээ эцэг эхчүүдтэй нь лацдан холбуулж байх тухай Ерөнхийлөгч Вилфорд Вудраффын хүлээн авсан илчлэлтийн тухай товч илтгэл бэлтгэж ирэхийг ангийн нэг гишүүнээс хүс (*Бидний Өв*, хуудас 117-гийн хоёр дахь догол мөрийг бүхэлд нь үз).
 - в. Нас барагсдын өмнөөс санваарын ёслолууд хийлгэсэн туршлагынхаа тухай товч ярихад бэлтгэхийг ангийн нэг буюу хоёр гишүүнээс хүс. Эдгээр ёслолыг тэдний өмнөөс гүйцэтгэсэн хүмүүсийн талаар ямар бодол төрснийг нь яриулахад ангийн эдгээр гишүүдийг урь.
 - г. Энэ газар “ариун сүмүүдээр тэмдэглэгдэх” цаг ирнэ гэж хэлсэн Ерөнхийлөгч Жозеф Ф.Смитийн бошиглолын талаар товч илтгэл бэлтгэхийг ангийн нэг гишүүнээс хүс (*Бидний Өв*, хуудас 125-ын эхний догол мөрийг бүхэлд нь үз).
4. Хэрэв дараах зургууд байвал хичээлийн үед ашиглахаар бэлтгэ: Гэр бүлүүдийг үүрд мөнхөд лацдан холбох хүчийг Елиа сэргээж байгаа нь (Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 417); Вилфорд Вудрафф (Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 509); Жозеф Ф.Смит (Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 511); Гордон Б.Хинкли (63001; Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 520). Ерөнхийлөгч Вудрафф, Смит, Хинкли нарын зургийг тус тусад нь үзүүлэхийн оронд та Хожмын үеийн Бошиглогчдын зургийг ашиглаж болно (62575; Сайн мэдээний Уран Зургийн Цуглуулга 506).

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

Хожмын Үеийн Гэгээнтэн номлогчид сэргээгдсэн сайн мэдээг номлож байгааг Фредерик Виллям Хөөрст анх сонсохдоо Австралид алт ухагчаар ажиллаж байжээ. Тэрээр ах Чарльзтайгаа хамт 1854 оны нэгдүгээр сард баптисм хүртэв. Гэр бүлийнхээ бусад гишүүдийг хөрвөгдөхөд нь туслахыг хичээж байсан ч, нөгөөдүүл нь түүнийг болон зааж байсан үнэнийг нь эсэргүүцдэг байв.

Фред Сүмд нэгдсэнээсээ хойш дөрвөн жилийн дараа Солт Лейк хотод шилжин суурьшсан аж. Тэгээд тэр нэлээд хэдэн оронд итгэлтэй номлогчоор үйлчилжээ. Тэр бас Солт Лейкийн Ариун сүмд зураачаар ажиллаж байв.

Тэрээр сүүлчийнхээ нэгэн тэмдэглэлд: “1893 оны гуравдугаар сарын 1-ний орчим, би зоогийн өрөөнд ганцаараа байж байлаа. Бусад маань бүгд унтсан байв. Намайг ширээндээ сууж байтал, ах Алфред маань орж ирээд, өөдөөс харж ширээнд суугаад инээмсэглэсэнд би хичнээн гайхсан гээч. “Та Ютад хэзээ ирэв ээ?” гэж би түүнээс асуув (тэр аль хэдийн энд ирсэн юм шиг харагдаж байлаа).

“Тэрээр хэлсэн нь: ‘Би дөнгөж сая Сүнсний дэлхийгээс ирлээ. Чиний харж байгаа чинь миний бие биш, цогцос минь булшинд байгаа. Сайн мэдээний тухай, бас Сүнсний дэлхий бол газар дэлхий шиг бодитой, мэдрэгдэхүйц болох тухай чи олон зүйлийг надад ярьдаг байсныг би хэлэхийг хүсч байна. Би чамд итгэдэггүй байсан. Гэвч би нас нөгчиж, тэнд очоод, чамайг үнэн хэлснийг өөрөө харлаа. Би Мормончуудын цуглаануудад оролцдог байлаа.” Тэрээр гараа өргөж, нэн их элэгсгээр хэлсэн нь: “Би бүх зүрх сэтгэлээрээ Их Эзэн Есүс Христэд итгэдэг. Итгэл, наманчлал, нүглээс ангижрахын төлөөх баптисмд би итгэдэг. Харин энэ бол миний хийж чадах зүйлүүд. Ариун сүмд миний өмнөөс ажил хийхийг чинь би харсан. . . Чи их ойрхон харагдаж байсан шүү. . . Чамайг энэ агуу ажлын тэргүүнд бидний өмнөөс байгааг бүгд бүгдээрээ харсан. Энд Сүмд байгаа төрөл төрөгсөд нь хайхрамжгүй, тэдний төлөө юу ч хийдэггүй, олон агуу сүнс уйлж, гашуудан байгааг би чамд хэлэхийг хүсч байна” (*Diary of Frederick William Hurst*, түүвэрлэсэн Самуел Х.Хөөрст, Айда Хөөрст [1961], 204).

Дөрвөн Бошиглогч: Елиа, Ерөнхийлөгч Вилфорд Вудрафф, Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит, Ерөнхийлөгч Гордон Б.Хинклийн ажлыг товч судалснаар та нар энэ хичээлээр нас барагсдын гэтэлгэлийн тухай ярилцана гэдгийг тайлбарла. Энэ хичээлийн зорилго бол нас барагсдыг гэтэлгэх хэрэгцээний тухай илүү сайн ойлголттой болох явдал мөн. Бид ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажилд оролцож болох зарим арга хэлбэрийг дараагийн хичээлээр ярилцана.

Ярилцах ба
хэрэгжүүлэх нь

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбиран сонгож ав. Судрын зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Елиа: “Энэ эрин үеийн түлхүүрүүд та нарын гарт итгэмжлэгдсэн юм”

С ба Г 2; 110:13-16; 138:47-48; Иосеф Смит-Түүх 1:37-39-ийг зааж, ярилц. Санваарын лацдах хүчийг сэргээж байгаа Елиагийн зургийг үзүүл .

- Тэнгэр элч Моронай Иосеф Смит дээр хүрч ирэхдээ, “эцгүүдэд нь хийгдсэн амлалтуудыг хүүхдүүдийнх нь зүрх сэтгэлд Елиа суулгана” гэж хэлжээ (С ба Г 2:2; Иосеф аль хэдийн 1:39). Энэ бошиглолд, эцгүүд гэдэг

үг бидний өвөг дээдсийг хэлж байгаа болно. Бидний өвөг дээдэст ямар амлалтууд хийгдсэн бэ?

Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит сургасан нь: “Хүүхдүүдийн зүрх сэтгэлийг эцгүүд рүү нь эргүүлснээр хожмын өдрүүдэд гүйцэлдэх ямар амлалт хийгдсэн юм бэ? Энэ бол Енох, Исаиа, мөн бошиглогчдоор дамжуулан дэлхийн үндэстнүүдэд Их Эзэний хийсэн, *нас барагсад гэтэлгэгдэх цаг ирэх ёстой*” гэсэн амлалт юм (*Doctrines of Salvation*, эмхтгэсэн Брус Р.МкКонки, боть 3, [1954-1956], 2:154).

Арванхоёрын Чуулгын Ахлагч Жефффри Р.Холланд, “Эртний патриархууд Адам, Ноа, Абрахам, Исаак, Иаков, бас бусад хүмүүст Бурхан эдгээр амлалтуудыг хийсэн юм. Сайн мэдээ сэргээгдэхээс өмнө дэлхийд ирсэн тэднийг бид эргэлзэж тээнгэлзэлгүйгээр өөрсдийн шууд эцэг, эхчүүдээ болгосон билээ. Бид тэдний төлөө сайн мэдээний аврагч ёслолуудыг хийхээр амласан юм” гэж хэлжээ (*Jesus and the New Covenant* [1997], 297).

- 1836 оны дөрөвдүгээр сарын 3-нд Кертландын Ариун сүмд, Бошиглогч Елиа Бошиглогч Иосеф Смит Оливер Каудери хоёр дээр хүрч ирсэн юм. Елиа Иосеф, Оливер хоёр дээр хүрч ирсний зорилго юу вэ? (С ба Г 110:13-16; мөн С ба Г 2; Иосеф Смит-Түүх 1:38-39-ийг үз. Тэрээр санваарын лацдалтын хүчийг Иосеф Смитэд олгожээ. Энэхүү хүч мөнхийн гэрлэлт, эцэг эхчүүдийг лацдан холбох, нас барагсдын төлөөх ариун сүмийн ёслолын ажлыг боломжтой болгосон юм)
- Иосеф Смит-Түүх 1:37-39; С ба Г 138:47-48-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Хэрэв бидэнд лацдалтын хүч байхгүй бол дэлхий яагаад “ [Их Эзэний] ирэлтээр бүрмөсөн арчигдаж” болох вэ? (Дэлхий дээрх амьдралын нэг гол зорилго бол мөнхийн гэр бүлийн харилцааг үндэслэн бий болгох явдал мөн. Лацдалтын хүчгүйгээр энэ нь боломжгүй юм)

Лацидалтын хүчгүйгээр “гэр бүлийн хэлхээ холбоо үүрд мөнхөд оршихгүй, хүмүүний гэр бүл чухамдаа үүрд мөнхөд ‘үндэс ч үгүй [өвөг дээдэс], мөчир ч үгүй [үр удам] үлдэх байсан.’ Чухам иймээс. . . лацдан холбогдсон, нэгдсэн, селестиел маягаар аврагдсан Бурханы гэр бүл бол мөнх бус байдлын туйлын зорилго юм. Энэ зорилгыг аливаа байдлаар хөсөрдүүлэх нь авралын төлөвлөгөөг бүхэлд нь “бүрмөсөн нураахад” хүргэнэ” гэж Ахлагч Жефффри Р.Холланд хэлжээ. (*Jesus and the New Covenant*, 297-298).

2. Ерөнхийлөгч Вилфорд Вудрафф: “Хэн нэгэн нь тэднийг гэтэлгэсэн юм”

Ерөнхийлөгч Вилфорд Вудраффын зургийг үзүүл. Нас барагсдыг гэтэлгэх болон гэр бүлийг үүрд мөнхөд лацдан холбох ажилд Ерөнхийлөгч Вудрафф бие сэтгэл бүхнээ зориулсныг тайлбарла. Түүний үйлчлэлийн үед Сүмийн олон гишүүн удмын бичгийн номлолд үйлчилж, улмаар Тэргүүн Зөвлөл 1894 онд удмын бичгийн нийгэмлэгийг зохион байгуулах ажлыг удирджээ (*Бидний Өв*, хуудас 119). Арванхоёрын Чуулгын Ахлагч Рассел М.Нелсонгийн өгүүлснээр, “түүхэн тэр жилийн [1894 оны] үйл явдлууд гэр бүлийн түүхийн судалгаа, Ариун сүмийн үйлчлэлийг Сүм дэх *нэг ажил* болгон үндэслэсэн юм” (In Conference Report, 1994 оны аравдугаар сар, 114; *Ensign*, 1994 оны арваннэгдүгээр сар, 85).

Нас барагсдын төлөөх ариун сүмийн ажлын тулгамдсан хэрэгцээний тухай, эцэг эх, өвөг дээдэстэйгээ лацдан холбуулах бидний хэрэгцээний тухай заахад дараах болсон явдлуудыг ашигла.

Нас барагсдын төлөөх Ариун сүмийн ажлын тулгамдсан хэрэгцээ

Бидний Өв, хуудас 116-117-гоос бишоп Хенри Баллард болон охиных нь тухай болсон явдлыг нэгтгэн дүгнэхийг даалгавар авсан ангийн гишүүнээс хүс.

Ерөнхийлөгч Вудрафф Ютагийн Сейнт Жорж дахь Ариун сүмийн ерөнхийлөгчөөр хэсэгхэн хугацаанд үйлчилж байсныг тайлбарла. Энэ эрин үед нас барагсдын өмнөөс ариун сүмийн хишиг хүртээлтийг анх удаа энэ ариун сүмд гүйцэтгэсэн юм (*Doctrines of Salvation*, 2:171-ийг үз). Ерөнхийлөгч Вудрафф тэнд үйлчилж байхдаа нас барсан олон “алдартай хүний” сүнсээр зочлогджээ. Ерөнхийлөгч Вудраффын өгүүлсэн дараах шастирыг хуваалцахад ангийн нэг гишүүнийг урь:

“Нас барагсдын сүнснүүд миний эргэн тойронд цуглаж, бид яагаад тэднийг гэтэлгэхгүй байгааг мэдэхийг хүсч байлаа. ‘Та нар Хишигийн Ордонг хэдэн жил ашигласан атлаа бидний төлөө юу ч хийсэнгүй. Та нарыг эдүгээ удирдаж байгаа төр засгийн үндэс суурийг бид тавьсан юм шүү дээ . . . Бид төр засагтаа үнэнч хэвээр үлдэж, Бурханд итгэлтэй байсан’ хэмээн тэд хэлэв. Тэд бол Тусгаар Тогтнолын Тунхагт [Америкийн Нэгдсэн Улсын] гарын үсэг зурагчид байлаа. Тэд намайг хоёр өдөр, хоёр шөнө хүлээв. . . Би баптисмын сан руу шууд очиж, Тусгаар Тогтнолын Тунхагт гарын үсэг зурагчдын өмнөөс бас алдар цуутай бусад тавин хүн, бүгд нийлээд нэг зуун хүн, түүний дотор Жон Весли, Колумб, бусад хүмүүсийн өмнөөс надад баптисм хүртээнэ үү гэж МкАллистер ахыг дуудаж билээ” (*The Discourses of Wilford Woodruff*, эмхэтгэсэн Г.Хомер Дурхам [1946], 160-161).

- Бид энэ хоёр түүхээс юу сурч болох вэ? (Нас барсан хүмүүс өөрсдийнхөө төлөө ёслол гүйцэтгэхийг биднээс хүсэн хүлээж байдаг. Бид нас барагсдыг гэтэлгэх хүч ажилд нягт хичээнгүй байх хэрэгтэй нь хариулт байж болно)

Ахлагч Вилфорд Вудрафф Арванхоёрын Чуулгад үйлчилж байхдаа: “Нэгэн цагт амьдарч байсан ч талийгаач болсон хүмүүс, сүнсний дэлхийд орох хүртлээ сүнсээр нөлөөлөгдсөн хүний дуу хоолойг, сайн мэдээний номлолыг сүүлийн мянга найман зуун жилийн туршид огт сонсож байсангүй. Тэдний өмнөөс ийм ёслолыг махбодод байгаа хэн нэг нь гүйцэтгэсэнээр тэднийг гэтэлгэх ёстой. Учир нь сүнс хэлбэрээр байгаа тэд ёслолыг өөрсдийнхөө төлөө гүйцэтгэж чадахгүй. Иймээс энэ ажлыг хийхийн тулд Ариун сүмүүд бидэнд байх ёстой” хэмээн сургажээ (in *Journal of Discourses*, 19:228-229).

Эцэг эх болон өвөг дээдэстэйгээ лацдан холбуулах бидний хэрэгцээ

Бид гэр бүлийн түүхээ хөтөлж, хүүхдүүдээ эцэг эхтэй нь лацдан холбуулж байх талаар Ерөнхийлөгч Вудраффын хүлээн авсан илчлэлтийн тухай мэдээлэхийг даалгавар авсан ангийн гишүүнээс хүс (*Бидний Өв*, хуудас 116-117).

- Энэ илчлэлт гэр бүлийн талаар юу заадаг вэ? Хүүхдүүдийн зүрх сэтгэлийг эцгүүд рүү нь эргүүлэх тухай бошиглолыг хэрэгжүүлэхэд уг илчлэлт хэрхэн тусалдаг вэ?

3. Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит: “Ойлголтын мэлмий минь нээгдэв”

Ерөнхийлөгч Вудраффын дараах мэдэгдлийг унших буюу өөрийнхөө үгсээр хуваалц:

“Ерөнхийлөгч Иосеф Смитийг залгамжилсан Ерөнхийлөгч [Бригам] Янг . . . Израилын уулс дахь бусад ариун сүмийн хамт [Солт Лейкийн Ариун сүмийн] суурийг тавьсан юм. Яах гэж тэр вэ? Бид нас барагсдын гэтэлгэлийн зарчмуудыг хэрэгжүүлж болохын төлөө. Бурхан гараас нь шаардсан бүхнийг тэрээр биелүүлсэн юм. Гэвч тэрээр энэ ажилд хамаарах бүх илчлэлтийг хүлээж аваагүй билээ; Wilford Woodruff, 153-154).

Ерөнхийлөгч Жозеф Ф.Смитийн зургийг үзүүл. Сүмийн зургаа дахь Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Смит нас барагсдыг гэтэлгэх ажлыг үргэлжлүүлэхэд тусалсан нэг илчлэлт хүлээн авсныг тайлбарла. 1918 оны аравдугаар сарын 4-нд, нас барахаасаа өмнө ердөө хэдхэн долоо хоногийн өмнө тэрээр ерөнхий чуулган дээр хэлэхдээ:

“Миний бие сүүлийн таван сарыг нэн хүнд өвчинд ороогдож өнгөрүүлээ. . . Энэ таван сард би ганцаараа байсангүй. Залбирал, даруухан залбирал, итгэл бишрэл болон шийдвэр төгс байдлын сүнсэнд байлаа би. Мөн Их Эзэний Сүнстэй байнгын харилцаатай байлаа би” гэжээ (In Conference Report, 1918 оны аравдугаар сар, 2).

Ерөнхийлөгч Смит энэ мэдэгдлийг хийхийн өмнөх өдөр, нас барагсдын гэтэлгэлийн талаарх Гэгээнтнүүдийн ойлголтыг өргөжүүлсэн нэг илчлэлт хүлээн авчээ. Энэ илчлэлт бол эдүгээ Сургаал ба Гэрээний хэсэг 138 юм. Энэ бол Түүний цогцос булшинд байх үеэр Аврагч Сүнсний дэлхийд зочилсон тухай цэдэг юм.

- Ерөнхийлөгч Смит нас барагсдын гэтэлгэлийн тухай үзэгдэл хүлээн авсан үедээ юу хийж байсан бэ? (С ба Г 138:1-11-ийг үз. Тэрээр судруудыг бас Есүс Христийн Цагаатгалыг тунгаан бодож байв. Тэрээр тунгаан бодож байхдаа мөнх бус байдлын дараах сүнсний дэлхий дэх Есүсийн үйлчлэлийн тухай мэдээлэл байдаг 1 Петр 3, 4-ийг уншихад хөтлөгдсөн ажээ)
- С ба Г 138:12-19-ийг ангийн гишүүдтэй хамт унш. Сүнсний дэлхийд Аврагч ямар сүнснүүд дээр очсон бэ? (Доор жагсаасан зүйлс хариулт байж болно. Та хариултыг самбар дээр дээр нэгтгэн дүгнэхийг хүсч болно)

Аврагч дараах сүнснүүд дээр очжээ:

- а. “Мөнх бус байдалд амьдарч байхдаа Есүсийн тухай гэрчлэлд итгэлтэй байсан” (С ба Г 138:12) хүмүүсийн сүнс.
- б. “Бурханы Хүүгийн аугаа золиослолтой адил төстэй золиослол хийсэн” (С ба Г 138:13) хүмүүсийн сүнс.
- в. “Гэтэлгэгчийнхээ нэрээр гай зовлон амссан хүмүүс” (С ба Г 138:13)-ийн сүнс.
- г. “Бурхан Эцэг болон түүний Түүний Төрсөн Ганц Хүү, Есүс Христийн ач ивээлээр дамжсан, алдар суут амилуулалтад бат найдан, мөнх бус амьдралыг орхисон” (С ба Г 138:14) хүмүүсийн сүнс.
- д. “Баясал болон баяр хөөрөөр дүүрсэн, мөн тэдний чөлөөлөлтийн өдөр ойрхон байсны улмаас хамтдаа баясан цэнгэж байсан” (С ба Г 138:15) сүнснүүд.

- Ямар сүнснүүд дээр Аврагч *очоогүй* вэ? (С ба Г 138:20-21-ийг үз.) “Үнэний тухай мэдлэггүйгээр нүгэлдээ нас барсан хүмүүст” сайн мэдээг номлож болохын тулд Аврагч юу хийсэн бэ? (С ба Г 138:27-37-г үз. Тэрээр зөв шударга сүнснүүдийг зохион байгуулж, сайн мэдээг хараахан хүлээн аваагүй сүнснүүдэд заах итгэмжлэлийг тэдэнд олгожээ.) Өнөөдөр Сүнсний дэлхийд сайн мэдээг хэн заадаг вэ? (С ба Г 138:57-г үз.)
- С ба Г 138:22-24, 57-59-ийг ангийн гишүүдтэй хамт унш. Сүнсний дэлхийд Есүсийн тухай гэрчлэлд итгэлтэй байсан сүнснүүд, итгэлгүй байсан сүнснүүдийн ялгааг олохыг тэднээс хүс. Сүнсний дэлхийд сайн мэдээг заахын ач холбогдлын талаар эдгээр шүлгүүд юу зааж байна вэ? Нас барагсдын өмнөөс санваарын ёслол хийлгэх хариуцлагыг тань эдгээр шүлгүүд та нарт хэрхэн мэдрүүлдэг вэ?

Нас барагсдын өмнөөс ёслол хийлгэсэн туршлага, төрсөн бодлынх нь талаар товчхон ярихыг даалгавар авсан ангийн гишүүдээс хүс (“Бэлтгэл,” зүйл 3в-г үз).

4. Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли: “Бид Ариун сүмүүдийг хүмүүст хүргэхээр . . . шийдээд байна”

Энэ газар “ариун сүмүүдээр тэмдэглэгдэх” (*Бидний Өв*, хуудас 125) цаг ирнэ гэсэн Ерөнхийлөгч Жозеф Ф.Смитийн бошиглолын талаар илтгэхийг даалгавар авсан ангийн гишүүнээс хүс.

Ерөнхийлөгч Гордон Б.Хинклийн зургийг үзүүл. Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли бол ариун сүмийн ажлын тухай бидний ойлголтыг өргөжүүлсэн бошиглогч гэдгийг тайлбарла. Түүнийг 1995 онд Сүмийн Ерөнхийлөгч болоход үйл ажиллагаа явуулдаг 47 ариун сүм байв. Хоёр жил хагасын дараа тэрээр дараах мэдэгдлийг хийжээ:

“Гишүүнчлэл нь цөөхөн, ойрын ирээдүйд төдийлөн ихээр өсөх төлөвгүй, алслагдсан бөглүү олон бүс Сүмд байдаг. Эдгээр бүсүүдэд аж төрдөг хүмүүс Ариун сүмийн ёслолоос ирдэг адислалыг үүрд хүртэхгүй хэвээр байх хэрэг үү? Хэдхэн сарын өмнө бид ийм нэг газарт очсон үеэрээ залбирч, энэ асуудлыг бүхэлд нь тунгаан бодсон билээ. Хариу нь тод томруунаар ирсэн гэдэгт бид итгэдэг.

“Эдгээр бүсийн заримд нь бид жижиг Ариун сүмүүдийг ёслолыг бүгдийг нь гүйцэтгэх бүх барилга байгууламжийн хамтаар барих болно. Эдгээр барилгыг цуглааны байрны стандартаас илүү өндөр ариун сүмийн стандартын дагуу барина. Жижиг Ариун сүмд нас барагсдын өмнөөс хийх баптисм, хишиг хүртээх үйлчлэл, лацдан холболт, түүнчлэн амьд байгаа хүмүүс, нас барагсдын аль алиных нь төлөө Их Эзэний өргөөнд гүйцэтгэгдэх ёстой бусад бүх ёслол хийгдэх болно. . . .

“ . . . Бид Ариун сүмүүдийг хүмүүст хүргэж, Ариун сүмийн шүтээнээс ирдэг нэн үнэ цэнэтэй бүх адислалыг тэдэнд хүртээмжтэй болгохоор. . . шийдээд байна” (In Conference Report, 1997 оны аравдугаар сар, 68-69; *Ensign*, 1997 оны арваннэгдүгээр сар, 49-50).

Энэ зууны эцэс гэхэд үйл ажиллагаа явуулдаг, 100 Ариун сүмтэй болох зорилгыг Ерөнхийлөгч Хинкли 1998 оны дөрөвдүгээр сард зарласан билээ (Conference Report, 1998 оны 4-р сар, 115; *Ensign*, 1998 оны 5-р сар, 88-ыг үз).

- Ариун сүмийн барилга өсөн нэмэгдсэн нь та нарт хэрхэн нөлөөлж байна? Энэ нь таньдаг хүмүүст чинь хэрхэн нөлөөлж байна вэ? (Хэрэв Ариун сүмүүд барих ажлыг хурдасгах тухай илчлэлтийг Ерөнхийлөгч Хинкли хүлээн аваагүй бол хэчнээн олон хүмүүс Ариун сүмийн адислалыг хүртэх боломжгүй байх байсныг та хэлж болно) Ариун сүм барих ажлыг хурдасгасан нь сайн мэдээг хүлээн авалгүйгээр нас барсан хүмүүст хэрхэн нөлөөлөх вэ?

Дүгнэлт

Өнөөдөр бидний хийж байгаа шиг ийм ихийг хийх боломж түүхэн дэх хүмүүст урьд өмнө нь хэзээ ч байгаагүйг онцлон тэмдэглэ. Ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажилд оролцох арга замын тухай дараагийн хичээлээр ярилцана гэдгийг тайлбарла. Сүнсээр чиглүүлэгдсэний дагуу, Ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажлын ач холбогдлын тухай гэрчил.

Нэмэлт заах санаа

Та зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмж дараах санааг ашиглаж болох юм.

Ариун сүмийн ажил дахь залуучуудын оролцоо

Хэрэв та залуучуудад заадаг бол нас барагсдын өмнөөс баптисм хүртэх замаар ариун сүмийн ажилд оролцоход нь тэднийг урамшуулан дэмж. Хэрэв та насанд хүрэгчдэд заадаг бол ариун сүмийн ажилд оролцоход нь эцэг эхчүүд хүүхэддээ тусалдаг байхыг зөвлөмж болго. Далын Ахлагч Ж.Баллард Вошбөөрнийн өгүүлсэн дараах болсон явдлыг хуваалцахад анхаар:

“Би гадасны чуулганы дараа өсвөр насны хүүхдүүдтэй нэг гэр бүлтэй ярилцаж байлаа. Би хүүхдүүдэд хандан, “Та нар нэг л мэдэхэд аав ээжтэйгээ хамт ариун сүмд явж чадахаар зөв шударга амьдрах хэрэгтэй” гэв. Арван зургаан настай нэг охин, “Өө, бид ариун сүмд аав ээжтэйгээ бараг долоо хоног бүр явна. Бид очоод, гэр бүлийнхээ файлын нэрсээр баптисмууд хийнэ” гэж хариулав. *Гэр бүл Ариун сүмд хамтдаа явах нь мөн ч сайхан зүйл шүү*” гэж би бодож билээ (In Conference Report, 1995 оны 4-р сар, 12; *Ensign*, 1995 оны 5-р сар, 11).

- Ариун сүмүүдэд хийгддэг ажилд өөр ямар арга замаар залуучууд тусалж болох вэ? (Тэд гэр бүлийн түүхийн судалгаа хийж, ариун сүмд явах эцэг эхийнхээ хүч чармайлтад дэмжлэг үзүүлэх нь хариулт байж болно)

Ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажилд баяр баяслыг олох нь

Хичээл
40

Зорилго

Ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажилд оролцож болох олон янзын арга хэлбэрийг олж харахад нь ангийн гишүүдэд туслах. Эдүгээ тэдний оролцох арга хэлбэрийг бүрэн тогтоохын тулд залбирахад нь тэднийг урамшуулан дэмжих.

Бэлтгэл

1. *Ангийн гишүүний Судлах Удирдамж* (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.
2. Ирэх долоо хоногт Ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажилд ямар нэг хэлбэрээр оролцохыг ангийн хоёр гишүүнээс долоо хоногийн өмнө хүс. Энэ ажлыг хийх олон арга зам байдгийг ойлгоход нь тэдэнд тусал. Жишээ нь, тэд гэр бүлийн цэдгийг гүйцээх, өвөг дээдсийнхээ нэрсийг ариун сүмийн ёслол хийлгэхээр явуулах, Ариун сүмд орох, өдрийн тэмдэглэл буюу хувийнхаа түүхийг хөтөлж болно, өвөг дээдсийнх нь тухай хүүхдэд зааж болно. Хичээлийн нэг хэсэг болгон туршлагынхаа талаар ярихаар бэлтгэхэд тэднийг урь.
3. Ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажилд зориулан Сүмээс гаргасан зарим эх сурвалжийн хувиудыг олж авахыг та хүсч болно. Ингэснээр та тэдгээр эх сурвалж материалуудыг хичээлийн гурав дахь хэсэгт үзүүлж болно (хуудас 270-г үз). Хэрэв танай тойрог буюу салбар гэр бүлийн түүхийн зөвлөхтэй бол эдгээр эх сурвалжуудын талаар товч танилцуулга бэлтгэхийг та түүнээс хүсч болно.

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа

Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

Самбарын гол дунд өөрийнхөө нэрийг бич. Самбарын бусад хэсэгт эцэг эх, зарим өвөг дээдэс, хэрэв та эцэг, эх бол, хүүхдүүдийнхээ нэрсийг бич. Нэрийг нь бичсэн хүн бүр таны юу болох, ямар хамаатай болохыг ангийн гишүүдэд товчхон ярь.

Эдгээр хүмүүсийн зарим нь бие биеэсээ түр хугацаагаар салж хагацдаг хэлбэрүүдийг тайлбарла. Жишээ нь, зарим нь нас барсны улмаас салдаг. Зарим нь өөр газарт амьдардаг учраас салж болно.

Гэр бүлийн гишүүд түр хугацаагаар саллаа ч гэсэн, тэд үүрд мөнхөд нэгдэж чадна гэдгийг хэл. Тэдний зүрх сэтгэл бие биедээ тэмүүлдэг (С ба Г 110:14-15).

Ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажилд бидний оролцож болох арга хэлбэрийг энэ хичээлээр ярилцдагийг тайлбарла. Бид энэ ажилд оролцсоноор,

мөнхийн гэр бүлийн нэг хэсэг байх нь ямар учир холбогдолтойг ухаарах илүү агуу ойлголттой болдог. Бидний зүрх сэтгэл өвөг дээдэс рүүгээ хандаж, тэдний зүрх сэтгэл бидэн рүү ханддаг. Мөн эцэг эх, үр хүүхдийн зүрх сэтгэл бие бие рүүгээ ханддаг.

Ярилцах ба
хэрэгжүүлэх нь

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбиран сонгож ав. Ярилцаж байгаа зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Энэ хичээл бол ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажлын тухай хоёр хичээлийн хоёр дахь нь гэдгийг ангийн гишүүдэд сануул. Ариун сүмд орж, санваарын ёслолыг хүлээн авалгүйгээр нас барсан хүмүүсийн өмнөөс эдгээр ёслолуудыг гүйцэтгэх хэрэгцээний тухай хичээл 39 дээр ярилцсан билээ. Ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажилд бидний оролцож болох бусад зарим арга замыг энэ хичээлээр ярилцана.

1. Елиагийн сүнс зүрх сэтгэлээ өвөг дээдэс рүүгээ эргүүлэхэд хүмүүсийг өдөөж байна

Елиагийн Сүнсний тухай Хожмын үеийн Гэгээнтнүүд олонтаа ярилцдагийг тайлбарла. Энэ нийлэмж үг “Эцгүүдийн зүрх сэтгэлийг хүүхдүүд рүү нь, мөн хүүхдүүдийнхийг эцгүүд рүү нь эргүүлэх” (С ба Г 110:15) хүмүүсийн хүслийг заадаг. Санваарын лацдан холболтын түлхүүрүүдийг Елиа Иосеф Смитэд сэргээсэн учраас бид үүнийг Елиагийн Сүнс (С ба Г 110:13-16) гэж нэрлэдэг. Энэ хүчээр дамжуулан, гэр бүлийг үүрд мөнхөд нэгтгэдэг лацдан холбох ёслолуудыг гүйцэтгэж болно.

- Елиагийн Сүнс Сүмийн гишүүдэд юу хийхэд нь нөлөөлдөг вэ? (Өөрсдийнхөө төлөө Ариун сүмийн ёслол хүлээн авах, гэр бүлийн түүхийн судалгаа хийх, ариун сүмд орж, нас барагсдын өмнөөс санваарын ёслолууд хийлгэхэд Елиагийн сүнс биднийг өдөөдөг нь хариулт байж болно. Дараах эшлэлийг мөн үз) Елиагийн Сүнсээр нөлөөлөгдлөө гэж бодсон үед чинь ямар туршлага та нарт тохиолдсон бэ?

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли: “Манай гэр бүлийн түүхийн өргөн цар хүрээтэй хүч чармайлт ариун сүмийн ажилд чиглэгддэг. Үүнээс өөр зорилго гэж үгүй. Ариун сүмийн ёслол бол Сүмийн санал болгодог адислалуудын дээд оргил нь юм” хэмээн онцлон тэмдэглэжээ (In Conference Report, 1998 оны 4-р сар, 115-116; *Ensign*, 1998 оны 5-р сар, 88).

- Елиагийн Сүнс ямар зүйлийг дэлхий даяар хийхэд хүмүүсийг удирддаг вэ? (Удмын судалгаа дэлхий даяар хүмүүсийн сонирхдог зүйл болсон, технологийн дэвшил удмын судалгааг улам амар хялбар, хүртээмжтэй болгож байгаа нь хариулт байж болно.)

2. Сүмийн гишүүн бүр Ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажилд оролцож чадна

Өнгөрсөн долоо хоног дахь ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажлын туршлагынхаа талаар товч ярихыг даалгавар авсан ангийн гишүүдэдээ хүс (“Бэлтгэл,” зүйл 2-ыг үз).

Ангийн эдгээр гишүүд туршлагаа хуваалцсаны дараа Арванхоёрын Чуулгын Ерөнхийлөгч Боид К.Пакерын дараах үгсийг унш:

“Ариун сүмийн ажил болон энэ ажилд дэмждэг үзүүлдэг удмын судалгаанаас илүүгээр хүнийг хамгаалдаг ажил энэ Сүмд үгүй. Сүнслэг байдлын хувьд илүү ихээр цэвэршүүлдэг ажил гэж үгүй. Үүнээс илүүгээр хүчийг бидэнд өгдөг ажил гэж үгүй” (“Temple,” *Ensign*, 1995 оны 2-р сар, 36).

- Сүнслэг байдлын сайжралт болон бурханлиг хүч өсөн нэмэгдсэнийг мэдрэхэд ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажил та нарт хэрхэн тусалсан бэ?

Ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажилд бид бүгд насан туршдаа ямар нэг хэлбэрээр оролцож чадна гэдгийг хэл. Арванхоёрын Чуулгын Ахлагч Даллин Х.Өүкс хэлсэн нь: “Нас барагсдыг гэтэлгэх ажилд олон зорилт байдаг. Мөн . . . бүх гишүүд хувийнхаа нөхцөл байдал, тодорхой цаг үед тохирох арга хэлбэрийг сонгоход залбирч оролцох ёстой. . . . Бидний хүч чармайлт бол бүх зүйлийг хийхэд хүн бүрийг албадан шахах биш, харин ямар нэг зүйлийг хийхэд хүн бүрийг урамшуулан дэмжих явдал мөн” (“Family History: ‘In Wisdom and Order,’ ” *Ensign*, 1989 оны зургадугаар сар, 6).

- Ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажилд оролцохын тулд та нарын хийсэн зарим зүйл юу вэ? (Ангийн гишүүдийн хариултыг самбар дээр бич. Ярилцах буюу хариулт дээр нэмэхийн тулд дараах мэдээллийг ашигла. Хэрэв та насанд хүрэгчдэд заадаг бол, амьдралынхаа янз бүрийн шатанд ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажилд хэрхэн оролцож байсныг нь та тэднээс асууж болно.)

Ариун сүмийн хүчинтэй зөвшөөрлийн бичигтэй байж, Ариун сүмд тогтмол орж бай

Ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажилд бид оролцож болох нэг хэлбэр бол ариун сүмийн хүчинтэй зөвшөөрлийн бичигтэй байж, боломжийнхоо хэрээр Ариун сүмд аль болох олон удаа орж байх явдал мөн. Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлсэн нь:

“Ариун сүмийн зөвшөөрлийн бичигтэй байхаар зохистой амьдарч, энэхүү зөвшөөрлийн бичгийг үнэт эд хөрөнгө лүгээ адил эрхэмлэн, Их Эзэний өргөөнд очиж, тэндэх Сүнс болон адислалаас хүртэхэд илүү их хүч чармайлт гаргахыг миний бие чадлынхаа хэрээр, бүхий л үнэмшүүлэл сэнхрүүлээр, орон бүр дэх манай хүмүүст ихэд хичээнгүйлэн уриалж байна. Ариун сүмд ордог эрэгтэй, эмэгтэй хүн бүр Их Эзэний өргөөнөөс гарч явахдаа чин сэтгэлийн хийгээд итгэл бишрэлийн сүнстэй, илүү сайн хүн болсон байдагт би сэтгэл хангалуун явдаг. Бид бүгдийн амьдралд байнгын сайжралт хэрэгтэй. Дэлхийн дуу шуугиан, хөл үймээнийг үе үе орхиж, Түүний Сүнсийг ариун, амар амгалангийн орчинд мэдрэхийн төлөө Бурханы ариун өргөөний ханануудын дотор алхан орох хэрэгцээ байдаг” (In Conference Report, 1995 оны аравдугаар сар, 72; *Ensign*, 1995 оны арваннэгдүгээр сар, 53).

Ариун сүмд тогтмол орох боломжийг нөхцөл байдал маань олгохгүй байлаа ч гэсэн, бид ариун сүмийн зөвшөөрлийн бичигтэй байх ёстойг хэл. Ерөнхийлөгч Ховард В.Хантер хэлсэн нь: “Хэрэв насанд хүрсэн гишүүн бүр ариун сүмийн зөвшөөрлийн бичигтэй байхаар зохистой амьдарч, ийм бичигтэй байх юм бол Их Эзэн үүнд баярлана Ариун сүмийн зөвшөөрлийн бичигтэй байхуйц зохистой амьдрахын тулд бидний хийх ёстой зүйл, хийх ёсгүй зүйл нь биднийг хувь хүмүүсийн хувьд ч гэр бүлийн хувьд ч аз

жаргалтай болгох зүйлс байдаг” (In Conference Report, 1994 оны аравдугаар сар, 8; *Ensign*, 1994 оны арваннэгдүгээр сар, 8).

- Ариун сүмийн зөвшөөрлийн бичгээр болон Ариун сүмд орохоор дамжуулан бид ямар адислал хүлээн авч болох вэ?
- Ариун сүмийн ач холбогдлын тухай эцэг эхчүүд хүүхэддээ хэрхэн зааж болох вэ? (Эцэг эхчүүд Ариун сүмд тогтмол орох буюу ариун сүмд орох талаар идэвхтэй ажиллах, Ариун сүмийн тухай хүүхдүүддээ заах болон Ариун сүмээр дамжуулан бидний хүлээж авдаг адислалын тухай гэрчлэх, нас барагсдын өмнөөс баптисм хийлгэхийн тулд 12 болон түүнээс дээш настай хүүхдүүдээ Ариун сүм рүү дагуулж явах нь хариулт байж болно)

Нас барсан төрөл төрөгсдийнхөө төлөө ёслол гүйцэтгэхэд бэлтгэх нь

Ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажилд бид оролцож болох өөр нэг арга зам бол нас барсан төрөл төрөгсдийнхөө төлөө ёслол гүйцэтгэхэд бэлтгэх явдал гэдгийг тайлбарла. Гэр бүл дэх бусад хүмүүс гэр бүлийн түүхээр ажиллаж байлаа ч гэсэн, тэдний төлөө Ариун сүмийн ёслол гүйцэтгэх хэрэгтэй байгаа нас барсан төрөл садангийн хүмүүс бидэнд олон байдаг.

Бид нас барсан төрөл төрөгсдөө тогтоосноор энэ ажлыг эхэлдэг. Бид гэр бүлийн цэдгүүдийг шүүж үзэх, бусад өвөг дээдсийнхээ тухай ярьж өгөхийг эцэг эх, эмээ өвөө нар, гэр бүлийн бусад гишүүдээс хүсэх замаар санах ёстой хүмүүсийн жагсаалтыг гаргаж болно. Сүмээс эрхлэн гаргасан компьютерийн программуудыг бид энэ ажилд туслалцаа авахын тулд гэр орондоо болон Гэр Бүлийн Түүхийн Төвүүдэд ашиглаж болно. Өвөг дээдсээ тогтооход Сүнсний хүчирхэг нөлөө бидэнд тусалдгийг онцлон тэмдэглэ. Бид итгэлээ ашигласан үед нэрс болон мэдээлэл хүсэн хүлээгээгүй арга замаар, хүсэн хүлээгээгүй газраас бидэнд ирж болно.

Бид өвөг дээдсийнхээ тухай мэдсэнээр, олж авсан мэдээллээ удмын схем, гэр бүлийн цэдэг зэрэг гэр бүлийн түүхийн маягтууд дээр тэмдэглэх хэрэгтэй. Хэрэв өвөг дээдсийн чинь хэн нэгэн нь нас барахаасаа өмнө санваарын ёслол хүлээн авсан бол ёслол гүйцэтгэгдсэн он, сар, өдрийг тэмдэглэх нь ашигтай. Ингэснээр бид ямар ёслолууд хийлгэх хэрэгтэй байгааг мэдэж чадна.

Өвөг дээдсийнхээ төлөө ёслол гүйцэтгэхийн өмнө Ариун сүмд шаардлагатай мэдээллийг бэлтгэхэд тойрог, салбарын эсвэл гадасны гэр бүлийн түүхийн зөвлөхүүд бидэнд тусалж чадна. Сүмийн гэр бүлийн түүхийн ном хэвлэл, орон нутгийн санваартны удирдагчид, Ариун сүм эдгээр зааврыг бас өгөх ёстой.

Арванхоёрын Чуулгын Ахлагч Ричард Г.Скотт: “Нас барсан өвөг дээдсийнхээ төлөө лацдан холболт болон бусад ёслолыг зохион байгуул. . . . Өөр хүний өмнөөс төлөөлөх ёслол хүлээж авахдаа уг хүнд тухайлан хандахыг хичээх нь тустай болохыг би мэднэ. Би тэр хүний тухай бодож, тэрээр ёслолыг хүлээн авч, ёслолоос ашиг тус олохын төлөө залбирдаг. Ариун Сүнс ойлголтыг чинь өргөжүүлж, амьдралыг чинь баялаг агуулгатай болгохын төлөө зүрх сэтгэлдээ залбирч, эдгээр зүйлийг хийгтүн. Ийм залбирал хариулагдана” хэмээн зөвлөжээ (In Conference Report, 1999 оны 4-р сар, 33; *Ensign*, 1999 оны 5-р сар, 27).

Өвөг дээдсийнхээ амьдралын тухай мэд

- Та нар өвөг дээдсийнхээ амьдралын тухай хэрхэн мэдсэн бэ? Өвөг дээдсийнхээ амьдралын тухай мэдсэн нь та нарт хэрхэн ашиг тустай байсан бэ?
- Өвөг дээдсийнхээ тухай эцэг эхчүүд хүүхдэдээ юу зааж болох вэ?

Далын Ахлагч Деннис Б.Ньюэншвандер хүүхдүүд, ач зээ нартаа гэр бүлийнхээ түүхийг заах үүргийнхээ тухай өгүүлж хэлсэн нь:

“Миний өвөө, эмээ нарын тухай ямар ч дурдатгал хүүхдүүдийн маань хэнд нь ч байдаггүй. Хэрэв ой дурдатгалд минь одоог хүртэл оршсоор байгаа эдгээр хүмүүсийн тухай хүүхдүүд, ач зээ нартаа мэдүүлэхийг хүсэх юм бол би тэдний хооронд гүүр барих ёстой. Миний хоёр талд байгаа үеийнхний хооронд ганцхан би л холбоос болж чадна. Тэд бие биеэ нүүр нүүрээрээ хэзээ ч танихгүй байж болох ч гэсэн, хайр, хүндэтгэлээр дамжуулан зүрх сэтгэлийг нь хооронд нь холбох нь миний үүрэг юм. Хэрэв би ач зээ нартаа гэр бүлийнх нь түүхийг уламжлан мэдүүлэхгүй юм бол, тэд энэ тухай юу ч мэдэхгүй байх болно. Ямар нэг байдлаар миний хийгээгүй юм намайг нас барахад алга болно. Мөн миний хийгээгүй зүйл үр удамд минь дамжин очихгүй, тэдэнд хэзээ ч байхгүй байх болно. Мөнхийн гэр бүлийн мэдээллийг цуглуулж, хуваалцах нь хувь хүний үүрэг мөн. Энэхүү үүргийг өөр хүнд шилжүүлэх буюу дамжуулан өгч болдоггүй юм” гэжээ (In Conference Report, 1999 оны 4-р сар, 109; *Ensign*, 1999 оны 5-р сар, 83-84).

Тэмдэглэл хөтөл эсвэл хувийн түүх, гэр бүлийн түүхээ бэлтгэ

- Тэмдэглэл хөтлөх буюу хувийн түүхийг бичих нь гэр бүлийн түүхэнд оролцоход бидэнд хэрхэн тусалдаг вэ? Тэмдэглэл хөтлөх болон түүх бичихээс ямар адислал ирдэг вэ? (Тэд өөрсдөө, үр хүүхэд, ач зээ нар нь хэрхэн адислагдаж болох тухай ярилцахыг ангийн гишүүдэд зөвлөмж болго.)
- Гэр бүлийн түүх бичих нь бидний зүрх сэтгэлийг гэр бүлийнхээ гишүүд рүү эргүүлэхэд хэрхэн тусалж чадах вэ?

3. Ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажилд оролцоход бидэнд туслах олон эх сурвалж Сүмд байдаг

Ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажилд оролцоход бидэнд туслах олон эх сурвалж Сүмд байдгийг тайлбарла. Үүнд:

- Ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажлын гишүүний удирдамж (34697).
- Гэр бүлийн түүхийн маягтууд (Удмын судалгааны схем, гэр бүлийн цэдгүүд).
- Компьютерийн програмууд.
- Интернет дэх мэдээлэл.
- Гэр бүлийн Түүхийн Төвүүд ордог (гэр бүлийн түүхийн хамгийн ойрхон байдаг төвийг олж мэдэхийг та хүсч болно).

Гишүүний Удирдамж болон гэр бүлийн түүхийн маягтуудыг үзүүлж, ангийн гишүүд эдгээрийг хэрхэн олж авч болохыг тайлбарла. Хэрэв та эдгээр эх сурвалжийн тухай ангийн гишүүдэд ярьж өгөхийг тойргийн эсвэл салбарын гэр бүлийн түүхийн зөвлөхөөс хүссэн бол түүгээр яриул (“Бэлтгэл,” зүйл 3-ыг үз). Ангийн гишүүд эдгээр эх сурвалжийг олж үзэх боломжгүй байлаа

ч гэсэн, ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажилд оролцож болно гэдгийг тэдэнд ойлгуулахад анхаар.

Дүгнэлт

Ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажилд оролцохын ач холбогдлын тухай бодол санаагаа хуваалц. Энэ ажилд өөрсдийн оролцож болох арга хэлбэрийг бүрэн тодорхойлохын төлөө залбирахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Сүнсээр өдөөгдсөний дагуу хичээлийн үеэр ярилцсан үнэнүүдийн тухай гэрчил.

Нэмэлт
заах санаа

Та зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмж дараах санааг ашиглаж болно.

Ангийн гишүүдэд зориулсан үйл ажиллагаа

Удмын судалгааны схем буюу гэр бүлийн цэдэг зэрэг зэрэг одоо мөрдөгдөж байгаа гэр бүлийн түүхийн маягтуудыг гишүүн бүрд өгөхөд хангалттай тоогоор олж ав. Та санваартны удирдагчид буюу гэр бүлийн түүхийн зөвлөхөөр дамжуулан эдгээр маягтуудыг олж авч болно.

Хичээлийн хэсэг болгон, маягтын нэг хувийг ангийн гишүүн бүрд өг. Хэрэв цаг гарвал ангийн гишүүдэд үзэг, харандаа өгч хичээлийн үеэр энэ маягтан дээр тэднийг ажиллуулж болно. Хэрэв хичээл дээр цаг гарахгүй бол, уг маягтан дээр гэртээ ажиллахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Зорилго Сайн мэдээг бүх дэлхийд хүргэхэд оролцох, шинээр хөрвөгчдийг бэхжүүлэхэд ангийн гишүүдэд сүнслэгээр нөлөөлөх.

- Бэлтгэл**
1. Дараах судрууд болон бусад материалыг залбирч судал:
 - а. Сургаал ба Гэрээ 1:4-5, 30; 65; 88:81; 109:72-74.
 - б. *Бидний Өв*, хуудас 136-137 (“Ерөнхийлөгч Давид О.МкКей,” догол мөр 4-өөс 8-ыг дуустал), 145-146.
 2. *Ангийн гишүүний Судлах Удирдамж* (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.
 3. *Бидний Өвөөс* дараах мэдээллийг нэгтгэн дүгнэхэд бэлтгэхийг ангийн гишүүдээс хүс.
 - а. Номлолын ажил Ерөнхийлөгч Давид О.МкКейн удирдлагаар (хуудас 136-137).
 - б. Сүмийн бүс нутгийн төлөөлөгчдөд хандаж Ерөнхийлөгч Спенсер В.Кимбаллын хэлсэн үг (хуудас 145, хоёр, гурав дахь догол мөр).
 4. Сүмийн шинэ гишүүдийн хувьд бодол санаагаа товчхон хуваалцахыг та ангийн нэг буюу хоёр шинээр хөрвөгч гишүүнээс хүсч болно. Тэдэнд бусад гишүүд хэрхэн тусалсныг ярихыг хүс. Бусад гишүүд хэрхэн илүү сайн тусалж болохыг тэд бас санал болгож болно.
-

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

Хичээлийн өмнө дараах нэрсийг самбар дээр бич:

Англи	Герман	Самоа
Тахити	Тонга	Шинэ Зеланд
Австрали	Турк	Өмнөд Америк
Исланд	Мексик	Франц
Итали	Чехословак	Хавай
Швейцарь	Хятад	

- Сүм зохион байгуулагдсанаас хойшхи эхний 20 жилд дээрх бүсүүдээс алинд нь номлогчид очсон гэж та нар бодож байна?

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл хэлсэн нь: “Би Сүмийн түүхийг уншаад, эхэн үеийн ах нар дэлхий рүү явахдаа хэчнээн зоригтой байсныг эргэцүүлэн боддог. Тэд замаа олсон юм . . . Арванхоёр 1837 оны эхээр Англид, 1844 онд Тахитид, 1851 онд Австралид, 1853 онд Исландад, 1850 онд Италид, бас Швейцарь, Герман, Тонга, Турк, Мексик, Чехословак, Хятад, Самоа, Шинэ Зеланд, Өмнөд Америк, Франц, Хавайд Сатантай тэмцэж явлаа. . . . Эхэн үеийн энэхүү номлолын ихэнхийг Хадат Уулсыг хөндлөн гулд аялан, газар боловсруулж, гэр орноо төвхнүүлж явсан удирдагчид хийсэн юм. Энэ бол итгэл бишрэл, дээд зэргийн итгэл бишрэл байлаа” (“When the World Will Be Converted,” *Ensign*, 1974 оны аравдугаар сар, 6).

Сүмийн удирдагчид Сэргээлтийн анхны өдрүүдээс эхлэн сайн мэдээг бүх дэлхийд хүргэх итгэмжлэлийг хүлээсэн юм. “Бид яаж ийгээд . . . өөрсдийнхөө хүч хүрэх бүхнийг хийсэн үед Их Эзэн улс орнуудыг номлолын ажилд нээж өгнө гэж би боддог. Үүнд би итгэн биширдэг” гэж Ерөнхийлөгч Кимбалл итгэл бишрэлээ илэрхийлсэн байдаг. Бид эдүгээ энэхүү итгэл бишрэлийг үргэлжлүүлж байгаа билээ (*Ensign*, 1974 оны аравдугаар сар, 7).

Сайн мэдээ бүх дэлхийд тархаж байгаа нэлээд хэдэн арга замыг энэ хичээлээр ярилцана гэдгийг тайлбарла.

Ярилцах ба
хэрэгжүүлэх нь

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбиран сонгож ав. Ярилцаж байгаа зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Сүм тодорхойгүй байдлаас урагш гарч ирсэн нь

Багаахан нэрд гарсан жижигхэн бүлэг хүмүүсээс Сүм хэрхэн өсч хөгжсөнийг энэ жилийн сургалт харууллаа. Сүм эдүгээ бараг дэлхийн орон бүрд гишүүдтэй болтлоо өсч хөгжлөө. Гишүүнчлэлийн энэхүү эрчимтэй өсөлтийг Сүмийн эхэн үеийн тэмцэл, мөрдлөг хавчлага, ядуу тарчиг байдлын үед бүх талаас нь ойлгож харахад хэцүү байлаа. Гэвч Их Эзэн Өөрийн Сүмийн гайхалтай хувь тавиланг Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан илчилсэн юм.

Дараах судруудыг уншихыг ангийн гишүүдээс хүсч, Сүмийн хувь тавилангийн тухай эдгээр судар бүр юу зааж байгааг ярилц.

- а. С ба Г 1:30. (Их Эзэний Сүмийг удирдахаар Бурханаас дуудагддаг хүмүүст Сүмийг тодорхой бус байдлаас урагш гарган авчрах хүч байх болно.)
- б. С ба Г 65:1-6. (Сайн мэдээ дэлхийг бүхэлд нь дүүргэх хүртэл урагш өнхрөх болно. Сайн мэдээг хүлээн авдаг хүмүүс Аврагчийн Хоёр дахь Ирэлтэд бэлтгэгдэнэ)
- в. С ба Г 109:72-74. (Сүм дэлхийг дүүргэнэ. Сүм аглаг буйдаас гарч ирэн, “Нар мэт . . . тунгалаг гэрэлтэн урагшлан” ахина.)

“Ариусгагдаагүй гар энэ ажлыг өсч дэвжихээс нь зогсоож чадахгүй; мөрдлөг хавчлага гаарч болно, танхайрагч бүлгүүд нэгдэж болно, цэрэг арми цуглаж болно, гүтгэлэг нэр төрийг гутааж болно, гэвч Бурханы үнэн эрэлхэг зоригтойгоор, ялгууснаар, тусгаар байдалтайгаар тив болгонд нэвтэртлээ, уур амьсгал бүрд хүртлээ, улс орон бүрд очтолоо, бас чих бүрд

сонсогдох хүртлээ, Бурханы зорилго гүйцэлдэх хүртэл, Агуу Иехова ажил хийгдлээ хэмээн хэлэх хүртэл урагш ахих болно” хэмээн Бошиглогч Иосеф Смит мэдэгджээ (*History of the Church*, 4:540).

- Сүм ямар арга замаар дэлхий даяар тодорхой бус байдлаас гарч ирж байна вэ?

2. Сайн мэдээг бүх дэлхийд хүргэх шаардлагыг хожмын үеийн бошиглогчид бидэнд тавьдаг

Сүм дэлхий даяар урагш ахисан нэг чухал арга зам бол гишүүн бүрийн номлолын хүч чармайлт юм гэдгийг тайлбарла. Гишүүн номлогчид, бүрэн цагийн номлогчдын хувьд сайн мэдээг хуваалцахад илүү их хүч чармайлт гаргахыг хожмын үеийн бошиглогчид бидний зорилт болгон дэвшүүлдэг билээ.

“Гишүүн бүр номлогч” гэсэн үгс нь Ерөнхийлөгч Давид О.МкКейг ихэд нэрд гаргасан юм. Ерөнхийлөгч МкКейн үе дэх номлолын ажлын тухай илтгэхийг даалгавар авсан ангийн гишүүнээс хүс (*Бидний Өв*, хуудас 136-137).

Хожим нь Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл номлолын үйлчлэл дэх алхаагаа өргөжүүлэхэд Сүмийн гишүүдийг уриалан дуудсан билээ. Улс орнууд сайн мэдээний номлолд үүд хаалгаа нээж өгөхийн төлөө, эдгээр үүд хаалгаар нэвтэрч орохын тулд бэлтгэгдсэн номлогчдын тоог нэмэгдүүлэхийн төлөө бид залбирдаг байхыг тэрээр Сүмийн гишүүдээс хүсчээ. Бүс нутгийн төлөөлөгчдөд хандаж Ерөнхийлөгч Кимбаллын хэлсэн үгийн талаар илтгэхийг даалгавар авсан ангийн гишүүнээс хүс (*Бидний Өв*, хуудас 146, эхний хоёр догол мөр). Номлолын ажил дэлхий дахинд хэрхэн урагшлан ахих тухай Ерөнхийлөгч Кимбаллын үзэгдэл одоо хэрэгжиж байгааг тайлбарла.

Сайн мэдээ дэлхийг дүүргэх тухай энэ үзэгдлийг тохиолгон авчрахад бид бүгд үүрэг хариуцлага хүлээдэг тухай Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли заасан нь:

“Ингэхэд, ирээдүй ямар байх бол? Ирэх он жилүүд ямархуу байх бол? Байдал гэвэл найдвар төрүүлж байна. Бид ямар хүмүүс вэ, бид ямар үнэт зүйлсийг эрхэмлэдэг вэ? гэдгийг хүмүүс харж эхэлж байна. . . .

“Хэрэв бид зорилгоосоо хараа салгалгүй, хэний ч тухай мууг ярилгүй, үнэн гэдгийг нь өөрсдийнхөө мэдэх агуу зарчмуудаар амьдрах юм бол урагш ахих болно, энэ зорилго агуу сүр хүчтэйгээр урагшлан, дэлхийг дүүргэнэ. Эдүгээ хаалттай байгаа хаалганууд сайн мэдээг номлоход нээгдэнэ. Хэрэв шаардлагатай бол, Бүхнийг Чадагч хүмүүсийг даруусгахын тулд үндэстнүүдийг сэгсэрч, Бурханы үйлчлэгчдийг сонсохоор болгоно. Хэрэгтэй юм бүхэн тохиох болно.

“Бидэнд тулгарч байгаа агуу сорилтын, тэрчлэн энэ ажлын амжилтын түлхүүр нь өөрсдийгөө Хожмын үеийн Гэгээнтнүүд гэж нэрлэдэг тэр хүмүүсийн итгэл бишрэл байх болно” (In Conference Report, 1997 оны аравдугаар сар, 92; *Ensign*, 1997 оны арваннэгдүгээр сар, 68).

- Дэлхийг бүрхэх сайн мэдээний тухай эдгээр бошиглол хэрхэн биелэгдэж байна вэ?

3. “Гишүүн бүр номлогч”

- С ба Г 1:4-5, 88:81-ийг ангийн гишүүдтэй хамт унш. Сайн мэдээг хуваалцах бидний үүрэг хариуцлагын тухай эдгээр хэсгүүд юуг зааж байна?

- Бид бүгд номлолын ажилд туслахын тулд юу хийж болох вэ? (Ярилцах буюу ангийн гишүүдийн хариулт дээр нэмэхийн тулд дараах мэдээллийг ашигла. Ярилцах үед гарчгуудыг самбар дээр бич.)

Бүрэн цагийн номлолд үйлчлэхээр бэлтгэ

- Бид өөрсдийгөө бүрэн цагийн номлолд хэрхэн бэлтгэж болох вэ? Бид дуудагдахаасаа өмнө өөрсдийгөө бэлтгэх нь яагаад чухал вэ?

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл хэлсэн нь: “Миний бие илүү олон номлогчдыг хүсч байна. Гэхдээ гэрчлэлгүй эсвэл зохистой биш олон номлогчдыг хүсч байгаа юм биш. Бид илүү эрт эхэлж, манай номлогчдыг дэлхий даяарх салбар, тойрог бүрд илүү сайнаар сурган бэлтгэхийг би хүсч байна. . . . Номлолд явах нь агуу онцгой боломж, номлогчид бие бялдрын хувьд ч, оюун ухааны хувьд ч, сүнслэг байдлын хувьд ч онцгой сайн байх ёстой. ‘Их Эзэн нүглийг өчүүхэн төдий ч хүлцсэн янзаар хүлээн зөвшөөрч чаддаггүйг’ [С ба Г 1:31] залуу хүмүүс ойлгох ёстой” (“When the World Will Be Converted,” *Ensign*, 1974 оны аравдугаар сар, 7).

- Бүрэн цагийн номлогчид болохоор бэлтгэхэд нь эцэг эхчүүд, бусад насанд хүрэгчид залуу хүмүүст хэрхэн тусалж болох вэ? (Зохистой байхыг мөн зохих цаг үед номлолын дуудлагад бэлэн байхыг тэдэнд заах, номлолын туршлагыг тэдэнтэй хуваалцах, номлолын ажлын баяр баясгалан болон адислалыг заах, өөрсдийнхөө болон өвөг дээдсийнхээ хөрвүүлгийн түүх, номлолын санг нь хэрхэн бий болгосныг ярих, хэрхэн шаргуу ажиллахыг заах нь хариулт байж болно.)
- Бүрэн цагийн номлолд бэлтгэхэд нь залуучуудад ямар бэрхшээл тохиолддог вэ? Эдгээр бэрхшээлийг тэд хэрхэн даван туулж чадах вэ? Бүрэн цагийн номлолд үйлчлэхээр бэлтгэхэд нь ахимаг настай гишүүдэд ямар бэрхшээл тулгардаг вэ? Эдгээр бэрхшээлийг тэд хэрхэн даван туулж чадах вэ?

Бүрэн цагийн номлолд үйлчил

- Бүрэн цагийн номлолд хэн үйлчлэх ёстой вэ?

Зохистой, чадварлаг, 19-25-ыг дуусталх насны бүх залуу эрэгтэйчүүд бүрэн цагийн номлолд үйлчлэх ёстой. Бүрэн цагийн номлогчийн үйлчлэл бол залуу эрэгтэйчүүдийн хувьд санваарын үүрэг нь юм. 21 болон түүнээс дээш насны эмэгтэйчүүд өөрсдөө хүсэх юм бол тэднийг бас бүрэн цагийн номлолд үйлчлүүлэхээр зөвлөмж болгож болно. Ахмад настай гэр бүлийн хосууд номлолд үйлчлэх боломжтой бол тэднийг номлолд үйлчлэхийг нь урамшуулан дэмждэг. Бүх номлогчид зохистой байх ёстой.

Арванхоёрын Чуулгын Ахлагч Давид Б.Хейт зөвлөхдөө: Сүм дэх бие бялдрын хувьд чадвартай гэр бүлийн хос бүрийн зорилго нь Сүмийн арван есөн настай залуу эрэгтэй бүрийн адил номлолд үйлчлэх явдал байх ёстой. Ахмад насандаа номлогчийн үйлчлэлээр дамжуулан хүүхдүүд эсвэл ач зээ нартаа эцэг эхчүүдийн үзүүлж болох үлгэр жишээнээс илүү сайхан үлгэр жишээ гэж үгүй, хуваалцах гэрчлэлээс нь илүү сайхан гэрчлэл гэж үгүй” гэжээ (In Conference Report, 1987 оны 4-р сар, 73; *Ensign*, 1987 оны 5-р сар, 61).

Бүрэн цагийн номлогчдыг дэмж

- Одоо үйлчилж байгаа номлогчдыг бид хэрхэн дэмжиж болох вэ? (Залбиралдаа тэднийг оруулах, урам хайрласан захидал бичих, тойргийн буюу салбарын номлолын сан, Номлолын Ерөнхий Санд хандивлах нь хариулт байж болно. Сонирхогчдыг олох, тэдэнд заах болон бусад тусалцааг үзүүлснээр бид өөрийнхөө бүсэд үйлчилж байгаа номлогчдод дэмжлэг үзүүлж чадна.)

“Ах эгч нар аа, нэг бол номлогчид энэ ажлыг дангаараа хийг гээд бид тэднийг зөнд нь орхиж болно. Нөгөө бол бид тэдэнд тусалж чадна. Хэрэв номлогчид энэ ажлыг дангаараа хийх юм бол өдөр бүр хаалга тогшин явсаар, ургац тарчигхан байх болно. Нөгөө талаар сонирхогчдыг олж, заахад нь гишүүд бид номлогчдод тусалж чадна” гэж Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлжээ (“Find the Lambs, Feed the Sheep,” *Ensign*, 1999 оны 5-р сар, 107).

Насан туршидаа сайн мэдээг хуваалц

- Насан туршидаа сайн мэдээг бусадтай хуваалцах нь бидний хувьд яагаад чухал байдаг вэ? Сайн мэдээг бусадтай хуваалцахад та нар ямар туршлага хуримтлуулсан бэ?
- Яагаад бид заримдаа сайн мэдээг хуваалцахаас айдаг вэ? Ийм айдсыг бид хэрхэн даван туулж болох вэ?
- Сүмийн аль нэг гишүүний үлгэр жишээ, нөхөрлөлийн улмаас Сүмд нэгдэхэд нөлөөлөгдсөн хүн та нарын дотор байна уу? Сүмийн энэ гишүүний үйл хэрэг чамд хэрхэн нөлөөлсөн бэ?
- Бид өдөр тутмынхаа амьдралын хэсэг болгон сайн мэдээг бусадтай хуваалцаж болох ямар арга замууд байдаг вэ? (Дараах зүйлүүд хариулт байж болно.)
 - а. Гэр бүлийн гишүүд, хөрш, найз нартаа сайн үлгэр жишээ үзүүл.
 - б. Мормоны Номыг хуваалц.
 - в. Сонирхсон хүмүүсийн нэрсийг номлогчдод өг.
 - г. Сайн мэдээний тухай бодол санаагаа хүмүүстэй хуваалц.
 - д. Сүмийн үйл ажиллагаа, цуглаан, галын дэргэдэх ярилцлагуудад хүмүүсийг урь.
 - е. Гэр бүлийн үдэш, хөршүүдтэйгээ хамт зохион байгуулах үйл ажиллагаанд хүмүүсийг урь.
 - ё. Ургийн судалгааг сонирхдог хүмүүсийг Гэр Бүлийн Түүхийн Төвд очиж үзэхийг урь.
 - ж. Баптисмын үйлчлэлд хүмүүсийг урь.

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл хэлсэн нь: “ [Сайн мэдээ] ‘үндэстэн бүрд,’ ‘улс орон бүрд,’ ‘дэлхийн хязгааруудад,’ ‘бүх хэлтэнд,’ ‘бүх хүмүүст,’ ‘бодгаль бүрд,’ ‘бүх дэлхийд,’ ‘олон улс оронд’ очих ёстой гэж Их Эзэн хэлэхдээ, тэрээр өөрийн үгсийг сонгосон юм шиг надад санагддаг. Эдгээр үгсэд чухал учир холбогдол байгаа нь лавтай! . . . Хэрэв бид чадах бүхнээ хийвэл тэр шүү. Бүх дэлхийд зааж байгаа байдалдаа бид сэтгэл хангалуун байдаг

уу? . . . Алхаагаа уртасгахад, бас хараагаа өргөжүүлэхэд бид бэлтгэгдсэн үү?” (*Ensign*, 1974 оны аравдугаар сар, 5).

- Ямар арга замаар бид бүгд алхаагаа уртасгаж, өдөр тутмынхаа амьдралд сайн мэдээг хуваалцахыг эрэлхийлж болох вэ?

Ерөнхийлөгч Кимбалл хэлсэн нь: “Бидний агуу хэрэгцээ, бидний агуу дуудлага бол тодорхой бус байдал болон харанхуйгаас баяр баясгалан, амар амгалан, сайн мэдээний үнэнүүд рүү энэ дэлхийн хүмүүсийг удирдахын тулд тэдэнд ойлголтын захиасыг авчрах явдал мөн. Бид сайн үйлсэд шантрамтгай байх ёсгүй гэдэгт би итгэдэг. Сайн мэдээг бусдад болон дэлхийн оршин суугчдад хүргэхэд туслахын тулд би юу хийж болох вэ? гэсэн асуултыг бид өөрсдөөсөө дахин асуух цаг болсон гэдэгт би итгэдэг” (“Are We Doing All We Can?” *Ensign*, 1983 оны 2-р сар, 5).

Сонирхогчдыг олж, тэдэнтэй нөхөрлөхөд үлгэр жишээ үзүүлэх үүрэг хариуцлагыг өөртөө авахыг Ерөнхийлөгч Хинкли санваартны удирдагч бүрээс хүссэн билээ. Ариун ёслолын цуглаан дээр энэ сэдвийг үе үе ярилцаж байхыг тэрээр хүссэн юм. Сонирхогчдыг олж, тэдэнтэй нөхөрлөх ажлыг төлөвлөхөд Санваартны, Нийгмийн Халамжийн Бүлгийн, Залуу Эмэгтэйчүүдийн, Хүүхдийн Хэсгийн, тойргийн зөвлөлийн, тэрчлэн гадасны зөвлөлийн цуглааныг ашигладаг байхыг тэрээр бас хүсчээ. (*Ensign*, 1999 оны 5-р сар, 107.)

4. Шинэ хөрвөгчдийг дэмжих нь бидний байнгын үүрэг мөн

Дараах өгүүлбэрийг самбар дээр бич: “Баптисмд зохистой ямар ч сонирхогч нь авралын хувьд зохистой хөрвөгч байдаг” (Гордон Б.Хинкли, *Ensign*, 1999 оны 5-р сар, 109). Жил бүр хэдэн зуун мянган хөрвөгчдийг Сүмд авчирч байгааг тайлбарла. Бид бүгд энэ шинэ гишүүдийг дэмжин, урам хайрлаж, бэхжүүлэх хэрэгтэй.

- Шинээр хөрвөгчид Сүмд идэвхтэй байх нь зарим үед яагаад хэцүү байдаг вэ?

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлсэн нь: “Энэ Сүмийн гишүүн болох нь амар хялбар зүйл биш. Энэ Сүмийн гишүүн болох нь ихэнх тохиолдолд хуучин дадал хэвшлээ хаяж, хуучин найз нар, өмнө нь харилцаа холбоотой байсан хүмүүсээ орхин, бусдаас ялгаатай, ямар нэг хэмжээгээр шаардлага тавьдаг шинэ нийгэмлэг рүү алхан орох явдал байдаг” (In Conference Report, 1997 оны 4-р сар, 66; *Ensign*, 1997 оны 5-р сар, 47).

- Шинээр хөрвөгчид өөрсдийгөө бэхжүүлэхийн тулд юу хийж болох вэ? Шинээр хөрвөгчдийг бэхжүүлэхийн тулд бусад гишүүд юу хийж болох вэ? Гишүүд шинэ хөрвөгчдийг бэхжүүлэх ажлыг үр ашигтайгаар хийхийг та нар хэрхэн харсан бэ?

“Хөрвөгч бүр гурван зүйлтэй байх ёстой гэж Ерөнхийлөгч Хинкли заасан юм:

“1. Сүмийн найз. Тэрээр энэ найздаа байнга хандаж, найз нь түүнийг урамшуулан дэмжиж, асуултанд нь хариулж, асуудлыг нь ойлгодог байх ёстой.

“2. Ажил үүрэг. Үйл ажиллагаа бол энэ Сүмийн ялгарах онцлог. Энэ бол бидний өсч хөгждөг үйл явц мөн. Их Эзэнд итгэх итгэл, түүнийг хайрлах хайр бол гарын минь булчин лугаа адил юм. Хэрэв би Их Эзэнд итгэх

итгэл, түүнийг хайрлах хайрыг ашиглах юм бол, энэхүү итгэл, хайр улам хүчтэй болно. Хэрэв би итгэл, хайраа ашиглахгүй бол Их Эзэнд итгэх итгэл, түүнийг хайрла хайр бүр үлбэгэр сул болно. Хөрвөгч бүр Сүмийн зүгээс өөртэй нь ажиллахыг хүсэн хүлээдэг нь зүй ёсны юм. . . .

“3. Хөрвөгч бүр ‘Бурханы сайн үгээр тэжээгдэж’ (Моронай 6:4) байх ёстой. Тэрээр Санваартны аль нэг чуулга, Нийгмийн Халамжийн Бүлэг, Залуу Эмэгтэйчүүд, Залуу Эрэгтэйчүүд, Ням гарагийн хичээл, эсвэл Хүүхдийн Хэсэгт харьяалагддаг байх нь чухал. Ариун ёслолын цуглаанд ирэхэд нь түүнийг урамшуулан дэмждэг байх ёстой” (*Ensign*, 1999 оны 5-р сар, 108).

Сүмийн шинэ гишүүн байхад нь төрдөг байсан сэтгэгдлээ хуваалцахыг та ангийн гишүүдээс хүссэн бол одоо тэднээр яриул (“Бэлтгэл,” зүйл 4-ийг үз).

Дүгнэлт

Их Эзэн Өөрийн Сүмийг удирдаж, сайн мэдээг бүх дэлхийд хүргэх арга замыг нээж байгааг онцлон тэмдэглэ. Бүрэн цагийн номлолд бэлтгэх, эргэн тойрныхоо хүмүүстэй сайн мэдээг хуваалцах үйл ажиллагаагаа идэвхжүүлэхэд нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Бас шинэ гишүүдийг дэмжин, бэхжүүлэхэд тэднийг урамшуулан дэмж. Сүнсээр өдөөгдсөний дагуу хичээлийн үеэр ярилцсан үнэнүүдийн тухай гэрчил.

Нэмэлт заах санаа

Та зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмж дараах санааг ашиглаж болно.

Үндэстнүүдэд туг видео танилцуулга

An Ensign to the Nations (53980) видео хуурцаг байдаг бол нэг хэсгийг нь хичээлийн үеэр үзүүлэхэд анхаар. Энэ видео нь Европ, Номхон Далайн арлууд, Латин Америк, Ази, Африк дахь Сүмийн өсөлтийн тухай сүнслэгээр нөлөөлөгдсөн түүхүүд юм. Видео Ариун сүмүүдийг мөн “Алхам тутам дахь итгэл” дууллыг дуулж буй бүх дэлхийн хүмүүсийг харуулснаар төгсдөг.

Видео хуурцаг 60 минут үргэлжилдэг учраас хичээл дээр бүгдийг нь үзүүлэх боломж байхгүй. Гэвч та видеог урьдчилж үзээд, заадаг хүмүүст чинь онцгой сүнслэгээр нөлөөлөх хэсгийг сонгож болно.

Хожмын үеийн Бошиглогчдод илчлэлт ирсээр байгаа нь

Зорилго

Их Эзэн хожмын үеийн бошиглогч, үзмэрч, илчлэгчдэд өгдөг илчлэлтээр дамжуулан Сүмийг удирдсаар байгааг ангийн гишүүдэд ойлгуулах.

Бэлтгэл

1. Дараах судрууд болон бусад материалыг залбирч судал:
 - а. Сургаал ба Гэрээ 1:38; 68:1-4; 84:109-10; 107:25, 34, 93-98; 132:8.
 - б. Албан Тунхаг 2 (Сургаал ба Гэрээ хуудас 409-411).
 - в. *Бидний Өв*, хуудас 138, 146-148.
 2. *Ангийн гишүүний Судлах Удирдамж* (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.
 3. *Бидний Өвөөс* дараах мэдээллийг нэгтгэн дүгнэхэд бэлтгэхийг ангийн гишүүдээс хүс:
 - а. Сүмийн зохицуулалтын талаарх мэдээлэл (138-ын хоёр догол мөр).
 - б. Сүмийн зохистой эрэгтэй гишүүн бүрд санваарын адислалыг хүртээмжтэй болгосон илчлэлтийн тухай шастир (хуудас 146-148).
-

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа

Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

Ерөнхийлөгч Харольд Б.Лийгийн хуваалцсан дараах түүхийг ярь:

“Арванхоёрын Зөвлөлийн Ахлагч Жон А.Видцөү нэг удаа гадасны хэсэг ажилтантай ярилцсан тухайгаа өгүүлжээ. Ярилцах явцад хэн нэгэн нь, ‘Видцөү ах аа, Сүм илчлэлт хүлээн авснаас хойш хичнээн хугацаа өнгөрсөн юм бол?’ гэж түүнээс асуусан аж. Видцөү ах бодлогошрон эрүүгээ илснээ хариу болгож, ‘Аа, өнгөрсөн пүрэв гарагаас хойш байх шүү’ гэсэн гэдэг” (*Stand Ye in Holy Places* [1974], 132-133).

Сүм илчлэлтээр удирдагдсаар байгааг Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл мэдэгдсэн нь:

“Илчлэлт үргэлжлэн ирсээр байгааг сар бүр, өдөр бүр ирж байгаа эдгээр илчлэлтийг Сүмийн бүх бичиг баримт агуулдгийг бид дэлхийд гэрчилж байна. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм зохион байгуулагдсан 1830 оноос хойш, Бурханаар болон түүний хүмүүсээр хүлээн зөвшөөрөгдсөн Бошиглогч байсаар байгаа мөн урт удаан хугацаанд байсаар байна. Их Эзэний оюун бодол, хүсэл тааллыг Бошиглогч үргэлж тайлбарласаар байх болно. . . .

“Хүн илчлэгдсэн үгсийн байнгын урсгалд дөжирч, сонирхолтой зүйлийг хүсэн хүлээдэг байж таарахгүй. Сэргээлтийн Бошиглогчоос манай одоогийн бошиглогч хүртэл харилцааны шугам тасраагүйг, эрх мэдэл үргэлжилж байгааг, хурц, нэвтлэгч гэрэл үргэлжлэн гэрэлтсээр байгааг миний бие туйлын даруу байдлаар, гэхдээ бодгальд минь шатах лугаа адил оршигч гэрчлэлийн хүчээр хэлж байна. Их Эзэний дуу хоолойн чимээ тасралтгүй уянгалаг бөгөөд аянга нүргэлэх лүгээ адил уриалдаг. Энэ дуу хоолой бараг бүтэн хагас зууны туршид тасалдаагүй байгаа билээ” (In Conference Report, 1977 оны 4-р сар, 115; *Ensign*, 1977 оны 5-р сар, 78).

Ерөнхийлөгч Кимбаллын үг өнөөдөр ч гэсэн үнэн байгааг онцлон тэмдэглэ. Тэнгэр нээлттэй байна. Их Эзэн хүсэл тааллаа хожмын үеийн бошиглогчдод илчилсээр байна.

Ярилцах ба
хэрэгжүүлэх нь

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбиран сонгож ав. Ярилцаж байгаа зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

С ба Г 1:38, 68:1-4-ийг ангийн гишүүдтэй хамт унш. Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүд бол хожмын үеийн бошиглогчид, үзмэрчид, илчлэгчид гэдгийг онцлон тэмдэглэ. Сүмийг удирдах илчлэлтийг тэд хүлээн авсаар байна. Тэдний удирдлага бол “Их Их Эзэний таалал, . . . Их Их Эзэний оюун, . . . Их Эзэний үг, . . . Их Эзэний дуу хоолой, авралын төлөөх Бурханы хүч юм” (С ба Г 68:4). Энэ хичээлээр Сүмийг удирдах илчлэлт үргэлжлэн ирсээр байгаагийн хэдхэн жишээг ярилцана гэдгийг тайлбарла.

1. Сүмийн зохицуулалт

Бидний Өв, хуудас 138 дахь хоёр догол мөр болон хуудас 139-ийг дуусталх Сүмийн зохицуулалтын тухай мэдээллийг нэгтгэн дүгнэхийг даалгавар авсан ангийн гишүүнээс хүс. Их Эзэнээс Түүний бошиглогчдод ирсэн илчлэлтээр Сүмийн зохицуулалт санаачлагдан өнөөдрийг хүртэл ажилласаар байгааг онцлон тэмдэглэ.

Сүмийн зохицуулалтын зорилго бол “Бурханы зөв замыг” (Иаков 7:7) хадгалах явдал гэдгийг тайлбарла. Зохицуулалт нь Сүмийн үүрэг зорилгыг хэрэгжүүлэхэд туслах зорилготой юм. Энэхүү үүрэг зорилго нь “Христэд ирэгтүн, мөн түүгээр төгөлдөржигтүн” (Моронай 10:32; С ба Г 20:59-ийг үз) хэмээн бүх хүмүүсийг урих явдал юм.

Тэргүүн Зөвлөл болон Арванхоёрын Чуулга Сүмийн зохицуулалтад хяналт тавьдаг. Зохицуулалтад дараах зүйлүүд багтдаг:

- а. Сургаалын цэвэр байдлыг сахин хамгаалах.
- б. Гэр бүл ба гэр орны ач холбогдолд онцгой анхаарал тавих.
- в. Сүмийн бүх ажлыг санваарын удирдлага дор байлгах.
- г. Сүмийн байгууллагуудын хооронд зохистой харилцааг бий болгон төлөвшүүлэх.
- д. Сүмд эв нэгдэл, дэг журмыг хангах.
- е. Сүмийн хөтөлбөр, сүмийн материалуудыг энгийн ойлгомжтой байлгах.

Зохицуулалт бол “Бид Сүмийн бүх хөтөлбөрийг нэгтгэн хооронд нь уялдуулж, нэг цэгт төвлөрүүлэн, нэг багц болгон зангиддаг, бүгдийг нийлүүлэн

нэг хөтөлбөр болгодог, үйл ажиллагаанд нь Сүмийн бүх гишүүдийг оролцуулдаг, улмаар энэ бүхнийг санваарын удирдлага дор хэрэгжүүлдэг” үйл явц юм гэж Арванхоёрын Чуулгын Ахлагч Брус Р.МкКонки хэлжээ (*Let Every Man Learn His Duty* [товхимол, 1976], 2).

Сүмийн зохицуулах хүч чармайлт бидний амьдралыг хэрхэн адисалдаг тухай ярилцахад дараах материалыг ашигла. Ярилцах үедээ гарчгуудыг самбар дээр бич.

Гэр бүлийн ач холбогдол

Зохицуулах хүч чармайлт нь гэр бүлийн ач холбогдлыг олон арга замаар онцгойлон авч үздэг. Нэг арга зам нь гэр бүлийн үдшийн хөтөлбөрийг бий болгосон явдал мөн. Гэр бүлдээ зааж, гэр бүлээ бэхжүүлэхийн тулд эцэг эхчүүд гэр бүлийн үдшийг долоо хоног тутам явуулж байх ёстой. Сүм даяар нэг дэх өдрийн оройг гэр бүлийн үдэшт зориулдаг бөгөөд энэ өдөр Сүмийн цуглаан болон бусад үйл ажиллагааг зохион байгуулах ёсгүй.

- Гэр бүлийн үдэш амьдралд чинь хэрхэн нөлөөлдөг вэ? Гэр бүлийн үдшийг амжилттай болгохын тулд та нар юу хийсэн бэ?

Зохицуулах хүч чармайлт нь гэр бүлийн талаар Сүмийн байгууллага, хөтөлбөр болон үйл ажиллагаануудын үүргийг тодруулснаар гэр бүлийн ач холбогдлыг онцгойлон авч үздэг. *Сүмийн Заавруудын Гарын Авлагад* өгүүлсэн нь:

“Сайн мэдээний заалт болон удирдлага дахь хамгийн чухал хэсэг бол гэр бүл ба гэр орон юм (Мозая 4:14-15; С ба Г 68:25-28-ыг үз). . . . Сүмийн чуулга, хавсралт байгууллага, хөтөлбөр болон үйл ажиллагаанууд нь гэр бүлийг бэхжүүлж, дэмжих ёстой. Эдгээр нь үйл ажиллагаагаар өрсөлдөх биш, харин сайн мэдээн дээр төвлөрсөн гэр бүлийн үйл ажиллагааг өргөжүүлэх ёстой” гэжээ (*Ном 2: Санваартны болон Хавсралт байгууллагын Удирдагчид* [1998], 299).

- Сүмийн хавсралт байгууллага, хөтөлбөр болон үйл ажиллагаанууд нь гэр бүлийг дэмжихийн төлөө оршдогийг ойлгох нь яагаад чухал вэ? Сүмийн байгууллага, үйл ажиллагаанууд чамайг, мөн гэр бүлийг чинь хэрхэн бэхжүүлсэн бэ?

Сүмийн хөтөлбөр, үйл ажиллагаанууд Сүм гишүүдийн хүч чармайлт, цаг зав, бусад нөөц боломжийг хэрэгцээгүй зүйлд зориулах шаардлага тавихгүй байхыг зохицуулахад онцгой анхаардаг.

Сүмийн туслах бүлгүүдийн үйл ажиллагаа

Зохицуулалтын нэг чухал үүрэг бол Сүмийн туслах бүлгүүд-Нийгмийн Халамжийн Бүлэг, Залуу Эрэгтэйчүүд, Залуу Эмэгтэйчүүд, Хүүхдийн Хэсэг, Ням гарагийн хичээлийн нэгдмэл байдлыг хангаж, үйл ажиллагааг нь зохицуулах явдал мөн. Эдгээр бүлгүүд олон жилийн туршид ямар нэг хэмжээгээр бие даасан байдалтай байгаа билээ. Сүмийн ерөнхий түвшинд, эдгээр байгууллагын зарим нь өөрийн сэтгүүл, санхүү, чуулгантай байдаг. Эдгээр байгууллага өсч хөгжихийн хэрээр адил нийтлэг шинж чанар нь өсөн нэмэгдэж, хөтөлбөр болон материалуудад нь шаардлагагүй давхардал олонтаа гардаг болшоо.

Зохицуулалтын үр дүнд ийм адил нийтлэг байдал, давхардал багасч байна. Зохицуулалтаар дамжуулан туслах бүлгүүдийг санваартны удирдагчдын удирдлага дор ажиллуулахад онцгой анхаарал тавьж байна. Жишээ нь, тойрогт эдгээр байгууллага бүгдээрээ бишопын зөвлөлийн удирдлага дор ажилладаг.

- Тойрог дахь туслах бүлгийн үйл ажиллагааны нэгдлийг хангаж, уялдуулан зохицуулах нь яагаад чухал вэ? Тэдний хүч чармайлтыг уялдуулан зохицуулснаар эдгээр байгууллага хэрхэн илүү үр ашигтай ажиллах боломжтой болсныг та нар харсан уу?

Сүмийн ном хэвлэлийг бэлтгэх нь

Хичээлийн гарын авлага, Сүмийн сэтгүүлүүд зэрэг Сүмийн ном хэвлэлийг Есүс Христийн сайн мэдээнээс суралцаж, үүгээр амьдрахад нь гишүүдэд туслахын тулд нийтэлдгийг тайлбарла. Сургалтын эдгээр материал нь судар дээр тулгуурласан, сургаалын хувьд зөв, хэрэглэгчиддээ тохирсон байхад зохицуулах үйл явц тусалдаг. Сүмийн бүх ном хэвлэлийг Тэргүүн Зөвлөл болон Арванхоёрын Чуулгын удирдлага дор төлөвлөж, бэлтгэн, хянаж, хэвлэн гаргадаг.

Сүмийн ном хэвлэлийн уялдуулан зохицуулалтын нэг үр дүн бол насанд хүрэгчид болон залуучуудын Сайн мэдээний сургаалын ангиуд, Хүүхдийн Хэсгийн ихэнх ангиуд тухайн жилд судрын нэг номыг адилхан судалдаг явдал мөн. Энэ нь гэртээ судруудыг ярилцахад урам дэм, түлхэц өгч болно.

- Сүм дээр заагддаг хичээл гэртээ хүүхдүүддээ заах эцэг эхчүүдийн хүч чармайлтад хэрхэн дэмжлэг болдог вэ?

Гэрийн багшлалт

С ба Г 20:53-55-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Санваартнууд гэрээр очиж заадаг нь Бошиглогч Иосеф Смитийн үеэс хойш Сүмийн үйл ажиллагааны нэг хэсэг байсаар ирснийг тайлбарла. Уялдуулан зохицуулах хүч чармайлтын нэг хэсэг болсон энэхүү айлчлалтад 1960-аад онд дахин онцгой анхаарал хандуулж, гэрийн багшлалт гэж нэрлэх болжээ. Гэрийн багшлалт нь багш нар, прист, Мелкизедек санваар эзэмшигчдийн нэн чухал үүрэг хэвээр байна.

- Гэрийн багшлалтын зорилго вэ? Гэрийн багшлалтын ач холбогдол та нарт ямар туршлага болсон бэ?

Сүмийн уялдуулан зохицуулалтын талаарх ярилцлагаа төгсгөхийн тулд С ба Г 84:109-10, 132:8-ыг ангийн гишүүдтэй хамт унш.

- Сүмийн зохицуулалт нь дээрх үгсийг хэрэгжүүлэхэд ямар арга замаар бидэнд тусалдаг вэ?
- Бид Сүмийн зохицуулалтын зарчмуудыг хувиараа болон Сүмийн дуудлагадаа хэрэгжүүлэхийн тулд юу хийж болох вэ?

2. Сүмийн зохистой эрэгтэй гишүүн бүрд санваарын адислалыг хүртээмжтэй болгох тухай илчлэлт

Сүмийн зохистой эрэгтэй гишүүн бүрд санваарын адислалыг хүртээмжтэй болгох тухай илчлэлтийг Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл 1978 оны

зургадугаар сард зарласныг тайлбарла. *Бидний Өв*, хуудас 146-148-аас энэ илчлэлтийн тухай шастирыг нэгтгэн дүгнэхийг даалгавар авсан ангийн гишүүнээс хүс.

- Албан Тунхаг 2-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Энэ илчлэлт Сүмд хэрхэн адислал болсоор байдаг вэ?
- Энэ илчлэлтийг хүлээн авахаас өмнө Ерөнхийлөгч Кимбаллын туулж өнгөрүүлсэн амьдралаас бид юу сурч болох вэ? (*Бидний Өв*, хуудас 146-148-ыг үз.)

3. Хожмын Үеийн Гэгээнтний судруудын шинэ хэвлэл

Тэргүүн Зөвлөл болон Арванхоёрын Чуулгын удирдлага дор хэдэн жил няхуур ажилласны дараа 1979 онд Сүм Хожмын Үеийн Гэгээнтний Библийг англи хэл дээр хэвлэснийг тайлбарла. Библийн энэ хэвлэлийн бичвэр нь Хаан Жеймсийн англи хэл дээрх хувилбартай адилхан боловч, *Topical Guide*, *Bible Dictionary*, судрын бусад номнуудын хэсгүүдэд холбогдох зүүвэр тайлбар, Библийн Иосеф Смитийн Орчуулгын эшлэлүүд зэрэг судлах тусгай тусламжуудыг агуулсан байдаг.

Гурамсан судрын шинэ хэвлэлийг (Мормоны Ном, Сургаал ба Гэрээ, Агуу Үнэт Сувдыг нэг боть болгон), өргөтгөсөн зүүвэр тайлбар болон индексстэйгээр Сүм 1981 онд англи хэлээр хэвлэсэн юм.

- Езекиел 37:15-19-ийг ангийн гишүүдтэй хамт унш. “Иудагийн саваа” бол Библи, “Ефраимын саваа” бол Мормоны Ном гэдгийг тайлбарла. Судруудын шинэ хэвлэл нь Библи, Мормоны Ном хоёрыг “[та нарын] гарт нэг” болгоход хэрхэн тусалдаг вэ?

Англи хэл дээрх Библийн олон зүүвэр тайлбар Мормоны Номон дахь судруудад холбогддогийг бас Мормоны Номон дахь олон зүүвэр тайлбар Библи дэх судруудад холбогддогийг тайлбарла. Арванхоёрын Чуулгын Ахлагч Бойд К.Пакер: “Иудагийн саваа буюу цэдэг – Хуучин Гэрээ, Шинэ Гэрээ, мөн Ефраимын саваа буюу цэдэг-Мормоны Ном, Есүс Христийн бас нэгэн гэрээ нь – эдүгээ та нар нэгийг нь судлаад нөгөө рүү нь хөтлөгдөн очих, нэгнээс нь сураад нөгөөгөөр нь гэгээрэх байдлаар судрын энэ хоёр ном хоорондоо нягт сүлжилджээ. Библи, Мормоны Ном хоёр үнэхээр бидний гарт нэг юм” хэмээн хэлжээ (In Conference Report, 1982 оны аравдугаар сар, 75; *Ensign*, 1982 оны арваннэгдүгээр сар, 53).

Хожмын Үеийн Гэгээнтний судруудын хэвлэл дэх судлах тусламжийг ангийн гишүүдэд харуулахад хэдэн минут гарга (та хоёр дахь нэмэлт заах санааг ашиглаж болно). Тэгээд дараах асуултуудыг асуу:

- Судрууд дахь судлах тусламжуудыг та нар ямар байдлаар ашигласан бэ? Эдгээр эх сурвалжууд судар судлахад чинь та нарт хэрхэн тусалсан бэ? Хожмын Үеийн Гэгээнтний судруудын хэвлэлийн улмаас Сүм ямар арга замаар адислагдсан гэж та нар боддог вэ?

Эдгээр судрууд хэвлэгдсэний дараахан, Ахлагч Бойд К.Пакер бошиглосон нь: “Хэдэн жил өнгөрсний дараа эдгээр судрууд Их Эзэн Есүс Христийг мэддэг, Түүний хүслийг дуулгавартай дагах эрмэлзэлтэй Христэд итгэгчдийн амжилттай, итгэл бишрэлтэй үеийнхнийг төрүүлэх болно. . . Илчлэлтүүд дэлхийн түүхэн дэх өөр [үеийхэнд] биш, харин тэдэнд нээгдэнэ. Эдүгээ тэдний гарт Иосефын болон Иудагийн саваанууд ороод

байна. Тэд сайн мэдээний мэдлэгийг өвөг дээдсийнхээ хүрч чадсан хэмжээнээс илүү гарган хөгжүүлнэ. Есүс бол Христ мөн гэдэг гэрчлэл тэдэнд байх бөгөөд Түүнийг тунхаглах, Түүнийг хамгаалах талаар чадварлаг болно” (In Conference Report, 1982 оны аравдугаар сар, 75; *Ensign*, 1982 оны арваннэгдүгээр сар, 53).

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли Ахлагч Пакерын үгс гүйцэлдэж байгааг харуулсан мэдэгдлийг 1995 оны дөрөвдүгээр сарын ерөнхий чуулган дээр хийж, хэлсэн нь: “Би залуу зандан насаа эргэн харлаа. Залуу эрэгтэйчүүд ч, залуу эмэгтэйчүүд ч тэр үед судар төдийлөн их уншдаггүй байсан. Хичнээн гайхалтай өөрчлөлт гарч вэ! Их Эзэний үгийг мэддэг шинэ үеийнхэн өсөн өндийж байна” (In Conference Report, 1995 оны 4-р сар, 117; *Ensign*, 1995 оны 5-р сар, 87).

4. Далын Чуулгуудыг нэмж байгуулсан нь

Сүм өсч хөгжихийн хэрээр дэлхий даяарх гишүүдийн хэрэгцээг хангахын тулд Сүмийн ерөнхий удирдлага хэрхэн өөрчлөгдөх ёстойг Их Эзэн илчилснийг тайлбарла. Далын Чуулгуудыг нэмж зохион байгуулсан нь энэхүү өөрчлөлтийг тодорхой харуулж байна.

- С ба Г 107:25, 34-ийг ангийн гишүүдтэй хамт унш. Далын үүрэг хариуцлага юу вэ?

Олон жилийн туршид Сүмийн долоохон Ерөнхий Эрх Мэдэлтэн Далаар үйлчилж байсныг тайлбарла. Тэд Далын Нэгдүгээр Зөвлөлийг бүрдүүлж байв. 1975 онд бусад зөвлөлүүд дуудагдсан байна. Тэд Далын Нэгдүгээр Чуулгад үйлчилж байлаа. 1989 онд Далын Хоёрдугаар Чуулга нэмэгдэж, дахин өргөжсөн байна.

Зургаан жил орчим хугацаагаар үйлчлэх, Бүсийн Эрх Мэдэлтнүүд гэж нэрлэгдсэн, орон нутгийн ажилтнуудын шинэ дуудлагыг Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли 1995 оны дөрөвдүгээр сард зарлажээ. (Conference Report, 1995 оны 4-р сар, 71-72; *Ensign* 1995 оны 5-р сар, 52-ыг үз.)

Бүсийн Эрх Мэдэлтнүүд нь Далаар томилогдож Далын Гуравдугаар, Дөрөвдүгээр, Тавдугаар Чуулгуудыг бүрдүүлэх боллоо гэж Ерөнхийлөгч Хинкли 1997 онд зарлав. Ерөнхий Эрх Мэдэлтнээр үйлчилдэг Далуудтай адилгүй нь Бүсийн Эрх Мэдэлтэй Далууд нь өөрсдийнхөө ажиллаж, амьдардаг бүсүүдэд үйлчилдэг. (Conference Report, 1997 оны 4-р сар, 4-5; *Ensign*, 1997 оны 5-р сар, 5-6-г үз.)

- С ба Г 107:93-97-г ангийн гишүүдтэй хамт унш. Далын Чуулгуудыг нэмж байгуулсан нь энэ илчлэлт дэх заавартай хэрхэн нийцэж байна вэ?
- Бүсийн Эрх Мэдэлтэй Далуудыг дуудсан нь өсөлт хөгжилтийнх нь үед Сүмд хэрхэн тусалсан гэж та нар боддог вэ?

Далын Чуулгуудыг нэмж байгуулсан туха, Ерөнхийлөгч Хинкли хэлэхдээ: “Бид эдгээр харьяалах чуулгуудыг орон нутагт газар дээр нь байгуулснаар, шаардлагын дагуу сонгогдож, дэлхий даяар ажиллах Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөл болон Бүсийн Эрх Мэдэлтэй Далын байгууллагыг бий болгосноор Сүм ямар ч хэмжээнд хүртэл өсч хөгжиж болох загварыг бий болгоод байна. Одоо Их Эзэн Өөрийнхөө хаант улсыг дээрээс харж байна. Үргэлж өсөн нэмэгдсээр байгаа Сүмийн гишүүнчлэлд

анхаарал халамж тавих ёстой удирдлагад нь Тэрбээр сүнслэгээр нөлөөлж байна” гэжээ (In Conference Report, 1997 оны 4-р сар, 5; *Ensign*, 1997 оны 5-р сар, 6).

Дүгнэлт

Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглаагүй бол, хуудас 278-279 дээрх Ерөнхийлөгч Спенсер В.Кимбаллын мэдэгдлийг унш. “[Бошиглогчиддоо] өгдөг Их Эзэний дуу хоолойн чимээ тасралтгүй уянгалаг бөгөөд аянга нүргэлэх лүгээ адил уриалдаг” гэсэн Ерөнхийлөгч Кимбаллын гэрчлэлд онцгой анхаарал хандуул. Хожмын үеийн бошиглогчдоор дамжин ирдэг Их Эзэний удирдамжийн төлөө талархлаа илэрхийл.

Сүнсээр өдөөгдсөний дагуу хичээлийн үеэр ярилцсан үнэнүүдийн тухай гэрчил.

Нэмэлт заах санаанууд

Та зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болгож дараах санаануудаас нэгийг буюу хоёуланг нь ашиглаж болно.

1. “Санваарын талаарх илчлэлт” видео танилцуулга

Хэрэв *Teachings from the Doctrine and Covenants and Church History Video танилцуулгууд* (53912) байдаг бол “Санваарын талаарх илчлэлт,” долоон минутын хэсгийг хичээлийн хоёр дахь хэсгийн үеэр үзүүлэхэд анхаар.

2. Судруудын Удирдамжийг ашиглахыг урамшуулан дэмжих үйл ажиллагаа

Судруудын Удирдамжийг ашиглахад нь ангийн гишүүдэд туслахын тулд дараах үйл ажиллагааг ашигла:

Судруудаа хаахыг ангийн гишүүдээс хүс. Тэгээд Судруудын Удирдамж дахь өргөн хүрээтэй эшлэлүүдээс сайн мэдээний хоёр эсвэл гурван өөр сэдвээр судрын аль болох олон эшлэлийг цээжээр хэлэхийг тэднээс хүс. Жишээ нь, даруу зан, дуулгавартай байдал, Ариун Сүнсний бэлгийн тухай тухай эшлэлүүд хэлэхийг та тэднээс хүсч болно. Тэд цааш нь эшлэлүүдийг хэлж чадахгүй болсон үед, дээрх сэдвүүдийг Судруудын Удирдамжаас тэднээр олуул. Эдгээр сэдвүүдээр жагсаасан хэдэн судрыг унш.

Та энэ үйл ажиллагааг дуусгасны дараа Аврагчийн тухай олон эшлэлийг харахын тулд Судруудын Удирдамжийн хуудас 72-76 -г ангийн гишүүдээр гаргуул. Тэд эдгээр эшлэлүүдийг үзэх үеэ, Арванхоёрын Чуулгын Ерөнхийлөгч Бойд К.Пакерын мэдэгдлийг хуваалцахыг та хүсч болно. Тэрээр дээрх хуудсуудыг “Есүс Христ сэдвээр дэлхийн түүхэнд урьд хожид цуглуулж байгаагүй хамгийн олон талыг хамарсан судрын эшлэлийн түүвэр мөн” хэмээн үзжээ (“The Peaceable Followers of Christ,” *Ensign*, 1998 оны 4-р сар, 64).

“Миний өвч хуяг дуулгыг өөрсөд дээрээ авагтун”

Хичээл
43


Зорилго Хилэнцийн эсрэг тэмцэлд өөрсдийгөө хамгаалахын тулд Бурханы өвч хуяг дуулгыг өмсөхөд нь ангийн гишүүдэд туслах.

- Бэлтгэл**
1. Энэ хичээлийн судруудыг залбирч судал.
 2. *Ангийн гишүүний Судлах Удирдамж* (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.
 3. Хэрэв та залуучуудад заадаг бол *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* (36550) товхимлын дараах хэсгүүд дэх мэдээллээс заримыг нь буюу бүгдийг нь нэгтгэн дүгнэхэд бэлтгэхийг ангийн гишүүдээс хүс:
 - а. “Бэлгийн харилцааны цэвэр ариун байдал” (хуудас 26-28).
 - б. “Хувцаслалт ба гадаад төрх” (хуудас 14-16).
 - в. “Үзвэр ба мэдээллийн хэрэгсэл” (хуудас 17-19).
 - г. “Хөгжим, бүжиг” (хуудас 20-21).
 - д. “Шударга байдал” (хуудас 31).
 - е. “Хэл яриа” (хуудас 22-23).

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

Доорх зурагт харуулсантай адилаар, хүний дүрсийг самбар дээр зур. Хүний дүрсийг чиглэн, олон талаас нь ирж байгаа хэдэн хэдэн сум зур.



Судрууд заримдаа уруу таталтуудыг “дайсны галт сумнууд” (С ба Г 3:8; Ефес 6:16; 1 Нифай 15:24; С ба Г 27:17-г үз) гэж нэрлэдгийг тайлбарла. Энэ

хичээл бол эдгээр уруу таталтын заримынх нь тухай, мөн эдгээр уруу таталтаас өөрсдийгөө хамгаалахын тулд бидний өмсөж болох “хуяг дуулгын” тухай юм.

Ярилцах ба
хэрэгжүүлэх нь

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбиран сонгож ав. Эдгээр зарчмыг амьдралдаа хэрхэн хэрэглэх тухай ярилцахад ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Бурханы өвч хуяг дуулгыг өмс

- С ба Г 76:25-28; Мосе 4:3-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Тэнгэр дэх Дайнд оролцсон хоёр хүчний удирдагчид хэн байсан бэ, тэдний зорилго юу байсан бэ? Өнөөдөр дэлхий дээр үүнтэй төстэй зөрчил сөргөлдөөнд бид хэрхэн оролцдог вэ? (С ба Г 76:29; Мосе 4:4-ийг үз)
- Нүгэл хилэнцийн эсрэг тулалдаанд Их Эзэн биднийг хамгаалалтгүй орхиогүйг онцлон тэмдэглэ. С ба Г 27:15-18-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Эдгээр шүлгүүдэд дүрслэгдсэн Их Эзэний хуяг дуулга юу вэ? (Дараах зүйлийг самбар дээр бич. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашигласан бол эдгээрийг өөрийнхөө зурсан хүний дүрсний дэргэд бич)

Үнэнээр бүсээ чанга бүсэл

Зөв шударгын цээжний хуяг

Амар амгалангийн сайн мэдээний бэлтгэлийг хөлдөө өмс

Итгэлийн бамбай

Авралын дуулга

Бурханы Сүнсний илд мөн илчлэлтээр дамжсан Түүний үг

- Бурханы “Өвч хуяг дуулгыг” өмсөхийн тулд бид юу хийж болох вэ? Та нар залбирснаар, судруудыг судалснаар, Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахиснаар, Ариун сүмд явснаар, санваарыг дээдлэн хүндэстгэснээр уруу таталтаас хамгаалах нэмэлт хамгаалалтыг хэрхэн мэдэрдэг вэ?
- Их Эзэний хуяг дуулгын зөвхөн нэг хэсгийг өмссөнөөр эсвэл бүр богино хугацаагаар ч гэсэн үүнийг өмсөхийг үл тоомсорлосноос ямар үр дагавар гарч болох вэ?

Сатан “Хүн бүрийн хуяг дуулганд ямар нэг сул талыг олохыг эрэлхийлдэг. Тэр бидний сул талыг мэддэг, хэрэв бид түүнд боломж олгох юм бол эдгээр сул талыг хэрхэн ашиглахыг ч мэддэг. Зөвхөн зарлигуудыг ойлгосноор, залбирал, судруудыг судлах болон Их Эзэний тослогдогсдын зөвлөгөөг дагаснаар, түүний дайралт, заль мэхнээс бид өөрсдийгөө хамгаалж чадна” хэмээн Арванхоёрын Чуулгын Ахлагч Жозеф Б.Вөөртлин анхааруулжээ (In Conference Report, 1988 оны аравдугаар сар, 44; *Ensign*, 1988 оны арваннэгдүгээр сар, 35).

Энэ хичээлийн үлдсэн хэсэг нь өнөө үе дэх бидний хуяг дуулган дахь сул талуудыг Сатан ашиглахыг хичээж буй гурван зүйл: ариун явдал, шударга зан, хэл яриан дээр анхаарал төвлөрүүлнэ гэдгийг тайлбарла.

2. Ариун явдлын хуулиар амьдар

- Их Эзэний Ариун явдлын хууль гэж юу вэ? (С ба Г 42:22-24; 59:6; 63:16; мөн дараах эшлэлүүдийг үз)

“Их Эзэний ёс суртахууны хууль бол хууль ёсны гэрлэлтээс гадуурх харилцааг цээрлэх, гэрлэлтдээ чин үнэнч байх явдал мөн. Бэлгийн харилцаа зөвхөн нөхөр эхнэр хоёрын хооронд гэрлэлтийн холбооны хүрээнд жам ёсны дагуу байх ёстой. Бэлгийн харилцааны аливаа бусад хавьтал, түүний дотор завхайрал, садар самуун, ижил хүйстэнтэй бэлгийн харилцаанд орох, тэрчлэн лесби бол нүгэл мөн” гэж Тэргүүн Зөвлөл мэдэгджээ (Тэргүүн Зөвлөлийн захидал, 1991 оны арваннэгдүгээр сарын 14).

Арванхоёрын Чуулгын Ахлагч Ричард Г.Скотт сургасан нь: “Гэрлэлтийн холбооноос гадуурх бэлгийн харилцааны аливаа хэт дотносолт, өөр хүний ариун, нууцлаг эрхтнүүдэд хувцастай буюу хувцасгүй байхад нь санаатайгаар хүрэх нь нүгэл бөгөөд Бурхан үүнийг хориглосныг би хэлж байна. Бие махбоддоо сэрлийн ийм өдөөлтүүдийг зориудаар хийх нь бас зөрчил мөн” (In Conference Report, 1994 оны аравдугаар сар, 51; *Ensign*, 1994 оны арваннэгдүгээр сар, 38).

Хэрэв та *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* товхимол дахь “Бэлгийн харилцааны цэвэр ариун байдал” хэсгийг нэгтгэн дүгнэхийг ангийн аль нэг гишүүнээс хүссэн бол үүнийг хийлгэ.

- Ариун явдлын хуулийг зөрчсөний зарим үр дагавар юу вэ? (Сүнсний болон бие махбодын, тэр даруйд илрэх болон урт удаан хугацааны үр дагаврын тухай ярилц) Хүн ариун явдлын хуулийг зөрчих нь бусдад хэрхэн нөлөөлдөг вэ?

“Ёс суртахуунгүй явдал бол хэвийн, хүлээн зөвшөөрч болох, сөрөг үр дагаваргүй зүйл гэсэн санал бодол бол сүүлийн житлүүдэд гарсан хамгийн уршигтай заль мэх юм. Хэрэг дээрээ бол, ёс суртахуунгүй явдал нь олон гай зовлонгийн шалтгаан болдог бөгөөд өнөө үед өргөн дэлгэрсэн бусад олон асуудал, түүний дотор хяналтаас гарсан өвчин, үр зулбуулалт, гэр бүл салж сарних, эцэггүй гэр бүлүүд, өөрсдөө хүүхдээрээ байгаа эхчүүд зэрэг асуудлуудын голлох шалтгаан болж байна” гэж Ахлагч Жозеф Б. Вөөртлин сургажээ (In Conference Report, 1994 оны аравдугаар сар, 100; *Ensign*, 1994 оны арваннэгдүгээр сар, 76).

- Бид ариун явдлын хуулиар амьдарснаар хэрхэн адислагддаг вэ? (С ба Г 121:45-46-г үз) Бид илүү их амар амгалан, баяр баясгаланг, эхнэр буюу нөхрөө, тэрчлэн гэр бүлийн гишүүдээ хайрлах хайр, өөрийгөө болон бусдыг хүндэтгэх хүндлэлийг мэдэрдэг. Ариун явдлын хуулиар амьдрах нь бидний хувьд Ариун Сүнсний нөхөрлөлтэй байхад, ариун ёслолоос зохистойгоор хүртэхэд зайлшгүй чухал нь хариулт байж болно) Бид ариун явдлын хуулинд дуулгавартай байх нь бусдад хэрхэн нөлөөлж болох вэ?
- Ариун явдлын хуулийг зөрчихөд Сатан хүмүүсийг яаж уруу татдаг вэ? Энэ хуулийг зөрчсөнөө хүмүүс яаж зөвтгөхийг оролддог вэ?

Хэрэв та *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* товхимлын хэсгүүдийг нэгтгэн дүгнэхийг ангийн гишүүдээс хүссэн бол дараах хэсгүүдийг тэднээр нэгтгэн дүгнүүл: “Хувцаслалт ба гадаад төрх байдал”, “Үзвэр ба мэдээллийн хэрэгсэл,” “Хөгжим, бүжиг.”

“Та нар порнографийн материал олох гэж Интернетийг шүүх ёсгүй. Та нар бузар бусармаг юм сонсох гэж холын дуудлагын утасны дугаар залгах ёсгүй. Мөн аливаа хэлбэрийн порнографи бүхий видео үзэх ёсгүй. Жигшүүртэй энэ зүйл та нарт огт тохирохгүй. Та нар тахлаас зугтаадаг шиг порнографиас зугтаа. Энэ бол хорлонтой эд. Порнографи зуршил болж мэднэ. Иймээс порнографитай орооцолдсон хүн үүндээ олзлогдож, улмаар үүнийг өөрөө орхиж чадахгүйд хүрдэг. Энэ бол донтуулдаг зүйл” гэж Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли сэрэмжлүүлжээ (In Conference Report, 1998 оны 4-р сар, 66-67; *Ensign*, 1998 оны 5-р сар, 49).

- Ариун явдлын хуулийг зөрчүүлэх уруу таталтуудаас бид өөрсдийгөө хэрхэн хамгаалж болох вэ? Бид ёс суртахуунгүй явдлын нөлөөнөөс зайлсхийхийн тулд гэр орондоо юу хийж болох вэ?
- Ариун явдлын хууль үйлдлийн нэгэн адил бодол санааны цэвэр ариун байдлыг өөртөө багтаадаг уу? (С ба Г 63:16-г үз.) Бид цэвэр ариун биш бодол санааг оюун ухаанаасаа хэрхэн зайлуулж болох вэ?

“Тэгээрүүлэгч аливаа зүйлийг байранд нь” тавих замаар зохисгүй бодол санааг оюун ухаанаасаа зайлуулахыг Арванхоёрын Чуулгын Ахлагч Бонд К.Пакер бидэнд зөвлөжээ (In Conference Report, 1977 оны аравдугаар сар, 90; *Ensign*, 1977 оны арваннэгдүгээр сар, 60). Энэ зөвлөгөөг яаж дагахыг ярилц. Хүч чадлын төлөө залбирах, дуртай дууллаа дуулах буюу дуртай судраа цээжээр давтан хэлэх, гэр бүлийн гишүүдээ хайрлах хайрынхаа тухай бодохыг зөвлөж болно.

3. Шударга бай

- Шударга байх гэж юу гэсэн үг вэ?

“Шударга зан чанар бол худал хэлэхгүй байхаас илүү чухал зүйл. Энэ бол үнэнийг хэлэх, үнэнийг өгүүлэх, үнэнээр амьдрах, үнэнээр хайрлах явдал мөн” гэж Ерөнхийлөгч Жеймс И.Фауст сургажээ (In Conference Report, 1996 оны аравдугаар сар, 57; *Ensign*, 1996 оны арваннэгдүгээр сар, 41).

Хэрэв та *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* товхимлоос “Шударга байдал” хэсгийг нэгтгэн дүгнэхийг ангийн нэг гишүүнээс хүссэн бол үүнийг хийлгэ.

- С ба Г 42:21, 51:9, 97:8-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Бид амьдралынхаа бүх үед шударга байх нь яагаад чухал вэ? Шударга бус байхын үр дагавар юу вэ? Бид шударга байснаар хэрхэн адислагддаг вэ?
- Бид ямар байдлаар шударга биш байхаар уруу татагддаг вэ? Шударга биш байх, ялиггүй жижиг уруу таталтуудад бууж өгөх нь бусад уруу таталтад биднийг хэрхэн илүү өртөмтгий болгож болох вэ? Бид шударга биш байх уруу таталтыг хэрхэн даван туулж чадах вэ?
- Их Эзэнд шударга байх гэж юу гэсэн үг вэ? (Их Эзэнтэй бидний хийсэн гэрээнүүд, бусад амлалтыг сахих, Сүмийн ажил үүргийг биелүүлэх, ариун ёслолоос зохистойгоор хүртэх, аравны нэг болон өргөлөө төлдөг байх нь хариулт байж болно)
- Өөртөө шударга байх гэж юу гэсэн үг вэ? (Энэ нь бид нүглийн хор хөнөөлийг бага гэж үзэж, уучилж болохгүй гэсэн үг.)

- Бид шударга зан чанарыг гэр орондоо хэрхэн үр ашигтайгаар зааж болох вэ? (Ангийн гишүүдийг хариулсны дараа шударга зан чанарыг гэр орондоо заахын тулд *Family Home Evening Resource Book* [31106], хуудас 194-96-г ашиглахыг та тэдэнд зөвлөмж болгохыг хүсч болно)

Шударга байхаар сонгох нь хэцүү ч гэсэн, шударга байхаар сонгосон туршлагаа хуваалцахад ангийн гишүүдийг урь. Эсвэл ажил, сургууль, хамт олон буюу гэртээ өөрсдийн харсан шударга зан чанарын үлгэр жишээг хуваалцахыг тэднээс хүс.

4. Бурханд хүндэтгэл үзүүлдэг, гэгээрүүлэгч хэл яриаг ашигла

- С ба Г 63:60-62, 136:21-ийг ангийн гишүүдтэй хамт унш. Бид Түүний нэрийг хэрхэн хэрэглэх талаар Их Эзэний ямар зарлиг байдаг вэ? Их Эзэний нэрийг хүмүүс дэмий хоосон хэрэглэдэг ямар хэлбэр байдаг вэ? (Их Эзэний нэрийг хүндэтгэлгүйгээр хайнга, хайш яйш хэрэглэх, мөн бүдүүлэг санаа бодол, хилэнцэт үйлтэй холбогдуулан хэрэглэх нь хариулт байж болно)
- Бид Их Эзэний нэрийг дэмий хоосон хэрэглэхээс гадна бусад ямар үг ярианаас зайлсхийх ёстой вэ? (Бүдүүлэг, ичгүүргүй, жудаггүй эсвэл гутамшигтай үг хэллэг хариулт байж болно)

Ерөнхийлөгч Хинкли хэлсэн нь: “Хараал зүхлийн үг бүү хэл. Бүдүүлэг үг хэллэг бүү хэрэглэ. Заваан онигоо гэгчээс зайлсхий. Хар ярианы болон олиггүй муухай үг хэллэгээр буртаглагдсан ярианаас хол хөндий бай. Хэрэв та нар ийм байх юм бол илүү аз жаргалтай байх болно бас үлгэр жишээ тань бусдад хүч чадал өгнө” (In Conference Report, 1987 оны аравдугаар сар, 59; *Ensign*, 1987 оны арваннэгдүгээр сар, 48).

Хэрэв та *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* товхимлын “Хэл яриа” хэсгийг нэгтгэн дүгнэхийг ангийн нэг гишүүнээс хүссэн бол одоо түүгээр үүнийг хийлгэ.

- Зохисгүй үг яриа хэрэглэхийн үр дагавар юу вэ? (Бурханыг болон бусдыг гомдоох, өөрийгөө гутамшигтай болгох, Ариун Сүнсний нөхөрлөлийг алдах нь хариулт байж болно)

Арванхоёрын Чуулгын Ахлагч Даллин Х.Өүкс, “Бүдүүлэг, хар ярианы болхи үг хэллэг бол . . . биднийг Бурханаас тусгаарлаж, Ариун Сүнснийг биднээс холдоход хүргэдгээрээ бидний сүнсний хамгаалалтыг эрэмдэг зэрэмдэг болгодог нүгэл мөн” гэж хэлжээ (In Conference Report, 1986 оны 4-р сар, 69; *Ensign*, 1986 оны 5-р сар, 52).

- Бүдүүлэг, жигшүүртэй, олиггүй муухай үг хэллэг хэрэглэхэд Сатан хүмүүсийг яаж уруу татдаг вэ? Бид зохисгүй үг хэллэг хэрэглэх уруу таталтыг хэрхэн даван туулж чадах вэ? (Зохисгүй үг хэллэг хэрэглэдэг зуршлыг хэрхэн засч залруулах тухай та ярилцаж болно)
- Хэл яриандаа хяналт тавьж сурах нь бидний сүнслэг байдлын өсөлтөд яагаад чухал байдаг вэ? Хэл яриагаа хянах нь бусад уруу таталтаас хол байхад бидэнд хэрхэн тусалж чадах вэ?
- Зохисгүй үг хэллэг хэрэглэдэг хүмүүс бидний эргэн тойронд байгаа үед эсвэл кино, телевиз, номонд зохисгүй үг хэллэг хэрэглэж байгаа үед бид

үүнд хэрхэн хариулах ёстой вэ? (Боломжтой бол зохисгүй үг хэллэг хэрэглэж байгаа газрыг бид орхин явах ёстой. Бид ийм үг яриаг эсэргүүцэж болно)

- Зохисгүй үг хэллэг хэрэглэхгүй байхыг эцэг эхчүүд хүүхдүүддээ хэрхэн зааж болох вэ? (Ангийн гишүүдийг хариулсны дараа зохисгүй үг хэллэг хэрэглэхгүй байхыг хүүхдүүдэд заахын тулд *Family Home Evening Resource Book*, хуудас 215-216-г ашиглахыг та тэдэнд зөвлөмж болгож болно)
- Бид ямар үг яриа хэрэглэхэд Их Эзэн дуртай байдаг вэ? (С ба Г 52:16; 136:24; Ефес 4:29-ийг үз) Бидний үгс ямар байдлаар бусдыг гэгээрүүлж болох вэ? Бурханыг хүндэтгэдэг, гэгээрүүлдэг үг яриа ашиглахад бид бусдыг хэрхэн урамшуулан дэмжиж болох вэ?

Дүгнэлт

Тэнгэрлэг Эцэг бидэнд хайртай, уруу таталтаас хамгаалагдахын тулд Түүний “өвч хуяг дуулгыг” өмсөхийг Тэр биднээс хүсдэгийг онцлон тэмдэглэ. Ариун явдлын хуулиар амьдрах, шударга байх, гэгээрүүлэгч үг яриа ашиглахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Сүнсээр өдөөгдсөний дагуу хичээлийн үеэр ярилцсан үнэнүүдийн тухай гэрчил.

Нэмэлт заах санаанууд

Та зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болгож дараах санаануудаас нэгийг буюу илүү олныг нь ашиглаж болно.

1. Бидний эзэмшиж чадах зэвсгүүд бол Бурханы өвч хуяг дуулга юм

Ахлагч Харольд Б.Лий Арванхоёрын Чуулгад үйлчилж байхдаа Бурханы хуяг дуулга бол зөвхөн хамгаалалт төдийгүй, бид идэвхтэйгээр ашиглаж болох зэвсгүүд болохыг тайлбарласан байдаг:

“[Өвч хуяг дуулгыг өмссөн] хүн нэг гартаа бамбай, нөгөө гартаа илд барьсан байдаг. . . Тэр бамбай нь итгэлийн бамбай, илд нь Бурханы Үг болох Сүнсний илд байдаг. Итгэл болон Бурханы Үг агуулагддаг. . . судруудын мэдлэгээс илүү хүчирхэг ямарваа зэвсгийн тухай би мэдэхгүй юм. Тийнхүү хуяг дуулга өмсөж, хүн, дээрх зэвсгүүдээр бэлтгэгдсэн хүн дайсны өдөөс гарч очиход бэлтгэгдсэн байдаг” (*“Feet Shod with the Preparation of the Gospel of Peace,”* Brigham Young University Speeches of the Year [1954 оны арваннэгдүгээр сарын 9], 7).

2. Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө товхимлоор явуулах үйл ажиллагаа

Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө товхимол дахь жишгүүдээр амьдрах нь хүчирхэг, бат найдвартай хуяг дуулгаар хангахад тусалдгийг тайлбарла. Ангийн гишүүдийг хоёр бүлэгт хувааж, *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* товхимол дахь аль нэг сэдвийг бүлэг бүрд даалгавар болгон өг.

Сэдвийг ярилцахад бүлгүүдэд таван минут өгч, санаануудыг ангид танилцуулахаар бэлтгүүл. Тэгээд бүлэг бүрээр товч танилцуулга хийлгэ. Бүлгүүд танилцуулгандаа дараах даалгавраас нэгийг буюу илүү олныг ашиглахыг зөвлөмж болго:

- а. Аль нэг жишиг энд авч үзэх ёстой асуудал байх нөхцөл байдлын жишээнүүдийг нэрлэ.
- б. Жишээнд нэрлэсэн хүний туршлагыг эсвэл найз нарынхаа туршлагыг хуваалц.
- в. Энд яригдсан амьдралын бодит нөхцөл байдалд хэрхэн хандахыг харуулахын тулд биечлэн үзүүлэх тоглоомыг ашигла.
- г. Энэ жишгийг сахихад тэдэнд юу тусалсан тухай ярилц.
- д. Энэ жишгийг сахихад бусдад хэрхэн туслах тухай санаануудыг хуваалц.
- е. Хэрэв энэ жишгээр амьдрах нь нас чацуутнуудын бүлэгт эсвэл хувь хүнд зөрчил бий болговол юу хийхийг ярилц.

3. Залуучуудыг дэмжих нь

Хэрэв та насанд хүрэгчдэд заадаг бол нэг эцэг эх, Залуу Эрэгтэйчүүдийн эсвэл Залуу Эмэгтэйчүүдийн аль нэг удирдагчийг урьж, залуучуудад тулгарч байгаа сорилт болон тэдний амжилтын тухай товч яриул.

Сонссон зүйлээ анхааралтайгаар нягтлан үзэхийг ангийн гишүүдээс хүс. Залуучуудыг илүү ихээр дэмжиж болох арга замын талаар бодоход нь тэднийг урь. Хариултыг самбар дээр нэгтгэн дүгнэ. Зарим зөвлөмжийг доор жагсаав:

- а. Залуучуудын нэрсийг мэдэж, сана.
- б. Тэднийг шударгаар сонирхож, санаа тавьдаг зүйлүүдээ тэдэнд мэдүүл.
- в. Онцгой хэрэгцээг нь мэдэж, уг хэрэгцээнд хариулах санаачлага гарга.
- г. Авъяас чадвар, хувийн түүх, өсч том хүн болох туршлага, гэрчлэл төлөвших туршлагыг хуваалцах боломжийг эрж хай.
- д. Тэдэнд зааж байсан эсвэл тэдэнтэй хамт ажиллаж байсан залуучуудтай Сүмийн дуудлагаасаа чөлөөлөгдсөний дараа харилцахаа үргэлжлүүл.
- е. Христийнхтэй адил амьдралын сайн үлгэр жишээг үзүүл.
- ё. Өнгөрсөн үеийн алдааг уучилж, хувь хүмүүст элдэв зохимжгүй нэр хаяг өгөхөөс татгалз.

4. “Бурханы өвч хуяг дуулга” видео танилцуулга

Шинэ Гэрээний Видео танилцуулга (53914) байдаг бол “Бурханы өвч хуяг дуулга,” 13 минутын хэсгийг үзүүлэхэд анхаар.

Зорилго Засаг төрийн ажилд оролцох, хуулийг дуулгавартай дагах, нийгэм хамт олныг бэхжүүлэхэд оролцсоноор сайн иргэд байхад нь Сүмийн гишүүдийг урамшуулан дэмжих.

Бэлтгэл

1. Дараах судрууд болон бусад материалыг залбирч судал:
 - а. Сургаал ба Гэрээ 58:21-22, 26-28; 98:4-10; 134; Итгэлийн Тунхаг 1:12.
 - б. Америкийн Нэгдсэн Улсын Хөдөө Аж Ахуйн Нарийн Бичгийн Даргаар үйлчилсэн Ахлагч Эзра Тафт Бенсоны үйлчлэлд анхаарал төвлөрүүлсэн *Бидний Өв*, хуудас 155-56.
2. *Ангийн гишүүний Судлах Удирдамж* (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.

Багшид анхааруулах нь: Төр засаг болон хуулиуд нь улс орон, соёл заншил бүрд өөр өөр байдаг. Энэ хичээлээр юу ярилцах тухай шийдэхдээ орон нутгийн нөхцөл байдалд мэдрэмтгий бай. Зарим бүсэд хичээлийн цагийн ихэнхийг хичээлийн гурав дахь хэсгийг ярилцахад зориулж болно. Маргах буюу шүүмжлэхийг өдөөсөн ярилцлагаас зайлсхий. Шаардлагатай өрчлөлт гаргуулахын тулд хуулийн хүрээнд ажиллахыг Сүмийн удирдагчид бидэнд үргэлж зааварладгийг санагтун.

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

Ахлагч Эзра Тафт Бенсоныг 1952 онд Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгад үйлчилж байхад нь Үндэсний Хөдөө Аж Ахуйн Нарийн Бичгийн даргаар ажиллана уу гэж Нэгдсэн Улсын Ерөнхийлөгч Двайт Д.Эйзенхаур хүссэнийг тайлбарла. Сүмийн Ерөнхийлөгч Давид О.МкКей дэмжсэнээр, Ахлагч Бенсон энэ ажлыг хүлээн авч, сайн ажилласан ажээ. Тэрээр Хөдөө Аж Ахуйн Нарийн Бичгийн Дарга болсныхоо дараа ерөнхий чуулган дээр хэлсэн анхныхаа үгэнд:

“Энэ агуу улс оронд, удирдлага дор нь бидний амьдарч байгаа засгийн газарт, л багахан ч гэсэн үйлчлэх онцгой боломжинд би баяртай байна. Тэргүүн Зөвлөлд мөн зөвхөн зөвшөөрөл төдийгүй, энэхүү гүйцэтгэх ерөнхий дуудлагад хариулахад адислал өгсөн ах нартаа би баярлан талархаж байна” гэжээ (In Conference Report, 1953 оны 4-р сар, 40).

- Ахлагч Бенсоныг уг үүрэгт ажлыг хүлээн авахад нь яагаад дэмжсэн гэж та нар бодож байна?

Сайн иргэд байхад бас нийгэм, улс үндэстнээ бэхжүүлэхэд Сүмийн удирдагчид биднийг дэмждэгийг тайлбарла. Сайн иргэд байх олон арга зам бий. Төр засгийн болон улс төрийн үйл хэрэгт оролцох, хуулийг дээдлэн дуулгавартай сахих, нийгэм хамт олонд үйлчлэх нь эдгээр арга замуудад багтана. Энэ хичээлээр төр засгийн тухай, сайн иргэд байх талаарх Их Эзэний сургаалыг ярилцдаг.

Ярилцах ба
хэрэгжүүлэх нь

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбиран сонгож ав. Судрын зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Удирдлагад оролцох нь

1835 оны наймдугаар сард Огайогийн Көртландад болсон Сүмийн ерөнхий хуралдайгаар төр засгийн талаарх итгэлийн тунхгийг санал нэгтгэйгээр баталсныг тайлбарла. Энэ тунхаг С ба Г 134-т цэдэглэгдсэн байдаг.

- Иргэний засгийн газрын зорилго юу вэ? (С ба Г 134:1, 6-8, 11-ийг үз. Доор жагсаасан зүйлс хариулт байж болно)
 - а. “Нийгмийн сайн сайхан болон аюулгүй байдлын төлөө” (С ба Г 134:1).
 - б. “Гэм зэмгүй хүмүүсийг хамгаалах болон гэмтнүүдийг цээрлүүлэхийн тулд” (С ба Г 134:6).
 - в. “Шашны итгэлээ чөлөөтэйгөөр хөгжүүлэх явдлыг бүх иргэдийн хувьд хамгаалах ” (С ба Г 134:7).
 - г. “Бүх буруу зүйл болон гомдлуудыг барагдуулах” (С ба Г 134:11).
- Бид төр засгийн эдгээр зорилгыг хэрэгжүүлэхэд туслахын тулд юу хийж болох вэ?

Арванхоёрын Чуулгын Ахлагч Том Л.Перригийн дараах мэдэгдлийг унш:

“Сүмийн гишүүд бид олон өөр улс оронд аж төрдөг. Бид амьдардаг улс орондоо өөрсдийн байдал, байр суурийг ойлгодог байх нь хичнээн чухал билээ! Бид улс орныхоо түүх, өв уламжлал, биднийг удирддаг хуулиудыг мэддэг байх ёстой. Төр засгийн ажил хэрэгт оролцох эрхийг хангаж өгдөг орнуудад бид сонгох эрхээ ашиглаж, үнэний зарчмууд, эрх, эрх чөлөөг дэмжин, хамгаалахад идэвхтэй оролцох ёстой” (In Conference Report, 1987 оны аравдугаар сар, 87; *Ensign*, 1987 оны арваннэгдүгээр сар, 72).

- Бид төр засгийн ажил хэрэгт оролцох замаар үнэн, эрх, эрх чөлөөг хэрхэн дэмжиж, хамгаалж чадах вэ?
- “Хуулийг эрх тэгш болон шударга ёсонд нийцүүлэн хэрэглэдэг” (шүлэг 3) удирдагчдыг бид олж сонгон, дэмжих ёстойг Сургаал ба Гэрээ 134 заадаг. Бид удирдагчдыг сонгохдоо өөр ямар шинж чанаруудыг харгалзан үзэх ёстой вэ? (Жишээ нь, С ба Г 98:10-ыг үз) Бид удирдагчдыг ухаалгаар сонгоход өөрсдийгөө хэрхэн бэлтгэж болох вэ?

Бид төр засгийн болон улс төрийн үйл хэрэгт оролцохдоо, “Сүм улс төрийн хувьд төвийг сахидаг. Улс төрийн нам, улс төрийн түшиц байгууллагууд эсвэл улс төрийн намаас нэр дэвшигчдийг Сүм дэмжин сурталчилдаггүй. Сүм болон Сүмийн удирдагчид өөрийг нь дэмждэг гэсэн ойлголтыг нэр дэвшигчид битүүгээр төрүүлэх ёсгүй. Сүм улс төрийн нам буюу нэр

дэвшигчдийг дэмждэг хэмээн тайлбарлаж болох аливаа мэдэгдэл юм уу ийм үйлдлээс Сүмийн удирдагчид, гишүүд зайлсхийх ёстойг бид ойлгодог байх шаардлагатай” гэдгийг тайлбарла (*Church Handbook of Instructions, Book 2: Санваартны болон Туслах Бүлгүүдийн Удирдагчид* [1998], 325).

2. Улс орны хуулиудыг дээдлэн дуулгавартай дагах нь

- Улс орны хуулиудын талаарх бидний үүрэг юу вэ? (С ба Г 58:21-22; 98:4-6; 134:5-6; Итгэлийн Тунхаг 1:12-ыг үз.) Эцэг эхчүүд, багш нар, удирдагчид улс орны хуулиудыг дуулгавартай дагахыг хүүхдэд хэрхэн зааж болох вэ?
- Бид хууль батлан гаргадаг албан тушаалтан, иргэний бусад албан тушаалтнуудад хэрхэн хандах ёстой вэ? (С ба Г 134:3, 6-г үз.) Тэдний хүч чармайлтын төлөө бид талархлаа хэрхэн харуулж болох вэ?
- Шашин, иргэний засгийн газрын хооронд ямар харилцаа байх ёстой вэ? (С ба Г 134:4, 9-ийг үз. Хэрэв шашин шүтлэг нь бусдын эрх, эрх чөлөөг зөрчөөгүй бол засгийн газар шашны талаар хуулиуд гаргаж тулган хүлээлгэх ёсгүйг эдгээр шүлгүүд заадаг) Шашин засаг төрийг хэрхэн бэхжүүлж болох вэ?

3. Нийгэм хамт олныг бэхжүүлэх нь

Church Handbook of Instructions-аас дараах хэсгийг унш:

“Нийгмийг ёс суртахуун, эдийн засаг, соёл зан заншлын хувьд бэхжүүлдэг арга хэмжээнүүдийг дэмжих замаар гишүүд иргэний үүргээ биелүүлэх ёстой. Нийгэм хамт олныг сайжруулах, аж төрж, гэр бүлийг өсгөн өндийлгөх эрүүл саруул газар болгох зохистой зорилгуудад идэвхтэй оролцохыг гишүүдэд уриалдаг билээ” (*Ном 2, хуудас 325*).

Хамт олныг бэхжүүлэх гэж самбар дээр бич.

- Бид хамт олноо бэхжүүлж чадах ямар арга замууд байдаг вэ? (Ярилцах буюу ангийн гишүүдийн хариултууд дээр нэмэхийн тулд дараах мэдээллийг ашигла. Гарчгуудыг самбар дээр бичиж, ярилц)

Бусдад үйлчил

- Сүмийн гишүүд хамт олондоо үйлчлэх нь яагаад чухал вэ?
- Та нар эсвэл Сүмийн бусад гишүүд хамт олны үйлчлэлийн ямар төслүүдэд оролцдог вэ? (Эдгээр туршлагаудыг хуваалцахад ангийн гишүүдийг урь) Гачигдалтай хүмүүсийг та нар хэрхэн мэддэг вэ? Төслийг амжилттай болгоход бүлэг юу хийсэн бэ?
- Та нар, Сүмийн бусад гишүүд хувийн, албан бус арга замуудаар хамт олондоо хэрхэн үйлчлэл үзүүлсэн бэ?
- Өнөөдөр манай нийгэм хамт олонд үйлчлэлийн ямар боломжууд байна вэ? (Зарим зөвлөмжүүдийг хоёр дахь нэмэлт заах санаанаас үз) Нийгэм хамт олны үйлчлэлийн илүү их боломжийг бид яаж мэдэж болох вэ? (Сонин унших, нийгэм хамт олны хэрэгцээнүүдийг Сүмийн удирдлагын цуглаанууд дээр ярилцах, хэрхэн тусалж болохыг ярилцахын тулд улсын байгууллагын албан хаагчидтай уулзаж ярилцах нь хариултуудад багтаж болно)

- Нийгэм хамт олны үйлчлэл ямар арга замуудаар нийгэмд ашиг тустай байдаг вэ? Бид үйлчилснээрээ ямар арга замуудаар адислагддаг вэ?

Олон нийтийн үйлчлэлийн албуудад сонгогдох буюу томилогдож үйлчил

Тэргүүн Зөвлөлөөс Сүмийн гишүүдэд хандаж гаргасан дараах мэдэгдлийг унш:

“Сургуулийн зөвлөлүүд, хотын болон дүүргийн зөвлөл, комиссууд, төрийн хууль тогтоох байгууллагууд, түүнчлэн сонгогддог буюу томилогддог бусад өндөр албуудад үйлчлэх хүсэлтэй байхыг бид эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд шаргуугаар уриалж байна” (Тэргүүн Зөвлөлийн захидал, 1998 оны нэгдүгээр сарын 15).

- Манай нийгэмд байдаг олон нийтийн үйлчлэлийн зарим жишээнүүд юу вэ? Ийм албуудад хүмүүс нийгэмд сайн сайхныг авчрах ямар боломжтой байдаг вэ?

Зохистой зорилго буюу үйл ажиллагаануудыг дэмж

- С ба Г 58:27-г ангийн гишүүдтэй хамт унш. Нийгэм дэх сайн зорилгуудад бид хэрхэн “санаа тавин оролцдог” болох вэ?

Зохистой зорилгыг дэмжих замаар нийгэм, улс орондоо чухал хувь нэмэр оруулсан Хожмын Үеийн нэгэн Гэгээнтний тухай дараах шастирыг хуваалц:

“Долина Смитийг 1986 онд Онтариогийн Торонто Гадасны Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчөөр үйлчилж байхад өсөн нэмэгдсээр байсан порнографийн тухай галын дэргэдэх ярилцлага дээр мэргэжилтний хувиар үг хэлэхийг хүсчээ. Хожим нь тэрээр улс орны үндэсний хэмжээний бүлэгт оролцож, энэ бүлэг порнографийн эсрэг мянга мянган Канадчуудыг тэдний сонгосон албатнуудтай хэлхээ холбоо тогтоолгож, порнографийн тухай асуудлуудыг сөхөн тавиулахад дайчилсан ажээ. . . .

“ . . . 1990 онд түүнийг Канадчууд Ёс Жудгийн төлөө бүлгийн даргад нэр дэвшүүлэхэд түүний оролцоо улам нэмэгдсэн байна. Энэ шинэ ажил үүргийнхээ дагуу тэрээр порнографийн хуулиуд гаргах, өөрчлөх үүрэгтэй мужийн болон холбооны засгийн газрын бүлгүүдийн өмнө олон танилцуулга хийжээ. Тэр нийгмийн дотор порнографи дэлгэрэх явдалд хатуу хяналт тавих талаар орон нутгийн удирдлагуудтай ажилладаг иргэдийн олон бүлэгт хандаж үг хэлсэн байна” (Дональд С.Конки, “Together We Can Make a Difference,” *Ensign*, 1996 оны 2-р сар, 68).

- Нийгэм хамт олны дунд бидний дэмжиж болох зохистой ямар зорилгууд байдаг вэ? Манай нийгэм дэх хилэнцэт нөлөөнүүдтэй бид хэрхэн зохих ёсоор тэмцэж болох вэ?
- Нийгэмд үйлчлэхэд ямар бэрхшээлүүд тохиолддог вэ? Эдгээр бэрхшээлүүдийг бид хэрхэн даван туулж болох вэ? (Нэг бэрхшээл нь бид үйлчлэх цаг хугацаагаа төлөвлөх явдал байж болно. Энэ бэрхшээлийг даван туулах нэг арга зам бол гэр бүлийн гишүүд эсвэл тойргийн гишүүд боломжтой үед хамт ажиллах явдал мөн. Гэр бүл тус тусдаа үйлчлэх биш харин хамтдаа байх боломжийг олгодог)

Арванхоёрын Чуулгын Ахлагч М.Рассел Баллардын дараах мэдэгдлийг хуваалц:

“ ‘Дэлхийд бай гэвч дэлхийнх биш бай. . . гэдэг хэллэгийг бид Сүмд олонтаа эш татан хэрэглэдэг. Энэ хэллэгийг бид . . . хоёр тусдаа анхааруулга буюу зөвлөгөө болгож болно. Нэгдүгээрт, ‘Дэлхийд бай.’ Оролц; Мэдээлэлтэй бай. Бусдыг ойлгодог, хүлээцтэй байх, мөн олон янз байдлыг харгалзан үзэхийг хичээж бай. Үйлчлэл, оролцоогоор дамжуулан нийгэмд утга учиртай хувь нэмрээ оруул. Хоёрдугаарт, ‘Дэлхийнх бүү бай.’ Буруу замаар бүү яв эсвээс зөв биш зүйлийг сонирхох буюу бүү хүлээн ав. . .

“Сүмийн гишүүд бид нөлөөлөгдөх биш харин бусдад нөлөөлөх хэрэгтэй. Бид нүгэл, хилэнцийг үндсээр нь тасалж, идэвхгүй байхын оронд үүнийг оргүй болтол нь арилгах ёстой. Бидний хүн нэг бүр асуудлаас зайлсхийх буюу үл тоомсорлох биш, харин үүнийг шийдвэрлэхэд туслах ёстой ” (In Conference Report, 1989 оны 4-р сар, 100-101; *Ensign*, 1989 оны 5-р сар, 80).

Хожмын Үеийн Гэгээнтнүүд бид хаана аж төрж байгаагаасаа үл хамааран сайн иргэд байх ёстойг онцлон тэмдэглэ. Сайн төр засгийг дэмжих, хамт олноо бэхжүүлэхийн тулд өөрсдийнхөө чадах зүйлүүдийг хийхэд нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Нэмэлт заах санаанууд

Зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр дараах материал нэмэгдэж байна. Та хичээлийнхээ нэг хэсэг болгон эдгээр санаануудаас нэгийг буюу илүү олныг нь ашиглаж болно.

1. Нийгэм дэх сайн дурын үйлчлэлийн тайлан

Нийгэм хамт олны доторх сайн дурын зохион байгуулалттай үйлчлэлүүд, түүнчлэн эдгээр үйлчлэлүүдэд хэрхэн оролцох талаар илтгэх тойргийн буюу салбарын гишүүнийг урьдчилан томил. Эсвэл нийгэм хамт олны ямар нэг хэлбэрийн үйлчлэлд оролцдог ангийн гишүүнийг хийдэг зүйлээ тайлбарлахад урь.

Ярилцлагын хэсэг болгон Сүмийн удирдагчдаас дуудлага буюу үүрэг даалгавар хүлээн авахыг бид хүлээх хэрэггүй, үүнээс өмнө хувиараа буюу хэсэг бүлгээрээ үйлчлэх хэрэгтэйг онцлон тэмдэглэ.

2. Нийгэмд үзүүлэх үйлчлэлийн санаанууд

Хэрэв нийгэмд үзүүлэх үйлчлэлийн хэлбэрүүдийг бодож олоход ангийн гишүүдэд хүндрэлтэй байвал та дараах санаануудаас заримыг нь зөвлөмж болгож болох юм. Энэ ярилцлагын хэсэг болгон Матай 25:34-40-ийг ангийн гишүүдээр уншуул.

Эрүүл мэндийн үйлчлэл: Өвчтэй хүмүүст зориулж хувцас, хоол хүнс хий; эмнэлэгт байгаа буюу орчныхоо өвчтэй хүүхдүүдэд халамж тавь; эмнэлэгт байгаа гэр бүлгүй өвчтөнүүдэд цэцэг аваачиж өг; баяр ёслолуудын үеэр өвчтэй хүмүүсийг сана.

Нийгмийн үйлчлэл: Ур чадвараа хөгжүүлэхэд нь залуучуудад туслах бүлгүүдийг зохион байгуулж удирд; өнчин хүүхдийн асрах байрны хүүхдүүд, орчныхоо сургуулийн сурагчид эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст

оёдол, хоол хийх, гар урлалыг зааж сурга; өндөр настны асрах байранд байдаг хүмүүст юм уншиж өг; өөрийн чинь хэлээр ярьдаггүй хүмүүст хэлний ур чадварыг заа; хараагүй хүмүүст юм уншиж өг; гэр бүлийнхээ болон орчныхоо өндөр настай хүмүүстэй очиж уулзан, ярилц.

3. Эелдэг үйлсээр дамжуулан нийгэм хамт олныг бэхжүүлэх нь

Ерөнхийлөгч Гордон Б.Хинклийн дараах үгсийг хуваалц:

“Эелдэг үйлс юу хийж чаддаг нь гайхмаар юм. Эелдэг үйлс дутагдвал эмгэнэлт явдал тохиож болно. Бид амьдардаг хотуудынхаа замын хөдөлгөөнөөр үүнийг өдөр бүр хардаг. Хэн нэгнийг зам гаргаж өгөхөд зориулсан нэг агшин нь туслуулсан хүнд ч, тусалсан хүнд ч адилхан сайн үйлс байдаг. Бид бусдад эелдэг найрсаг, хүндэтгэлтэй хандсан үед бидний дотоод сэтгэлд ямар нэг зүйл болдог. Энэ бол сайжралтын үйл явцын бүх тал юм, хэрэв шаргуу үргэлжлүүлэх юм бол, энэ нь бидний мөн чанарыг өөрчлөх болно” (In Conference Report, 1996 оны 4-р сар, 70; *Ensign*, 1996 оны 5-р сар, 49).

- Эелдэг үйлсийг өдөр бүр бусдад харуулах ямар боломжууд бидэнд байдаг вэ? (Бид ажиллаж байхдаа, машинаар явж байхдаа, дэлгүүрээс юм авахаар явж байхдаа эсвэл зүгээр л гудамжаар явж байхдаа бусдад тусалж болох нь хариултауд байж болно) Эелдгээр туслах нь нийгэм, хамт олныг хэрхэн бэхжүүлж болох вэ?

Зорилго

Гэр бүлийн мөнхийн ач холбогдлыг ойлгоход нь ангийн гишүүдэд тусалж, гэр бүлээ бэхжүүлэхэд нь тэдэнд сүнслэгээр нөлөөлөх.

Бэлтгэл

1. “Гэр бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг”-ийг залбирч судал (*Ensign*, 1995 оны арваннэгдүгээр сар, 102). Хичээлийн үед ашиглах тунхагийн нэг хувь ангийн гишүүн бүрд байх ёстой. Тунхаг нь энэ гарын авлагын хуудас 304, *Ангийн гишүүний Судлах Удирдамж* (35686)-ийн хуудас 25-26 дээр байгаа. Энэ нь бас бие даасан хэлбэрээр (35602, 35538) байдаг.
2. *Ангийн гишүүний Судлах Удирдамж* (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.
3. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах бол, “Families Can Be Together Forever” (*Hymns*, no. 300; *Children’s Songbook*, 188) дууллыг ангийн гишүүдээр дуулуулахад бэлтгэ. Эсвэл Хүүхдийн Хэсгийн цөөхөн хүнтэй бүлэг танай ангид ирж, энэ дууг дуулж өгөхийг урь.

Багиуд өгөх анхааруулга: Гэр бүлийнх нь нөхцөл ангийн гишүүдийн хувьд өөр өөр байж болно. Эдгээр ялгаануудад мэдрэмтгий бай, хүн бүр дэлхийн буюу Тэнгэрлэг эх эцгийн гэр бүлийн нэг хэсэг гэдгийг онцгойлон анхаар.

**Хичээлийг заах
зөвлөмж**

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа

Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

“Families Can Be Together Forever” дууг ангийн гишүүдээр эсвэл Хүүхдийн Хэсгийн бүлэг хүүхдээр дуулуул (“Бэлтгэл,” зүйл 3-ыг үз).

Дууг дуулсны дараа, доорх үгсийг нийтээр давтан хэлэхийг ангийн гишүүдэд сануул: “Би гэрийнхэнтэйгээ ямагт хамт байхыг хүснэ, / Яавал би ингэж чадахыг Их Эзэн надад харуулсан юм.”

Тэргүүн Зөвлөл болон Арванхоёрын Чуулгаар дамжуулан өгөгдсөн “Гэр бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг”-ийн тухай энэ хичээлээр ярилцана гэдгийг тайлбарла. Тунхаг нь гэр бүлийн талаарх Их Эзэний сургаалыг агуулдаг. Бид эдгээр сургаалыг дагаснаар эдүгээ гэр бүлээ бэхжүүлж, нэгтгэн, мөнхийн гэр бүл болон амьдрахад бэлтгэж чадна.

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбиран сонгож ав. Ярилцаж байгаа зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Бурханы төлөвлөгөөнд гэр бүл төв байр эзэлдэг

“Гэр бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг”-ийг Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли Ерөнхий Нийгмийн Халамжийн Бүлгийн цуглаан дээр 1995 оны есдүгээр сард танилцуулсныг тайлбарла. Тэр үеэс хойш уг тунхгийг Сүмийн гишүүд болон дэлхий даяарх бусад хүмүүст зориулж, олон хэлээр дахин дахин хэвлэсээр байгаа билээ. Тунхгийг олон улс оронд төр засгийн удирдагчдад таницуулсан байна.

Тунхгийн нэр, дэд нэр, эхний хоёр догол мөрийг ангийн гишүүдээр уншуул.

- Бурханы бошиглогчдын энэхүү зөвлөгөө, сэрэмжлүүлэг хэрэгтэйг сануулсан ямар зүйлс бидний гэр бүл, нийгэм, хамт олон, улс оронд болж байна вэ?

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли сургасан нь: “Гэр бүлийн энэ тунхаг эдүгээ яагаад бидэнд байгаа юм бэ? Яагаад гэвэл гэр бүл дайралтын бай болж байна. Бүх дэлхий даяар гэр бүл салж сарниж байна. Нийгэм дэх сайжруулах ёстой газар бол гэр орон мөн. Хүүхэд гэдэг чинь яаж зааж сургасан байна, ихэнхдээ түүгээр л байдаг шүү дээ. Бид гэр бүлийг улам хүчирхэг болгох замаар дэлхийг илүү сайн болгохыг хичээж байна” (“Inspirational Thoughts,” *Ensign*, 1997 оны наймдугаар сар, 5).

- Гэрлэлт болон гэр бүл “Бурханаас томилогддогийг,” бас “Түүний хүүхдүүдийн мөнхийн хувь тавилангийн төлөөх [Түүний] төлөвлөгөөнд төв байр” эзэлдгийг эл тунхаг нотолж байна. Бурханы хүүхдүүдийн мөнхийн хувь тавилангийн төлөөх Түүний төлөвлөгөөнд гэр бүл яагаад төв байр эзэлдэг вэ? (С ба Г 131:1-4; 1 Коринт 11:11-ийг үз.)
- Бурханы бүх сүнсэн хүүхдүүд Түүний дүр төрхөөр бүтээгдсэнийг тунхаг нотолдог (мөн Эхлэл 1:26-27-г үз). Бидний ирээдүйн боломжийн тухай энэ сургаал юу заадаг вэ? Та бол Тэнгэрлэг Эцэгийн гэр бүлийн нэг гишүүн гэдгээ мэдсэн нь дэлхийн гэр бүлийнхээ тухай бодол санаанд чинь хэрхэн нөлөөлдөг вэ? Энэ сургаал биднийг хэрхэн бэхжүүлж чадах вэ?

2. Үүрд мөнхөд хамт байх боломжийг ариун ёслол гэр бүлүүдэд олгодог

Тунхгийн гурав дахь догол мөрийг уншихыг ангийн нэг гишүүнээс хүс.

- Мөнх бус амьдралын зорилгын тухай энэ догол мөр юу зааж байна вэ? Бидний дэлхийн туршлага мөнхийн өсөлт дэвшилд маань хэрхэн тусалж чадах вэ?
- Гэрлэлт, гэр бүл мөнх байхад юу зайлшгүй чухал вэ? (Гэр бүлийн хос Ариун сүмд лацдан холбох ёслолыг хүлээн авах ёстой. Мөн уг ёслолтой холбоотой гэрээнүүдийг сахих ёстой).
- Бид ариун сүмийн гэрээнүүдээ сахих үүргээ хэрхэн бэхжүүлж болох вэ? Ариун сүмд ороход бэлтгэхэд нь эцэг эхчүүд ямар арга замаар хүүхэддээ тусалж болох вэ?

- Бид гэр бүлтэйгээ мөнхөд амьдарч чадна гэсэн амлалт гэр бүлийн гишүүдтэйгээ харилцах бидний өнөөгийн байдалд хэрхэн нөлөөлөх ёстой вэ?

3. Мөнх бус амьдралыг бүтээдэг хүч ариун юм

Тунхгийн дөрөв тав дахь догол мөрийг ангийн гишүүдээр уншуул.

- Мөнх бус амьдралыг бүтээх хүчийг ашиглах талаар Бурхан юу гэж зарлиг болгосон бэ? Энэ зарлигийг дуулгавартай дагах нь яагаад чухал вэ?

Арванхоёрын Чуулгын Ахлагч Хенри Б.Айринг сургасан нь:

“Үр хүүхэд бол энэ амьдралд бас үүрд мөнхөд бидэнд соёрхсон Их Эзэний өв юм. Мөнх амьдралыг зөвхөн бидний үр удам энэ амьдралаас өвлөн авах юм биш. Энэ бол бас мөнхийн өсөлт юм. . . .

“Амьдралыг дээдлэн биширч, ариун нандин болгодог хүчнүүдийг хайрлахыг Тэнгэрлэг Эцэг яагаад зарлиг болгосныг бид ойлгож болно. Хэрэв хүндэтгэл бишрэлийн мэдрэмж энэ амьдралд бидэнд байхгүй бол, үүнийг бидний Эцэг үүрд мөнхөд бидэнд яаж өгч чадах юм бэ?” (“The Family,” *Ensign*, 1998 оны 2-р сар, 15).

Арванхоёрын Чуулгын Ахлагч Жефффри Р.Холланд сургасан нь: “Бие бол бодгалийн зайлшгүй чухал хэсэг мөн. . . Бурханаас өгсөн өөр хүний бие махбодыг бурханлиг зөвшөөрөлгүйгээр ашигладаг хүн өөрийнхөө бодгалийг буруугаар ашиглаж байгаа хэрэг. Амьдралын гол зорилго, үйл явцыг зүй бусаар ашиглаж байгаа хэрэг. . . Бэлгийн харилцааны зөрчил гаргасан хүн бие махбод, сүнс нь аль алинаар гадсанд аргамжигдсан байдгийг” бид нотолж байна (In Conference Report, 1998 оны аравдугаар сар, 99-100; *Ensign*, 1998 оны арваннэгдүгээр сар, 76).

- Хүүхдүүд нь ёс суртахууны цэвэр ариун байдлын ач холбогдлыг ойлгоход туслахын тулд эцэг эхчүүд юу хийж болох вэ? (*Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* [36550] товхимолд эсвэл *Эцэг Эхчүүдийн Удирдамжид* [31125]) байдаг бэлгийн харилцааны цэвэр ариун байдлын тухай сургаалыг хүүхдүүдтэйгээ хамт нэгтгэн дүгнэж ярилцахыг та зөвлөмж болгож болно.

4. Эцэг эхчүүд бие биедээ анхаарал халамж тавьж, хүүхдүүддээ зааж сургах ариун үүрэгтэй

Тунхгийн зургаа дахь догол мөрийг ангийн нэг гишүүнээр уншуул.

- Гэрлэсэн хос бие биеэ хайрлах хайраа бэхжүүлэхийн тулд юу хийж болох вэ?

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли сургасан нь: “Та нар гэрлэхээрээ бие биедээ зүү орох зайгүй үнэнч бай. Аминч үзэл бол аз жаргалтай гэр бүлийн амьдралыг бусниулан сүйрүүлэгч мөн. Хэрэв та ханийнхаа ая тух, сайн сайхан байдал, аз жаргалыг энэ тэргүүнд санаа тавих зүйлээ болгон, хувийнхаа аливаа санаа тавилтыг илүү өндөр зорилго руу чиглүүлэх юм бол аз жаргалтай байх болно бас гэрлэлт тань үүрд мөнхийг туулан өнгөрнө” (“Excerpts from Recent Addresses of President Gordon B. Hinckley,” *Ensign*, 1995 оны 12-р сар, 67).

- Бие биеэ хайрладаг, бие биедээ анхаарал халамж тавьдаг эцэг эхтэй хүүхдүүд хэрхэн адислагддаг вэ?
- Хүүхэддээ заахад эцэг эхчүүд ямар үүрэг хариуцлага хүлээдэг вэ? (Мозая 4:14-15; С ба Г 68:25-28; 93:40-ийг үз) Эдгээр зарчмуудыг хүүхдэд заах үр ашигтай ямар арга зам байдаг вэ? Эцэг эхийн заадаг зүйлээс та нар ямар ашиг тус олсон бэ?
- Эцэг эхчүүд хүүхдэдээ заах ямар боломжуудтай байдаг вэ? (Гэр бүлийн үдэш, гэр бүлийн залбирал, хоолны цаг, унтах үе, хамт юманд явах, хамтран ажиллах нь хариулт байж болно) Эдгээр зүйлийн аль нэгээр нь хүүхдэдээ заасан туршлагаа хуваалцахад ангийн гишүүдийг урь (эсвэл эцэг эх нь тэдэнд заасан тохиолдлыг).
- Хүүхдэд заахад Сүм ямар үүрэгтэй вэ? (Дараах эшлэлийг үз.) Эцэг эхчүүд хүүхдэдээ заахад Сүмтэй хэрхэн хамтран ажиллаж болох вэ?

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл хэлсэн нь: “Хүүхдүүддээ заах нь эцэг эхчүүдийн үүрэг юм. Ням гарагийн хичээл, Хүүхдийн Хэсэг, [Мючел] түүнчлэн Сүмийн бусад байгууллага энэ талаар хоёр дахь үүрэгтэй юм” (*The Teachings of Spencer W. Kimball*, хянан тохиолдуулсан Эдвард Л.Кимбалл [1982], 332).

5. Амжилттай гэрлэлт болон бат бөх гэр бүл зөв шударга зарчмууд дээр үндэслэдэг

Тунхгийн долоо дахь догол мөрийг ангийн нэг гишүүнээр уншуул.

- “Их Эзэн Есүс Христийн сургаал дээр үндэслэсэн гэр бүл аз жаргалд хүрнэ гэдэгт итгэж болно” гэж тунхагт заасан байдаг. Христийн сургаал танай гэрт аз жаргалыг хэрхэн авчирсан бэ?
- “Аз жаргалтай гэрлэлт болон гэр бүлүүд нь итгэл, залбирал, наманчлал, уучлал, хүндэтгэл, хайр энэрэл, өрөвч сэтгэл, ажил хөдөлмөр, түүнчлэн эрүүл саруул, идэвхтэй амралтын үйл ажиллагааны зарчмууд дээр үндэслэгдэж, эдгээрийг баримтлан оршин тогтнодог” гэж тунхагт өгүүлжээ. Эдгээр зарчмуудаас аль нь та нарын гэрлэлт, гэр бүлд онцгой чухал вэ? Эдгээр зарчмуудыг гэр бүлдээ заах үр ашигтай ямар арга хэлбэрийг та нар олсон бэ? (Сүнсээр өдөөгдсөний дагуу, дээрх зарчмуудаас зөвхөн нэг буюу хоёр дээр нь та анхаарал төвлөрүүлж болно. Хэрэв та тунхгийн энэ хэсэгт илүү их хугацаа зориулахыг хүсвэл, дөрөв дэх нэмэлт заах санааг үз.)
- Тунхагт өгүүлснээр, эцгийн үндсэн үүрэг хариуцлага юу вэ? “Хайр болон зөв шударга байдлаар . . . тэргүүлэх” гэж юу гэсэн үг вэ? (С ба Г 121:41-46-г үз)
- Хөвгүүд, залуу эрэгтэйчүүд гэр бүлээ ханган тэтгэхийн тулд одооноос өөрсдийгөө хэрхэн бэлтгэж болох вэ? Албан боловсрол олж, ажлын ур чадварт суралцахад нь залуучуудыг урамшуулан дэмжихийн тулд эцэг эхчүүд юу хийж болох вэ?

- Эхийн үндсэн үүрэг хариуцлагыг тунхагт юу гэж дүрсэлсэн бэ? Энэ үүргээ биелүүлэхэд залуу эмэгтэйчүүд одооноос өөрсдийгөө хэрхэн бэлтгэж болох вэ?

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли сургасан нь:

“Өнгөрсөн үеэс авч хэрэглэх хуучны, ариун үнэт зүйлс байдаг бол, энэ нь гэр орноос эхлэх учиртай. Үнэнд суралцах, ариун журам, хувийн сахилга төлөвших, хайр соёолон хөгжих газар бол гэр орон юм. . .

“Эгч нар аа, үр хүүхдээ хамгаал. . . Эхчүүд та нарт үр хүүхдээс чинь илүү эрхэм үнэт эрдэнэ үнэхээр байхгүй. Энэ амьдралд эсвэл үүрд мөнхөд та нарт байх хамгийн үнэ цэнэтэй зүйл бол үр хүүхэд чинь юм. Та нар нас өтөлсөн үедээ, дэлхийд авчирсан үр хүүхдээ харахад, хэрэв тэд зөв шударгаар, ариун журмаар, цэвэр ариун ёс суртахуунаар амьдарч байвал, та нар хэчнээн аз жаргалтай байх билээ” (“Walking in the Light of the Lord,” *Ensign*, 1998 оны арваннэгдүгээр сар, 99).

- Аавууд хүүхдүүдээ өсгөн хүмүүжүүлэхэд хэрхэн тусалж болох вэ? Эцэг эхчүүд адил тэгш хамтрагчдын хувьд бие биедээ туслах нь яагаад чухал вэ?

6. Гэр бүлээ бэхжүүлэх нь хүн бүрийн үүрэг мөн

Гэр бүл салж сарнихын ноцтой үр дагаврын тухай сэрэмжлүүлгээр, гэр бүлийг бэхжүүлэхэд бүх хүмүүсийг уриалан дуудсанаар тунхаг төгсдөг. Тунхгийн сүүлчийн хоёр догол мөрийг ангийн нэг гишүүнээр уншуул.

- Гэр бүлд чинь илүү их хүч чадал, эв нэгдлийг авчрахад тусалсан ямар зүйл чи хийсэн бэ?
- Нийгэм хамт олныхоо дотор илүү бат бөх гэр бүлүүдийг хөхүүлэн дэмжихийн тулд хувь хүмүүс болон гэр бүлүүд юу хийж болох вэ?

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хотын дарга нарын болон төр засгийн бусад албан тушаалтнуудын цугларалт дээр үг хэлэхдээ: “Манай сургуулиудыг шинэчлэх, сайн иргэд байх ёс жудгийг заахад, өртөг зардал ихтэй шорон гяндан, хорих газруудыг барьж, ажиллуулахаас хавьгүй илүү зардал шаардлагатай байгааг би улс орны хотуудыг тэргүүлдэг, үлэмж их нөлөө бүхий эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд та бүгдэд хандан хэлж байна. . . Гэтэл сургуулиас ч илүү чухал өөр нэг газар бий. Энэ бол гэр бүл юм. Улс орон гэр бүлүүдийнхээ хүч чадлаас илүү их хүчтэй байж чадна гэдэгт би итгэдэггүй” гэжээ (“U.S. Conference of Mayors,” *Ensign*, 1998 оны арваннэгдүгээр сар, 109).

- Улс үндэстнүүд оршин тогтнохын тулд яагаад гэр бүлүүд бат бөх байх ёстой вэ?

Дүгнэлт

Гэр бүлийнхээ талаар эргэцүүлэн бодохыг мөн дараах асуултуудыг авч үзэхийг ангийн гишүүдээс хүс: Гэр бүлийн маань бүх гишүүд өөрсдийг нь хайрладаг миний хайрыг мэдэрдэг үү? Бид мөнхийн гэр бүл байхын төлөө амьдрахыг хичээдэг үү? Би гэр бүлээ бэхжүүлэхийн төлөө юу хийж болох вэ?

Тунхаг дахь зарчмууд үнэн гэдгийг гэрчилж, тунхагт агуулагдсан сургаалуудыг цааш нь судалж, хэрэгжүүлэхэд ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

Нэмэлт заах санаанууд

Та зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр нэмэлт болгож дараах санаануудаас нэгийг буюу илүү олныг нь ашиглаж болно.

1. Зүй бусаар харьцахыг ойлгож, үүнээс зайлсхийх нь

“Хань ижил, үр хүүхэдтэйгээ зүй бусаар харьцсан . . . хүмүүс нэг өдөр Бурханы өмнө өчиг мэдүүлнэ” гэдгийг тунхаг сэрэмжлүүлжээ. Сүмийн удирдагчид бүхий л төрлийн зүй бус харьцааг эсэргүүцдэг. Санваартан ах нарт хандаж хэлсэн Ерөнхийлөгч Гордон Б.Хинклийн дараах үгс эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд аль алинд хамаатай юм:

“Эхнэртэйгээ зүй бусаар бүү харьц. Үр хүүхэдтэйгээ ч зүй бусаар бүү харьц. Харин эхнэр, хүүхдээ өөрийгөө тойруулан хүрээлүүлж, хайраа, хүндэтгэл талархлаа тэдэнд мэдрүүл. Сайн нөхөр бай. Сайн эцэг бай ” (“Inspirational Thoughts,” *Ensign*, 1999 оны зургадугаар сар, 2).

2. “Эцэг эхчүүдийн үүрэг” видео танилцуулга

Doctrine and Covenants and Church History Video танилцуулга (53912) байдаг бол “Эцэг эхчүүдийн үүрэг,” долоон минутын хэсгийг үзүүл. Видеог үзэх үед дараах асуултуудыг тунгаан бодохыг ангийн гишүүдээс хүс:

- Та нар эцэг эхчүүдийнхээ заадаг зүйлээр ямар байдлаар адислагдсан бэ? Хүүхдүүд чинь танаас юу сурахыг та хүсэхсэн бол?

3. Гэр бүлийн талаарх нэмэлт мэдэгдэл

Арванхоёрын Чуулгын Ахлагч Роберт Д.Хейлсийн дараах мэдэгдлийг та уншиж болно:

“Эцэгийн төлөвлөгөө бол гэр бүлийн хайр, гэр бүлийн нөхөрлөл үүрд мөнх үргэлжлэх явдал юм. Гэр бүлийн гишүүн бүрд анхаарал халамж тавьдаг, тэднийг хайрладаг, өргөн дээдэлдэг, бэхжүүлдэг гэр бүлийн дотор байдаг хүн . . . мөнх бус байдалд эцсийг хүртэл зөв шударгаар тэвчиж чадна, бас үүрд мөнхөд хамтдаа аж төрж чадна. Зөвхөн өөрсдийгөө аврах нь хангалтгүй юм. Манай гэр бүлүүд дэх эцэг эх, ах эгч нар дүү нар бүгдээрээ аврагдах нь нэгэн адил чухал юм. Хэрэв бид Тэнгэрлиг Эцэгтээ ганцаараа эргэж очих юм бол, ‘Гэр бүлийн чинь үлдсэн нь хаана байгаа юм бэ?’ гэж биднээс асуух болно” (In Conference Report, 1996 оны аравдугаар сар, 88; *Ensign*, 1996 оны арваннэгдүгээр сар, 65).

4. Бүлгээр ярилцах нь

Тунхгийн долоо дахь догол мөрд жагсаасан аз жаргалтай гэрлэлт, аз жаргалтай гэр бүлийн есөн зарчмыг самбар дээр бич (“аз жаргалтай гэрлэлт ба аз жаргалтай бат бөх гэр бүл” гэсэн нийлэмж үгийн дараа). Ангийн гишүүдийг хоёр бүлэгт хувааж, бүлэг бүрд нэг буюу түүнээс олон зарчмыг даалгавар болгон өг. Эдгээр зарчмуудыг гэр бүлдээ бий болгон, бэхжүүлэхэд туслах арга замын тухай бодохыг бүлгүүдээс хүс. Бүлгүүд үүнийг хэдэн минут ярилцсаны дараа, бүлгийнхээ санааг хуваалцах нэг хүнийг бүлэг бүрээс урь.

5. Тунхгийг гэр бүлийн үдшээр хэлэлцэх нь

Гэр бүлийн тунхгийг энэ долоо хоногийн гэр бүлийн үдшийн үеэр ярилцахыг ангийн гишүүдэд зөвлөмж болго. Дараагийн долоо хоногийн хичээлийн эхэнд энэ туршлагынхаа талаар илтгэл бэлтгэж ирэхийг тэднээс хүс.

ГЭР БҮЛ

ДЭЛХИЙ ДАХИНАА ӨРГӨХ ТУНХАГ

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Тэргүүн Зөвлөл ба Арванхоёр Төлөөлөгчийн Зөвлөл

Есүс Христийн хожмын үеийн гэгээнтнүүдийн сүмийн тэргүүн зөвлөл ба арванхоёр төлөөлөгчийн зөвлөлийнхөн бид эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хоорондын гэрлэлт нь Бурханаас заяасан бөгөөд гэр бүл нь Бүтээгчийн төлөвлөгөөний төвд байдгийг чин сэтгэлээсээ тунхаглаж байна.

Бүх хүн төрөлхтөн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг Бурхан, өөрийн дүр төрхөөр бүтээсэн. Хүн бүр Тэнгэрлэг Эцэг Эхийн хайртай сүнсэлг охин, хүү нь бөгөөд хүн бүр бурханлиг шинж чанар, хувь тавилантай юм. Хүйс бол хувь хүний мөнх бус байдлын өмнөх, мөнх бус болон мөнхийн амьдралын тодорхойлолт ба зорилгын салшгүй шинж чанар юм.

Мөнх бус байдлын өмнөх амьдралд сүнсэлг охид хөвгүүд Бурханыг Мөнхийн Эцэг хэмээн мэдэж, биширч, мөнхийн амьдралыг өвлөн авах тэнгэрлэг хувь заяагаа бүрэн дүүрэн ухааран ойлгож төгс төгөлдөр болон хөгжин дэвшихийн тулд бие махбодтой болж энэ дэлхийд амьдрах тухай Түүний төлөвлөгөөг хүлээн зөвшөөрсөн юм. Аз жаргалын тэнгэрлэг төлөвлөгөө нь насан эцэслэсний дараа ч гэр бүлийн холбоог мөнхжүүлдэг. Ариун сүмийн ёслолууд болон гэрээнүүд нь хувь хүн Бурханы оршихуйд эргэн очих, гэр бүлүүд мөнхөд нэгдэх боломжийг олгодог.

Бурханы Адам, Ева хоёрт өгсөн анхны зарлиг нь эхнэр нөхрийн хувьд эцэг эх болох талаар байлаа. Өдгөө бид Бурханы хүүхдүүдээ “өсөн нэмэгдэж, өнөр өтгөн болж, газар дэлхийг дүүргэ” хэмээсэн зарлиг нь хүчин төгөлдөр байгааг тунхаглаж байна. Түүнчлэн “үр удмаа үлдээх энэхүү нандин хүч нь зөвхөн хууль ёсоор гэрлэсэн эхнэр нөхөр болон эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд байх ёстой” хэмээсэн Бурханы зарлигийг тунхаглаж байна.

Мөнх бус амьдралын арга зам нь тэнгэрээс тогтоогдсон гэдгийг бид тунхагладаг. Бурханы мөнхийн төлөвлөгөөн дэх амьдралын цэвэр ариун байдал, түүний ач холбогдлын чухлыг бид батлан хэлж байна.

Эхнэр нөхөр хоёр нь бие биеэ болон үр хүүхдээ хайрлан халамжлах хариуцлага хүлээнэ. “Үр хүүхэд бол Их Эзэний өв

юм” (Дуулал 127:3). Эцэг эхчүүд нь хүүхдүүдээ хайр, зөв шударга байдалаар өсгөн хүмүүжүүлж бие бялдар болон оюун санааных нь хэрэгцээг хангаж, бие биеэ хайрлан, үйлчилж, Бурханы зарлигуудыг дагаж, хаана ч амьдарсан хуулиа хүндэтгэн сахидаг иргэд байхыг зааж сургах нандин үүрэгтэй юм. Эхнэр нөхөр, эцэг эхчүүд үүргээ хэрхэн биелүүлснээрээ Бурханы өмнө хариуцлага хүлээнэ.

Гэр бүл Бурханаас заяагддаг. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс гэр бүл болох нь Түүний мөнхийн төлөвлөгөөний зайлшгүй нэг хэсэг юм. Хүүхдүүд нь гэр бүлд төрж, гэрлэлтийн тангарагаа үнэнчээр сахидаг эцэг эхээр өсгүүлэх эрхтэй. Их Эзэн Есүс Христийн сургаал дээр үндэслэсэн гэр бүл аз жаргалд хүрнэ гэдэгт итгэж болно. Аз жаргалтай гэрлэлт болон гэр бүлүүд нь итгэл, залбирал, наманчлал, өршөөл, хүндэтгэл, хайр, өрөвч сэтгэл, ажил хөдөлмөр ба гэр бүлээрээ үр бүтээлтэй үйл ажиллагаа зохиох зарчмуудыг баримтлан амьдарна. Тэнгэрийн загвараар эцэг нь гэр бүлээ хайр болон зөв шударга ёсоор тэргүүлэн удирдаж, хэрэгцээт зүйлсээр нь хангаж, хамгаалах үүрэгтэй. Эхийн үндсэн үүрэг бол хүүхдүүдээ хайраар өсгөн хүмүүжүүлэх явдал юм. Энэхүү нандин үүрэг биелүүлэхдээ эцэг эхчүүд харилцан бие биедээ адил тэгш туслах ёстой. Хувь хүн тахир дутуу болох, нас нөгчих болон бусад нөхцөл байдалд зайлшгүй дасан зохицох шаардлага гарч болно. Төрөл төрөгсөдөө шаардлагатай үед туслан дэмжих ёстой.

Ариун явдлын гэгээгээ зөрчин, хань ижил, үр хүүхэдтэйгээ зүй бусаар харьцсан, гэр бүлийнхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүй хувь хүн хожмын нэг өдөр Бурханы өмнө очиг мэдүүлэх болохыг бид анхааруулж байна. Түүнчлэн гэр бүлээ сарниулбал эрт эдүгээгийн бошиглогчдын зөгнөн хэлснээр хувь хүн, нийгэм, улс үндэстнүүдэд гай гамшиг авчрах болно гэдгийг бид сануулж байна.

Итгэл хүлээсэн иргэд, төрийн албан хаагч та бүхнийг нийгмийн үндсэн нэгж болох гэр бүлийг бэхжүүлэн авч явах арга замуудыг ямагт хэрэгжүүлэгчүн хэмээн уриалан дуудаж байна.

Энэхүү тунхгийг 1995 оны 9 сарын 23-нд Юта мужийн Солт Лейк хотноо болсон Ерөнхий Нийгмийн Халамжийн бүлгийн чуулган дээр Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли захисанхаа нэгэн хэсэг болгон унисан юм.

“Сион зүрх сэтгэлдээ цэвэр ариун тэд болой”

Хичээл
46

Зорилго Сионы тухай судрууд юу заадгийг ойлгоход нь ангийн гишүүдэд тусалж, Сионыг байгуулах хүч чармайлтад нь тэдэнд сүнслэгээр нөлөөлөх.

- Бэлтгэл**
1. Дараах судрууд болон бусад материалыг залбирч судал:
 - а. Сургаал ба Гэрээ 57:1-3; 64:33-43; 82:14-15; 97:8-28; 105:1-12; Мосе 7:12-19, 61-63, 68-69; Итгэлийн Тунхаг 1:10.
 - б. *Бидний Өв*, хуудас 43-46, 169-170.
 2. *Ангийн гишүүний Судлах Удирдамж* (35686) дахь энэ хичээлд зориулсан материалыг нэгтгэн дүгнэ. Уг материалыг хичээлийн үед эш татах арга хэлбэрийг төлөвлө.
 3. Мосе 7:12-19, 68-69-д цэдэглэгдсэний дагуу Енохын хотын тухай шастирьг товчлон бэлтгэхийг ангийн нэг гишүүнээс хүс.
 4. Хэрэв та анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагааг ашиглах бол ангийн гишүүн бүрд хэсэг цаас, харандаа эсвэл үзэг авчир.
-

Хичээлийг заах зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа Дараах үйл ажиллагаагаар эсвэл илүү тохиромжтой өөрийнхөө үйл ажиллагаагаар хичээлийг эхэл.

Ангийн гишүүн бүрд цаас, үзэг эсвэл харандаа өг. Амьдралдаа биелүүлэхийг хүсдэг таван чухал зүйлийг тэмдэглэхийг тэднээс хүс. Бичих цаг олгосны дараа Бошиглогч Иосеф Смитийн дараах мэдэгдлийг унш:

“ Бид Сионыг өөрсдийнхөө хамгийн агуу барилга болгон баривал зохино. . . Зөвхөн Сионд болон түүний гадаснуудад биш аваас хүмүүнд ямар ч амар амгалан байхгүй тэр цаг удахгүй ирнэ” (*Teachings of the Prophet Joseph Smith*, эмхтгэсэн Жозеф Фиелдинг Смит [1976], 160-161).

Чангаар хариулахгүйгээр дараах асуултуудыг тунгаан бодохыг ангийн гишүүдээс хүс:

- Жагсаалтаас тань харахад Сионыг байгуулахад хичнээн зүйл тусалж болох вэ? Та нар Бошиглогч Иосеф Смитийн сануулгад хариулахын тулд жагсаалтаа яаж өөрчилж болох вэ?

Сургаал ба Гэрээнд цэдэглэгдсэн илчлэлтүүд Сионыг байгуулах тухай олон зааврыг агуулдаг. Энэ хичээлээр Сион гэж юу болох, Сионыг байгуулахад туслахад биднээс юу шаардагддаг тухай ярилцана.

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хичээлийн материалыг залбиран сонгож ав. Судрын зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж.

1. Сион гэдэг үг хэд хэдэн утгатай

Сион гэдэг үг судруудад олон өөр утгатайг тайлбарла. Дараах судрын хэсгүүдийг ангийн гишүүдтэй хамт унш. Хэсэг бүр дэх Сионы утгыг тогтоож, самбар дээр бич.

а. С ба Г 97:21. (Зүрх сэтгэлдээ цэвэр ариун хүмүүс)

б. С ба Г 82:14. (Сүм болон түүний гадаснууд)

в. Мосе 7:19. (Енохын хот)

г. 2 Самуел 5:6-7; Хаадын Дээд 8:1. (Эртний Иерусалим хот)

д. С ба Г 45:66-67; 57:1-2; Итгэлийн Тунхаг 1:10. (Миссурид баригдах Шинэ Иерусалим.)

е. Еврей 12:22-23. (Өргөмжлөгдсөн хүмүүсийн оршин суух газар)

Судруудад Сион нь Их Эзэний хүмүүс (зүрх сэтгэлдээ цэвэр ариун хүмүүс), өвөрмөц газар эсвэл аль аль нь гэсэн утгатай байж болдгийг онцлон тэмдэглэ. Сионыг өнөө үед байгуулах тухай хичээлээр ярилцахдаа, амьдардаг газар маань Сион хэмээн нэрлэгдэхийн тулд бид зүрх сэтгэлээ ариусган цэвэршүүлэх тухай авч үзэх болно.

2. Сион өмнөх эрин үеүдэд оршиж байсан нь

Бурханы хүмүүсийн дунд Сион оршиж байсан цөөхөн цаг үе өмнөх эрин үеүдэд байсныг тайлбарла. Енохын хот бол Сионыг үндэслэн байгуулсан хүмүүсийн нэг жишээ юм. Мосе 7:12-19, 68-69-д цэдэглэгдсэн үйл явдлуудыг нэгтгэн дүгнэхийг даалгавар авсан ангийн гишүүнээс хүс.

- Енохын үеийн Сионыг юу тодорхойлж байсан бэ? (Мосе 7:12-19-ийг үз.) Тэдний хотыг яагаад Сион гэдэг байсан бэ? (Мосе 7:18-ыг үз) “Нэг зүрх сэтгэл, нэг оюунтай” байх гэж юу гэсэн үг вэ?
- Мянган Жилд Енохын хотод юу тохиолдох вэ? (Мосе 7:61-63-ыг үз. Енохын хот дэлхийд эргэж ирэн Шинэ Иерусалимын хэсэг болно) Енох болон түүний хүмүүсийн шастир өнөөдөр бидэнд яагаад чухал вэ? (Енохын хотын хувь заяаг ойлгоход бидэнд туслахаас гадна, уг шастир нь Сионыг байгуулахын тулд бид юу хийх ёстойг ойлгоход тусалж чадна)

3. Манай эрин үеийн Гэгээнтнүүдэд Сионыг байгуулахыг зарлиг болгосон нь

Сургаал ба Гэрээнд хамгийн олон удаа дурдагддаг нэг сэдэв бол хожмын өдрүүдэд Сионыг байгуулах явдал мөн. Эдгээр илчлэлтэд Сионы талаар 200 гаруй эшлэл байдаг. Зарим эшлэл нь тодорхой байршлыг, зарим нь зүрх сэтгэлийн байдлыг, зарим нь Их Эзэний Сүмийг байгуулах тухай заасан байдаг. Сүм албан ёсоор зохион байгуулагдахаас өмнө “Сионы ашиг сонирхлыг авчирч мөн төлөвшүүлэхийг эрэлхийлэхэд” (С ба Г 6:6; 11:6; 12:6; 14:6) нэлээд олон ах нарыг Их Эзэн чиглүүлжээ.

Сионыг байгуулах нь эхэн үеийн Гэгээнтнүүдийн хувьд зөвхөн зүрх сэтгэлдээ цэвэр ариун болж, эв нэгдэлтэйгээр амьдрах явдал байгаагүй юм. Энэ нь

Сионы хот буюу Шинэ Иерусалимыг байгуулах явдал байлаа. Сионы хот Миссурид, төв газар нь Индепенденс болж баригдах ёстойг Их Эзэн 1831 оны долдугаар сард Бошиглогч Иосеф Смитэд илчилжээ (С ба Г 57:1-3). Энэ илчлэлтийн дараа олон Гэгээнтэн Миссурид цугласан юм. Тэд хэсэгхэн хугацаанд цэцэглэн хөгжсөн ч, удалгүй тэдний дунд зөрчил сөргөлдөөн, хагарал тэмцэл гарчээ. Бас уг нутаг дахь бусад суурьшигчдын дунд ч хурцадмал байдал бий болов. Танхайрагч бүлгүүд 1833 оны арваннэгдүгээр сард Гэгээнтнүүдийг гэр орноос нь хөөв. Гэгээнтнүүд “Сионы гэтэлгэлийг багаахан хугацаагаар хүлээх” (С ба Г 105:9) шаардлагатай болсныг Их Эзэн хэдхэн сарын дараа 1834 оны долдугаар сард илчилжээ. (Миссурид Сионы хотыг байгуулах тухай дэлгэрэнгүй мэдээллийг хичээл 12, 27-гоос үз)

- Эхэн үеийн Гэгээнтнүүд яагаад Сионы хотыг байгуулж чадаагүй вэ? (С ба Г 101:6-8; 105:1-12-ыг үз) Сионыг өнөөдөр байгуулахад бидэнд тусалж чадах юуг тэдний туршлагаас сурч болох вэ? (Сионыг хотод, гадаснуудад эсвэл бид гэр орондоо ч байгуулах байна уу ялгаагүй Сионы хүмүүсийн шинж чанар: цэвэр ариун зүрх сэтгэл, эв нэгдэл, амин хувиа үл хичээх чанарыг хөгжүүлэх ёстойг тайлбарла)

Сионы хотыг байгуулах нь хойшлогдсон ч, зүрх сэтгэлдээ, гадаснууддаа, бас гэр орондоо Сионыг байгуулах хүч чармайлтаа үргэлжлүүлэхийг Хожмын үеийн Бошиглогчид бидэнд ухуулсаар байгаа билээ. Ерөнхийлөгч Харольд Б.Лий хэлсэн нь:

“Зөв шударга хүмүүс, зүрх сэтгэлдээ цэвэр ариун хүмүүс оршин суух Сионы хил хязгаар эдүгээ өргөжин тэлэх ёстой. Сионы гадаснууд бэхжих ёстой. Энэ бүхэн бол дэлхий даяар авралын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд улам илүү хичээнгүй байх замаар Сион өндийн босч, гэрэл цацруулах явдал мөн” (In Conference Report, 1973 оны 4-р сар, 5; *Ensign*, 1973 оны долдугаар сар, 3).

- С ба Г 82:14-15-ыг ангийн гишүүдтэй хамт унш. Эдгээр шүлгүүдэд Их Эзэн юу хийхийг зарлиг болгосон бэ? Сионыг байгуулахын тулд бидний хийх ёстой зарим онцлог зүйл юу вэ? (Дараах судруудыг ангийн гишүүдээр уншуулж, эдгээр судар Сионыг байгуулах талаар юу зааж байгааг тогтоо. Мэдээллийг самбар дээр нэгтгэн дүгнэ. Ярилцлагыг дэмжихийн тулд дараах асуултуудаас сонгож ав)
 - а. С ба Г 97:21. (Зүрх сэтгэлдээ цэвэр ариун байхыг хичээ.) Их Эзэн Сионыг “зүрх сэтгэлдээ цэвэр ариун тэд юм” (С ба Г 97:21) гэж нэрлэн Сионы тодорхойлолтыг хамгийн энгийнээр өгсөн байдаг. Бид зүрх сэтгэлдээ цэвэр ариун болоход өөрсдөдөө туслахын тулд юу хийж болох вэ? (Моронай 7:47-48; 10:32-ыг үз)
 - б. С ба Г 38:27. (Нэгдмэл бай.) Енохын хотын хүмүүс “нэг зүрх сэтгэлтэй мөн нэг оюунтай байсныг” (Мосе 7:18) дүрсэлжээ. Эхэн үеийн Гэгээнтнүүдэд эв нэгдэл дутмаг байсан нь Сионы хотыг байгуулж чадаагүйн нэг шалтгаан байв (С ба Г 101:6; 105:4). Гэр бүлд эв нэгдлийг дээшлүүлэх үр ашигтай ямар арга зам байна вэ? Бид тойрогтоо хэрхэн улам эв нэгдэлтэй байж болох вэ?
 - в. С ба Г 64:34-35; 105:3, 5-6. (Дуулгавартай бай) Сионы хот тэр үед байгуулагдаагүй нэг шалтгаан бол дуулгаваргүй байдал мөн гэж Их Эзэн С ба Г 105-д дурдсан байдаг. Сайн мэдээний зарчмуудад дуулгавартай байсны үр дүнд чи өөрөө бас танай гэрийнхэн ямар арга замаар

бэхэжсэн бэ? Гишүүд сайн мэдээний зарчмуудад дуулгавартай байснаар танай тойрог болон гадас хэрхэн бэхэжсэн бэ?

- г. С ба Г 105:3. (Ядуус, зовж зүдэрсэн хүмүүст анхаарал халамж тавь) “Ядуус болон өөрсдийн дундах зовж зүдрэгсдэд” (С ба Г 105:3) анхаарал халамж тавиагүй учраас Миссурид Сионыг байгуулахыг хичээж байсан Гэгээнтнүүдийг Их Эзэн шүүмжилсэн билээ. Гачигдалтай хүмүүст анхаарал халамж тавих нь яагаад Сионыг байгуулахын нэг хэсэг байдаг вэ? Гачигдалтай хүмүүст анхаарал халамж тавих ямар боломж бидэнд байдаг вэ?
- д. С ба Г 97:10-16. (Ариун сүм барьж, адислалыг нь хүлээж ав) Сионыг байгуулахад ариун сүм яагаад чухал байдаг вэ? (С ба Г 97:13-16; 105:9-12-ыг үз)
- е. С ба Г 105:10. (Бие биедээ зааж, үүрэгтээ улам төгс суралц) Бид гэр бүлдээ болон Сүмийн албан ёсны үйл ажиллагаан дээрх заалтыг сайжруулахын тулд юу хийж болох вэ? Бид ямар арга замаар ажил үүрэгтээ илүү сайн суралцах хэрэгтэй вэ?
- ё. С ба Г 133:8-9. (Сайн мэдээг дэлхийд номло) Их Эзэн хүмүүсийг Вавилоноос (дэлхий) Сион руу дуудахад Сүмийн ахлагч нарыг чиглүүлж байв. Сайн мэдээг номлох нь Сионы гадаснуудыг ямар арга замаар бэхжүүлдэг вэ?

4. Сионы ирээдүйн тухай алдар суут амлалтуудыг судрууд агуулдаг

Эцсийн өдрүүдэд Сионд ирэх олон адислалын тухай Их Эзэн Сургаал ба Гэрээнд өгүүлсэн байдаг. Эдгээр адислалын заримынх нь жишээ болгож, С ба Г 97:18-25-ыг ангийн гишүүдээр уншуулж, Сионд тухайлан амлагдсан адислалуудыг олуул. Мөн дараах жагсаалтыг үз.

- а. Сион өрнөн дэлгэрч, сүр жавхлантай, аугаа болно (С ба Г 97:18).
- б. Дэлхийн үндэстнүүд Сионыг хүндэлнэ (С ба Г 97:19).
- в. Их Эзэн Сионы аврал байна (С ба Г 97:20).
- г. Сион баясах болно (С ба Г 97:21).
- д. Сион Их Эзэний өшөө авалтаас зайлна (С ба Г 97:22-25).
- Бид эдгээр адислалыг хүртэхийн тулд юу хийх ёстой вэ? (С ба Г 97:25-ыг үз.)
 - Сионы ирээдүй та нарт ямар сэтгэгдэл төрүүлдэг вэ?

“Сионыг байгуулах нь эрин зуун болгон дахь Бурханы хүмүүсийн сонирхлыг татсан зорилго юм. Энэ бол Бошиглогчид, санваартнууд, хаадын онцгой баяр баясалтайгаар дээдэлсээр ирсэн сэдэв мөн. Тэд бидний амьдарч байгаа энэ үеийг баяр баясалтайгаар хүсэн хүлээсээр ирсэн юм. Тэд тэнгэрлигээр, баяр хөөртэй хүсэн хүлээлтээр сүнслэгээр нөлөөлөгдөж, манай өнөө үеийн тухай дуулж, бичин, бошиглож байв. . . Бид бол Хожмын Үеийн алдар сууг тохиолгон авчрахаар Бурханы [сонгосон], ивээгдсэн хүмүүс юм” хэмээн Бошиглогч Иосеф Смит сургажээ (*Teachings of the Prophet Joseph Smith*, эмхтгэсэн, Жозеф Фиелдинг Смит [1976], 231).

Дүгнэлт

Ерөнхийлөгч Гордон Б.Хинклийн дараах мэдэгдлийг хуваалц:

“Би нэн тодорхой биш дэлхийд гайхалтай ирээдүйг харж байна. Хэрэв үнэт зүйлсээсээ салахгүй байх юм бол, хэрэв бид өөрсдийнхөө өв дээр барих юм бол, хэрэв бид Их Эзэний өмнө дуулгавартайгаар зөвхөн сайн мэдээгээр амьдрах юм бол, бид гайхалтай сайхан арга замаар адислагдана.

Биднийг аз жаргалын онцгой түлхүүрийг олсон, хосгүй өвөрмөц хүмүүс хэмээн харах болно.

“ ‘Олон ард түмэн ирцгээ, ирцгээ Эзэний уул руу . . . гэнэ. Учир нь хууль Сионоос гарч, Эзэний үг Иерусалимаас гарна’ (Исаиа 2:3).

“Бидний өнгөрсөн үе агуу байлаа, өнөө үе маань гайхалтай байна, ирээдүй маань алдар суутай байж чадна” (In Conference Report, 1997 оны 10-р сар, 94; *Ensign*, 1997 оны 11-р сар, 69).

Сионыг зүрх сэтгэлдээ, гэр бүлдээ, гадаснууддаа байгуулахад нь ангийн гишүүдийг урамшуулан дэмж. Сүнсээр өдөөгдсөний дагуу энэ хичээлийн үеэр ярилцсан үнэнүүдийн тухай гэрчил.

Нэмэлт

заах санаа

Та зөвлөмж болгосон хичээлийн төлөвлөгөөн дээр дараах санааг нэмэн ашиглаж болно.

Сионы тухай дууллууд

Дараах дууллуудын нэгийг ангийн гишүүдээр дуулуулах буюу үгсийг нь уншуулахаар бэлтгэ: “Өндөр Уулын оргил дээр” (*Дууллууд*, но. 5); “Израил, Израил, Бурхан дуудаж байна ” (д. 7); эсвэл “Beautiful Сион, Built Above” (д. 44). Эсвэл дууллуудын нэгийг гоцлол дуучин буюу цөөн хүнтэй бүлгээр дуулуулахаар бэлтгэ. Уг дуулал Сионыг байгуулах тухай хэрхэн дүрсэлж байгааг ярилц.

Сүмийн түүхийн он дараалал ба газрын зургууд

Сүмийн түүхийн он дараалал

1805 оны арванхоёрдугаар сарын 23

Эцэг Иосеф Смит, Люси Мак Смит нарын гэр бүлд Иосеф Смит Вермонтын Шаронд төржээ (Иосеф Смит Түүх 1:3-4-ийг үз).

1820 оны хаврын эхээр

Иосеф Смит Нью-Йорк (Иосеф Смит Түүх 1:15-20-ийг үз) мужид гэрийнхээ ойролцоо ойн цоорхойд Анхны Үзэгдлийг хүлээн авав.

1823 оны есдүгээр сарын 21-22

Тэнгэр элч Моронай Иосеф Смит дээр ирж, Мормоны Номын цэдгийн тухай ярих. Иосеф ойролцоох гүвээнд (Кумора) булсан алтан ялтсуудыг үзэв (Иосеф Смит Түүх 1:27-54-ийг үз).

1827 оны есдүгээр сарын 22

Иосеф Смит Кумора гүвээн дээр алтан ялтсуудыг Моронайгаас хүлээн авав (Иосеф Смит-Түүх 1:59-ийг үз).

1829 оны тавдугаар сарын 15

Иохан Баптист Аароны санваарыг Иосеф Смит, Оливер Каудери хоёрт Пеннсилвангийн Хармонид олгожээ (С ба Г 13; Иосеф Смит Түүх 1:71-72-ыг үз).

1829 оны тавдугаар сар

Иосеф Смит, Оливер Каудери хоёр Мелкизедек санваарыг Петр, Иаков, Иохан нараас Пеннсилвангийн Хармони, Нью-Йоркийн Колесвиллийн хоорондох Сасквиеханна голын ойролцоо хүлээн авчээ (С ба Г 128:20).

1829 оны зургадугаар сар

Мормоны Номны орчуулга дуусав. Гурван Гэрч мөн Найман Гэрчид алтан ялтсуудыг үзүүлжээ (2 Нифай 11:3; 27:12-13; С ба Г 17-г үз).

1830 оны гуравдугаар сарын 26

Анхны хэвлэмэл Мормоны Ном Нью-Йоркийн Палмирад гарав.

1830 оны дөрөвдүгээр сарын 6

Нью-Йоркийн Фейетте хотхонд Сүм зохион байгуулагдав.

1830 оны есөөс аравдугаар сар

Леменчүүдэд (уугуул америкчууд) номлох анхны номлогчид дуудагдав (С ба Г 28; 30; 32-ыг үз).

1830 оны арванхоёрдугаар сараас 1831 оны нэгдүгээр сар

Огайод цуглахыг Их Эзэн Гэгээнтнүүдэд зарлиглав (С ба Г 37; 38:31-32-ыг үз).

1831 оны долдугаар сарын 20

Миссурийн Индепенденс дэх Сионы хотын газар (Шинэ Иерусалим) Бошиглогч Иосеф Смитэд илчлэгдэв (С ба Г 57; Итгэлийн Тунхаг 1:10-ыг үз).

1833 оны гуравдугаар сарын 18

Сидней Ригдон, Фредерик Г.Виллямс хоёр Сүмийн Ерөнхийлөгчийн Зөвлөлийн зөвлөхөөр онцгойлон адислагдаж, хаант улсын түлхүүрүүдийг тэдэнд өгөв (С ба Г 81, 90-ийн хэсгийн тойм; С ба Г 90:6-г үз).

1833 оны арваннэгдүгээр сарын 7

Гэгээнтнүүд Миссурийн Жаксон дүүрэг дэх танхайрагч бүлгүүдээс зугтаж, Миссури мөрнийг гатлан, Миссурийн Клей дүүрэг рүү шилжиж эхлэв.

1834 оны тавдугаар сарын 5

Жаксон дүүргээс албадуулан гарсан Гэгээнтнүүдэд туслахын тулд Иосеф Смит Сионы Хуарангийн удирдагчийн хувьд, Огайогийн Кертландыг орхин Миссурийг зорив.

1835 оны хоёрдугаар сарын 14

Огайогийн Кертландад Арванхоёрын Чуулгын Төлөөлөгчид зохион байгуулагдав (С ба Г 107:23-24-ийг үз).

1835 оны хоёрдугаар сарын 28

Далын Нэгдүгээр Чуулгыг Огайогийн Кертландад зохион байгуулав.

1835 оны наймдугаар сарын 17

Сургаал ба Гэрээг Огайогийн Кертландад Сүмийн жишиг бүтээлээр хүлээн зөвшөөрөв.

1836 оны гуравдугаар сарын 27

Кертландын Ариун сүм онцгойлон адислагдав (С ба Г 109-ийг үз).

1836 оны дөрөвдүгээр сарын 3

Есүс Христ Кертландын Ариун сүмд Иосеф Смит, Оливер Каудери хоёр дээр хүрч ирэв (С ба Г 110:1-10-ыг үз). Мосе, Елиас, Елиа нар хүрч ирэн, санваарын түлхүүрүүдийг дамжуулж өгөв (С ба Г 110:11-16-г үз).

1837 оны долдугаар сарын 19

Ахлагч Хебер К.Кимбалл, өөр зургаан хүний хамт анхны гадаад дахь номлолоор Английн Ливерпүүлд хүрч ирэв.

1838 оны дөрөвдүгээр сарын 26

Сүмийн нэр илчлэлтээр тодорхой болов (С ба Г 115:4-ийг үз).

1838 оны арванхоёрдугаар сарын 1-нээс 1839 оны дөрөвдүгээр сарын 16

Бошиглогч Иосеф Смит болон бусад хүмүүс Миссурийн Либерти дэх Либерти Шоронд хоригджээ (С ба Г 121-23-ыг үз).

1840 оны наймдугаар сарын 15

Нас барагсдын өмнөөс хийх баптисмыг Бошиглогч Иосеф Смит олон нийтэд зарлав.

1841 оны аравдугаар сарын 24

Абрахамын хүүхдүүдийг эргэж ирэхийн төлөө Ахлагч Оорсон Хайд Палестиныг онцгойлон адислав.

1842 оны гуравдугаар сарын 17

Эмэгтэйчүүдийн Нийгмийн Халамжийн Бүлэг Иллинойн Наувуд зохион байгуулагдав.

1842 оны тавдугаар сарын 4

Ариун сүмийн анхны бүрэн хишиг Иллинойн Наувуд өгөгдөв.

1844 оны зургадугаар сарын 27

Иосеф Смит „Хайрум Смит хоёр Иллинойн Картейж шоронд алагдав (С ба Г 135-ыг үз).

1846 оны хоёрдугаар сарын 4

Наувугийн Гэгээнтнүүд өрнөд рүү шилжихийн тулд Миссипи мөрнийг гатлав. Зарим Гэгээнтнүүд Нью-Йорк хотоос Калифорнийг зорин *Бруклин* далайн онгоцоор гарав.

1846 оны долдугаар сарын 16

Мормоны Суман Айовад Нэгдсэн Улсад алба хааж эхлэв.

1847 оны дөрөвдүгээр сар

Ерөнхийлөгч Бригам Янгийн анхдагч нарын бүлэг өрнөд рүү аянд гарч, Винтер Квортерсыг орхив (С ба Г 136-г үз).

1847 оны долдугаар сарын 24

Ерөнхийлөгч Бригам Янг Солт Лейкийн Хөндийд орж ирэв.

1847 оны арванхоёрдугаар сарын 27

Бригам Янг Сүмийн Ерөнхийлөгчөөр дэмжигдэн батлагдав.


1848 оны тав-зургадугаар сар

Солт Лейк Хөндийд хүрэлзгэнэ ургац сүйтгэв. Хүрэлзгэнийг цахлайн сүрэг барьж идсэн учир тариан талбай бүрэн устгагдахаас аврагджээ.

1849 оны арванхоёрдугаар сарын 9

Ням гарагийн хичээлийг Ричард Баллантин зохион байгуулав.

<p>1850 оны зургадугаар сарын 15 Deseret News Солт Лейк хотод хэвлэгдэж эхлэв.</p> <p>1856 оны аравдугаар сар Виллийн болон Мартины гар тэрэгтэй бүлэг өвлийн эхэн үеийн цасан шуурганд саатсаныг Солт Лейкийн Хөндийгөөс ирсэн аврах бүлэг олжээ.</p> <p>1869 оны арваннэгдүгээр сарын 28 Залуу Эмэгтэйчүүдийн Хөтөлбөрийн өмнөх байгууллага Залуу Бүсгүйчүүдийн Хэмнэлтийн Нийгэмлэг зохион байгуулагдав.</p> <p>1875 оны зургадугаар сарын 10 Залуу Эрэгтэйчүүдийн хөтөлбөрийн өмнөх байгууллага Залуу Эрэгтэйчүүдийн Харилцан Сайжралтын Нийгэмлэг зохион байгуулагдав.</p> <p>1877 оны дөрөвдүгээр сарын 6 Ютагийн Сейнт Жоржийн Ариун сүм онцгойлон адислагдав. Санваартны байгууллага болон Сионы гадаснуудыг зохион байгуулж, цэгцлэх илчлэлтийг Ерөнхийлөгч Бригам Янг хүлээн авав.</p> <p>1878 оны наймдугаар сарын 25 Аурели Спенсер Рожерс Хүүхдийн Хэсгийн анхны цуглааныг Ютагийн Фармингтонд зохион байгуулав.</p> <p>1880 оны аравдугаар сарын 10 Жон Тейлор Сүмийн Ерөнхийлөгчөөр дэмжигдэн батлагдав. Агуу Үнэт Сувдыг жишиг бүтээл болгон хүлээж авав.</p> <p>1883 оны дөрөвдүгээр сарын 14 Далыг зохион байгуулах илчлэлт Ерөнхийлөгч Жон Тейлорт өгөгджээ.</p> <p>1889 оны дөрөвдүгээр сарын 7 Вилфорд Вудрафф Сүмийн Ерөнхийлөгчөөр дэмжигдэн батлагдав.</p> <p>1890 оны аравдугаар сарын 6 Олон эхнэр авах ёсыг төгсгөл болгон, “Тунхаг Бичиг” ерөнхий чуулган дээр дэмжигдэн батлагдав (Албан Тунхаг 1-ийг үз).</p> <p>1893 оны дөрөвдүгээр сарын 6 Ерөнхийлөгч Вилфорд Вудрафф 40 жил баригдсаных нь дараа Солт Лейкийн Ариун сүмийг онцгойлон адислав.</p> <p>1898 оны есдүгээр сарын 13 Лорензо Снөү Сүмийн Ерөнхийлөгч болов.</p> <p>1899 оны тавдугаар сарын 17 Аравны нэгд онцгой анхаарал хандуулахыг өдөөсөн илчлэлтийг</p>	<p>Ерөнхийлөгч Лорензо Снөү Ютагийн Сейнт Жоржид хүлээн авчээ.</p> <p>1901 оны аравдугаар сарын 17 Жозеф Ф.Смит Сүмийн Ерөнхийлөгч болов.</p> <p>1918 оны аравдугаар сарын 3 Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит нас барагсдын гэтэлгэлийн тухай үзэгдэл хүлээн авчээ (С ба Г 138-ыг үз).</p> <p>1918 оны арваннэгдүгээр сарын 23 Хебер Ж.. Грант Сүмийн Ерөнхийлөгч болов.</p> <p>1936 оны дөрөвдүгээр сар Эдийн засгийн их уналтын үед ядуучуудад туслахын тулд бий болсон Сүмийн аюулгүй байдлын хөтөлбөрийг Сүмийн Халамжийн хөтөлбөр болгов. Уг хөтөлбөр Ерөнхийлөгч Хебер Ж.Грантын өмнө нь хүлээн авсан илчлэлтээс эхлэн хөгжжээ.</p> <p>1941 оны дөрөвдүгээр сарын 6 Арванхоёрын туслахууд анх удаа дуудагдав.</p> <p>1945 оны тавдугаар сарын 21 Жорж Альберт Смит Сүмийн Ерөнхийлөгч болов.</p> <p>1951 оны дөрөвдүгээр сарын 9 Давид О.МкКей Сүмийн Ерөнхийлөгчөөр дэмжигдэн батлагдав.</p> <p>1961 оны есдүгээр сарын 30 Сүмийн бүх хөтөлбөр санваараар дамжуулан гэр бүл, хувь хүмүүсийг бэхжүүлэхийн төлөө зохицуулагдаж байх ёстойг Тэргүүн Зөвлөлийн удирдлага дор, Ахлагч Харольд Б.Лий зарлав.</p> <p>1964 оны аравдугаар сар Гэр бүлийн үдшийг тогтмол явуулж байхад онцгой анхаарал хандуулав.</p> <p>1970 оны нэгдүгээр сарын 23 Жозеф Фиелдинг Смит Сүмийн Ерөнхийлөгч болов.</p> <p>1971 оны нэгдүгээр сар Сүмийн шинэ сэтгүүлүүд—<i>Ensign</i>, <i>New Era</i>, <i>Найз</i> нийтлэгдэж эхлэв.</p> <p>1972 оны долдугаар сарын 7 Харольд Б.Лий Сүмийн Ерөнхийлөгч болов.</p> <p>1973 оны арванхоёрдугаар сарын 30 Спенсер В.Кимбалл Сүмийн Ерөнхийлөгч болов.</p> <p>1975 оны аравдугаар сарын 3 Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл Далын Нэгдүгээр Чуулгыг өөрчлөн зохион байгуулсныг зарлав.</p>	<p>1976 оны дөрөвдүгээр сарын 3 Агуу Үнэт Сувдад хоёр илчлэлт нэмэгдэв. 1981 онд эл хоёр илчлэлтийг С ба Г-ний хэсэг 137, 138 болгон шилжүүлжээ.</p> <p>1978 оны есдүгээр сарын 30 Арьсны өнгийг харгалзахгүйгээр зохистой эрэгтэй гишүүн бүрд санваар олгох тухай илчлэлтийг Сүм дэмжин баталжээ (Албан Тунхаг 2-ыг үз).</p> <p>1979 оны есдүгээр сар Хаан Жеймсийн Библийн ХҮГ-ний хэвлэл судлах тусламжийн хамт хэвлэгдэв.</p> <p>1981 оны есдүгээр сар Мормоны Ном, Сургаал ба Гэрээ, Агуу Үнэт Сувд шинээр хэвлэгдэв.</p> <p>1984 оны зургадугаар сар Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөлүүд албан ёсоор нээгдэж, гишүүдийг нь Далаас дууджээ.</p> <p>1985 оны арваннэгдүгээр сарын 10 Эзра Тафт Бенсон Сүмийн Ерөнхийлөгч болов.</p> <p>1989 оны дөрөвдүгээр сарын 1 Далын Хоёрдугаар Чуулгыг өөрчлөн зохион байгуулав.</p> <p>1994 оны зургадугаар сарын 5 Ховард В.Хантер Сүмийн Ерөнхийлөгч болов.</p> <p>1995 оны гуравдугаар сарын 12 Гордон Б.Хинкли Сүмийн Ерөнхийлөгч болов.</p> <p>1995 оны дөрөвдүгээр сарын 1 Бүсийн Эрх мэдэлтэн гэдэг удирдлагын шинэ албан тушаалыг зарлав.</p> <p>1995 оны есдүгээр сарын 23 Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын “Гэр бүл: Дэлхий дахинаа Өргөх Тунхаг”-ийг Ерөнхий Нийгмийн Халамжийн Бүлгийн цуглаан дээр Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли уншиж танилцуулав.</p> <p>1997 оны дөрөвдүгээр сарын 5 Бүсийн Эрх Мэдэлтнүүд Далуудаар дуудагдах болов. Далын Гуравдугаар, Дөрөвдүгээр, Тавдугаар Чуулга зохион байгуулагдав.</p> <p>1997 оны аравдугаар сарын 4 Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли жижиг ариун сүмүүд барих төлөвлөгөөг зарлав.</p> <p>1997 оны арваннэгдүгээр сар Сүмийн гишүүнчлэл 10 саяд хүрэв.</p> <p>1998 оны дөрөвдүгээр сарын 5 Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли 2000 онд үйлчлэлд байгаа 100 ариун сүмтэй болох зорилгыг зарлав.</p>
--	---	---



1. Өмнөд Бейнбриж. Бага Иосеф Смит Эмма Хейл хоёр энд 1827 оны нэгдүгээр сарын 18-нд гэрлэжээ (Иосеф Смит Түүх 1:57-г үз).

2. Колесвилл. Колесвилл хотхонд 1830 онд эцэг Жозеф Найтын гэрт Сүмийн анхны салбаруудын нэг зохион байгуулагджээ.

3. Хармони дахь Хүү Иосеф Смитийн гэр. Мормоны Номны орчуулгын ихэнх нь энд хийгджээ. 1829 онд Сасквисханна голын эрэг дээр санваар сэргээгдэв (С ба Г 13; 128:20; Иосеф Смит–Түүх 1:71-72-ыг үз).

4. Фейетте. Энд Гурван Гэрч алган ялгууд болон тэнгэр элч Моронайг харжээ (С ба Г 17-г үз). 1829 оны зургадугаар сард энд Мормоны Номын орчуулга дуусав. 1830 оны дөрөвдүгээр сарын 6-нд Сүм энд зохион байгуулагдав (С ба Г 20-21-ийг үз).

5. Мендон. Бригам Янг Хебер К.Кимбалл хоёр сэргээгдсэн сайн мэдээг анх сонсох үедээ энд амьдарч байв.


6. Кертланд. Леменчүүд рүү илгээгдсэн номлогчид 1830 онд энд зогсож, Сидней Ригдон болон бусад хүмүүст энд багтисм хүртээжээ. 1831 оны хоёрдугаар сарын эхнээс 1838 оны нэгдүгээр сарын 12-ныг хүртэл Кертландад Сүмийн байгуулага байв. Энэ эрин үеийн анхны ариун сүм энд баригдаж, 1836 оны гуравдугаар сарын 27-нд онцгойлон адислагджээ (С ба Г 109-ийг үз).

7. Эри Суваг. Нью-Йорк дахь Сүмийн гурван салбар 1831 оны дөрөв, тавдугаар саруудад Эри Суваг, Эри нуураар дамжин, Огайогийн Кертланд руу дүрвэжээ.

8. Хайрам. Иосеф Эмма хоёр 1831 оны есдүгээр сараас 1832 оны есдүгээр сар хүртэл энд амьдарч байв. Иосеф Сидней Ригдон хоёр Библийн Иосеф Смитийн орчуулга дээр ажиллаж байв. Энд хүлээн авагдсан илчлэлтүүд: С ба Г 1, 65, 67-69, 71, 73-74, 76-81, 99, 133.

9. Амхерст. 1832 оны нэгдүгээр сарын 25-нд энд Иосеф Смит Дээд Санваартны Ерөнхийлөгчөөр дэмжигдэн багтагджээ (*History of the Church*, 1:243; мөн С ба Г 75-ын хэсгийн тоймыг үз).

10. Торонто. Сүмийн гурав дахь Ерөнхийлөгч болсон Жон Тейлор, хожим нь Хайрум Смиттэй гэрлэсэн Мэри Фиелдинг нарын амьдарч байсан газар.



1. Индепенденс. 1831 оны долдугаар сард Их Эзэн Индепенденсийг Сионы төв газар болгон тогтоожээ (С ба Г 57:2- 3-ыг үз). 1831 оны наймдугаар сарын 3-нд энд Ариун сүмийн газар онцгойлон адисгагджээ. 1833 оны арваннэгдүгээр сард танхайрагч бүлгүүд Гэгээнтнүүдийг Индепенденс болон Жаксон дүүргээс албадан хөөжээ.

2. Фишинг Гол. Иосеф Смит болон Сионы Хуаран Жаксон дүүргийн Гэгээнтнүүдэд газрыг нь буцааж олгохын тулд, 1834 онд Огайогийн Кертиандаас Миссури хүртэл аялжээ. С ба Г 105 энэ мөрний эрэг дээр илчлэгдсэн ажээ.

3. Фар Вест. 1836-1838 онуудад Гэгээнтнүүдэд зориулж байгуулсан орогнох газар.Энэ нь 1838 оны хагаст Сүмийн төв байр байлаа. Ариун сүмийн газар энд онцгойлон адислагджээ (С ба Г 115-ыг үз).1838 оны долдугаар сарын 8-нд, галаадал номлолд үйлчлэх дуудлагыг Арванхоёрын Чуулга Их Эзэнээс

хүлээн авав (С ба Г 118-ыг үз). 1838- 39 онуудад Гэгээнтнүүд Иллиной руу зугтахаар албадуулжээ.

4. Адам-ондай-Аман. Адам нас барахаасаа гурван жилийн өмнө энд зөв шуларга үр удмаа адисгалжээ (С ба Г 107:53- 57-г үз). Аврагчийн Хоёр дахь Ирэлтийн өмнөхөн энд нэгэн агуу цугларалт болно (Даниел 7:9-14; С ба Г 78:15; 116; *Teachings of the Prophet Joseph Smith*, эмхтгэсэн Жозеф Фиелдинг Смит [1976], 157-г үз).

5. Либерти. Гэгээнтнүүд шилжин явах шаардлагатай болсон үед Жаксон дүүргээс энэ бүсэд 1833 оноос 1836 оныг хүртэл цуглажээ. Иосеф Смит болон бусад хүмүүс энд 1838 оны арванхоёрдугаар сараас 1839 оны дөрөвдүгээр сарыг хүртэл хилсээр шоронд хориглож байлаа. Сүмийн хувьд гай зовлон учирсан үеийн дундуур, Иосеф Их Эзэнд хандан удирдлага хүсч залбираад, С ба Г 121-23-ыг хүлээн авсан ажээ.


6. Науву. Миссипи мөрний эрэг дээр байдаг энэ бүс нутаг 1839-1846 онуудад Сүмийн төв байр байв. Энд ариун сүм баригдаж, нас барагсдын өмнөөс хийх багтисм, хишиг хүргээлт, гэр бүлийн лашдан холбогт зэрэг ёслолууд хийгдэж эхэлжээ. 1842 онд энд Нийгмийн Хадамжийн Бүлэг зохион байгуулагдла. Энд хүлээн авагдсан илчлэгүүдийн нэг нь С ба Г 124-29 юм.

7. Картейж. 1844 оны зургадугаар сарын 27-нд энд Бошиглогч Иосеф Смит ах Хайрумынхаа хамт алагдав (С ба Г 135).

8. Винтер Квортерс. Солт Лейк Хөндий рүү Гэгээнтнүүдийн дүрвэх зам дахь төв байгуулагын суурил (1846-1848). Өрнөд рүү хийх аянд зориулж энд Израйлын Буудлыг зохион байгуулжээ (С ба Г 136-г үз).

9. Каунсил Блаффс (Кейнсвилл). 1847 оны арванхоёрдугаар сарын 27-нд энд Тэргүүн Зөвлөл дэмжигдлэн баглагдаж, Бригам Янг Ерөнхийлөгч нь болжээ.

Газрын зураг 3: Сүм өрнөд рүү шилжсэн нь



- Фейетте. Бошилогч Иосеф Смит 1831 оны нэгдүгээр сард Огайогийн Кертландыг зорин, Фейеттегээс явжээ. 1831 оны дөрөв, тавдугаар сард Нью-Йоркийн гурван салбар Их Эзэний зарлигаар цугларахаар хөдлөв (С ба Г 37-38-ыг үз).
- Кертланд. Бошилогч 1831 оны хоёрдугаар сарын эхнээс 1838 оны нэгдүгээр сарын 12-нд Миссурийн Фар Вест рүү шилжих хүртэл Сүмийн төв байгууллага энд ажиллаж байв.
- Индепенденс. Их Эзэн 1831 оны долдугаар сард Индепенденсийг Сионы төв газар байхаар тогтоов (С ба Г 57:2-3-ыг үз). Танхайрагч бүлгүүд 1833 оны арваннэгдүгээр сард Гэгээнтнүүдийг эндээс шилжин явахад албаджээ.
- Либерти. Гэгээнтнүүд 1833 оноос 1836 оныг хүртэл эндээс шилжин явах шаардлагагүй болох хүртлээ Жаксон дүүргээс энэ бүст цугларч байв.
- Фар Вест. 1836-38 онуудад Гэгээнтнүүдэд зориулж байгуулсан орогнох газар. Энэ нь 1838 оны хагаст Сүмийн төв байр байв. 1838-1839 онуудад Гэгээнтнүүд Иллиной руу зугтахаар албадуулжээ.
- Науву. 1839-1846 онуудад Сүмийн төв байгуулага энд байв. Бошилогч ах Хайрумынхаа хамт алагдсанаас хойш хоёр жил орчмын дараа Гэгээнтнүүд өрнө зүгт шилжжээ.
- Каунсил Блафс (Кейнсвилл). Анхдагч нар 1846 оны зургадугаар сард энд ирэв. Мормоны Сумангийн гишүүд 1846 оны долдугаар сарын 21-нд дэслэгч Жеймс Аллены удирдлагаар эндээс хөдөлжээ.
- Винтер Квортес. Солт Лейкийн Хөндий (1846-1848) рүү Гэгээнтнүүдийн хийсэн аяны дамжин өнгөрөх төв суурин. Ерөнхийлөгч Бригам Янгийн удирдсан манлай бүлэг 1847 оны дөрөвдүгээр сард аянд гарчээ.
- Форт Леавенворт. Мормоны Суман 1846 оны наймдугаар сард өрнө зүгт хээрийн аянд гарчээ хын өмнө энд бэлтгэлээ хангажээ.
- Санта Фе. 1846 оны аравдугаар сарын 19-нд Мормоны Суман эндээс хээрийн аянаар хөдлөхөд дэслэгч хурандаа Филипп Кук захирсан ажээ.
- Пуэбло. Мормоны Сумангийн өвчтэй гурван цэргийг элгэртэл нь Пуэблод байлгах тушаал гарч, тэд 1846-1847 оны өвлийг Миссисипийн Гэгээнтнүүдтэй хамт өнгөрүүлэв. Энэ бүлэг 1847 оны долдугаар сард Солт Лейкийн Хөндийд очжээ.
- Сан Диего. 1847 оны нэгдүгээр сарын 29-нд Мормоны Суман 3200 км-ийн хээрийн аянаа энд дуусгав.
- Лос Анжелес. 1847 оны долдугаар сарын 16-нд энд Мормоны Суман халагджээ.
- Сакраменто. Сумангийн халагдсан зарим гишүүд энд, түүнчлэн алт нээж олоход өөрсдийнхөө тусалж байсан Америк голоос алс зүүннээ Саттерын үйлдвэр дээр ажиллаж байлаа.
- Солт Лейк хот. Ерөнхийлөгч Бригам Янг Солт Лейкийн Хөндийд 1847 оны долдугаар сарын 24-нд иржээ.

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

MONGOLIAN



4 02356 85363 5

35685 363